ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙД ХОЛБОГДОХ СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ЭМХЭТГЭЛ XX БОТЬ

(2024 онд хийж гүйцэтгэсэн судалгаа)

Улаанбаатар хот
2025 он

ННА 67.408
ДАА 345
Э-807

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН АЛСЫН ХАРАА

Олон улсын жишигт нийцсэн эрдэм, шинжилгээ, сургалт мэдээллийн үндэсний хүрээлэн болон хөгжинө.

© Бүх эрх хуулиар хамгаалагдсан болно. Зохиогч болон нийтлэгчийн зөвшөөрөлгүйгээр тус номын агуулгыг хэсэгчлэн болон бүтнээр хэвлэх, электрон аливаа хэлбэрээр хувилах, бичлэг хийх, хайлтын системд оруулах, хэвлэн олшруулахыг хориглоно. Хууль зүйн үндэсний хүрээлэн.

Хянан тохиолдуулсан:	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Хууль зүйн ухааны доктор (Dr.jur.) Х.Эрдэм-Ундрах
Эмхэтгэсэн:	Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын эрхлэгч (LL.M) Б.Ариунжаргал
	Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын эрдэм шинжилгээний ахлах ажилтан (LL.M) Х.Буянбат
	Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын эрдэм шинжилгээний ажилтан Ц.Нинж-Эрдэнэ
Хэвлэлийн эх бэлтгэсэн:	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эх бэлтгэгч, дизайнер Б.Заяа
Хавтасны гэрэл зураг:	Цагдаагийн ерөнхий газар
Цаасны хэмжээ:	176/250
Хэвлэлийн хуудас:	33 х.х

“Тоонот принт” ХХК-д хэвлэв.

ISBN: 978-9919-9142-5-7

ӨМНӨХ ҮГ

Эрхэм хүндэт уншигч та бүхний амар амгаланг айлтган мэндчилье.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд тусгасан эрх зүйн салбарт хийгдэж буй суурь судалгааны үр дүнг нэгтгэн жил бүр хэвлүүлэх зорилтын хүрээнд бид 2024 онд гүйцэтгэсэн судалгааны тайланг эмхэтгэл “Нийтийн эрх зүйд холбогдох судалгаа (Судалгааны тайлангийн эмхэтгэл XIX боть)”, “Эрүүгийн эрх зүйд холбогдох судалгаа (Судалгааны тайлангийн эмхэтгэл XX боть)”, “Хувийн эрх зүйд холбогдох судалгаа (Судалгааны тайлангийн эмхэтгэл XXI боть)”, “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эрх зүйн зохицуулалтад холбогдох судалгаа (Судалгааны тайлангийн эмхэтгэл XXII боть)” хэмээх дөрвөн ботио уншигч танаа толилуулж байна.

Эрүүгийн эрх зүйд холбогдох судалгааны тайланг эмхэтгэсэн энэхүү XX ботид Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төсөл боловсруулах ажлыг арга зүйн удирдлагаар хангах хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар батлсан аргачлалын дагуу гүйцэтгэсэн 5 бодлогын судалгаа болон харьцуулсан лавлагааг эмхэтгэв. Үүнд, Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг болон гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цахимжилт, Гэрч хохирогчийг хамгаалах тухай болон Монгол Улсын соёлын өвийн эсрэг гэмт хэргийн талаар гэх мэт нийгэмд тулгамдсан асуудлыг хөндөн судалж, шийдвэрлэх арга замыг эрэлхийлсэн болно.

Тус хүрээлэнгээс 2024 онд гүйцэтгэсэн “Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ" сэдэвт судалгааны хүрээнд Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг, Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа, Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах талаарх эрх зүйн зохицуулалтын тулгамдаж буй асуудлыг судлан үзэж, шийдвэрлэх талаар тодорхой санал, зөвлөмж дэвшүүлсэн юм.

Шүүхийн цахимжилттай холбоотой асуудал яригдаж буй энэ үед эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт болон цахим хавтаст хэрэг, цахим нотлох баримттай холбоотой эрх зүйн зохицуулалтыг үнэлж, бусад улсын сайн туршлагыг судлан үзсэн болно.

“Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх үнэлгээ” сэдэвт судалгаагаар тус хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, хуулийн төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн санал, зөвлөмж боловсруулсан.

Түүнчлэн, “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ” болон “Монгол Улсын Соёлын өвийн эсрэг гэмт хэргийн эрүүгийн

эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт” сэдэвт судалгааг гүйцэтгэсэн. Мөн “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны эрх зүйн зохицуулалтын талаарх харьцуулсан лавлагаа” сэдвийн хүрээнд ХБНГУ, АНУ, Япон Улс, БНСУ, ОХУ, Шведийн Хаант Улс, Норвегийн Хант Улс, Бүгд Найрамдах Эстони Улсын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судаллаа.

Уг эмхэтгэлд багтсан бидний судалгаа Монгол Улсын эрүүгийн эрх зүйн салбарт тулгамдаж буй асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй шийдвэрлэхэд зохих ёсны хувь нэмрийг оруулахын зэрэгцээ хууль зүйн чиглэлээр судалгаа, шинжилгээ хийж буй эрдэмтэн, судлаач, тус салбарт ажиллаж буй албан хаагчид, оюутнуудын судалгааны чухал эх сурвалж болно гэдэгт итгэж байна.

ЗАХИРАЛ Х.ЭРДЭМ-УНДРАХ

ГАРЧИГ

Өмнөх үг III
Товчилсон үгийн жагсаалт VI
Хүснэгтийн жагсаалт VIII
Графикийн жагсаалт X
Нэг. Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ (Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг, гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах) 1
Хоёр. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ (Цахим хавтаст хэрэг, цахим нотлох баримт, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт). 73
Гурав. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх үнэлгээ (Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 18 дугаар тогтоол) 171
Дөрөв. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ 237
Тав. Монгол Улсын соёлын өвийн эсрэг гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт. 269
Зургаа. Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны эрх зүйн зохицуулалтын талаарх харьцуулсан лавлагаа. 331

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

CERT	Computer Emergency Response Team
CSIRT	Computer Security Incident Response Team
ECF	Electronic Case File
NYSCEF	New York State Courts Electronic Filing
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АТГ	Авлигатай тэмцэх газар
АТИ	Авлигын төсөөллийн индекс
БЗД	Баянзүрх дүүрэг
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНЭсУ	Бүгд Найрамдах Эстони улс
ЕП	Европын парламент
ЕХ	Европын холбоо
ЗХШХШтХ	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ИХШХШтХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
МБ	Мөрдөн байцаалт
МУГХУСАЗЗ	Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУБХ	Олон улсын бага хурал
ОХУ	Оросын Холбооны Улс
СБД	Сүхбаатар дүүрэг
СӨХтХ	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
СХД	Сонгинохайрхан дүүрэг
УДШ	Улсын Дээд Шүүх
УЕП	Улсын ерөнхий прокурор
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
УИХ	Улсын Их Хурал
ХБ	Хэрэг бүртгэлт
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЗДХ	Хууль зүй, дотоод хэрэг
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЗЯ	Хууль зүйн яам
ХУД	Хан-Уул дүүрэг
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЦХХХ	Цахим хөгжил, харилцаа холбоо
ЧД	Чингэлтэй дүүрэг
ШССМХ	Шүүхийн сургалт, судалгаа мэдээллийн хүрээлэн
ШШГтХ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
ЭБШХ	Эрүүгийн байцаан шийтгэх хууль
ЭХАШШ	Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх
ЭХЕА	Эрүүгийн хуулийн ерөнхий анги
ЭХНӨОтХ	Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

ЭХТА	Эрүүгийн хуулийн тусгай анги
ЭХХША	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
ЭХХШтХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1. Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт 6

Хүснэгт 1.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт 8

Хүснэгт 1.3. Монгол Улсын авлигын индексэд өгсөн үнэлгээ 12

Хүснэгт 1.4. Гомдол, мэдээлэл шийдвэрлэлт 19

Хүснэгт 1.5. Шалгасан хэрэг 19

Хүснэгт 1.6. Шалгасан хэрэг /төрлөөр/. 19

Хүснэгт 1.7. Шүүхээр шийдвэрлэгдсэн байдал 20

Хүснэгт 1.8. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн зохицуулалт 21

Хүснэгт 1.9. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдал 22

Хүснэгт 1.10. Хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялтай гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа 35

Хүснэгт 1.11. Хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн 37

хөөн хэлэлцэх хугацаа 37

Хүснэгт 1.12. Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйл. 38

Хүснэгт 1.13. Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хөнгөн, хүнд гэмт хэрэгт ижил тоолохоор хуульчлагдсан жишээ 40

Хүснэгт 1.14. 2022, 2023 онд нэмэлтээр оруулсан зохицуулалт 43

Хүснэгт 1.15. Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа 44

Хүснэгт 1.16. Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авагдсан 60

Хүснэгт 2.1. Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн 79

хүрээнд сонгосон зохицуулалт 79

Хүснэгт 2.2. Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт 80

Хүснэгт 2.3. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт 80

Хүснэгт 2.4. БНСУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт ашиглах тухай хуулийн зохицуулалт 103

Хүснэгт 2.5. ЗХШХШтХ болон ИХШХШтХ-ийн цахим баримт, ... 109

түүнийг үнэлэх 109

Хүснэгт 2.6. Цахим нотлох баримтын онцлог 110

Хүснэгт 2.7. Тоон нотлох баримтыг агуулж болох төхөөрөмж, хэрэгслүүд 113

Хүснэгт 2.8. БНСУ-ын Хэргийн бүртгэлийг хадгалах журам. 149

Хүснэгт 3.1. Зорилгод хүрэх түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт 177

Хүснэгт 3.2. Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт 178

Хүснэгт 3.3. Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт 179
Хүснэгт 3.4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт 179
Хүснэгт 3.5. Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт 179
Хүснэгт 3.6. Тохирох шалгах хэрэгсэл 181
Хүснэгт 3.7. Тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг үнэлэх хэсэг 181
Хүснэгт 3.8. Сэжигтэн, гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн. 189
Хүснэгт 3.9. Ойлгомжгүй байгаа хуулийн төслийн зохицуулалт 202
Хүснэгт 3.10. Шүүх хуралдааны талаар орсон өөрчлөлт 207
Хүснэгт 3.11. Жагсаалтаар батлагдсан төрийн нууц мэдээллийн тоо: 211
Хүснэгт 4.1. Үнэлэх зүйл, заалт 239
Хүснэгт 4.2. Тогтоосон шалгуур үзүүлэлтэд тохирох харьцуулах хэлбэр 240
Хүснэгт 4.3. Хохирогчийг тодорхойлсон тодорхойлолтууд 246
Хүснэгт 4.4. ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс болон Тахарын албаны бие даасан байдал 254
Хүснэгт 4.5. Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам”-ын харьцуулалт . . . 260
Хүснэгт 5.1. Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд Соёлын өвийн эсрэг гэмт хэргийг хуульчилсан байдал 272
Хүснэгт 5.2. Соёлын өвийн эсрэг гэмт хэргийг хуульчилсан байдлыг харьцуулсан нь 273
Хүснэгт 5.3. Түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж 280
Хүснэгт 5.4. Түүх, соёлын дурсгалт ул хөдлөх дурсгалыг эвдэх, гэмтээх, устгах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж 281
Хүснэгт 5.5. Соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж 282
Хүснэгт 5.6. Хууль бусаар археологи, палеонтологийн хайгуул, малтлага хийх гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж 283
Хүснэгт 5.7. Соёлын биет өвийн хууль бус худалдааг зохион байгуулах, зуучлах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж 284
Хүснэгт 5.8. Түүх, соёлын дурсгалт зүйлийг тогтоосон хугацаанд хилээр оруулж ирэхгүй байх гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж 284
Хүснэгт 5.9. Эрдэнэсийн сангийн үндсэн санг хууль бусаар зарцуулах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж 285
Хүснэгт 5.10. Түүх, соёлын чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг Хулгайлах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж. 286
Хүснэгт 5.11. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж 286

Хүснэгт 5.12. Гадаад орнуудын соёлын өвийн эсрэг гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг харьцуулсан нь 287
Хүснэгт 5.13. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоон мэдээлэл (2017-2024 он) 299
Хүснэгт 5.14. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэргийн тоо (2018-2023 он) 299
Хүснэгт 5.15. 2018-2023 онд ЭХТА-ийн 17.1 дүгээр зүйлийн 2.2-т заасан гэмт хэргийн улмаас учирсан хохирол, түүний нөхөн төлөлт (хувиар). 304
Хүснэгт 5.16. Шүүгдэгч нарын нас болон нийгмийн байдал 305

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 4.1. 2017-2023 онд Эрүүгийн хуулийн 21.5 дугаар зүйлд заасан гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдал 250

График 4.2. 2024 оны эхний 08 сарын байдлаар бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 251

График 4.3. 2024 оны эхний 08 сарын байдлаар гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоо 252

График 4.4. Гэрч хохирогчийг хамгаалахад хэрэгжүүлсэн арга хэмжээ 252

График 4.5. Гэрч хохирогчийг хамгаалалтад авсан хүний тоо 253

График 5.1. Хэрэг бүртгэлт явуулсан хэргийн тоо (Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.2 дахь хэсэг) 300

График 5.2. Мөрдөн байцаалт явуулсан хэргийн тоо (Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.2 дахь хэсэг) 301

График 5.3. Хэрэг бүртгэлт явуулсан хэргийн тоо (Эрүүгийн хуулийн 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг) 302

График 5.4. Мөрдөн байцаалт явуулсан хэргийн тоо (Эрүүгийн хуулийн 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг) 302

График 5.5. Хэрэг бүртгэлт явуулсан хэргийн тоо (Эрүүгийн хуулийн 25 дугаар бүлэг) 303

График 5.6. Мөрдөн байцаалт явуулсан хэргийн тоо (Эрүүгийн хуулийн 25 дугаар бүлэг) 303

График 5.7. Яллагдагчаар татагдсан хүмүүсийн насны байдал. 304

График 5.8. Хянан шийдвэрлэгдсэн байдал (Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.2 дахь хэсэг) 306

График 5.9. Хянан шийдвэрлэгдсэн байдал (Эрүүгийн хуулийн 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг) 307

График 5.10. Хянан шийдвэрлэгдсэн байдал (Эрүүгийн хуулийн 25 дугаар бүлэг) 308

НЭГ. ЭРҮҮГИЙН ХУУЛЬ БОЛОН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

(Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг, гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах)

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Хууль зүйн ухааны доктор (Dr.jur.)

Судалгааны багийн бусад гишүүд:

М.Түвшинжаргал	Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
Б.Ариунжаргал	Эрдэм шинжилгээний ажилтан
Х.Санчир	Эрдэм шинжилгээний ажилтан
М.Энхжин	Эрдэм шинжилгээний ажилтан
Э.Энхжаргал	Эрдэм шинжилгээний ажилтан

Судалгааг захиалагч: Хууль зүй, дотоод хэргийн яам
Судалгааг гүйцэтгэж хүргүүлсэн огноо: 2024.05.13.

АГУУЛГА

УДИРТГАЛ 3
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ 4
1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох нь 4
1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох 5
1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох 5
1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох 8
1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох 9
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох 9
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ 10
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ 11
3.1.“Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал.....11
3.2.“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал 51
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ 67
НОМ ЗҮЙ 70

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.7-д “...Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно...” гэж, мөн 4.2.1-д “....Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно...” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 77-д “...нийгмийн хор аюул, үйлдэгдэж байгаа арга, хэлбэрээс хамаарч зарим гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах эрүүгийн хариуцлагыг оновчтой болгох зорилгоор Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ...” гэж, мөн Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 6 дахь хэсгийн “Төрийн бүтээмжийн сэргэлт”-ийн 6.5-д “Авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгана.” гэж тус тус заажээ.

Дээрх бодлогын баримт бичигт тусгагдсан зохицуулалтууд нь авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тухайн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг уртасгах, ялын бодлогыг чангатгах, гэмт хэргийн шинж, бүрэлдэхүүн, эрүүгийн хариуцлагыг оновчтой болгох гэх мэт олон асуудлыг хөндөж байна. Энэхүү зохицуулалтуудыг хэрэгжүүлэхийн тулд Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан “Авлигын гэмт хэрэг”-ийн зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулах, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг уртасгах, зарим гэмт хэргийн шинж, бүрэлдэхүүн, эрүүгийн хариуцлагыг чангатгах асуудал нэн тэргүүнд тавигдаж байсан. Иймээс ч УИХ-аас 2022 онд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, тус хуулиар Авлигын гэмт хэрэгтэй холбоотой хэд хэдэн нэмэлт, өөрчлөлт оруулсан билээ.

Энэхүү судалгааны хүрээнд Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан Авлигын гэмт хэрэг, тэр дундаа Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэг болон авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа, тус гэмт хэргийг үйлдэж олсон хөрөнгө орлогыг хураахтай холбоотойгоор Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан зохицуулалтыг сонгон хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхээр тогтов.

Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт хийх энэхүү үнэлгээний зорилго нь хуулийн хэрэгжилтийн явц дахь хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэн, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгөх, зөвлөмж боловсруулахад оршино.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Эрүүгийн хууль болон ЭХХШтХ-ийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн. Төлөвлөх үе шатанд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох нь

Эрүүгийн хууль нь хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилготой хууль юм. Энэ ч утгаараа эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал нь хүний эрхийг хамгийн ихээр хязгаарладаг хариуцлагын хэлбэр билээ. Хүн бүр тэгш эрхтэй ч Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэн эрүүгийн хариуцлага хүлээж буй хүний эрхийг хуулиар хязгаарлах нь зүйн хэрэг. Нөгөөтээгүүр хүний эрх, эрх чөлөөг хамгийн ихээр хязгаарладаг Эрүүгийн хууль нь эрх зүйн хэм хэмжээний хийдэлтэй байвал энэ нь эргээд нийгэмд сөрөг үр дагаврыг бий болгож, хүний эрхийг хязгаарлах гол хэрэгсэл болж хувирахыг ч үгүйсгэх аргагүй юм.

Хууль шударга ёсыг тогтоох хэрэгсэл гэтэл эсрэгээрээ шударга бус зүйлийг бий болгох эх уурхай болж болохгүй гэдгийг санах нь зүйтэй.

Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний суурь эрх, халдашгүй байдлыг илүү баталгаажуулсан, олон улсын нийтийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцсэн урт хугацаанд тогтвортой үйлчлэх хуулийг батлан гаргах зүй ёсны шаардлага бий болж[1] улмаар Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулж 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр батлан 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх болсон билээ.

Хэдийгээр шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг дагаж мөрдөөд долоон жилийн хугацаа өнгөрч байгаа боловч Эрүүгийн хуулийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, хэрэглэхэд хүндрэлтэй, эрх зүйн хийдэлтэй зохицуулалт нэлээдгүй байгааг салбарын эрдэмтэн, судлаач, шүүгч, прокурор, өмгөөлөгчид хөндсөөр ирсэн.

Тэр дундаа сүүлийн жилүүдэд авлигын гэмт хэрэгтэй холбоотой асуудлууд олон нийтийн анхаарлын төвд ороод байна. Тухайлбал, Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа бага байгаа нь тухайн гэмт хэргийг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болж байна. Мөн тус гэмт хэрэгт оногдуулах

1 Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал, ХЗДХЯ, (Уб, 2013).

ялын хэмжээ бага атлаа нийгмийн хор аюулын шинж их, зарим гэмт хэргийн хувьд үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүнд ялгамжтай бус ижил хэмжээний ял оногдуулахаар хуульчилсан гэх мэт олон асуудлууд үүсээд байсан билээ.

УИХ-аас 2022 онд баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар авлигатай холбоотой хэд хэдэн нэмэлт, өөрчлөлтийг оруулсан боловч зарим зохицуулалтын хувьд одоог хүртэл практикт маргаан дагуулсан хэвээр байгаа тул авлигын гэмт хэргийн зарим зохицуулалт болон холбогдох бусад зохицуулалтын хэрэгжилтэд үнэлгээ хийх зайлшгүй шаардлага үүссэн хэмээн үзэж энэхүү судалгааг гүйцэтгэлээ.

Түүнчлэн, авлигын гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах асуудал практикт түгээмэл байгаа ба зарим гэмт хэрэгтэй харьцуулахад цаг хугацаа, хөрөнгө санхүү, хүний нөөц, хамтын ажиллагаа гэх мэт олон хүчин зүйлээс шалтгаалж ээдрээ төвөгтэй байдаг тул энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлогыг хураахтай холбогдсон Эрүүгийн хууль болон ЭХХШтХ-д заасан зарим зохицуулалтын хэрэгжилтийг мөн судлан үзнэ.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг. Өөрөөр хэлбэл, үнэлгээ хийх болсон шалтгаан (өмнө тодорхойлсон)-тай харилцан уялдаа, хамааралтайгаар хийгдэх ажиллагаа бөгөөд тодорхойлогдсон эерэг, сөрөг нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудал, үр дагавар бүхий харилцаатай холбогдсон хуулийн зохицуулалтыг илрүүлнэ.

Үнэлгээний хүрээг тогтоохдоо үнэлгээ хийх ажлын төлөвлөлт, зохион байгуулалт, хүний нөөц, цаг хугацаа, гарах зардлыг заавал харгалзан үзэх нь чухал. Хуулийг бүхэлд нь үнэлэх ажиллагааны зардал ихэвчлэн хэт өндөр гардаг тул зөвхөн тухайн хуулийн зорилго, үнэлгээний шалгуурт хамгийн ихээр нөлөөлж болохуйц хуулийн зохицуулалтыг зөв сонгох шаардлагатай. Иймээс дээр дурдсан хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх хэрэгцээ шаардлагад тулгуурлан Эрүүгийн хуулийн 22 бүлэгт заасан Авлигын гэмт хэрэг, түүнтэй холбоотойгоор Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэг болон Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт, тус гэмт хэргийг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураахтай холбоотой зохицуулалтуудад хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийхээр тогтлоо.

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараах хоёр шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1. Зорилгод хүрсэн түвшин;
2. Практикт нийцэж байгаа байдал;

1.3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Эрүүгийн хуулийн 1.1 дүгээр зүйлд энэ хуулийн зорилгыг “Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино” хэмээн тодорхойлжээ. Иймээс үнэлгээний шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дээр дурдсан зорилгыг хангахтай холбогдуулан тусгасан зүйл заалтын нэг болох Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэг /Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйл. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих/, Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийг тус тус сонгож “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээг хийлээ. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1.1. *Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт*

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйл.	**22.10 дугаар зүйл.Үндэслэлгүйгээр хөрөнгөжих** 1.Нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Тайлбар: -Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан “их хэмжээ” гэдэгт нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгоно. 2.Энэ гэмт хэргийг улс төрд нөлөө бүхий этгээд үйлдсэн бол үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2	Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйл.	**1.10 дугаар зүйл.Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа** 1.Гэмт хэрэг үйлдсэнээс хойш дараах хугацаа өнгөрсөн нь тогтоогдвол яллагдагчаар татаж болохгүй: 1.1.энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн; 1.2.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн; 1.3.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг арван таван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван хоёр жил өнгөрсөн; 1.4.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг арван хоёр жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг хорин жил хүртэл тогтоосон ба бүх насаар хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэнээс хойш хорин жил өнгөрсөн.

		1.5.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш гурван жил өнгөрсөн. 2.Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолно. 3.Гэмт хэрэг үйлдсэн этгээд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаа өнгөрөөгүй байхад гэмт хэрэг санаатай дахин үйлдвэл хөөн хэлэлцэх хугацааг сүүлчийн гэмт хэргийг үйлдсэн үеэс гэмт хэрэг тус бүрд шинээр тоолно. 4.Энэ хуульд бүх насаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг, хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй. 5.Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш таван жил байна. 6.Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдэж энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан бол тухайн зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай адил байдлаар хөөн хэлэлцэх хугацааг тоолно. 7.Хуулиар халдашгүй байдлыг баталгаажуулсан албан тушаалтны бүрэн эрхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан түдгэлзүүлээгүй бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг зогсоож, бүрэн эрх дуусгавар болсны дараа тоолж эхэлнэ. 8.Сэжигтэн мөрдөн шалгах ажиллагаанаас оргон зайлсан бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг оргон зайлсан өдрөөс эхлэн зогсоож уг этгээд баригдсан, эсхүл хэргээ өөрөө илчилж ирсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл хөөн хэлэлцэх хугацааг сэргээн тоолно. 10.Энэ хуулийн 12.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 12.3 дугаар зүйлийн 2.1, 3.2 дахь заалт, 13.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтад заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоож, хохирогчийг арван найман насанд хүрсний дараа тоолж эхэлнэ.

1.3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Энэхүү шалгуур үзүүлэлт нь тухайн хууль тогтоомжийн зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлоход чиглэгддэг. Иймд судалгааны энэхүү хэсэгт “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 9 дэх хэсэг, мөн хуулийн 7.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр бүлэгт заасан хөрөнгө, орлогыг хураахтай холбоотой зарим зохицуулалтыг сонгож, уг зүйл, заалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа байдал, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл, бэрхшээл байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1.2. *“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт*

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 9 дэх хэсэг	**1.10 дугаар зүйл. Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа** 2. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссанаас үл хамааран шүүхийн шийдвэрээр хураж улсын орлого болгоно.
2	Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.	1.Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулна.
3	ЭХХШтХ-ийн 21.1 дүгээр зүйл, 21.2 дугаар зүйл.	**21.1 дүгээр зүйл. Хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хадгалах** 1.Шүүх, прокурор, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтын хадгалалт, хамгаалалтыг хариуцна. 3.Хураан авсан үндэсний болон гадаад валютыг тусгай дансанд байршуулна. 4.Хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйлийг хадгалах талаар гаргасан оролцогчийн хүсэлтийг үндэслэн тэдгээрийг хаана хадгалахыг шүүх, прокурорын шийдвэрт тусгайлан зааж болно. **21.2 дугаар зүйл. Эд хөрөнгө битүүмжлэх** 1.Хохирлыг нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгуулах болон хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээг хангах зорилгоор яллагдагч, шүүгдэгчийн эд хөрөнгийг шүүх, прокурорын шийдвэрээр битүүмжилнэ. 2.Шүүх, прокурорын шийдвэрээр хураан авсан эд мөрийн баримт овор хэмжээ ихтэй, эсхүл бусад шалтгаанаар хадгалах боломжгүй бол мөрдөгч байгаа газарт нь битүүмжилнэ. 3.Эд хөрөнгийг битүүмжлэхдээ эд хөрөнгөө бусдад шилжүүлэх, устгах, өөрчлөх, захиран зарцуулах, хөдөлгөхийг хориглож, өөрт нь, эсхүл бусад боломжтой хүнд хадгалах, хамгаалах үүрэг хүлээлгэнэ. 5.Эд хөрөнгө битүүмжлэхдээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан хүний өдөр тутмын зайлшгүй хэрэгцээний эд зүйлийг битүүмжилж болохгүй. 6.Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааг хураан авах, нэгжлэг хийх ажиллагаатай хамт явуулж болно.

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрүүдээс сонгоно. Үүнд:

- Байх ёстой болон одоо байгаа;
- Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших;
- Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших;
- Тохиолдол судлах.

Судалгааны явцад дээр дурдсан Эрүүгийн хууль, ЭХХШтХ-ийн зүйл, заалтад хамаарах агуулга тус бүр дээр байх ёстой болон одоо байгаа, хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших, тохиолдол

судлах харьцуулах хэлбэрийн аль тохирохыг ашиглана. Мөн гадаад орнуудын эрх зүйн зохицуулалт, сайн туршлагыг харьцуулан судална.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох

Шалгуур үзүүлэлтийг томьёолохдоо сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр Эрүүгийн хуулийн сонгон авсан хэсэгт тохируулан дараах таамаглал дэвшүүлж, асуулт боловсруулаа:

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан гэмт хэрэг зорилгодоо хүрсэн эсэх?

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйл заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх?

Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Эрүүгийн хууль болон ЭХХШтХ-д заасан хөрөнгө, орлогыг хураахтай холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Авлигын гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлогыг хураахад хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдөх байдал, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор тухайн асуудлын хүрээнд гаргасан ном, сурах бичиг, гарын авлага, судалгааны тайлан эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл, шүүхийн шийдвэр уншиж судлах, түүхчилсэн, харьцуулсан судалгаа хийх, холбогдох байгууллагаас судалгаа мэдээлэл авах зэрэг аргыг ашиглана.

Мэдээлэл цуглуулах арга:

- Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах;
- Холбогдох субъектээс судалгаа авах аргыг сонгон хэрэгжүүллээ;

Байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд:

Эрүүгийн хууль, ЭХХШтХ холбогдох сурах бичиг, гарын авлага, эмхэтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайлан, шүүхийн шийдвэр, статистик мэдээ зэргийг цуглуулж үнэлгээ хийхэд ашиглав.

Холбогдох субъектээс судалгаа авах хүрээнд:

Авлигын гэмт хэрэг, түүнтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын хэрэгжүүлэх явцад тулгамдаж буй асуудлыг илрүүлэхийн тулд хуульч, өмгөөлөгчдөөс ярилцлагын аргаар судалгаа авч, холбогдох байгууллагаас үйл ажиллагааны тайлан, судалгаа, бусад мэдээллийг гаргуулан авч үнэлгээ хийхэд ашиглав.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Хэрэгжүүлэх үе шатны гол зорилго нь хэрэгцээтэй, шаардлагатай байгаа ач холбогдол бүхий мэдээллийг цуглуулан судалснаар хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох юм.

Эрүүгийн хууль, ЭХХШтХ-ийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн судалгаа, харьцуулсан судалгааны аргад тулгуурлаж энэхүү судалгааг гүйцэтгэв.

Баримт бичгийн судалгаа: Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, эрдэмтэн, судлаачдын эрдэм шинжилгээний бүтээлүүд, илтгэл, өгүүлэл, судалгааны тайланг ашигласан болно.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн сонгосон зүйл, заалтуудыг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ.

3.1. “ЗОРИЛГОД ХҮРСЭН ТҮВШИН” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд Монгол Улс авлигын эсрэг хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, бодлогын баримт бичгийг судлан үзэж, Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан Авлигын гэмт хэрэг, тэр дундаа Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэргийн зохицуулалтын зорилгодоо хүрсэн эсэх, “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэргийн талаарх ойлголт, гадаад улс орны туршлагыг судлан үзнэ.

Мөн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалт нь зорилгодоо хүрсэн эсэх, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны асуудал, гадаад орны туршлагыг тус тус судална.

3.1.1. Авлигын эсрэг хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, бодлогын баримт бичиг

Монгол Улсын Их Хурал 1996 онд Авлигын эсрэг хууль, 2002 онд Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг баталж, Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулж, хяналт тавих орон тооны бус Үндэсний зөвлөлийг байгуулж ажиллуулсан.[2] Манай Улс 2005 онд НҮБ-ын Авлигын эсрэг конвенцод нэгдэн орж, улмаар 2006 онд Авлигын эсрэг хуулийг шинэчлэн баталсан бөгөөд тус хуулийн дагуу Монгол Улсад анх удаа авлигатай тэмцэх тусгай байгууллага болох “Авлигатай тэмцэх газар” байгуулагдаж, 2007 оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Сүүлийн жилүүдэд манай улсад авлигын асуудал ихээхэн анхаарал татсан, зайлшгүй шийдвэрлэх асуудлын нэг болоод байна.

Түүнчлэн, 2023 онд Транспэрэнси Интернэйшнл байгууллагаас гаргадаг Авлигын төсөөллийн индекс (АТИ)-ийн дүнгээр Монгол Улс 33 оноо авч, 180 улс орноос 121 дүгээр байрт эрэмбэлэгдсэн. Уг индексээр Монгол Улс 2012-2023 онд дунджаар 36.17 оноо авсан. Сүүлийн 12 жилийн хугацаанд АТИ-ийн дэлхийн дундаж оноо өөрчлөгдөөгүй буюу боломжит 100 онооноос 43 оноо байна. Дэлхийн улс орнуудын гуравны хоёр нь 50-аас доош оноо авсан нь эдгээр улс орнуудад авлига ноцтой асуудал болсныг илтгэж байна. Мөн шүүхийн тогтолцоо суларч буй дэлхий нийтийн чиг хандлага нь нийтийн албан тушаалтны хариуцлагыг бууруулж, улмаар авлига цэцэглэх боломжийг олгож байгааг Транспэрэнси Интернэйшнл байгууллага онцлон тэмдэглэжээ.

Сүүлийн 4 жилд авлигын индексэд оноо өгдөг судалгааны байгууллагууд манай улсад дор дурдсан оноог өгсөн байна.

2 Авлигатай тэмцэх газар, Түүхэн замнал, https://iaac.mn/erhem-zorilgo-undsen-zarchim-tuuhen-zarchim

Хүснэгт 1.3. *Монгол Улсын авлигын индексэд өгсөн үнэлгээ*[3]

№	Байгууллага-судалгаа	2020	2021	2022	2023
1	Пи Ар Эс групп – Эрсдэлийн үнэлгээ 2020, 2021	41	37	32	33
2	Ай Эм Ди – Дэлхийн өрсөлдөх чадварын эмхэтгэл, Үзэл бодлын судалгаа 2020, 2021	32	29	30	33
3	Ардчиллын олон талт байдлын төсөл 2020, 2021	34	34	28	25
4	Дэлхийн эдийн засгийн форум – Үзэл бодлын судалгаа	28	34	30	-
5	Бертелсман сан – Шилжилтийн индекс 2020, 2022	37	37	37	37
6	Дэлхийн банк – Улс орны бодлого, институцийн үнэлгээ 2019, 2020	35	-	-	-
7	Эдийн засгийн мэдээллийн нэгж – Улс орнуудын эрсдэлийн үнэлгээ 2020, 2021	33	33	37	37
8	Дэлхийн эрх зүйн төсөл – Хууль дээдлэх ёсны индекс	33	35	35	33
9	Глобал инсайт байгууллага – Улс орнуудын эрсдэлийн түвшин 2019, 2020	35	35	35	35
Дундаж оноо		**35**	**35**	**33**	**33**

Манай улс авлигын төсөөллийн индексийн дундаж оноогоор:

- 2020 онд 35 оноо авч 180 орноос 111 дүгээр байр;
- 2021 онд 35 оноо авч 180 орноос 110 дугаар байр;
- 2022 онд 33 оноо авч 180 орноос 116 дугаар байр;
- 2023 онд 33 оноо авч 180 улсаас 121 дүгээр байрт тус тус эрэмбэлэгджээ.

Дээрх тоон мэдээнээс харвал, 2022, 2023 онд өмнөх жилүүдтэй харьцуулахад авлигын төсөөллийн индексийн оноо 2-оор буурч, 6-11 байр ухарсан үзүүлэлттэй байна. Авлигын индекс буурч, хэлбэлзэж байгаа нь ардчилсан тогтолцоо бэхжээгүй, гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг улс төрийн намуудын төлөвшил муу байгаагийн илрэл юм.

Тус судалгаанд Ази номхон далайн бүс нутгаас хамрагдсан 31 орны дундаж оноо нь 45 байхад Монгол Улс бүс нутгийн дунджаас доогуур үзүүлэлттэй байна. Энэхүү судалгаанд хамрагдсан 180 орноос дундаас доогуур орлоготой 50 улсын авлигын төсөөллийн индексийн дундаж оноо нь 33 байна. Харин манай улсын хувьд сүүлийн 2 жилийн байдлаар 33 оноо нь авсан нь энэ ангилалд багтах үндэслэл болж байна.

Тиймээс ч төрийн бодлогын баримт бичгүүдэд авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар тусгайлан тусгажээ. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2.7-д “...хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх...” гэж, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасан”... нийгмийн хэв журмыг сахин хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах...” бүрэн эрхийнхээ хүрээнд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын”-ын “Засаглал”-ын зорилт, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын “Төрийн бүтээмжийн сэргэлт”-ийн зорилтыг тус тус үндэслэн Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолоор 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласан.

3 Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан номын тоон мэдээнээс, (2020, 2021, 2022 он)

Монгол Улсын хэмжээнд авлигатай тэмцэх зорилгоор төрөөс баталсан эрх зүйн баримт бичгүүдээс дурдвал:

- **Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоол**

Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолоор 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласан.

2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласантай холбогдуулж “Авлигатай тэмцэх таван үйл ажиллагаа”-г хавсралтаар баталсан. Үүнд:

Нэг.Шүгэл ажиллагаа

- Авлига, албан тушаалын гэмт хэргийн талаар нийтийн эрх ашгийн төлөө мэдээлж байгаа шүгэл үлээгчийг хамгаалах хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганаар батлуулах;
- Шүгэл үлээх үйл ажиллагааг бүх талаар дэмжих хөдөлгөөн зохион байгуулж, авлигыг үл тэвчих, үл эвлэрэх хандлагыг төлөвшүүлэх, олон нийтийн дэмжлэг авах;
- Төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг багасгах, иргэд, хувийн хэвшлийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хамтран ажиллах.

Хоёр.Шүүр ажиллагаа

- Улс төрд нөлөө бүхий этгээдийн хууль ёсны орлогоос давсан хэрэглээг таслан зогсоох, нийтийн албанд танилын хүрээгээр томилогдохгүй байх нөхцөлийг бүрдүүлэх;
- Авлига, албан тушаалын гэмт хэргийн хариуцлага гарцаагүй байх, холбогдсон этгээдийг нийтийн албанаас шүүрдэн цэвэрлэх;
- Төрийн алба, төрийн өмчийг “шимэгчид”-ээс салгах;
- Авлига, албан тушаалын гэмт хэргийг хуулийн хүрээнд бүрэн гүйцэд, шуурхай шалган шийдвэрлүүлэх.

Гурав.Шувуу ажиллагаа

- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гадаад улс руу оргон зайлсан этгээдийг Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжийн хүрээнд эргүүлэн авчрах, хариуцлага хүлээлгэх;
- Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх чиглэлээр шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах.

Дөрөв.Шилжүүлэн авах ажиллагаа

- Оффшор бүс болон гадаад улсад нуун дарагдуулсан хууль бус хөрөнгийг илрүүлэн буцаан авчрах;
- Гэмт хэргийн замаар олсон хөрөнгө, орлогыг хураах үйл ажиллагааг ил тод болгох, сан бүрдүүлж, олон нийтийн оролцоотойгоор зарцуулах тогтолцоог бүрдүүлэх.

Тав.Шил ажиллагаа

- Цахимжилтыг эрчимжүүлж, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, хүнд суртлыг арилгах, бүх төрлийн сонгон шалгаруулалтыг нээлттэй болгох;
- Төрийн өмчит компаниудыг олон нийтийн хяналттай, нээлттэй компани болгох, ур чадвар бүхий менежментийн багийг ажиллуулах;
- Улс төрийн намын хууль, эрх зүйн орчныг сайжруулж, улс төрийн болон улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгох, олон намын оролцоотой шударга өрсөлдөөнтэй, ардчилсан парламентын засаглалыг төгөлдөржүүлэх;
- Ёс зүйтэй, шударга өрсөлдөх орчныг бүрдүүлж, цэвэр, тунгалаг бизнесийг дэмжин хөгжүүлэх.

- **Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр /2023-2030 он/**

Тус хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна.

- Сонгуулийн үеэр санал худалдан авахад чиглэсэн бүх хэлбэрийг хориглож, хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- Сонгуулийн бус үеэр санал худалдан авахад чиглэсэн бүх хэлбэрийг хориглоно.
- Намын санхүүжилт, үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх замаар намын хариуцлага, ёс зүй, ил тод байдлыг сайжруулна.
- Төрийн бодлого, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахуйц эерэг нөлөөтэй сонгуулийн тогтолцоог бүрдүүлэх, сонгуулийн болон сонгуулийн бус үеийн санхүүжилтийг ил тод болгож, сонгуулийн зардлыг бууруулан иргэний сонгох, сонгогдох эрхийг хамгаалах, нэр дэвшигчийг өрсөлдөх тэгш боломжоор хангана.
- Төрийн бодлого, шийдвэр гаргахад нийгмийн сонирхлын бүлэг, иргэн оролцох, нөлөөлөх /лоббидох/ эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.
- Төрийн албаны хүний нөөцийн удирдлага болон томилгооны ил тод, мэргэшсэн, тогтвортой байдлыг бэхжүүлнэ.
- Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянах үйл ажиллагаанд олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгоно.
- Нийтийн албан тушаалтан зарлагаа мэдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, татварын болон төрийн бусад мэдээлэлтэй уялдуулан хяналт тавих цахим системийг хөгжүүлнэ.
- Төрийн өндөр албан тушаалтан, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтныг ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- Төрийн үйл ажиллагааны мэдээллийг цахимжуулах замаар иргэдийн мэдэх эрхийг баталгаатай эдлүүлнэ.
- Салбарын эрсдэлийг оновчтой тодорхойлж, түүнд чиглэсэн арга хэмжээг үе шаттайгаар, цогц байдлаар хэрэгжүүлнэ.

- Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн чиг үүрэг, эрх хэмжээ, бүтцийг олон улсын жишиг, сайн туршлага, олон улсын байгууллагын зөвлөмжийг үндэслэн оновчтой тодорхойлж, олон нийтийг төлөөлөх боломж, нөхцөлийг хангасан эрх зүйн орчныг боловсронгуй болгоно
- Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх болон хэрэгжилтийг үнэлэхэд иргэн, иргэний нийгмийн байгууллагын бодит оролцоог хангаж иргэнд ээлтэй бодлого, шийдвэр гаргах нөхцөлийг хэвшүүлнэ.
- Төрийн үйл ажиллагаанд хараат бус хөндлөнгийн хяналт тавих иргэний нийгмийн байгууллагыг бэхжүүлэхэд шаардлагатай дэмжлэг бий болгоно.
- Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийг хамгаалах эрх зүйн орчныг бэхжүүлж, хариуцлагыг нэмэгдүүлнэ.
- Бизнесийн ёс зүй, Комплаенсын сайн туршлагыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- Шударга өрсөлдөөнийг дэмжих, бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлж байгаа авлигын хүчин зүйлсийг арилгана.
- Авлигын улмаас олсон хөрөнгө, орлогыг илрүүлэх, мөнгө угаах эрсдэлийг бууруулж, хуулийн этгээдийн хүлээх үүрэг, хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ.
- Авлигатай тэмцэх газрын төсөв, санхүү, хүний нөөцийн чадавхыг сайжруулах цогц арга хэмжээг авч олон улсын жишигт хүргэнэ.
- Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжид үнэлгээ хийж, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх замаар иргэдийн итгэл хүлээсэн шүүхийн тогтолцоог бэхжүүлнэ.
- Прокурорын байгууллагын томилгоо, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах замаар хараат бус байдлыг нэмэгдүүлнэ.
- Авлигын эрсдэлийг тодорхойлж, хариу арга хэмжээ авах тогтолцоог бүрдүүлнэ.
- Авлигатай тэмцэхэд төрийн аудитын байгууллагын үр нөлөөтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар Хөтөлбөрийн хэрэгжилтэд төрийн аудитын байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлнэ.
- Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын хэрэгжилтийг бүрэн хангана.
- Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцыг эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх үндэслэл болгон хэрэглэх, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг бусад улс оронтой байгуулах ажлыг эрчимжүүлж, дотоодын байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулна.
- Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн нас барсан, сураггүй алга болсон, оргон зайлснаас үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж, улсын орлого болгох тогтолцоог бүрдүүлнэ.
- Шаардлагатай бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.

- Төсвийн төлөвлөлтийн тогтолцоог урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулж, тэгш хүртээмжтэй, нээлттэй, олон нийтийн оролцоог хангах замаар бэхжүүлнэ.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэл, төлөвлөлт, ашиглалт, зарцуулалт, дуудлага худалдааг нээлттэй, боловсронгуй болгож, хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлнэ.
- Засгийн газрын өр, тусгай сан, гадаадын зээл, тусламжийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, менежментийг сайжруулах чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.
- Худалдан авах ажиллагааг хэрэгцээ, шаардлагад үндэслэн төлөвлөх, хяналт тавих, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгоно.
- Төрийн аудит, дотоод аудитын тогтолцооны хараат бус, ил тод, бие даасан байдлыг бэхжүүлнэ.
- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын томилгоог ил тод болгож, олон улсын хөрөнгийн зах зээлийн нээлттэй компанийн жишигт нийцсэн хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ.
- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, орлогыг завших, үрэгдүүлэх, мөнгө угаах эрсдэлийг бууруулж, хяналт, хариуцлагыг нэмэгдүүлнэ.
- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг холбогдох тооцоо, судалгаа, зардал, үр ашгийн тооцоонд үндэслэн үүсгэн байгуулах, татан буулгах, бүтцэд өөрчлөлт оруулах шалгуур, шаардлага, журмыг боловсронгуй болгоно.
- Байгалийн баялгийн орлого, үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, иргэнд тэгш, шударга хүртээнэ.
- Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг шинжлэх ухаан, технологийн дэвшил, судалгаанд суурилсан байдлаар төлөвлөн хэрэгжүүлнэ.
- Олон нийтийг авлигаас ангид байлгах, нийгмийн ёс суртахууныг дээшлүүлэх зорилгоор үндэсний контентыг бүтээж, түгээнэ.
- Ёс суртахуун, хүмүүжлийн ажлын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор бүх түвшний сургалтын агуулга, хөтөлбөрийг олон улсын туршлагад тулгуурлан шинэчлэлт, үнэлгээ хийж хэвшүүлнэ.
- Хүүхдийн шударга байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг бууруулах арга замаар ёс зүйн төлөвшлийг дэмжинэ.
- Төрийн албанд ёс зүйн шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж ажилд авах соёлыг төлөвшүүлж, тогтолцоог бүрдүүлнэ.
- Авлигын эрсдэлтэй үйл ажиллагаа, салбарын онцлог, нөхцөл байдалд чиглэгдсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагааг цогц байдлаар төлөвлөн хэрэгжүүлж, үр дүнг тооцож хэвшинэ.
- Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх, дотоод хяналтыг сайжруулах тусгайлсан бодлого, хөтөлбөр, тогтолцоог бий болгоно.

- Гамшгаас хамгаалах болон онц байдлын үеийн хариу арга хэмжээний санхүүжилт, хандив, тусламжийн үйл ажиллагаанд авлигаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох бодлогын баримт бичгийг боловсруулж, гүйцэтгэлийн мөрөөр авч хэрэгжүүлэх хяналт, хариуцлагыг нэмэгдүүлнэ.
- Ирээдүйд тулгарч болзошгүй нөхцөл байдлын үеийн авлигын эрсдэлийг тооцоолон хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, учирч болох хор хохирлоос урьдчилан сэргийлнэ.
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн зохион байгуулалт, тайлагналт, хяналт шинжилгээ, үнэлгээний үр нөлөөг дээшлүүлнэ.

- **Авлигын эсрэг хууль (2006 он)**

Авлигын эсрэг хуулийн зорилго нь авлигатай тэмцэх үйл ажиллагаа, авлигатай тэмцэх байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Тус хууль нь олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах, авлигатай тэмцэх байгууллага, түүний бүрэн эрх, авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны баталгааны талаар зохицуулдаг.

- **Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (2012 он)**

2012 онд батлагдсан тус хуулийн зорилт нь нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол болон хуулиар хүлээсэн албан үүрэг хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, хянах замаар нийтийн албаны үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх нөхцөлийг баталгаажуулж төрийн албаны ил тод, итгэл даах байдлыг хангахад оршино. Тус хууль ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, хуулийн хэрэгжилтийг хянах талаар зохицуулалтыг агуулдаг.

- **Эрүүгийн хууль (2015 он)**

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт Авлигын гэмт хэргийг тусгайлан хуульчилсан. Үүнд:

- Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйл /Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/;
- Эрүүгийн хуулийн 22.3 дугаар зүйл /Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах/;
- Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйл /Нийтийн албан тушаалтан хахууль авах/;
- Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйл /Хахууль өгөх/;
- Эрүүгийн хуулийн 22.6 дугаар зүйл /Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах/;
- Эрүүгийн хуулийн 22.7 дугаар зүйл /Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх/;

- Эрүүгийн хуулийн 22.8 дугаар зүйл /Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/;
- Эрүүгийн хуулийн 22.9 дүгээр зүйл /Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/;
- Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйл /Үндэслэлгүйгээр хөрөнгөжих/;
- Эрүүгийн хуулийн 22.11 дүгээр зүйл /Дураараа аашлах/;
- Эрүүгийн хуулийн 22.12 дугаар зүйл /Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах/;
- Эрүүгийн хуулийн 22.13 дугаар зүйл /Хахууль авах/ гэмт хэргийг тус тус хуульчилжээ.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлснээс хойш хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан. Тухайлбал, 2022 онд Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт авлигын гэмт хэргийн шинж, бүрэлдэхүүн, тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах, өршөөл үзүүлэхгүй байх гэх мэт хэд хэдэн асуудлыг хөнджээ.

Тухайн үеийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд *"...Манай улс авлигатай тэмцэх эрх зүйн орчин зохих түвшинд бүрдсэн ч Авлигын индексийн үзүүлэлт 2016 оноос тогтмол, огцом буурч байгаа нь авлигатай тэмцэх тогтолцооны үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай болохыг харуулж байна. Авлигын гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 2017 онд 658, 2018 онд 858, 2019 онд 894, 2020 онд 1020, 2021 онд 1144, шалгасан эрүүгийн хэрэг 2017 онд 427, 2018 онд 1138, 2019 онд 1300, 2020 онд 1331, 2021 онд 1307, шүүхээр шийдвэрлэсэн хэрэг 2017 онд 44, 2018 онд 84, 2019 онд 68, 2020 онд 114, 2021 онд 160 байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн тоо, шүүхээр шийдвэрлэж байгаа хэрэг өсөж байгааг харуулж байна. Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийн үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүн нь адил хэмжээний ял хариуцлага оногдуулахаар заасан байгааг ялгамжтай байхаар өөрчлөх, энэ бүлгийн зарим төрлийн гэмт хэргийн шинжийг тодорхой болгох, зарим гэмт хэргийг шинээр нэмж хуульчлах, Хахууль авах, Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн субъектийг зөвхөн нийтийн албан тушаалтнаар хязгаарлахгүй нийтийн албан тушаалтнаас бусад этгээд хамаарахаар өргөжүүлэх, оногдуулах ялын бодлогыг чангатгах зэрэг өөрчлөлтийг хийж авлигатай тэмцэх төрийн бодлогыг чангатгах шаардлагатай байна..."*[4] гэж үзжээ.

Судалгааны энэхүү хэсэгт дээрх хууль тогтоомж, хөтөлбөр арга хэмжээнээс Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан "Авлигын гэмт хэрэг"-ийг судлан үзнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Авлигатай тэмцэх байгууллагын хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах хэргийн тусгасан. Үүнд: Эрүүгийн хуулийн 22.1-22.13 дугаар зүйлд заасан гэмт хэрэг болон Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан авлигын гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад илрүүлсэн Эрүүгийн хуулийн 18.6

4 Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, ХЗДХЯ, (Уб, 2022).

дугаар зүйлд заасан “Мөнгө угаах” гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулахаар хуульчилжээ.

Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан “Авлигын гэмт хэрэг”-т Авлигатай тэмцэх газар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж байна.

Авлигатай тэмцэх газрын сүүлийн дөрвөн жилийн тайлангаас үзвэл:

Хүснэгт 1.4. *Гомдол, мэдээлэл шийдвэрлэлт*[5]

№	Үзүүлэлт	2020	2021	2022	2023
1	Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан	487	594	684	870
2	Харьяаллын дагуу шилжүүлсэн	27	44	52	44
3	Эрүүгийн хэрэг үүсгэсэн буюу хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн	462	460	621	701
4	Ажиллагаанд	44	46	56	55
Нийт шалгасан гомдол, мэдээлэл		1020	1144	1413	1670

Хүснэгт 1.5. *Шалгасан хэрэг*

Он	Хэргийн тоо	Өссөн, буурсан хувь	Холбогдогчийн тоо	Өссөн, буурсан
2020	1331	-	696	-
2021	1307	-1.8	909	+30.6
2022	1520	+16.2	1184	+30.2
2023	1837	+21.0	1402	+18.4

Дээрх 2 хүснэгтээс харвал, авлигын гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй хэргийн тоо жил ирэх тусам өсөж байна. Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийг зүйл, ангиар задлан үзвэл:

Хүснэгт 1.6. *Шалгасан хэрэг /төрлөөр/*[6]

№	Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг	Он			
		2020	2021	2022	2023[7]
1	22.1 дүгээр зүйл. Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах	799	820	1011	1011
2	22.3 дугаар зүйл. Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах	-	-	-	-
3	22.4 дүгээр зүйл. Нийтийн албан тушаалтан хахууль авах	-	-	-	-
4	22.5 дугаар зүйл. Хахууль өгөх	108	134	138	138
5	22.6 дугаар зүйл. Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах	-	-	-	-
6	22.7 дугаар зүйл. Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх	1	-	-	-
7	22.8 дугаар зүйл. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах	23	20	22	22
8	22.9 дүгээр зүйл. Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах	-	-	-	-
9	22.10 дугаар зүйл. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих	41	36	52	52
10	22.11 дүгээр зүйл. Дураараа аашлах	3	-	-	-

5 Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан номын тоон мэдээнээс, (2020, 2021, 2022 он)
6 Мөн тэнд.
7 Авлигатай тэмцэх газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан, 28 дахь тал.

11	22.12 дугаар зүйл. Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах	21	26	34	-
12	22.13 дугаар зүйл. Хахууль авах	207	225	239	239
13	Бусад	50	225	258	258
Нийт		1331	1543	1806	1806

Дээрх хүснэгтээс үзвэл, Авлигын гэмт хэргүүдээс Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд заасан “Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах” гэмт хэрэг хамгийн их үйлдэгдсэн байна.

Хүснэгт 1.7. *Шүүхээр шийдвэрлэгдсэн байдал*[8]

Он	Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо	Өмнөх онтой харьцуулахад өссөн, буурсан хувь
2020	114	-
2021	160	+40.3
2022	188	+17.5
2023	192	+2.1

Дээрхээс хүснэгтээс үзвэл, Авлигатай тэмцэх газраас тухайн жилд мөрдөн шалгасан нийт хэргийн 10 орчим хувь нь шүүхээр шийдвэрлэгдэж байна.

2022 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Эрүүгийн хуулийн 6.14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “...Энэ хуульд заасан хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт өршөөл, уучлал үзүүлэхгүй. Авлигын гэмт хэрэгт өршөөл үзүүлэхгүй...” гэж нэмэлт оруулсан. Мөн тус хуулийн 6.12 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “...22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн ялтныг хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоохгүй...” гэж заасан нь төрөөс авлигын гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулсан ялыг бүрэн бодитой эдлүүлэхэд чиглэсэн бодлого баримталж байгааг харуулж байна.

Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан 12 төрлийн авлигын хэргийг бүхэлд нь судлан үзэхэд цаг хугацаа, хөрөнгө санхүү ихээхэн орох учир энэхүү судалгааны хүрээнд Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэргийн талаар дэлгэрүүлэн судалсан болно.

3.1.2. Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан гэмт хэрэг зорилгодоо хүрсэн эсэх?

Үнэлгээ:

Монгол Улс 1996 онд Авлигын эсрэг хууль, 2002 онд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг баталж, 2005 онд НҮБ-ийн Авлигын эсрэг конвенцыг нэгдэн орж, 2006 онд Авлигын эсрэг хуулийг шинэчлэн баталж, 2007 онд Авлигатай тэмцэх газрыг байгуулсан.

ЭХХШтХ-ийн 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт АТГ-ын харьяалан шалгах хэргийг тусгайлан хуульчилсан бөгөөд үүнд Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд

8 АТГ-аас ирүүлсэн тоон мэдээ.

заасан “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэгт хамаарч байна. Манай улс анх 2002 оны Эрүүгийн хуулийн 270[1] дүгээр зүйлд “Хууль бусаар хөрөнгөжих” гэмт хэргийг 2012 онд тусгасан бөгөөд 2015 шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэг болгон хуульчилжээ.

Тус зүйлд 2022 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд өмнөх зохицуулалтыг нэмэлт, өөрчлөлттэй харьцуулан үзвэл:

Хүснэгт 1.8. *Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн зохицуулалт*

Зүйл, заалт	2015 оны Эрүүгийн хуулийн зохицуулалт	2022 оны нэмэлт, өөрчлөлт
22.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	Нийтийн албан тушаалтан өөрийн хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь хууль ёсны болохыг үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй бол үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж, нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	Нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Тайлбар: -Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан “их хэмжээ” гэдэгт нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгоно.
22.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	Энэ гэмт хэргийг улс төрд нөлөө бүхий этгээд үйлдсэн бол үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж, нийтийн албанд томилогдох, эсхүл сонгогдох эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	Энэ гэмт хэргийг улс төрд нөлөө бүхий этгээд үйлдсэн бол үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд 2022 онд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэгт оногдуулах ялыг чангатгасан байна.

Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэгт Авлигатай тэмцэх газар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байна.

Авлигатай тэмцэх газар Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэг 2020 онд 41 хэрэгт, 2021 онд 36, 2022 онд 52, 2023 онд 52 хэрэг, 2024 оны эхний хагас жилд 54 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулжээ.[9]

Манай улс 2012 онд “Хууль бусаар хөрөнгөжих” үйлдлийг Эрүүгийн хуульдаа гэмт хэрэг болгон тусгаснаар албан тушаалтны хууль бус орлогын цаана буй

9 АТГ-ын 2020, 2021, 2022, 2023, 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлангаас.

үйлдэл, эс үйлдэхүйг нотолж чадахгүйгээс албан тушаалаа урвуулан ашиг орлого олох гэмт явдалд эрүүгийн хариуцлага тооцох боломжгүй байсан нөхцөл байдал өөрчлөгдөж, Авлигын гэмт хэргийн хамгийн далд, нууц хэлбэрүүдтэй хийх тэмцэлд мэдэгдэхүйц ахиц гарсан гэж үзэж байсан боловч УДШ-ийн Практик судлалын хэлтэс, Судалгааны хүрээлэнгээс хийсэн судалгааны үр дүнгээс харахад харьцангуй цөөн тооны хэргийг 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 270[1], 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.10 дугаар зүйлд зааснаар зүйлчлэгдэж мөрдөн шалгах ажиллагаа явагдсан байх бөгөөд шүүхээр ял шийтгүүлсэн хэрэг цөөн байгаа нь хүлээсэн үр дүнгийн хувьд чамлалттай хэвээр байна[10] гэж үзжээ.

Нөгөөтээгүүр, Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн шинжийг зөв тодорхойлж нотлох ажиллагааг энэ гэмт хэргийн өөрийн онцлогт тулгуурлан явуулах нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт энэ төрлийн гэмт хэргийн хувьд хангагдах урьдач нөхцөл болно.

Shuukh.mn-д 2024 оны 09 дүгээр дугаар сарын 17-ны өдрийн байдлаар эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2015 оны Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” 13 хэрэг шийдвэрлэсэн байна. Үүнээс:

Хүснэгт 1.9. *Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдал*

№	Зүйл, заалт	Шийдвэрлэсэн хэргийн тоо
1	Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	12
2	Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг	1
Нийт		13

Тохиолдол 1.[11]

Хэргийн товч утга: “Ш.Н” нь Нийслэлийн прокурорын газрын Ерөнхий прокуророор ажиллаж байхдаа байгууллагын жолооч “Э.С”-ээр дамжуулан 2020 оны 7 дугаар сарын 20-ны өдөр Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэр Зайсангийн гүүр орчмоос 50,000,000 төгрөгийг, 2020 оны 8 дугаар сарын 27-ны өдөр Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Блю Скай /Blue Sky/ төвийн орчмоос 49,000,000 төгрөгийг тус тус бусдаас авсан, 2021 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Блю Скай /Blue Sky/ төвийн орчим –“Э.С”-д 50,000,000 төгрөг өгсөн, 2021 оны 6 дугаар сард Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороо, 8/8 дугаар байрны 37 тоот гэрээсээ 50,000,000 төгрөгийг “Э.С”-ээр авхуулж, Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Найман шарга” валют арилжааны төвд ам.долларoор солиулж авсан зэргээр өөрийн хөрөнгө, орлого их хэмжээгээр буюу 199,000,000 төгрөгөөр нэмэгдсэн нь хууль ёсны болохыг үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй гэх хэрэгт холбогджээ.

10 Авлига болон эдийн засгийн зарим гэмт хэргийн эрх зүйн шинж практик /гарын авлага/, УДШ, (Уб, 2022), 154 дэх тал.

11 ЧД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 2021/ШЦТ/516 дугаартай шийтгэх тогтоол.

ЧД-ийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс шүүгдэгч “Ш.Н”-ийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, Ш.Н-ийн нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жилийн хугацаагаар хасаж, арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний буюу арван дөрвөн сая төгрөгийн торгуулийн ял оногдуулах прокурорын саналыг шүүгдэгч хүлээн зөвшөөрсөн, хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд хуульд заасан журам зөрчигдөөгүй гэж үзэн торгох ял оногдуулж шийдвэрлэжээ

2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиас өмнөх буюу 2002 оны Эрүүгийн хуулийн 270[1] дугаар зүйлд заасан хууль бусаар хөрөнгөжих гэмт хэргээр шийдвэрлэгдсэн хэргүүдээс заримыг нь дурдвал:

Тохиолдол 2:

Хэргийн товч утга: “Р.Э” нь 2012 оноос 2015 оны хооронд Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төрийн нарийн бичгийн дарга, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга буюу нийтийн албан тушаалтнаар тус тус ажиллах үедээ 1,141,800,000 төгрөгийн үнэ бүхий Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, “Ривер гарден” хотхоны 302 дугаар байрны 6 давхрын 602 тоот, 344.8 м.кв талбайтай орон сууц, 2 ширхэг автомашины зогсоолын хамт худалдан авч, хөрөнгө нь их хэмжээгээр нэмэгдсэн боловч уг хөрөнгө хууль ёсны болохыг үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй гэх гэмт хэрэгт, “Ж.Г” нь найз “Р.Э””г үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг үйлдэхэд учрах саадыг арилган дэмжлэг үзүүлж хамтран оролцсон гэх гэмт хэрэгт тус тус холбогджээ.

ХУД-ийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс[12] “Р.Э”-д холбогдох хэргийг 2015 оны Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 3.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус заасныг журамлан, мөн хуулийн тусгай ангийн 22.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн хэргийг Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дэх хэсэг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 34.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтыг тус тус үндэслэн хэрэгсэхгүй болгож цагаатгаж шийдвэрлэсэн байна.

“Р.Э”-д холбогдох “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэргийг цагаатгаж шийдвэрлэсэнтэй холбоотойгоор “Ж.Г”-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгаж шийдвэрлэсэн байна. Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх[13], Улсын дээд шүүхээс[14] тус хэргийг хянан хэлэлцээд анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг шалгах, улмаар шүүх дээр албан тушаалтны гэм бурууг нотлоход энэ гэмт хэргийн шинж, бүрэлдэхүүний элементүүдийг хууль сахиулагч, прокурор, шүүгч нарийвчлан бусад төстэй гэмт

12 ХУД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 08 сарын 13-ны өдрийн 377 дугаар цагаатгах тогтоол.

13 Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 1011 дугаар магадлал.

14 Улсын дээд шүүхийн 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 121 дугаар тогтоол .

хэрэг эсхүл зөрчлүүдээс ялгах нь нэн чухал.[15]

Манай улсын хувьд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг Эрүүгийн хуульд тусгасан боловч тус хэргийн илрүүлэлт, шүүхээр шийдвэрлэгдэж буй байдал хангалттай түвшинд хүрээгүй байна.

Түүнчлэн, хууль хоорондын уялдаа холбоог хангах нь нэн чухал. Ялангуяа Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан Авлигын гэмт хэргийн хувьд практикт үйлдэгдэж буй тоо шүүхээр шийдвэрлэгдэж буй хэргийн тоотой харьцуулахад маш бага байх магадлалтай. Учир нь авлигын гэмт хэрэг нь нуугдмал гэмт хэрэг төдийгүй, тухайн хэргийн илрүүлэх, мөрдөн шалгах, гэмт хэрэг үйлдсэнийг нотлох, олж тогтоох ажиллагаа нарийн эзэдрээ төвөгтэй байдаг. Иймд зөвхөн Эрүүгийн хуульд авлигын гэмт хэргийн ялын бодлогыг чангатгах, хөөн хэлэлцэх хугацааг уртасгах, авлигын зарим гэмт хэрэг үйлдсэн ялтныг хорих ялыг хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоохгүй байх гэх мэт зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулснаар тухайн асуудал шийдэгдэхгүй.

Харин авлигын гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй АТГ-ын албан хаагчдыг чадавхжуулах, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, НҮБ-ын Авлигын эсрэг конвенц, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудын уялдаа холбоог сайжруулах, Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүн, шинжийг оновчтойгоор тодорхойлох гэх мэт илүү үр дүнтэй аргуудыг хэрэглэх нь зүйтэй.

Нөгөөтээгүүр, манай улсын хувьд хуулийн хоорондын уялдаа холбоо хангалтгүй байгаагаас авлигын гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрт ашигтай хуулийн зохицуулалтыг баримталж, ял завших явдал цөөнгүй байна.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн тухайд гэхэд Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "...Нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ..." гэж заасан. Энэхүү зохицуулалтын тайлбар хэсэгт "...их хэмжээгээр гэдгийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгоно..." гэж заажээ. Өөрөөр хэлбэл, 100.000.000 төгрөгөөс дээш хэмжээгээр нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлого нэмэгдсэн бол Эрүүгийн хуульд заасан "Үндэслэлгүйгээр хөрөнгөжих" гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцох үндэслэл болох юм.

Гэтэл Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "их хэмжээний хохирол" гэж тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгохоор заасан. Дээрхээс үзвэл, Эрүүгийн хуульд "их хэмжээ"-г ялгамжтай байдлаар хэрэглэх асуудал бий болж байна.

15 Авлигын болон эдийн засгийн зарим гэмт хэргийн эрх зүйн шинж, шүүхийн практик /гарын авлага/, 2022 он, УДШ, 131 дэх тал.

Түүнчлэн, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлд хориглох зүйлийг хуульчилсан тус зүйлийн 1.8-д "Үндэслэлгүйгээр хөрөнгөжих" зохицуулалтыг тусгасан бөгөөд энэ зүйлийн тайлбар хэсэгт "...Албан тушаалтан зургаан сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыгоо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй тохиолдолд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэж үзнэ..." гэж тодорхойлжээ.

Энэхүү тодорхойлолт нь үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэж үзэх мөнгөн дүнг Эрүүгийн хууль шиг нарийвчлан тусгаагүй боловч 6 сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыг үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй бол үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэж үзэхээр байна. Монгол Улсын хувьд албан тушаалтны дундаж цалин орлогыг 3 сая гэж бодвол 18 сая төгрөгийн хөрөнгө орлогоо хууль ёсны дагуу олсон болохоо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй бол Авлигын эсрэг хуульд зааснаар "Үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн" гэж үзнэ.

Дээрхээс дүгнэвэл, Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан "Үндэслэлгүйгээр хөрөнгөжих" гэмт хэргийн зохицуулалтын хохирлын хэмжээ гэхэд өөр хоорондоо болон бусад хуулийн зохицуулалттай уялдахгүй байна.

Энэ мэтчилэн хууль хоорондын уялдаа холбоогүй байдлаас үүдэн авлигын гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял завших, эрх зүйн хэм хэмжээний хийдэлтэй асуудлууд байсаар байна. Иймд Эрүүгийн хуулийн дээрх зохицуулалт зорилгодоо хангалттай хүрсэн гэж үзэх боломжгүй байна.

3.1.3. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн харьцуулсан судалгаа, олон улсын туршлага

Авлигын эсрэг олон улсын бүс нутгийн гурван том конвенц үндэслэлгүйгээр хөрөнгөжихийг гэмт хэрэгт тооцсон нь энэ үйлдлийг эрүүжүүлэх процесст шууд нөлөө үзүүлсэн гэж үздэг.

Авлигын эсрэг Америкийн улсуудын конвенц (IACAC-1996) анх үндэслэлгүйгээр хөрөнгөжих үйлдлийг гэмт хэрэг гэж зарласан бөгөөд Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх Африкийн Холбооны конвенц (AUCPCC-2003), Авлигын эсрэг НҮБ-ын конвенц (UNCAC-2003) тус тус үндэслэлгүйгээр хөрөнгөжих нь гэмт хэрэг болохыг хүлээн зөвшөөрсөн.[16]

Авлигын эсрэг Америкийн улсуудын конвенц нь үндэслэлгүйгээр хөрөнгөжихийг гэмт хэрэгт тооцож үндэсний хууль тогтоомждоо өөрчлөлт оруулахыг гишүүн улсуудад үүрэг болгосон бөгөөд бусад хоёр конвенц нь зөвлөмжийн чанартай байна.[17] Гэвч АНУ, Канад улс Авлигын эсрэг Америкийн улсуудын Конвенцын үндэслэлгүйгээр хөрөнгөжихийг гэмт хэрэгт тооцох тухай заалтад тайлбар гаргаж нэгдсэн байдаг.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенц болон Авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх Африкийн холбооны конвенцын үг хэллэгийн томьёолол нь улс орнуудад үндэслэлгүйгээр хөрөнгөжилтийн тухай хуулийг хэрэглэх эсэхийг өөрсдөө шийдэх боломж олгодог бол Авлигын эсрэг Америкийн улсуудын конвенцод нэгдсэн улс

16 Мөн тэнд, 129 дэх тал.

17 Мөн тэнд, 130 дахь тал.

орнууд үндэслэлгүйгээр хөрөнгөжихийг гэмт хэрэгт тооцох нь Үндсэн хуулиар олгогдсон эрхтэй зөрчилдөж байна гэж үзвэл гэмт хэргийн зүйл ангийг хууль тогтоомждоо нэвтрүүлэхээс татгалзаж болдог байна. Авлигын эсрэг Америкийн улсуудын конвенц болон Авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх Африкийн холбооны конвенц нь гэмт хэргийг харилцан зөвшөөрөх асуудлыг шууд авч үздэггүй ч аль алинд нь үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг нэвтрүүлээгүй оролцогч улсаас тус төрлийн гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд үзүүлэх тусламжийн талаар бараг ижил заалтууд байдаг.

НҮБ-ын Авлигын эсрэг конвенцын 20 дугаар зүйлд “үндэслэлгүйгээр хөрөнгөжих”–ийг тусгасан бөгөөд тус зохицуулалтыг манай улс *Хууль бусаар баяжих буюу “*Хууль бусаар баяжих санаатай үйлдлийг, өөрөөр хэлбэл, төрийн албан тушаалтан хөрөнгө нь их хэмжээгээр нэмэгдсэнийг өөрийнхөө хууль ёсны орлоготой холбогдуулан үндэслэлтэйгээр тайлбарлаж чадахгүй байгаа бол ийнхүү хөрөнгө нь нэмэгдсэнийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох хууль тогтоох болон бусад арга хэмжээг авах асуудлыг оролцогч улс бүр үндсэн хууль болон эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн авч үзнэ” гэж орчуулжээ.

Түүнчлэн, дэлхийн улс орон болгон “үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэх ойлголтыг харилцан адилгүй тодорхойлдог учир “үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэх нэр томьёог олон улсад нэг мөр ойлгон хэрэглэдэггүй. Энэхүү ойлголтыг “хууль бусаар хөрөнгөжих”, “үндэслэлгүйгээр ашиг хонжоо олох”, “шударга бусаар хөрөнгөжих”, “тайлбарлагдаагүй хөрөнгө чинээ”, “тайлбарлагдаагүй өмч” олж авах гэх мэтээр нэрлэн хэрэглэж байна.[18]

“Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” үйлдлийн олон улсын нэгдмэл тодорхойлолтыг бий болгохыг зорьсон зорилго нь нэг ижил ухагдахуунтай холбоотой ашиглагдаж байгаа олон төрлийн тодорхойлолт, үг хэллэгийг нэг мөр тодорхой болгох явдал байсан. Тухайлбал, “үндэслэлгүйгээр хөрөнгөжих” (illicit enrichment), “тайлбарлагдаагүй хөрөнгө чинээ” (unexplained wealth), “шударга бусаар хөрөнгөжих” (unjust enrichment) гэсэн нэр томьёонуудыг яг ижил, эсхүл тун төстэй нөхцөл байдлыг тодорхойлоход ижил утгаар хэрэглэсээр байна.[19] Тус нэр томьёоны ойлголтыг нэг мөр тодорхойлон хэрэглэхэд ээдрээ төвөгтэй учир хамгийн оновчтой байдлаар тодорхойлон хуульчлах нь нэн чухал юм.

Ихэнх улс орнуудад гэмт хэргийн хөрөнгийг мэдсэн атал шилжүүлсэн эсхүл үндэслэлгүйгээр олсон хөрөнгийг хүлээн авах нь иргэний эсхүл эрүүгийн хуулийн дагуу хариуцлага хүлээхээр заагдсан бөгөөд үүнд хамтран оролцох, хуйвалдаан, санаатайгаар үл тоомсорлох, хайхрамжгүй байдал, хуурамчаар түдгэлзэх эсхүл орхигдуулсан залилангийн үйлдэл хамаардаг.[20]

Түүнчлэн, Үндэслэлгүйгээр хөрөнгөжих (нийтийн албан тушаалтан нь тухайн хөрөнгийг хэрхэн олж авсан талаарх үндэслэлтэй тайлбарыг өгч чадахгүй тохиолдолд хууль бусаар олсон гэж үздэг), гадаад улсын нийтийн албан тушаалтны

18 Б.Мөнгөнсувд,Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг нотлох ажиллагаа, (2024), 5 дахь тал.

19 Эндрью Дорнбьерер, Үндэслэлгүй хөрөнгөжилт, Тайлбарлаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж боловсруулагчдад зориулсан гарын авлага, (2021), 16 дахь тал.

20 Жан-Пьер Бран, Анастасия Сотиропаолу нар, Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага / Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж, Хоёр дахь хэвлэл/, АТГ, УЕПГ, Дэлхийн банк, (2020), 65 дахь тал.

авлигын гэмт хэрэг хэд хэдэн улс оронд хуульчлагдаагүй байдаг. Шууд нэр томьёог нь орчуулбал, харилцан гэмт хэрэгт тооцогдохгүй нөхцөл байдал үүснэ. Энэ нь тухайн улсаас эрх зүйн туслалцааны хүсэлт хүсэх боломжгүй[21] байдлыг бий болгож байдаг. Иймд үндэслэлгүйгээр хөрөнгөжих үйлдэл нь гэмт хэрэгт тооцогддоггүй тохиолдолд тус үйлдлийг мөнгө угаах гэх мэт бусад гэмт хэрэгтэй холбон тайлбарлах шаардлагатай.[22]

Нөгөөтээгүүр, мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа гэмт хэрэг нь хүсэлт хүлээн авагч улсад өөр өөр нэршилтэй гэмт хэрэгт тооцдог байх боломжтой. Тухайлбал, нэг улсад үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэгт хамаарч байгаа үйлдлийг нөгөө улсад хахууль авах гэмт хэрэгт тооцдог байх боломжтой. Гадаад улсын нийтийн албан тушаалтны хахуулийн гэмт хэргийг хүсэлт хүлээн авагч улс оронд тухай улсын нийтийн албан тушаалтны хахуулийн гэмт хэрэг нэр томьёотойгоор хэрэглэдэг байх боломжтой. Тиймээс ч үндэслэлгүйгээр хөрөнгөжих хэргийг яллах нь зарим улсын хууль эрх зүйн зохицуулалтын давхар гэмт хэргийн шаардлагыг хангахад хүндрэл учруулж болзошгүй.

Эдүгээ дэлхийн 98 улсад Үндэслэлгүйгээр хөрөнгөжилтийн тухай хууль тогтоомжтой улс орнууд үндэслэлгүйгээр хөрөнгөжилтийн тухай Эрүүгийн хууль, Үндэслэлгүйгээр хөрөнгөжилтийн тухай Иргэний хууль, Шалгуур тогтоосон үндэслэлгүйгээр хөрөнгөжилтийн тухай Эрүүгийн хууль, Шалгуур тогтоосон үндэслэлгүйгээр хөрөнгөжилтийн тухай Иргэний хууль болон Үндэслэлгүйгээр хөрөнгөжилтийн тухай Захиргааны хуулийг хэрэглэж байна. Үүнээс Ази-Номхон далайн бүс нутагт 36, Африк тивд 25, Америк тивд 25, Европ тивд 2 байна.

Энэ хууль нь эх газрын болон Ром-Германы эрх зүйн бүлд харьяалагдах улсуудын аль алинд нь тархсан байх бөгөөд 47 нь Ром-Германы эрх зүйн бүл давамгайлсан улсад харьяалагдаж байгаа бол, 35 нь эх газрын бүл давамгайлсан улсад, 18 нь холимог тогтолцоотой байна. Эдгээр хууль тогтоомжийн ихэнх нь эрүүгийн эрх зүйд харьяалагдаж байгаа нь дэлхийн улс орнууд үндэслэлгүйгээр хөрөнгөжилтийг гэмт хэрэг гэж үзэж байгааг харуулж байна. Тодруулбал, тус 98 хуулийн 78 хууль нь эрүүгийн эсхүл шалгуур тогтоосон үндэслэлгүйгээр хөрөнгөжих Эрүүгийн хуулийн ангилалд, 18 нь иргэний эсхүл шалгуур тогтоосон үндэслэлгүйгээр хөрөнгөжилтийн тухай Иргэний хуулийн ангилалд багтаж байна. Үлдсэн 2 нь захиргааны эрх зүйн ангилалд хамаарч байна.[23] Манай улсын хувьд энэхүү ангиллын үндэслэлгүйгээр хөрөнгөжилтийн тухай Эрүүгийн хуультай улсад хамаарч байна.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг Франц, АНУ, Сингапур, Ирланд, Хонконгод хэрхэн хуульчилсан талаар судлан үзвэл:

ФРАНЦ УЛС

Франц улсын Эрүүгийн хуулийн 321-326 дугаар зүйлд дараах нөхцөл байдал тогтоогдсон бол тухайн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэж тооцно гэжээ. Үүнд:

21 Мөн тэнд, 254 дэх тал.

22 Мөн тэнд, 51-52 дахь тал.

23 Эндрью Дорнбьерер, Үндэслэлгүй хөрөнгөжилт, Тайлбарлаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж боловсруулагчдад зориулсан гарын авлага, (2021), 45 дахь тал.

- Хорих ялын доод хэмжээ 5 жил түүнээс дээш хорих ялтай гэмт хэрэг үйлдэхэд оролцсон нэг буюу түүнээс дээш этгээдтэй байнгын харилцаа холбоотой байдаг;
- Өөрийн амьжиргааны түвшин эсхүл эзэмшиж байгаа эд хөрөнгө худалдан авахад ашигласан эх үүсвэрээ үндэслэлтэйгээр тайлбарлаж, нотолж чадахгүй байгаа.

Өөрөөр хэлбэл, хэрэв сэжигтэн нь хөрөнгийн эх үүсвэрээ зөвтгөн тайлбарлаж чадахгүй байгаа эсхүл хууль ёсны орлогынхоо хүрээнд хөрөнгөө зөвтгөн тайлбарлаж чадахгүй байгаа бөгөөд ял шийтгэл авсан этгээдтэй тогтмол харилцаа холбоотой болохыг төр нотолбол түүнд ял шийтгэл оногдуулахаар хуульчилжээ.[24]

Энэ утгаараа прокурор нь хэрэгт холбогдож байгаа хөрөнгө чинээ нь салангид гэмт хэрэг эсхүл яллагдагч тухайн гэмт хэргийг үйлдсэн гэж нотлох шаардлагагүй байдгаараа үндэслэлгүйгээр хөрөнгөжилтийн тухай хуультай тун төстэй байна.

Түүнчлэн, хариуцагч нь өөрийн хөрөнгийн гарал үүсэл эсхүл хөрөнгөө хууль ёсны орлогын эх үүсвэрийн хүрээнд зөвтгөн тайлбарлаж чадаагүй тохиолдолд хариуцлага хүлээлгэдэг. Эдгээр ижил төстэй шинж байгаа ч үндэслэлгүйгээр хөрөнгөжилтийн тухай хуулиас ялгагдах шинж нь прокурор тухайн гэмт хэргийг өөр этгээд үйлдсэн болон 321-326 дугаар зүйлээр шийтгэгдсэн этгээд тус яллагдагчтай байнгын харилцаа холбоотойг нотлох шаардлага тавигддаг асуудал юм. Түүний улмаас эд хөрөнгийг хууль бус эх үүсвэртэй гэж үзэх таамаг нь яллагдагч нь эд хөрөнгийн эх үүсвэрээ зөвтгөн тайлбарлаж чадаагүй дээр зөвхөн үндэслэхгүй бөгөөд тухайн этгээд энэхүү гэмт хэргийг үйлдэл шийтгүүлсэн этгээдтэй харилцаа холбоотой гэсэн факт дээр мөн үндэслэдэг байна.[25]

Ял шийтгэл оногдуулах процесс хуулийн 321-6 дугаар зүйлд хэн нэгэн хүн “нэг буюу хэд хэдэн хүн өөрийн амьдралын хэв маягтай нийцүүлэн орлого, эсхүл хөрөнгийн эх үүсвэрээ тайлбарлаж чадаагүй бөгөөд энэ хэргийн улмаас, эсхүл хохирогчоос шууд болон шууд бусаар ашиг олсон тохиолдолд хүнд, эсхүл хүндэвтэр гэмт хэргийг байнга үйлдсэн гэж үзэж 5 жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж заасан. Энэ гэмт хэрэгт гурваас долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх ба шийтгүүлсэн хүний хөрөнгийг бүхэлд нь хураах боломжтой. Хөрөнгө хураах процесс хуулийн 131-21 дүгээр зүйлд шүүгдэгч хөрөнгийнхөө хууль ёсны эх үүсвэрийг баталж чадаагүй бол түүний хөрөнгийг бүхэлд нь хурааж болох талаар заасан. Энэ гэмт хэргийн улмаас шууд болон шууд бусаар ашиг олсон бол хамгийн багадаа таван жилийн хорих ял шийтгэгдэх ёстой.

Францын Эрүүгийн хуульд тухайн гэмт хэрэгт хариуцлага оногдуулахдаа зөвхөн тэр хөрөнгийг хууль бусаар олж авсан этгээдэд төдийгүй, түүнийг олж авахад тусалсан, хамжсан, энэ үйлдлийг нь хамгаалсан этгээдэд мөн хариуцлага хүлээлгэдэг. Гэхдээ өөрийн амьдралын амьжиргааны түвшин нь олж буй орлоготой харьцуулахад жирийн, тохирсон хэмжээнд байвал тэр хүний данс тооцоог шалгах боломжгүй гэж заасан[26] байдаг.

24 Мөн тэнд, 90 дэх тал.
25 Мөн тэнд, 87 дахь тал.
26 Ж.Батмөнх, Хууль бусаар баяжих гэмт хэргийг Монгол Улсын Эрүүгийн хуульд хуульчлах шаардлага, (Уб, 2011), 7 дахь тал.

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

АНУ-ын Эрүүгийн хууль тогтоомж нь жишгийн эрх зүйн тогтолцоотой улсын хувьд гол төлөв шүүгчийн урьд гаргасан шийдвэрийн үндсэн дээр бүрэлддэг жишгийн хууль, мөн зарим талаар хууль тогтоох байгууллагаас батлан гаргасан хуулиуд зэрэг олон тооны эрх зүйн хэм хэмжээнээс бүрдсэн байдаг.[27] Бараг муж улс бүр нь Эрүүгийн төрөлжсөн хуультай боловч эдгээр нь нийтлэг байдлаар жишгийн хуульд үндэслэж, түүнээс иш татсан байдаг.

АНУ-д хууль бусаар хөрөнгөжих/үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг тусдаа бие даасан гэмт хэрэг гэж тооцоход хүндрэлтэй байдаг. Учир нь үндэслэлгүйгээр хөрөнгөжихийг бие даасан гэмт хэрэг гэж үзэх нь эрүүгийн эрх зүйн зарим зарчмуудтай зөрчилддөг. Тиймээс ч АНУ, Канад улс Авлигын эсрэг Америкийн улсуудын конвенцод үндэслэлгүйгээр хөрөнгөжихийг гэмт хэрэгт тооцох тухай заалтад тайлбар гаргаж нэгдсэн байдаг бөгөөд тус улсын Үндсэн хуулиар баталгаажсан “шүүгдэгч гэм буруутай эсэхээ нотлох үүрэггүй”, “гэм буруу нь шүүхээр тогтоогдох хүртэл хэн ч гэм буруугүй”, “шүүгдэгчийн гэм бурууг төр нотлох” зарчмуудад харш гэж тайлбарласнаас үзвэл нотлох ажиллагааны зарим хэсгийг шүүгдэгчид шилжүүлэх байдлаар хялбаршуулан тогтоосон энэ процедурыг шилжилтийн үеийн эдийн засгийн сөрөг нөлөөтэй тэмцэх цаг хугацааны шалгууртай түр арга хэмжээ бөгөөд эрүүгийн эрх зүйн суурь үзэл баримтлалд цаашид оршин байх боломжгүй гэж үздэг бололтой.[28]

АНУ энэхүү тайлбартаа үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг нэвтрүүлэх нь АНУ-ын Үндсэн хууль болон эрх зүйн үндсэн зарчмуудтай (хариуцагчид шилжих нотлох үүргээс болж) зөрчилдөх тул тус гэмт хэргийг дотоодын хуульдаа тусгах шаардлагагүй гэж ойлгож байна гэсэн байдаг. Нөгөө талаас, АНУ дотоодын хууль тогтоомжоор олгогдсон бүхий л боломжийг ашиглан үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн хэргийг шалгаж буй бусад оролцогч орнуудад туслалцаа үзүүлж, хамтран ажиллана гэдгээ тодорхой илэрхийлжээ.[29]

Түүнчлэн, АНУ нь олон улсын гэрээ хэлцэлд тусгагдсан үндэслэлгүйгээр хөрөнгөжилтийн тухай зүйл, заалтын хэрэгжилтийг түдгэлзүүлэх шийдвэрийг хэд хэдэн удаа гаргаад байгаа ч тухайн этгээдийн хууль ёсны хөрөнгө орлоготой нийцэхгүй байгаа хөрөнгийг татвараас зайлсхийсэн гэж ялласаар ирсэн байдаг. Тухайлбал, HOLLAND V UNITED STATES хэрэгт прокурор буруутгагдаж буй этгээдийн хөрөнгө чинээ нь гурван жилийн хугацаанд түүний мэдүүлсэн хууль ёсны орлоготой илт нийцэхгүйгээр нэмэгдсэн болохыг нотолсноор түүнийг АНУ-ын Орлогын албан татварын тухай хууль (US internal revenue code)-ийн дагуу татвараас зайлсхийх зүйл ангиар яллаж, ял оногдуулсан. Гэхдээ энэ төрлийн хэрэгт “хүсэл зориг/сэдэл”-ийг “бие даасан/тусдаа нотлох баримт”-аар нотлох шаардлагатай бөгөөд “хөрөнгө орлогоо бууруулан мэдүүлсэн” гэх асуудал дээр үндэслэн дүгнэх боломжгүй байдаг нь үндэслэлгүйгээр хөрөнгөжилтийн тухай хуулиас ялгагдаж

27 Авлигын болон эдийн засгийн зарим гэмт хэргийн эрх зүйн шинж, шүүхийн практик /гарын авлага/, УДШ, (Уб, 2022), 26 дахь тал.

28 Ч.Хосбаяр, “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэг ба авлигын эсрэг олон улсын конвенцууд дахь түүний агуулга, Шударга ёс сэтгүүл, АТГ, (Уб, 2019), 11 дэх тал.

29 Эндрью Дорнбьерер, Үндэслэлгүй хөрөнгөжилт, Тайлбарлаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж боловсруулагчдад зориулсан гарын авлага, (2021), 175-176 дахь тал.

байгаа юм.[30]

СИНГАПУР

Авлигын эсрэг амжилттай тэмцсэн улсад Сингапур, Хонконг зүй ёсоор нэрлэгддэг. Тус улсуудад авлигын эсрэг үйл ажиллагаанд тухайн улсын авлигатай тэмцэх байгууллага голлох үүрэгтэйгээр оролцож, маш богино хугацаанд эерэг үр дүнд хүрсэн байдаг.

Тухайлбал, 2018 онд Сингапур Авлига, мансууруулах бодис наймаалах, бусад онц ноцтой гэмт хэргийн (ашиг хонжоог хураан авах) тухай хуульдаа 47АА зүйлийг нэмж оруулсан нь зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн мөнгө хөрөнгийг зөөгч (money mule) нарыг уг хуульд хамруулах зорилготой байсан юм. Энэхүү заалтаар “мансууруулах бодис наймаалах эсхүл бусад гэмт явдлын ашиг хонжоо гэж сэжиглэгдэж байгаа эд хөрөнгийг шууд эсхүл шууд бусаар эзэмшиж эсхүл ашиглаж байгаа төлөөний этгээд” нь тухайн эд хөрөнгийг хэрхэн олж авснаа үндэслэлтэйгээр тайлбарлаж чадахгүй бол гэм буруутайд тооцох зохицуулалтыг бий болгосон юм.

Сингапур нь Үндэслэлгүй хөрөнгөжилт /Тайлбарлагдаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж боловсруулагчдад зориулсан гарын авлага/-д тодорхойлсон “Шалгуур үзүүлэлт тогтоосон үндэслэлгүйгээр хөрөнгөжилтийн тухай эрүүгийн хуультай” улсын жагсаалтад хамаарч байна.

ИРЛАНД УЛС

Ирландын 1996 оны Гэмт хэргийн гаралтай орлогын тухай хууль нь үндэслэлгүйгээр хөрөнгөжилтийн тухай хуультай тун төстэй бөгөөд хөрөнгө хураан авахтай холбоотой зохицуулалтуудыг агуулсан байдаг.

Тус хууль нь иргэний эрх зүйн процесст тулгуурлах бөгөөд “хэрэв хариуцагч нь шууд эсхүл шууд бусаар гэмт хэргийн гаралтай орлогыг бүрдүүлж байгаа” эсхүл “хэсэгчлэн эсхүл бүхэлдээ шууд эсхүл шууд бусаар гэмт хэргийн гаралтай орлогыг ашиглаж эсхүл үүнтэй холбогдож байгаа хөрөнгө ашиглаж худалдаж авсан эд хөрөнгийг эзэмшиж эсхүл хяналтдаа байлгаж байгаа” бол тус хөрөнгийг хураан авах боломжтой гэж тодорхойлжээ. Үүнийг тогтоохдоо хууль сахиулах байгууллагын алба хаагчаас бүрдүүлсэн нотлох баримтад үндэслэсэн “итгэл үнэмшил”-д тулгуурладаг байна. Үүнээс гадна, энэхүү хууль нь үндэслэлгүйгээр хөрөнгөжилтийн тухай хуультай адилаар нотолгооны үүргийг хариуцагчид шилжүүлэх заалт агуулдаг. Хэрэв хариуцагч нь “тухайн өмч нь шууд эсхүл шууд бусаар гэмт хэргийн гаралтай орлогоос үүсээгүй” болохыг үндэслэлтэйгээр нотолж чадахгүй бол шүүх нь хөрөнгө хураах шийдвэр гаргадаг байна.[31]

Мөн энэхүү хуульд шүүх нь хариуцагчид холбогдох эд хөрөнгийн жагсаалт болон эдгээрийг эзэмших, худалдан авахтай холбоотой ашигласан орлогын эх үүсвэрээ тодорхойлох мэдүүлэг шүүхэд гаргаж өгөх захирамж гаргаж болох заалт байдаг.[32]

30 Мөн тэнд, 89 дэх тал.

31 Эндрью Дорнбьерер, Үндэслэлгүй хөрөнгөжилт, Тайлбарлаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж боловсруулагчдад зориулсан гарын авлага, (2021), 84 дэх тал.

32 Мөн тэнд.

Ирландын Эрүүгийн (Авлигын гэмт хэрэг) хуулийн 16 дугаар зүйл үндэслэлгүйгээр хөрөнгөжилтийн тухай хуультай төстэй шинжийг агуулж байна. Тус зүйлийн дагуу, хэрэв тусдаа хянан шийдвэрлэх ажиллагааны үеэр төрийн албан хаагч нь "бүртгүүлэх ашиг сонирхлын мэдүүлэг"-тээ тусгаагүй хөрөнгө эзэмшиж байгаа нь мэдэгдвэл түүний эх үүсвэрийг "авлигажсан хөрөнгөжилт гэж үзэх таамаг" дэвшүүлэх боломж бүрддэг байна. Энэ тохиолдолд энэхүү таамгийг үндэслэлтэй няцааж чадаагүй бол тухайн хөрөнгө нь "албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, бусдад давуу байдал бий болгосныг урамшуулж, шагнаж, эсхүл хүлээн зөвшөөрсний үндсэн дээр олж авсан бэлэг, шагнал, давуу байдлаас шууд эсхүл шууд бусаар олж авсан эд хөрөнгө" гэж дүгнэдэг байна. Гэхдээ энэ заалтыг хэрэглэхийн тулд авлигын гэмт хэрэг хянан шийдвэрлэх тусдаа ажиллагаа явагдсан байх шаардлагатай тул тус бүтээлд мөн л үндэслэлгүйгээр хөрөнгөжилтийн тухай хууль тогтоомжуудын жагсаалтад оруулаагүй болно.[33]

ХОНКОНГ[34]

1950-аад оны эхээр, Хонконг албан ёсны цалин хөлс нь эзэмшиж байгаа хөрөнгө эсхүл амьдралын хэв маягтай нь нийцэхгүй байгаагаа үндэслэлтэйгээр тайлбарлаж чадахгүй байгаа төрийн албан хаагчид сахилгын шийтгэл оногдуулах зохицуулалтыг нэвтрүүлжээ. Энэ нь Хонконгийн 1971 онд хүчин төгөлдөр болсон Үндэслэлгүйгээр хөрөнгөжилтийн тухай хуулийн эхлэл болсон.[35] Авлигын түвшнээр Азид тэргүүлдэг байсан ХонКонг үндэслэлгүйгээр хөрөнгөжихийг гэмт хэрэгт тооцсоноос хойш авлигагүй орнуудыг нэг болсон гэж зарим судлаачид үздэг.

Хонконгийн Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд "Үндэслэлгүйгээр хөрөнгөжих"-ийг тодорхойлохдоо:

Тайлбарлагдаагүй өмч эзэмших гүйцэтгэх захирлын эсхүл төрийн албан тушаалд ажиллаж байсан/ байгаа хувь хүн нь:

(a) Одоо хашиж байгаа эсхүл өмнө нь хашиж байсан албан тушаалын цалин хөлстэй үл нийцэх амьжиргааны түвшинтэй;

(b) Одоогийн эсхүл өмнөх албан ёсны цалин хөлстэй нийцээгүй мөнгөн хөрөнгө өмчийг хянаж байгаа бол;

Уг амьжиргааны түвшнийг хэрхэн хангаж байгаа, санхүүгийн эх үүсвэр эсхүл өмчийг хэрхэн эзэмших болсон тухай хангалттай тайлбарыг шүүхэд гаргаж чадахгүй бол түүнийг тус зохицуулалтаар гэм буруутайд тооцно.

Тухайн зохицуулалтаар гэм буруутайд тооцогдсон тохиолдол нэг сая Хонконг доллартой тэнцэх хэмжээгээр торгож, 10 жилийн хугацаагаар хорих; харин Тангарагтны шүүх эсхүл энгийн шүүхээр шийдвэрлэх шаардлагагүй хөнгөн хэргийн хувьд 10 дугаар зүйлд зааснаар 500.000 Хонконг доллартой тэнцэх хэмжээгээр торгож, 3 жилийн хугацаагаар хорих ял оногдуулна. 1 дүгээр дэд хэсэгт заасан ял шийтгэлээс гадна шүүхээс 10 дугаар зүйлийн 1(b)-д заасан гэмт хэрэг үйлдсэн

33 Мөн тэнд, 85 дахь тал.

34 Б.Мөнгөнсувд,Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг нотлох ажиллагаа, (Уб, 2024), 17 дахь тал.

35 Эндрью Дорнбьерер, Үндэслэлгүй хөрөнгөжилт, Тайлбарлаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж боловсруулагчдад зориулсан гарын авлага, (2021), 22 дахь тал.

этгээдэд дараах дүнгээр Засгийн газарт торгууль төлөх үүрэг хүлээлгэж болно. Үүнд: Санхүүгийн эх үүсвэрээс нь хэтрэхгүй хэмжээтэй тэнцүү дүнгээр; эсхүл шүүхэд хангалттай тайлбарлаж чадаагүй өмчийн үнийн дүнгээс хэтрээгүй дүнгээр.

Хонконгийн Үндэслэлгүйгээр хөрөнгөжилтийн тухай Эрүүгийн хуулийн 10 дугаар бүлэгт зааснаар хариуцагч өөрийн өнгөрсөн эсхүл одоогийн албан ёсны цалин хөлсөнд үл нийцэх амьжиргааны түвшин эсхүл эд хөрөнгө эзэмшиж, өмчлөх болсноо үндэслэлтэйгээр тайлбарлаж чадахгүй бол түүнийг гэм буруутайд тооцдог байна.

Дээрхээс дүгнэвэл, Авлигын эсрэг олон улсын бүс нутгийн гурван том конвенц үндэслэлгүйгээр хөрөнгөжихийг гэмт хэрэгт тооцсон нь энэ үйлдлийг эрүүжүүлэх процесст шууд нөлөө үзүүлсэн. Авлигын эсрэг Америкийн улсуудын конвенц (1996) анх үндэслэлгүйгээр хөрөнгөжих үйлдлийг гэмт хэрэг гэж зарласан бөгөөд Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх Африкийн холбооны конвенц (2003), Авлигын эсрэг НҮБ-ын конвенц (2003) тус тус үндэслэлгүйгээр хөрөнгөжих нь гэмт хэрэг болохыг хүлээн зөвшөөрсөн.

Энэхүү 3 конвенцоос Авлигын эсрэг Америкийн улсуудын конвенц нь үндэслэлгүйгээр хөрөнгөжихийг гэмт хэрэгт тооцож үндэсний хууль тогтоомждоо өөрчлөлт оруулахыг гишүүн улсуудад үүрэг болгосон байхад бусад хоёр конвенцод зөвлөмжийн чанартай тусгагджээ.[36]

Дээрхээс дүгнэвэл, Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэх нэр томьёог улс орон бүр харилцан адилгүй байдлаар томьёолон хэрэглэж байна. Түүнчлэн, үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй холбоотой харилцааг иргэн, эрүү, захиргааны журмаар өөр өөрөөр харьяалуулан шийдвэрлэж байгаа улс орнууд ч цөөнгүй байна. Харин улс хоорондын эрх зүйн туслалцаа үзүүлэх асуудалд нь тухайн улсад үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг хуульчилсан эсэхээс хамаарч тухайн асуудлыг хэрхэн шийдвэрлэх арга зам өөр өөр байна. Учир нь улс орнууд нэг нэгэндээ эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх нөхцөл нь давхар гэмт хэрэгт тооцох зарчим буюу хүсэлт гаргагч улсад мөрдөж буй гэмт хэрэг нь нөгөө улсад мөн гэмт хэрэгт тооцогдох асуудал байдаг. Нөгөөтээгүүр, үндэслэлгүйгээр хөрөнгөжих хэргийг шалгах олон улсын хамтын ажиллагаанд саад тотгор учруулдаг зүйл бол үндэслэлгүйгээр хөрөнгөжихийг гэмт хэрэгт тооцдоггүй улс орнууд энэхүү зарчмыг баримталдаг явдалтай холбоотой байна.

3.1.4. Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйл заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх? Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны асуудал.

Үнэлгээ:

Эрх зүйн шинжлэх ухаанд хөөн хэлэлцэх хугацааны ойлголт Ромын эрх зүйн үеэс үүсэн бий болж хөгжиж байгаа боловч эрүүгийн эрх зүй дэх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны ойлголт нь иргэний эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацааны ойлголтоос хожуу бий болсон. Орчин үед эрүүгийн эрх зүй дэх хөөн хэлэлцэх

36 Ч.Хосбаяр, “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэг ба авлигын эсрэг олон улсын конвенцууд дахь түүний агуулга, Шударга ёс сэтгүүл, АТГ, (Уб, 2019), 11 дэх тал.

хугацааны эрх зүйн зохицуулалт нь эх газрын бүлийн улс орнуудад түгээмэл хэрэглэгддэг. Харин жишгийн эрх зүйн бүлийн улс орнуудад хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэх нь маш хязгаарлагдмал байдаг бөгөөд хуулийн дагуу зөвхөн хүнд гэж тооцогддоггүй хэргүүдэд хэрэглэх боломжтой байдаг.[37]

Эрх зүйн шинжлэх ухааны хөгжлийн явцад Эрүүгийн хуульд тусгагдсан хөөн хэлэлцэх хугацааны ойлголт нь харьцангуй тогтсон ойлголт юм. Хөөн хэлэлцэх хугацааны ойлголт нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлж байгаа үндэслэлийн нэг болно. Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх гэдэг нь гэмт хэргийн нийгмийн аюулын хэр хэмжээ болон гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдлыг харгалзан түүнд хуульд заасан үндэслэлийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байхыг ойлгодог. Эрүүгийн хариуцлагаас чөлөөлж байгаа үндэслэл нь сонгох болон заавал чөлөөлөх гэсэн хоёр төрөлтэй бөгөөд эрүүгийн хариуцлагаас заавал чөлөөлөх үндэслэл нь шүүхээс үл хамааран бий болдог. Улс орнуудын Эрүүгийн хуульд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа буюу эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаа өнгөрсөн тохиолдолд эрүүгийн хариуцлагаас заавал чөлөөлөхөөр заасан байна.[38]

Улс орнууд эрүүгийн хуульдаа гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа хэзээ эхлэх, түдгэлзэх, үргэлжлүүлэн тоолох, зогсох буюу тасрах, дуусгавар болох болон ямар гэмт хэрэгт хэрэглэхгүй байхыг нарийвчлан зохицуулж байна.[39] Мөн авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан хөөн хэлэлцэх хугацааны ерөнхий зориулалтаар зохицуулагдан хэрэгждэг.

Манай улсын хувьд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд зааснаар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг зорчих эрхийг хязгаарлах болон хорих ялын хэмжээнээс хамааруулан тоолохоор хуульчилсан. Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлсний дараагаар практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, эрх зүйн хийдэлтэй байсан зохицуулалтуудын нэг нь Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалт байсан. Учир нь:

1. Торгох ялтай буюу хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн яаж тоолох нь хуульчлагдаагүй орхигдсон;

2. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.1, 1.2-т заасан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилдөн эрх зүйн хийдлийг бий болгосон;

3. Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн ангиллыг үл харгалзан тогтоосон нь зарим хийдэл, зөрчил, ойлгомжгүй байдлыг үүсгэсэн, гэмт хэргийн ангиллыг ач холбогдолгүй болгосон;

4. Хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалтыг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн тухайн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах хүртэл тоолох уу, эсхүл анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолох уу гэдэг нь эргэлзээтэй;

5. Зорчих эрхийг хязгаарлах ялтай гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох вэ? Түдгэлзүүлсэн ял дээр хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэх нь зөв эсэх асуудлууд үүсээд байсан билээ.

37 Х.Сэлэнгэ, Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа: Онол, практикийн асуудал, (Уб, 2024), 3-4 дэх тал.

38 Мөн тэнд , 4 дэх тал.

39 Мөн тэнд.

Иймд тус эрх зүйн хийдэл бүхий зохицуулалтад 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт оруулсан. Гэвч энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр тус зохицуулалтын эрх зүйн хийдлийг бүрэн арилгаж чадаагүй гэж үзэж болохоор байгаа юм.

2002 оны Эрүүгийн хуулиар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн ангиллаас /хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд/ нь хамааруулан тоолдог байсныг 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар өөрчлөн ялын доод болон ялын дээд хэмжээнээс хамааруулан ялгамжтай байдлаар тоолохоор зохицуулсан нь эрх зүйн шинэчлэлийн хүрээнд нэлээдгүй ахиц дэвшлийг авчирсан нь сайшаалтай ч зарим гэмт хэргүүд дээр гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь ойлгомжгүй байдлаар хуульчлагджээ.

Шинэ батлагдсан Эрүүгийн хуульд 209 төрлийн гэмт хэрэг хуульчлагдсанаас 83[40]-н гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь эргэлзээтэй, ойлгомжгүй байдлыг үүсгээд байсан. Эрүүгийн хуульд хорих, зорчих эрхийг хязгаарлах, торгох, эрх хасах, нийтэд тустай ажил хийлгэх гэсэн 5 төрлийн ялыг оногдуулахаар тусгаснаас эрх хасах ял нь нэмэгдэл ял бусад нь үндсэн ял.[41] Гэтэл хууль тогтоогч хорих болон зорчих эрхийг хязгаарлах гэсэн 2 төрлийн ялтай гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тоолохоор хуульчлан өгчээ. Өөрөөр хэлбэл, энэ хуулиар хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхээр заасан торгох ялтай гэмт хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолохыг зохицуулаагүй байсан юм. Энэ мэтчилэн эргэлзээтэй, хийдэлтэй зохицуулалтын улмаас хүний эрхийг зөрчих нь хуулийн зорилго, ач холбогдлыг алдагдуулж байсан билээ.

Харин 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан нэмэлт, өөрчлөлт нь дээр дурдсан эрх зүйн хийдлийг арилгах, засаж сайжруулах боломжийг бүрдүүлсэн томоохон алхам болсон гэж үзэж болох ч зарим хийдэлтэй зохицуулалт байсаар байна. Өөрөөр хэлбэл, тус зохицуулалттай холбоотой эрх зүйн хийдлийг 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр бүрэн арилгаж чадаагүй, харин эрх зүйн хийдлийг арилгах эхлэл тавигдсан гэж үзэж болох юм.

Одоогийн бидний дагаж мөрдөж буй Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалтад дор дурдсан асуудлууд үүссэн хэвээр байна. Үүнийг өмнөх зохицуулалттай харьцуулан үзвэл:

Асуудал 1. 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан /хүснэгт 1.10-т дурдсан/ хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялтай гэмт хэргүүдийн хувьд ялын хэмжээгээр хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох вэ? гэсэн асуудал бий болж байсан.

Учир нь 2015 оны Эрүүгийн хуульд зааснаар хорих ялын доод хэмжээ нь 1 жил, дээд хэмжээ нь 8 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг 5 жил байхаар хуульчилсан боловч дээрх гэмт хэргүүдийн хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээ 6 сараас эхэлж байсан нь тус хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.2 дахь заалт нь хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээ болох 1 жилд хүрэхгүй байна. Өөрөөр хэлбэл, хорих

40 Дэлгэрэнгүйг хүснэгт 1.10, 1.11-ээс үзнэ үү.

41 Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 5.2 дугаар зүйлд ялын төрлийг хуульчилсан.

ялын доод хэмжээ нь 1 жил хүрэхгүй байгаа учраас энэхүү заалтаар хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь ойлгомжгүй байсан.

Мөн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.1 дэх заалтад зааснаар хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээг 1 жил түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг 1 жил байхаар тогтоосон. Гэтэл зарим гэмт хэргийн хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээ 6 сараас эхэлж байгаа ч ялын дээд хэмжээ нь 5 хүртэл жил байгаа нь гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг 1 эсхүл 5 жилийн аль хугацаагаар тоолох нь эргэлзээтэй байдлыг бий болгож байлаа.

Энэхүү асуудал нь Эрүүгийн хуульд эрх зүйн хийдлийг бий болгож, зайлшгүй засаж сайжруулах шаардлагатай зохицуулалтын нэгд зүй ёсоор тооцогдох болсон. Тиймээс 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар гэмт хэргийн хөөн хэлэлцэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтад хэд хэдэн нэмэлт, өөрчлөлт оруулсан юм. */Дэлгэрэнгүйг "Хүснэгт 1.10"-ийн тайлбар хэсгээс үзнэ үү/*

Хүснэгт 1.10. *Хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялтай гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа*

2015 оны Эрүүгийн хуулийн зохицуулалт				Тайлбар
№	Зүйл, заалт	Ялын доод хэмжээ	Ялын дээд хэмжээ	
1	10.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	2020 оны 1 сарын 10-ны өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.5-д "...энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш гурван жил өнгөрсөн" нь тогтоогдвол яллагдагчаар татаж болохгүй гэж нэмж хуульчилсан байна. Ийнхүү тус заалт Эрүүгийн хуульд нэмэгдсэнээр 1 эсхүл 5 жилийн алинаар нь гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох нь эргэлзээтэй байдал үүсгээд байсан 53 зохицуулалтаас 50 зохицуулалтад нь 3 жилийн хугацаагаар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох боломжийг бүрдүүлсэн юм. Энэхүү эрх зүйн хийдэл бүхий 53 хэргээс онцлог 1 хэргийг тусгайлан тайлбарлавал:
2	11.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
3	11.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
4	11.4 дүгээр зүйлийн 2.3 дахь заалт	6 сар	3 жил	
5	11.7 дугаар зүйлийн 2.3 дахь заалт	6 сар	2 жил	
6	12.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил	
7	12.5 дугаар зүйлийн 2.2 дахь заалт	6 сар	3 жил	
8	13.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил	
9	14.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	2 жил	
10	15.1 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	3 жил	
11	17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
12	17.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
13	17.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	2 жил	
14	17.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	2 жил	
15	18.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
16	18.4 дүгээр зүйлийн 2.2 дахь заалт	6 сар	3 жил	
17	18.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил	
18	18.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил	
19	18.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
20	18.16 дугаар зүйлийн 2.2 дахь заалт	6 сар	3 жил	
21	19.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
22	19.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
23	19.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил	
24	19.15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
25	19.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	3 жил	
26	19.16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	

27	19.17 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил	2015 оны Эрүүгийн хуульд заасан хорих ялгүй, зорчих эрхийг хязгаарлах ялтай нийт 48 хэрэг байснаас гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь эргэлзээтэй нэг хэрэг байсан нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 15.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх” гэмт хэрэг юм. Учир нь тус хуулийн 15.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “...эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ...” гэж заасан. Өөрөөр хэлбэл энэхүү зохицуулалт нь 2015 оны Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.1 болон 1.2 дахь заалтад аль алинд нь хамаардаггүй байсан. Харин 2020 оны 1 сарын 10-ны өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.5-д “... эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш гурван жил өнгөрсөн” гэсэн заалт нэмж хуульчилснаар тус зохицуулалтад тоолох хөөн хэлэлцэх хугацаа 3 жил болсон юм.
28	20.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
29	21.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил	
30	21.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	3 жил	
31	21.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
32	22.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
33	22.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг	6 сар	3 жил	
34	22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
35	22.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
36	22.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
37	22.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
38	23.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
39	23.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	3 жил	
40	23.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
41	23.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	2 жил	
42	25.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	3 жил	
43	25.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
44	25.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
45	25.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил	
46	26.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил	
47	27.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил	
48	27.10 дугаар зүйлийн 2.4 дэх заалт	6 сар	3 жил	
49	28.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил	
50	13.5 дугаар зүйлийн 2.2 дахь заалт	3 сар	2 жил	Эрүүгийн хуулийн 13.5 дугаар зүйлийн 2.2 дахь заалтад оногдуулах хорих ялын доод хэмжээг 3 сар байхаар хуульчилж өгсөн байсан нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар “... 6 сараас 20 жил хүртэл хугацаагаар .... хорих ялыг эдлүүлнэ” гэж заасантай зөрчилдөж байсныг 2020 оны 1 сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулж хорих ялын доод хэмжээг 6 сар болгон ЭХЕА-ийн зохицуулалтад нийцүүлсэн байна.
51	17.1 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	5 жил	Энэхүү 3 зохицуулалтын хувьд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь 1 эсхүл 5 жилийн аль алинд нь хамаарсан хэвээр байна.
52	17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	5 жил	
53	17.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	5 жил	

2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан нэмэлт, өөрчлөлт нь дээр дурдсан асуудлыг засаж сайжруулах боломжийг бүрдүүлсэн хэдий ч Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 17.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь эргэлзээтэй хэвээр байгаа юм.

Учир нь тус зохицуулалтууд нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 1.2 дахь заалтад заасан “...хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээ найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон...” гэсэн заалтад мөн 2020 оны 1 сарын 10-ны өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.5-д “...энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд

хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон," гэж нэмж хуульчилсан заалтад ч хамаарахгүй байна. Өөрөөр хэлбэл, дээрх 3 зохицуулалт нь одоог хүртэл эрх зүйн хийдэлтэй хэвээр байна.

Асуудал 2. 2015 оны Эрүүгийн хуулийн 6 бүлгийн 30 зүйл, заалтад зөвхөн торгох ял оногдуулахаар хуульчилсан байна. Гэтэл тус хуульд хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялтай гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тоолохоор хуульчилж өгсөн учир торгох ял[42] оногдуулахаар заасан хэргүүдэд хэрхэн хөөн хэлэлцэх хугацааг тоолох нь ойлгомжгүй байсан юм.

Харин 2020 оны 1 дүгээр сарын 10 өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт "...Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдэж энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан бол тухайн зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай адил байдлаар хөөн хэлэлцэх хугацааг тоолно..." гэж нэмж хуульчилснаар зөвхөн торгох ял оногдуулахаар хуульчилсан хэргүүд буюу хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан заалтуудад гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тоолох боломжийг бүрдүүлсэн.

Хүснэгт 1.11. *Хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа*

№	Зүйл, заалт	Торгох ялын хэмжээ	Хөөн хэлэлцэх хугацаа/2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт/	
			Тухайн зүйлийн 1 дэх хэсэгт заасантай ижил хугацаагаар тогтоовол	Хуулийн этгээд хариуцлага хүлээлгэхээр заасан заалтын дээд хэсэгт заасан ижил хугацаагаар тогтоовол
1	18.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	10.000-80.000 нэгж	1 жил	1 жил
2	18.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	20.000-120.000 нэгж	3 жил	5 жил
3	18.5 дугаар зүйлийн 5 дахь хэсэг	200.000-400.000 нэгж	1 жил	12 жил
4	18.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	100.000-400.000 нэгж	1 жил	12 жил
5	18.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	100.000-400.000 нэгж	5 жил	12 жил
6	18.8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	10.000-80.000 нэгж	3 жил	12 жил
7	18.9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг	10.000-80.000 нэгж	3 жил	12 жил
8	18.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	10.000-80.000 нэгж	1 жил	1 жил
9	18.13 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	10.000-80.000 нэгж	3 жил	5 жил
10	20.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	40.000-200.000 нэгж	5 жил	20 жил
11	20.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	40.000-200.000 нэгж	5 жил	12 жил
12	20.11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг	20.000-120.000 нэгж	5 жил	5 жил
13	20.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг	200.000-400.000 нэгж	5 жил	5 жил
14	20.12 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	10.000-80.000 нэгж	5 жил	5 жил
15	20.12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	20.000-120.000 нэгж	5 жил	5 жил

42 Зөвхөн торгох ялтай гэмт хэргүүдийн хувьд 10.000-80.000, 20.000-100.000, 20.000-120.000, 40.000-200.000, 120.000-400.000, 200.000-400.000 нэгжтэй тэнцэх хэмжээгээр торгох ял оногдуулахаар хуульчилсан байна.

16	20.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	20.000-120.000 нэгж	5 жил	5 жил
17	20.14 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг	20.000-120.000 нэгж	3 жил	5 жил
18	20.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг	200.000-400.000 нэгж	3 жил	5 жил
19	22.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	120.000-400.000 нэгж	3 жил	5 жил
20	24.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг	20.000-120.000 нэгж	5 жил	5 жил
21	24.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг	40.000-200.000 нэгж	5 жил	5 жил
22	24.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	20.000-120.000 нэгж	5 жил	5 жил
23	24.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	120.000-400.000 нэгж	5 жил	5 жил
24	24.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	20.000-120.000 нэгж	5 жил	5 жил
25	24.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	40.000-200.000 нэгж	5 жил	5 жил
26	24.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	120.000-400.000 нэгж	12 жил	12 жил
27	24.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	20.000-120.000 нэгж	1 жил	5 жил
28	24.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	120.000-400.000 нэгж	12 жил	12 жил
29	25.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	10.000-80.000 нэгж	1 жил	5 жил
30	25.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг	10.000-80.000 нэгж	3 жил	5 жил

Гэсэн хэдий ч тус зохицуулалт нь хэд хэдэн асуудлыг бий болгож байна. Үүнд:

1. 1.Тус хуулийн Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт "...тухайн зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай адил байдлаар хөөн хэлэлцэх хугацааг тоолно..." гэж заасан. Гэтэл энэхүү заалтыг хэд хэдэн утгаар ойлгон хэрэглэж болохоор байгаа юм. Тухайлбал, тус хуулийн 22.5 дугаар зүйл гэхэд 3 хэсгээс бүрдэж байна. 22.5 дугаар зүйлийн 1, 2-т заасан зохицуулалтуудад зорчих эрхийг хязгаарлах болон хорих ял оногдуулахаар заасан буюу хөөн хэлэлцэх хугацаа тоолох боломжтой. Тэгвэл хуулийн этгээд Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээх боловч тухайн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг 22.5 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг яг аль хэсгээр нь тоолох нь ойлгомжгүй.

Хүснэгт 1.12. *Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйл*

№	Зүйл, заалт	Хөөн хэлэлцэх хугацаа
1	22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	3 жил
2	22.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	5 жил

2. Хэрэв тухайн зүйлийн 1 дэх хэсэгт заасантай ижил хугацаагаар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолно гэвэл дараах асуудал үүсэж болохоор байна:

- Торгох ялын хэмжээ ижил хэр нь хөөн хэлэлцэх хугацаа ялгамжтай байдлаар тоологдохоор байна. Тухайлбал, 10.000-80.000 нэгжийн торгох ялтай 8[43]-н хэргийн хувьд 3 хэрэгт нь 1 жил, 4 хэрэгт нь 3 жил, 1 хэрэгт нь 5 жилийн хугацаагаар тус тус хөөн хэлэлцэх хугацааг тоолохоор байгаа юм.
- Торгох ялын хэмжээ нь бага хэр нь хөөн хэлэлцэх хугацаа нь бусад хэрэгтэйгээ харьцуулахад өндөр байна.

43 Эрүүгийн хуулийн 18.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 18.8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 18.9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 18.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 18.13 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт, 20.12 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 25.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 25.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг.

- Нэг зүйлд заасан хэргүүдийн хувьд хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхдээ хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй үйлдсэн, үндсэн бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэн гэмт хэрэгт оногдуулах торгох ялын хэмжээ өөр хэр нь хөөн хэлэлцэх хугацаа нь ижил тоологдохоор байгаа юм.
- Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан гэмт хэрэгт тоолох гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа богино байх зэрэг асуудлыг үүсгэж болох юм.

3. Хэрэв 18.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхээр заасан байвал 18.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар хөөн хэлэлцэх хугацаа тоолно буюу тухайн хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх заалтын дээд талын хэсэгт заасан хугацаагаар хөөн хэлэлцэх хугацааг тоолно гэвэл дор дурдсан асуудлууд үүсэхээр байна:

- Торгох ялын хэмжээ ижил хэр нь хөөн хэлэлцэх хугацаа ялгамжтай байдлаар тоологдохоор байна. Тухайлбал, 10.000-80.000 нэгжийн торгох ялтай 8 хэргийн хувьд 2 хэрэгт нь 1 жил, 4 хэрэгт нь 5 жил, 2 хэрэгт нь 12 жилийн хугацаагаар тус тус хөөн хэлэлцэх тоолохоор байгаа юм. Хэрвээ энэ хувилбараар зохицуулбал шударга ёсны зарчим алдагдах юм.

- Торгох ялын хэмжээ нь бага хэр нь хөөн хэлэлцэх хугацаа нь бусад хэрэгтэйгээ харьцуулахад өндөр байна. Жишээ нь: Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт 40.000-120.000 нэгжээр торгох ялтай хэр нь гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь 20 жил байгаа бол мөн хуулийн 20.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт 200.000-400.000 нэгжээр торгохоор заасан боловч хөөн хэлэлцэх хугацаа нь 5 жил байна.

- Нэг зүйлд заасан хэргүүдийн хувьд хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхдээ хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй үйлдсэн, үндсэн бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэн гэмт хэрэгт оногдуулах торгох ялын хэмжээ өөр хэр нь хөөн хэлэлцэх хугацаа нь ижил тоологдохоор байгаа юм. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 20.11 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг.

Асуудал 3. Нэр томьёог нэг мөр болгох.

2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд “...гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа...” гэсэн нэр томьёог хэрэглэжээ. Гэтэл 2015 оны Эрүүгийн хуульд тус зохицуулалтыг “... гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа...” гэж хуульчилсан байна. Өөрөөр хэлбэл, дээрх нэр томьёо нь нэг утга санааг илэрхийлж байгаа хэдий ч ялгамжтай байдлаар хуульчлагдсаныг нэг мөр болгох нь зүйтэй.

Асуудал 4.

2002 оны Эрүүгийн хуулиар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолохдоо гэмт хэргийн ангиллаас хамааруулан тоолдог байсан. Харин шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг зорчих болон хорих ялын дээд, доод хэмжээнээс хамааруулан тоолохоор хуульчилсан билээ. Ийнхүү гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн ангиллыг үл харгалзан тогтоосон

нь гэмт хэргийн ангиллыг ач холбогдолгүй болгосон гэж зарим талаар дүгнэж болохоор байна. Учир нь шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 2.6 дугаар зүйлд:

1. Энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг хоёр жил, түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар тогтоосон гэмт хэргийг хүнд гэмт хэрэг гэнэ.

2. Энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг таван жил, түүнээс доош хугацаагаар оногдуулахаар тогтоосон, эсхүл хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэргийг хөнгөн гэмт хэрэг гэнэ" гэж зааснаас үзвэл гэмт хэргийг хөнгөн, хүнд гэсэн 2 ангиллаар ангилжээ. Хэдийгээр энэ хуульд гэмт хэргийг хөнгөн, хүнд гэж ангилсан боловч гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт хүнд, хөнгөн гэмт хэргийн хувьд адил тоологдохоор хэд хэдэн гэмт хэрэг Эрүүгийн хуулийн тусгай ангид хуульчлагдсан байна.

Учир нь Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.2 дахь заалтад "....Энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн..." гэж заасан нь хөнгөн, хүнд гэмт хэрэгт аль алинд нь хамаарч байгаа юм. Өөрөөр хэлбэл, хөнгөн гэмт хэрэг, хүнд гэмт хэрэгт ижил хугацаагаар хөөн хэлэлцэх хугацаа тоолж байгаа нь гэмт хэргийн ангиллыг үгүйсгэсэн байж болохоор байна. Хөнгөн, хүнд гэмт хэргийн ангиллыг үгүйсгэсэн нийт 175 гэмт хэрэг байна.

Хүснэгт 1.13. *Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хөнгөн, хүнд гэмт хэрэгт ижил тоолохоор хуульчлагдсан жишээ*

Хөнгөн гэмт хэрэг	Хүнд гэмт хэрэг	Тайлбар
10.2 дугаар зүйл.Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүнийг алах 1.Өөрт нь, ойр дотнын хүнд нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хүндээр доромжлогдсон, эрхшээл дарамтад оруулсан хохирогчийн зүй бус үйлдлийн улмаас сэтгэл санааны гэнэтийн цочролд хоромхон зуур автаж, сэтгэцийн хэвийн байдал алдагдсаны улмаас хүнийг алсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. /Энэ хэсгийг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/	10.3 дугаар зүйл.Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж хүний,г алах 1.Гэмт хэрэг үйлдсэн хүн, оргосон ялтныг баривчлах, эрх бүхий байгууллагад хүргэх, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох зорилгоор халдахдаа тухайн хүний үйлдсэн гэмт үйлдлийн шинж чанар, хэр хэмжээнд илт тохирохгүй үйлдэл хийж; тухайн хүнд зайлшгүй хохирол учруулж саатуулах шаардлагатай нөхцөл байдал үүсээгүй байхад халдаж алсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	Эдгээр гэмт хэргийн хувьд хөнгөн болон хүнд гэмт хэрэг дээр хөөн хэлэлцэх хугацаа ижилхэн байна. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.2-т заасны дагуу "энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн" гэсэн байдлаар хөөн хэлэлцэх хугацааг хуульчилж өгсөн нь хөнгөн болон хүнд гэмт хэргийн хувьд хөөн хэлэлцэх хугацаа нь адилхан таван жил байх нөхцөл байдлыг бүрдүүлсэн байна.

10.6 дугаар зүйл.Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох 2.Энэ гэмт хэргийн улмаас хоёр, түүнээс олон хүний амь насыг хохироосон бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	10.4 дүгээр зүйл.Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх 1.Эд хөрөнгө, албан тушаал, гэр бүлийн хамаарал бүхий харилцаа, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа хүнийг байнга хүчирхийлсэн, доромжилсон, зодсон, тамлан зовоосон, айлган сүрдүүлсний улмаас амиа хорлоход гарцаагүй хүргэсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	

Асуудал 5.

2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг баталсан. Гэтэл тус хууль нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй, хүний эрхийг ноцтой зөрчсөн зэрэг үндэслэлээр Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгэн шийдвэрлүүлээд байна. Энэ хууль нь гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны асуудлын хүрээнд Монгол Улсын түүхэнд урьд өмнө нь гарч байгаагүй асуудлыг хөндсөн буюу Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх тэр дундаа эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхгүй гэсэн зарчмын заалтыг үгүйсгэн хуульчлагдсан нь асуудал дагуулаад байсан юм. Хэдийгээр уг хуулийг бүхэлд нь хүчингүй болгох шийдвэрийг Үндсэн хуулийн цэц гаргасан.

Түүнчлэн, УДШ-ийн нийт шүүгчдийн 2022 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаас гаргасан Дугаар 11 тогтоолоор Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг гаргасан.

Тус тайлбарт, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйл нь материаллаг болон процессын эрх зүйн хэм хэмжээний аль алиныг агуулж байх боловч тус тусын агуулга, зорилгод нийцүүлэн ялгамжтай байдлаар хэрэглэх нь шүүхийн шийдвэр эрх зүйн үндэслэлтэй, хууль ёсны байх шаардлагад нийцнэ. Эрүүгийн эрх зүйн аливаа хэм хэмжээг аль хуульд тусгагдсан байдлаар шалгуур болгож материаллаг эсхүл процессын хэм хэмжээнд хамааруулж дүгнэлт хийх нь цаашид хууль хэрэглээний алдаатай шийдвэр гаргах эрсдэл дагуулна. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацааны дотор тухайн этгээдийг яллагдагчаар татсан бол хөөн хэлэлцэх хугацаа зогсох ба энэхүү процессын хэм хэмжээний мөн чанарыг агуулсан зохицуулалт нь хүчин төгөлдөр болж мөрдөгдөж эхэлснээсээ хойш үйлчлэх бөгөөд уг заалт өөрчлөгдөхөөс өмнө мөрдөж байсан зохицуулалтыг буцааж хэрэглэхгүй гэж тайлбарлажээ.

Харин шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 1.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт *“...Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, гэм буруутай хүн, хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг тухайн гэмт хэргийг үйлдэх үед дагаж мөрдөж байсан хуулиар тодорхойлно...” гэж, мөн хуулийн 1.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “...Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон, оногдуулах ялыг хөнгөрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэнэ...”* гэж тус тус заасан.

Дээрх зохицуулалтуудаас үзвэл, Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалтыг буцаан хэрэглэх боломжтой байдлаар хуульд тусгасан гэж үзэж болох юм.

Учир нь практикт, Улсын дээд шүүхээс 2002 оны Эрүүгийн хуулийн 72 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалтыг буцаан хэрэглэж шийдвэрлэсэн шийдвэр байгаа эсэхийг судлан үзэхэд:

Улсын дээд шүүхийн 2019 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн 260 дугаар тогтоолд *"... анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх үндэслэлийг тогтоохдоо шүүгдэгчийн эрх зүйн байдлыг зөвхөн тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээнээс хамааруулан тодорхойлж буй нь учир дутагдалтай байна. Учир нь шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хууль гэдэгт өмнөх хуулиар гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулж байсан ялын төрлийг Эрүүгийн шинэ хуулиар ялын төрлөөс хассан, хүчингүйд тооцсон, тодорхой төрлийн ял оногдуулах, эдлүүлэх, ял, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, журам, нөхцөлийг шинэ хуулиар гэмт хэрэг үйлдсэн хүнд ашигтай байдлаар хуульчилсан, оногдуулсан ялыг тэнсэх, хойшлуулах, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг оногдуулах, хэрэглэх үндэслэл журмыг хөнгөрүүлсэн зэрэг нөхцөл байдлыг хамааруулан ойлгох бөгөөд эдгээр бүх нөхцөл нь шүүгдэгчид ашигтайгаар хуульчлагдсан тохиолдолд хууль буцаан хэрэглэнэ. Хэдийгээр 2015 оны Эрүүгийн хуулиар гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах ялыг хөнгөрүүлсэн атлаа эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх буюу хөөн хэлэлцэх хугацаа, оногдуулсан ялыг тэнсэх, хойшлуулах асуудлыг 2002 оны Эрүүгийн хуульд заасан хэмжээнээс хүндрүүлсэн тохиолдолд хууль буцаан хэрэглэхгүйгээр, гэмт хэрэг үйлдэгдэх үед мөрдөгдөж байсан хуулиар шийдвэрлэн, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгох, оногдуулсан ялыг тэнсэх, хойшлуулах нь шүүгдэгчийн эрх зүйн байдлыг илүү дээрдүүлсэнд тооцогдоно..."* гэж;

Мөн Улсын дээд шүүхийн 2021 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 238 дугаар тогтоолд *"...2015 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 12 дугаар дүгнэлтээр түдгэлзүүлснээс гадна тухайн хууль нь 2002 оны Эрүүгийн хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа тоолох журмыг хөндөөгүй тул энэ талаар шүүгдэгчийн өмгөөлөгч нарын гомдолд дурдсан үндэслэлийг хүлээн авч, прокуророос "А", "Б", "Б.Б", "Г" нарт 2002 оны Эрүүгийн хуулийн 263.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг мөн хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.2-т заасан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн үндэслэлээр нэр бүхий шүүгдэгч нарыг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, энэ талаар шийтгэх тогтоол, магадлалд өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн үзэв..."* гэж хэргийг шийдвэрлэсэн тохиолдол байна. Мөн дээрх шийдвэрээс гадна гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой асуудлыг шийдвэрлэсэн шийдвэрүүд ч байсныг дурдах нь зүйтэй.

Үүнээс дүгнэвэл, Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх зохицуулалтад тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээ багассан эсэхээс гадна гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа богино байх асуудал ч хамаарч байна хэмээн үзэж Улсын дээд шүүх зарим хэргүүдийг шийдвэрлэсэн байна. Гэтэл гаргасан шийдвэрийнхээ үндэслэлийг дээр дурдсан байдлаар тайлбарласан хэр нь тус үндэслэлээсээ өөр буюу гэмт

хэргийн хөөн хэлэлцэх хугацааны асуудал нь процессын хэм хэмжээ учир буцаан хэрэглэхгүй гэх утга бүхий тайлбар гаргасан нь учир дутагдалтай байна.

Түүнчлэн, 2022, 2023 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн дараах зохицуулалтыг нэмсэн.

Хүснэгт 1.14. *2022, 2023 онд нэмэлтээр оруулсан зохицуулалт*

Зүйл, заалт	Агуулга
1.10 дугаар зүйлийн 7 дахь хэсэг	Хуулиар халдашгүй байдлыг баталгаажуулсан албан тушаалтны бүрэн эрхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан түдгэлзүүлээгүй бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг зогсоож, бүрэн эрх дуусгавар болсны дараа тоолж эхэлнэ.
1.10 дугаар зүйлийн 8 дахь хэсэг	Сэжигтэн мөрдөн шалгах ажиллагаанаас оргон зайлсан бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг оргон зайлсан өдрөөс эхлэн зогсоож уг этгээд баригдсан, эсхүл хэргээ өөрөө илчилж ирсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл хөөн хэлэлцэх хугацааг сэргээн тоолно.
1.10 дугаар зүйлийн 9 дэх хэсэг	Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссанаас үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж улсын орлого болгоно.
1.10 дугаар зүйлийн 10 дахь хэсэг	Энэ хуулийн 12.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 12.3 дугаар зүйлийн 2.1, 3.2 дахь заалт, 13.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтад заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоож, хохирогчийг арван найман насанд хүрсний дараа тоолж эхэлнэ.

2022, 2023 онд оруулсан дээрх өөрчлөлт нь олон талаар эерэг үр дагаврын бий болгосон зохицуулалт болсон. Тухайлбал , Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт "...Хуулиар халдашгүй байдлыг баталгаажуулсан албан тушаалтны бүрэн эрхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан түдгэлзүүлээгүй бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг зогсоож, бүрэн эрх дуусгавар болсны дараа тоолж эхэлнэ..." гэж нэмж хуульчилсан нь халдашгүй бүрэн эрхтэй байх хугацаандаа гэмт хэрэг үйлдсэн албан тушаалтныг үйлдсэн гэмт хэрэгт нь хариуцлага хүлээлгэх боломжийг бий болгож байна. Ийнхүү нэмэлт, өөрчлөлт оруулах болсон шалтгаан нь "...Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод нийцүүлэн хуулиар халдашгүй байдлыг баталгаажуулсан албан тушаалтны бүрэн эрхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан түдгэлзүүлээгүй бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг зогсоож, бүрэн эрх дуусгавар болсны дараа тоолно гэж заасны дагуу халдашгүй бүрэн эрхээр халхавчлан хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр эрүүгийн хариуцлага хүлээдэггүй, эрүүгийн хариуцлага гарцаагүй байх, шударга ёсны зарчмыг гажуудуулдаг байдлыг халах зорилгоор энэхүү өөрчлөлтийг тусгалаа..."[44] гэжээ.

Түүнчлэн, Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан зарим гэмт хэрэг нь бусад гэмт хэргээс олон талаар ялгаатай, нийгмийн хор аюулын хэмжээ, хохирогчид учирсан сэтгэл зүйн цочрол, сэтгэцэд учирсан гэм хорын асуудал зөвхөн тухайн үед үүсээд зогсохгүй насан туршид нь үргэлжлэх боломжтой байдаг. Иймээс ч хууль тогтоогч Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг буюу "Хүчиндэх" гэмт хэргийн хохирогч арван найман насанд хүрсний дараа тоолж эхлэхээр зохицуулжээ. Гэхдээ тус зохицуулалтад 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэмт хэрэг хамаарахгүй байгаа нь учир дутагдалтай байна.

Мөн гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссанаас үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж улсын орлого болгохоор тусгасан нь эерэг нөлөөлөл бүхий зохицуулалт болсон байна. Гэхдээ

44 Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, ХЗДХЯ, (Уб, 2022).

энэхүү зохицуулалт практикт хэрэгжихэд зарим талаар маргаан дагуулах үндэслэлтэй.

Энэ мэт дээр дурдсан асуудал нь гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалтад бүхэлд нь хамаарах бөгөөд авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нарийвчлан судлан үзвэл:

Хүснэгт 1.15. *Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа*

Зүйл, заалт	Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа
Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	12 жил
Эрүүгийн хуулийн 22.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	12 жил
Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг	20 жил
Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	3 жил
Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	3 эсхүл 5 жил
Эрүүгийн хуулийн 22.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	12 жил
Эрүүгийн хуулийн 22.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	3 жил
Эрүүгийн хуулийн 22.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	3 жил
Эрүүгийн хуулийн 22.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	3 жил

Монгол Улсад авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа нь ихээхэн удаашралтай байгаагаас хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болж, хэргийг хэрэгсэхгүй болгох явдал түгээмэл байгаа нь олон нийтийн шүүмжлэл өртөж байна.[45]

3.1.5. Гадаадын зарим орны эрүүгийн хуульд хөөн хэлэлцэх хугацааны талаар тусгасан байдал, харьцуулсан судалгаа

Гадаадын зарим орны Эрүүгийн хууль тогтоомжид хөөн хэлэлцэх хугацааны талаар хэрхэн тусгасан байдлыг авч үзэх нь нэг талаас гадаад орнуудын Эрүүгийн хуульд энэ талаар тогтоосон хэм хэмжээний нийтлэг болон ялгаатай талыг танин мэдэх, нөгөө талаасаа өөрийн орны Эрүүгийн хуульд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны талаар тогтоосон хэм хэмжээг бусад орныхтой харьцуулан үзэх, туршлага судлах зэрэг олон талын ач холбогдолтой.

45 Х.Сэлэнгэ, Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа: Онол, практикийн асуудал, (Уб, 2024), 4 дэх тал.

Эрүүгийн хууль нь тухайн улс орныхоо соёл иргэншил, түүхэн уламжлал, нийгэм, эдийн засаг, улс төрийн байгууламж зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан өөр өөр байдаг. Англи-Америкийн эрүүгийн хууль тогтоомжид эрүүгийн хууль үйлчлэх цаг хугацааг заадаггүй, тэрчлэн хөөн хэлэлцэх хугацаа гэсэн институт байдаггүй.[46] Иймд энэхүү судалгааныхаа хүрээнд Англи-Америкийн эрүүгийн эрх зүйн системийн орнуудыг харьцуулан судлаагүй бөгөөд Ром Германы буюу эх газрын болон холимог эрх зүйн системийн улс орнуудаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Оросын Холбооны Улсад гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн хуульчилсан байдгийг судлан өөрийн орны зохицуулалттай харьцуулан үзэхийг зорилоо.

Мөн дээрх улсуудад авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн зохицуулсан судлан үзлээ.

Эх газрын (Ром-Германы) эрүүгийн эрх зүйн систем

Эх газрын эрх зүйн тогтолцоо нь XII-XIII зууны үед Европ тивд Ромын эрх зүйн агуулгаар үүссэн. Энэ тогтолцооны онцлог шинж нь бичмэл эрх зүйд тулгуурласан байдаг тул хуулийг эрүүгийн эрх зүйн гол эх сурвалж гэж үздэг. Эрүүгийн хуулиудыг төрөлжүүлэн нэгтгэсэн байдаг. Шүүхийн прецедентийг хүлээн зөвшөөрдөггүй. Эрүүгийн эрх зүйн хориглолтыг томьёолох өвөрмөц арга, түүнийг хуульд хийсвэрлэн тусгах замаар заасан, хэллэг нь туйлын тодорхой бөгөөд тэдгээрийг хамгийн түгээмэл тохиолдолд хэрэглэдэг нь энэхүү тогтолцооны онцлог юм.[47]

Түүнчлэн, Эрүүгийн хууль тогтоомж нь бүрэн кодификацчилагдаагүй, хагас буюу хэсэгчилсэн байдлаар системчлэгдсэн байдаг. Өөрөөр хэлбэл, эрүүгийн хууль тогтоомж нь зөвхөн нэг хуулиас биш хэд хэдэн зэрэгцсэн Эрүүгийн хууль, хуульчилсан актаас бүрдэх ба ихэнхдээ ерөнхий анги нь хагас буюу хэсэгчилж хуваарилагдсан байх ба тусгай ангийн институт нь кодификацчилагдсан байдгаараа онцлогтой.[48] Эх газрын эрүүгийн эрх зүйн системийн тогтолцоотой улс орнуудад хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн хуульчилсныг дор авч үзье.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХБНГУ-ын эрүүгийн эрх зүйн эх сурвалж нь 1949 оны ХБНГУ-ын Үндсэн хууль, 1998 оны 11 сарын 13-ны өдөр редакц хийсэн Эрүүгийн хууль (Энэхүү хуульд хамгийн сүүлд 2019 оны 6 дугаар сарын 19-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан)[49], Холбооны тусгай хууль, мужийн Эрүүгийн хууль тогтоомжоос бүрддэг.

ХБНГУ-ын Эрүүгийн хуульд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь хэзээ эхэлж, хэзээ зогсох, түдгэлзэх, дуусгавар болох үндэслэл, ямар гэмт хэрэгт хэрэглэхгүй байхыг нарийвчлан зохицуулжээ. Тухайлбал, ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 78а-д “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт үйлдэл, эс үйлдэхүй төгссөн үеэс эхэлнэ” гэжээ. Мөн ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 78b-д гэмт хэргийн талаарх өргөдөл гомдол ирээгүй учраас хэргийг мөрдөн шалгах боломжгүй байх, гэмт этгээд нь Бундестагийн гишүүн учраас хэргийг мөрдөн шалгах боломжгүй

46 Д.Баярсайхан, Харьцуулсан эрүүгийн эрх зүй, (Уб, 2012), 42 дахь тал.
47 С.Нарангэрэл, Монгол Улсын эрүүгийн эрх зүй, (Уб, 1999), 372 дахь тал.
48 Мөн тэнд.
49 German Criminal Code https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html

болсон гэх мэт хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэх олон үндэслэлүүдийг, Эрүүгийн хуулийн 78с-д гэмт этгээд нь яллагдагчаар татагдсан хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх болсон гэх мэт хөөн хэлэлцэх хугацаа зогсох олон үндэслэлүүдийг тус тус заажээ. Түүнээс гадна ХБНГУ-ын Эрүүгийн хуульд мөрдөн шалгах явцын болон шүүхээр хэргийг хянан шийдвэрлэх үеийн хөөн хэлэлцэх хугацааг ялгаж зааглан зохицуулсан байна.[50]

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5-р хэсгийн 1-р бүлэгт “Хөөн хэлэлцэх хугацаа” гэсэн бүлгийг хуульчилсан байдаг ба уг бүлгийн 78 дугаар зүйлд:[51]

а) Бүх насаар нь хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 30 жил өнгөрсөн;

б) Арав буюу түүнээс дээш жилийн хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш хорин жил өнгөрсөн;

в) Таваас доошгүй арван жилээс дээшгүй хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван жил өнгөрсөн;

г) Нэгээс доошгүй таван жилээс дээшгүй хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн;

д) Нэг жил хүртэл хугацаагаар хорих буюу бусад төрлийн ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш гурван жил өнгөрсөн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татахгүй байхаар тогтоожээ.

Дээрхээс үзвэл, ХБНГУ-ын Эрүүгийн хуулиар тогтоосон эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаа нь манай одоогийн дагаж мөрдөж байгаа хуулиас хүнд байгаа боловч гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг оногдуулж буй ялын төрөл хэмжээнээс хамаарч тоолохоор зохицуулж байгаа байдал нь манай улсын зохицуулалттай ижил. Харин “хор уршиг гэмт үйлдлээс хойш учирсан бол хор уршиг учирсан өдрөөс хөөн хэлэлцэх хугацааг тоолно”[52] гэж хуульчилсан нь манай эрүүгийн эрх зүйн зохицуулалтаас ялгаатай байна.

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн нэг онцлог нь бүх насаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тоолохоор зохицуулсан нь манай Эрүүгийн хуулийн зохицуулалтаас ялгаатай. Монгол Улс 2015 оны Эрүүгийн хуульд ялын шинэ төрөл болох бүх насаар хорих ялыг шинээр хуульчилж, уг ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тоолохгүй байхаар тусгасан юм.

ХБНГУ-ын Эрүүгийн хуульд шийтгэх тогтоол биелүүлэх хугацаа өнгөрсөн тохиолдолд ялаас чөлөөлөх хугацааг уг хуулийн ерөнхий ангийн 5 дугаар хэсгийн 2 дугаар бүлгийн 79 дүгээр зүйлд хуульчилсан байна.[53]

“Шүүхийн ял болон бусад албадлагын арга хэмжээ оногдуулсан тогтоолыг дор дурдсан хугацаанд биелүүлээгүй бол түүнийг биелүүлэх хугацаа хүчингүй:

50 Х.Сэлэнгэ, Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа: Онол, практикийн асуудал, (Уб, 2024), 9 дэх тал.

51 German Criminal Code, Section 78 https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html

52 Мөн тэнд, 78а дугаар зүйл.

53 Мөн тэнд, 79 дүгээр зүйл.

а) Бүх насаар нь хорих ял оногдуулсан таслан шийдвэрлэх тогтоолд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй;

б) Арваас дээш жил хорих ял оногдуулсан таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолыг 25 жилийн хугацаанд биелүүлээгүй бол;

в) Таваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулсан таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолыг 20 жилийн хугацаанд биелүүлээгүй бол;

г) Нэгээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулсан таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолыг 10 жилийн хугацаанд биелүүлээгүй бол;

д) Нэг жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулсан эсхүл, 30 өдрийн орлогоос дээш хэмжээгээр торгох ял оногдуулсан таслан шийдвэрлэх тогтоолыг 5 жилийн хугацаанд биелүүлээгүй бол;

е) 30 өдөр хүртэлх орлогын хэмжээгээр торгох ял оногдуулсан таслан шийдвэрлэх тогтоолыг 3 жилийн хугацаанд биелүүлээгүй бол” гэж заасан байна.

Мөн таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолын хөөн хэлэлцэх хугацааг хүчин төгөлдөр болсон өдрөөс уг ялыг биелэгдэх хүртэл тоолно гэж заасан нь ихээхэн ач холбогдолтой юм. Учир нь тухайн шийтгэх тогтоолыг хуульд заасан хугацаа өнгөрсөн тохиолдолд биелүүлэхгүй байх боломжийг хуулиар олгож байна. Энэ нь тухайн шийтгэх тогтоолоор оногдуулсан ялын хэр хэмжээ, гэмт хэргийн хохирол, хор уршгаас шалтгаалан зарим төрлийн буюу хөнгөн гэмт хэрэгт явуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой зардал, цаг хугацаа, хүн хүч, ажлын ачаалал гэх мэт олон төрлийн зайлшгүй гарах зардлыг бууруулах ач холбогдолтой. Харин манай улсын хувьд шийтгэх тогтоол биелүүлэх хугацаа өнгөрсөн тохиолдолд ялаас чөлөөлөх хугацааг хуульчлаагүй байна.

Бүгд Найрамдах Солонгос Улс

БНСУ-ын одоогийн хүчин төгөлдөр дагаж мөрдөж байгаа Эрүүгийн хууль нь 1953 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд ерөнхий болон тусгай ангиас бүрдсэн 42 бүлэг, 372 зүйлтэй. Ерөнхий ангийн 1 дүгээр дэвтрийн 7 дугаар хэсгийн 77 дугаар зүйлд эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааг үйлдсэн гэмт хэрэгт нь оногдуулж болох ялын төрөл хэмжээтэй нь харьцуулан дараах байдлаар хуульчилжээ.[54] Үүнд:

а) Цаазаар авах ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш гучин жил өнгөрсөн;

б) Бүх насаар нь хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш хорин жил өнгөрсөн;

в) Арван жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван таван жил өнгөрсөн;

г) Таван жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван жил өнгөрсөн;

д) Таван жил хүртэл хугацаагаар хорих буюу эд хөрөнгө хураах, торгох (500 воноос дээш) ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн;

е) Бага хэмжээгээр торгох (500 хүртэл вон) буюу баривчлах ял (1-30 хоног)

54 Criminal code https://www.refworld.org/pdfid/3f49e3ed4.pdf?fbclid=IwAR18CNwc-G9McbrKQDE4FNcDdauNEd5mILyWy8Wsg3XtNL75nNoAvpXskYs

оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн бол гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татахгүй байхаар заасан байна.

БНСУ-д гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг оногдуулж буй ялын төрөл, хэмжээнээс хамаарч тоолохоор хуульчилсан. Мөн цаазаар авах ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолдог бөгөөд цаазаар авах, хорих, эд хөрөнгө хураах, торгох, баривчлах ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхээр зохицуулснаараа манай улсын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтаас илүү боловсронгуй буюу ялын бүх төрөлд хөөн хэлэлцэх хугацааг тоолох боломжтой байдлаар хуульчилжээ. Харин манай улсын хувьд зорчих эрхийг хязгаарлах, торгох болон хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт л хөөн хэлэлцэх хугацааг тоолж байна.

Холимог эрүүгийн эрх зүйн систем

Дэлхийн эрх зүйн системийн зонхилох гол загвар болох Англи-Америкийн болон Эх газрын системүүд нь хоорондоо зааг ялгаатай, онцлог хэв шинжийг тусгаж ирсэн боловч улс, үндэстнүүдийн соёл, түүхэн уламжлал тэдгээрийн өвөрмөц байдлаас хамаарч янз бүрийн тогтолцоо бүлүүдийг бий болгон хөгжүүлснийг харж болно. Ялангуяа хөгжингүй болон хөгжиж буй улс орнууд, тэрчлэн шинэ тутам болон хот улс, жижиг арлын орнуудад үндсэн ба зарим системийн хэв шинж, соёл, тогтолцооны хосолсон буюу холимог хэлбэр илэрч байна. Холимог эрүүгийн эрх зүй гэдэг нь түүхэн сонголтын болон түүхэн цаг үеийн нөхцөлд өөрийн орны сонгосон аль нэг системийг хөгжүүлэх явцад эх газрын болон Англи Америкийн системээс зээлдэн авсан буюу өмнөх системээ халж, өөр системд шилжихдээ системүүдийн хэв шинж холилдсон буюу аль нэг систем нь давамгайлсан хандлага бий болсон байдлыг хэлнэ.[55]

Бүгд Найрамдах Хятад Ард Улс

БНХАУ нь эрүүгийн эрх зүйн маш өвөрмөц онцлогийг тусгасан байдгийн дээр хэд хэдэн системийн шинжийг өөртөө хослуулан хадгалахын сацуу өөрийн гэсэн бие даасан онол практикийг хослуулан хөгжүүлж байна. БНХАУ нь 1979 онд шинэ Эрүүгийн хуулиа баталсан бөгөөд 1997 онд зарим нэмэлт, өөрчлөлт оруулж шинэчлэн баталжээ.[56] Хөөн хэлэлцэх хугацааг БНХАУ-ын Эрүүгийн хуулийн Наймдугаар хэсэгт Хүчинтэй хугацаа хэмээн хуульчилж өгчээ.[57]

87 дугаар зүйл. Ял хийгээд доорх хугацаанаас хэтэрсэн байвал нэхэмжлэн заалдахгүй.

(Нэг) Хуулиар тогтоосон хамгийн хүнд эрүү шийтгэл нь таван жил үл хүрэх хугацаатай хорихоор шийтгэгдэх ёстой байтал нэгэнт таван жил өнгөрөн байвал;

(Хоёр) Хуулиар тогтоосон хамгийн хүнд эрүү шийтгэл нь таван жилээс дээш арван таван жил үл хүрэх хугацаатай хорихоор шийтгэгдэх ёстой байтал нэгэнт арван жил өнгөрсөн байвал;

55 Д.Баярсайхан, Харьцуулсан эрүүгийн эрх зүй, (Уб, 2012), 55 дахь тал.

56 Criminal Law of the People's Republic of China https://www.fmprc.gov.cn/ce/cgvienna/eng/dbtyw/jdwt/crimelaw/t209043.htm

57 Д.Баярсайхан, Харьцуулсан эрүүгийн эрх зүй, (Уб, 2012), 58 дахь тал.

(Гурав) Хуулиар тогтоосон хамгийн хүнд эрүү шийтгэл нь арван жилээс дээш хугацаатай хорихоор шийтгэгдэх ёстой байтал нэгэнт арван таван жил өнгөрсөн байвал;

(Дөрөв) Хуулиар тогтоосон хамгийн хүнд эрүү шийтгэл нь хугацаагүй хорих, алахаар шийтгэх ёстой байтал нэгэнт хорин жил өнгөрсөн байвал хэрвээ хорин жилийн хойно заавал нэхэмжлэн заалдах хэрэгтэй гэж үзвэл эрх биш Ардын дээд байцаах хороонд мэдүүлж хянан зөвшөөрүүлэх хэрэгтэй.

88 дугаар зүйл. Ардын байцаах хороо, Дотоодын хамгаалах байгууллага, Улсын амар төвшнийг хамгаалах байгууллага хэрэг болгон туршин байцаах буюу Ардын шүүх хороо хэргийг хүлээн авсны дараа туршин байцаалт буюу шүүн таслалтаас зайлсан байвал нэхэмжлэн заалдах хугацааг хязгаарлахгүй.

Хорлогдогсод нэхэмжлэн заалдах хугацаан дотор илчлэн заалдсан байхад ардын шүүх хороо, ардын байцаах хороо, дотоодын хамгаалах байгууллага хэрэг болгох ёстой байтал үл болгосон байвал нэхэмжлэн заалдах хугацаанд хязгаарлагдахгүй.

89 дүгээр зүйл. Нэхэмжлэн заалдах хугацааг ял хийсэн өдрөөс эхлэн бодно. Ялт үйл ажиллагаа нь залгалдсан буюу үргэлжилсэн байдалтай байвал ялт үйл ажиллагааны илэрсэн өдрөөс эхлэн бодно. Нэхэмжлэн заалдах хугацаанд дахиж ял хийсэн байвал өмнөх ялын нэхэмжлэн заалдах хугацааг хойших ялыг хийсэн өдрөөс эхлэн бодно.[58]

БНХАУ-ын хувьд 60 төрлийн гэмт хэрэгт цаазаар авах ял оногдуулдаг буюу цаазаар авах ялыг маш өргөн хүрээнд хэрэглэдгээрээ онцлогтой.[59] Гэсэн хэдий ч бүх насаар хорих ял оногдуулах гэмт хэрэг болон алахаар заасан гэмт хэрэг дээр хөөн хэлэлцэх хугацааг хорин жил байхаар тогтоож өгсөн нь өвөрмөц зохицуулалт болжээ. Мөн хөөн хэлэлцэх хугацаа зогсох, тасрах, түүнийг хэрхэн тоолох талаар зохицуулалтыг хуульчилсан байна.

Оросын Холбооны Улс

ОХУ-д төрийн ДУМ-аас 1995 оны 7 дугаар сарын 19-ний өдөр баталж 1996 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдсөн 4 дэх[60] Эрүүгийн хууль (тус хуульд хамгийн сүүлд 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан)[61] үйлчилж байгаа бөгөөд уг хуулийн ерөнхий ангийн 4 дүгээр хэсгийн “Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх” хэмээх 11 дүгээр бүлгийн 78 дугаар зүйлд эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааг доорх байдлаар тогтоожээ.

“Гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш дор дурдсан хугацаа өнгөрвөл гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.[62]

а) Нийгмийн хор аюулаар бага гэмт хэрэг үйлдсэнээс хойш хоёр жил өнгөрсөн;

б) Хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэнээс хойш зургаан жил өнгөрсөн;

58 Э.Зууннасан, Б.Батзориг, БНХАУ-ын Эрүүгийн ба Эрүүгийн заргын хууль, (Уб, 2006).
59 Б.Баярсайхан, Харьцуулсан эрүүгийн эрх зүй, (Уб, 2012), 58 дахь тал.
60 ОХУ-д 1922, 1923, 1960, 1995 онд тус тус Эрүүгийн хууль батлагжээ.
61 Уголовный кодекс российской федерации http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_10699/
62 ОХУ-ын Эрүүгийн хууль, 78 дугаар зүйл.

в) Хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван жил өнгөрсөн;

г) Онц хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван таван жил өнгөрсөн” гэж заасан ба хугацааг тоолох журам, нөхцөлийг тогтоосон байна.

Мөн хугацааг тогтоосон үндэслэл (гэмт хэргийн ангиллаар) болон хүн төрөлхтний болон энх тайвны эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй гэж заасан нь манай 2002 оны Эрүүгийн хуулийн хэм хэмжээтэй ижил юм.

Таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацааны талаар ОХУ-ын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 4 дүгээр хэсгийн 12 дугаар бүлгийн 83 дугаар зүйлд дараах байдлаар хуульчилжээ:

“Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулсан шүүхийн таслан шийдвэрлэх шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш доорх хугацаанд түүнийг биелүүлээгүй бол (биечлэн эдэлж дуусаагүй) биелүүлж болохгүй. Энэ тохиолдолд ялтанг уг ялыг эдлэхээс чөлөөлнө.

а) Нийгмийн хор аюулаар бага гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан ялыг хоёр жилийн хугацаанд биелүүлээгүй бол;

б) Хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан ялыг зургаан жилийн хугацаанд биелүүлээгүй бол;

в) Хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан ялыг арван жилийн хугацаанд биелүүлээгүй бол;

г) Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан ялыг арван таван жилийн хугацаанд биелүүлээгүй бол биелүүлж болохгүй” гэж эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаатайгаа ижил байдлаар тогтоожээ.

Таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацааны тухай ОХУ-ын Эрүүгийн хуулийн хэм хэмжээ нь тухайлбал, хугацааг тоолох журам, нөхцөл нь манай 2002 оны Эрүүгийн хуулийн хэм хэмжээтэй ерөнхийдөө адил боловч ял эдлэхээс зайлсхийсэн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа тасардаггүй, харин зогсдог байхаар хуульчилснаараа онцлогтой. Мөн хүн төрөлхтний болон энх тайвны эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байхаар тогтоожээ. ОХУ-ын хувьд Эрүүгийн хууль нь бүрэн системчлэгдсэн (кодификацчилагдсан) байдаг бөгөөд нэгдмэл төрөлжсөн нэг Эрүүгийн хуультай гэдгээрээ манай улстай ижил. Үүнээс гадна гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн ангиллаас хамааруулан зохицуулсан нь манай 2002 оны Эрүүгийн хуулийн зохицуулалттай адил байна.

Дээрх улс орнуудад хөөн хэлэлцэх хугацааны хоёр төрлийг хоёр хэлбэрээр өөрөөр хэлбэл, эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааг гэмт хэргийн ангиллаар болон оногдуулж болох ялын дээд хэмжээтэй нь харьцуулан, харин таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацааг гэмт хэргийн ангиллаар болон таслан шийдвэрлэх тогтоолоор оногдуулсан ялын төрөл, хэмжээтэй нь харьцуулан тогтоосон байх ба хугацааг тоолох нөхцөл, журам нь ерөнхийдөө нийтлэг боловч хугацааны хязгаар нь харилцан адилгүй байна. Энэ нь тухайн улс орны эрүүгийн эрх зүйн бодлого, гэмт хэргийн гаралт, зан заншил, үндэсний онцлогтой холбоотойгоор тайлбарлагдах бөгөөд дэлхийн хөгжлийн чиг хандлага, гарч буй гэмт хэргийн нөхцөл байдалтай (терроризм, хүн төрөлхтний

болон энх тайвны эсрэг гэмт хэрэг, үндэстэн дамнасан хэрэг) уялдан хөөн хэлэлцэх хугацааны хязгаарыг багасгах биш нэмэгдүүлэх хандлага давамгайлж байгаа нь харагдлаа. Манай улсын хувьд хөөн хэлэлцэх хугацааг зөвхөн зорчих эрхийг хязгаарлах, торгох болон хорих ялтай гэмт хэрэгт тоолохоор зохицуулсан бөгөөд харин таслан шийтгэх тогтоол биелүүлэх хугацаан дээр хөөн хэлэлцэх хугацааг тоолохгүй байхаар буюу хуулиар зохицуулж өгөөгүй. Харьцуулсан судалгаанаас үзэхэд улс орнууд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг оногдуулж буй ялын бүх төрөл дээр тооцдог байхаар хуульчилсан нь харагдаж байна.

Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт хэргийн төрлөөс үл хамаарч, гэмт хэргийн ангилал болон гэмт хэрэгт оногдуулж буй ялын дээд хэмжээгээр тодорхойлогддог түгээмэл жишиг байна. Иймд авлигын гэмт хэрэг нь нийтийн ашиг сонирхлыг хөндөж, нийгэмд учруулах хор аюул, хохирлын хэмжээ их байдаг тул түүнд оногдуулах ялын хэмжээг хүндрүүлэн тогтоодог. Дэлхийн ихэнх улс орнууд авлигын гэмт хэргийн эсрэг тэмцэл явуулж байгаа бөгөөд авлигын эсрэг тэмцэх Сингапурын болон Шведийн гэсэн хоёр загвар байдаг юм. Сингапурын загварын нэг гол асуудал нь авлигын гэмт хэрэгт оногдуулах ялыг чангатгах явдал болно. Авлигын эсрэг тэмцэх Сингапурын загварын дагуу зарим улс орнууд авлигын гэмт хэрэгт оногдуулах ялыг чангатгахаас гадна авлигын гэмт хэргийн төрлийг нэмэгдүүлж, нарийвчлан хуульчлах болсон байна.[63]

ХБНГУ, АНУ, Франц зэрэг улс орнууд авлигын гэмт хэргийн ойлголт, түүний мөн чанар, агуулга, хэлбэр, төрлийг нарийвчлан тодорхойлж хуульчилжээ. Тухайлбал, ихэнх улс орнуудын хувьд нийтийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх, урвуулан ашиглах, хахууль авах, өгөх, үндэслэлгүйгээр хөрөнгөжих үйлдлийг авлигын гэмт хэрэгт тооцож байгаа боловч зарим улс орнуудад авлигын гэмт хэргийг нийтийн албан тушаалтнуудын үйл ажиллагааны чиглэлээр төрөлжүүлэн эрүүгийн хариуцлага оногдуулахаар хуульчилсан байна. Тухайлбал, шүүх, гааль, банкны ажилтны авлигын гэмт хэрэг гэх мэт.[64]

3.2.“ПРАКТИКТ НИЙЦЭЖ БАЙГАА БАЙДАЛ” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Судалгааны энэ бүлэгт Эрүүгийн хууль болон ЭХХШтХ-д заасан хөрөнгө орлого хураахтай холбоотой эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт, тулгамдаж буй асуудлын талаар судлан үзнэ. Энэ хүрээнд авлигын гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлогыг хураах холбоотой асуудлын дэлгэрүүлэн судалж, зарим улсын туршлагыг судлан үзнэ.

3.2.1. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах тухай ойлголт

“Хөрөнгө хураан авах” гэдэг нь шүүх болон эрх бүхий бусад байгууллагын гаргасан шийдвэрийн дагуу эд хөрөнгийг бүрмөсөн авахыг хэлнэ. Хөрөнгийн эрх, гэрчилгээг улс өөрийн нэр дээр шилжүүлэн авах бөгөөд тэдгээрийг эзэмшиж байсан этгээдэд ямар нэгэн нөхөн төлбөр олгохгүй. Хөрөнгийг хураан авахад хууль сахиулах байгууллагын албан хаагчид, прокурор, шүүгч, санхүүгийн шинжээч, хөрөнгийн менежер эсвэл хөрөнгийн удирдлагын агентлаг зэрэг төрөл бүрийн ур чадвартай хувь хүн, байгууллагууд харилцан уялдаа холбоотой, хамтран ажиллах шаардлагатай.

63 Х.Сэлэнгэ, Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа: Онол, практикийн асуудал, (Уб, 2024), 10 дахь тал.

64 Мөн тэнд.

Авлигын эсрэг НҮБ-ын Конвенц ба ФАТФ-ын Зөвлөмжүүд (ФАТФ 2019) шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураахыг дэмждэг бөгөөд хөрөнгө хураан авах талаар зохицуулалтыг өргөжүүлж, уг зарчмыг хүлээн зөвшөөрөн шинээр нэвтрүүлж буй улс орны тоо өсөн нэмэгдсээр байна. Хөрөнгө хураан авах үндэслэл нь:

Нэгдүгээрт, хууль бус орлого бий болгож буй авлига, бусад гэмт хэрэг нь төр, Засгийн газар, эсвэл хувь этгээдэд хохирол учруулдаг тул тэдгээрт нөхөн төлбөр олгогдох ёстой.

Хоёрдугаарт, эдгээр гэмт хэргийг үйлдэх үндсэн зорилго нь хууль бус орлого олох явдал байдаг тул хөрөнгийг хураасnаар ашиг шимийг нь хүртэх боломжгүй болгож улмаар урьдчилан сэргийлэх үр нөлөө үзүүлдэг. Тухайлбал, хөрөнгө хураан авах нь “гэмт хэрэг үйлдэж орлого олох боломжгүй” гэсэн ойлголтыг бий болгох зорилготой.

Хөрөнгө хураахтай холбоотой хууль тогтоомж, практикт ажиглагдаж буй томоохон ач холбогдол бүхий чиг хандлагын нэг нь няцаагдах боломжтой презумпци буюу үндэслэл бүхий таамаг, дүгнэлтийг илүү өргөнөөр ашиглах болсон явдал юм. Презумпци гэдэг нь бодит баталгаагүй нөхцөлд учир шалтгааныг магадлах, тунгаан бодох замаар тодорхой нөхцөл байдалд тулгуурлан баримт, таамаглалын үнэн болохыг тогтоосон гаргалгаа, дүгнэлтийг хэлнэ.

Төрийн албан хаагчдын авлигын хэргүүдэд гэмт үйлдэл болон шүүгдэгчийн өмчилж, эзэмшиж буй хөрөнгө хоорондын хэлхээ холбоог тогтоох бараг боломжгүй байдаг. Энэ тохиолдолд презумпци чухал үүрэг гүйцэтгэдэг. Төрийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэх хугацаанд олсон орлого, хөрөнгийнхөө гарал үүслийг өөрөө тайлбарлаж чадахгүй нөхцөлд прокурорын байгууллагаас уг хөрөнгийн эх үүсвэр хууль бус болохыг нотлох шаардлагагүй болсон нь яллах ба хөрөнгө хураах шийдвэр гарах магадлалыг ихээхэн нэмэгдүүлж өгсөн. Мөн хөрөнгийн үнэлгээнд суурилсан хөрөнгө хураах хэлбэр буюу гэмт хэргийн улмаас олсон ашиг хонжооны дүнг шүүх болон эрх бүхий байгууллагууд тооцоолж тухайн дүнд дүйцэх хөрөнгийг шүүгдэгчээс хураах шийдвэр гаргадаг.

Хөрөнгө хураах авах ойлголтын эрх зүйн зохицуулалтын түүхэн хөгжил ба сүүлийн үеийн чиг хандлага

Хөрөнгө хураах авах тухай ойлголт нь олон жил хэрэгжиж байгаа бөгөөд олон мянган жилийн өмнөх хуулийн баримт бичгүүдэд хөрөнгө хураах жишээнүүдийг дурдсан байдаг. Эдгээр эртний хуулиудаас өвлөгдөн ирсэн хөрөнгө хураах хуулиуд Английн хуулийн тогтолцоо, Эх газрын эрх зүйн тогтолцооны аль алинд нь шингэн тусгагдсан. 1980-аад онд мансууруулах бодисын наймаа, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хүчин чармайлт нэмэгдэхийн хэрээр зарим улс оронд эрүүгийн журмаар хөрөнгө битүүмжлэх, мөн яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах ажиллагааг хэрэгжүүлж ирсэн.

Сүүлийн жилүүдэд хууль бус хөрөнгө, орлогыг хураах нь илт ихэссэн, учир нь гэмт хэрэг үйлдэж олсон орлого маш өндөр байхад хураасан хөрөнгийн хэмжээ их биш байгаа юм. Үүнтэй холбоотойгоор хөрөнгө, орлогыг хураах хууль тогтоомжид шинээр дараах чиг хандлага бий болсон. Үүнд:

- Яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах заалтыг нэвтрүүлсэн;

- Хөрөнгө хураах үнэлгээнд суурилсан аргачлалыг хөгжүүлсэн;
- Нотлох баримтын стандартыг бууруулсан;
- Зарим нөхцөлд нотлох шаардлагаас чөлөөлсөн;
- Презумпцийг илүү өргөнөөр ашиглах болсон;
- Гэмт хэргийн бэлэн мөнгө, бусад хэрэгслийг шүүхийн бус буюу захиргааны аргаар хураах тохиолдол нэмэгдсэн.

Хууль бус хөрөнгийг хураан авах журам

Авлигын хөрөнгө , орлогыг хураах гурван төрөл байна. Үүнд:

- эрүүгийн журмаар,
- яллах шийдвэргүйгээр,
- захиргааны журмаар.

Мөн зарим оронд холимог тогтолцоог хэрэглэж байна. Тухайлбал, шүүхэд нэхэмжлэл гаргах, тусгаарлах зэрэг иргэний процессын арга хэмжээг эрүүгийн ажиллагаанд хэрэглэж хөрөнгө, орлогыг хураадаг.

Эрүүгийн журмаар хөрөнгө хураах

Эрүүгийн журмаар яллаж хөрөнгө хураахын тулд шүүхээр хэлэлцэж яллах шийдвэр гаргуулсан эсхүл шүүгдэгч гэм буруугаа хүлээж зөвшөөрсөн байх ёстой байдаг. Яллах дүгнэлт гарсан хойно шүүхээс хөрөнгө хураах эцсийн шийдвэр гаргадаг, ихэнх тохиолдолд энэ нь шүүгдэгчид оногдуулсан ялын нэг хэсэг байдаг. Зарим улс орнуудад хөрөнгө хураах нь шүүхийн шийдвэрт заавал ордог бол зарим улсад шүүх эсхүл тангарагтны шүүх уг асуудлыг өөрийн үзэмжээр шийддэг. Эрүүгийн журмаар хөрөнгө хураах нь өмчид суурилсан, үнэлгээнд суурилсан, эсвэл хослуулсан байж болдог.

Зарим улс оронд (тухайлбал, яллах үйл явц, хөрөнгө хураах үйл явц гэх мэт) хэргийн хоёр үе шатанд эд мөрийн баримтын тухайд өөр өөр стандартууд ашиглаж болдог. Яллах ажиллагааны тухайд эрүүгийн стандартын дагуу тавигддаг нотолгоо, эд мөрийн баримтыг бүрдүүлж шүүгдэгчид яллах дүгнэлт гаргуулах нь прокурорын хувьд хамгийн чухал асуудал байдаг, үүнд нийтийн эрх зүйн тогтолцоотой улс оронд “үндэслэл бүхий сэжиг”, харин эх газрын эрх зүйн тогтолцоонд “бодит үнэнийг тогтоох” зарчмыг ашиглаж болно. Гэмт хэрэг үйлдэгдсэн гэдгийг нотлохын тулд эд мөрийн баримт, нотолгооны энэ стандартыг эхний ээлжид хангасан байх ёстой, үүний дараа хөрөнгө хураах асуудал яригдана.

Хөрөнгө хураах ажиллагааны тухайд эд мөрийн баримт, нотолгооны өөр стандарт мөрдөгдөж болох хэдий ч хөрөнгө хураах асуудлыг хэлэлцэх явцад үйлдсэн хэрэг, хураах хөрөнгө хоорондын хэлхээ холбоог тогтоох зэрэг нэмэлт шаардлагыг шүүхээс тавьж болно. Зарим улсад ийм хоёрдогч шаардлагыг хангахад нотлох баримтын стандартын “магадлалын тэнцвэр” доогуур байхыг зөвшөөрдөг бол заримд нь эрүүгийн яллах ажиллагаа, хөрөнгө хураах ажиллагаанд яг ижил түвшний нотлох баримт шаарддаг.

Яллах шийдвэр гарсан байх шаардлага үйлчилж байгаа нөхцөлд хэрэгтэн нас барсан, өөр орон руу зугтсан, эсхүл өөр ямар нэг шалтгаанаар шүүхээр орох

боломжгүй болсон тохиолдлуудад хөрөнгө хураахад бэрхшээлтэй болдог. Хэрэгтэн оргон зайлсан гэдэг нь тогтоогдсон бол зарим улсад холбогдогчийн эзгүйд шүүх хурлыг явуулдаг, эсвэл хөрөнгө хураах зорилгоор хэрэгтэнг “яллагдсанд” тооцдог болсон.

Яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах

Яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах (зарим тохиолдолд “иргэний журмаар” хөрөнгө хураах гэгддэг) нь ихэнх тохиолдолд хөрөнгийг эзэмшиж, өмчилж буй этгээдийн эсрэг бус өмчид суурилсан тухайн хөрөнгийн эсрэг ажиллагаа байдаг тул яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах ажиллагаанд тухайн хөрөнгийг гэмт хэргийн улмаас олж авсан гэдгийг нотлоход л хангалттай байдаг. Үүнд холбогдогч этгээдийн эсрэг яллах шийдвэр гарсан эсэх нь хамаагүй. Ийм төрлийн хөрөнгө хураалт хоёр арга замаар явагддаг.

Нэгд, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд явагддаг, гэхдээ яллах шийдвэр гарах, гэм буруутайг нотолсон байх шаардлага тавигддаггүй. Энэ тохиолдолд яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах хуулийг Эрүүгийн хууль, Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль, эсхүл өөр бусад эрүүгийн хууль тогтоомжид нэгтгэн оруулдаг бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг хэсэг гэж үздэг.

Хоёрт, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас тусдаа, бие даасан байдлаар эсвэл зэрэгцээ ажиллагаа явуулах боломжтой бие даасан хууль гаргаж хөрөнгө хураах нь яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах. Энэ нь эрүүгийн гэхээсээ илүүтэйгээр иргэний эсхүл захиргааны журмаар явагдах нь түгээмэл байдаг. Иргэний журмаар хөрөнгө хураах зарчим ашигладаг улс орнуудад нотлох баримтын стандартын “магадлалын тэнцвэр” эсхүл “нотлох баримтын давамгай байдал” доогуур байхыг зөвшөөрдөг тул өмч, хөрөнгийг гэмт хэргийн улмаас олж авсан гэдгийг прокурор нотлох үүрэг, шаардлагыг бууруулж өгдөг. Гэхдээ гэмт хэрэг үйлдэгдсэн, тухайн хөрөнгийг гэмт хэргийн улмаас олж авсан, эсхүл гэмт хэрэг үйлдэхэд ашигласан гэдгийг нотлох шаардлага тавигдсан хэвээр байдаг. Нотлох баримт нь эрүүгийн журмаар яллах дүгнэлт гаргахад хангалтгүй нөхцөлд хөрөнгө хураах шийдвэр гаргаж болдог.

Захиргааны журмаар хөрөнгө хураах

Захиргааны журмаар хөрөнгө хураахад шүүхийн шийдвэр шаардлагагүй байж болдог. Гэхдээ улс орноос хамааран зарим тохиолдолд шүүхээр орох шаардлагатай байдаг. Аль нэг тал хөрөнгө хураахыг эсэргүүцээгүй, мөн тодорхой (жишээлбэл, талуудад мэдэгдэл хүргүүлсэн, хэвлэн нийтэлсэн, мөн сөрөг нэхэмжлэл ирээгүй гэх мэт) шаардлагууд хангагдсан нөхцөлд түгээмэл ашигладаг. Үүнээс гадна, захиргааны журмаар хураах хөрөнгийн үнийн дүнд дээд хэмжээ заах, эсхүл төрөл зүйлийн жагсаалт гаргах гэх мэтээр үйлчлэх цар хүрээг хязгаарлах заалтуудыг хуульд тусгадаг. Мөн захиргааны журмаар хөрөнгө хураах тухай хуулиудад зарим шийдвэрийг шүүхээс гаргах тухай зохицуулалт оруулах тохиолдол түгээмэл байдаг.

Хураан авах үйл ажиллагаа

Хөрөнгө хураахад 1/ хөрөнгөд суурилсан (тодорхой хөрөнгийг зааж өгдөг), эсхүл 2/ үнэлгээнд суурилсан (тодорхой этгээдийн төлөх ёстой үнийн дүнг зааж

өгдөг) гэх хоёр аргачлалыг ашигладаг. Зарим улс оронд энэ хоёр аргачлалыг аль алийг нь хослуулан ашигладаг бөгөөд олж тогтоосон хөрөнгө, орлогыг хураах, мөн холбогдогч этгээдийн хууль ёсны өмч хөрөнгөөс хохирлыг барагдуулах шийдвэр гаргуулдаг. Эдгээр хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаанд нийтлэг зүйл олон байдаг. Гэхдээ ашиглаж буй журам, үйл явц, хөрөнгө, орлогыг хураахад тавигддаг нотлох баримт, эд мөрийн баримтын шаардлага, стандартууд нь ялгаатай.

Авлигын замаар олсон орлогыг хураах нь дараах зорилготой.

1. Урьдчилан сэргийлэх: Авлига авсан албан тушаалтны гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах нь шинээр гэмт хэрэг үйлдэхээс сэргийлээд зогсохгүй ижил төрлийн гэмт хэрэгт өртөмтгий бусад хүмүүст сэрэмжлүүлэг болдог.
2. Хохирол нөхөн төлүүлэх/нөхөн сэргээх: авлигын гэмт хэргийн хохирогчдын хохирлыг нөхөн төлүүлэх, бусад эрх, ашиг сонирхлыг хамгаалах зэрэг үндсэн агуулгуудад багтана.

Зарим улс оронд авлигын гэмт хэрэг үйлдэхэд ашигласан хэрэгсэл, олсон орлогыг хураахаас гадна ял шийтгүүлсэн хүний бүх хөрөнгийг, тэр дундаа хууль ёсны дагуу, хууль ёсны эх сурвалжаас олж авсан эд хөрөнгийг ч хураан авдаг.

Хөрөнгө хураах нь шийтгэлийн үүрэг гүйцэтгэдэг CAN (Зүүн Европ ба Төв Азийн авлигын эсрэг сүлжээ)-ийн орнууд.

- Армени, Беларусь, Казахстан, Киргизстан, Тажикстан, Туркменистан, Украйн зэрэг багтана.

Урьдчилсан сэргийлэх үүрэг гүйцэтгэдэг бүс нутгийн орнууд.

- Азарбайжан, Гүрж, Литва, Молдав, Румын, Серби, Словени, Хорват, Монтенегро, Эстони зэрэг.

Ихэнх улс оронд эд хөрөнгө хураах нь хохирогчид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, эсвэл хураагдсан эд хөрөнгийн зардлаар тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нөхөн сэргээх чиг үүрэгтэй байдаг.

Хөрөнгө хураах журмын 3 үе шат:

1. Мөрдөн шалгалтын үе. Энэ үе шатанд гэмт хэргээс олсон орлогыг илрүүлэх, байршлыг тогтоох, эзэмшигчийн талаарх нотлох баримт (мөн эд хөрөнгийн талаарх мэдээлэл)-ыг цуглуулах санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг хийнэ. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд шүүхийн шийдвэрээр хожим хураан авах зорилгоор түр зуурын арга хэмжээ (битүүмжлэх) авч болно.
2. Шүүхийн үе шат. Энэ үе шатанд ял шийтгэл оногдуулах (эсвэл, цагаатгах), эсвэл эд хөрөнгийг хураах талаарх эцсийн шийдвэрийг шүүхээс гаргана.
3. Удирдах үе шат. Төрөөс тухайн эд хөрөнгийг бодитоор хураан авч олон улсад хөрөнгө хуваарилах, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах үе шат.

Манай улсын хувьд хөрөнгө, орлогыг хураах эрх зүйн зохицуулалтыг ерөнхийд нь:

1. Эрүүгийн эрх зүйн хөрөнгө, орлогыг хураах ажиллагаа
2. Иргэний журмаар хөрөнгө, орлогыг хураах ажиллагаа
3. Захиргааны журмаар хөрөнгө, орлогыг хураах ажиллагаа гэж хувааж байна.

Үүнээс эрүүгийн эрх зүйн хөрөнгө, орлого хураах ажиллагаа нь in personam буюу шүүгдэгчийн эсрэг биечлэн хийх үйлдэл байдаг ба яллах дүгнэлтэд эд хөрөнгийг хураах саналтай байгаа тухай тусгадаг. Ингэхдээ ял шийтгэл заавал оногдуулах шаардлагатай ба эд хөрөнгө хураах нь тухайн ялын нэг хэсэг болдог. Эрүүгийн эрх зүйн хөрөнгө, орлого хураах ажиллагаа нь тухайн шүүгдэгчийн ашиг сонирхлоор хязгаарлагддаг бөгөөд үүнд шүүгдэгчийн хууль бус үйл ажиллагаанаас олсон орлогыг хамаатуулан ойлгодог. Өөрөөр хэлбэл, яллагдагчийг ялласан тодорхой тооллогод хамаарах эд хөрөнгөөр хязгаарлагддаг.

Түүнчлэн, Монгол Улсын хувьд хөрөнгө орлогыг хураах нь Эрүүгийн хуульд заасан албадлагын арга хэмжээний нэг төрөл юм. Албадлагын арга хэмжээ нь эрүүгийн ялын зорилгыг хангах, ялын үр нөлөөг дээшлүүлэхийн тулд шүүхийн шийтгэх тогтоолоор эрүүгийн хуулийн тусгай ангийн санкцид заасан ялаас гадна ялтанд тусгай үүрэг хүлээлгэж эрхийн хязгаарлалт тогтоохыг хэлнэ гэж тодорхойлсон.[65] Үүнээс гадна албадлагын арга хэмжээг гэмт хэрэг үйлдэж, гэм буруутайд тооцогдсон этгээдэд шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулдаг, ялын бус шинжтэй, төрийн албадлагын арга хэмжээний төрлийг хэлнэ гэж тодорхойлсон байдаг.

Албадлагын арга хэмжээг Эрүүгийн хууль тогтоомжид ялаас гадна аюулгүй байдлын арга хэмжээг оногдуулж болдог дуалист тогтолцоо бүхий улс орнуудад албадлагын гэхээс илүүтэйгээр тухайн этгээдийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн гэмт этгээдийн өөрийнх нь эрх ашигт нийцсэн арга хэмжээг давхар хэрэглэдэг бөгөөд энэ нь ял биш, гагцхүү гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж буй этгээдэд шүүхээс оногдуулсан ялтай хамтатган хэрэглэдэг жишиг гадаадын улс орнуудад тогтсон байна.

Албадлагын арга хэмжээ нь эрүүгийн хариуцлагын нэг хэлбэр боловч ялаас ялгагдах дараах онцлог шинжтэй.[66] Үүнд:

- Албадлагын арга хэмжээ нь ял биш /ялын шинжийг агуулдаггүй/, ялын төрөл биш. Эрүүгийн хариуцлагын зорилгод нийцүүлэн гэмт хэрэг үйлдэж, гэм буруутай болох нь нотлогдсон хүнтэй үр дүнтэй ажиллах, хувь хүнд нөлөөлөх шинжтэй арга хэмжээ юм.
- Албадлагын арга хэмжээ нь эрүүгийн хариуцлагын нэг төрөл бөгөөд бие даасан ойлголт, ухагдахуун юм.
- Эрүүгийн хуулийн тусгай ангид гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ялын төрөл, хэмжээг тухайн зүйлийн санкцид тогтоосон, шүүх тухайн төрөл, хэмжээний дотор ял оногдуулдаг бол тусгай ангийн санкцид албадлагын

65 Д.Бадам, “Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй (Тайлбар толь)”, (Уб, 2018), 6 дахь тал.

66 Г.Гантөмөр, Б.Энхболд, С.Гантулга, “Эрүүгийн эрх зүй Ерөнхий анги”, (Уб, 2020), 419-420 дахь тал.

арга хэмжээ, түүний төрөл, хэмжээг хуульчилж өгөөгүй. Харин Эрүүгийн хууль дахь тусгай журмаар зохицуулдаг.

Албадлагын арга хэмжээний дээрх тодорхойлолт болон зорилгод хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ нь мөн хамаарна. Өөрөөр хэлбэл, хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ нь эрүүгийн ялын зорилгыг хангах, ялын үр нөлөөг дээшлүүлэхийн тулд шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулах ялын бус, өөрийн эрх ашигт нийцсэн тусгай үүрэг хүлээлгэж эрхийн хязгаарлалт тогтоох үйл ажиллагаа юм.

Монгол Улсын хөрөнгө, орлогыг хураах эрх зүйн зохицуулалтын түүхэн уламжлал

1926, 1929, 1934 оны Шүүх цаазын бичиг, 1942, 1961, 1986, 2002 оны Эрүүгийн хуульд хөрөнгө, орлогыг хураах зохицуулалтыг хуульчилж ирсэн байна. 1926, 1929, 1934 оны Шүүх цаазын бичиг, 1942, 1961, 1986, 2002 оны Эрүүгийн хуульд нэмэгдэл ял болон ялын шинжтэй хуульчилж ирсэн байна.

1926, 1929 оны Шүүх цаазын бичгүүдийн 5 дугаар зүйлд хөрөнгийг хураахыг албадан хураах, 1934 оны Шүүх цаазын бичгийн 14 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт хөрөнгийг бүрэн буюу заримыг хураах, 1942 оны Эрүүгийн хуулийн 19 дүгээр зүйлд энэ ялыг хэвээр хуульчилсан. Эд хөрөнгө хураах ялыг 1926, 1929 оны хуулиар гол төлөв эд хахууль авах ба өгөх, хулгайлах, булаах, дээрэмдэх, контрабанд үйлдэх, хууль бус ан хийх, улсын ба ард олны эд хөрөнгийг сүйтгэх зэрэг шунахай сэдэлт бүхий гэмт хэргүүдэд эд хөрөнгө хураах ялыг нэмэгдэл ялын чанартай хэрэглэж байсан. 1934, 1942 оны Шүүх цаазын бичгийн 1 дүгээр бүлэгт заасан “Хувьсгалын эсэргүү гэмт хэргүүд”-эд буудан алж, хөрөнгийг бүрэн хураах ял шийтгэхээр хуульчилсан нь онцгой зохицуулалт болсон.[67]

1961 оны Эрүүгийн хуулийн 25 дугаар зүйлд “Шийтгэгдсэн этгээдийн амины өмч буюу бусадтай хамтарсан дундын өмч болох хөрөнгөнөөс түүнд оногдох хэсгийг бүгдийг буюу заримыг үнэ төлбөргүйгээр хурааж улсын санд нийлүүлэхийг хөрөнгө хураах ял гэнэ.” гэж анх удаа энэ ялын тодорхойлолтыг хуульчлагдсан бөгөөд шийтгэгдсэн этгээдийн амины өмч буюу бусадтай хамтарсан дундын өмч болох хөрөнгөнөөс түүнд оногдох хэсгээс шийтгэгдсэн этгээд буюу түүний асрамжаар амьдарч байгаа хүмүүст зайлшгүй хэрэгцээтэй хурааж болохгүй эд зүйлийн жагсаалтыг хуульчлан заасан нь өмнөх хуулиудын зохицуулалттай харьцуулбал энэрэнгүй агуулгатай болсон. Энэ хуулийн төрийн эсрэг онц аюултай гэмт хэргүүд болох эх орноосоо урвах /45 дугаар зүйл/, тагнуул үйлдэх /46 дугаар зүйл/, улс төрийн зорилгоор аллага хийх /47 дугаар зүйл/, хорлон сүйтгэх /48 дугаар зүйл/ гэмт хэргүүдэд цаазаар авч хөрөнгө хураах нэмэгдэл ял хуульчлагдсан.[68]

1986 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 20 дугаар зүйлд эд хөрөнгө хураах ялыг нэмэгдэл ялын чанартай хэрэглэхээр зааж байсныг хэвээр үлдээж, төрийн эсрэг онц аюултай гэмт хэргүүдэд нэмэгдэл ял болгон хэрэглэхээр тусгажээ.[69]

67 С.Жанцан, “Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол (ялын тухай сургаал) II боть”, (Уб, 2014), 174 дэх тал.

68 Мөн тэнд.

69 Мөн тэнд.

2002 оны Эрүүгийн хуульд эд хөрөнгө хураах ял хэмээн ялын нэг төрөл болгон хуульчилсан байна. Ингэхдээ 46.2-т зааснаар зөвхөн нэмэгдэл ялын чанартай хэрэглэхээр зохицуулсан байна. Энэхүү ялыг тус хуулийн 49 дүгээр зүйлд дараах байдлаар зохицуулсан байна.

- Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд ногдох эд хөрөнгийг бүгдийг буюу заримыг үнэ төлбөргүйгээр албадан гаргуулж, төрийн өмчлөлд шилжүүлэхийг эд хөрөнгө хураах ял гэнэ.
- Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл буюу түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг болон бусад хэрэгслийг эд хөрөнгө хураах ялаас гадуур заавал хураана.

2002 оны Эрүүгийн хуульд заасан 145 дугаар зүйл буюу Бусдын эд хөрөнгийг хулгайлах, 147 дугаар зүйл буюу Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, 148 дугаар зүйл буюу Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, 149 дүгээр зүйл буюу Бусдын эд хөрөнгийг авахаар далайлган сүрдүүлэх, 156 дугаар зүйл буюу Банкны тухай хууль тогтоомж зөрчих, 157 дугаар зүйл буюу Банкны үйл ажиллагаанд албан тушаалын байдлаа урвуулж буюу эрх мэдлээ хэтрүүлж оролцох, 161 дүгээр зүйл буюу Хориглосон үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэх, 166 дугаар зүйл буюу Татвар төлөхөөс зайлсхийх, 175 дугаар зүйл буюу Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх, 176 дугаар зүйл буюу Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, онцгой албан татварын тэмдгийг хуурамчаар үйлдэх, ашиглах, борлуулах гэсэн гэмт хэргүүдэд эд хөрөнгө хураах ялыг нэмэлтээр оногдуулж болохоор хуульчилсан байна.

Харин шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд хөрөнгө, орлогыг хураах зохицуулалтыг 7.2 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэгт зааснаар албадлагын арга хэмжээ болгон хуульчилсан байна. Энэхүү албадлагын арга хэмжээг тус хуулийн 7.5 дугаар зүйлд тухайлан хуульчилж зохицуулсан байна.

2002 оны Эрүүгийн хуульд нэмэгдэл ялд хамаарч байсан эд хөрөнгө хураах ялыг 2015 оны Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ болгон хуульчилсан нь дараах учир шалтгаантай. Үүнд:

1. Монгол Улсын олон улсын гэрээнд эд хөрөнгө хураах явдлыг гэмт хэрэгт оногдуулах ял байх нь зохисгүй гэж үздэг.
2. Монгол Улсын олон улсын гэрээнд гэмт хэргийн замаар олсон хөрөнгө, орлогыг гэдгийг Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн тэмцэх конвенцын агуулгаар тодорхойлох шаардлагатай.
3. Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл буюу түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, хэрэгслийг 2002 оны Эрүүгийн хуульд /49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсэг/ эд хөрөнгө хураах ялаас гадуур заавал хураана гэж заасан нь хэрэглэхэд бэрхшээл учруулж байсан.[70]

3.2.2. Хөрөнгө, орлогыг хураахтай холбоотой зохицуулалтын практик хэрэгжилт

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Эрүүгийн хууль болон ЭХХШтХ-д заасан хөрөнгө, орлогыг хураахтай холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж

70 Сургагч багш нарт зориулсан гарын авлага, ХЗДХЯ, (Уб, 2017), 81 дэх тал.

байна вэ? Авлигын гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлогыг хураахад хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

Үнэлгээ:

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг 2015 онд баталж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөх болсон. Тус хуулийн 7.2 дугаар зүйлд заасан албадлагын арга хэмжээний нэгэн төрөлд хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг хуульчилсан байна.

Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд шүүх энэхүү арга хэмжээг хэрэглэхдээ хураах эд зүйл, түүний үнэ, эд хөрөнгө, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналга, галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйлийг шийтгэх тогтоолдоо нэг бүрчлэн заана.

Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд оногдох эд хөрөнгө гэдгийг иргэний эрх зүйн агуулгаар ойлгоно. /Монгол Улсын Иргэний хуулийн 127 дугаар зүйл. Гэр бүлийн гишүүн хуваарьт эд хөрөнгөө /хувьд оногдох/ өөрийн үзэмжээр эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах эрхтэй бөгөөд өөрөөр тохиролцоогүй бол гэр бүлийн гишүүд хувийн үйл ажиллагаатай холбогдсон үүргээ өөрийн хуваарьт эд хөрөнгөөр хариуцдаг.[71]

Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "...Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого гэж Монгол Улсад бол энэ хуулийн тусгай ангид заасан, гадаад улсад бол тухайн улсын хуулиар нэг жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдэж шууд, шууд бусаар олсон эдийн, эдийн бус хөрөнгө, түүний үнэ, түүнээс олсон ашиг, орлого, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, ашиглахаар завдсан техник, хэрэгслийг ойлгоно..." гэж заажээ.

Мөн энэ хуульд хуулийн этгээдэд оногдуулах эрүүгийн хариуцлага болгож хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг Эрүүгийн хуулийн 9.2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт хуульчилсан байна. Улмаар тус хуулийн 9.5, 9.6 дугаар зүйлд үүнийг тухайлан зохицуулсан байна.

Эрүүгийн хуулийн 9.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "...Хуулийн этгээдийг татан буулгасан тохиолдолд хөрөнгө, орлогыг хураан авч гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөхөд зарцуулж, үлдсэн хөрөнгийг улсын төсөвт шилжүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ..." гэж, 9.6 дугаар зүйлийн 1-д "...Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хуулийн этгээдийн ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулна..." гэж, тус зүйлийн 2 дахь хэсэгт "....Хуулийн этгээдийн хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг хэрэглэхдээ энэ хуулийн 7.5 дугаар зүйлд заасан журмыг баримтална..." гэж тус тус заажээ.

Өөрөөр хэлбэл, хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ нь зөвхөн гэмт хэрэг үйлдсэн хүнд хамааралтай зогсохгүй хуулийн этгээдэд оногдуулж болох эрүүгийн хариуцлагын төрөл юм.

71 Мөн тэнд..

Шүүхийн шийтгэх тогтоолд заасан эд хөрөнгийг бүрэн хурааж, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөхөөс гадна хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалд зарцуулна. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогын хэмжээ нь хохирлоос илүү гарсан тохиолдолд улсын төсөвт шилжүүлснээр уг арга хэмжээг биелүүлсэнд тооцно.

Монгол Улсын хувьд 2019-2022 онд хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг гүйцэтгэсэн байдлыг харвал:

Хүснэгт 1.16. *Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авагдсан*

Он	Гүйцэтгэвэл зохих этгээдийн тоо	Гүйцэтгэсэн этгээдийн тоо	Үлдэгдэл
2019	523	400	123
2020	961	641	320
2021	1316	808	508
2022	1640	1161	479

Дээрх хүснэгтээс харвал, жил ирэх тусам хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авсан тохиолдол нэмэгдэж байна. Монгол Улсын хэмжээнд сүүлийн 3 жилийн хугацаанд АТГ-аас хяналт шалгалтын үйл ажиллагааны хүрээнд албан тушаалтны хөрөнгөжих, нуугдмал хөрөнгийг олж илрүүлсний үндсэн дээр битүүмжлэх болон хураан авсан эд хөрөнгийн нарийвчлан үзвэл:

2024 оны эхний хагас жилд шалгагдсан гэмт хэргийн улмаас 428.213.259.053,06 (дөрвөн зуун хорин найман тэрбум хоёр зуун арван гурван сая хоёр зуун тавин есөн мянга тавин гурав) төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 213.721 956.513,75 (хоёр зуун арван гурван тэрбум долоон зуун хорин нэгэн сая есөн зуун тавин зургаан мянга таван зуун арван гурав) төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 20.756.341.909,00 (хорин тэрбум долоон зуун тавин зургаан сая гурван зуун дөчин нэгэн мянга есөн зуун ес) төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна.

2023 онд шалгагдсан гэмт хэргийн улмаас 845.797.805.525,00 (найман зуун дөчин таван тэрбум, долоон зуун ерэн долоон сая, найман зуун таван мянга таван зуун хорин тав) төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 238.689.979.559,00 (хоёр зуун гучин найман тэрбум, зургаан зуун наян есөн сая, есөн зуун далан есөн мянга таван зуун тавин ес) төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 17.137.615.448,00 (арван долоон тэрбум, нэг зуун гучин долоон сая, зургаан зуун арван таван мянга, дөрвөн зуун дөчин найм) төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна.

Нийт учирсан хохирлын 28.2 хувийг мөрдөн шалгах ажиллагааны явцад нөхөн төлүүлж, хахуулийн 8.680.730.871 (найман тэрбум зургаан зуун наян сая долоон зуун гучин мянга найман зуун далан нэг) төгрөгийн үнэ бүхий бэлэн мөнгө, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө хураан авсан.

2022 онд шалгагдсан гэмт хэргийн улмаас 5.024.895.829.317,00 (таван их наяд, хорин дөрвөн тэрбум, найман зуун ерэн таван сая, найман зуун хорин есөн мянга, гурван зуун арван долоо) төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах

ажиллагааны явцад 2.374.934.309.243,00 (хоёр их наяд гурван зуун далан дөрвөн тэрбум, есөн зуун гучин дөрвөн сая, гурван зуун есөн мянга, хоёр зуун дөчин гурав) төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 518.039.332.298,00 (таван зуун арван найман тэрбум, гучин есөн сая, гурван зуун гучин хоёр мянга, хоёр зуун ерэн найм) төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна.

Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, гэмт хэргийн улмаас учирсан хохирол 5 дахин, нөхөн төлүүлэлт 24.7 дахин, битүүмжлэн хамгаалсан хөрөнгө 4.3 дахин өссөн үзүүлэлттэй байна. Нийт учирсан хохирлын 47.3 хувийг нөхөн төлүүлээд байна. Хахуулийн 18,874,521.566 төгрөгийн үнэ бүхий бэлэн мөнгө, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө хураан авсан.

Тохиолдол 3.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хэлтсийн даргаар ажиллаж байхдаа иргэд, аж ахуйн нэгжээс хясан боогдуулах замаар их хэмжээний хахууль авсан “Н.Б” нарт холбогдох хэргийг УДШ 2021 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр эцэслэн шийдвэрлэсэн. Тус хэргийг мөрдөн шалгах ажиллагааны үед эд мөрийн баримтаар “Н.Б”-ийн Хан-Уул дүүргийн Жаргалан хотхон дахь орон сууцанд нэгжлэг хийж зочны өрөөнөөс 5.1 сая төгрөг, 16.460 ам.доллар, унтлагын өрөөнөөс 17.5 сая төгрөг, сейфээс 140 сая төгрөг, 127.117 ам.доллар, 50.000 юань, мөн түүний ажлын өрөөнөөс 10.8 сая төгрөг, 8600 ам.доллар тус тус хураан авсан нь нийт 230.8 сая төгрөг, 152.177 ам.доллар, 70.000 юань олсон бөгөөд дээрх мөнгө, валютыг шүүхээс Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлийн 3, 4-т заасан гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого гэж үзэх үндэслэл гэж үзэн улсын төсөвт шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Хэрэг эцэслэгдэн шийдвэрлэгдсэний дараа “Н.Б”-ээс хураан авч Авлигатай тэмцэх газарт битүүмжлэгдэн хадгалж байсан 173.4 сая төгрөг, 152.177 ам.доллар, 50.000 юань, “Г.Э”-ээс хураан авсан 5 сая төгрөг, “С.Б”-ээс хураан авсан 5 сая төгрөг буюу нийт 639,244,450 төгрөгийг мөрдөгчид Сангийн яамны төрийн сангийн дансанд тушааж улсын орлого болгосон.

Мөн энэ хэргийн өөр нэг холбогдогч болох “Э.А”-д холбогдох хэргийг тусгаарлаж, анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаажээ. Мөрдөн шалгах ажиллагааны явцад “Э.А”-йн өмчлөлийн Рапид хотхон дахь орон сууцнаас 57.4 сая төгрөг, 20.000 юань эд мөрийн баримтаар хураан авсан байна.

2022 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт “ ...Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссанаас үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж улсын орлого болгоно...” гэх зохицуулалтыг шинээр нэмж хуульчилсан. Тус зохицуулалтыг хуульчилснаар гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх эрх зүйн үндэслэл болох боловч гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг шүүхийн шийдвэрээр хурааж улсын орлого болгох боломжит зохицуулалт юм. Гэхдээ нэгэнт гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дуусаж яллагдагчаар татаж болохгүй үндэслэл тогтоогдсон учир гэмт хэрэг үйлдсэн хүний хувьд тухайн хөрөнгийг хэрхэн гэмт хэрэг үйлдэж олсон гэдгийг нотлох, яаж шалгах нь маш эргэлзээтэй зохицуулалт болохоор байна.

ЭХХШтХ-ийн 21 дүгээр бүлэгт “Хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтын талаар авах арга хэмжээ”-ний талаар зохицуулсан бөгөөд тус хуулийн 21.1 дүгээр зүйлд “Хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хадгалах” зохицуулалтыг тусгажээ. Тус зүйлийн 1 дэх хэсэгт “...Шүүх, прокурор, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтын хадгалалт, хамгаалалтыг хариуцна...” гэж мөн зүйлийн 3 дахь хэсэгт “...Хураан авсан үндэсний болон гадаад валютыг тусгай дансанд байршуулна...”, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “...Хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйлийг хадгалах талаар гаргасан оролцогчийн хүсэлтийг үндэслэн тэдгээрийг хаана хадгалахыг шүүх, прокурорын шийдвэрт тусгайлан зааж болно...” гэж тус тус заажээ.

Үүнээс гадна Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 191 дүгээр зүйлд хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх талаар зохицуулсан. Гэвч ЭХХШтХ, ШШГтХ-д битүүмжилсэн хураасан эд хөрөнгийг тусгай зориулалтын байранд хадгалуулна гэж заасан боловч ийм төрлийн хадгалах байртай шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага манай улсад байхгүй байна. Тусгай зориулалтай байр нь онцгой бараа бүтээгдэхүүн эд зүйлсийг хадгалах тоног төхөөрөмж тоноглогдсон байх шаардлагыг дотроо агуулна. Гэвч хууль болон журмаар тэрхүү тусгай зориулалтын байрын стандартыг тогтоогоогүйгээс шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүрэг бүхий байгууллагууд дотооддоо сул, чөлөөтэй өрөө тасалгаандаа хураан авсан хөрөнгөө хадгалж байна. Хөрөнгийг хадгалах тусгай зориулалтын байрын стандарт байхгүйгээс дээр дурдсан хөрөнгийн шинж чанар алдагдах эрсдэлийг давхар үүсгэж байна.[72]

Өөрөөр хэлбэл, хуульд зохицуулалт нь тусгагдсан боловч практикт тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломжгүй байна. Мөн албадлагын арга хэмжээ авч хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйлийг улсын орлого болгож, улсын төсөвт оруулахтай холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нарийвчлан зохицуулсан журам байхгүй байна.

Авлигын эсрэг хуулийн 33 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...Шүүгч энэ хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчсөн этгээдийн тухайн олсон эд хөрөнгө, орлогыг хураах буюу давуу эрхийг хүчингүй болгох...” гэж заажээ. Тус хуулийн 7.1.7-д “...албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх...” гэж, 7.1.8-д “...үндэслэлгүйгээр хөрөнгөжих...” гэж заажээ. Энэ нь Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд заасан Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэгтэй ижил агуулгыг илэрхийлж байна. Нөгөөтээгүүр, Эрүүгийн хуульд заасан дээрх 2 төрлийн гэмт хэргийн шинжийг бүрэн хангаагүй ч /тухайлбал, Үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн тохиолдолд хохирлын хэмжээ 100.000.000 төгрөг хүрэхгүй байх/ Авлигын эсрэг хуульд зааснаар хариуцлага хүлээх боломжтой мэт харагдаж байгаа боловч практикт энэхүү зохицуулалтаар хариуцлага хүлээсэн тохиолдол байхгүй байна.

Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуульд заасан дээрх гэмт хэрэг үйлдсэн гэж үзвэл шүүх Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийг хэрэглэн шийдвэр гаргаж байна. Нөгөөтээгүүр, Авлигын эсрэг хуулийн 33 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт дээрх тохиолдолд хариуцлага хүлээлгэхээр заасан боловч гэмт хэргийн шинж,

72 Э.Өнөболд, Э.Цэрэнханд, “Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг оногдуулсан хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй зарим асуудал” сэдэвт өгүүлэл, https://legaldata.mn/buteel/pdf?id=1755

бүрэлдэхүүн хангагдаагүй тохиолдолд зөвхөн Авлигын эсрэг хуульд зааснаар хариуцлага хүлээлгэх боломжгүй байна. Энэ нь тухайн хүнийг хариуцлагаас чөлөөлөх, ял завших боломжийг олгож байна. Иймд хууль хоорондын уялдаа холбоог хангах зайлшгүй шаардлагатай байна.

Түүнчлэн, өндөр түвшний авлигын гэмт хэргийн замаар олсон хөрөнгө, орлогыг эргүүлэн авахад нэлээдгүй бэрхшээл тулгардаг байна. Хөрөнгө эргүүлэн өгөх олон улсын шинжтэй үйл ажиллагаанд хууль тогтоомжийн ялгаатай байдал, мэргэшсэн техник ур чадвар хангалтгүй байх, эргүүлэн өгөх үйл явцыг удирдан зохион байгуулах улс төрийн хүсэл зориг сул байх, авлигын асуудалд нэрвэгдсэн, улс төр, эдийн засаг, нийгэм нь тогтворгүй байгаа улс оронд хөрөнгө эргүүлэн өгөхтэй холбоотой зовнил түгшүүр зэрэг техникийн болон улс төрийн янз бүрийн саад бэрхшээл тулгарч байна. Авлига, мөнгө угаах, хөрөнгө буцаан олгох ажиллагаанд хоёр өөр улсын шүүх өндөр түвшний авлигын гэмт хэргийн замаар олсон хөрөнгийг хураан авах, эргүүлэн өгөх асуудалд өөр өөр өнцгөөс ханддаг нь ихээхэн бэрхшээл учруулж байгааг улс орнууд анхааралдаа авч энэхүү сорил бэрхшээлийг арилгахад хүчин чармайлтаа нэгтгэх шаардлагатай байна.[73]

3.2.3. Хөрөнгө, орлогыг хураахтай холбоотой харьцуулсан судалгаа, олон улсын туршлага

Европын холбооны парламентын зөвлөлийн тайлан: (Хөрөнгө хураахтай холбогдох заалтууд)

Шийтгэх үндэслэлээр эд хөрөнгө хураах (4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг)

Дөрөвдүгээр зүйлийн 1-д гишүүн орнуудын хувьд гэмт хэрэг үйлдсэн нь эцсийн байдлаар хууль бусаар хөрөнгө олж авсан, хөрөнгийн үнэлгээ нь орлоготой таарч байгаа тохиолдолд хөрөнгө хураах боломжтой. Үүнийг өөр улсын шүүхээс тогтоогдсон байж болно.

Бүх гишүүн улсууд эцсийн шийдвэр гарсан тохиолдолд гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг хураах боломжтой.

Ихэнх гишүүн орнуудад (Бельги, Болгар, Чех, Грек, Испани, Кипр, Франц, Итали, Латви, Люксембург, Мальта, Унгар, Австри, Польш, Португал, Словени, Словак, Финлянд, Швед) гэмт хэргийн хэрэгсэл, олсон орлоготой дүйцэхүйц үнэ бүхий бусад хөрөнгийг хураан авдаг. Зарим гишүүн орнууд (Герман, Эстони, Ирланд, Хорват, Литва, Нидерланд) хурааж авах эд хөрөнгийн үнэд дүйцэх хэмжээний мөнгийг ялтанд төлөх боломжийг олгодог.

Шийтгэх үндэслэлгүй эд хөрөнгө хураах (4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг)

Хэрэв 4 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу эцсийн тогтоолоор хууль бусаар олж авсан хөрөнгө гэдэг нь тогтоогдсон хэдий ч өвдсөн эсвэл оргон зайлсан буюу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжгүй болсон тохиолдолд сэжигтэн, яллагдагч хэмээн үзэж гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг хураах боломжийг бүрдүүлэх ёстой.

73 Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлогыг буцаан авах ажиллагаа /Гарын авлага/, УЕПГ, АТГ, (2020).

Мальта, Австри улсад өвчтэй, оргон зайлсан тохиолдолд урьд нь ял шийтгэлгүйгээр эд хөрөнгийг хураах боломжтой байдаг. Румынд улсад төрийн албан тушаал хашиж буй албан тушаалтны эх үүсвэр нь тодорхойгүй хууль бус хөрөнгө, орлогыг хурааж авдаг.

Швед улсад (жишээ нь, гэмт хэрэгтэн нас барсан эсвэл хөөн хэлэлцэх хугацаа дууссан) яллагдагч, сэжигтэн этгээдэд ял оноох боломжгүй тохиолдолд хөрөнгө хураах асуудлыг хэлэлцдэг бол Грекийн мөнгө угаахтай тэмцэх хууль тогтоомж нь гэмт хэрэгтэн нас барсан, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа зогссон эсвэл хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж мэдэгдсэн тохиолдолд гэмт хэргийн улмаас олсон орлогыг хураах боломжтой болдог.

Өргөтгөн хураах (5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг)

5 дугаар зүйлд хураах хугацааг сунгах тухай заалтуудыг тусгасан гэмт хэрэгтнээс хураан авч буй эд хөрөнгө нь эдийн засгийн үр өгөөжтэй байх ёстой гэж үздэг.

Тухайлбал, Австри улсад эд хөрөнгийг хууль бусаар олсон гэж үзэх үндэслэл тогтоогдвол хөрөнгө, орлогыг хураан авах хугацааг сунгахыг зөвшөөрдөг. Эстони, Кипр, Нидерландад шүүх эд хөрөнгийг хууль бус үйл ажиллагаанаас олсон гэж «таамаглах» боломжтой байдаг бол Испанид шүүх эд хөрөнгө нь хууль бус үйл ажиллагаанаас үүдэлтэй болохыг «бодит нотолгоонд үндэслэн шийдвэрлэх» ёстой байдаг.

Хугацаа сунгах шаардлагатай эрүүгийн гэмт хэргийн хамрах хүрээ (5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг)

5 дугаар зүйлийн 2-т гэмт хэргийн тодорхой жагсаалт, мөн Захирамжийн 3 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт (Европын холбооны баримт бичиг эсвэл үндэсний хууль тогтоомжийн дагуу) хорих ялаар шийтгэгдэх ёстой гэж заасан байдаг. Энэ нь хамгийн багадаа 4 жил.

Гуравдагч этгээдээс хураах (6 дугаар зүйл)

6 дугаар зүйлд сэжигтэн эсвэл яллагдагчаас гуравдагч этгээдэд шилжүүлсэн гэмт хэргийн орлогыг хураах эрхийг гишүүн орнуудаас шаарддаг. 6 дугаар зүйлд зааснаар гуравдагч этгээд хөрөнгө шилжүүлэн авахдаа нөгөө хүний зорилго нь эд хөрөнгөө хураалгахаас зайлсхийсэн явдал гэдгийг мэдэж байсан тохиолдолд гуравдагч этгээдийн эд хөрөнгийг хураах боломжтой байдаг.

Бельги, Унгар, Австри, Словак зэрэг улсад эд зүйлийг сэжигтэн, яллагдагч, гуравдагч этгээдийнх эсэхээс үл хамааран хураан авах, хууль бус гарал үүсэлтэй бол хураан авах ерөнхий дүрмийг баримталдаг.

Гуравдагч этгээд хөрөнгө шилжүүлэн авахдаа зорилго нь хураалгахаас зайлсхийж байсан гэдгийг мэдэж байсан эсвэл мэдсэн байх ёстой гэсэн шаардлагыг ихэнх гишүүн орнуудын хууль тогтоомжид тусгасан байдаг (Болгар, Чех, Герман, Эстони, Ирланд, Грек, Испани, Кипр, Литва, Мальта, Нидерланд, Польш, Португал, Словени, Финлянд, Швед).

Франц, Латви, Люксембургийн хууль тогтоомжид ял шийтгүүлсэн этгээдийн өмч хөрөнгийг хураах тухай заалт байдаг. Италийн хууль тогтоомж нь ялтны өмч барааг (бие хүн, хуулийн этгээдээр дамжуулан) хураахыг зөвшөөрдөг. Хорватын хуульд "хүний нэр дээр шилжүүлсэн эсвэл сайн санааны үүднээс олж авааг үй" хууль бус өмчийг хураах тухай зохицуулсан байдаг.

6 дугаар зүйлд зөвхөн "гуравдагч этгээдэд шууд болон шууд бусаар шилжүүлсэн буюу олж авсан орлогыг" хураах тухай заасан.

Румынд үндэсний хууль тогтоомжид гэр бүлийн гишүүд болон хуулийн этгээдийн өмч хөрөнгийг хураах тухай заасан байдаг. Болгар улсад уг заалтыг иргэний эд хөрөнгийг хураах тухай хуулиар сольсон бөгөөд энэ нь гэмт хэргийн тодорхой жагсаалтад хамаарна.

6 дугаар зүйлийн 2-т шударга гуравдагч этгээдийн эрхийг зөрчих ёсгүй гэж заасан. Гишүүн орнуудын хууль тогтоомж нь уг удирдамжийн энэ заалттай нийцэж байгаа бөгөөд гуравдагч этгээдийн шударга ёсны эрхийг хадгалахыг баталгаажуулдаг.

Царцаах (7 дугаар зүйл)

7 дугаар зүйлийн 1-д гишүүн орнуудын хувьд шаардлагатай арга хэмжээний дагуу битүүмжлэх боломжийг бүрдүүлдэг бөгөөд энэ нь дараагийн шатанд эд хөрөнгийг хураан авах зорилготой. Мөн эд хөрөнгийг үрэгдүүлэхгүйн тулд яаралтай царцаах (худалдах, шилжүүлэх, үрэх, үрэх гэх мэт) хэрэгтэй гэж үздэг.

Гишүүн орнуудад эд хөрөнгийг дараа нь хураах зорилгоор битүүмжлэх боломжтой болсон. Герман, Чех, Эстони, Ирланд, Итали, Латви, Люксембург, Унгар, Польш, Португал, Словак, Швед улсууд прокурор, хууль сахиулах байгууллагад яаралтай арга хэмжээ авч, шүүхийн зөвшөөрөл авахаас өмнө эд хөрөнгийг битүүмжлэх эрхийг олгосон байна.

7 дугаар зүйлийн 2-т гишүүн орнууд гуравдагч этгээдийн өмч хөрөнгийг дараа нь хураах зорилгоор битүүмжлэх боломжийг олгохыг шаарддаг. Энэ нь бүх гишүүн орнуудад хэрэгжих боломжтой байдаг.

Бүгд Найрамдах Солонгос Улс:

Авлига хахуулиар олж авсан хөрөнгийг хурааж авах тухай хууль тогтоомж

Гуравдугаар зүйл (Авлигын аргаар олж авсан эд хөрөнгийг хураах)

1. Авлигын аргаар олж авсан эд хөрөнгийг дараах тохиолдолд хурааж болно. Хэрэв бусад хууль тогтоомжид авлигын аргаар олж авсан эд хөрөнгийг хураах шаардлагатай тохиолдолд хууль, журмын дагуу тухайн эд хөрөнгийг хураана.
2. (1)-д заасны дагуу хураан авахаар заагдсан авлигын аргаар олж авсан эд хөрөнгө нь бусад эд хөрөнгөтэй холилдсон тохиолдолд авлигын аргаар олж авсан эд хөрөнгө болон бусад өмчийг /"нийлсэн эд хөрөнгө" гэж үзэн/ хурааж болно.

Дөрөвдүгээр зүйл (хураагдах нөхцөл)

1. 3 дугаар зүйлд заасны дагуу хөрөнгө хураах нь авлигын аргаар олж авсан, эсвэл нийлсэн эд хөрөнгө нь гэмт хэрэг үйлдсэн этгээдээс өөр этгээдэд хамаарахгүй тохиолдолд: Гэмт хэрэг үйлдэгдсэнээс хойш тухайн эд хөрөнгийг өөр этгээдэд шилжүүлэн хариуцуулах тохиолдолд тухайн хөрөнгийг авлигын арга замаар олж авсан, гэмт хэргийн шинжтэй гэдгийг мэдсээр байж авсан тохиолдолд “Эрүүгийн орлого нуун дарагдуулах, ял шийтгэл оногдуулах тухай хуулийн 4 дүгээр зүйл”-д зааснаар хурааж авч болно.
2. Авлигын аргаар олж авсан эд хөрөнгө, эсвэл нийлсэн эд хөрөнгө нь гэм буруутай этгээдээс өөр этгээдэд өвлөгдсөн, үнэ төлбөргүй өгсөн буюу бэлгийн шугамаар авсан, үнэлгээнээс хямд үнээр эзэмшиж байгаа бол бүхэлд нь буюу хэсэгчлэн хурааж болно. Энэ нь тухайн хүн эдгээрийн аль нэг байдлаар эд хөрөнгө авахдаа гэмт хэргийн талаар мэдээгүй байсан тохиолдолд.
3. 3 дугаар зүйлд заасны дагуу ил тод, барьцаа зээл, хууль ёсны, үүрэг хариуцлагын хүрээнд эд хөрөнгийг хураасан тохиолдолд гэмт хэрэг үйлдэхээс өмнө болон дараа өөр этгээд авсан тохиолдолд үүрэг хариуцлага хүлээнэ.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Тус судалгааны хүрээнд зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан Авлигын гэмт хэрэг, тэр дундаа Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэг, Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг сонгон авч судалсан болно. Харин практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд авлигын гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураан авах ажиллагааг сонгон авч Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлд заасан хөрөнгө, орлогыг албадан хураахтай холбоотой эрх зүйн зохицуулалт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр бүлэгт заасан хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтын талаар авах арга хэмжээтэй холбоотой зарим зохицуулалтыг сонгон авч хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэллээ. Мөн харьцуулсан судалгаа хийж, гадаадын сайн туршлага бүхий улс, орнууд болох Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Америкийн Нэгдсэн Улс, Оросын Холбооны Улс гэх мэт тухайн эрх зүйн зохицуулалтын хүрээнд өөр өөр улс сонгон авч судалсан болно.

Тус судалгааны ажлыг гүйцэтгэж, дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

1. Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэг, тэр дундаа Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэргийн тухайд Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн шинжийг зөв тодорхойлж, нотлох ажиллагааг энэ гэмт хэргийн өөрийн онцлогт тулгуурлан явуулах нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт энэ төрлийн гэмт хэргийн хувьд хангагдах урьдач нөхцөл болохоор байна. Манай улсын хувьд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг Эрүүгийн хуульд тусгасан боловч тус хэргийн илрүүлэлт, шүүхээр шийдвэрлэгдэж буй байдал хангалттай түвшинд хүрээгүй болох нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Түүнчлэн, хууль хоорондын уялдаа холбоог хангах нь нэн чухал асуудал болоод байна. Ялангуяа Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан Авлигын гэмт хэргийн хувьд практикт үйлдэгдэж буй тоог шүүхээр шийдвэрлэгдэж буй хэргийн тоотой харьцуулахад маш бага байх магадлалтай. Учир нь авлигын гэмт хэрэг нь нуугдмал гэмт хэрэг төдийгүй, тухайн хэргийн илрүүлэх, мөрдөн шалгах, гэмт хэрэг үйлдсэнийг нотлох, олж тогтоох ажиллагаа нарийн ээдрээ төвөгтэй байдаг. Иймд зөвхөн Эрүүгийн хуульд авлигын гэмт хэргийн ялын бодлогыг чангатгах, хөөн хэлэлцэх хугацааг уртасгах, авлигын зарим гэмт хэрэг үйлдсэн ялтныг хорих ялын хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоохгүй байх гэх мэт зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулснаар тухайн асуудал шийдэгдэхгүй.

Харин авлигын гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй АТГ-ын албан хаагчдыг чадавхжуулах, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, НҮБ-ын Авлигын эсрэг конвенц, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудын өөр хоорондын уялдаа холбоог сайжруулах, Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүн, шинжийг оновчтойгоор тодорхойлох гэх мэт илүү үр дүнтэй аргуудыг хэрэглэх нь зүйтэй.

Хуулийн хоорондын уялдаа холбоо хангалтгүй байгаа нь авлигын гэмт хэрэг үйлдсэн хүнд ял завших боломжийг олгож байгаа төдийгүй Эрүүгийн хуульд Авлигын гэмт хэргийн зохицуулалт, тэр дундаа Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн зохицуулалт зорилгодоо хангалттай хүрэхгүй байна.

Иймд Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан Авлигын гэмт хэргийн шинж, бүрэлдэхүүнийг зөв тодорхойлж, бусад хуулийн зохицуулалттай уялдуулах зайлшгүй шаардлагатай байна.

2. Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт хэргийн төрлөөс үл хамаарч, гэмт хэргийн ангилал болон гэмт хэрэгт оногдуулж буй ялын дээд хэмжээгээр тодорхойлогддог түгээмэл жишиг байна. Иймд авлигын гэмт хэрэг нь нийтийн ашиг сонирхлыг хөндөж, нийгэмд учруулах хор аюул, хохирлын хэмжээ их байдаг тул түүнд оногдуулах ялын хэмжээг хүндрүүлэн тогтоодог.

Монгол Улсад авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа нь ихээхэн удаашралтай байгаагаас хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болж, хэргийг хэрэгсэхгүй болгох явдал түгээмэл байгаа нь олон нийтийн шүүмжлэлд өртөж байна.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалтыг хуульчилсан бөгөөд тус зохицуулалтад хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт оруулж, эрх зүйн хийдэл бүхий асуудлыг зохицуулахыг оролдож байсан билээ. Гэхдээ өнөөдөр ч тус зохицуулалтад эрх зүйн хийдэлтэй асуудлууд байсаар байна. Иймд тухайн асуудлуудыг нэгтгэн дүгнэж, цогц байдлаар засаж сайжруулах шаардлагатай.

Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Албадлагын арга хэмжээг Эрүүгийн хууль тогтоомжид ялаас гадна аюулгүй байдлын арга хэмжээг оногдуулж болдог дуалист тогтолцоо бүхий улс орнуудад албадлагын гэхээс илүүтэйгээр тухайн этгээдийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн гэмт этгээдийн өөрийнх нь эрх ашигт нийцсэн арга хэмжээг давхар хэрэглэдэг бөгөөд энэ нь ял биш, гагцхүү гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж буй этгээдэд шүүхээс оногдуулсан ялтай хамтатган хэрэглэдэг жишиг гаднын улс орнуудад тогтсон байна.

Монгол Улсын хувьд хөрөнгө орлогыг хураах нь Эрүүгийн хуульд заасан албадлагын арга хэмжээний нэг төрөл юм. Албадлагын арга хэмжээ нь эрүүгийн ялын зорилгыг хангах, ялын үр нөлөөг дээшлүүлэхийн тулд шүүхийн шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн санкцид заасан ялаас гадна ялтанд тусгай үүрэг хүлээлгэж эрхийн хязгаарлалт тогтоохыг хэлнэ гэж тодорхойлжээ.

Судалгааны хүрээнд Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлд заасан “Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ”, ЭХХШтХ-ийн 21 дүгээр бүлэгт заасан “Хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтын талаар авах арга хэмжээ”-ний зохицуулалтын заримыг сонгон авч үнэлэхэд хуульд зохицуулалт нь тусгагдсан боловч практикт тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал тогтоогдож байна.

Манай улсад албадлагын арга хэмжээ авч хураан авсан хөрөнгө, орлогыг улсын орлого болгож, улсын төсөвт оруулахтай холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нарийвчлан зохицуулсан журам байхгүй. Мөн хууль хоорондын уялдаа холбоо хангалтгүй байгаагаас зарим зохицуулалт практикт хэрэгжих боломж хязгаарлагдаж байна.

Түүнчлэн, өндөр түвшний авлигын гэмт хэргийн замаар олсон хөрөнгө, орлогыг эргүүлэн авахад нэлээдгүй бэрхшээл тулгардаг байна. Нөгөөтээгүүр, хөрөнгө эргүүлэн өгөх олон улсын шинжтэй үйл ажиллагаанд хууль тогтоомжийн ялгаатай байдал, мэргэшсэн техник ур чадвар хангалтгүй байх, эргүүлэн өгөх үйл явцыг удирдан зохион байгуулах улс төрийн хүсэл зориг сул байх, авлигын асуудалд нэрвэгдсэн, улс төр, эдийн засаг, нийгэм нь тогтворгүй байгаа улс оронд хөрөнгө эргүүлэн өгөхтэй холбоотой зовнил түгшүүр зэрэг техникийн болон улс төрийн янз бүрийн саад бэрхшээл тулгарч байна.

Авлига, мөнгө угаах, хөрөнгө буцаан олгох ажиллагаанд хоёр өөр улсын шүүх өндөр түвшний авлигын гэмт хэргийн замаар олсон хөрөнгийг хураан авах, эргүүлэн өгөх асуудалд өөр өөр өнцгөөс ханддаг нь ихээхэн бэрхшээл учруулж байгааг улс орнууд анхааралдаа авч энэхүү сорил бэрхшээлийг арилгахад хүчин чармайлтаа нэгтгэх шаардлагатай байна.

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг

1. Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992, №1;
2. Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний байгууллагын конвенц, 2003;
3. Авлигын эсрэг хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2006, №35;
4. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2012, №8;
5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017, №24;
6. Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002, №5;
7. Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016, №7;
8. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №23;
9. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
10. Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
11. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”;
12. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”;

Ном, сурах бичиг, судалгааны тайлан, эмхэтгэл

1. Авлига болон эдийн засгийн зарим гэмт хэргийн эрх зүйн шинж практик / гарын авлага/, УДШ, (Уб, 2022).
2. АТГ-ын 2020 оны үйл ажиллагааны тайлан.
3. АТГ-ын 2021 оны үйл ажиллагааны тайлан.
4. АТГ-ын 2022 оны үйл ажиллагааны тайлан.
5. АТГ-ын 2023 оны үйл ажиллагааны тайлан.
6. АТГ-ын 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан.
7. Б.Мөнгөнсувд, Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг нотлох ажиллагаа, (Уб, 2024).
8. Г.Гантөмөр, Б.Энхболд, С.Гантулга, “Эрүүгийн эрх зүй Ерөнхий анги”, (Уб, 2020).
9. Г.Халиунаа, Б.Ариунжаргал, “Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа” тулгамдаж буй асуудал, (Уб, 2021).
10. Д.Бадам, “Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй (Тайлбар толь)”, (Уб, 2018).
11. Д.Баярсайхан, Харьцуулсан эрүүгийн эрх зүй, (Уб, 2012).
12. Ж.Батмөнх, Хууль бусаар баяжих гэмт хэргийг Монгол улсын Эрүүгийн хуульд хуульчлах шаардлага, (Уб, 2011).
13. Жан-Пьер Бран, Анастасия Сотиропаолу нар, Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага /Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж, Хоёр дахь хэвлэл/, АТГ, УЕПГ, Дэлхийн банк, (Уб, 2020).

14. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном -2016, МУГХУСАЗЗ, (Уб, 2017).
15. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном -2017, МУГХУСАЗЗ, (Уб, 2018).
16. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном- 2018, МУГХУСАЗЗ, (Уб, 2019).
17. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном- 2019, МУГХУСАЗЗ, (Уб, 2020).
18. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном- 2020, МУГХУСАЗЗ, (Уб, 2021).
19. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном- 2021, МУГХУСАЗЗ, (Уб, 2022).
20. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном- 2022, МУГХУСАЗЗ, (Уб, 2023).
21. С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /Ерөнхий ба тусгай анги/, 2011 он;
22. С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол – I боть, 2009 он;
23. С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол /Ялын тухай сургаал/ - II боть, (Уб, 2014).
24. С.Нарангэрэл, Монгол Улсын эрүүгийн эрх зүй, (Уб, 1999).
25. С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг (Анхны хэвлэл), (Уб, 2007).
26. Сургагч багш нарт зориулсан гарын авлага, ХЗДХЯ, (Уб, 2017).
27. Х.Сэлэнгэ, Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа: Онол, практикийн асуудал, (Уб, 2024).
28. Ч.Хосбаяр, “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэг ба авлигын эсрэг олон улсын конвенцууд дахь түүний агуулга, Шударга ёс сэтгүүл, АТГ, (Уб, 2019).
29. Э.Зууннасан, Б.Батзориг, БНХАУ-ын Эрүүгийн ба Эрүүгийн заргын хууль, (Уб, 2006).
30. Эндрью Дорнбьерер, Үндэслэлгүй хөрөнгөжилт, Тайлбарлаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж боловсруулагчдад зориулсан гарын авлага, (Уб, 2021).
31. Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал, ХЗЯ, (Уб, 2013).
32. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, ХЗДХЯ, (Уб, 2022).
33. Эрүүгийн эрх зүй гарын авлага, ХЗДХЯ, (Уб, 2007).

Гадаад хэл дээрх эх сурвалж

1. Criminal Law of the People’s Republic of China https://www.fmprc.gov.cn/ce/cgvienna/eng/dbtyw/jdwt/crimelaw/t209043.htm
2. German Criminal Code https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html
3. Уголовный кодекс российской федерации http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_10699/

Бусад эх сурвалж

1. Judcouncil.mn, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн албан ёсны цахим хуудас.
2. Prokuror.mn, Монгол Улсын Ерөнхий Прокурорын Газрын албан ёсны цахим хуудас;

3. Shuukh.mn, Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан;
4. Авлигатай тэмцэх газар, Түүхэн замнал https://iaac.mn/erhem-zorilgo-undsen-zarchim-tuuhen-zarchim
5. Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 1011 дугаар магадлал;
6. УДШ-ийн 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 121 дугаар тогтоол;
7. ХУД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 08 сарын 13-ны өдрийн 377 дугаар цагаатгах тогтоол;
8. ЧД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 2021/ШЦТ/516 дугаартай шийтгэх тогтоол.

ХОЁР. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ

(Цахим хавтаст хэрэг, цахим нотлох баримт, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт)

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Хууль зүйн ухааны доктор (Dr.jur.)

Судалгааны багийн бусад гишүүд:

М.Түвшинжаргал	Эрдэмтэн нарийн бичгийн дарга Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
О.Энхүслэн	Эрдэм шинжилгээний ахлах ажилтан (LL.M)
Б.Ариунжаргал	Эрдэм шинжилгээний ажилтан (LL.M)
Т.Билгүүн	Эрдэм шинжилгээний ажилтан
Х.Санчир	Эрдэм шинжилгээний ажилтан

Судалгааг захиалагч: Хууль зүй, дотоод хэргийн яам

Судалгааг гүйцэтгэж хүргүүлсэн огноо: 2024.05.09.

АГУУЛГА

УДИРТГАЛ 75
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ 76
1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох нь 76
1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох 78
1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох 78
1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох 81
1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох 82
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох 82
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ 83
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ 84
3.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэрэгтэй холбоотой хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ 84
3.2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим нотлох баримттай холбоотой хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ 109
3.3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалттай холбоотой зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ 136
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ 152
НОМ ЗҮЙ 157

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.7-д “...Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно...” гэж заажээ. Уг зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улсын Их Хурал 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан. Үүнтэй холбогдуулан тодорхой асуудлыг судлан холбогдох хуулийн төслийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн боловсруулах талаар тусгасан “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 18 дугаар тогтоолыг баталсан.

Энэхүү тогтоолын 5 дахь хэсэгт “хавтаст хэргийг цахимжуулах, цахим суурьтай нотлох баримтыг шүүх хуралдаанд шинжлэн судлах, цахим суурьтай нотлох баримтыг үнэлэх журмыг боловсронгуй болгох” гэж, 8 дахь хэсэгт “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах нөхцөл боломжийг бий болгох, 6-аас дээш сар хадгалах эрх зүйн орчныг бүрдүүлэх” гэж тус тус заажээ. Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь процессыг боловсронгуй болгох, хялбаршуулах, үр нөлөөг дээшлүүлэх, найдвартай байдлыг бүрдүүлэх улмаар хүний эрхийг хангах, хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх гэх мэт ач холбогдолтой гэж үзжээ.

Иймд дээр дурдсан асуудалд хамаарах Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх хэрэгцээ, шаардлага үүсэж байна.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн. Төлөвлөх үе шатанд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох нь

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 оны 7 сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлээд 7 жилийн хугацаа өнгөрч байгаа боловч тус хуульд эрх зүйн хэм хэмжээний хийдэлтэй, практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй маргаан бүхий зохицуулалт нэлээдгүй олон байна. Энэ нь нийгэм хөгжин өөрчлөгдөхийн хэрээр нийгмийн харилцаанд зохицуулагдаж байгаагүй шинэ ойлголт, асуудлууд бий болсоор байдагтай холбоотой.

Манай улс сүүлийн жилүүдэд шүүхийн цахимжилттай холбоотой асуудалд нэлээд анхаарал хандуулах болсон бөгөөд нийгэм, цаг үеийн олон талт нөлөөлөлтэй шууд хамааралтай. Нөгөөтээгүүр, дан ганц шүүхийн цахимжилт төдийгүй нийгмийн бүхий л салбарт цахимжилт явуулах, цахим засаглалыг сайжруулах хэрэгцээ шаардлага бий болсоор байна.

Иймээс ч Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Цахим Монгол” арга хэмжээг авч хэрэгжүүлэх тусгасан бөгөөд үүнтэй холбогдуулан цахим багц хуулийг батлан хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд Монгол Улсын Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 5 сарын 18-ны өдрийн А/24 тушаалаар “Цахим үндэстэн” баримтлах чиглэл (2022-2027)-ийг баталсан.

Өөрөөр хэлбэл, манай улс цахим засаглалыг хөгжүүлэх чиглэлд хууль, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Нийтийн мэдээллийн ил байдлын тухай хууль, Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хуулийг батлан хэрэгжүүлж эхэлсэн бол бодлого, стратегийн хүрээнд Шинэ сэргэлтийн бодлого, Төрийн бүтээмжийн сэргэлт, “Цахим үндэстэн” дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байна.[1]

Түүнчлэн, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод төрийн үйл ажиллагааг үе шаттай бүрэн цахимжуулах зорилтыг тавьж, шүүхийн үйл ажиллагаанд цахим технологи нэвтрүүлж, үйл ажиллагааг шуурхай, чирэгдэлгүй

1 2023 оны 3 сарын 23-24-ний өдөр зохион байгуулагдсан “Монгол Улсын Шүүхийн цахимжуулалт” ОУБХ-д ЦХХХ-ны дэд сайд Ж.Эрхэмбаатарын хэлэлцүүлсэн “Монгол Улсын шүүхийн болон хуулийн байгууллагуудыг цахимжуулах мэдээлэл технологийн үүрэг” сэдэвт илтгэлээс. https://docs.google.com/presentation/d/13pM_ibCxZi40sK3fBIKzffalucrgXh1X/edit#slide=id.p25

болгох асуудлыг тусгасан. Мөн шүүхийн шинэчлэлийн хүрээнд баталсан Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.11-д *"...шүүхийн Тамгын газрын үйл ажиллагаанд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх нэгдсэн бодлого батлах, хэрэгжүүлэх..."* гэж, 74 дүгээр зүйлийн 74.1.6-д *"...шүүхийг дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр хангах нэгдсэн бодлого батлах, хэрэгжүүлэх..."* гэж тус тус заасан бөгөөд дээрх зохицуулалтуудтай уялдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 332 дугаар тогтоолоор "Шүүхэд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх нэгдсэн бодлого"-ыг баталсан.

Мөн Улсын ерөнхий прокурорын газраас "Прокурорын байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөө"-г Төрийн албаны тухай хууль, "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдэд нийцүүлэн боловсруулсан бөгөөд энэхүү стратеги төлөвлөгөөнд дараах 5 зорилтыг дэвшүүлж, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон байна. Үүнд:

- Олон нийтэд прокурорын байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байдлаар сурталчлан таниулж, эерэг хандлагыг нэмэгдүүлэх;
- Прокурорын үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлыг хангах;
- Прокурорын хяналтын ажлын чанар, үр нөлөөг сайжруулж, боловсронгуй болгох;
- Хамт олны дунд эерэг хандлагыг төлөвшүүлж, удирдлагын манлайллыг сайжруулах;
- Цахим шинэчлэлийг хэрэгжүүлэх замаар ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх.

Энэхүү зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд прокурорын байгууллага үйл ажиллагаандаа мэдээллийн технологийн дэвшил, инновац нэвтрүүлэх, ажлын үр нөлөө, бүтээмжийг нэмэгдүүлэх, их өгөгдлийг бодлогын шийдвэр гаргахад ашиглах, зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, статистикийн үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах зэрэг арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэн ажиллаж байна.[2]

Дээрхээс дүгнэвэл, шүүх эрх мэдлийн байгууллагуудын цахимжилттай холбоотой асуудлууд хууль, эрх зүйн хүрээнд тусгалаа олж бодлогын баримт бичгүүдэд тодорхой байдлаар зохицуулжээ. Мөн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд ч энэхүү агуулга тусгагдсан байна.

Харин ЭХХШтХ-ийн 11.11 дүгээр зүйлд заасан Эрүүгийн хавтаст хэрэгтэй холбоотой зохицуулалтад 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар "... Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг, хэргийн материал нь цаасан болон цахим хэлбэртэй байж болно. Цаасан баримтыг шүүх, прокурор, мөрдөн шалгах эрх бүхий байгууллагын ажилтан хөрвүүлж, тоон гарын үсгээр баталгаажуулна..." гэж, мөн 1.16 дугаар зүйлд "Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах" зохицуулалтыг шинээр нэмсэн нь цахим хавтаст хэрэг, цахимжуулсан хавтаст хэрэг, цахим нотлох баримт зэрэг цахимтай холбоотой зарим асуудлыг ЭХХШтХ-д хуульчлах урьдач нөхцөл болсон гэж үзэж болох юм.

2 ГХУСА33, Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2022, (Уб, 2023), 86 дахь тал.

Гэвч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтад цахим хавтаст хэрэг, цахим нотлох баримт болон түүний хадгалалттай холбоотой зохицуулалтыг нарийвчлан тусгаагүй байна. Иймд тус судалгааны хүрээнд дээрх асуудлыг судалж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зөвлөмжийг өгөх юм.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээ хийх хүрээг тогтоох ажиллагаа нь хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг. Энэ нь үнэлгээ хийх болсон шалтгаанууд (өмнө тодорхойлсон)-тай харилцан уялдаа, хамааралтайгаар хийгдэх ажиллагаа бөгөөд тодорхойлогдсон эерэг, сөрөг нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудал, үр дагавар бүхий харилцаатай холбогдсон хуулийн зохицуулалтыг илрүүлнэ.

Үнэлгээ хийх хүрээг тогтоохдоо үнэлгээ хийх ажлын төлөвлөлт, зохион байгуулалт, хүний нөөц, цаг хугацаа, гарах зардлыг заавал харгалзан үзэх хэрэгтэй. Хуулийг бүхэлд нь үнэлэх ажиллагааны зардал ихэвчлэн хэт өндөр гардаг тул зөвхөн тухайн хуулийн зорилго, үнэлгээний шалгуурт хамгийн ихээр нөлөөлж болохуйц хуулийн зохицуулалтыг зөв сонгох шаардлагатай.

Иймд ЭХХШтХ-д заасан цахим нотлох баримт, хавтаст хэрэг, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалалттай холбоотой зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхээр тогтлоо.

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараах гурван шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1. Зорилгод хүрсэн түвшин;
2. Практикт нийцэж байгаа байдал;
3. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал;

I. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Тухайн хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд төлөвлөсөн зорилгодоо хүрсэн эсэх байдлыг тогтооно. Үндсэн болон дагалдах зорилгыг тодорхойлно.

2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.1 дүгээр зүйлд зааснаар *“…гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино...”* гэж зорилгыг тодорхойлжээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах зохицуулалтуудыг тухайн шалгуур үзүүлэлтийн түвшинд судлахаар тогтов.

Хүснэгт 2.1. *Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт*

№	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт	Тус зохицуулалтыг сонгосон үндэслэл
1	**11.11 дүгээр зүйл.Эрүүгийн хэргийн хавтаст хэрэг** 1.Хавтаст хэрэг нь хэрэгт тусгасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шийдвэр, баримт бичиг, хэрэгт хавсаргасан бусад баримт бичиг, зүйлээс бүрдэнэ. 2.Мөрдөгч, прокурор, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нь оролцогч, бусад оролцогчоос гаргасан хүсэлт, гомдол, мэдээлэл, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шийдвэр, бусад баримт бичиг, эд зүйлийг тэмдэглэл үйлдэж, эсхүл төрийн албан хэрэг хөтлөх журмын дагуу бүртгэж, хавтаст хэрэгт тусгаж, хавсаргана. 3.Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэний баталсан болон бичсэн баримт бичгийг хавтаст хэрэгт шууд тусгана. 4.Овор хэмжээ, бусад шалтгааны улмаас хавтаст хэрэгт тусгах боломжгүй эд зүйл, баримт бичгийг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу тэмдэглэлд тусгана. 5.Хавтаст хэрэг нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад мөрдөгчид, энэ хуульд заасан үндэслэлээр шилжүүлсэн, эсхүл татаж хянаж байгаа бол прокурорт, шүүхийн шатанд тухайн шүүхэд байна.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хавтас хэргийг цахимжуулаагүйн улмаас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа нь цаг үеэсээ хоцорч, бусад эрх зүйн зохицуулалт, бодлогын баримт бичигт нийцэхгүй байна. Мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хавтаст хэргийг цахим болгосноор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шуурхай, тасралтгүй, найдвартай, ил тод байх байдал хангагдана.

II. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Шинэчлэн найруулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно.

Энэ шалгуур үзүүлэлтээр ихэвчлэн тухайн хуулийг хэрэгжүүлэгч этгээдээс болон байгууллагаас уг зохицуулалт практикт хэрэгжиж чадаж байгаа эсэхийг тогтооход түлхүү ашигладаг. Мөн хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон практикт гарч байгаа эерэг болон сөрөг ямар үр дагаврууд байгааг тодорхойлох бөгөөд хуулийн зохицуулалтын ойлгомжтой байдал, түүнийг хэрэгжүүлэх боломж бололцоо практикт байгаа эсэхийг тооцох нь чухал юм. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах зохицуулалтуудыг тухайн шалгуур үзүүлэлтийн түвшинд судлахаар болов.

Хүснэгт 2.2. *Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт*

№	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт	Тус зохицуулалтыг сонгосон үндэслэл
1	**16.14 дүгээр зүйл.Нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх** 1.Энэ хуульд заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулах замаар нотлох баримт цуглуулж, хэрэгт цугларсан эд мөрийн баримт, баримтат мэдээллийг мөрдөн шалгах ажиллагааны болон шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны тэмдэглэлд тусгаж бэхжүүлнэ..	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах нөхцөл боломжийг сайжруулах шаардлага үүсэж байна.
	2.Нотлох баримт бэхжүүлэхдээ тэмдэглэл үйлдэхийн зэрэгцээ мэдээллийг тусгасан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийх, гэрэл зураг авах, гар зураг үйлдэх, ул мөрнөөс хэв, хээ буулгаж авах зэрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчимд нийцэх бусад аргыг хэрэглэнэ 3.Мөрдөгч нотлох баримт цуглуулж, бэхжүүлэхдээ тэдгээрийг устах, гэмтэх, үрэгдэхээс хамгаалах арга хэмжээг авна. 4.Нотлох баримт цуглуулж, бэхжүүлэхдээ иргэний амь нас, эрүүл мэндэд аюултай, эсвэл тэдний нэр төрийг гутаан доромжлох, хүнлэг бус, хэрцгий харьцах, айлган сүрдүүлэх, мэдүүлэг, тайлбар, дүгнэлт гаргуулахаар тулган шаардах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэхийг хориглоно.	

III. “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Иргэд, хуулийн этгээдээс хуулийг хэрхэн хүлээн авч буй байдал болон хуулийг хэрэгжүүлж байна уу? гэдгийг тодорхойлно. Хуулийн үр нөлөөг шууд хүртэж байгаа этгээдээс авах нь зохимжтой. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах зохицуулалтуудыг тухайн шалгуур үзүүлэлтийн түвшинд судлахаар болов.

Хүснэгт 2.3. *Хүлээн зөвшөөрөгдсөн байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт*

№	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт	Тус зохицуулалтыг сонгосон үндэслэл
1	**16.1 дүгээр зүйл.Нотлох баримт** 1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан аливаа баримтат мэдээллийг нотлох баримт гэнэ. 2.Баримтат мэдээлэл нь гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлэг, эд мөрийн баримт, баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг, мөрдөгчийн магадалгаа, энэ хуульд заасны дагуу бэхжүүлсэн кино ба гэрэл зураг, зураглал, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, эрх бүхий байгууллагын цахим мэдээллийн сангаас цахим гарын үсгээр баталгаажуулж авсан лавлагаа, тодорхойлолт, ул мөрөөс авсан хэв, мөрдөн шалгах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл, хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас ирүүлсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл болон энэ хуульд заасан бусад баримтаар тогтоогдоно. 3.Прокурор, мөрдөгч, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээлэл, өргөдлийг шалгах, эрүүгийн хэргээс бусад зөрчил, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа, мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтын явцад хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, бэхжүүлсэн болон энэ хуулийн Дөчин хоёрдугаар бүлэгт заасан журмаар гадаад улсаас ирүүлсэн баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцож болно.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь нотлох баримтын төрөлд цахим нотлох баримтын төрлийг хуульчилж түүнтэй холбоотой процессыг зохицуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулж шуурхай, тасралтгүй, найдвартай, ил тод байх байдлыг хангана.

	3.Прокурор, мөрдөгч, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээлэл, өргөдлийг шалгах, эрүүгийн хэргээс бусад зөрчил, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа, мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтын явцад хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, бэхжүүлсэн болон энэ хуулийн Дөчин хоёрдугаар бүлэгт заасан журмаар гадаад улсаас ирүүлсэн баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцож болно. 4.Мөрдөгч энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу нотлох баримт цуглуулж, шалгаж, бэхжүүлнэ. 5.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцох нь тэдгээрийг шалгах зорилгоор мөрдөн шалгах ажиллагаа явуулахыг хязгаарлах үндэслэл болохгүй. 6.Нотлох баримтыг хууль бус арга, хэрэгслээр цуглуулж, бэхжүүлэхийг хориглоно. 7.Энэ хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж авсан баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцохгүй. 8.Шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдаанаар шинжлэн судалсан нотлох баримт шүүхийн шийдвэрийн үндэслэл болно. 9.Хавтаст хэрэгт авагдаагүй нотлох баримт шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй. 10.Хохирогч, яллагдагч тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөс гаргаж өгсөн эд зүйл, баримт бичиг, гомдол, мэдээлэл, бусад баримтыг мөрдөгч, прокурор авч хавтаст хэрэгт тусгаж хавсаргана. 11.Энэ хуульд заасны дагуу оролцогчоос прокурор, мөрдөгчид гаргаж өгсөн эд зүйл, баримт бичиг, гомдол, мэдээлэл, бусад баримтыг олж авсан эх сурвалжийг зааж хэлээгүй бол дангаараа нотлох баримт болохгүй. 12.Өмгөөлөгчийн хууль зүйн туслалцаа үзүүлэх, өмгөөлөх үйл ажиллагаатай холбоотой харилцааны баримтыг нотлох баримтаар тооцохгүй. 13.Шүүх, прокурор, мөрдөгч тухайн хэрэгт хамааралтай энэ хуульд заасны дагуу цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтыг хэргийг хянан шийдвэрлэхэд хангалттай эсэхийг бүхэлд нь үнэлнэ. 14.Нотлох баримтыг шинжлэн судлах явцад хэрэгт ач холбогдолтой, хамааралтай эсэхэд эргэлзэх үндэслэл байвал тухайн нотлох баримтыг шүүх, прокурорын шийдвэрийн үндэслэл болгохгүй. 15.Хавтаст хэрэгт тусгагдсан нотлох баримтыг шүүх хуралдаанаар шинжлэн судалж аль нь шүүхийн шийдвэрийн үндэслэл болохыг шүүх шийдвэрлэнэ.	

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрүүдээс сонгоно. Үүнд:

- Байх ёстой болон одоо байгаа;
- Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших;
- Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших;
- Тохиолдол судлах.

Судалгааны явцад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дээрх зүйл, заалтад хамаарах агуулга тус бүр дээр байх ёстой болон одоо байгаа, хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших, хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших, тохиолдол судлах харьцуулах хэлбэрийг аль тохирохыг ашиглана. Мөн гадаад улсуудын эрх зүйн зохицуулалт болон туршлагыг харьцуулан судална.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох

“Шалгуур үзүүлэлтийг томьёолох” гэдэг нь сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр тодорхой таамаглал дэвшүүлэх буюу асуулт тавьдаг бөгөөд үнэлгээний хүрээнд хамаарах зохицуулалтад “зорилгод хүрсэн түвшин ямар байна вэ?”, “практикт хэрхэн нийцэж байна вэ?”, “хүлээн зөвшөөрөгдөж байна уу?” гэсэн асуултын хүрээнд гүйцэтгэв.

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдөх байдал, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор шүүхийн шийдвэр буюу шүүхийн практик, энэхүү сэдвээр бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл уншиж судлах, түүхчилсэн судалгаа хийх, харьцуулсан судалгаа хийх, судалгааны тайлан унших, харьцуулалт хийх, холбогдох байгууллагаас судалгааг гаргуулах зэрэг аргыг ашиглана.

Мэдээлэл цуглуулах арга:

- Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах;
- Холбогдох субъектээс судалгаа авах аргыг сонгон хэрэгжүүллээ;

Байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, холбогдох сурах бичиг, гарын авлага, эмхэтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайланг цуглуулж үнэлгээ хийхэд ашиглав.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн судалгаа, харьцуулсан судалгааны аргад тулгуурлаж энэхүү судалгааг гүйцэтгэв.

Баримт бичгийн судалгаа: Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, эрдэмтэн, судлаачдын эрдэм шинжилгээний бүтээлүүд, илтгэл, өгүүлэл, судалгааны тайланг ашигласан болно.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зүйл, заалтуудыг сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу дараах байдлаар үнэлгээг хийсэн.

3.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэрэгтэй холбоотой хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ

Энэ хэсэгт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэргийн талаар нарийвчлан авч үзэх бөгөөд манай улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шинээр зохицуулж хуульчлах хэрэгцээ, шаардлага бий эсэхийг судална. Мөн бусад улсын сайн туршлагыг судална үзнэ.

3.1.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэргийн ойлголт, шинж

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт эрүүгийн хэргийн хавтаст хэргийг хэрэгт тусгасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шийдвэр, баримт бичиг, хэрэгт хавсаргасан бусад баримт бичиг, зүйлээс бүрдэнэ гэж тодорхойлсон. Мөрдөгч, прокурор, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нь оролцогч, бусад оролцогчоос гаргасан хүсэлт, гомдол, мэдээлэл, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шийдвэр, бусад баримт бичиг, эд зүйлийг тэмдэглэл үйлдэж, эсхүл төрийн албан хэрэг хөтлөх журмын дагуу бүртгэж, хавтаст хэрэгт тусгаж, хавсаргана. Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэний баталсан болон бичсэн баримт бичгийг хавтаст хэрэгт шууд тусгана. Овор хэмжээ, бусад шалтгааны улмаас хавтаст хэрэгт тусгах боломжгүй эд зүйл, баримт бичгийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу тэмдэглэлд тусгана. Хавтаст хэрэг нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад мөрдөгчид, энэ хуульд заасан үндэслэлээр шилжүүлсэн, эсхүл татаж хянаж байгаа бол прокурорт, шүүхийн шатанд тухайн шүүхэд байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар “...Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг, хэргийн материал нь цаасан болон цахим хэлбэртэй байж болно. Цаасан баримтыг шүүх, прокурор, мөрдөн шалгах эрх бүхий байгууллагын ажилтан хөрвүүлж, тоон гарын үсгээр баталгаажуулна...” гэх зохицуулалтыг нэмж тусгаснаас өөр хавтаст хэрэгтээ холбоотой зохицуулалтад цахим хавтаст хэргийн талаар зохицуулалт байхгүй байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цахим баримт буюу хавтаст хэрэг гэдэгт эрүүгийн хэрэгт хамааралтай цахим баримт бичиг, тухайлбал дижитал файл, цахим шуудан, мессеж, зураг болон бусад хэлбэрийн цахим өгөгдлийг хамаарууллан ойлгодог. Хууль эрх зүйн процессыг цахимжуулах эрүүгийн хэрэг бүртгэлт, шүүх хуралдаанд цахим баримт бичиг ашиглах жишиг ихээр дэлгэрч байгаа энэ үед цахим хавтаст хэрэг ихээхэн ач холбогдолтой юм. Эдгээр цахим баримт бичиг нь нотлох баримт, гэрчийн мэдүүлэг, хууль ёсны бусад мэдүүлэг байхаас гадна тухайн хэрэгт хамааралтай бусад материалыг агуулж болно. Цахим баримт бичиг нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны уламжлалт цаасан баримт бичигтэй ижил дүрэм, журамд захирагддаг бөгөөд энэ нь хүлээн зөвшөөрөгдөх

байдал, үнэн зөв, хамааралтай байх ёстой. Энэ тухай дараа дараагийн хэсгүүдэд нарийвчлан авч үзэх болно.

3.1.2. Монгол Улс дахь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим хавтаст хэргийн нөхцөл байдал, хэрэгцээ, шаардлага

Аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал болон дэлхий нийтээрээ цахим шилжилтэд шилжиж буй өнөө үед харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшил нь хөгжлийн хурдасгуур, цахим үндэстнийг цогцлоон хөгжүүлэх гол хүчин зүйл болж байна.[3] Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 3-т "...*Шүүх улсын төсвөөс санхүүжнэ. Шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана...*" гэж, мөн "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжихээр заасан. Ингэхдээ 2021-2030 он төрийн албаны хувьд төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх үе гэж тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл, Монгол Улс ойрын жилүүдэд төрийн алба, мөн түүний нэг төрөл болох шүүхийн албаны үр дүн, үр нөлөөг дээшлүүлэхийг зорьж байна. Төрийн үйлчилгээг ийнхүү үр дүн, үр нөлөөгөөр (output/outcome) хэмжиж дээшлүүлэх нь New public management буюу нийтийн албаны шинэ менежментийн ухаанаас улбаатай гэж үзэх бөгөөд энэ нь бизнесийн салбарын удирдлагын "багаар ихийг хийх" (do more with less) -тэй холбоотой зарим арга зүйг төрийн буюу нийтийн албанд нэвтрүүлж үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэжээ.[4] Энэ хүрээнд шүүхийн цахимжилтын асуудал нэн тэргүүнд хөндөгдөж байна.

Түүнчлэн, шүүхийн цахимжилт нь дан ганц шүүхийн асуудал биш шүүх эрх мэдлийн бүхий л байгууллага, цагдаа, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, улсын бүртгэлийн газар гэх мэт олон талын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцох интеграци учир хууль, эрх зүйн орчинд ач холбогдол өгөх ёстой. Тодруулбал, иргэн, эрүү, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх процессын хуулиудад цахимаар мэдүүлэх, цахим нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, үнэлэх, цахим хавтаст хэрэг үүсгэх, цахимаар мэтгэлцэх эрх зүйн орчныг бүрдүүлж өгөх хэрэгцээ шаардлага тулгараад байна.[5]

Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн хэрэг, цагдан хорих гэх мэт асуудлыг цахимжуулах боломжтой. Гадаад орнуудын туршлагаас харахад процессын хуулиудад ерөнхий зохицуулалтыг тусгаж, нарийвчилсан зохицуулалтыг журам батлан хэрэгжүүлдэг туршлага нийтлэг байна. Манай улс хуульдаа цахимаар мэдүүлэх, цахим хавтаст хэрэгтэй холбоотой ерөнхий зохицуулалтыг тусгах нь цаашдын шүүх болон бусад хуулийн байгууллагын цахимжилтад эергээр нөлөөлөх боломжтой.[6]

---

3 Монгол Улсын Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 5 сарын 18-ны өдрийн А/24 тушаалаар баталсан "Цахим үндэстэн" баримтлах чиглэл (2022-2027)

4 2023 оны 3 сарын 23-24-ний өдөр зохион байгуулагдсан "Монгол Улсын Шүүхийн цахимжуулалт" ОУБХ-д Н.Отгончимэгийн хэлэлцүүлсэн "Шүүхийн санхүүжилтийн механизмыг шинэчлэх шаардлага" сэдэвт илтгэлээс. https://docs.google.com/document/d/10Dj6LDSgTdrjOyp8UkrRIZ0z3Bq-DyvcaqLBsJSrEAw/edit

5 Г.Даваадорж: Шүүхийн цахимжилтад хууль эрх зүйн орчин ус агаар мэт хэрэгтэй байна, https://www.judcouncil.mn/site/news_full/13818

6 Мөн тэнд.

Улсын Их Хурлын Байнгын хороо 2015 онд “Шүүх хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн цахим нэгдсэн сүлжээ бүрдүүлэх тухай” 23 дугаар тогтоол гарсан. Энэ тогтоолыг үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн яам, шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон ХБНГУ-ын Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс хамтран хэрэгжүүлсэн *“Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчныг баталгаажуулах”* төслөөс шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудыг нэгдсэн сүлжээнд холбосон.[7]

2020-2021 онд “Ковид-19” цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд шүүхээс хэрэг, нэхэмжлэл, гомдлыг цахимаар хүлээн авах, хэргийн оролцогчдыг цахимаар шүүх хуралдаанд оруулах, зарим нотлох баримтыг төрийн эрх бүхий байгууллагуудаас авах, солилцох зэргээр үйл ажиллагааныхаа тодорхой хэсгийг цахимд шилжүүлэн, шүүн таслах ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулж байсан.[8]

Өөрөөр хэлбэл, Коронавирус цар тахлын дэгдэлттэй холбоотойгоор шүүх эрх мэдлийн байгууллагын хүрээнд үүссэн шүүхийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах, шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, шүүхийн үйлчилгээг иргэдэд үзүүлэх, шүүхийн байранд аюулгүй байдлыг хангах, хамгаалах, удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтын цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ шүүхийн зарим үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлсэн. Энэ нь шүүхийн ачаалал, цаг хугацаа, хөрөнгө санхүү, хүний нөөц, шүүх хурлын танхим зэрэг олон асуудлыг бууруулахад эерэг нөлөөлөл үзүүлж байсан тиймээс ч цаашид шүүхийн цахимжилтийн эрчимжүүлэх хэрэгцээ шаардлага байгааг практикт ажиллаж буй шүүх, прокурор, өмгөөлөгч, хууль сахиулах байгууллагын төлөөллүүд олон удаагийн хурал, сургалт, хэлэлцүүлгийн явцад хөндсөөр байна.

Энэ талаар сүүлийн жилүүдэд шүүхийн цахимжилт, цахим нотлох баримттай холбоотой олон улсын бага хурал, хэлэлцүүлэг, сургалтууд цөөнгүй зохион байгуулагдаж байгаагаас харж болох юм. Тухайлбал, 2022 оны 3 сарын 28, 29-ний өдрүүдэд АНУ-ын Элчин Сайдын яамны Нууц албанаас УЕПГ, АТГ, Цагдаагийн байгууллагын алба хаагчдад “Цахим нотлох баримт, криптовалют” сэдэвт мэргэшүүлэх сургалт, 2023 оны 5 сарын 15-18-ны өдрүүдэд УЕПГ, АНУ-ын Хууль зүйн яамны Прокурорын хөгжил, туслалцаа, сургалтын газрын хамтын ажиллагааны хүрээнд “Дижитал нотлох баримт болон Зэрлэг ан амьтдыг худалдаалах, Мөнгө угаах гэмт хэргийг шалгаж шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт сургалт, 2023 оны 9 сарын 16-ны өдөр УДШ-ийн дэргэдэх ШССМХ-гээс Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн шүүгч нарт “Цахим нотлох баримт” сэдэвт сургалт, 2023 оны 3 сарын 2-ны өдөр “Шүүх эрх мэдлийн байгууллагуудын цахимжилт ба шинэчлэлт” сэдэвт хэлэлцүүлэг, 2023 оны 9 сарын 3-16-ны өдрүүдэд БНСУ-ын Сөүл хотод зохион байгуулагдсан “Мөнгө угаах гэмт хэрэг ба цахим нотлох баримт” сэдэвт сургалт, 2023 оны 3 сарын 23-24-ний өдрүүдэд “Монгол Улсын шүүхийн цахимжуулалт” ОУБХ, 2024 оны 3 сарын 25-28-ны өдрүүдэд Монголын Хуульчдын холбоо, АНУ-ын Элчин сайдын яамтай хамтран хэрэгжүүлж буй “US speaker” хөтөлбөрийн хүрээнд “Шүүхийн цахимжилт ба тулгамдсан асуудал” сэдэвт хэлэлцүүлэг тус тус зохион байгуулагдсан байна.

7 Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын төсөлд хийсэн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ /Хөндлөнгийн судалгаа/, (Уб, 2023), 86-87 дахь тал.

8 Мөн тэнд, 87 дахь тал.

Үүнээс 2023 оны 3 сарын 23-24-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Монгол Улсын шүүхийн цахимжуулалт” ОУБХ-д хэлэлцүүлсэн зарим илтгэлүүдээс онцлох зүйлийг дурдвал:

Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар “Монгол Улсын Шүүх эрх мэдлийн байгууллага болон бусад холбогдох байгууллагуудын цахимжуулалт, уялдаа холбоог хангах нь” сэдэвт илтгэлдээ *“…Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай буюу цахим хэлбэрээр хүргэх нөхцөлийг бүрдүүлж, цахим гэрээ, хэлцлийн хууль, эрх зүйн орчныг сайжруулан цахим орчинд хийгдсэн гэрээ, хэлцлийг шүүхэд нотлох бариматаар тооцох, шүүхийн зарим үйл ажиллагааг цахимжуулж, баялаг бүтээгч, хувийн хэвшлийг дэмжих хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хуульт ёсыг бэхжүүлнэ…”* гэжээ.[9]

Мөн тус олон улсын бага хурлын үеэр шүүх, прокурор, цагдаагийн байгууллагын төлөөллүүд цахимжилттай холбоотойгоор санал, дүгнэлтээ танилцуулснаас дурдвал:

Шигтгээ 1.

Цахимжилттай холбоотойгоор шинэ, шинэ нэр томьёо хэрэглэгдэх болсон. Тухайн нэр томьёог анхнаас нь зөв тодорхойлж, нэр мөр ойлгох нь маш чухал. Нөгөөтээгүүр, цахимжих үйл явц нь цахим гарын үсгийн хэрэглээтэй нягт уялдаа холбоотой бөгөөд манай улсын хувьд цахим багц хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан цахим гарын үсгийн хэрэглээ эрс нэмэгдэж байна.

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүгч Г.Даваадорж

Шигтгээ 2.

Хавтаст хэргийг цахимжуулах нь маш чухал хэрэгжүүлэх шаардлагатай ажлын нэг болоод байна. Хэрэв цахим хавтаст хэрэгтээ байсан бол шүүхийн нотлох баримт шинжлэн судлан үе шатанд гэхэд дан ганц прокурор хавтаст хэргийн ... хуудас гээд тухайн судалж буй нотлох баримтыг ганцаар уншиж танилцуулахгүйгээр тухайн шүүх хуралдааны танхимд сууж буй хүн бүрд нээлттэй, үнэн зөв байх боломжийг бүрдүүлнэ. Нөгөөтээгүүр, хэрэг маргаан олон жил шалгагдан үргэлжилж байгаа тохиолдолд цаасан суурьтай баримт дэс дараалалгүйгээр үдэгдэж хавсрагддаг. Цахим хавтаст хэрэгт бол тухайн нотлох баримтыг төрөлжүүлэх, шүүгч, прокурор өмгөөлөгчдийн хувьд ч тухайн хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтуудын уялдаа холбоотой байдлыг шалгах, танилцахад хялбар болно.

Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга, УЕП-ын туслах прокурор О.Мөнхбаатар

9 Г.Даваадорж: Шүүхийн цахимжилтад хууль эрх зүйн орчин ус агаар мэт хэрэгтэй байна, https://www.judcouncil.mn/site/news_full/12923

Шигтгээ 3.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах ажлыг эхлүүлээд байна. Тухайлбал, 2023 оны 3 сарын 20-ны өдрөөс эхлээд ЧД-ийн Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, Замын цагдаагийн хэлтэстэй хамтраад 100 орчим эрх бүхий албан тушаалтанд эрх олгож шинэ программыг үйл ажиллагаанд нэвтрүүлэн ашиглаж эхлээд байна.

ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Статистик мэдээллийн хэлтсийн дарга, Цагдаагийн дэд хурандаа Д.Жанчивдорж

2024 оны 3 сарын 28-ны өдөр зохион байгуулагдсан “Шүүхийн цахимжилт ба тулгамдсан асуудал” сэдэвт хэлэлцүүлэгт ЦХХХ-ны сайд Н.Учрал хэлсэн үгэндээ *“...Цахим шилжилт нь зөвхөн технологийн асуудал биш юм. Холбогдох харилцааг зохицуулсан хууль тогтоомж, дүрэм журам буюу процесс, ажиллуулж чаддаг, ашиглаж чаддаг хэрэглэгч, тохиромжтой технологийн шийдэл нийлж байж цахим шилжилт амжилттай хэрэгжинэ. Тиймээс өнөөдөр манай улсад хүчин төгөлдөр хэрэгжиж буй 109 хуульд цахим шилжилтийг тусгасан нэмэлт, өөрчлөлтийг боловсруулж, УИХ-аар хэлэлцүүлэн батлуулж, энэ жилийн 3 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж эхлээд байна. 109 хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр шийдсэн гол өөрчлөлтүүдийн нэг нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд цаасан болон цахим эх хувийг адил тэнцүү, аль түрүүлж үүссэн хэлбэрийг нь эх нотлох бариммаар тооцох зохицуулалтыг тусгасан. Энэ өөрчлөлт нь шүүхийн цахим шилжилтэд маш том дэмжлэг, суурь нөхцөлийг нь хангаж өгч байна. Тухайлбал шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргахдаа цахим хэлбэрээр,“e-Mongolia”-аар, киоскоор дамжуулан гаргаж болно. Үүнийг хэвлэхгүй, цахим хэлбэрээр нь ХУР-аар дамжуулан шүүхийн системд илгээх, бусад нотлох баримт, лавлагаа тодорхойлолтыг албаны цахим шуудан, лавлагаа системээс мөн цахим хэлбэрээр нь бүрдүүлэн авч цахим хавтаст хэрэг бүрдүүлэх боломжтой. Цаашид хэрэг хянан шийдвэрлэх процессын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа юм…”* талаар дурджээ.

Мөн ЧД-ийн ЭХАШШ-ийн шүүгч Л.Галбадар “Эрүүгийн шүүхийн цахимжилт, тулгамдсан асуудал” сэдэвт илтгэлдээ *“…Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа бүхэлдээ цахимжих боломжгүй. Зарим цахимжих боломжгүй ажиллагаа байгаа харин шүүхийн зөвшөөрөл, хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх хэрэг, зөрчлийн хэргийн хүрээнд цахимжилт хийгдэх бүрэн боломжтой. Үүний тулд Цагдаагийн байгууллага зөрчил, гэмт хэргийн талаар гомдол, мэдээлэл ирэхэд тухайн гомдол, мэдээллийн дагуу хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагааг явуулахдаа сонголттойгоор буюу цахимаар эсвэл уламжлалт цаасан суурьтайгаар нотлох баримт бүрдүүлэх боломжийг хуульд тусгаж өгөх нь зүйтэй. Монголын хөрөнгө, хохирол үнэлэгчдийн холбоо цахимаар хохирлынхоо үнэлгээг гаргаад тоон гарын үсгээр баталгаажуулан явуулж болдог болсон гэсэн ч одоогийн байдлаар үүнийг шууд хэвлээд хавтаст хэрэгт хийх боломжгүй. Хэрэв цахим хавтаст хэрэгтээ байсан бол шууд татаад хавтаст хэрэгт хавсаргах боломжтой. Иймээс хэдийгээр нэг талдаа цахимаар нотлох баримт цуглуулах боломж байгаа боловч одоогийн практикт заавал цаасан хэлбэрт буулгаж, нотлох бариммаа бүрдүүлж байна.*

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим суурьтай нотлох баримт, цахим хавтаст хэрэг бүрдүүлэх зохицуулалтыг тусгаж өгөх шаардлагатай. Энэ нь хуульдаа тусгагдаж байж практикт хэрэгжих боломж нь бүрдэнэ. Түүнээс хууль заагаагүй эх сурвалж нотлох баримт болохгүй, нотолгооны чанараа алдана. Үүнийг анхаарах зайлшгүй шаардлагатай. Түүнчлэн, шүүх хуралдааны цахимаар явуулах асуудлыг журмаар бус хуульдаа тусгаж өгөх хэрэгтэй…" гэжээ.

Дээрх хурал, хэлэлцүүлгийн үр дүнгээс харахад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас мөрдөгч нотлох баримт цуглуулж, хавтаст хэрэг бүрдүүлдгээрээ ялгаатай болохын хувьд шүүхийн цахимжилт нь цагдаагийн байгууллага, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын цахимжилт өөр хоорондоо шууд харилцан хамааралтай байна.

Мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэргийн ач холбогдол, хэрэгцээ, шаардлага нөхцөл байдлын талаар холбогдох мэргэжилтэн, судлаач дараах мэдээллийг өгсөн юм.

Шигтгээ 4.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахимжилтын нөхцөл байдлыг авч үзвэл одоогоор хавтаст хэргийг цахим байдлаар архивлаж буй үйл ажиллагаа хамаарч байна. Түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд 18 төрлийн баримт бичгийг шүүхээс цахимаар (Үүнд e-mongolia системээс авч болох иргэний үнэмлэхийн лавлагаа, төрсний бүртгэлийн лавлагаа гэх мэт) шүүхийн тамгын газраар дамжуулан авч байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хавтаст хэргийг цахимаар бүрдүүлэх нь тухайн үйл ажиллагааны ил тод байдал, хэргийг талуудад танилцуулах ач холбогдолтой.

Нийгэмд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим хавтаст хэрэг, баримт бичгийг ашиглах хэрэгцээ, шаардлага бий болоод байгаа. Тухайн харилцааг хуульчлахаас илүү нийгмийн харилцаанд цахим үйл ажиллагаа ихээр бий болоод байгааг хүлээн зөвшөөрөх ёстой. Тухайлбал, одоогийн байдлаар хүмүүсийн цахим хэрэглээ ихсэж эмнэлэгт цаг авахаас эхлүүлээд хэрэглээний зээлийг хүртэл цахимаар авахаар болсон. Ковид-19 цар тахлын үед цахим хэрэглээ хурдацтай нэмэгдэж ихэнх үйл ажиллагааг цахимаар явуулах практик суусан. Үүнээс гадна цахим багц хууль батлагдсан нь энэ төрлийн харилцааг зохицуулах шаардлагатайг харуулж байна.

Гэхдээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хавтаст хэргийг цахимжуулах тал дээр хэд хэдэн хүндрэлтэй асуудлууд бий болж болох юм. Тодруулбал, хавтаст хэргийг цахимжуулсны дараа мэргэжлийн оролцогч болон энгийн оролцогчдыг тусад нь ялгаж авч үзэх; хэрэгжүүлэгч байгууллагуудын цахим системийн хоорондын уялдаа холбоог хангах, аюулгүй байдлыг хангах, программ хангамжийг сайжруулах, хадгалах багтаамж (storage)-ийг нэмэгдүүлэх гэх мэт. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулахдаа нэгэнт бий болоод байгаа нэгдсэн платформууд болох e-mongolia систем, ХУР систем, Дан системийг ашиглах шаардлагатай.

Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн гишүүн Н.Баасанжавтай хийсэн ярилцлагын хэсгээс...

3.Түүнчлэн, цахим нотлох баримт, цахимжуулсан нотлох баримт, цахим хавтаст хэргийн асуудал нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлэх буюу гомдол, мэдээлэл хүлээн авахаас эхлэн цахим эсвэл цаасан суурьтай

хавтаст хэрэг бүрдүүлэх сонгох боломжийг хуульд тусгах, хэргийн оролцогч, өмгөөлөгч, прокуророос шүүхэд хандаж буй гомдол, хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэх журмыг хуульд тусгах, зарим төрлийн /зөрчил, хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх хэрэг/ хэрэгт цахим хавтаст хэрэг үүсгэх боломжийг сонголттойгоор хуульчлах гэх мэт асуудлыг цахимжилтын хүрээнд нэн тэргүүнд шийдвэрлэж, хэрэгжүүлэх боломжтой.

3.1.3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэргийн харьцуулсан судалгаа

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэргийн харьцуулсан судалгааг хийхдээ шүүх, хууль, эрх зүйн үйл ажиллагааг цахимжуулах талаар дэвшил гаргасан, эрх зүйн тогтолцооны хувьд жишиг болгож судалдаг дараах улсуудыг судалсан юм.

3.1.3.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын сайн туршлага

ХБНГУ-ын хувьд анхлан “Шүүх байгууллагын цахим үйл ажиллагааг дэмжих тухай хууль”-ийг[10] Холбооны засгийн газрын санаачилгаар “Орчин үеийн техник, технологийн дэвшлийг ашиглан цахим хууль зүйн үйл ажиллагааг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд таниулан сурталчлах, шүүх эрх мэдлийн байгууллагын цахимаар үйл ажиллагаа явуулахад учирч буй хүндрэлийг бууруулах, харилцааны шинэ сувагтай харьцах хэрэглэгчдийн итгэлийг бэхжүүлэхэд чиглэсэн хууль эрх зүйн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх...”[11] зорилгоор боловсруулж, Бундестагаас 2013 оны 10 дугаар сарын 10-ны өдөр батлан гаргасан бөгөөд ХБНГУ-ын холбооны Засгийн газраас уг хуулийг дагаж мөрдөх зардал нь улсын төсөвт дарамт учруулахгүй буюу шүүхийн үйл ажиллагаа цахимжсанаар шуудангаар (шуудан, факсын хураамж) болон цаасаар харилцах, үйл ажиллагаа явуулахтай харьцуулахад хэмнэлттэй, зардал буурна гэж үзсэн байна.[12]

Тус хуулийн дагуу,

- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (ZPO);
- Гэр бүлийн шүүхийн тухай хууль (FamFG);
- Хөдөлмөрийн шүүхийн тухай хууль (ArbGG);
- Нийгмийн шүүхийн тухай хууль (SGG);
- Захиргааны хэргийн шүүхийн хууль (VwGO);
- Санхүүгийн шүүхийн тухай хууль (FGO) зэрэг нийт ХБНГУ-ын 23 хууль тогтоомжид өөрчлөлт орж дээрх салбар эрх зүйн шүүх байгууллагуудын үйл ажиллагааг цахимжуулах буюу хуульч, эрх бүхий байгууллагууд шүүхүүдтэй харилцахдаа цахим хэлбэрээр харилцах, шүүхийн үйл ажиллагаанд шаардлагатай баримт бичгийг цахимаар дамжуулах арга, хэрэгслийг тодорхойлох зэрэг асуудлын эрх зүйн үндсийг тавьсан боловч уг хуулийн үйлчлэх хүрээнд Үндсэн хууль болон ЭХХШтХ багтаагүй байна.

10 Шүүх байгууллагын цахим үйл ажиллагааг дэмжих тухай хууль (Gesetz zur Förderung des elektronischen Rechtsverkehrs mit den Gerichten, 2013)

11 Beschlussempfehlung und Bericht des Rechtsausschusses zu dem Gesetzentwurf der Bundesregierung Drucksache 17/12634 – vom 12. Juni 2013, Verfügbar um https://dserver.bundestag.de/btd/17/139/1713948.pdf

12 Gesetzentwurf der Bundesregierung BT-Drucksache 17/12634 vom 6. März 2013, S. 3 ff, Verfügbar um https://dserver.bundestag.de/btd/17/126/1712634.pdf

Ийнхүү олонх салбар эрх зүйн шүүх байгууллагын үйл ажиллагаанд цахим хэлбэрийг нэвтрүүлэх ажил үе шаттайгаар хэрэгжиж 2017 оны 7 дугаар сарын 12-ны өдөр Бундестагаас нэмэлтээр "Шүүхийн үйл ажиллагаанд цахим хавтаст хэргийг нэвтрүүлэх, цаашид цахим хууль зүйн үйл ажиллагааг дэмжих тухай хууль"-ийг[13] нэмэлтээр баталж 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон байна. Уг хуулийн төслийг боловсруулсан ажлын хэсгийн зөвлөмж, тайланд уг хуулийг батлан гаргах замаар холбогдох салбар эрх зүйн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим хавтаст хэргийн удирдлагыг нэвтрүүлэх нэмэлт өөрчлөлтийг хийх болсон шалтгаан буюу тулгамдаж буй асуудал, түүний шийдлийг дараах байдлаар тусгасан байна.

2017 оны 4 дүгээр сарын 28-ны ХБНГУ-ын засгийн газрын хуулийн төслийн талаарх хууль зүйн болон хэрэглэгчийн эрхийг хамгаалах хорооны (6 дугаар хороо) тогтоолын зөвлөмж, тайлан /18/9416/ [14]

Асуудал

*Шүүхийн байгууллагын эрхлэн явуулдаг ихэнх хянан шийдвэрлэх ажиллагаа нь олон жилийн турш цахим хэлбэрийн сонголттой байсаар ирсэн бөгөөд 2013 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн "Шүүх байгууллагын цахим үйл ажиллагааг дэмжих тухай хууль"-иар цахим хууль зүйн үйл ажиллагааны зохицуулалтыг үндсээр нь шинэчилж, шүүх байгууллагуудын эрхлэн явуулдаг ихэнх хянан шийдвэрлэх ажиллагаа нь олон жилийн турш цахим хэлбэрийн сонголттой байсаар ирсэн. Харин эрүүгийн хавтаст хэрэг өнөөг хүртэл цаасан хэлбэрээр байгаа боловч тэдгээрт агуулагдаж буй баримт бичгийн дийлэнх нь цахим мэдээлэл боловсруулалтыг ашиглан үүсгэгдсэн байх бөгөөд өдөр ирэх тусам цахимаар дамжуулагдах зэргээр цахимжсаар байна. Энэ нь одоогийн эрх зүйн зохицуулалтаар эцсийн үр дүн нь цаасан баримт бичиг боловч шүүх хавтаст хэргийг хөтлөн явуул*ах үйл ажиллагаагаа цахимаар явуулах бүрэн боломжтой болсон гэсэн үг юм.

Холбооны засгийн газар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ч мөн техник технологийн дэвшлийг тусгах, эрүүгийн эрх зүйн тогтолцоог шинэчлэх зорилготой медиа сувгийг өөрчлөх урьдчилсан нөхцөл болгон цахим хавтаст хэргийг нэвтрүүлэх эрх зүйн үндсийг бий болгохоор зорьж байна. Уг ажлын хүрээнд эрүүгийн хэргийн цахим хавтаст хэрэг, үйл ажиллагааны зохицуулалтыг бусад харьяалах эрх зүйн салбартай нэгэн адил буюу 2013 онд бий болгосон эрх зүйн зохицуулалттай нийцүүлэхээр төлөвлөж байна. Мөн хууль зүйн мэргэжлийн хэрэглэгчийн давхар сувгаар дамжилгүйгээр цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны порталд шууд хандан хавтаст хэрэгтэй танилцах, ашиглах үүргийг өргөжүүлэх үүднээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд ч холбогдох нэмэлт, өөрчлөлт хийх шаардлагатай байна.

13 ХБНГУ-ын Шүүхийн үйл ажиллагаанд цахим хавтаст хэргийг нэвтрүүлэх, цаашид цахим хууль зүйн үйл ажиллагааг дэмжих тухай хууль (Gesetz zur Einführung der elektronischen Akte in der Justiz und zur weiteren Förderung des elektronischen Rechtsverkehrs, 2017).

14 Beschlussempfehlung und Bericht des Ausschusses für Recht und Verbraucherschutz (6. Ausschuss) zu dem Gesetzentwurf der Bundesregierung, Deutscher Bundestag, Drucksache 18/12203, Wahlperiode 28.04.2017. Verfügbar um https://dserver.bundestag.de/btd/18/122/1812203.pdf

Шийдэл

Хуулийн төслийг нэмэлт, өөрчлөлтөөр батлах тухай. Тодруулбал, Хорооноос цахим хавтаст хэргийн удирдлагыг зөвхөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тодийгүй бусад процессын хууль тогтоомжид (11-23 дугаар зүйл) тусгаж өгөхийг зөвлөж байна. Энэ нь шүүхийн байгууллагын үйл ажиллагааг бүхэлд нь цахимжуулах ажлыг дуусгах сүүлийн хугацаа нь 2026 он юм. Нэмж дурдахад баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлэх журмыг бүх процедурын зохицуулалтад стандартчилж, үйлчилгээнд тавигдах шаардлагын талаар хялбаршуулсан байх ёстой (StPO – Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн §32e(3); ZPO – Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн §169, 298a(2); VwGO – Захиргааны хэргийн шүүхийн тухай хуулийн § 55b(6) хэсгийн тус тус үзнэ үү). Шүүх, прокурорууд хавтаст хэрэгт хандах эрх олгоход илүү уян хатан хандах боломжийг олгохын тулд хавтаст хэрэгт хандах журамд өөрчлөлт оруулах шаардлагатай (StPO-Е-ийн 32f хэсэг, 299 дүгээр зүйлийн (3) дахь хэсэг, VwGO-ийн 100 дугаар зүйлийн (2) дахь хэсгийг үзнэ үү). Эцэст нь тус хорооноос Шүүхийн Үндсэн хуулийн хуульд заасан харьяаллын төвлөрөлтэй холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шилжүүлэхийг зөвшөөрөх тухай тодорхой заалт оруулахыг зөвлөж байна (28 дугаар зүйл).

(Хэсэгчлэн авав.)

Уг хуулийн холбогдох хэсгийн дагуу ХБНГУ-ын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт орсон байна. Тухайлбал тус хуулийн 1, 2 дугаар зүйлийн дагуу тус тус ЭХХШтХ-ийн 1 дүгээр бүлгийн “Хавтаст хэргийн удирдлага (менежмент) ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь харилцаа холбоо” гэсэн 4 дүгээр дэд бүлэгт “Цахим хавтаст хэргийн удирдлага (менежмент), түүнтэй холбоотой хуульд заасан арга хэмжээ авах бүрэн эрх” гэсэн 32 дугаар зүйлийг 32a, 32b, 32c, 32d, 32f, 32e гэсэн 6 дэд зүйлийн хамтаар; 8 дугаар бүлэгт “Цахим хавтаст хэрэг дэх хувийн мэдээллийг хамгаалах; цахим хавтаст хэргээс гаргаж авсан хувийн мэдээллийг ашиглах” гэсэн 4 зүйл (496, 497, 498, 499 дүгээр зүйл) бүхий 4 дүгээр дэд бүлгийг тус тус нэмсэн байна. Ийнхүү шүүх, прокурорын байгууллагын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны материалыг цахим хэлбэрээр ашиглах, хадгалах, дамжуулах журам, тэдгээрийн эрх зүйн үндсийг ЭХХША-ны хууль тогтоомжид баталгаажуулсан байна.

ХБНГУ-ын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль” дахь цахим хавтаст хэргийн зохицуулалтын агуулга (гарчиг)[15]

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Дэд бүлэг 4. Хавтаст хэргийн удирдлага ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь харилцаа холбоо

- 32 дугаар зүйл Цахим хавтаст хэргийн удирдлага, түүнтэй холбоотой хуульд заасан арга хэмжээ авах бүрэн эрх
- Зүйл 32a Прокурорын байгууллагууд болон шүүхүүдийн цахим харилцаа холбоо; хуульд заасан арга хэмжээ авах бүрэн эрх
- Зүйл 32b Прокурорын байгууллага, шүүхийн ашиглаж буй цахим баримт бичгийг бүрдүүлэх, дамжуулах; хуульд заасан арга хэмжээ авах эрх
- Зүйл 32c Цахим хэлбэр; хуульд заасан арга хэмжээ авах эрх
- Зүйл 32d Цахим дамжуулалтын үүрэг

15 ХБНГУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Strafprozeßordnung – StPO, 1987)

- Зүйл 32e Хавтаст хэргийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор баримт бичгийг хувиргах (хөрвүүлэх)
- Зүйл 32f Хавтаст хэргийн шалгалт (Танилцах буюу хандах эрх); хуульд заасан арга хэмжээ авах эрх

НАЙМДУГААР БҮЛЭГ МЭДЭЭЛЛИЙН ХАМГААЛАЛТ БА ХЭРЭГЛЭЭ

Дэд бүлэг 4. Цахим хавтаст хэрэг дэх хувийн мэдээллийг хамгаалах; цахим хавтаст хэргээс гаргаж авсан хувийн мэдээллийг ашиглах

- 496 дугаар хэсэг. Цахим хавтаст хэрэг дэх хувийн мэдээллийг ашиглах
- 497 дугаар хэсэг. Мэдээллийг (өгөгдлийг) түүний хянах этгээдийн нэрийн өмнөөс боловсруулах
- 498 дугаар хэсэг. Цахим хавтаст хэргээс гаргаж авсан хувь хүний мэдээллийг ашиглах
- 499 дүгээр хэсэг. Хавтаст хэргийн цахим хуулбарыг устгах.

*Тухайн зохицуулалтуудын орчуулгын дэлгэрэнгүйг “Хавсралт” хэсэгт оруулсан болно.

ХБНГУ-ын Хамбург мужийн туршлага

Дээр дурдсанчлан Холбооны Бундестагаас 2017 оны 7 дугаар сарын 12-ны өдөр баталсан “Шүүхийн үйл ажиллагаанд цахим хавтаст хэргийг нэвтрүүлэх, цаашид цахим хууль зүйн үйл ажиллагааг дэмжих тухай хууль”-иар холбооны ЭХХШтХ-д эрүүгийн хавтаст хэргийг цахимаар хөтлөх хууль зүйн зохицуулалтын үндсийг тавьснаас гадна муж улсын засгийн газруудад цахим хавтаст хэргийг хадгалах хугацаа, түүнчлэн цахим хавтаст хэрэг үүсгэх, удирдах, хадгалахад хамаарах зохион байгуулалт, техникийн тогтолцооны нөхцөл, журам зэргийг батлан гаргах муж улсын хэмжээнд мөрдүүлэх ажлыг зохион байгуулах, үүнтэй холбоотой зарим бүрэн эрхийг холбогдох муж улсын яамдад шилжүүлэх бүрэн эрхийг олгосон байна. Мөн муж улс бүр цахим хавтаст хэрэгтэй холбоотой холбогдох эрх зүйн зохицуулалт, дүрэм, журмыг батлах, дагаж мөрдөх ажлыг холбооны улсын хэмжээнд 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр гэхэд зохион байгуулж дуусгахаар дээрх хуульд зохицуулсан.

Дээрх зохицуулалтын дагуу ХБНГУ-ын муж улс бүр уг ажлыг өөр хоорондоо харилцан адилгүйгээр хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа олон жишээ байна (Хамбург, Баден-Вюртемберг, Байерн г.м). Эдгээр мужуудаас энд ХБНГУ-ын Хамбург мужийн туршлагыг энд дурдаж болно.

Хамбург мужийн засгийн газраас (парламент) 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдөр “Хамбург мужийн шүүхүүд дэх цахим хавтаст хэргийн удирдлагын тухай журам”-ыг батлан гаргасан байна.[16] Уг журмаар цахим хавтаст хэргийн удирдлагын талаар илүү нарийн зохицуулалтыг хийсэн бөгөөд тухайлбал,

- Эрүүгийн хэрэг болон зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль (StPO, OWiG);
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (ZPO);
- Гэр бүлийн маргаан болон маргаангүй харьяал бүхий нэхэмжлэл хянан шийдвэрлэх тухай хууль (FamFG);
- Хөдөлмөрийн шүүхэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль (ArbGG);

16 Verordnung über die elektronische Aktenführung in der Hamburger Justiz (HmbEAktFVO, 2019) Verfügbar um https://www.landesrecht-hamburg.de/bsha/document/jlr-JElektAktfVHAV9Anlage1/part/X

- Нийгмийн шүүхийн тухай хууль (SGG);
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (VwGO);
- Санхүүгийн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (FGO) зэрэг хуулиудтай холбоотой цахим хавтаст хэргийн удирдлага болон гомдол, нэхэмжлэлийг цахимаар гаргах журмыг нарийвчлан зохицуулсан байна.

Ийнхүү Хамбург мужид 2019 оноос цахим хавтаст хэргийн удирдлагыг шүүхийн үйл ажиллагаанд нэвтрүүлэн, хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаандаа ашиглаж нэвтрүүлэх ажил амжилттай явагдаж байна. Үүнийг “Хамбург мужийн шүүхүүд дэх цахим хавтаст хэргийн удирдлагын тухай журам”-ын хавсралт 1 дүгээр хавсралт дахь уг журам үйлчлэх мужийн шүүх болон прокурорын байгууллагуудын жагсаалтаас харж болох бөгөөд тус мужийн цахим хавтаст хэргийн удирдлагатай холбоотой журам, зохицуулалт улам бүр нарийвчилсан болж шинэчлэгдсээр байна.[17]

ХБНГУ-ын Хамбург мужийн “Хамбург мужийн шүүхүүд дэх цахим хавтаст хэргийн удирдлагын тухай журам”-ын агуулга (гарчиг)[18]

§ 1. Цахим хавтаст хэргийн хөтлөх журам

§ 2. Цахим хавтаст хэрэг үүсгэх

§ 3. Цаасан баримт бичгийг цахим хэлбэрт хувиргах

§ 4. Цахим хавтаст хэргийг дамжуулах

§ 5. Орлуулах арга хэмжээ

§ 6. Хүртээмжтэй байдал

Хавсралт 1 - Журам үйлчлэх шүүх, прокурорын байгууллагуудын жагсаалт

Хавсралт 2 - Журам үйлчлэх Хамбург мужийн дээд шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаа, үйлчилж эхлэх хугацаа

Хавсралт 3 - Цахим хэлбэрт шилжүүлэх цаасан хэлбэрээр байгаа үндсэн хавтаст хэрэг/бүртгэлийн хавтаст хэргийн жагсаалт

Хавсралт 4 - Цаасан хэлбэрээр үүсгэсэн хавтаст хэргийг цахим үргэлжлэлийг 1-р хэсгийн 1-р зүйлийн 4-р зүйлийн 1-р зүйлийн дагуу захиалах журам, хугацаа

Дээрхээс дүгнэвэл, ХБНГУ-ын хувьд олон тооны хууль тогтоомжид өөрчлөлт оруулж шүүх байгууллагуудын үйл ажиллагааг цахимжуулах буюу хуульч, эрх бүхий байгууллагууд шүүхүүдтэй харилцахдаа цахим хэлбэрээр харилцах, шүүхийн үйл ажиллагаанд шаардлагатай баримт бичгийг цахимаар дамжуулах арга, хэрэгслийг тодорхойлох зэрэг асуудлын эрх зүйн үндсийг тавьсан боловч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд төдийлөн өөрчлөлт ороогүй байсан. Улмаар 2017 оны 7 дугаар сарын 12-ны өдөр Бундестагаас нэмэлтээр “Шүүхийн үйл ажиллагаанд цахим хавтаст хэргийг нэвтрүүлэх, цаашид цахим хууль зүйн үйл ажиллагааг дэмжих тухай хууль”-д нэмэлт оруулж үүний дагуу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар цахим хавтаст хэргийн зохицуулалт бий болсон байна. Энэхүү зохицуулалтад цахим хавтаст хэргийн удирдлага, түүнтэй

17 Elektronische Akte in der Justiz, 2024.02.28, https://justiz.hamburg.de/e-justice/elektronische-akte-in-der-justiz zuletzt besucht 2024.03.20.

18 Мөн тэнд.

холбоотой хуульд заасан арга хэмжээ авах бүрэн эрх, прокурорын байгууллагууд болон шүүхүүдийн цахим харилцаа холбоо, прокурорын байгууллага, шүүхийн ашиглаж буй цахим баримт бичгийг бүрдүүлэх, дамжуулах; хуульд заасан арга хэмжээ авах эрх, цахим хавтаст хэрэг дэх хувийн мэдээллийг ашиглах, мэдээллийг түүний хянах этгээдийн нэрийн өмнөөс боловсруулах, цахим хавтаст хэргээс гаргаж авсан хувь хүний мэдээллийг ашиглах гэх мэт боловсронгуй, хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, үйл ажиллагааг үр дүнтэй болгоход чиглэсэн олон нарийвчилсан зохицуулалт орсон нь сайн жишиг болж байна. Мөн түүнчлэн холбооны хэмжээнд бус мужийн хэмжээнд нарийвчилсан, боловсронгуй зохицуулалтууд бий болсон байна. Тухайлбал, Хамбург мужийн засгийн газраас 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталсан “Хамбург мужийн шүүхүүд дэх цахим хавтаст хэргийн удирдлагын тухай журам”.

Монгол Улсын хувьд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим хавтаст хэргийн талаар тусгахдаа ХБНГУ-тай адилаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэргийн зохицуулалтыг сүүлд нь зохицуулж байгаа тул ХБНГУ-ын сайн жишгийг баримтлах нь зүйтэй байна. Тодруулбал, цахим хавтаст хэргийн удирдлага, түүнтэй холбоотой хуульд заасан арга хэмжээ, прокурорын байгууллагууд болон шүүхүүдийн цахим харилцаа холбоо, прокурорын байгууллага, шүүхийн ашиглаж буй цахим баримт бичгийг бүрдүүлэх, дамжуулах; хуульд заасан арга хэмжээ, цахим хавтаст хэргээс гаргаж авсан хувь хүний мэдээллийг ашиглах гэх мэт боловсронгуй зохицуулалтын агуулга, зарчмыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нийцүүлэн тусгах шаардлагатай.

3.1.3.2. Бүгд Найрамдах Эстони Улсын сайн туршлага

Эстони улсын хувьд бусад улс орнуудтай харьцуулахад шүүхийн байгууллагын үйл ажиллагаа харьцангуй эрт буюу 2009 оноос нэвтэрч эхэлсэн бөгөөд шүүхийн үйл ажиллагааг дижитал болгосноор улс орны эдийн засаг, төрийн үйлчилгээний чанар, хөдөлмөрийн зах зээл, бизнесийн өсөлт зэргийг нэмэгдүүлнэ хэмээн үзсэн байна. Сүүлийн 15 жилийн хугацаанд Эстони улс шүүхийн тогтолцоог дижитал болгоход ихээхэн хүчин чармайлт гаргасан бөгөөд шүүхийн удирдлага, үйл ажиллагаа, шүүх болон бусад талуудын харилцаа холбоонд мэдээлэл, харилцаа холбооны хамгийн сүүлийн үеийн технологийг нэвтрүүлсэн орны нэг юм.[19]

Эстони улсын шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагын цахимжуулалт

Эстони улс шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хурдаараа Европт хоёрдугаарт ордог. Эстони улсын цахимжуулсан шүүхийн систем нь цахим хавтаст хэргийн төв мэдээллийн систем (e-File), шүүхийн мэдээллийн систем (KIS), иргэд болон бусад талуудад зориулсан олон нийтийн портал гэсэн үндсэн гурван хэсгээс бүрддэг.

Цахим хавтаст хэргийн систем буюу e-File нь Эстонийн шүүхийн системийн хамгийн чухал нь юм. Энэхүү төв мэдээллийн систем нь шүүхийн мэдээллийн систем болох KIS2, цагдаа, хорих байгууллага, прокурор, эрүүгийн хавтаст хэргийн удирдлагын мэдээллийн системийг датагаар хангадаг. Мэдээллийг нэг л удаа

19 Factsheet E-Justice. Available at https://e-estonia.com/wp-content/uploads/2020mar-facts-a4-v04-e-justice.pdf

оруулдаг тул цахим хавтаст хэрэг (e-File) нь цаг хугацаа, мөнгө хэмнэдэг бөгөөд талуудын хоорондын бүх харилцаа цахим хэлбэрээр явагддаг.

Эстонийн шүүхийн мэдээллийн систем KIS2[20] нь шүүхийн бүхий л хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирдах цогц шийдэл юм. Энэхүү цогц шийдлийг Хууль зүйн яам Эстонийн шүүхүүдэд хариуцан хэрэгжүүлсэн бөгөөд 2014 оноос эхлэн цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.

Эстонийн шүүхүүдэд тулгарч байсан хамгийн том хүндрэл бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чухал баримт бичгүүдийг талуудад хүргэх явдал байсан. Энэхүү асуудлыг шүүхийн олон нийттэй харилцах портал e-File[21] шийдэж, шүүхэд виртуал хэлбэрээр олон нийттэй харилцах боломжийг олгосон. Энэхүү портал дээр тал бүрийн хэрэг үүсгэж, аливаа баримт бичигт хандаж, илгээх боломжтой. Анхны нэхэмжлэлийг 24/7 нийтийн порталаар дамжуулан гаргаж болно. Ажлын урсгалын хөдөлгүүр нь хуваарилагдсан шүүгчид шаардлагатай өгөгдлийг порталаар дамжуулан хүргэдэг.

Эстонийн шүүхүүд дэх мэдээлэл, харилцаа холбооны технологийн (ICT) түүх

- 2002 он – Шүүхийн шийдвэрүүд болон статистик тоо баримт нийтлэх зорилгоор анхны шүүхийн цахим мэдээллийн систем KOLA нэвтрүүлэв.
- 2006 он – Баримт бичгийн удирдлагыг хэрэгжүүлэх, автоматжуулсан мэдэгдэл, урилга зэргийг илгээх үндсэн чиг үүрэг бүхий 1 дүгээр үеийн цогц шүүхийн мэдээллийн систем KIS-г хэрэглээнд нэвтрүүлэв.
- 2009 он – анхны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талууд (цагдаа, прокурор, хуульч, өмгөөлөгч, иргэд г.м) хороондоо харилцах боломж бүхий олон нийттэй харилцах порталыг хэрэглээнд нэвтрүүлэв.
- 2013-2014 он – 2 дугаар үеийн шүүхийн мэдээлэл KIS2 системийг хэрэглээнд нэвтрүүлэв.
- 2015 он – Цаасгүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэв. 2017 он – Торгуулийг автоматаар хураадаг болов.

Эстони улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль дахь цахим хавтаст хэргийн зохицуулалт

Өмнөх хэсэгт дурдсанчлан Эстони улс нь шүүхийн үйл ажиллагаа буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаа бүрэн цахимжуулсан бөгөөд ЭХХША-нд хавтаст хэргийн E-File системийг нэвтрүүлсэн байна. Эстони улсын ЭХХШтХ-даа Цахим хавтаст хэргийн систем E-file-н (210 дугаар зүйл) талаар болон бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе дэх цахим хавтаст хэргийн системийг ашиглах зохицуулалтын тус тус хийсэн байна.

20 БНЭсУ-ын Шүүхийн мэдээллийн систем, https://www.rik.ee/en/international/court-information-system

21 БНЭсУ-ын Шүүхийн олон нийттэй харилцах порталын веб, https://www.rik.ee/en/international/public-e-file

БНЭсУ-ын "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль" дахь цахим хавтаст хэргийн (E-File) зохицуулалт[22]

§ 149. Гэрэл зураг

(3) Дижитал гэрэл зургийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аливаа шийдвэрт тусгаж, эсхүл хавсралт болгон танилцуулж, компьютерийн файл хэлбэрээр цахим хавтаст хэргийн системд (E-File) хадгална. Дижитал гэрэл зураг нь видео бичлэгээс авсан дан зураг (скрийн шот) байж болно.

[RT I 2008, 28, 180 - 2008.07.15 хүчин төгөлдөр болсон]

§ 156[1]. Шүүх хуралдааны бичлэг, тэмдэглэлийг шалгах

(4) Шүүх хуралдааны дууны (аудио) бичлэгийн хуулбарыг шүүхийн байгууллага холбогдох хүсэлтийг гаргаснаас хойш гурав хоногийн дотор дижитал мэдээллийн хэрэгслээр гаргах буюу цахим хэрэгслээр илгээнэ. Шүүх хуралдааны аудио бичлэгийг цахим хавтаст хэргийн системээр (E-File) прокурорт нээлттэй болгож байна.

§ 156[2]. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийг шүүх хуралдаанд бэлэн болгох

(1) Шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх баримт бичгийг шүүх хуралдааны оролцогчдод хэрхэн хүргэж байгаагаас үл хамааран E-File систем дэх шүүх хуралдаанд оролцогчдод нэн даруй нээлттэй болгоно.

§ 160[1]. Хавтаст хэрэг

(5) Шүүхийн хэргийг дижитал хэлбэрээр хөтөлж байгаа бол цаасан баримтыг сканердаж, холбогдох журмын дагуу цахим файлын системд хадгална. E-File систем нь баримт бичгийн хадгалагдсан хугацаа, түүнийг хадгалж буй хүний мэдээллийг автоматаар бүртгэнэ. Цахим файлын системд хадгалагдсан баримт бичиг цаасан баримтыг орлоно.

§ 160[2]. Цахим (дижитал) баримт бичгийг дамжуулах

(1) Энэ хуульд өөрөөр заагаагүй бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цахим (дижитал) хүсэлт, давж заалдах болон бусад баримт бичгийг шууд буюу цахим хавтаст хэргийн системээр (E-File) дамжуулна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй байгууллага нь шууд илгээсэн цахим баримт бичгийг (дижитал) цахим хавтаст хэргийн системд (E-File) оруулна.

[RT I 2008, 28, 180 - 2008.07.15 хүчин төгөлдөр болсон]

(2) Цахим (дижитал) баримт бичгийг эрүүгийн хавтаст хэрэгт хавсаргахын тулд баримт бичгийг хэвлэж, хавтаст хэрэгт оруулна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй байгууллага нь хэвлэсэн баримт бичгийн үнэн зөв, тоон баримт бичигтэй тохирч байгааг өөрийн гарын үсгээр баталгаажуулж, цахим хавтаст хэргийн системд (E-File) тухайн баримт бичгийн таних дугаарыг нэмж оруулна.

[RT I 2008, 28, 180 - 2008.07.15 хүчин төгөлдөр болсон]

22 БНЭсУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Kriminaalmenetluse seadustik, 2003) https://www.riigiteataja.ee/akt/104102013004

§ 165. Бичгээр зарлан дуудах хуудас хүргэх журам

(4) Хэрэв зарлан дуудах хуудсыг цахим хавтаст хэргийн системээр (E-File) дамжуулан авах боломжтой бол дуудагдсан этгээдэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичигт заасан цахим шуудангийн хаягаар нь зарлан дуудах хуудас байгаа тухай мэдэгдэнэ. Ийнхүү шүүхийн зарлан дуудаж байгаа мэдэгдэлд цахим хавтаст хэргийн (E-File) систем дэх тоон (дижитал) зарлан дуудах хуудасны лавлагааг хавсаргах бөгөөд түүнд хандах хугацаа нь зарлан дуудах хуудас илгээсэн өдрөөс хойш гурав хоног байна.Илгээгч болон түүнийг илгээсэн цагийг E-File системээр тодорхойлох боломжтой бол зарлан дуудах хуудасны хамт тоон гарын үсэг оруулахгүй.Хүлээн авагч нь баримт бичгийг нээлгүйгээр мэдээллийн системд нээсэн буюу мэдээллийн системд хүлээн авснаа баталгаажуулсан бол цахим файлын системээр дамжуулан авах боломжтой зарлан дуудах хуудсыг хүргүүлсэн гэж үзнэ. Мэдээллийн систем дэх баримт бичгийг хүлээн авагч идэвхжүүлсэн. Хэрэв зарлан дуудах хуудсыг илгээсэн өдрөөс хойш гурав хоногийн дотор цахим хавтаст хэргийн системээр хүлээн аваагүй бол зарлан дуудах хуудсыг шуудангаар илгээх, эсхүл зарлан дуудагдаж буй этгээдэд өөр нь гардуулна.

[ТХГН-ийн I, 2013.03.22, 9 - хүчин төгөлдөр болох 2013.04.01]

(5) Гарын үсгийн эсрэг зарлан дуудах хуудас гардуулах тухай мэдэгдэл, шуудангийн үйлчилгээ үзүүлэгчээс гаргасан хүргэлтийн мэдэгдэл, зарлан дуудах хуудас олгох тухай цахим шуудангийн хэвлэмэл материал, зарлан дуудах хуудсыг хүлээн авсныг баталгаажуулсан цахим шуудангийн хэвлэмэл материалууд зэргийг хавтаст хэрэгт хавсаргана. E-File системээр дамжуулан зарлан дуудах хуудас хүлээн авсан бол хүлээн авсан тухай баримтыг цахим хавтаст хэргийн системд бүртгэж, хэвлэмэл хэлбэрээр хавтаст хэрэгт тусгахгүй.

[RT I, 2011.02.23, 1 - 2011.09.01 хүчин төгөлдөр болсон]

(6) Хууль зүйн сайд нь шүүх хуралдааны явцад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийг цахим хавтаст хэргээр (E-File) дамжуулан хүргэхэд илүү тодорхой шаардлагыг журмаар тогтоож болно.

[ТХГН-ийн I, 2013.03.22, 9 - хүчин төгөлдөр болох 2013.04.01]

§ 210. Цахим хавтаст хэргийг боловсруулах мэдээллийн систем (E-File)

(1) Цахим хавтаст хэргийг боловсруулах мэдээллийн систем (цаашид энд E-File гэнэ) нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдээлэл, хувийн мэдээллийг боловсруулахад зориулагдсан төрийн мэдээллийн системд хамаарах мэдээллийн сан бөгөөд дараах зорилготой.

1. Мөрдөн шалгах байгууллага, прокурор, шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа, түүнчлэн эхлээгүй эрүүгийн хэргийн талаарх тоймыг өгөх;
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гүйцэтгэгдсэн ажиллагааны мэдээллийг тусгах;
3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй байгууллагуудын үйл ажиллагааг зохион байгуулах боломжийг олгох;
4. эрүүгийн бодлогын талаар шийдвэр гаргахад шаардлагатай гэмт хэрэгтэй холбоотой статистик мэдээллийг цуглуулах;
5. өгөгдөл, баримт бичгийг цахим хэлбэрээр дамжуулах боломжийг бүрдүүлэх.

(2) Мэдээллийн санд дараах мэдээллийг оруулна.

1. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй эрүүгийн хэрэг, эхлээгүй, дуусгавар болсон эрүүгийн хэргийн талаарх мэдээлэл;

2. эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гүйцэтгэгдсэн ажиллагааны талаарх мэдээлэл;

3. энэ хуульд заасан тохиолдолд цахим (дижитал) баримт бичиг;

4. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй байгууллага, хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид, ял шийтгүүлсэн этгээд, шинжээч, гэрчийн талаарх мэдээлэл;

[RT I, 2011.02.23, 1 - 2011.09.01 хүчин төгөлдөр болсон]

5. Шийдвэрүүд.

(3) Цахим хавтаст хэргийн системийг бий болгох, түүний ажиллагааны журмыг батлах ажлыг Бүгд Найрамдах Улсын Засгийн газар гүйцэтгэнэ.

(4) Цахим хавтаст хэргийн системийн ерөнхий процессор (боловсруулагч) нь Хууль зүйн яам юм. E-File системийн эрх бүхий процессор нь Хууль зүйн сайдын томилсон хүн байна.

(5) Хууль зүйн сайдын зүгээс E-File системийн үйл ажиллагааны зохион байгуулалтын журмыг батлан гаргаж болно.

(6) Хууль зүйн яам E-File системийн мэдээлэлд үндэслэн жил бүрийн 3-р сарын 1-ний дотор өмнөх оны гэмт хэргийн тайланг нийтэлнэ.

(7) Гэмт хэргийн статистик мэдээллийг Хууль зүйн яам нийтэлнэ.

(8) Гэмт хэргийн статистик мэдээг нийтлэх журмыг Бүгд Найрамдах Улсын Засгийн газар тогтооно.

6. [RT I 2008, 28, 180 - 2008.07.15 хүчин төгөлдөр болсон]

Дээрхээс дүгнэвэл, Бүгд Найрамдах Эстони Улс нь цахим хавтаст хэргийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд чухалчилж авч үздэг болох нь харагдаж байна. Тус улс нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульдаа энэ тухай хуульчилж гэрэл зураг, шүүх хуралдааны бичлэг, тэмдэглэлийг шалгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийг шүүх хуралдаанд бэлэн болгох, цахим хавтаст хэргийн ерөнхий зохицуулалт, цахим баримт бичгийг дамжуулах, бичгээр зарлан дуудах хуудас хүргэх журам, цахим хавтаст хэргийг боловсруулах мэдээллийн системийн талаар нарийвчлан авч үзсэн нь сайн жишиг болохоор байна. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим хавтаст хэргийн зохицуулалтыг тусгахдаа тус улсын жишгийг харгалзан үзэх нь зүйтэй.

3.1.3.3. Америкийн Нэгдсэн Улсын сайн туршлага

New York-д e filing (цахим хавтас хэрэг, бүртгэл) нь анх 1999 онд хязгаарлагдмал тооны газруудад жижиг ангиллын хэрэгт хэрэглэх эрхтэй болсон. 1999 онд цахим хэлбэрээр хэрэг ирүүлээгүй. 13 жилийн дараа Хууль тогтоох байгууллага цахим мэдүүлгийг ашиглах зөвшөөрлийг аажмаар өргөжүүлснээр ихээхэн ахиц дэвшил гарсан. Нью-Йорк мужийн шүүхийн цахим мэдүүлгийн системийн бүртгэлтэй 21,000 гаруй хэрэглэгчийн 350,000 орчим хэрэгт 1,3 сая гаруй баримт бичгийг Нью-Йоркийн шүүхэд цахим хэлбэрээр (“NYSCEF”) өгсөн байна.

Нью-Йоркт үүсгэн байгуулагдсанаасаа хойш цахим хавтаст хэрэг нь найдвартай, үр ашигтай, тохиромжтой, аюулгүй болох нь батлагдсан. NYSCEF хөтөлбөр нь шүүхийн байр руу явах шаардлагагүйгээр шүүхийн баримт бичгийг бараг л агшин зуур, хүссэн үедээ, хаанаас ч гаргаж өгөх боломжийг олгодог. Өмгөөлөгч нар

өдөр, шөнийн аль ч цагт, интернэт холболттой аль ч газраас онлайнаар хэргийн материалаа үзэх боломжтой. Цахим мэдүүлэг нь баримт бичгийг хадгалах, сэргээх, хуулбарлах зардлыг эрс багасгах, эсрэг талуудад бичиг баримт өгөх ачаа, зардлыг ихээхэн хэмжээгээр арилгах, баримт бичгийг бүрдүүлэх, авахын тулд шүүхийн байранд очиход зарцуулах үнэ цэнтэй алдагдсан цагийг арилгах боломжтой юм. Цахим мэдүүлэг нь шүүхийн оролцогчид, өмгөөлөгчид, шүүхүүд болон дүүргийн бичиг хэргийн ажилтнуудад ихээхэн хэмжээний зардлыг хэмнэх мөн бүх нийтийн цахим мэдүүлэг нь Нью-Йоркийн шүүхэд зарга мэдүүлж буй хувь хүмүүс, аж ахуйн нэгжүүд, муж, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын зардлыг хэдэн зуун сая долларoор бууруулах боломжтой гэж тооцоолж байна. Мөн цахим мэдүүлэг нь хууль зүйн тогтолцооноос илүү ногоон, байгаль орчинд ээлтэй хандлагыг тусгаж, жил бүр олон мянган тонн цаасны хэрэглээг арилгах юм.

Холбооны шүүхэд цахим хавтаст нь Нью Йоркоос илүү хурдацтай явагдаж байна. АНУ-ын дүүргийн шүүхүүдэд 2002 онд, давж заалдах шатны шүүхүүдэд 2005 онд хэрэгжиж эхэлсэн. Холбооны шүүхэд цахим мэдүүлэг гаргах нь заавал байх ёстой бөгөөд холбооны шүүхийн үйл ажиллагаа болон холбооны хуулийн практикт үндсэн бөгөөд хүлээн зөвшөөрөгдсөн бүрэлдэхүүн хэсэг болсон. ECF системийг иргэний болон эрүүгийн хэргийн бүх дүүргийн шүүх, улсын хэмжээнд дампуурлын шүүх, бүх бүс нутгийн давж заалдах шатны шүүх, Холбооны нэхэмжлэлийн шүүх, Олон улсын худалдааны шүүхэд ашиглаж байна. Холбооны шүүхэд сар бүр зургаан сая гаруй баримт бичгийг цахим хэлбэрээр илгээдэг бөгөөд 500,000 гаруй өмгөөлөгч цахим мэдүүлгийн системийг ашигладаг.

Улсын хэмжээнд улсын шүүхэд цахим мэдүүлэг гаргах нь жишиг болж байна. Одоогоор 41 мужид зөвшөөрөгдсөн бөгөөд үлдсэн ихэнх мужид хэрэгжих төлөвтэй байна. АНУ-ын мужийн анхан шатны шүүхүүдийн ихэнх нь орон нутгийн удирдлагатай байдаг тул эдгээр шүүхэд цахим мэдүүлгийг хэрэгжүүлэх нь муж тус бүрээр явагддаг бөгөөд ихэвчлэн туршилтын хөтөлбөрүүдэд зориулсан шүүхийн дүрэм мөн хуулиар тогтоосон зөвшөөрөл дагалддаг[23].

Case Management/Electronic Case Files Хэргийн менежмент/Цахим хэргийн файлууд (CM/ECF) нь нэхэмжлэл, хүсэлт, өргөдөл зэрэг хэргийн баримт бичгийг шүүхэд онлайнаар илгээх боломжийг олгодог холбооны шүүхийн систем юм. CM/ECF-ийг өмгөөлөгчид, АНУ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч, дампуурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч нар ихэвчлэн ашигладаг. Зарим шүүхүүд дампуурлын нэхэмжлэгч болон нэхэмжлэлийн шаардлагыг хангаж буй хүмүүст CM/ECF ашиглан мэдүүлэг гаргахыг зөвшөөрдөг[24].

NYSCEF хөтөлбөр нь өмгөөлөгчид болон өөрийгөө төлөөлж буй заргалдагч тал шүүхийн байр руу явах шаардлагагүйгээр өдрийн аль ч цагт, аль ч газраас шүүхийн баримт бичгийг бүрдүүлж, үйлчлэх боломжийг олгодог. Мөн NYSCEF нь интернэтэд холбогдсон өмгөөлөгчдөд хавтаст хэргийг хүссэн үедээ хаанаас ч үзэх боломжийг олгодог. NYSCEF нь тусгай техник хангамж, программ хангамж шаарддаггүй. Харин цахим мэдүүлэг гаргахад шаардлагатай тоног төхөөрөмж нь: компьютер, үндсэн (software) программ хангамж (веб хөтөч болон Adobe гэх мэт PDF/A уншигч/ бичигч),

23 Electronic Filing in Criminal Actions and Proceedings: A REPORT TO THE GOVERNOR, LEGISLATURE AND CHIEF JUDGE, page 10 https://ww2.nycourts.gov/sites/default/files/document/files/2018-06/eFile_Criminal_Report%20April%2019.pdf

24 Electronic Filing (CM/ECF), https://www.uscourts.gov/court-records/electronic-filing-cmecf

интернэт холболт, сканер. Баримт бичгийг бүрдүүлэхийн тулд өмгөөлөгч эсвэл өөрийгөө төлөөлж буй шүүхийн оролцогч нь хэрэглэгчийн ID, нууц үг авах ёстой бөгөөд энэ нь онлайнаар хийгддэг энгийн процесс юм. Ганц хэрэглэгчийн ID болон нууц үг нь Нью-Йоркт бүртгэлтэй өмгөөлөгчид аль ч муж, шүүх, цахим мэдүүлэг өгөх эрх бүхий хэрэгт цахим мэдүүлэг гаргах боломжийг олгодог. NYSCEF-ийн иргэний хэргийн хавтаст хэрэгт байгаа нууцлалгүй, битүүмжлэлгүй баримт бичгүүдийг онлайн зочноор үзэхийн тулд хэрэглэгчийн ID болон нууц үг шаардлагагүй байдаг (олон нийт гэр бүлийн болон эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд цахимаар бүрдүүлсэн баримт бичигт хандах боломжгүй). Шүүхийн ердийн хураамжаас гадна NYSCEF-ийг ашиглахад ямар ч төлбөр байдаггүй байна.

NYSCEF нь хэрэглэгчдэд ээлтэй ба цахимаар мэдүүлэх баримт бичгүүдийг эхлээд баримт бичгийг боловсруулсны дараа PDF/A формат руу программ хангамжийн хөрвүүлэлт эсвэл сканераар дамжуулан хөрвүүлдэг бөгөөд энэ нь өнөөгийн ихэнх өмгөөлөгчдийн мэддэг энгийн процесс юм. Цахим файл үүсгэгч нь хэрэглэгчийн ID болон нууц үгээр NYSCEF-д нэвтэрч , дэлгэцэн дээрх зааврыг дагаж баримтыг NYSCEF систем рүү оруулна. Баримт бичгийг дамжуулсны дараа NYSCEF нь цахим файл илгээгч болон хэргийн бусад цахим мэдүүлэг гаргагч талуудад хүлээн авсан тухай мэйл мэдэгдлийг автоматаар үүсгэдэг. Шинээр бүрдүүлсэн баримт бичгийн аюулгүй холбоосыг агуулсан эдгээр мэдэгдэл нь тухайн баримт бичгийн оролцогч хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээг бүрдүүлдэг. Цахим хэлбэрээр эхэлсэн тохиолдолд ч гэсэн цаасан хэлбэрээр биечлэн ирүүлэх ёстой баримт бичгээс бусад тохиолдолд талууд эсрэг талуудад бичиг баримт өгөх ачааллаас чөлөөлөгддөг - NYSCEF нь энэ үүргийг автоматаар гүйцэтгэж, бүртгэдэг.[25]

Дээрхээс дүгнэвэл, АНУ-ын хэмжээнд шүүхэд цахим мэдүүлэг гаргах, цахим хавтаст хэрэг бүрдүүлэх нь жишиг болж байна. Одоогоор 41 мужид зөвшөөрөгдсөн бөгөөд үлдсэн ихэнх мужид хэрэгжих төлөвтэй байна. Тус шинэчлэлт нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хөнгөвчилж, хэргийн оролцогч, өмгөөлөгчдөд бий болох саад бэрхшээлийг арилгах үр дүнтэй өөрчлөлт болсон байна. Мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэргийн боловсруулалтыг техник технологи талаас нь боловсронгуй болгосон ба үүнийг ашиглахад ямар нэг төлбөр хураамж авдаггүй нь сайн жишиг болж байна.

3.1.3.4. Бүгд Найрамдах Солонгос Улсын сайн туршлага

Бүгд Найрамдах Солонгос Улсад цахим хавтаст хэрэг нь эрүүгийн цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүрэлдэхүүнд хамаардаг. Эрүүгийн хэргийн цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэдэг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийг цахим баримт хэлбэрээр бэлтгэх, ирүүлэх, удирдах, үйлчлэх, үзэх, хадгалах зэрэг үйл ажиллагааг хамаардаг. Эрүүгийн хэргийн цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь цаасан баримтаас илүү цахим баримт дээр суурилдаг тул талууд баримт бичгийг цахим хэлбэрээр бүрдүүлж, хүлээн авч, шүүх нь цаасан хэрэг хөтлөлтийн оронд цахим бүртгэл үүсгэж, удирддаг.

2010 онд патентын маргаанаас эхлэн иргэний хэрэг, захиргааны хэрэг, ахуйн хэрэг, дампуурлын хэрэг зэрэг эрүүгийн хэргээс бусад шүүхийн ихэнх ажиллагаанд

25 Electronic Filing in Criminal Actions and Proceedings: A REPORT TO THE GOVERNOR, LEGISLATURE AND CHIEF JUDGE, page 8 https://ww2.nycourts.gov/sites/default/files/document/files/2018-06/eFile_Criminal_Report%20April%2019.pdf

цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем хэрэгжиж эхэлсэн байна. Гэвч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хараахан нэвтрээгүй байгаа нь олон чирэгдэл учруулж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нэвтрүүлэх шаардлагатай гэдэг дээр нэгдсэн байр суурь бий болж байгаатай байгаатай холбогдуулан 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн БНСУ-ын парламентын чуулганы нэгдсэн хуралдаанаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт ашиглах тухай хуулийг баталсан. Улмаар үүний дагуу 2024 оны 10-р сарын 20-ны өдрөөс эхлэн бүрэн хэмжээний эрүүгийн цахим шүүх хуралдааныг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Эрүүгийн цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нэвтрүүлэхийн ач холбогдол:

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх.

Цахим эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нэвтрүүлснээр шүүх хуралдааны оролцогчид цаг хугацаа, газар нутгаас үл хамааран эрүүгийн хэргийн талаарх мэдээллийг хялбархан авах боломжтой болно. Эрүүгийн хэргийн талаарх мэдээллийг ил тод, системтэй, эргэлт буцалтгүй удирддаг тул эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа илүү ил тод, шударга явагдах боломжтой.

- Шүүгчдийн үндсэн эрхийн хамгаалалтыг бэхжүүлэх

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цахим хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цахим бүртгэлээр хэрэг бүртгэлтийг шуурхай үзэж, удирдаж, хэргийн гол асуудлуудыг түргэн шуурхай тодорхойлох боломжтой болж, улмаар шүүгдэгчийн шүүх хурлыг шударгаар, шуурхай шийдвэрлүүлэх, шүүх хуралдаанд оролцогч талуудын эрх ашгийг дээшлүүлэх, өмгөөлөх эрх, хохирогчийн үйл ажиллагаанд оролцох эрх зэрэг багтана. Үндсэн эрхийг илүү өндөр түвшинд баталгаажуулсан.

- Цаасан бүртгэлийн хязгаарлалтыг даван туулах хурдан бөгөөд үр дүнтэй журам

Цахим эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд шүүхийн гишүүд болон шүүгдэгч, өмгөөлөгч, прокурор хэрэгтэй зэрэгцэн танилцах боломжтой болж, шүүх хуралдааныг илүү нарийвчилсан байдлаар явуулах боломжтой болсон. Цахим хэрэг бүртгэлийг удирдан, цахим баримт бичгийг хүргэснээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа илүү хурдан, үр дүнтэй явагдаж, цаасан хэрэг үүсгэх, хүргэх, хадгалахад шаардагдах хугацаа, зардлыг бууруулах боломжтой[26].

2021 оны 10 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт ашиглах тухай хуулийн зорилго нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт бичгийг ашиглах, удирдах үндсэн зарчим, журмыг тогтоосноор эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шуурхай, ил тод байдлыг нэмэгдүүлэх, иргэдийн эрх ашгийг хамгаалах юм. Тус хуулийн 2 дугаар зүйлд “Цахим хавтаст хэрэг” болон “Цахимжуулсан хавтаст” хэргийг дараах байдлаар тодорхойлсон.

26 미리 보는 형사전자소송, https://help.scourt.go.kr/nm/min_9/min_9_9/index.html

Цахим хавтаст хэрэг - Цахим баримт болон цахим гүйлгээний суурь хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу мэдээлэл боловсруулах системээр цахим хэлбэрээр бэлтгэсэн, дамжуулсан, хүлээн авсан, хадгалсан мэдээлэл[27]

Цахимжуулсан хавтаст хэрэг - Цаасан баримт болон бусад хэлбэрээр цахим байдлаар бэлтгээгүй баримт, эсхүл зураг, гэрэл зураг, дуу, дүрсний өгөгдөл гэх мэт / цаашид “дижитал баримт бичиг” гэх/-ийг цахим хэлбэрт шилжүүлж, компьютержсон мэдээлэл болгон боловсруулах. Энэ нь системд бүртгэгдсэн цахим баримт бичигт хамаарна[28].

2021 оны 10 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт ашиглах тухай хуульд дараах үйл ажиллагааг тусгасан[29].

Хүснэгт 2.4. *БНСУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт ашиглах тухай хуулийн зохицуулалт*

Зүйл, заалт	Зохицуулалтын агуулга
5 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахим баримт бичгээр гүйцэтгэх	- Сэжигтэн, шүүгдэгч, хохирогч, гомдол гаргагч, мэдээлэгч, өмгөөлөгч болон Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн журамд заасан бусад этгээд 7 дугаар зүйлд заасны дагуу хэрэглэгчээр бүртгүүлсэн бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарна. Баримт бичиг, зураг, гэрэл зураг, аудио, дүрс бичлэгийн материалыг Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн дүрэмд заасны дагуу мэдээлэл боловсруулах цахим системээр дамжуулан цахим баримт бичиг хэлбэрээр гаргаж болно. - Шаардлагыг хангасан цахим баримт бичгийг энэ хуульд заасны дагуу бэлтгэж, ирүүлсэн, хүргүүлсэн, хадгалсан бол тухайн баримт бичгийг бэлтгэсэн, ирүүлсэн, хүргүүлсэн, хадгалсанд тооцно. - Энэ хуулийн дагуу цахимжуулсан, бүртгүүлсэн баримт бичиг нь дижитал хэлбэрт шилжих баримт бичигтэй адил байна. - Энэхүү хуульд заасны дагуу компьютержсон мэдээлэл боловсруулах системээр цахим баримт бичиг хэлбэрээр хэвлэсэн баримт бичгийг цахим баримт бичигтэй адилтгана. - 3 дугаар зүйлийн дэд хэсэг бүрд баримт бичгийн хуулбарыг олгох, хүргүүлэх, хадгалах гэх мэтээр заасан тохиолдолд мэдээллийн компьютержсон системээр цахим баримт хэлбэрээр хэвлэсэн баримт бичиг нь баримт бичгийн эх хувь байх ёстой.

27 Framework act on electronic documents and transactions of Korea, https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=27334&type=part&key=28

28 Act on the Use of Electronic Documents in Criminal Judicial Procedures [Enforced into force on October 20, 2024] [Law No. 18485, enacted on October 19, 2021], https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%ED%98%95%EC%82%AC%EC%82%AC%EB%B2%95%EC%A0%88%EC%B0%A8%EC%97%90%EC%84%9C%EC%9D%98%EC%A0%84%EC%9E%90%EB%AC%B8%EC%84%9C%EC-%9D%B4%EC%9A%A9%EB%93%B1%EC%97%90%EA%B4%80%ED%95%9C%EB%B2%95%EB%A5%A0/(18485,20211019)

29 Act on the Use of Electronic Documents in Criminal Judicial Procedures [Enforced into force on October 20, 2024] [Law No. 18485, enacted on October 19, 2021], https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%ED%98%95%EC%82%AC%EC%82%AC%EB%B2%95%EC%A0%88%EC%B0%A8%EC%97%90%EC%84%9C%EC%9D%98%EC%A0%84%EC%9E%90%EB%AC%B8%EC%84%9C%EC-%9D%B4%EC%9A%A9%EB%93%B1%EC%97%90%EA%B4%80%ED%95%9C%EB%B2%95%EB%A5%A0/(18485,20211019)

6 дугаар зүйл. Компьютержсон мэдээлэл боловсруулах системийг ажиллуулах	- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллага бүрийн дарга мэдээлэл боловсруулах компьютержуулсан системийг суурилуулж ажиллуулна. - Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллагууд цахим баримт бичгийн ашиглалт, менежментийн стандартыг бий болгохын тулд бие биетэйгээ хамтран ажиллах ёстой. - Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллага нь энэхүү хуулийг хэрэглэх буюу компьютержсон мэдээлэл боловсруулах системийг ажиллуулахдаа хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настан гэх мэт хүмүүст эрхээ бүрэн эдлэх боломжийг хангахыг хичээнэ.
7 дугаар зүйл. Хэрэглэгчийн бүртгэл	- Мэдээлэл боловсруулах компьютержуулсан системийг ашиглахыг хүссэн хүн бүр (эрүүгийн шүүх хянан шийдвэрлэх байгууллагад харьяалагддаг төрийн албан тушаалтнуудаас бусад) Ерөнхийлөгчийн зарлиг болон Улсын дээд шүүхийн дүрмийн дагуу хэрэглэгчээр бүртгүүлэх ёстой. - (1)-д заасны дагуу хэрэглэгчээр бүртгүүлсэн (цаашид “хэрэглэгчийн бүртгэл” гэх) хүн /цаашид “бүртгүүлсэн хэрэглэгч” гэх/ Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн тогтоолоор тогтоосон хэрэглэгчийн бүртгэлээ цуцалж болно. - Дараах шалтгааны аль нэг нь байвал эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх албаны дарга Ерөнхийлөгчийн зарлиг болон Улсын дээд шүүхийн дүрэмд заасан бүртгэлтэй хэрэглэгчийн компьютержсон мэдээлэл боловсруулах системийг ашиглахыг түдгэлзүүлэх, хэрэглэгчийн бүртгэлийг цуцалж болно. 1. Бүртгүүлсэн хэрэглэгчийн биеийн байцаалт танигдаагүй үед; 2. Хэрэглэгчийн бүртгэлд бүртгүүлэх, хэрэглэгчийн мэдээллийг өөрчлөхдөө мэдээлэл боловсруулах компьютержсон системд худал мэдээлэл оруулсан бол; 3. Мэдээлэл боловсруулах компьютержсон системийг ашиглан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад саад учруулах, тухайлбал, бүртгэлтэй бусад хэрэглэгчийн мэдээллийг компьютержуулсан мэдээлэл боловсруулах системийг ашиглахад саад учруулсан, бусад бүртгэлтэй хэрэглэгчийн мэдээллийг хулгайлсан тохиолдолд; 4. Санаатай болон илт хайхрамжгүй байдлаас болж мэдээлэл боловсруулах компьютержсон системд гэмтэл гарсан тохиолдолд; 5. Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн журамд заасан 1-4 дэх хэсэгт заасан бусад шалтгаан байгаа тохиолдолд;
8 дугаар зүйл. Цахим гарын үсэг	- Эрүүгийн байцаан шийтгэх байгууллагад цахим баримт бичгийг ирүүлэхийг хүссэн хүн цахим баримт бичигт цахим гарын үсэг (гарын үсэг зурсан хүний жинхэнэ нэрийг баталгаажуулах боломжтой, цаашид энэ хэсэгт мөн адил хамаарна) байрлуулах ёстой. Харин цахим гарын үсгийг ашиглах боломжгүй, ирүүлсэн этгээдийн биеийн байцаалтыг баталгаажуулсан, Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн дүрэмд заасан тохиолдолд цахим гарын үсэг ашиглахыг хориглоно. - Шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нар шүүхийн шийдвэр, тэмдэглэл зэргийг цахим баримт бичигт бэлтгэхдээ Улсын дээд шүүхийн журамд заасан шүүхийн цахим гарын үсэгт гарын үсэг зурна. Энэ тохиолдолд 3 дугаар зүйлд заасан хуульд заасны дагуу мэдэгдэл гаргаж байгаа этгээдийн гарын үсэг шаардлагатай бол цахим хэлбэрээр гарын үсэг зурна. - Шүүхээс бусад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд харьяалагддаг төрийн албан тушаалтнууд цахим баримт бичигт шийдвэр, тэмдэглэл, тайлан гаргахдаа Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу захиргааны цахим гарын үсэг зурах ёстой. Энэ тохиолдолд 3 дугаар зүйлд заасан хуульд заасны дагуу мэдэгдэл гаргаж байгаа этгээдийн гарын үсэг шаардлагатай бол цахим хэлбэрээр гарын үсэг зурна.

	- Хэрэв 1-3 дахь хэсэгт заасны дагуу цахим гарын үсэг, шүүхийн цахим гарын үсэг, захиргааны цахим гарын үсэг хийгдсэн бол гарын үсэг, нэрийн тамга нь хуулийн дагуу хийгдсэн гэж үзнэ. - Хэрэв 1-ээс 3 дахь хэсэгт заасны дагуу ирүүлсэн буюу бэлтгэсэн цахим баримт бичигт хуудасны тоог заасан бол 3 дугаар зүйлийн дэд зүйл бүрийн дагуу хууль тогтоомжийн дагуу тамга дарсан гэж үзнэ.
9 дүгээр зүйл. Цахим баримт бичгийг хүлээн авах	- Цахим баримт бичгийг компьютержсон мэдээлэл боловсруулах системд цахим хэлбэрээр бүртгэсэн тохиолдолд хүлээн авсанд тооцогдоно. - Компьютержсон мэдээлэл боловсруулах системээр ирүүлсэн цахим баримт бичгийг хүлээн авах журам, аргыг Ерөнхийлөгчийн зарлигаар буюу Улсын дээд шүүхийн дүрмээр тогтооно. Энэ тохиолдолд ирүүлсэн цахим баримт бичгийн хувийн шинж чанарыг хадгалах техникийн арга хэмжээний тухай асуудлыг агуулгад оруулах ёстой. - 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу цахим баримт бичгийг ирүүлсэн бүртгэлтэй хэрэглэгч нь хүлээн авсан цахим баримт бичгийг баталгаажуулах хүсэлт гаргавал Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллага Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн журамд заасан баталгаажуулах боломжийг олгох ёстой. - Хэрэв 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу ирүүлсэн цахим баримт бичгийн агуулга нь хүлээн авсан цахим баримт бичгийн агуулгатай таарахгүй бол бүртгэлтэй хэрэглэгч Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн дүрэмд заасны дагуу холбогдох байгууллагад засвар оруулах хүсэлт гаргаж болно. - Хүлээн авсан цахим баримт бичгийг хуурамчаар үйлдсэн эсвэл өөрчилсөн эсэхийг шалгах шаардлагатай бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллага нь 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу цахим баримт бичгийг ирүүлсэн бүртгэлтэй хэрэглэгчээс эх хувийг нь гаргаж өгөхийг хүсэж болно.
10 дугаар зүйл. Цахим баримт бичгийг бэлтгэх	- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны байгууллагад харьяалагддаг төрийн албан тушаалтнууд шүүх хуралдааны тэмдэглэл, яллах дүгнэлт, шилжүүлсэн шийдвэр, сэжигтэн байцаалтын бүртгэл зэрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой баримт бичгүүдийг бүрдүүлэхдээ цахим баримт бичиг болгон бэлтгэдэг. Гэхдээ дараах тохиолдлуудын аль нэг нь Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн дүрэмд заасан үндэслэл байвал энэ нь хамаарахгүй. 1. Компьютержсон мэдээлэл боловсруулах системд асуудал гарсан тохиолдолд; 2. Цахим баримт бичгийг бэлтгэхэд ихээхэн хүндрэлтэй буюу зохисгүй тохиолдолд. - Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллагад харьяалагддаг төрийн албан тушаалтан сэжигтний байцаалтын тэмдэглэлийг (1) дэх заалт бүрийн текстийн дагуу цахим баримт бичиг болгон бэлтгэсэн бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан сэжигтэн байцаалтын тэмдэглэлийг бүрдүүлэх журам, аргачлалыг Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу хэрэгжүүлэх ёстой.
11. дүгээр зүйл. Дижитал баримт бичгийг бэлтгэх	- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд харьяалагдах төрийн албан тушаалтан дижитал баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлж, мэдээлэл боловсруулан цахим системд бүртгүүлнэ. Харин цахимжуулах баримт бичгийг дижитал хэлбэрт шилжүүлэхэд ихээхэн хүндрэлтэй, тохиромжгүй үед Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн журамд заасны дагуу хөрвүүлэх, бүртгэхийг хориглоно. - Цахим хэлбэрт шилжүүлэх баримт бичгийг дижитал хэлбэрт шилжүүлэх, мэдээлэл боловсруулах цахим системд бүртгэх журам, аргыг Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн дүрмээр тогтооно. Энэ тохиолдолд дижитал хэлбэрт оруулах баримт бичгийн онцлог байдлыг хадгалах техникийн арга хэмжээний тухай асуудлыг агуулгад оруулах ёстой.

12 дугаар зүйл. Дижитал хэлбэрт шилжүүлсэн баримт бичгийг хадгалах	- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллага нь 11 дүгээр зүйлд заасны дагуу цахим хэлбэрт шилжүүлж, бүртгүүлсэн баримт бичгийг Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн журамд заасан хугацаа хүртэл хадгална. - 1 дэх хэсгийг үл харгалзан цахим хэлбэрт шилжүүлэх баримт бичгийг ирүүлсэн этгээдээс хүсэлт гаргавал байгууллага цахим хэлбэрт шилжүүлэх баримт бичгийг буцааж болно. - Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллага нь 2 дахь хэсэгт заасны дагуу цахимжуулах баримт бичгийг ирүүлсэн этгээдэд буцааж өгөхдөө цахим хэлбэрт шилжүүлэх баримт бичиг болон цахимжуулах баримт бичгийг мөн адил баталгаажуулах боломжийг олгоно.
13 дугаар зүйл. Цахим баримт бичиг тараах	- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой бэлтгэсэн цахим баримт бичгийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад байгууллагад илгээхдээ компьютержсон мэдээлэл боловсруулах системээр дамжуулан явуулах ёстой. - Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллага эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллагаас өөр байгууллагад шилжүүлэх тохиолдолд цахим баримт бичгийг мэдээлэл боловсруулах компьютержуулсан системээр хэвлэж, бичгийн баримтыг илгээдэг. Харин цахим баримт бичгийг цахим баримт бичгийг илгээх, хүлээн авах системээр тоноглогдсон байгууллагын хувьд Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн дүрэмд заасан байгууллагад шилжүүлэх, дамжуулахдаа цахим баримт бичгийг цахим хэлбэрээр илгээж болно. 2 дахь хэсгийн үндсэн бичвэрт заасны дагуу цахим баримт бичгийг хэвлэх журам, аргыг Ерөнхийлөгчийн зарлигаар буюу Дээд шүүхийн дүрмээр тогтооно. Энэ тохиолдолд цахим баримт бичгийн үнэмлэхийг хадгалах техникийн арга хэмжээний тухай асуудлыг агуулгад оруулах ёстой.
14 дүгээр зүйл. Цахим үйлчилгээ эсвэл мэдэгдэл	Үйлчилгээ, мэдэгдэл хүлээн авах этгээд нь дор дурдсан зүйлсийн аль нэгэнд хамаарах бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллага мэдээлэл боловсруулах цахим системээр дамжуулан үйлчилгээ, мэдэгдлийг цахим хэлбэрээр хийж болно. 1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллагын хувьд 2. Хэрэв та эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллагад харьяалагддаг төрийн албан тушаалтан бол 3. Цахим хүргэлт, мэдэгдлийг зөвшөөрсөн бүртгэлтэй хэрэглэгч, Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн дүрэмд заасан этгээд бол. - (1)-д заасны дагуу үйлчилгээ, мэдэгдлийг эрүүгийн байцаан шийтгэх байгууллага цахим баримт бичгийг мэдээлэл боловсруулах цахим системд бүртгэж, тухайн баримт бичгийг гардуулах буюу мэдэгдэх этгээдэд цахимаар мэдэгдэнэ.
15 дугаар зүйл. Хэвлэсэн цахим баримтыг хүргүүлэх	- Дараах тохиолдлын аль нэгэнд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх байгууллага нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 60 дугаар зүйлд заасны дагуу цахим баримт бичгийг компьютержсон мэдээлэл боловсруулах системээр дамжуулан илгээнэ. - (1)-д заасны дагуу цахим баримт бичгийг хэвлэх журам, аргыг Ерөнхийлөгчийн зарлигаар эсвэл Дээд шүүхийн дүрмээр тогтооно. Энэ тохиолдолд цахим баримт бичгийн танилтыг хадгалах техникийн арга хэмжээний тухай асуудлыг агуулгад оруулах ёстой.

16 дугаар зүйл. Цахим баримт бичгийг үзэх, хуулбарлах гэх мэт	- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 35, 55, 59-2, 59-3, 174, 185, 200-4, 262 дугаар зүйлийн 2, 266-3 дугаар зүйл, 266-4 дүгээр зүйл, 266-11 дүгээр зүйл, 294-4 дүгээр зүйлд заасныг үл харгалзан энэ хуулийн дагуу бэлтгэсэн цахим баримт бичгийг үзэх, хуулбарлахдаа интернэт, эсвэл компьютержсон мэдээлэл боловсруулах системийг ашиглах ба цахим хэлбэрээр үзэх, хуулах, дамжуулах замаар хийж болно. - 1-р хэсгийг үл харгалзан, бүртгэлтэй хэрэглэгчээс өөр хүн цахим баримтыг үзэх, хуулбарлах хүсэлт гаргасан тохиолдолд компьютержсон мэдээлэл боловсруулах системээр дамжуулан баримт бичгийг хэвлэн гаргаж болно. - (1)-д заасны дагуу цахим баримт бичгийг үзэх, хуулбарлах, дамжуулах журам, аргыг Ерөнхийлөгчийн зарлигаар эсвэл Дээд шүүхийн дүрмээр тогтооно. Энэ тохиолдолд цахим баримт бичгийн танилтыг хадгалах техникийн арга хэмжээний тухай асуудлыг агуулгад оруулах ёстой. - Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 266-3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шүүгдэгч (шүүгдэгч байсан этгээдийг оролцуулан), өмгөөлөгч (өмгөөлөгч байсан этгээдийг оролцуулан) баримт бичгийг үзэх, хуулбарлах, дамжуулах боломжтой. Цахим баримт бичгийг зориулалтын бус зорилгоор интернэт эсвэл компьютержсон мэдээлэл боловсруулах системээр дамжуулан өөр этгээдэд дамжуулах, олгох (цахим баримт бичгийг хэвлэх, бичгээр олгох гэх мэт) холбогдох хэрэг болон холбогдох хэргийн шүүх хуралдаанд бэлтгэх тухай танилцуулахыг хориглоно (цахим баримт бичгийг хэвлэх, бичгээр танилцуулах, харилцаа холбооны хэрэгслээр хангах гэх мэт).
17 дугаар зүйл. Зөвшөөрлийг гүйцэтгэх тусгай заалтууд	Дараах батлан даалт, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ, зөвшөөрөл, хүсэлт зэргийг /цаашид “зөвшөөрөл” гэх/ цахим хэлбэрээр олгосон бол прокурор, шүүхийн цагдаагийн ажилтан: Улсын дээд шүүхийн журамд заасны дагуу; баталгаа гэх мэтийг цахим баримт бичгийг танилцуулах, дамжуулах замаар гүйцэтгэж болно. 1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 73, 113, 200-2, 201, 215 дугаар зүйлд заасны дагуу баталгаа гаргах. 2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 172, 221-3 дугаар зүйлд заасан үнэлгээний цагдан хорих байр 3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 173 дугаар зүйл, 221-4 дүгээр зүйлд зааснаар зөвшөөрлийн бичиг. 4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 473 дугаар зүйлд заасан гүйцэтгэх хуудас 5. Жинхэнэ нэрийн санхүүгийн гүйлгээ, нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу баталгаа. 6. Харилцаа холбооны нууцыг хамгаалах тухай хуулийн 6, 8 дугаар зүйлд заасны дагуу харилцаа холбоог хязгаарлах арга хэмжээ авах зөвшөөрөл 7. Харилцаа холбооны нууцыг хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу харилцаа холбоог баталгаажуулах мэдээлэл өгөх хүсэлт 8. Харилцаа холбооны нууцыг хамгаалах тухай хуулийн 13-2 дугаар зүйлд заасны дагуу харилцаа холбоог баталгаажуулах мэдээлэл өгөх хүсэлт - (1)-д заасны дагуу цахим баримт бичиг хэлбэрээр гаргасан хүсэлт гэх мэтийг гүйцэтгэхэд ихээхэн хүндрэлтэй, зохисгүй тохиолдолд цахим баримт бичиг хэлбэрээр олгосон хүсэлт гэх мэтийг компьютерын цахим хэрэгслээр хэвлэсэн бичгээр үйлдэж болно.

	- Мэдээлэл боловсруулах компьютержсон системээр 2 дахь хэсэгт заасны дагуу цахим баримт хэлбэрээр олгох батлан даалт зэргийг хэвлэх журам, аргыг Улсын дээд шүүхийн журмаар тогтооно. Энэ тохиолдолд агуулга нь цахим баримт бичгийн хувийн шинж чанарыг хадгалах, олон хуулбарыг шүүгчийн гаргасан зориулалтаас өөрөөр гаргахаас урьдчилан сэргийлэх техникийн арга хэмжээг агуулсан байх ёстой.
18 дугаар зүйл. Нотлох баримтыг шалгах тусгай заалтууд	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 292, 292-3 дугаар зүйлийг үл харгалзан эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд цахим баримт бичгийн нотлох баримтыг шалгах ажиллагааг дараах байдлаар хийж болно. 1. Захидал, бусад тэмдэгт, зураг, гэрэл зураг гэх мэтийн нотлох баримтыг судлах: Холбогдох цахим баримт бичгийг дэлгэц, дэлгэц гэх мэтээр үзэх арга. 2. Аудио, дүрс бичлэгийн мэдээллийг нотлох баримт шалгах: Холбогдох цахим баримт бичгийн аудиог сонсох, дүрс бичлэгийг тоглуулах арга
19 дүгээр зүйл. Шүүх хуралдааны гүйцэтгэлийг удирдах аргын талаарх тусгай заалтууд	- Шүүхийн шийдвэр, шүүх хуралдааны тэмдэглэлийг цахим баримтаар бүрдүүлсэн бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 461 дүгээр зүйлийн үндсэн бичгийг үл харгалзан прокурор шүүх хуралдааны гүйцэтгэлийг цахим баримтаар удирдана. - (1)-ээс үл хамааран шүүхийн гүйцэтгэлийг цахим баримтаар удирдан чиглүүлэхэд хүндрэлтэй байгаа бол шүүхийн гүйцэтгэлийг цахим баримт бичигт бэлтгэсэн бичгээр гаргасан шүүхийн шийдвэрээр, эсхүл компьютерын төхөөрөмжөөр хэвлэсэн шүүхийн протоколоор дамжуулан шийдвэрлэнэ. - 2 дахь хэсэгт заасны дагуу цахим баримт бичгийг хэвлэх журам, аргыг Ерөнхийлөгчийн зарлигаар буюу Дээд шүүхийн дүрмээр тогтооно. Энэ тохиолдолд цахим баримт бичгийн үнэмлэхийг хадгалах техникийн арга хэмжээний тухай асуудлыг агуулгад оруулах ёстой.
20 дугаар зүйл. Цахим баримт бичгийг устгах	- Мэдээлэл боловсруулах компьютержсон системээр бий болсон цахим баримт бичгийг дараах ангиллын дагуу тогтоосон хугацаанд устгана. 1. Ял оногдуулсан шүүх хуралдааныг баталгаажуулсан хэрэг: Шийтгэх хөөн хэлэлцэх хугацаа дууссан бол; Харин цагдан хорих, хөнгөн торгох ял оногдуулсан бол шийдвэр гарсан өдрөөс хойш гурван жил өнгөрсний дараа; 2. Цагаатгах, ялаас чөлөөлөх, яллах дүгнэлт үйлдүүлэхийг хэрэгсэхгүй болгох, хорих ялыг хойшлуулах тогтоол батлагдсан тохиолдолд: Яллах хөөн хэлэлцэх хугацаа дууссаны дараа 3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 245 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 2-т зааснаар яллагдагчаар татаагүй, шилжүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн хэргүүд: Хөөн хэлэлцэх хугацаа дууссан тохиолдолд. - 1 дэх хэсгийг үл харгалзан Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн дүрэмд заасан хэргүүд, тухайлбал, дотоод, олон улсын ноцтой хэрэг, хамсаатнуудыг мөрдөн шалгах шаардлагатай тохиолдолд цахим баримт бичгийг Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын дээд шүүхийн журмын дагуу байнга хадгалж болно. Эсвэл 1 дэх хэсэгт заасны дагуу устгах хугацаа хойшлогдож болно.

Дээрхээс дүгнэвэл, БНСУ-ын тухайд 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн БНСУ-ын парламентын чуулганы нэгдсэн хуралдаанаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт ашиглах тухай хуулийг баталж нарийвчилсан хуулиар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хавтаст хэргийг зохицуулж байгаа нь сайн жишиг бүхий боловсронгуй зохицуулалт болж байна. Тус хуульд «цахим хавтаст хэрэг", "цахимжуулсан хавтаст хэрэг" гэх нэр томьёог нарийвчлан тодорхойлсноос гадна эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахим баримт бичгээр гүйцэтгэх, компьютержсон мэдээлэл боловсруулах системийг ажиллуулах, цахим баримт бичгийг хүлээн авах, цахим баримт бичгийг бэлтгэх, цахим баримт бичгийг үзэх, хуулбарлах, цахим баримт

бичгийг устгах гэх мэт зохицуулалтыг тусгасан байна. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим хавтаст хэргийн зохицуулалтыг тусгахдаа дээрх зохицуулалтын агуулгыг тусгах талаар авч үзэх хэрэгтэй.

3.2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим нотлох баримттай холбоотой хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ

Судалгааны хоёрдугаар бүлгээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэргийн талаар нарийвчлан авч үзэх ба Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд үүнийг шинээр зохицуулж хуульчлах шаардлага бий эсэхийг судална. Мөн түүнчлэн ийнхүү хуульчлахдаа гадаадын зарим улс, орнуудаас нутагшуулах сайн жишиг бүхий зохицуулалтыг болон олон улсын гэрээ, конвенцын зохицуулалтыг тодорхойлох болно.

3.2.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим нотлох баримтын ойлголт, шинж

ЭХХШтХ-ийн 16.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “...эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан аливаа баримтат мэдээллийг нотлох баримт гэнэ...” гэж тодорхойлсон байдаг.

Энэхүү тодорхойлолтоос үзвэл, манай улсын ЭХХШтХ-д нотлох баримтыг ерөнхий байдлаар тодорхойлж өгсөн бөгөөд цахим нотлох баримтын талаар хуульд тусгайлан заагаагүй байна. Харин ЗХШХШтХ, ИХШХШтХ-д “цахим баримт” гэсэн нэр томьёог хуульчилсан.

Хүснэгт 2.5. *ЗХШХШтХ болон ИХШХШтХ-ийн цахим баримт, түүнийг үнэлэх*

	ЗХШХШтХ	**ИХШХШтХ**
Цахим баримт	31.2.Нотлох баримт нь хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, бичмэл, цахим баримт, эд мөрийн баримт, эсхүл баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, кино ба гэрэл зураг, зураглал, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, ул мөрнөөс буулгаж авсан хэв, үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл зэрэг нотолгооны хэрэгслээр тогтоогдоно.	37.2.Хэргийн нотлох баримт нь зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, бичмэл ба цахим баримт, эд мөрийн баримт, эсхүл баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, кино ба гэрэл зураг, зураглал, дүрс, дууны бичлэг, ул мөрнөөс буулгаж авсан хэв, үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл зэрэг нотолгооны хэрэгслээр тогтоогдоно.

Цахим баримт бичгийг үнэлэх	38.7.Шүүх цахим баримт бичгийг үнэлэхдээ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 38 дугаар зүйлд[30] заасныг баримтална.	44.5.Шүүх цахим баримт бичгийг үнэлэхдээ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасныг баримтална.

Өөрөөр хэлбэл, манай улсад иргэн, захиргааны хэрэгт цахим баримтыг нотолгооны хэрэгсэлд хамааруулан авч үзэхээр хуульд тодорхойлон заасан нь цахим нотлох баримтыг цаасан суурьтай нотлох баримттай ижил түвшинд үнэлэх боломжийг бүрдүүлсэн гэж дүгнэж болохоор байгаа юм. Хэдийгээр одоогоор практикт цахим нотлох баримтын үр нөлөө цаасан суурьтай нотлох баримттай харьцуулахад бага байгаа боловч хуульд тусгагдсан учир цаашид цахим нотлох баримт цаасан суурьтай нотлох баримттай адил үнэлэгдэх боломж бүрдэж эхэлсэн гэж үзэж болох юм.

Цахим нотлох баримт нь өргөн утгаараа "...*тухайн хэрэгт ач холбогдол бүхий хуульд заасан арга, хэрэгслээр олж авсан цахим төхөөрөмж, хэрэгсэлд хадгалагдаж буй цахим баримт, мэдээллийг*..." илэрхийлнэ. Харин явцуу утгаараа *"зөрчил хэрхэн болсныг компьютер ашиглан батлах, эсвэл няцаах, тухайн зөрчил нь санаатайгаар үйлдэгдсэн, эсвэл хэрэгт холбогдолгүй болохыг батлах хадгалагдаж эсвэл дамжуулж буй аливаа өгөгдлийг"* хэлнэ.[31]

Хүснэгт 2.6. *Цахим нотлох бариmтын онцлог*[32]

Онцлог	Тайлбар
Хэврэг	Компьютерын сүлжээгээр боловсруулсан зарим цахим өгөгдөл маш хэврэг учир амархан устаж өөрчлөгддөг. Үүнийг цахим нотлох баримт цуглуулах үед онцгой анхаарах нь зүйтэй. Өгөгдөл зөвхөн RAM сүлжээний санах ойд хадгалагдах тул урьдчилан сэргийлэх техникийн тусгай арга хэмжээ аваагүй тохиолдолд сүлжээ гэмтэх буюу унтрах аюултай. Сүлжээний санах ойд хадгалагдсан мэдээлэл мөрдөн шалгах үйл ажиллагаанд чухал. Энэхүү нотлох баримтыг цуглуулах технологи нь уламжлалт нотлох баримт цуглуулах ажиллагаанаас ялгаатай.
Хувиргахад амархан	Цахим өгөгдлийг хувиргах буюу өөрчлөхөд амархан. Компьютерын шинжилгээний үндсэн суурь зарчмын нэг нь цахим нотлох баримтын бүрэн бүтэн байдлыг хадгалах явдал юм. Компьютерын өгөгдлийг бүрэн бүтэн хадгалах арга хэрэглэх, зохих бичиг баримт бүрдүүлэх нь мөрдөн байцаагчийн хувьд нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх талаар хуульд заасан журмыг баримтлаагүй буюу зөрчсөн гэх асуудлаар сэжигтний зүгээс гомдол гаргахаас зайлсхийхэд чухал.
Тархан байршсан хадгалалт	Өргөн зурвасын хүртээмж, серверт зайнаас хадгалах боломж нь мэдээлэл хадгалах арга замд нөлөөлдөг. Өмнө нь мөрдөн байцаагчдын хувьд сэжигтний орон байранд төвлөрч компьютерын өгөгдлийг хайж болдог байсан бол одоо цагт тэдний хувьд тоон мэдээллийг хилийн чанадад, шаардлагатай бол сэжигтэй мэдээллийг зөвхөн алсаас хандаж хадгалж болно гэдгийг анхаарах шаардлагатай.

30 Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 38 дугаар зүйлд Баримт бичгийн албан ёсны хүчинтэй байдлыг талаар тусгасан бөгөөд 38.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол цаасан болон цахим баримт бичиг нь хууль тогтоомж болон стандартаар тогтоосон баримт бичгийн бүрдлээр баталгаажна" гэж, 38.2-т "Цахим баримт бичиг нь цаасан баримт бичигтэй адил хүчинтэй байх бөгөөд зөрсөн тохиолдолд анх баталгаажсан баримт бичгийн хэлбэр (цаашид "баримт бичгийн эх хувь" гэх)-ийг баримтална" гэж, 38.3-т "Баримт бичгийн эх хувийг цаасан, эсхүл цахим баримт бичгийн хэлбэрт хуулбарласан тохиолдолд цаасан, эсхүл цахим баримт бичигт "хуулбар хувь" гэсэн тэмдэглэгээ хийнэ" гэж тус тус заажээ.

31 Л.Галбаатар, Кибер гэмт хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх нь, (Уб, 2015), 26 дахь тал.

32 ННФ, Кибер гэмт хэргийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа /Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, үйл ажиллагааны эрсдэлийн хүрээнд/, (Уб, 2022), 53-54 дэх тал.

Техникийн дэвшлийн хурд	Техникийн дэвшил хурдацтай урагшилж байгаа нь криминалистикийн шинжилгээнд шинэ сорилтыг бий болгож байна. Ийм хөгжил нь нотлох баримт цуглуулах үүрэгтэй хүмүүсийг сургах, түүнчлэн одоогийн криминалистикийн шинжилгээний багаж, хэрэгслийг шинэчлэхийг шаардана. Үйлдлийн систем болон бусад программ хангамжийн бүтээгдэхүүнүүдийн шинэ хувилбарууд мөрдөн шалгах үйл ажиллагаатай холбоотой янз бүрийн мэдээлэл, өгөгдөл бий болгодог болсон.

Мэдээлэл (дохио) боловсруулж буй аргад нь үндэслэн цахим нотлох баримтыг “аналоги” болон “дижитал (тоон)” баримт гэж 2 ангилдаг. Аналоги төхөөрөмж гэдэгт хар цагаан зураг, хальсан дээр буулгасан гэрэл зураг, видео-кассет, дуу хураагуурт хураасан бичлэг зэрэг нотлох баримтыг анхдагч шинжийг түлхүү агуулсан, хадгалалтын онцгой нөхцөл шаардах баримтуудыг ойлгох бөгөөд эдгээрийн хэрэглээ өнөөдрийн байдлаар буурсан. Харин дижитал нотлох баримтад “бит” бүр нь 1 эсвэл 0 гэсэн хоёртын хэлбэрээр илэрхийлэгдэж буй баримт мэдээллүүд болох компьютер, гар утас, мессеж, мессенжер зэрэг хадгалагдаж, дамжуулагдаж буй мэдээлэл, зурвасуудыг хамааруулдаг. Аналоги эсвэл дижитал гэдгээс үл хамаарч цахим нотлох баримт нь хүний хувийн мэдээллийг шууд агуулж байдаг тул “Мэдээлэлд нэвтрэх үйл ажиллагаа нь тухайн мэдээллийг хайж олох зорилгодоо нийцсэн байх” зарчим баримтлах шаардлагатай. Уг зарчмын дагуу мөрдөн шалгах ажиллагаанд нэг талаас “хувийн халдашгүй байдлыг хангах” буюу хүний хувийн мэдээллийг, тэр дундаа эмзэг мэдээллийг хамгаалах, нөгөө талаас “нийгмийн аюулгүй байдлыг хангах” буюу гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, үндэсний аюулгүй байдлыг хангах гэсэн хоёр ашиг сонирхлыг нэгдмэл байдлаар авч үзэж, харилцан тэнцвэртэй байдлыг хангах ёстой.[33]

Цахим нотлох баримт нь кибер гэмт хэрэг төдийгүй уламжлалт гэмт хэргийг мөрдөн шалгахад чухал ач холбогдолтой нотлох баримт юм. Тухайн нотлох баримтад хандах эрхийн зохицуулалт улс орон бүрд харилцан адилгүй боловч хүний хувийн халдашгүй байдалд халдах болон түүнийг хамгаалах үйл ажиллагааны түвшинд үндэслэн цахим нотлох баримтыг дараах гурван төрөлд ангилна. Үүнд:[34]

1. Хэрэглэгчийн мэдээлэл (Subscriber information) – Тодорхой үйлчилгээ авч буй хэрэглэгчийг тодорхойлоход ач холбогдолтой мэдээллүүд. Хэрэглэгч бүртгүүлэх болон түүнд тодорхой үйлчилгээ үзүүлэх үед цуглуулсан мэдээллүүд байна. Тухайлбал, нэр, гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар гэх мэт. Эдгээр мэдээлэл гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд нэн тэргүүнд шаардлагатай мэдээллүүд байх тул хуульд зааснаар мэдээлэлд шууд хандаж, хууль сахиулах эрх бүхий ажилтны бүрэн эрхэд хадгалагдана.

2. Хандалт /хөдөлгөөн буюу шилжүүлгийн өгөгдөл (traffic/Access and Transactional data) – хэрэглэгч хоорондын харилцсан мэдээлэл, холбоос, IP хаяг, газар зүйн байршлын мэдээлэл, тодорхой үйлчилгээнд авсан хугацаа, огнооны талаарх мэдээллүүд. Хууль, эрх зүйн зохицуулалтаас хамаарч зарим улс оронд үйлчилгээ эхлүүлэх, зогсоохтой холбоотой мэдээлэл мөн хамаардаг. Тухайн мэдээлэлд нэвтрэх, мэдээлэл цуглуулахад прокурорын зөвшөөрөлтэй байхыг шаардана.

3. Контентын өгөгдөл (Content data) – Контент болон цахим шуудан, мессеж, зурган мэдээллүүд. Эдгээр мэдээлэлд нэвтрэх эрхийг зөвхөн шүүгч захирамжийн дагуу олгодог.

33 Мөн мэнд, 50 дахь тал.

34 Мөн тэнд, 51-52 дахь тал.

Цахим нотлох баримтад дуу, бичлэг, зураг болон дижитал, эсвэл аналоги форматтай мета өгөгдөл зэргийг хамааруулсан бөгөөд дараах эх сурвалжаас үүсэж болохоор тодорхойлсон. Үүнд:

- Байгууллагын үүсгэсэн эсвэл хадгалсан мультимедиа (ярилцлага, хяналтын камерын болон машины камерын бичлэг, хувцсанд зүүсэн камер, хэргийн газрын бичлэг гэх мэт);

- Гуравдагч этгээдээс ирүүлсэн болон олж авсан мультимедиа (олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, видео бичлэгийн төхөөрөмжөөр хийгдсэн бичлэг, гар утас, дрон, CCTV камерын бичлэг, зүйлсийн интернэт (Internet of Things120) гэх мэт).

Манай улсад цахим нотлох баримт болон эд мөрийн баримтын хооронд эрх зүйн ялгаа байхгүй, цахим нотлох баримтыг эд мөрийн баримттай ижил хууль зүйн хүчин төгөлдөр гэдгийг тодотгон заагаагүй.[35] Иймд ЭХХШтХ-д цахим нотлох баримт, түүний төрөл тодорхойлж хуульчлах шаардлагатай. Үүний зэрэгцээ цахим нотлох баримтыг эд мөрийн баримтын нэг хэсэг болгон зохицуулах нь олон талын тустай.[36]

Цахим нотлох баримтыг цуглуулах, гаргуулан авах нь кибер гэмт хэргийг мөрдөн шалгах, шүүхээр хянан хэлэлцэх үйл явцын нэг чухал хэсэг байдаг. Мөн цахим нотлох баримт нь дээрэм, хулгай, авлига, өмч хөрөнгө ашиглах гэх мэт уламжлалт хэргүүд болон зохион байгуулалттай гэмт хэргүүдэд нотолгооны өндөр ач холбогдолтой болж байна. Уламжлалт гэмт хэргүүдэд утасны ярианы бичлэг, цахим шуудан, захидлууд, чат, IP холболтын бүртгэл, SMS мэдээлэл, гар утасны дуудлага, хаягийн бүртгэл, компьютерын файлууд олон нотлох баримт гаргаж өгөх эх сурвалж болж хувирсан.[37]

Тоон (цифр) нотлох баримт буюу цахим нотлох баримт гэж гэмт хэргийн тал бүрийн нөхцөл байдлыг тогтоохын тулд шүүхэд нотлох баримт болгон ашиглаж буй цифр хэлбэрээр хадгалсан, дамжуулсан аливаа мэдээлэл юм. Ихэнх улсын хуульд цахим тоон нотлох баримт гэдгийг “цахим хэлбэрээр хадгалж, эсхүл дамжуулж буй нотолгооны ач холбогдолтой аливаа мэдээлэл, түүний дотор компьютерын нотлох баримт, цифр аудио, видео, гар утас, цифр факсын мэдээллүүд” хэмээн тодорхойлсон байна.[38]

Тоон нотлох баримтуудын үндсэн шинж нь ДНК, хуруугны хээний мөртэй нэгэн адил янз бүрийн хэлбэрээр нуугдмал байдаг, ямар ч улсын хил хязгаараас үл хамаарсан, маш эмзэг, амархан өөрчилж болдог, хурдан өөрчлөгддөг, устгагддаг, цаг хугацаанд ихээхэн мэдрэмтгий байдагт оршино. Энэ шалтгааны улмаас энэ төрлийн нотлох баримтыг илрүүлэх, цуглуулах, хадгалах, баримтжуулах, судлахад онцгой дэгийг баримтлах шаардлагатай.[39]

Тоон нотлох баримттай ажиллах үед дараах зарчмыг чанд баримтлах ёстой:

- Тоон нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, аюулгүй байдлыг хангах, хадгалах, зөөвөрлөх үйл явц уг нотлох баримтыг өөрчлөхгүй байх;

35 Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг (Кибер) гэмт хэргийн гүнзгийрүүлсэн судалгаа, (Уб, 2019), 17 дахь тал.

36 Мөн тэнд.

37 Мөн тэнд, 33 дахь тал.

38 Мөн тэнд, 77 дахь тал. Дам эшлэв.

39 Мөн тэнд, 77 дахь тал.

- Тоон нотлох баримтыг шинжилж буй этгээд тусгайлан сургалтад хамрагдсан, зохих мэдлэг, чадвар, туршлагатай байх;
- Тоон нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, аюулгүй байдлыг нь хангах, хадгалах, зөөвөрлөх үйл явцыг заавал баримтжуулсан, зохих ёсоор хадгалсан, дараа нь үзэх боломжтой байх.[40]

Хүснэгт 2.7. *Тоон нотлох бариmтыг агуулж болох төхөөрөмж, хэрэгслүүд*[41]

№	Тоон төхөөрөмж	Хадгалагдаж байж болох нотлох баримт
1	Суурин компьютерын процессор их бие, зөөврийн компьютер	Төхөөрөмж өөрөө хулгай, хуурамчаар үйлдэх гэх мэт хэргийн нотлох баримт байж болно. Төхөөрөмж дотроо гэмт хэргийн нотолгоо болох төрөл бүрийн өгөгдөл, мэдээлэл, түүний дотор шууд харах боломжгүй устгасан мэдээлэл бүхий эд ангиуд агуулна. Компьютерын цифр-тоон шинжилгээ ашиглан өгөгдлийн дүрийг (image) хуулж, гаргаж авч, шинжилдэг. Мөрдөгч туршлага мэдлэгтэй бол дүрийг хуулан авах боломжтой.
2	Ажиллаж буй компьютер, серверийн дэлгэц, таблет, зөөврийн төхөөрөмж, гар утасны дэлгэц	Ажиллаж буй системийн дэлгэц дээр харагдаж буй бүх файл, зураг, график нотлох баримт байх боломжтой. Эдгээрийг видео, фото зураг хэлбэрээр бэхжүүлж баримтжуулдаг.
3	Ухаалаг карт, донгл, токен, крипто токен, биометр сканер болон бусад	Төхөөрөмж өөрөө болон түүнд агуулагдаж буй таних, баталгаажуулах мэдээлэл, хандалтын эрх, түвшин, тохируулга, зөвшөөрлийн мэдээллүүд
4	Хариулдаг машинууд	Төхөөрөмж дуут мэдээлэл, мэдээллийг үлдээсэн хугацааны талаар мэдээллийг хадгалан үлдэж болно. Холбогдсон сүүлийн дугаар, утасны дугаарууд, бичлэг, мэдээлэл гэх мэт мэдээлэл агуулж болно.
5	Тоон камерууд	Эдгээр төхөөрөмжөөс зураг, видео, дуу авиаг гаргаж авах, сольдог юмуу байнгын санах ойн мэдээллийг авах, цаг хугацааны мэдээлэл олж авах боломжтой.
6	Тоон гар төхөөрөмж, зохион байгуулагч, тэмдэглэлийн дэвтэр, гар утас, дэлгэцэн төхөөрөмж гэх мэт	Хаягийн тэмдэглэл, хуанли, хуваарь, уулзалт, баримт бичгүүд, цахим захидал, утасны дугаарууд, мессеж, мэдээллүүд, нууц үгнүүд гэх мэт маш олон мэдээллийг эдгээр төхөөрөмжөөс олж авч болно.
7	Хатуу болон SSD дискүүд	Энэ төхөөрөмж өөрөө болон түүнд агуулагдаж буй бүх мэдээлэл өгөгдөл
8	Сүлжээний төрөл бүрийн картууд	Төхөөрөмж өөрөө болон MAC (Media access control) хаягуудыг авна.
9	Чиглүүлэгч-рутер, холбогч-свитч, хаб болон модемууд	Төхөөрөмжүүд өөрөө болон тэдгээрт агуулагдаж буй тохируулгын файлууд, IP хаягууд
10	Серверүүд	Серверийн бүх бүртгэлийн файлууд, түүнд байх хандалтын мэдээллүүд, солилцсон мэдээлэл, ажиллаж буй систем дэх захидал, оруулсан, гаргасан, өөрчилсөн, устгасан, хадгалсан, боловсруулсан гэх мэт бүх мэдээлэл, хандсан интернэт хаягууд, татсан мэдээллүүд гэх мэт.
11	Сүлжээний кабел, холбогч толгой	Сүлжээний кабел нь түүнд холбогдсон төхөөрөмжүүдийг мөшгөн бүртгэх, баталгаажуулах боломжийг олгоно. Холбогч толгойг шинжилснээр ямар төрлийн төхөөрөмжүүд холбогддогийг илрүүлнэ.

40 Мөн тэнд.

41 Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг (Кибер) гэмт хэргийн гүнзгийрүүлсэн судалгаа, (Уб, 2019), 77 дахь тал.

12	Принтер	Принтерт сүүлийн хэвлэсэн зүйлсийн ул мөр, мэдээлэл, тоо, мөн сүүлийн үеийн загварууд нь ашиглалтын бүртгэл, цаг хугацааг хадгалан үлддэг. Сүлжээний принтер бол сүлжээний талаар зарим мэдээллийг хадгална. Түүнчлэн, сүүлд ашигласан хүмүүсийн гарын хээний мөрийг авч болно.
13	Зөөврийн тээгч, санах ой бүхий төхөөрөмж	Бүх төрлийн флаш диск, зөөврийн диск, шинэ үеийн гар утас, камер, дэлгэцэн таблет төхөөрөмжүүдийн санах ойд нотлох баримтын ач холбогдолтой олон файл хадгалагдаж болно.
14	Сканер	Энэ төхөөрөмж өөрөө болон түүний санах ойд үйлдсэн хууль бус үйлдлийн талаарх бүртгэлийн мэдээлэл
15	Телефон болон гар утас	Орчин үеийн ихэнх телефон утас дуудлагын түүх, нэр, бичгийн болон дуут мессеж, бичлэг, утасны дугаар, нууц үг болон дуудлага хийгчийн мэдээллийг хадгалсан байж болно.
16	Хувилагч	Хувилагчууд хувилсан баримт бичгийн ул мөрийг биетээр болон цахим хэлбэрээр хадгалж үлдсэн байж болно. Түүнчлэн, хэрэглэгч, хувилсан цаг хугацааны бүртгэлийг агуулдаг.
17	Диск уншигч, бичигч	Эдгээр төхөөрөмжид нотлох баримтын ач холбогдолтой файл, бүртгэл, огнооны мэдээлэл үлдэж болно.
18	Карт уншигчид	Картын соронзон тууз, чипийн дараах мэдээллүүд карт уншигчид үлдэж болно. Картын хугацаа Хэрэглэгчийн нэр, хаяг Картын дугаар
19	Цифр технологитой цагууд	Сүүлийн үеийн цифр-тоон цагууд хаяг, тэмдэглэл, ажлын хуваарь, утасны дугаар, цахим шуудан, замын маршрут, байршлын тухай мэдээлэл хадгалдаг.
20	Факсын машин	Факсын аппарат нь зарим баримт бичиг, бүртгэл, тухайлбал, холбогдсон утасны дугаарууд, илгээсэн, хүлээн авсан бүртгэл, хэвлэгч картриж хор агуулдаг. Картриж хороос сүүлийн хэвлэсэн зүйлсийн ул мөрийг гаргаж авч болно.
21	GPS байршил тодорхойлогч систем	Аялсан маршрут очдог газруудын байршил, замын цэгүүд, тэдгээрийн нэр гэх мэт олон мэдээлэл гарган авч болно.
22	Компьютерын гар, хулгана	Эдгээрээс хурууны хээ авч болохоос гадна ямар товчлуурыг илүү их дардаг, нууц үгээ хэрхэн оруулдаг зэргийг мэдэх боломжтой.

Цахим орчинд үйлдэгдэж буй гэмт халдлагыг шинжлэх ухааны тодорхой салбарын тусгай мэдлэг, тусгай техник хэрэгсэл, тусгай арга, арга зүйг ашиглан шинжлэн судалж гаргасан баттай дүгнэлтийг үндэслэн болж өнгөрсөн үйл явдлын бодит үнэнийг тогтоохоос өөрөөр уламжлалт аргаар мөрдөн шалгаж шийдвэрлэх ямар ч боломжгүй болсон. Цахим орчинд үйлдэгдэж буй гэмт халдлага бүр орон зай, цаг хугацааны хувьд ямар ч хязгаарлалтгүй төдийгүй үйлдэгч болон хохирогч, хохирлын шинж, онцлог, зорилго, сэдэл, үйлдэлдээ хэрэглэсэн арга, технологи шаардах болсонтой холбоотой.[42]

Дэлхийн бусад улс орнуудад ч эрүүгийн болон кибер гэмт хэргийн чиглэлээр шуурхай хамтран ажиллах механизм бий болгох нь маш чухал болохыг тэмдэглэж байна. Зарим улс хууль хамгаалах байгууллагуудын хоорондо албан бус хамтын ажиллагааны механизмыг хөгжүүлэхийг санал болгож байгаа бол зарим нь хоёр талын болон олон талын, бүс нутгийн гэрээ байгуулах замаар албан ёсны сувгуудыг хөгжүүлэхийг санал болгож байна. Түүнчлэн, CERT /Computer Emergency Response Team/, CSIRT /Computer Security Incident Response Team/-ийн шугамаар нотлох

42 Монгол Улсад үйлдэгдэж байгаа кибер гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, түүнтэй тэмцэх арга зам, үндсэн чиглэл /Суурь судалгааны тайлан/, (Уб, 2015), 88 дахь тал.

баримтыг даруй гаргуулж авах хамтын ажиллагааг санал болгож байна.[43]

Тоон (цифр) нотлох баримт нь кибер гэмт этгээдийн гэм бурууг нотлоход ашиглаж буй тоон хэлбэртэй төрөл бүрийн хэрэгслийг хэлдэг. Энэ нь хадгалж болдог болон түргэн хугацаанд устдаг өгөгдлүүд, компьютерын файл, дамжуулалт, үйлдлийн бүртгэл файлууд, журнал, мета өгөгдлүүд болон сүлжээний өгөгдлүүд хэлбэртэй байж болно.

Шүүхийн тоон шинжилгээний явцад ихэнхдээ тогтвортой бус, хялбархан өөрчлөгддөг, нотлох баримтын ач холбогдолтой мэдээллийг сэргээх ажиллагаа хийгддэг. Шүүхийн тоон шинжилгээний аргад эх өгөгдөлд өөрчлөлт орохоос сэргийлэх зорилгоор хадгалагдаж байгаа болон устгасан мэдээллийн хувийг "битийг битэд", "бичлэгийг блоклох" зарчмын дагуу үүсгэх арга ордог. Дэлхийн ихэнх улсад шүүхийн тоон шинжилгээний чадамжийг бий болгосон байхад Монгол улсад энэ нь эхлэл төдий байна. Монгол улсын нэгэн адил хөгжиж буй улсуудад шүүхийн тоон шинжээчид хүрэлцээгүй, шинжилгээ хийх хэрэгсэл, төхөөрөмж, тусгай программ хангамж дутагдалтай байна. Түүнчлэн, сэжигтнүүд шифрлэлтийг түлхүү ашигладаг болсон учир задлах түлхүүрийг олох хэрэгслүүд шаардлагатай болж байна. Ихэнх улсад тоон нотлох баримтын шинжилгээг цагдаагийн байгууллага гүйцэтгэж байна. Прокурорууд цахим нотлох баримтыг судлах, ойлгох шаардлагатай. Гэтэл прокурорын байгууллагад энэ чиглэлийн чадамж, чадвартай хүний нөөц байхгүй байна.[44]

Кибер гэмт хэргийн нөхцөл байдлыг нотлох буюу гэмт хэргийн ул мөрийг баримтжуулах нь тоон шинжилгээтэй (digital forensic) салшгүй холбоотой. Тоон шинжилгээ нь цахим нотлох баримт цуглуулах, шалгах, үнэлэхтэй холбоотой хийгдэж буй ажиллагаа буюу шүүхийн шинжилгээний нэг тусгай төрөл юм. Ийм тусгай шинжилгээг тоон шинжилгээ буюу компьютерын шинжилгээ гэсэн хоёр ойлголтоор илэрхийлдэг. Тоон шинжилгээ (digital forensic) гэдэг нь аливаа тоон тоног төхөөрөмжтэй хамааралтай материал дээр үндэслэн төрөл бүрийн тусгай арга механизм, техникийг ашиглан дүн шинжилгээ хийх замаар баримт бүрдүүлэх шинжилгээ судалгааны нэг төрөл юм. Харин компьютерын шинжилгээ нь тоон шинжилгээний нэг төрөл бөгөөд компьютер болон хадгалах төхөөрөмжид хадгалагдсан өгөгдөл дээр үндэслэн төрөл бүрийн тусгай арга механизм, техникийг ашиглан дүн шинжилгээ хийх замаар баримт бүрдүүлэх, дүгнэлт гаргах ажиллагаа юм.[45]

Манай улсын ЭХХШтХ-ийн 16.1 дүгээр зүйлийн 6-д "Нотлох баримтыг хууль бус арга, хэрэгслээр цуглуулж, бэхжүүлэхийг хориглоно" гэж, мөн хуулийн 16.11, 16.12 дугаар зүйлд нотлох баримтаар тооцохгүй байх тохиолдлуудыг хуульчилсан. Шүүхэд ирүүлж буй файлын төрөл нь эх төхөөрөмж дээр бичигдсэн байдлаас өөр байх нь мультимедиа нотлох баримтыг хүлээн зөвшөөрөх эсэхэд эргэлзээ төрүүлж, маргаан үүсгэдэг.[46]

43 Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг (Кибер) гэмт хэргийн гүнзгийрүүлсэн судалгаа, (Уб, 2019), 7 дахь тал.

44 Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг (Кибер) гэмт хэргийн гүнзгийрүүлсэн судалгаа, (Уб, 2019), 16 дахь тал.

45 Цахим орчин дахь гэмт хэргийн ул мөрийг баримтжуулж авах нь, https://www.mnb.mn/i/92447

46 ННФ, Кибер гэмт хэргийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа /Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, үйл ажиллагааны эрсдэлийн хүрээнд/, (Уб, 2022), 68 дахь тал.

Монгол Улсын хувьд ЭХХШтХ-ийн 16.1 дүгээр зүйлийн 4-т “Мөрдөгч энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу нотлох баримт цуглуулж, шалгаж, бэхжүүлнэ” гэж заасны дагуу мөрдөгч нотлох баримтыг бэхжүүлэх ажиллагааг гүйцэтгэдэг.

3.2.2. Монгол Улс дахь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим нотлох баримтын нөхцөл байдал, хэрэгцээ, шаардлага

Ковид 19 цар тахлын нөлөөгөөр цахим харилцаа холбоо, цахимжилт нийгмийн олон талт харилцаанд томоохон нөлөө үзүүлсэн. Ийнхүү цахим харилцаа холбоо өргөжин тэлэхийн хэрээр Монгол Улсад төдийгүй олон улсын хэмжээнд шинэ төрлийн гэмт хэргүүд бүртгэгдэж, цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэргийн тоо өсөх, зарим гэмт хэргийг урьд тогтсон уламжлалт хандлагаар авч үзэх боломжгүй байдлаар хувьсан өөрчлөгдөж агуулга, хэлбэр, хор уршиг, хохирлын хэмжээ нэмэгдэж байна. Иймээс ч тухайн гэмт хэргийг илрүүлэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгаж, хэргийн бодит байдлыг тогтооход цахим нотлох баримт чухал ач холбогдолтой болоод байна.

Тухайлбал, 2022 онд Прокурорын байгууллага Эрүүгийн хуулийн 26 дугаар бүлэгт заасан Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хамаарах нийт 751 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьж ажилласан бөгөөд Эрүүгийн хуулийн 26.1 дүгээр зүйлд заасан Кибер орчинд хууль бусаар халдах гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан 750 хэрэг, мөн хуулийн 26.3 дугаар зүйлд заасан Хор хөнөөлт программ хангамж бүтээх, ашиглах, тараах гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан 1 хэрэг байна. Энэхүү 751 хэргийн 2 хэргийг хэрэгсэхгүй болгож, 37 хэргийг шүүхэд шилжүүлж, 202 хэргийг нэгтгэн, 71 хэрэг бүртгэлтийн хэргийг хааж шийдвэрлэжээ.

Энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэхэд цахим нотлох баримт чухал үүрэгтэй боловч цахим суурьтай нотлох баримтыг бэхжүүлэх, цуглуулах, хадгалах, шинжлэн судлах зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цаасан суурьтай нотлох баримттай ижил түвшинд үнэлэхгүй байх, цахим нотлох баримтыг заавал цаасан суурьтай нотлох баримт болгох, цаасан хэлбэрт буулгаж хавтаст хэрэгт хавсаргах зэрэг арга хэмжээг авч ажиллаж байна.

Гэтэл кибер гэмт хэрэг үйлдэж буй орон зай, тухайн хэрэгт ашиглаж буй төхөөрөмж, хэрэгсэл, халдлагын зүйлээс шалтгаалж, зөвхөн уламжлалт нотлох баримт (бичгийн болон эд мөрийн баримт)-уудад тулгуурлан тухайн үйл явдал болсныг нотлох, эсвэл үгүйсгэх боломжгүй тул цахим нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, хадгалах, хамгаалах ажиллагаа чухал байр суурь эзэлдэг. Хэрэгт ач холбогдол бүхий цахим, аналоги, дижитал (тоон) баримтуудыг хамтад нь “цахим баримт” гэж нэрлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нийтлэг байдлаар хэрэглэж байна.

Цахимаар мэдүүлэх, цахим хавтаст хэрэг үүсгэх, цахим нотлох баримт, нотлох баримтыг цахим хэлбэрт оруулснаар цаасан суурьтай бичиг баримт бүрдүүлэх шаардлагагүй болж, байгаль орчинд эергээр нөлөөлнө. Мөн цахимаар шүүхэд мэдүүлэх, цахим хавтаст хэрэг үүсгэх зэргээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулснаар шүүхийн хүртээмж илүү нэмэгдэж, хэрэг маргаан хянан шийдвэрлүүлж буй этгээдийн хувьд цаг хугацаа, зардал хэмнэгдэж, шүүхэд итгэх

иргэдийн итгэл нэмэгдэн шүүх эрх мэдэл улам бэхжих юм.[47]

Түүнчлэн, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлснээр цаасан суурьтай баримт бичиг шаардахгүй байх үндэслэл бий болно. Ингэснээр иргэд заавал өөрийн биеэр очиж, хэн нэгэн албан тушаалтны хаалга үүдийг сахиж, цаас бүрдүүлэх шаардлагагүй болно. Нөгөөтээгүүр, цахим баримт бичгийг нотлох баримт бичгийн хэмжээнд хүлээн зөвшөөрдөг болох юм. Практикт төрийн байгууллагын үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэхэд цахим баримт бичгийг нотлох баримтын хэмжээнд үнэлдэггүй, цаасан баримт бичгийг л нотлох баримтын хэмжээнд хүлээн зөвшөөрдөг.[48]

Шигтгээ 5.

Цахим нотлох баримтын одоогийн практикийн хувьд ИХШХШтХ-ийн жишгээр буюу баримт бичгийн эх хувь нь цахим бол шүүх түүнийг нотлох баримтад тооцож байна. Гэвч цахим нотлох баримтыг үнэлэхэд шүүхэд тулгарч буй гол асуудал түүнийг үнэлэх, үнэн зөвийг нь тогтооход төвөгтэй, цаг хугацаа шаарддаг, зарим тохиолдолд нарийн мэргэжлийн мэдлэг, технологи шаардлагатай байдаг. Иймд шүүхүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь цахим нотлох баримтын үнэлэх чадавхыг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа юм.

Цахим нотлох баримтын тал дээр одоо хэрэгжиж байгаа туршлага гэвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай улсын мэдээллийн санд буй 18 төрлийн мэдээллийг шүүх нь тамгын газрын даргаар дамжуулан шууд авч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглаж байгааг дурдаж болно. Гэхдээ ийнхүү төрд цахимаар байгаа мэдээллийг шүүх шууд хандан авах практикийг цаашид эрүүгийн болон зарим тохиолдолд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илүү ашиглах, нэвтрүүлэх шаардлагатай бөгөөд учир нь ийнхүү нотлох баримтыг шүүх өөрөө цуглуулах нь иргэний эрх зүйн мэтгэлцэх зарчимтай харшлах магадлалтай юм.

Мөн энэ тал дээр бас нэг анхаарах чухал асуудал бол цахим буюу дижитал архивыг бий болгох, үйл ажиллагааг нь зохион байгуулах, ажиллах журмыг боловсруулах асуудал юм.

Ер нь ЭХХШтХ-д цахим нотлох баримтын хэлбэрийн шаардлага болон хэрхэн үнэлэх журам, цахим хавтаст хэргийн тодорхойлолт, түүнийг хөтлөх журам зэрэг нарийвчилсан зохицуулалтыг шууд хуульчлан тусгахын оронд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим нотлох баримтыг үнэлэх, хавтаст хэргийн цахимаар хөтөлж болох тухай ерөнхий зохицуулалтыг хийж цахим нотлох баримт, түүнийг баталгаажуулах, үнэлэх, цахим хавтаст хэргийг хөтлөх зэрэг ажлыг аргачлалаар хангах ажлыг зохион байгуулах боломж бий. Нэгэнт байгуулагдсан ШЕЗ гэх мэт институцид даалгах нь илүү оновчтой шийдэл байж болох юм.

Гэхдээ ийнхүү ажлыг зохион байгуулахдаа ХБНГУ зэрэг улсын жишгийн дагуу, хавтаст хэргийг цахимаар хөтлөх, нотлох баримтыг цахимаар авах, цахим хэлбэрт байгаа хавтаст хэрэгт хэргийн оролцогчид хандах, шүүх хуралдаанд эдгээр цахим баримтыг танилцуулах, үнэлэх зэрэг ажлыг аль болох хэргийн оролцогчид шууд хандаж ойлгох, ашиглахад хялбар хэлбэр бүхий технологийг ашиглах нь зүйтэй.

47 Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын төсөлд хийсэн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ /Хөндлөнгийн судалгаа/, (Уб, 2023), 47 дахь тал.

48 М.Бямбасүрэн, Цахим баримт бичгийг нотлох баримтын хэмжээнд үнэлдэг байх шаардлагатай нийтлэл, 2024.01.29, https://business.mn/2024/01/29/m-byambasuren-tsahim-barimt-bichgiig-notloh-barimtiin-hemjeend-uneldeg-baih-shaardlagatai/

Мөн шүүхийн цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар нэвтрүүлэх хэрэгтэй. Жишээлбэл, бага үнийн дүнтэй нэхэмжлэлийг шийдэх, таслан сэргийлэх арга хэмжээ авах, шүүгч ээлжээр ажиллах ажлыг цахимаар явуулахаар бол тодорхой хугацаа зааж, уг хугацааны хүрээнд уг ажлыг зохион байгуулна гээд тэр хугацаанд нь мэргэжлийн оролцогчдын тоон гарын үсгийг ашиглаж сурах боломжийг бүрдүүлэх гэх мэт.

Ийнхүү шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахим болгож буй гол үндсэн зорилго нь шүүхийн ажиллагааг хурдан шуурхай болгож, иргэдийн шударгаар шүүлгэх эрхийг хангах, ил тод байдлыг хангах бөгөөд хэрэгцээ шаардлагын хувьд өнөө үед нотлох баримт цахим байх, түүнийг үнэлэх, хавтаст хэргийг цахимаар хөтлөх зэрэг нь боломжтой, зарим тохиолдолд зайлшгүй цахим хэрэглээнд тохирсон зохицуулалт байх тул нийгмийн энэ хөгжлийг дагасан зохицуулалт хийх шаардлагатай.

Цахим хавтаст хэрэг, нотлох баримтыг хадгалах, архивлах ажлын хувьд тэдгээрийг хэрхэн хадгалах технологи (scanner), хадгалалтын хугацаанд тохирсон хэлбэр (pdf) зэргийг анхаарч үзэх мөн зарим төрлийн гэмт хэрэгтэй холбоотой хэргийн материал, хавтаст хэрэг зэргийг цаасаар байх эсэх гэх мэт зохицуулалтыг ч анхаарах шаардлагатай.

Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн гишүүн Н.Баасанжавтай хийсэн ярилцлагын хэсгээс...

Цахим нотлох баримт, цахим хавтаст хэрэг, цахимжуулсан хавтаст хэрэг гэх мэт цахимжуулалттай холбоотой асуудлыг шийдвэрлэхийн тулд юун түрүүнд эрх зүйн орчин, дата бааз, хадгалах сервер, технологийн шийдэл, бүрдүүлэх нь чухал.

Тухайлбал, цахим хавтаст хэрэг үүсгэснээр маш их хэмжээний дата буюу өгөгдөл бий болно. Иймд шүүхийн их өгөгдлийн сан буюу Big data-г үүсгэх нь чухал. Их өгөгдөл бол компьютерын шинжлэх ухаан, статистик хоёртой салшгүй холбоотой бөгөөд мэдээллүүдийг нэгтгэж, хооронд нь холбож, богино хугацааны давтамжтайгаар, олон үзүүлэлтээр боловсруулах, нарийвчлан задлах зэргээр маш хурдтай, цаг хугацааны алдагдалгүй, байгууллагын дотоод үйл ажиллагаанд ашиглах, иргэд олон нийтэд мэдээлэх, оновчтой бодлого шийдвэр гаргахад зориулагдсан технологийн \hadoop зэрэг\ шийдэл юм.[49]

3.2.3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим нотлох баримтын харьцуулсан судалгаа

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим нотлох баримтын талаар харьцуулсан судалгааг хийхдээ өмнө нь авч үзсэн шүүх, хууль, эрх зүйн үйл ажиллагааг цахимжуулах талаар дэвшил гаргасан, эрх зүйн тогтолцооны хувьд жишиг болгож судалдаг дараах улсуудыг судаллаа. Мөн олон улсын гэрээ, конвенцын зохицуулалтыг нэмж судлан харьцуулсан юм.

3.2.3.1. Олон улсын гэрээ, конвенцын зохицуулалт

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим нотлох баримт, хавтаст хэрэг, түүний хадгалалтын талаар дараах олон улсын гэрээ, конвенциуд хүчин төгөлдөр үйлчилж байна.

- Европын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараах хорих ял эдлүүлэх ажиллагаан дахь цахим нотлох баримтыг бий болгох, хадгалах журам (EU) 2023/154;

49 Г.Даваадорж: Шүүхийн цахимжилтад хууль эрх зүйн орчин ус агаар мэт хэрэгтэй байна, https://www.judcouncil.mn/site/news_full/13818

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим нотлох баримт цуглуулах үүрэг бүхий байгууллагыг үүсгэн байгуулах, түүний хууль ёсны төлөөлөгчдийг томилох зохицуулалтыг ижилтгэх удирдамж (EU) 2023/154;

- Кибер гэмт хэргийн тухай Будапештын конвенц (ETS No. 185);

- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц ба түүнд заасан протоколууд (55/255)

- Истанбулын протокол (Эрүүдэн шүүх болон бусад хэрцгий, хүнлэг бус буюу нэр төрийг гутаан харьцах, шийтгэхийг үр дүнтэй мөрдөн шалгах, баримтжуулах гарын авлага)

- Хувийн мэдээллийг автоматаар боловсруулахтай холбоотой хувь хүнийг хамгаалах тухай Европын зөвлөлийн конвенц гэх мэт.

1. “Европын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараах хорих ял эдлүүлэх ажиллагаан дахь цахим нотлох баримтыг бий болгох, хадгалах журам”[50] болон “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим нотлох баримт цуглуулах үүрэг бүхий байгууллагыг үүсгэн байгуулах, түүний хууль ёсны төлөөлөгчдийг томилох зохицуулалтыг ижилтгэх удирдамж”[51]-ийн гол зорилго нь цахим нотлох баримтын тогтворгүй шинж чанар, хадгалагдсан өгөгдлийн (дата) “байршлын алдагдлаас” үүссэн асуудлуудыг тусгайлан шийдвэрлэхийн тулд одоо байгаа олон улсын хамтын ажиллагаа, эрх зүйн харилцан туслалцааны хэрэгслүүдээс илүү хурдан, илүү үр дүнтэй механизмыг бий болгох явдал юм. Уг журамд гишүүн улсын эрх бүхий байгууллага эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Европын нотлох баримт бий болгох захиалга эсвэл хадгалалтын захиалга гаргаж, үүгээрээ Холбооны нутаг дэвсгэрт үйлчилгээ үзүүлж буй болон өөр гишүүн улсад байгуулагдсан үйлчилгээ үзүүлэгчээс (шууд), эсхүл ийм байгууллага байгуулаагүй бол өөр гишүүн улсын хууль ёсны төлөөлөгчөөр төлөөлүүлэн мэдээллийн байршлаас үл хамааран цахим нотлох баримтыг захиалж авах, бүрдүүлж болох юм.

Цахим нотлох баримтыг олж авах буюу түүнд хандах эрхийг олж авах эрх бүхий байгууллагын хувьд төвөгтэй, урт удаан процесс бөгөөд учир нь уг цахим өгөгдөл, түүнд хандах эрх нь ихэвчлэн өөр улсад байдаг. Онлайн үйлчилгээ үзүүлэгчид Европын холбооны доторх болон гаднах хэд хэдэн улс оронд байрлах серверүүд дээр хэрэглэгчдийн мэдээллийг хадгалдаг бөгөөд энэ нь цахим нотлох баримт, түүнд хандах эрхийг шүүх олж авах ажлыг илүү удаа төвөгтэй болгодог. Европын холбооны гишүүн орнууд даяар явагдаж буй нийт ЭХХША-ны 50 хувь гадаад дахь цахим нотлох баримтын авах, түүнд хандах зөвшөөрлийг хүссэн хүсэлт гадаад орнуудад гаргасан байдаг.

50 Regulation (EU) 2023/1543 of the European Parliament and of the Council of 12 July 2023 on European Production Orders and European Preservation Orders for electronic evidence in criminal proceedings and for the execution of custodial sentences following criminal proceedings, https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=uriserv%3AOJ.L_.2023.191.01.0118.01.ENG

51 Directive (EU) 2023/1544 of the European Parliament and of the Council of 12 July 2023 laying down harmonised rules on the designation of designated establishments and the appointment of legal representatives for the purpose of gathering electronic evidence in criminal proceedings, https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=uriserv%3AOJ.L_.2023.191.01.0181.01.ENG

Дээрх шалтгаануудыг үндэслэн 2018 оны 4-р сард Европын Зөвлөл болон Зөвлөлийн уриалгын дагуу Европын Комисс эрх баригчдад мэдээллийн байршлаас үл хамааран цахим нотлох баримтад хандахад хялбар, хурдан болгох шинэ зохицуулалтыг бий болгохыг санал болгосон байна. Ийнхүү ЕХ-ны хувьд таван жил үргэлжилсэн хэлэлцээний эцэст Европын Зөвлөл болон Европын парламент (ЕП) Европын холбооны эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим нотлох баримт цуглуулах шинэ тогтолцоог нэвтрүүлэх хууль тогтоомжийн актууд болох дээрх зохицуулалтыг баталжээ.[52]

“Европын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараах хорих ял эдлүүлэх ажиллагаан дахь цахим нотлох баримтыг бий болгох, хадгалах журам”[53]-ын 3 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт “цахим нотлох баримт”-ыг Европын нотлох баримтын захиалгын гэрчилгээ (EPOC) эсвэл Европын хадгалалтын захиалгын гэрчилгээг хүлээн авах үед үйлчилгээ үзүүлэгчээс эсвэл түүний өмнөөс цахим хэлбэрээр хадгалсан захиалагчийн өгөгдөл, шилжүүлгийн өгөгдөл эсвэл контентын өгөгдөл байхаар томьёологджээ. Мөн үүнтэй холбогдуулан дараах харилцааг зохицуулжээ.

I БҮЛЭГ. ЗОХИЦУУЛАХ АСУУДАЛ, ХАМРАХ ХҮРЭЭ БА НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

1-р зүйл. Зохицуулах асуудал

2-р зүйл. Хамрах хүрээ

3-р зүйл. Нэр томьёоны тодорхойлолт

II БҮЛЭГ. ЕВРОПЫН ЦАХИМ НОТЛОХ БАРИМТ БИЙ БОЛГОХ БОЛОН ХАДГАЛАХ ЗАХИАЛГА, ГЭРЧИЛГЭЭ

4-р зүйл. Эрх бүхий байгууллага

5-р зүйл. Цахим нотлох баримт бий болгох захиалга хийх нөхцөл /журам/

6-р зүйл. Цахим нотлох баримт хадгалах захиалга хийх нөхцөл /журам/

7-р зүйл. Европын цахим нотлох баримт бий болгох, хадгалах захиалга гаргах хаяг

8-р зүйл. Хууль сахиулах байгууллагад мэдэгдэх

9-р зүйл. Европын цахим нотлох баримт бий болгох, хадгалах захиалгын гэрчилгээ

10-р зүйл. Цахим нотлох баримт бий болгох захиалгыг гүйцэтгэх

11-р зүйл.

12-р зүйл. Европын цахим нотлох баримт бий болгох захиалгаас татгалзах үндэслэл

13-р зүйл. Хэрэглэгчийн мэдээлэл ба нууцлал

14-р зүйл. Зардлын нөхөн төлбөр

III БҮЛЭГ. ТОРГУУЛЬ БА АЛБАДАН ГҮЙЦЭТГЭЛ

15-р зүйл. Торгууль

16-р зүйл. Албадан гүйцэтгүүлэх процесс

52 E-evidence - cross-border access to electronic evidence Improving cross-border access to electronic evidence, https://commission.europa.eu/law/cross-border-cases/judicial-cooperation/types-judicial-cooperation/e-evidence-cross-border-access-electronic-evidence_en

53 Regulation (EU) 2023/1543 of the European Parliament and of the Council of 12 July 2023 on European Production Orders and European Preservation Orders for electronic evidence in criminal proceedings and for the execution of custodial sentences following criminal proceedings, https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=uriserv%3AOJ.L_.2023.191.01.0118.01.ENG

IV БҮЛЭГ. ЗӨРЧИЛДӨӨНИЙ ХЭМ ХЭМЖЭЭ БА АРГА ХЭМЖЭЭ

17-р зүйл. Зөрчилдөөнтэй үүрэг үүссэн тохиолдолд хянан шалгах процесс

18-р зүйл. Үр дүн бүхий арга хэмжээ

V БҮЛЭГ. ТӨВЛӨРЛИЙГ САРУУЛАХ ТОГТОЛЦОО

19-р зүйл. Эрх бүхий байгууллага, үйлчилгээ үзүүлэгч болон эрх бүхий байгууллагуудын хооронд дижитал харилцаа холбоо, мэдээлэл солилцох аюулгүй байдлыг хангах

20-р зүйл. Цахим баримт бичгийн эрх зүйн үр нөлөө

21-р зүйл. Цахим гарын үсэг ба тамга

22-р зүйл. Лавлагаа хэрэгжүүлэх программ хангамж

23-р зүйл. Төвлөрлийг бууруулах IT системийн зардал

24-р зүйл. Шилжилтийн үе

25-р зүйл. Актыг хэрэгжүүлэх

2. Кибер гэмт хэргийн тухай Будапештын конвенц нь интернэт болон бусад компьютерын сүлжээгээр үйлдэгдсэн гэмт хэргийн тухай, ялангуяа зохиогчийн эрхийг зөрчих, компьютертой холбоотой луйвар, хүүхдийн садар самууныг сурталчлах, сүлжээний аюулгүй байдлыг зөрчих зэрэг гэмт хэргийн тухай олон улсын анхны гэрээ юм. Энэ нь мөн компьютерын сүлжээг хайх, саатуулах зэрэг хэд хэдэн зохицуулалт, процедурыг агуулдаг. Оршил хэсэгт тусгагдсан гол зорилго нь нийгмийг цахим гэмт хэргээс хамгаалах, ялангуяа зохих хууль тогтоомжийг баталж, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн эрүүгийн нийтлэг бодлогыг хэрэгжүүлэх явдал юм[54]. Тус конвенцын 14, 35 дугаар зүйлд оролцогч тал бүр эрүүгийн гэмт хэргийн нотлох баримтыг цахим хэлбэрээр цуглуулахыг үүрэг болгосон ба 23, 25 дугаар зүйлд зааснаар цахим нотлох баримтын талаар өргөн хүрээнд хамтран ажиллана. Мөн түүнчлэн 46 дугаар зүйлд нотлох баримтыг цахим хэлбэрээр цуглуулах чиглэлээр талууд хамтарч ажиллахаар тусгажээ[55].

3. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцын 20, 29 дүгээр зүйлд үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд цахим тандалт, мөрдөх ажиллагааг хэрэгжүүлж орчин үеийн арга барил хэрэглэхийг талуудад үүрэг болгожээ[56].

4. Истанбулын протокол (Эрүүдэн шүүх болон бусад хэрцгий, хүнлэг бус буюу нэр төрийг гутаан харьцах, шийтгэхийг үр дүнтэй мөрдөн шалгах, баримтжуулах гарын авлага)-ын 232 дугаар зүйлд дараах зохицуулалтыг мөн тусгажээ.

- Мөрдөгч цахим төхөөрөмж дээр хадгалагдаж, хүлээн авсан эсвэл дамжуулсан аливаа нотлох мэдээллийг баталгаажуулахыг эрэлхийлэх ёстой. Ялангуяа компьютер, гар утас зэрэг электрон төхөөрөмжүүдийг хураан авах, нээлттэй эх сурвалжийн мэдээллийг интернэтээр үзэх замаар цахим нотлох баримтыг олж авч болно. Хэрэв хураан авсан цахим хэрэгслээс дижитал нотлох баримтыг олж авбал эдгээр төхөөрөмжийг эд мөрийн баримт болгон хадгалах шаардлагатай бөгөөд мэдээллийг гаргаж авсан дижитал шинжээч шүүхэд ашиглах боломжтой тайлан эсвэл нотлох баримтыг бэлтгэх ёстой. Дижитал нотолгоонд дараах зүйлс

54 Details of Treaty No.185, https://www.coe.int/en/web/conventions/full-list?module=treaty-detail&treatynum=185

55 Convention on Cybercrime Budapest, 23.XI.2001, https://rm.coe.int/1680081561

56 United Nations Convention against Transnational Organized Crime and the Protocols Thereto, https://www.unodc.org/unodc/en/organized-crime/intro/UNTOC.html

орно: (а) эрүүл мэндийн цахим бүртгэл; (б) хаалттай камераар бичигдсэн видео; (в) дижитал камер, ухаалаг утас зэрэг хөдөлгөөнт хэрэгслээр авсан зөрчил, бие махбодод гэмтэл учруулсан газар гэх мэтийг агуулсан зураг, видео; (г) олон нийтийн мэдээллийн хэрэгслээр байршуулсан зураг, видео болон бусад мэдээлэл; (д) санах ойн карт, USB хөтөч, CD-ROM гэх мэт компьютерын хатуу диск болон бусад дагалдах төхөөрөмжид хадгалагдсан мэдээлэл; (е) мэйл, текст болон шуурхай мессеж; (ж) агаарын болон сансрын хиймэл дагуулаас авсан зураг, тухайлбал, нууц саатуулах төв эсвэл зөрчлийн бусад газар; (ж) гар утас эсвэл олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд хадгалагдсан байршлын мэдээлэл; ба (і) мета өгөгдөл, өөрөөр хэлбэл файлын талаарх мэдээлэл (жишээ нь дижитал гэрэл зураг авсан цаг хугацаа, байршил гэх мэт). Дижитал нотлох баримтын жинхэнэ байдал нь түүнийг нотлох баримт болгон ашиглахад чухал ач холбогдолтой юм. Тиймээс түүний жинхэнэ эсэхийг дижитал шүүх эмнэлгийн хүлээн зөвшөөрөгдсөн арга техникийг ашиглан шалгах хэрэгтэй[57].

5. Хувийн мэдээллийг автоматаар боловсруулахтай холбоотой хувь хүнийг хамгаалах тухай Европын зөвлөлийн конвенцын зорилго нь оролцогч улс бүрийн нутаг дэвсгэрийн харьяалал, оршин суугаа газраас үл хамааран хүний хувийн халдашгүй байх эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх (“өгөгдлийн хамгаалалт”), ялангуяа хувийн нууцыг хамгаалах эрхийг хангахад оршино. Тус конвенцын 5 дугаар зүйлийн е хэсэгт агуулгыг таних боломжтой хэлбэрээр хадгалагдсан өгөгдлийг тухайн өгөгдлийг хадгалах зорилгод шаардагдах хугацаанаас илүүгээр хадгалж болохгүй талаар мөн зохицуулжээ[58].

3.2.3.2. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын сайн туршлага

Цахим нотлох баримт гэдэг нь тодорхой эрүүгийн мөрдөн байцаалтад хамаарах тоон (дижитал) хэлбэрээр хадгалагдсан эсвэл дамжуулсан бүх мэдээллийг хэлэх бөгөөд цахим нотлох баримтыг дижитал өгөгдөл хаана хадгалагдаж байгаа зөөвөрлөгчийг хайх, хураах, үйлчилгээ үзүүлэгчийн оролцоотойгоор дижитал өгөгдөл (захиалагчийн мэдээлэл, хөдөлгөөний мэдээлэл, агуулгын өгөгдөл) цуглуулах замаар олж авдаг.[59]

ХБНГУ-ын хувьд эрүүгийн процессын эрх зүй буюу ЭХХШтХ-даа цахим нотлох баримтыг тусгайлан тодорхойлж, зохицуулаагүй байна. Харин нотлох баримтын хувьд дараах нотлох баримтуудыг ЭХХША-нд хатуу (Strengbeweis) нотлох баримтаар тооцон үнэлнэ гэж заасан байдаг. Эдгээрт

- Шинжээчийн дүгнэлт (§§ ЭХХШтХ-ийн 72);
- Шүүхийн хяналт, шалгалт хийсэн баримт бичиг (§ ЭХХШтХ-ийн 86);
- Баримтат нотлох баримт (§ ЭХХШтХ-ийн 249);
- Гэрч (§§ ЭХХШтХ-ийн 48) зэрэг нотлох баримтын төрлүүд тус тус багтана.

57 Manual on the Effective Investigation and Documentation of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment, https://www.ohchr.org/sites/default/files/documents/pub lications/2022-06-29/Istanbul-Protocol_Rev2_EN.pdf

58 Convention for the Protection of Individuals with regard to Automatic Processing of Personal Data Strasbourg, 28.I.1981, https://rm.coe.int/1680078b37

59 European Judicial Network, Fiches Belges on electronic evidence Germany. Available at.https://www.ejn-crimjust.europa.eu/ejnupload/DynamicPages/FB-EEGermany.pdf

Эдгээрээс "Унших замаар нотлох баримтыг баримтжуулах; хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед уншиж танилцуулсан нотлох баримт" гэсэн ЭХХШтХ-ийн 249-р зүйлийн (1)-т *"...Цахим баримт бичгийг уншиж танилцах боломжтой бол баримт бичиг гэж үзнэ*."[60] гэж заасан байна.

Дээрхээс үзэхэд ХБНГУ-ын ЭХХШтХ-д цахим нотлох баримтыг тусгайлан тодорхойлж зохицуулаагүй ч ЭХХША-нд цахим нотлох баримтыг ашиглах, үнэлэхийг хориглосон аливаа хязгаарлалт байхгүй буюу хуульд заасан шаардлагыг хангасан тохиолдолд ЭХХША-нд ашиглах боломжтой байна. Өөрөөр хэлбэл Герман улсын ЭХХША-ны нотлох баримтад хэлбэрийн шаардлага тавьдаггүй буюу цахим нотлох баримтыг хэлбэрийн хувьд тусгайлан авч үзэх, эсхүл хязгаарласан хязгаарлалт байхгүй.

ХБНГУ-ын нэгдэн орсон цахим нотлох баримт, түүнийг цуглуулах, олж авах асуудалд хамаарах олон улсын хууль тогтоомж, гэрээ, конвенц.

- "Цахим (Кибер) гэмт хэргийн тухай" 2001 оны Будапештын конвенц;
- Эрүүгийн хэргийн мөрдөн шалгах ажиллагааны Европын журам (EU 2014);
- Европын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараах хорих ял эдлүүлэх ажиллагааны цахим нотлох баримтыг бий болгох, хадгалах журам (EU) 2023/1543;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим нотлох баримт цуглуулах үүрэг бүхий байгууллагыг үүсгэн байгуулах, түүний хууль ёсны төлөөлөгчдийг томилох зохицуулалтыг ижилтгэх удирдамж (EU) 2023/1544.

Цахим нотлох баримтыг ЭХХША-нд үнэнийг тогтоох зорилгоор Үндсэн хуулийн шаардлагыг хүрээнд ашиглах нь (ХБНГУ-ын практик туршлага)

Дээр дурдсанчлан ХБНГУ-д цахим нотлох баримтыг ЭХХША-нд үнэнийг тогтоох зорилгоор ашиглах боломжтой боловч ийнхүү ашиглахдаа хуульд заасан аливаа хязгаарлалтын хүрээнд буюу хуулийн шаардлагад нийцүүлэн ашиглах шаардлагатай юм. Ийнхүү нотлох баримтыг ЭХХША-нд үндсэн хуулийн шаардлагад нийцүүлэн ашиглах техник буюу ХБНГУ-ын практик туршлагыг энд танилцуулъя.[61]

Цахим нотлох баримтыг ЭХХША-нд Германы шүүхүүд цуглуулах, олж авах, үнэлэхдээ дараах шинжилгээний үндсэн бүтцийг (үе шатыг) ашигладаг. Үүнд:

- Үндсэн эрхийн нөхцөл байдал;
- Нотлох баримт бүрдүүлэх;
- Үнэлэх;
- Шүүх хуралдаанд оруулан танилцуулах.

60 Мөн тэнд.

61 Уг ХБНГУ-ын практикийг ХБНГУ-ын Бавари мужийн Цахим хувьслын судалгааны хүрээлэнгийн захирал, тус мужийн Хиймэл оюун ухааны зөвлөлийн гишүүн, Вюрцбург хотын Юлиус-Максимилианс Их Сургуулийн доктор, профессор Эрик Хилгендорфын Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн Ханнс-Зайделийн сантай хамтран "Цахим нотлох баримт" уулзалт, хэлэлцүүлгийн үеэр хийсэн танилцуулгаас авсан болно.
Эрик Хилгендорф, "Цахим нотлох баримт танилцуулга" сургалтын орчуулга, 2023.09.15.

Үндсэн эрхийн анхдагч нөхцөл (түүний хязгаарлаж болох нөхцөлүүд):

- /Зайнаас харилцахад/ харилцаа холбооны нууц, Германы Үндсэн Хуулийн 10 /GG/ Зөвхөн дамжуулах явцад хамаарах бөгөөд үндсэн эрхийг хязгаарлаж болно.
- Хүний нэр төр /хүн байх үнэ цэнэ, хүний эрхэмсэг оршихуй/ Германы Үндсэн Хуулийн 1 /GG/

  Хувь хүний мөн чанарын үндсэн цөм хэсгийг хамгаалалтдаа авсан, хязгаарлах боломжгүй.
- Хувийн мэдээллийг хэрхэхээ өөрөө тодорхойлох эрх, Германы Үндсэн Хуулийн 2-р зүйлийн 1 дэх хэсэг +1-р зүйлийн 1 дэх хэсэг

  хувийн мэдээллээ хамгаалах; хязгаарлах боломжтой.
- Мэдээллийн технологийн систем дэх халдашгүй байх эрх, Германы Үндсэн Хуулийн 2-р зүйлийн 1 дэх хэсэг .+1-р зүйлийн 1 дэх хэсэг

  Компьютер зэрэгт зөвшөөрөлгүй нэвтрэхээс хамгаалах, хязгаарлаж болно.

Хуулиар зохицуулсан мэдээлэл цуглуулах боломжтой тусгай тохиолдлууд (нотлох баримт цуглуулах):

- Утасны яриаг хянах, бичиж авах, Германы ЭХХШтХ-ийн /StPO/ §100a
- Кодыг тайлан и-мэйлийг нууцаар үзэх ажиллагаа , Германы ЭХХШтХ-ийн /StPO/ §100a
- Цахим холбоо харилцааны холболтын өгөгдөлд нэвтрэх, Германы ЭХХШтХ-ийн /StPO/ §100g
- Гар утасны мэдээллийг байршлыг тодорхойлох, Германы ЭХХШтХ-ийн / StPO/ §100i
- Хяналтын программд нууцаар нэвтрэх, Германы ЭХХШтХ-ийн /StPO/ §100б

Хуулийн шаардлага:

- Тодорхой заасан хүнд гэмт хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд ашиглах
- Шүүгчийн захирамж гарсан байх.

Уламжлалт хандалтын аргууд:

- Эд юмсыг хураах, нэгжлэг хийх (Германы ЭХХШтХ-ийн /StPO/ §§ 94, 102): компьютер, гар утас зэрэгт мөн хэрэглэнэ.
- Хууль сахиулах байгууллагын хүсэлтийн дагуу цахим /сүлжээний/ үйлчилгээ эрхлэгч эсвэл үүлэн операторуудаас сэжигтний мэдээллийг авах, Германы ЭХХШтХ-ийн /StPO/ §103

Хуулийн шаардлага:

- Эдгээр ажиллагаа нь далд бус, ил хэлбэрээр явагддаг учраас хөнгөн шаардлага тавигддаг.

Хувийн нууцыг хамгаалах

- Харилцаа холбооны хэрэгслийг хянах ажиглах болон хадгалагдсан өгөгдлийг нууцаар хайхад хүний хувийн амьдралын хүрээний үндсэн цөм хэсэгт хамаарах мэдээлэл/өгөгдлийг ашиглаж үл болно.
  - Өдрийн тэмдэглэлийн хэсэг
  - Эрүүгийн хуульд хамааралгүй сэдвээр эхнэр, нөхөртэйгөө ярилцах
  - Ажиглалтад буй этгээд нь эмч, хуульч гэх мэт тодорхой мэргэжлийн бүлгийн гишүүдтэй харилцсан яриа
- Өөрөө өөрийгөө буруутгах нөхцөл байдлыг дэлгэхгүй байх эрх (“nemo tenetor se ipsum accusare») нь гар утасны өгөгдлийг нотлох баримтаар үнэлэх үед хамгаалагдаж байна уу? Гар утас нь хэрэглэгчийн өөрийн «хадгалагдсан санах ой» юм.

Нотлох баримтыг үнэлэх:

- Үндсэн асуудал: цуглуулсан мэдээллийн жин хэт их
- Дагах асуудлууд:
  - Хэн үнэлэх вэ?
  - Тусгай албаныхан уу?
  - тэдгээрийн хэлтэс үү? Хууль ёсны зарчмын улмаас үүсэх ачаалал, Германы ЭХХШтХ-ийн /StPO/ §160.1, 163.
- Хэрхэн үнэлэх вэ?
  - тус бүрнээ шалгалт хийх, дээж авах, автомат хянах ажиллагаа, KI
- Мэдээллийг хэнд нээлттэй байлгах вэ?
  - Шүүх
  - Хууль зүйн туслалцаа үзүүлэгч: ямар хэлбэрээр? процесст оролцох “зэвсэг” тэгш байх тухай асуудал
- Мэдээллийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрхэн оруулж ирэх вэ?

Тусгай асуудал I: Өгөгдлийн шинжилгээнд хиймэл оюун ухааныг ашиглах

- Жишээ нь хүүхдийн садар самууныг сурталчлах болон бусад сэтгэлзүйн хувьд дарамттай мэдээллүүд
- Одоогоор Германы ЭХХШтХ-ийн /StPO/-д зохицуулалт байхгүй

Тусгай асуудал II: Батлан хамгаалах эрх

- Германы ЭХХШтХ-ийн /StPO/ §147.1: Өмгөөлөгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн материалтай танилцах, «албан журмаар хадгалагдаж буй нотлох баримттай танилцах» эрхтэй.
- Хэргийн материалтай танилцах эрхийн хүрээнд Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр -BVerfGE 63, 65-с.
- Хууль зүйн туслалцаа үзүүлэгчийн чадлаас хир давсан ойлголт вэ?
- Өмгөөлөгч хиймэл оюун ухаантай байх, түүнд олгох ёстой юу?

- Хиймэл оюун ухаан үйлдвэрлэгчдийн бизнесийн нууц яах вэ?
- Холбооны Үндсэн хуулийн шүүхийн /BVerfG/-ийн 2020 оны 11-р сарын 12-ны өдрийн шийдвэр, AZ 2 BvR 1616/18, NZV 2021, 41: Яллагдагч нь замын хөдөлгөөнд хурдны хязгаарыг хэтрүүлж байгааг нотлох зорилготой хяналтын камер ашиглах нөхцөлд түүнд камер хэрхэн ажилладаг талаар шаардлагатай бүх мэдээллийг өгөх ёстой.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зүйл болгох (Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зүйл болгох):

- Нотлох баримтын уламжлалт хэлбэрүүд: үзлэг, гэрч, баримт бичиг, шинжээч
- Эдгээр нотлох баримтын хэлбэрүүд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нээлтэй байдал, ил тод байдал, түүнийг хянах боломжийг баталгаажуулах зорилготой
- Цахим нотлох баримтыг уламжлалт нотлох баримтын адилаар шалгах:
- Хэвлэх
- Графикт оруулах
- Шинжээчдийн дүгнэлт •
- Хиймэл оюун ухаанаар үүсгэсэн өгөгдөлтэй ажиллах? Ийм мэдээллийг шалгах боломжтой юу?

3.2.3.3. Бүгд Найрамдах Эстони Улсын сайн туршлага

Эстони улсын ЭХХША-нд цахим (дижитал) нотлох баримт улам бүр нэмэгдэж байгаа боловч одоогийн хууль тогтоомжид ийм нотлох баримтыг олж авах, цуглуулах асуудлыг тодорхой журамлаагүй тул уламжлалт нотлох баримтыг цуглуулах, мөрдөн шалгах тухай заалтууд нь цахим нотлох баримтын үндэс зохицуулалт хэвээр байна.[62] Цахим нотлох баримт гэдгийг цахим хэлбэрээр (компьютерын өгөгдөл) байгаа нотлох ач холбогдолтой мэдээлэл гэж үзнэ.[63]

Эстони улсын ЭХХШтХ-ийн Нотолгоо гэсэн 3-р бүлэгт ЭХХША-ний нотлох баримтын зохицуулалтыг тусгасан байдаг бөгөөд “Нотлох баримт” гэсэн 63 -р зүйлд “Нотлох баримт гэж сэжигтэн, яллагдагч, хохирогчийн мэдүүлэг, гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, шинжээчийн дүгнэлтийн талаар тайлбар гаргасны дагуу шинжээчийн өгсөн мэдүүлэг, эд мөрийн баримт, мөрдөн байцаалтын ажиллагааны тайлан, шүүх хуралдааны тэмдэглэл, тайлан, тандалтын үйл ажиллагаа, бусад баримт бичиг, гэрэл зураг, кино эсвэл бусад мэдээллийн бичлэг.”[64] Гэж тодорхойлсон байна. Ерөнхийдөө, уг 63 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан нотлох баримтын төрлийг (хатуу нотлох баримт гэж нэрлэдэг) нотлох үндэслэлээр ЭХХША-нд ашиглаж болно.

Мөн уг 63 дугаар зүйлийн (1) дэх хэсэгт ороогүй нотлох баримтыг хэргийн үндсэн үйл баримтыг тогтоох зорилгоор бус ЭХХША-тай холбоотой баримтуудыг нотлох зорилгоор ашиглаж болно. 62 дугаар зүйлд заасан нотлох баримтаар ашиглах үндэслэлд дараах үндэслэлүүд хамаарна.

62 Eneli Lauritis, “Criminal procedure and digital evidence in Estonia”, Digital Evidence and Electronic Signature Law Review, 13 (2016), P.113

63 European Judicial Network, Fiches Belges on electronic evidence Estonia. Available at https://www.ejn-crimjust.europa.eu/ejnupload/DynamicPages/EE%20electronic%20evidence%20fb.pdf

64 БНЭсУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Kriminaalmenetluse seadustik, 2003)

1. гэмт хэрэг үйлдсэн цаг хугацаа, газар, арга хэлбэр, гэмт хэрэгтэй холбоотой бусад баримт;
2. Гэмт хэргийн зайлшгүй бүрэлдэхүүн хэсэг (элемент);
3. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм буруутай эсэх;
4. гэмт хэрэг үйлдсэн этгээд болон тухайн этгээдийн хариуцлагад нөлөөлж буй бусад нөхцөл байдлын талаарх мэдээлэл.

Энэхүү нотлох баримтын систем нь хүлээн зөвшөөрөгдөх янз бүрийн нотлох баримтууд болон нотлох баримтын янз бүрийн эх сурвалжуудын хооронд тодорхой ялгааг харуулж байгааг Эстонийн Дээд шүүх тогтоосон[65].

Эстонийн хууль тогтоох байгууллага ЭХХША-ны явцад нотлох баримтын зөвшөөрөгдөх хэлбэрийг тодорхойлсон. Дээрх заалт (63(1)) нь Эстонийн ЭХХШТХ-ийн нотлох баримтын төрлийг тодорхойлсон цорын ганц заалт юм. Нотолгооны зүйл болон нотлох баримтаар авах ерөнхий нөхцөлд тусад нь тодорхойлолт эсхүл тусгай журам тогтоогоогүй болно. Үүнтэй холбоотой дараах заалтууд ЭХХШтХ-д байдаг. Үүнд:

64-р зүйл. ЭХХША-нд нотлох бариматаар тогтоох (хэрэгт авах) ерөнхий нөхцөл[66]

(1) Нотлох бариматыг авахад оролцсон хүмүүсийн нэр төр, алдар хүндэд харшлахгүй, амь нас, эрүүл мэндэд нь аюул учруулахгүй, үндэслэлгүй эд хөрөнгийн хохирол учруулахгүй байхаар нотлох бариматыг авна. Хүнийг эрүүдэн шүүх, түүний эсрэг бусад хэлбэрээр хүчирхийлэх, ой санамжид нь нөлөөлөх, хүний нэр төрийг гутаан доромжлох зэргээр нотлох бариматыг авч болохгүй.

(2) Эрэн сурвалжлах, биет үзлэг хийх, харьцуулсан дээж авах явцад хүний хувцсыг тайлах шаардлагатай бол эрүүл мэндийн мэргэжилтэн, шүүх эмнэлгийн эмчээс бусад мөрдөн байцаах байгууллагын албан тушаалтан, прокурор, процесс ажиллагаанд оролцогчид тухайн хүнтэй ижил хүйсийн хүн байна.

(3) Нотлох баримт авах явцад техникийн хэрэгсэл ашигласан бол энэ тухай ЭХХША-нд оролцогчдод урьдчилан мэдэгдэж, техникийн хэрэгслийг ашиглах зорилгыг тайлбарлана.

(4) [Хүчингүй болсон - 2011.02.23-ны өдрийн 1 дүгээр тогтоол, 2011.09.01-ний өдөр хүчин төгөлдөр болсон.]

(5) Шаардлагатай бол энэ хуулийн § 214-д заасны дагуу шүүхийн өмнөх ажиллагаатай холбоотой мэдээллийг задруулахыг хориглохыг процессын ажиллагаанд оролцогчдод анхааруулна.

(6) Нууцаар ажиглах ажиглалтын үйл ажиллагаагаар нотлох баримт авах асуудлыг энэ хуулийн 31 дүгээр бүлгээр зохицуулна.

Эндээс үзэхэд Эстонийн ЭХХШтХ-д заасан нотлох баримтын төрлийг ерөнхийд нь тодорхойлсон тул энэхүү заалтыг үндэслэн цахим хэлбэрийн нотлох баримтыг

65 Eneli Lauritis, “Criminal procedure and digital evidence in Estonia”, Digital Evidence and Electronic Signature Law Review, 13 (2016), P.113

66 БНЭсУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Kriminaalmenetluse seadustik, 2003)

ЭХХША-нд ашиглах боломжтой гэсэн үг юм.[67] Үүний зэрэгцээ, Эстонийн хууль эрх зүйн орчинд цахим (дижитал) нотлох баримтын талаар тусгай журам, тодорхой заалтууд зайлшгүй шаардлагатай байгаа тухай хэлэлцүүлэг хэсэг хугацаанд явагдсан байна. Жишээлбэл, Эстонийн Хууль зүйн асуудал хариуцсан канцлер цахим харилцааны өргөн хэрэглээ, цахим мэдээллийн хэрэгсэлд агуулагдаж буй мэдээллийг задруулснаас үүдэлтэй үндсэн эрхийн зөрчлийн цар хүрээг харгалзан үзэж, уг зөрчигдөж буй үндсэн эрх, эрх чөлөөг илүү сайн хамгаалах чадвартай илүү нарийн зохицуулалт (шаардлагатай процедурын хамгаалалтыг дагалдсан) хийхийг санал болгож байв.[68] Эстонийн Хуульчдын холбооны зүгээс мөн нэгжлэг хийх явцад хураан авсан цахим мэдээлэл нь олон эрүүгийн хэрэгт нотлох баримт болж, ийм нотлох баримтын ач холбогдол улам бүр нэмэгдсээр байгааг олж тогтоосон бөгөөд Хуульчдын холбооноос цахим (дижитал) нотлох баримтыг олж авах, түүнийг ЭХХША-нд ашиглах асуудлыг уламжлалт нотлох баримтаас тусад нь зохицуулах нь зүйтэй гэж үзсэн байна. Учир нь уламжлалт нотлох баримттай холбоотой заалтуудыг цахим (дижитал) нотлох баримт дээр ашиглах нь ЭХХША-н дахь хүний эрх, түүнчлэн ийм нотлох баримтыг хүлээн зөвшөөрөх, найдвартай байдал, баталгаажуулалт зэрэгтэй бүрэн нийцэхгүй юм[69] гэж үсэн байна.

Эстонид Цахим (дижитал) нотлох баримтыг ЭХХШтХ дээр үндэслэн мөрдөн шалгах ажиллагааны процесс эсвэл нууцаар явуулсан сэжигтнийг ажиглах процесс ажиллагааны тусламжтайгаар олж авдаг ч цахим нотлох баримтыг уламжлалт нотлох баримтыг олж, цуглуулах процедурын дарааллын дагуу олж авч, цуглуулж, хэрэгт авдаг[70] хэвээр байна.

БНЭсУ-ын нэгдэн орсон цахим нотлох баримт, түүнийг цуглуулах, олж авах асуудалд хамаарах олон улсын хууль тогтоомж, гэрээ, конвенц.

- “Цахим (Кибер) гэмт хэргийн тухай” 2001 оны Будапештын конвенц;
- Эрүүгийн хэргийн мөрдөн шалгах ажиллагааны Европын журам (EU 2014);
- Европын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараах хорих ял эдлүүлэх ажиллагааны цахим нотлох баримтыг бий болгох, хадгалах журам (EU) 2023/1543;

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим нотлох баримт цуглуулах үүрэг бүхий байгууллагыг үүсгэн байгуулах, түүний хууль ёсны төлөөлөгчдийг томилох зохицуулалтыг ижилтгэх удирдамж (EU) 2023/1544 .

3.2.3.4. Америкийн Нэгдсэн Улсын сайн туршлага

Цахим нотлох баримт нь бусад нотлох баримтуудтай үзэл баримтлалын хувьд ижил байдаг—энэ нь гэмт хэргийн учир шалтгааны холбоог тогтоохын тулд хүмүүс, үйл явдлыг цаг хугацаа, орон зайд байрлуулахыг оролдсон мэдээлэл юм. Гэсэн хэдий ч цахим нотлох баримт нь биет нотлох баримттай харьцуулахад илүү өргөн цар хүрээтэй, илүү хувийн хүрээнд эмзэг, уян хатан, хөдөлгөөнт шинж чанартай, өөр бэлтгэл, багаж хэрэгсэл шаарддаг.

67 Эстонийн Дээд шүүх гар утасны зурвас болон цахим шуудангийн захидал харилцааны аль алиныг нь нотлох баримт болгон хүлээн зөвшөөрдөг боловч хувийн ярианы бичлэгийг ЭХХШтХ-ийн 63 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан мэдээллийн бичлэг гэж үнэлдэг.

68 Eneli Lauritis, “Criminal procedure and digital evidence in Estonia”, Digital Evidence and Electronic Signature Law Review, 13 (2016)

69 Мөн тэнд.

70 Мөн тэнд.

Цахим нотлох баримт нь “цахим төхөөрөмж дээр хадгалагдаж, хүлээн авсан эсвэл дамжуулсан мөрдөн байцаалтын явцад үнэ цэнтэй мэдээлэл, өгөгдөл юм” (National Institute of Justice [NIJ], 2008) . Ийм нотлох баримтууд үндсэн компьютер, телефон утасны систем гэх мэт хязгаарлагдмал хэлбэрээр олон арван жилийн турш оршин тогтнож байсан ч хувийн электрон төхөөрөмжүүд хурдацтай тархах тусам цахим нотлох баримтыг боловсруулахын ач холбогдол нэмэгдсээр байна. 21-р зууныг зөөврийн хөгжим тоглуулагч, гар утас, компьютерын төхөөрөмжүүдийн дэвшил тодорхойлсон. АНУ-ын Дээд шүүх саяхан гар утас нь ганц харилцаа холбооны хэрэгсэл биш, харин утас, календарь, өдрийн тэмдэглэл, цахим шуудангийн системийн үүрэг гүйцэтгэдэг микрокомпьютер юм гэж тайлбарласан; цахим нотлох баримт нь уламжлалт биет бүртгэл, нотлох баримтаас хэрхэн ялгаатай болохыг ойлгоход орчин үеийн технологи гурван шинж чанарыг бий болгодог: (1) Цахим нотлох баримт нь илүү өргөн хүрээг хамардаг, (2) биет болон хувийн нууц мэдээллийг хоёуланд нь авч үздэг, (3) хууль сахиулах байгууллагын нотлох баримт цуглуулах ердийн чиг үүргээс гадна эрүүгийн эрх зүйн харилцан уялдаатай асуудлуудыг хамардаг.

Цахим нотлох баримтын төрлүүд

Интернэт

Хууль сахиулах байгууллагын мөрдөн байцаалтад ашигладаг зарим дижитал нотлох баримтууд нь харилцаа холбооны веб сайтууд, ялангуяа мессежний самбар, чат өрөөнүүдээс гаралтай. Эдгээр төрлийн сайтууд нь одоогийн мөрдөн байцаалтын мэдээллийн эх сурвалж байсаар байгаа ч бусад интернэт болон интернэтэд холбогдсон технологиуд тархаж байгаа нь нотлох баримтын олон эх сурвалжийн тоонд багтаж байна гэсэн үг. Мессежний самбар болон чат өрөөнүүд нь хэрэглэгчдэд архив эсвэл тухайн цаг үеийн харилцаа холбоог уншиж, хариулах боломжийг олгодог. Эдгээр эх сурвалжийг ашиглахад хэд хэдэн бэрхшээл тулгардаг. Ийм сайтуудын байршил, хаяг нь олон нийтэд үргэлж мэдэгддэггүй, учир нь сайтуудыг олохын тулд анхан шатны мэдээлэл цуглуулах ажил эсвэл онлайн хайлт хийх шаардлагатай байдаг. Уншигчид чат харилцааг ойлгох, оролцогчдыг танихаас сэргийлэхийн тулд хэрэглэгчид нэрээ нууцлах, кодлогдсон эсвэл шифрлэгдсэн харилцаа холбоог ашигладаг. Интернэтийн дэлхий даяарх мөн чанар нь үүнийг улам хүндрүүлдэг, учир нь амжилттай танигдсан ч тухайн хүн нь мөрдөн байцаагчийн эрх мэдлээс гадуур байж болох юм. Мөрдөн байцаалтын явцад ашигладаг өөр нэг гол эх сурвалж бол файл хуваалцах сүлжээ юм. Эдгээр сүлжээнүүд нь зураг, видео зэрэг өгөгдлийн файлуудыг дамжуулахын тулд хэрэглэгчдийг холбодог. Хууль сахиулах байгууллагын мөрдөн шалгах ажиллагаа, хуулийн арга хэмжээ, ялангуяа зохиогчийн эрхийн зөрчил болон бусад хууль бус материал солилцохтой холбогдуулан олон тооны файл хуваалцах сүлжээг хаасан эсвэл шинэчилсэн байдаг. Хэрэглэгчдийг хянах боломжтой бөгөөд татаж авсан файлуудыг ихэвчлэн тодорхой IP хаягтай нь холбож болдог. Жишээлбэл, хөгжмийн зохиогчийн эрхийн хэрэг нь зохиогчийн эрхийг хуулиар зөрчсөн, ямар хэрэглэгчид оролцсон гэхээсээ илүү тодорхой хөгжмийн файлтай холбоотой байж болно. Гэсэн хэдий ч шилжүүлгийн агуулга нь хүүхдийн садар самууныг мөрдөн шалгах гэх мэт хэрэгт хамааралтай байж болно.

Компьютер

Хувийн компьютер дээр олон тооны цахим нотлох баримтууд байдаг. Эдгээр зүйлсийн ихэнхийг гар аргаар эсвэл logical аргаар гаргаж авч болно. Зарим нотлох баримтууд нь интернэтээс олж авсан мэдээлэлтэй давхцаж байгаа ч Интернэтээс бус биет төхөөрөмжөөс олж болох хэд хэдэн нэртэй эх сурвалжууд байдаг.

Интернэтээр аялж байхад программууд нь ихэвчлэн түр зуурын интернэт файл, (cookie) күүки болон хайлтын түүхийг хадгалдаг. Эдгээрийг хэрэглэгчийн веб түүхийг тодорхойлохын тулд мөрдөн байцаалтын явцад ашиглаж болно. Түр зуурын файлууд болон күүкиг ихэвчлэн веб сайтууд өөрсдөө хэрэглэгчдийг хянах, мэдээлэл хадгалахад ашигладаг байна.

Мэйл болон бусад мессежийг биет компьютер дээрээс олж болно. Хэдийгээр Google болон Microsoft-ын эсрэг сүүлийн үеийн хэргүүдээс харахад ихэнх цахим шуудан нь интернэт серверүүд дээр хадгалагддаг боловч зарим харилцаа холбооны программ хангамж нь өмнөх мессежнүүдийг компьютерын хатуу диск рүү архивладаг.

Зөөврийн электрон хэрэгсэл

Одоогийн байдлаар гар утас гэх мэт зөөврийн электроник хэрэгслээс цахим нотлох баримт гаргаж авах нь эксперт, судлаачдын анхаарлын төвд байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд ийм төхөөрөмжүүдийн хэрэглээ ба нөлөө нь эрс нэмэгдэж, электрон болон биет эх сурвалжийн өмнөх хослолоос илүү хувийн мэдээллийг агуулсан жижиг электрон төхөөрөмжүүдийг нийлүүлэхэд хүргэсэн.

Цахим нотлох баримтын салбарт гар утас зонхилох сонирхлыг татаж байгаа нь гайхах зүйл биш юм. Эдгээр төхөөрөмжүүд нь орчин үеийн нийгэмд бараг хаа сайгүй байгаа бөгөөд 21-р зуунд үзүүлэлтийн хувьд хувьсгал хийж , хууль эрх зүйн шинэ сорилтуудыг дагуулж байгаа тул АНУ-ын Дээд шүүх саяхан хэргийн газарт ихэнх гар утсыг нэгжиж шалгахад зөвшөөрөл шаардлагатай гэж шийдвэрлэсэн. Салбарын судалгаанаас үзэхэд АНУ-ын утасгүй сүлжээний захиалгын тоо одоогийн байдлаар нийт хүн амаас давж байна (336 сая хүн амтай, 313 сая хүн) ; Энэ захиалгын тооцоо нь арван жилийн өмнө байсан 159 сая байснаас хоёр дахин их байна (Утасгүй сүлжээний салбарын жилийн судалгаа, 2014). Ерөнхий шүүгч Жон Робертс Райлигийн шийдвэрт гар утас нь хүмүүсийн олон тооны чухал хэрэгцээг хангадаг «микрокомпьютер” юм гэж дурдсан. Нэг шалтгаан нь хэргийн газарт гар утсыг нэгжиж шалгахад хууль сахиулах байгууллага нь зөвшөөрөлтэй байх ёстой гэж шүүх шийдвэрлэсэн -цаас эсвэл бусад зөөврийн зүйлээс ялгаатай нь гар утасны мэдээлэл нь дэвтэр, өдрийн тэмдэглэл, хувийн компьютер гэх мэт зөөврийн бус том эд зүйлстэй адилхан байж болно. Гар утаснууд нь зураг авах, байршил тогтоох систем (GPS), мэйл болон бусад баримт бичгүүдээс ялгаатай текст мессеж илгээх зэрэг онцлогтой. Мөн гар утас нь ихэвчлэн утасны жагсаалт, дуудлага хийсэн болон хүлээн авсан бүртгэл, дуудлагын үргэлжлэх хугацаа зэргийг багтаасан байдаг.

Цахим нотлох баримттай холбоотой хууль эрх зүйн асуудлууд

Технологийн байнгын өөрчлөлтийн үед хуулийн байгууллагууд цахим нотлох баримттай холбоотой асуудлуудыг шийдвэрлэхийн тулд цаг үетэй нийцсэн бодлогын төслийг боловсруулах ёстой. Бодлого тогтоохын тулд хууль сахиулах

байгууллага нь шүүх, прокурор зэрэг талуудтай хамтран хэрэг бүртгэл мөн хүлээн зөвшөөрөгдөх эсэх нь хууль ёсны шаардлага хангаж байгаа эсэхийг тодорхойлох ёстой. Нотлох баримт нь хэргийн дараа зохисгүй олж авсан гэж үзвэл эрүүгийн эрх зүйн тогтолцоонд төдийлөн ач холбогдолгүй. Хууль сахиулах байгууллага мөн хамтарч буй байгууллагууд нь цахим нотлох баримтад нийцсэн хүлээлт тавих хэрэгтэй ба цахим бус нотлох баримтын процесс бодлого нь ялгаатай байдаг.

Үзлэг нэгжлэг хийх

АНУ-ын Дөрөв дэх нэмэлт өөрчлөлт нь төрийн эрх баригчдын үндэслэлгүй нэгжлэг, хураан авахаас хамгаалдаг. Шүүх нь цахим төхөөрөмж, цахим мэдээллийн өвөрмөц шинж чанарыг судалж Дөрөвдүгээр нэмэлт өөрчлөлт нь цахим мэдээлэлд хэрхэн үйлчлэх талаар тайлбарлахаар зорьж байна. Дөрөвдүгээр нэмэлт, өөрчлөлт үйлчилж байгаа тохиолдолд хууль сахиулах албан хаагч нь нэгжлэг хийхийн тулд зохих шүүхээс нэгжлэг хийх зөвшөөрөл авах ёстой боловч зарим үл хамаарах зүйлс байдаг. Зөвшөөрөлгүй нэгжлэгийг зохих этгээдийн зөвшөөрлөөр хийж болох ч хойшлуулшгүй нөхцөл байдал эсвэл нотлох баримт устах аюултай үед нь цахим хадгалах төхөөрөмжийг хязгаартайгаар үзлэг нэгжлэг хийх шалтгаан болдог. Хууль сахиулах ажилтнуудыг хамгаалах, нотлох баримт устахаас урьдчилан сэргийлэх шаардлагатай үед баривчлах ажиллагааны хүрээнд хязгаартай нэгжлэг хийж болно.

Хянан шалгагчид ил тод харагдах нотлох баримтууд нь үзлэг нэгжлэг хийхэд зөвшөөрөл авах шаардлагаас үл хамаарч болдог (Horton v California, 1990). Гэсэн хэдий ч цахим хэлбэрээр хадгалагдсан мэдээллийн хувьд энэ зарчмыг хэрэгжүүлэх нь илүү төвөгтэй болдог. Мерфи, Эсворти нар (2012) цахим нотлох баримт цуглуулах үйл явцыг хоёр үе шаттай үйл явц гэж үзэхийг зөвлөдөг. Эхний шат бол зөвшөөрөлд хамаарч төхөөрөмж эсвэл төхөөрөмжид байгаа мэдээллийг хураан авах явдал юм. Мерфи, Эсворти нарын хэлснээр, эхний хураан авалт нь хэт өргөн хүрээтэй бөгөөд нэгжлэг хийх зөвшөөрөлд хамраагүй олон мэдээллийг агуулж болохыг шүүх зөвшөөрсөн. Тиймээс хууль сахиулахын албан хаагчид нэгжих зөвшөөрлийн хүрээнд хураан авсан мэдээллийг шалгаж ялгаж авах хоёр дахь үе шат байх ёстой. Үүний тулд хураан авсан төхөөрөмжүүд дээрх файлуудыг шалгах шаардлагатай: Ийм шалгалтын явцад нэгжлэг хийх зөвшөөрлөөс гадуур гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагааны нэмэлт нотлох баримтууд илэрч болно.

АНУ-д Конгресс Дөрөвдүгээр нэмэлт өөрчлөлтийн шаардлага болон эрүүгийн мөрдөн байцаалтын хэрэгцээг тэнцвэржүүлэхийн тулд олон хууль баталсан. АНУ-ын хуулийн дөрвөн хэсэг нь цахим нотлох баримтад онцгой хамаатай: Wiretap Act (18 U.S.C. §2510 et seq.); the Pen Registers and Trap and Trace Device Statute (18 U.S.C. §3121 et seq.); Цахим харилцааны нууцлалын тухай хууль (ECPA) (18 U.S.C. §2701 гэх мэт); болон Нууцлалыг хамгаалах тухай хууль (PPA) (42 U.S.C. §2000aa ба бусад).

The Wiretap Act нь утсаар, амаар эсвэл цахим харилцаанд оролцогч талуудыг харилцаа холбоог гаднын этгээд чагнахаас хамгаалдаг. Уг үйлдэл нь аман харилцаа холбоо, утасны дуут болон текст мессеж, эсвэл шууд мессеж, цахим шуудан гэх мэт компьютероор үүсгэсэн мессежийг чагнах зориулалттай төхөөрөмжид хамаарна. Үндэслэлтэй бол шүүхээс хууль сахиулах байгууллагад хөндлөнгөөс оролцохыг зөвшөөрсөн захирамж гаргаж болдог. Шүүхийн захирамжгүйгээр харилцаа холбоог чагнах засгийн газрын оролдлого нь иргэний болон эрүүгийн хариуцлага хүлээлгэж, нотлох баримтыг таслан зогсооход хүргэдэг.

The Pen Registers and Trap and Trace Device Statute нь утас, интернэт холболттой холбоотой мета өгөгдөл цуглуулахыг хязгаарладаг. Харилцааны агуулгыг зохицуулдаг The Wiretap Act-с ялгаатай нь The Pen Registers and Trap and Trace Device Statute нь мэйл хаяг, залгасан утасны дугаар эсвэл хүлээн авсан дуудлагын утасны дугаар зэрэг мэдээллийг хамардаг. Хэрэв хуульд үл хамаарах зүйл байхгүй бол хууль сахиулах ажилтнууд харилцааны холбооны мета өгөгдлийг хайхаасаа өмнө шүүхийн захирамж авах ёстой.

Цахим харилцааны нууцлалын тухай хууль (ECPA) нь сүлжээ нийлүүлэгчийн хадгалсан бүртгэл, файлуудтай холбоотой заалтыг агуулдаг. Энэ нь интернэт сүлжээ нийлүүлэгчийн (ISP) хадгалсан мэйл болон бусад захиалагчийн мэдээллийг хууль ёсны зөвшөөрөлгүйгээр задруулахаас хамгаалдаг. Хадгалсан мэдээлэлд хандахын тулд хууль сахиулах байгууллагаас шаардагдах зөвшөөрлийн төрөл нь хайж буй мэдээллийн нууцлалаас хамааран шүүхэд дуудах хуудаснаас авхуулаад үзлэг нэгжлэг хийх зөвшөөрөл хүртэл байдаг. Уг хууль нь сэжигтний хувийн компьютерт хадгалагдсан харилцаа холбоотой мэдээлэлд хамаарахгүй. Боловсронгуй болж хууль нь хэт өргөн хүрээний иргэний зарлан дуудах хуудас нь интернэт сүлжээ нийлүүлэгч ISP-ийг хэрэглэгчийн хувийн мэдээллийг өгөхийг албадахад хангалтгүй байж магадгүй гэж үзэж байна (Мэрфи ба Эсворти, 2012). Гэсэн хэдий ч Цахим харилцааны нууцлалын тухай хууль нь гуравдагч этгээдийн сервер дээр 180 хоногоос дээш хугацаагаар хадгалагдсан материалыг орхигдуулсан гэж үздэг тул хууль сахиулах байгууллагын ажилтнууд зөвхөн мөрдөн байцаалтад хамааралтай болохыг нотолсон бичгээр мэдэгдэл өгөхөд л хангалттай. Өнөөдөр хэрэглэгчид гуравдагч этгээдийн сервер дээр мэйлээ тодорхойгүй хугацаагаар хадгалах магадлалтай бөгөөд энэ нь хууль сахиулах байгууллагад асар их давуу тал болж өгдөг, учир нь өөр тохиолдолд хэрэглэгчийн хувийн төхөөрөмжөөс ижил мэдээлэл авахад зөвшөөрөл авах шаардлагатай ба 180 хоногийн дүрмийг хасах талаар нэлээд маргаантай байдаг байна.

PPA нь зохиогчийн бүтээсэн бүтээгдэхүүн (онлайн мэдээллийн товхимол, блог гэх мэт), мөн тухайн бүтээгдэхүүнийг бүтээхэд ашигласан материалыг хамгаалдаг. PPA-д хамаарах материалууд нь нэгжлэг хийх зөвшөөрөлд хамаарахгүй. Гэсэн хэдий ч, материал нь гэмт хэрэг үйлдэхтэй холбоотой эсвэл хураан авах нь амь нас аврах, бие махбодод ноцтой гэмтэл учруулахаас сэргийлэх тохиолдолд үл хамаарах юм.

Баримтжуулах

Цахим нотлох баримтыг баримтжуулах нь гэрчлэх, баримт бичгийн бүртгэлийн хоёр асуудлыг багтаадаг. Баталгаажуулалт нь нотлох баримт нь түүнийг санал болгогчийн үзэж байгаа зүйл мөн болохыг тогтоох үйл явц юм. Нотлох баримт гаргаж буй тал нь тухайн зүйл жинхэнэ гэдгийг нотлох шаардлагатай. Цахим нотлох баримтыг баталгаажуулах гол асуудал бол цахим баримтын зохиогчийн хэн болохыг тогтоох явдал юм. Жишээлбэл, хариуцагчаас хохирогчид бичсэн цахим шуудан нь хариуцагч өөрөө бичсэн гэдгийг нотлох баримтыг прокурор нотлох шаардлагатай. Олон мужийн шүүхээс баталсан Холбооны нотлох баримтын дүрэмд компьютер, гар утас хураан авсан хууль сахиулах албан хаагч гэх мэт мэдлэгтэй гэрчийн мэдүүлгээр нотлох баримтыг тогтоохыг зөвшөөрдөг бөгөөд файлуудыг хаанаас авсан болохыг гэрчлэх боломжтой юм. И-мэйл нь хариуцагчийн мэддэг байсан

мэдээлэл эсвэл мессежийг илгээсэн төхөөрөмжид анх хандсан хүн нь хариуцагч байсан тухай гэрчлэх гэх мэт янз бүрийн арга хэрэгслээр дамжуулан баталгаажуулж болно. Баталгаажуулах үйл явцын нэг хэсэг болгон баримт бичгийн бүртгэл нь цахим нотлох баримтыг анхны хэлбэрээр нь хадгалж баталгаажуулдаг. Энэ нь нотлох баримтыг хэзээ цуглуулсан, хаанаас цуглуулсан (төхөөрөмжийн төрөл, таних тэмдэг, өмчлөгч гэх мэт), төхөөрөмжийг хэн эзэмшиж байсан, хэн түүнд хандах эрхтэй болохыг баримтжуулах боломжтой болно. Энэ нь нотлох баримтыг хэрхэн цуглуулсан (жишээ нь ямар арга хэрэгсэл, процедур ашигласан) зэргийг багтаана. Эцэст нь, баримт бичгийн бүртгэл нь нотлох баримт хэрхэн хадгалагдсан, хэн нотлох бариммттай харьцсан, хэн нэвтэрч байсан талаар баримтжуулсан байдаг[71].

Дээрхээс дүгнэвэл АНУ-д цахим нотлох баримтыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглах нь түгээмэл болох нь харагдаж байна. Мөн "цахим нотлох баримт" гэдгийг тодорхойлж өгснөөс гадна үзлэг нэгжлэг хийх, баримтжуулах үйл ажиллагааг Wiretap Act (18 U.S.C. §2510 et seq.); the Pen Registers and Trap and Trace Device Statute (18 U.S.C. §3121 et seq.); Цахим харилцааны нууцлалын тухай хууль (ECPA) (18 U.S.C. §2701 гэх мэт); болон Нууцлалыг хамгаалах тухай хууль (PPA) (42 U.S.C. §2000aa ба бусад) гэх хуулиудаар нарийвчлан зохицуулсан нь боловсронгуй зохицуулалт болжээ. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим нотлох баримтыг тусгахдаа дээрх боловсронгуй зохицуулалтыг жишиг болгон авч үзэх нь зүйтэй.

3.2.3.5. Бүгд Найрамдах Солонгос Улсын сайн туршлага

Одоогийн байдлаар Бүгд Найрамдах Солонгос Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим нотлох баримт болон түүнийг хураан авах, нэгжлэг хийх талаар ямар ч зохицуулалтыг тусгаагүй байна[72].

Мөн цахим мэдээлэл гэдэг нь компьютер гэх мэт мэдээлэл боловсруулах системээр боловсруулагдсан мэдээллийг хэлдэг бөгөөд үүнийг цахим нотлох баримт гэж нэрлэдэг. Цахим мэдээлэл нь компьютерын диск гэх мэт мэдээллийн хадгалах хэрэгсэлд хадгалагддаг. Цахим мэдээлэл нь биет бус боловч мэдээлэл хадгалах хэрэгсэл нь биет юм. Компьютер нь аж ахуйн нэгжийн болон хувь хүмүүсийн үйл ажиллагааны чухал хэрэгсэл болсон тул цахим мэдээллийг хадгалах, хайх хэрэгцээ улам бүр өргөжиж байна.

Цахим нотлох баримт гэдэг нэр томьёо нь гэмт хэрэг үйлдсэнийг нотлох эсвэл гэмт хэрэг болон түүний хохирогч, гэмт хэрэг болон түүнийг үйлдэгч хоёрын хооронд холбоо тогтоох боломжтой аливаа цахим өгөгдлийг агуулсан ойлголт юм. Цахим нотлох баримт нь үндсэндээ баримт бичиг, зураг, аудио, видео зэрэг мэдээллийн хэлбэрүүд ба нэмж дурдахад энэ нь хэл, тоонуудын өвөрмөц хослол хэлбэрээр компьютер дээр хуулбарлагддаг. Заримдаа цахим нотлох баримт нь соронзон орон, электрон импульсээс бүрдэх тул биет бус, бодитой бус нотлох баримт болох тохиолдол байдаг. Үүнийг тусгай багаж, тусгай техник ашиглан цуглуулж, шинжилж болдог. Үүнийг илрүүлэх, цуглуулах, ашиглах байдлын хувьд мэргэжлийн мэдлэг,

71 Digital Evidence and the U.S. Criminal Justice System: Identifying Technology and Other Needs to More Effectively Acquire and Utilize Digital Evidence. Sean E. Goodison, Robert C. Davis, and Brian A. Jackson. https://www.ojp.gov/pdffiles1/nij/grants/248770.pdf

72 형사절차상 digital evidence에 관한 연구 - 압수, 수색을 중심으로 - Digital Evidence in Criminal Procedure, pp.21, https://www.kicj.re.kr/boardDownload.es?bid=0001&list_no=9714&seq=1

тусгай багаж хэрэгсэл шаарддагийг эс тооцвол эд мөрийн баримтаас нэг их ялгагдахгүй. Харин эд мөрийн баримт нь гэмт хэрэгтэн устгасан тохиолдолд нөхөн сэргээх боломжгүй тохиолдол байдаг бол цахим нотлох баримтын хувьд нотлох баримтыг устгасан ч нотлох баримтын зарим хэсэг буюу хуулбар нь үлддэг.

Өнөөдрийн байдлаар олон янз илэрч буй кибер гэмт хэрэг нь түүнд тохирсон цахим нотлох баримтын янз бүрийн хэлбэрийг бий болгож байна. Жишээлбэл, кибер мөшгөгчид хохирогчдоо бэлгийн дарамт үзүүлэхийн тулд цахим шуудан ашигладаг, компьютерын хакерууд нэвтэрсэн ул мөрийг бүртгэлийн файлд үлдээдэг, хүүхдийн садар самууныг сонирхогчид компьютер дээрээ хүүхдийн садар самууныг харуулсан дижитал видео файлуудыг хадгалдаг. Тэдгээр нь амархан танигдахгүй янз бүрийн хэлбэрээр байдаг. Цахим нотлох баримтыг хэд хэдэн шалгуурт үндэслэн дараах байдлаар ангилдаг. Нэгдүгээрт, хүний оролцоотой боловсруулалтын процесс байсан эсэхээс хамааранд компьютероор хувиргасан нотлох баримт, компьютерын тусламжтай бий болсон нотлох баримт гэж бий. Эхнийх нь компьютер ажиллаж эхлэх үед өгөгдөл оруулах гэх мэт хүний оролцоогүйгээр тодорхой программыг хэвийн ажиллуулж, бие даан гүйцэтгэсэн ажлыг бүртгэдэг компьютероор үүсгэгдсэн нотлох баримт гэж хэлж болно. Тухайлбал, онгоцонд суурилуулсан хар хайрганд нислэгийн бүртгэл автоматаар бүртгэгддэг бол хүний гараар өгөгдөл оруулах, командыг гүйцэтгэх явцад компьютерын боловсруулалт хийх замаар өгөгдөл бүрдүүлдэг тохиолдол байдаг. Тодруулбал компьютероор залилангийн гэмт хэрэг хийх үеийн нотолгоо үүнд хамаарна. Үүнийг компьютерт хадгалагдсан нотлох баримт, компьютерын симуляци гэж хуваагддаг. Компьютерт хадгалагдсан нотлох баримт гэдэг нь хүний гараар дамжуулан компьютерт хадгалагдаж, төрийн байгууллага эсвэл компаниудад ашиглагдаж буй өгөгдлийг хэлнэ. Жишээлбэл нягтлан бодох бүртгэлийн төрөл бүрийн программууд эсвэл статистикийн программууд гэх мэт. Компьютерын симуляци гэдэг нь зам тээврийн осол, онгоцны ослын үед хоёр талын зам, хурд зэрэг виртуал өгөгдлийг оруулах замаар компьютерын программын үр дүнд бий болсон өгөгдлийг хэлнэ. Энэ нь голчлон тодорхой нөхцөлөөр боловсруулагдах үр дүнг шүүх хуралдаанд нотлох баримт болгон ашиглах нотлох баримт болгон гаргаж ирсэн тохиолдлуудад хамаарна. Гэсэн хэдий ч компьютерын симуляцийн хувьд загварчлалд ашигласан шинжлэх ухааны зарчмуудын үнэн зөв, зохистой байдлыг хүлээн зөвшөөрсөн ч загварчлал нь өөрөө өөр алдаа гаргавал эсэргүүцэлтэй тулгарах болно. Үүнийг хязгаарлах ёстой. Учир нь шинжээч шүүх хуралдаанд дүгнэлтээ хэлж, ийм симуляцийг өөрийн дүгнэлтийг батлах үндэслэл болгон ашиглахад нотлох баримтыг хүлээн зөвшөөрөх шаардлагагүй. Нэгдүгээрт, компьютероор үүсгэсэн нотлох баримтууд нь хүний амнаас гарсан нотлох баримт биш тул хүний амаар ярьсан нотлох баримт болохгүй, мөн бичлэг өөрөө найдвартай өндөр зэрэгтэй тул тухайн хэрэгт хамааралтай, үнэн зөв эсэх асуудлыг хөнддөггүй. Асуудлыг даван туулсан тохиолдолд үүнийг нотлох баримт болгон ашиглаж болно гэж хэлж болох ч компьютерын тусламжтай нотлох баримтыг мэдээлэл оруулагч эсвэл өгөгдөл нийлүүлэгчийн мэдэгдэл гэж хүлээн зөвшөөрч, дуу ярианы нотлох баримт гэж ангилдаг.

Цахим нотлох баримтын байгаа хэлбэрээс хамааран төрлийг дараах байдлаар ангилж болно. Өөрөөр хэлбэл, соронзон хальс, соронзон дискт хадгалагдсан цахим бичлэг, цахим бичлэгийг тодорхой цахим мэдээлэл боловсруулах төхөөрөмж, түүний тусламжтайгаар гаргаж, үүсгэсэн тохиолдол гэж хуваж болно. Энэ нь бичгийн нотлох баримт ба нотлох баримтыг ялгах тухай онолоос санаа авсан дүгнэлт

бөгөөд нотлох баримтыг судлах арга гэж хэлж болно. Энэ ангиллын арга нь эцсийн дүндээ цахим нотлох баримтыг баримтжуулж чадах эсэхээс хамаарна гэж хэлж болно. Эхнийх нь баримтжуулах боломжгүй төдийгүй харагдахуйц, уншигдахуйц хэлбэрээр үзүүлэхэд хэцүү бөгөөд тодорхой биет хэлбэрт хувиргах боломжгүй өгөгдөл юм. Сүүлийнх нь тодорхой агуулгатай, харагдахуйц, унших боломжтой баримт бичиг, зураг хэлбэрээр гаргаж болох, баримтжуулж болох, тиймээс шалгах шаардлагатай нотлох баримт бичигтэй дүйцэх мэдээллийн төрөл юм.

Эцэст нь цахим нотлох баримтыг хадгалсан эсэхээс нь хамааруулан төрөл болгон ангилж болно. Нарийн утгаараа цахим нотлох баримтыг хувийн компьютероос сүлжээний сервер эсвэл интернэтийн виртуал санах ойд хадгалах, мэдээлэл, харилцаа холбооны сүлжээгээр дамжуулж болно. Эхний тохиолдолд дижитал нотлох баримт хаана хадгалагдаж байгааг олж тогтоовол гэмт хэргийн нотлох баримт болгон нэгжлэг хийж хурааж авдаг бол сүүлийн тохиолдолд мэдээлэл, харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийн талаар мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг[73].

Цахим мэдээлэл хадгалах хэрэгсэлд хадгалагдаж буй цахим мэдээлэл нь асар том хэмжээтэй бөгөөд эрүүгийн хариуцлагатай холбоотой цахим мэдээллээс гадна компанийн худалдааны нууц, хувийн нууц зэрэг эрүүгийн хариуцлагатай холбоогүй контентыг хадгалах шинж чанартай байдаг. Иймд цахим мэдээллийг хураан авах, нэгжихдээ бусад албадлагаас илүү болгоомжтой байж тухайн субъектийн үндсэн эрхийг зөрчихгүй байх шаардлагатай.

Хураан авч буй зүйл нь компьютерын диск болон түүнтэй адилтгах бусад мэдээлэл хадгалах хэрэгсэл бол хадгалагдаж буй мэдээллийн хамрах хүрээг тодорхойлж, хэвлэж, эсхүл хуулбарлан ирүүлэх ёстой. Харин мэдээлэл хадгалах зөөвөрлөгч зэргийг хязгаарлагдмал хүрээнд хэвлэх, хуулбарлах боломжгүй буюу хураах зорилгодоо хүрэхэд ихээхэн хүндрэлтэй гэж үзвэл хурааж авч болно (БНСУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 3, 219 дүгээр зүйл).

Энэ мэтчилэн мөрдөн байцаах байгууллага цахим мэдээллийг хураан авч, нэгжлэг хийх нь зарчмын хувьд 1) зөвхөн нотолгоо гаргах үндэслэл болсон гэмт хэрэгт холбогдсон хэсгийг хэвлэмэл баримт болгон цуглуулах, 2) Газар дээрх нөхцөл байдал, их хэмжээний цахим мэдээллийн улмаас холбогдох мэдээллийг олж авахад удаан хугацаа шаардагдах, мэргэжлийн боловсон хүчин техникийн арга хэмжээ авах шаардлагатай зэрэг онцгой тохиолдолд холбогдох файлыг мөрдөн байцаах газрын зөөвөрлөдөг хадгалах хэрэгсэлд хуулбарлах 3) мэдээлэл хадгалах хэрэгслийг шууд хураан авах, 4) мэдээлэл хадгалах хэрэгсэлд агуулагдах бүх цахим файлыг цаасан хуулбар, дүрс бичлэг гэх мэт хэлбэрээр хураах байдлаар ангилж болно. Энэ тухай эрэн сурвалжлах зөвшөөрөлд заасан байх ёстой.

Мэдээлэл хадгалах хэрэгслээс хууль ёсны дагуу олж авсан хуулбарыг хайж олох, сэжиглэгдсэн баримттай холбоотой цахим мэдээллийг баримт болгон гаргах, файл болгон хуулбарлах зэрэг үйл явц нь мөн зөвшөөрлийн дагуу хураан авах, нэгжлэг хийх ажиллагааны нэг хэсэг гэж тооцогддог. Тиймээс ийм тохиолдолд баримт бичгийг хэвлэх, хуулбарлах объект, тухайлбал мэдээлэл хадгалах хэрэгслийн

73 형사절차상 digital evidence에 관한 연구 - 압수, 수색을 중심으로 - Digital Evidence in Criminal Procedure, pp.26-29, https://www.kicj.re.kr/boardDownload.es?bid=0001&list_no=9714&seq=1

байршилд хураан авах, нэгжлэг хийх зэрэг нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 114, 215 дугаар зүйл болон Үндсэн хуулийн 12 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэгд заасны дагуу сэжиглэгдсэн хэсгүүдээр хязгаарлагдах ёстой. Энэ нь процедурын зарчмууд ба пропорциональ байдлын үүднээс энэ нь зүй ёсны хэрэг юм. Иймд мэдээлэл хадгалах хэрэгсэлд хадгалагдаж байгаа цахим мэдээллийг, эсхүл мөрдөн байцаах газрын албанд авч явсан хуулбарыг дур мэдэн баримт болгон хэвлэх, эсхүл хэрэгт авагдсан баримтад хамааралгүйгээр хуулбарлан файл болгон хуулж байгаа үйлдэл нь зарчмын хувьд хууль бус хураан авах ажиллагаа юм.

Түүнчлэн дээрх цуврал ажиллагаанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 219, 121 дүгээр зүйлд заасан эрэн сурвалжлагдаж байгаа болон хураагдсан цахим мэдээллийг эзэмшигч этгээд, тэдгээрийн өмгөөлөгчийг оролцуулах боломжийг хангах, хамааралгүй цахим мэдээллийг дур зоргоороо давхардуулахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохих арга хэмжээг авч байна. Хэрэв ийм арга хэмжээ аваагүй бол сэжигтэн этгээд, эсхүл уг хэргийн мөн чанар, агуулгыг харгалзан хурааж авсан зүйлийн эзэмшигч этгээдийн процессын баталгааг хангах зорилгыг ноцтой зөрчсөн гэж үзэж болно.

Мөрдөн шалгах байгууллага, шүүх нь мэдээлэл хадгалах хэрэгслийг хураан авах замаар тодорхой мэдээлэл хүлээн авсан тохиолдолд тухайн мэдээллийн субъект болох, холбогдох баримтыг мэдээллээр таньж болох этгээдэд нэн даруй мэдэгдэх ёстой (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 219 дүгээр зүйлийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг)[74].

Дээрхээс дүгнэвэл, БНСУ-ын тухайд цахим нотлох баримтыг ангилан тодорхойлдог нь сайн жишиг бүхий зохицуулалт байх ба Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн нотлох баримттай холбоотой нийтлэг зохицуулалтуудад цахим нотлох баримтыг хамааруулж уялдуулан хуулийг хэрэглэдэг сайн туршлагатай байна. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим нотлох баримтын талаар тусгахдаа түүний ангилал болон хууль хэрэглээний талаар сайн жишгийг авч үзэх нь зүйтэй.

3.3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалттай холбоотой зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ

Судалгааны гуравдугаар бүлгээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь дахь дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалалтын талаар нарийвчлан авч үзэх ба Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд үүнийг шинээр зохицуулж хуульчлах шаардлага бий эсэхийг судална. Мөн түүнчлэн ийнхүү хуульчлахдаа гадаадын зарим улс, орнуудаас нутагшуулах сайн жишиг бүхий зохицуулалтыг тодорхойлох болно.

74 출처 : 법률저널(http://www.lec.co.kr)

3.3.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн ойлголт, шинж

ЭХХШтХ-ийн үзэл баримтлал, шинэ төрлийн нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх аргуудын талаар нэгдсэн ойлголт байхгүй, шинэлэг зохицуулалтуудыг төдийлөн ашиглахгүй, уламжлалт хуучин арга, тактикаар нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх нь давамгай байна.[75]

Судалгаанаас үзэхэд мөрдөгчид нотлох баримтыг бэхжүүлэхэд дуу-дүрсний бичлэг, гэрэл зургийн аппаратыг түгээмэл ашигладаг. Нотлох баримтын шаардлага хангах дуу-дүрсний бичлэг хийх төхөөрөмж, гэрэл зургийн аппаратыг олон мөрдөгч дундаа ашигладгаас шалтгаалж гол төлөв өөрийн гар утсаар орлуулж байна. Энэ нь нотлох баримт устах, алдагдах эрсдэл дагуулахын зэрэгцээ, нотлох баримтын шаардлага хангах эсэхэд эргэлзээ төрүүлдэг. Дараагийн түгээмэл хэрэглэдэг техник хэрэгсэл нь суурин компьютер, принтер бөгөөд эдгээр нь нотлох баримт бэхжүүлэх техник хэрэгсэл мөн боловч тэмдэглэл үйлдэхэд л голчлон ашигладаг. Цөөн тохиолдолд байршлыг нарийвчлан тогтоох GPS ашиглаж байна. Дийлэнх мөрдөгч эдгээрээс өөр техник хэрэгсэл ашигладаггүй гэсэн нь техник хэрэгслийн ололт дэвшлийг өргөнөөр ашиглаж чадахгүй байгааг харуулж байна.[76]

ЭХХШтХ-д нотлох баримт цуглуулах, бэхжүүлэхэд техник хэрэгсэл өргөн ашиглах, өмгөөлөгчийн зүгээс баримт сэлт гаргаж өгөх, нотлох баримт шалгах, үнэлэхтэй холбоотой олон шинэлэг зохицуулалт орсон боловч эрүүгийн процессын явцад эдгээр зохицуулалт төдийлөн ашиглагдахгүй, практик хэрэглээ нь үр дүн муутай байна.[77]

2019 оны 4 сарын 1-ний өдрийн Архивын ерөнхий газрын даргын дугаар А/51 тушаал “Кино, гэрэл зураг, дуу авианы баримтын архивын цахим баримт хадгалалтын журам батлах тухай”,

Нотлох баримт, түүнийг үнэлэх нь шүүн таслах ажиллагааны амин сүнс болсон асуудлын нэг юм. Үүний хамгийн тод жишээ бол “нотлогдоогүй бол гэм буруугүй” гэсэн эрх зүйн суурь зарчим юм. Тиймээс ч Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14-т –“гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно” гэж заасан. Эрүүгийн процессын онолд нотлох баримтыг хэлбэрийн хувьд мэдүүлэг, биет, бичмэл, буулгасан, виртуал гэж ангилан үздэг.[78]

Цахим нотлох баримт нь зөвхөн цахим төхөөрөмж, системээр гаргасан баримт бичгээр хязгаарлагдахгүй. Цаасан бичиг баримт, гэрэл зураг, дүрс бичлэгийг цахим нотлох баримт гэж үзэхээс гадна эд мөрийн баримтыг хүртэл цахим хэлбэрт шилжүүлж, хууль хяналтын байгууллагаас баталгаажуулан нотлох баримт болгон байршуулах боломжтой.[79]

75 ННФ, Нотолгооны өнөөгийн практик, арга зүй, техник хэрэгсэл, анхаарах асуудал /Судалгааны тайлан/, (Уб, 2021), 70 дахь тал.

76 Мөн тэнд, 62 дахь тал.

77 Мөн тэнд, 53 дахь тал.

78 Ш.Мөнхжаргал, Л.Уянга, Б.Нямцэрэн нар, Нотлох баримт, түүнийг үнэлэхтэй холбоотой эрх зүйн эх сурвалжуудыг судалж бичсэн, асуудал дэвшүүлсэн өгүүлэл. https://legaldata.mn/buteel/pdf?id=1761

79 U.S. Embassy - Ulaanbaatar, Mongolia

3.3.2. Монгол Улс дахь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдал, сайжруулах хэрэгцээ, шаардлага

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цахим нотлох баримт, түүнийг цуглуулах, бэхжүүлэх, шинжлэх судлах, үнэлэхтэй холбоотой холбогдох байгууллагуудаас гаргасан эрх зүйн акт, журмыг судлан үзвэл:

1. 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны 31 дүгээр тогтоол, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөв хэрэглэх албан ёсны тайлбарт:

Хуульд нэрлэн зааснаас бусад бичмэл болон цахим баримт, бусад эд зүйл нь хуулийн 16.2 дугаар зүйлд заасан нотолбол зохих байдал, эсхүл гэм буруу үгүйсгэхэд ач холбогдолтой тохиолдолд эд мөрийн баримт гэж үзэх бөгөөд зөвхөн нотлох ажиллагаанд ашиглаж, гэм буруутай эсэхийг эцэслэн шийдвэрлэсний дараа хууль ёсны өмчлөгч, эзэмшигчид нь буцаан өгөх, гүйлгээнд хориглосон болон цаашид ашиглах боломжгүй эд зүйлийг устгах буюу зохих байгууллагад шилжүүлэх, бичмэл эд мөрийн баримтыг хэрэгт хавсарган үлдээх зэргээр шийдвэрлэдэг онцлогтой. Хуульд "... бичмэл болон цахим баримт ..." гэж ерөнхий агуулгаар тусгагдсанаас тус бүрийн онцлог, нотлох баримтын бие даасан төрөл болох баримт бичгээс ялгагдах шинжийг тодорхойлох шаардлага үүсэж байна.

Цахим төхөөрөмжид үүсгэсэн, боловсруулсан, хадгалсан, өөрчилсөн, илгээсэн, дамжуулсан, хүлээн авсан бүх хэлбэрийн мэдээлэл нь гэмт хэрэг үйлдэхэд, эсхүл гэмт хэрэгт бэлтгэх, завдахад ашигласан, гэмт хэргийн ул мөр үлдсэн, агуулсан тохиолдолд эд мөрийн баримт болно.

Цахим баримт нь биет бус, олон байршилд хадгалах, олон хэрэглэгч зэрэг нэвтрэх боломжтой, тогтвортой бус түргэн хугацаанд хувирч өөрчлөгдөх, устах эрсдэлтэй, технологийн хурдацтай хөгжил мөрдөн шалгах ажиллагаанд нөлөөлдөг зэрэг онцлог шинж чанартай эд мөрийн баримтын төрөл юм. Энэ төрлийн баримтыг хайх, олж илрүүлэх, бэхжүүлэх, хадгалах, зөөвөрлөх, шалгах ажиллагаанд цахим мэдээллийн бүрэн бүтэн, найдвартай байдал нь нотлох баримтаар үнэлэхэд чухал ач холбогдолтой.

Цахим төхөөрөмжид агуулагдаж буй мэдээлэл нь түүний онцлог шинж чанараас шалтгаалан эх хувийг тогтооход бэршээлтэй, цуглуулах, бэхжүүлэх, хадгалах, зөөвөрлөх явцад амархан өөрчлөгдөх, устах эрсдэлтэй тул энэ төрлийн эд мөрийн баримтыг илрүүлэх, бэхжүүлэхдээ хуулийн 9.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тусгай мэдлэг, туршлага бүхий хүнийг мэргэжилтнээр оролцуулбал зохино.

Мэргэжлийн байгууллага, ур чадвар бүхий мэргэжилтнийг цахим баримтыг эрж хайх, олж илрүүлэх, бэхжүүлэх ажиллагаанд оролцуулсан бол тэдний хийсэн үйлдэл, үйл ажиллагаа бүрийг нэг бүрчлэн тэмдэглэлд тусгана. Цахим төхөөрөмжөөс өөрчлөгдсөн, устгасан мэдээллийг нарийн мэргэшсэн шинжээчийн тусламжтайгаар сэргээсэн тохиолдолд нотлох баримтад тооцогдоно[80] гэж тусгажээ.

80 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоол, Дугаар 31, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөв хэрэглэх албан ёсны тайлбар.

2. Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2021 оны 5 сарын 20-ны өдрийн А/69 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүгийн хэрэгт хөрөнгө, орлого, эд мөрийн баримт, эд зүйлийг хураан авах, бэхжүүлэх, хадгалах, хамгаалах, шилжүүлэх, шийдвэрлэх журам”

Тус журмын 7 дугаар зүйлд “Онцлог эд мөрийн баримтыг хураан авах, бэхжүүлэх, хадгалах, хамгаалах, шилжүүлэх, шийдвэрлэх” ажиллагааг тусгайлан тусгасан бөгөөд тус журмын 7.2.9. “цахим төхөөрөмж” гэж суурин болон гар утас, гэрэл зургийн аппарат, дүрс бичлэгийн камер, таблет, сканер, факсын машин, хэвлэгч, хувилагч, бусад төхөөрөмжийг, 7.2.10. “мэдээлэл хадгалах хэрэгсэл” гэж хард диск, флаш диск, санах ой бүхий картууд, CD, DVD болон бусад хэрэгслийг гэж тус тус тодорхойлжээ. Мөн энэхүү журмын 7.12-т цахим баримтын талаар дараах байдлаар тусгажээ.

7.12.1. цахим баримтыг мэргэжилтний тусламжтайгаар тусгай техник хэрэгсэл, программ ашиглан хуулбарлан авч, энэ тухай тэмдэглэл үйлдэж, үйл явцыг гэрэл зураг, дуу дүрсний бичлэгээр бэхжүүлнэ. Шаардлагатай тохиолдолд цахим төхөөрөмж , мэдээлэл хадгалах хэрэгслийг хураан авна.

7.12.2. мэдээллийг хуулбарлахдаа хөндлөнгийн хоёроос доошгүй гэрчийг байлцуулан засварлаж өөрчлөх боломжгүйгээр код үүсгэн “hash” /эшлэх-тусгай программ ашиглах/, тэмдэглэж хөтөлж, түүнд байлцсан хүмүүсээр гарын үсэг зуруулна.

7.12.3. цахим төхөөрөмж, мэдээлэл хадгалах хэрэгслийг хураан авахад ул мөр үлдсэн, интернэт холболтын модем, кабель шугам, бусад төхөөрөмжтэй холбогдсон эсэхийг шалгана.

7.12.4. шаардлагатай бол модем, свитч рүтер зэрэг сүлжээний төхөөрөмжийг хураан авч, тэмдэглэл үйлдэнэ.

7.12.5. тэмдэглэлд цахим төхөөрөмжийг хураан авах үед асаалттай ажиллагаатай байсан эсэх, тухайн үед хэн, хэрхэн ашиглаж байсан талаарх мэдээллийг тусгана.

7.12.6. компьютер, цахим төхөөрөмжид хадгалагдаж байгаа бүх төрлийн мэдээлэл нь устах, гэмтэх эрсдэлтэй тул үзлэг хийхээс өмнө төхөөрөмжид байгаа мэдээллийг үзэх, агуулгыг хайх, асаах, унтраах зэргээр дур мэдэн оролдохыг хориглоно.

7.12.7. компьютер, цахим төхөөрөмжийн дэлгэц дээрх мэдээлэл өөгдлийг устгаж байгаа шинж тэмдэг илэрсэн тохиолдолд шууд унтраана.

7.12.8. хэргийн газраас нууц үг бүхий цаас, программ, техник хангамжийн гарын авлага, компьютероос хэвлэсэн бичвэр болон график материалыг хураан авна.

7.12.9. цахим төхөөрөмж, гар утасны нууц үгийг эд зүйлээ хураалгаж буй этгээд буюу өмчлөгч, эзэмшигчээр бичүүлж, эд зүйлийн хамт уут, савand битүүмжилнэ.

7.12.10. цахим эд мөрийн баримтыг зөвхөн цаасан уут, хайрцаг зэрэг савand хийж, тээвэрлэх явцад доргилтоос хамгаална.

7.12.11.савлахын өмнө шошго тавьж, хоорондоо холбогдсон төхөөрөмжүүдийн холболтуудыг дараа нь угсарч ажиллуулах зорилгоор ойлгомжтой хэлбэрээр хаяглаж, үйл явцыг гэрэл зураг, дуу дүрсний бичлэгээр бэхжүүлнэ.

7.12.12. цахим баримтыг соронзон орон бүхий цахилгаан үүсгэх боломжтой аливаа төхөөрөмж материалаас хол, аюулгүй байдлын хамгаалалттай, температурын хяналт бүхий орчин, чийгшилгүй газарт зориулалтын хамгаалалтын уут эсхүл хайрцагт хадгална.

7.12.13. цахим мэдээлэл хадгалах хэрэгслийн мэдээлэл устгах, гэмтэхээс сэрэмжилж цахилгаан үүсгүүр, радио дамжуулагч зэрэг соронзон орны орчин үүсгэх, ердийн дулаанаас хэт өндөр температур, чийгшил, тоосжилт, доргилт ихтэй газарт хадгалахыг хориглоно.

Монгол Улсын хувьд цахим нотлох баримт хураан авах, бэхжүүлэх, хадгалах, хамгаалах үйл ажиллагааны дараалал, аргачлалыг журамлахдаа цахим баримт хадгалагдаж буй төхөөрөмж бүрд ялгаатай байдлаар бус, нийтлэг байдлаар журамласан.[81]

3. 2019 оны 12 сарын 5-ны өдрийн Дугаар 246, А/80 Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий Прокурорын хамтарсан захирамж, тушаалын[82] нэгдүгээр хавсралтаар *“Эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, барьцааны мөнгө, эд мөрийн бариmтыг шийдвэрлэх журам”*, хоёрдугаар хавсралтаар “*Хавтаст хэргийг хүлээн авах, хадгалах, шилжүүлэх журам”*-ыг тус тус шинэчлэн баталсан.

Эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, барьцааны мөнгө, эд мөрийн баримтыг шийдвэрлэх журмын 3.5-д *“… Эд мөрийн баримт болон мэдээллийн техник, технологийн тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл /бүх төрлийн CD, зөөврийн хатуу диск, хатуу диск, флаш.../ зэргийг хүлээн авахдаа хавтаст хэргийн онцлогоос шалтгаалан тухайн тоног төхөөрөмж нь хэвийн ажиллаж байгаа эсэх, гэмтэлтэй эсэх, серийн дугаар тохирч буй эсэхийг шалгана…”* гэж заажээ.

4. Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2022 оны 4 сарын 15-ны өдөр дугаар А/42 тушаалын нэгдүгээр хавсралтаар *“Эрүүгийн хэргийн тусгай, салбар архивд баримт хүлээн авах, тоо бүртгэл хөтлөх, хадгалах, ашиглуулах журам”*, хоёрдугаар хавсралтаар *“Архивд хөтлөгдөх тоо бүртгэлийн баримт бичиг, мэдээний жагсаалт, загвар”*-ыг тус тус баталжээ.

Эрүүгийн хэргийн тусгай, салбар архивд баримт хүлээн авах, тоо бүртгэл хөтлөх, хадгалах, ашиглуулах журамд:

3.8 дугаар зүйл. Цахим хэлбэрт шилжүүлэх

1.Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, цахим мэдээллийн сан үүсгэх аргачлалыг Улсын ерөнхий прокурорын тушаалаар батална;

2.Баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, тоо бүртгэл, эрэлт хайлт, ашиглалтын үйл ажиллагааг хөнгөн шуурхай болгох, эх баримтыг ашиглалтаас чөлөөлөх зорилгоор баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, цахим мэдээллийн сан үүсгэнэ;

3.Баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажилтантай нууц хадгалалтын гэрээ байгуулна.

3.9 дүгээр зүйл. Баримтыг цахим хэлбэрт шилжүүлэхдээ

1.Баримтын мэдээллийг алдагдуулахгүй, бодит байдлыг өөрчлөхгүй байх;

2.Баримтыг гэмтээхгүй байх;

3.Баримтын онцлог шинжийг хэвээр хадгалах;

4.Мэдээлэл тээгчийн шинж чанарыг муутгахгүй байх;

5.Баримтын үндсэн дараллыг алдагдуулахгүй;

6.Ажлын явцад баримтын бүрэн бүтэн байдлыг цахим хэлбэрт шилжүүлж байгаа ажилтан хариуцна.

81 ННФ, Кибер гэмт хэргийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа /Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, үйл ажиллагааны эрсдэлийн хүрээнд/, (Уб, 2022), 62 дахь тал.

82 “Эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, барьцааны мөнгө, эд мөрийн баримтыг шийдвэрлэх журам”, “Хавтаст хэргийг хүлээн авах, хадгалах, шилжүүлэх журам” http://old.supremecourt.mn/act/view/266

3.10 дугаар зүйл. Бусад

1.Цахим баримтыг хөмрөг үүсгэгч байгууллагын хөмрөгт хамааруулж, цаасан суурьтай баримтаас тусад нь хадгална;

2.Цахим хэлбэрт шилжүүлсэн баримтын мэдээг хариуцсан ажилтан сар бүрийн 05-ны дотор гаргаж, тусгай архивд ирүүлнэ;

3.Мэдээг удаа дараа буруу ирүүлсэн, хугацаа хожимдуулсан, алдаатай, худал ташаа ирүүлсэн, мэдээг огт ирүүлээгүй, зохих журмын дагуу серверт байршуулаагүй ажилтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцуулах албан бичгийг байгууллагын удирдлагад хүргүүлнэ;

4.Байгууллагын удирдлага нь цахим мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах, халдлагаас хамгаалах, мэдээлэл алдагдахаас сэргийлэх зорилгоор техник хэрэгслийн найдвартай байдал, сүлжээ, серверийн аюулгүй байдлыг хангах, хорт код вирусээс хамгаалах арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллана.

4.4 дүгээр зүйл. Хадгалалт

2.Цахим мэдээлэл хадгалах хэрэгслийн мэдээлэл устах, гэмтэхээс сэрэмжилж цахилгаан үүсгүүр, радио дамжуулагч зэрэг соронзон орны орчин үүсгэх, ердийн дулаанаас хэт өндөр температур, чийгшил, тоосжилт, доргилт ихтэй газарт хадгалахыг хориглоно.

4.6 дугаар зүйл. Баримтын шинж чанарыг тодорхойлох

6.Тусгай тээгчтэй болон цахим баримтын хадгалалтын байдалд 2 жил тутам нягтлан шалгалт хийж, шаардлагатай тохиолдолд цахим баримтын файлыг ашиглагдаж буй форматад хөрвүүлж, хадгалалтын тоног төхөөрөмжийг шинэчлэх, солих арга хэмжээ авна;

7.Цахим баримтыг зориулалтын хадгалах төхөөрөмж, бүх төрлийн сервер, компьютер, зөөврийн болон бусад тоон технологийн шийдэл ашиглан тээгчээс хамгийн багадаа гурван өөр тээгчид хуулбарлан хадгална.

5.2022 оны 1 сарын 6-ны өдрийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоол Дугаар 1 “Журам батлах тухай”

Энэхүү “Шүүхийн архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх журам”-ын 6 дугаар зүйлд цахим баримтыг хадгалах талаар тусгасан. Тухайлбал,

Журмын 6.3-т “...Цахим баримтыг тодорхой хугацааны давтамжтайгаар сервер болон тусгай тээгч /CD, DVD, Flash, Portable hard disk/-д хадгална...” гэж, 7.1-д “Цахим баримтын агуулгыг эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэрэг, баримт удирдлагын баримт бичгүүд гэсэн төрлөөр төрөлжүүлэн системд мэдээллийг оруулна”, 7.2-т “Системд оруулсан мэдээлэл болон хавсаргасан цахим файл нь тухайн баримтыг хайхад саадгүй илэрч байхаар зөв тодорхойлж, томьёологдсон байна”, 7.3-т “Цахим баримтаар архивын үйлчилгээ үзүүлэхэд системийг ашиглана. Тусгай архиваас системийг суурилуулах бөгөөд уг систем, программ хангамж дээр ажиллахад шаардлагатай мэргэжил, арга зүйн зөвлөгөөг өгнө” гэж тус тус заажээ.

Дээрх тайлбар, журмуудаас харвал цаашид цахим нотлох баримтыг ЭХХШтХ-д тодорхойлон заах шаардлагатай байна. Энэ нь тухайн нэр томьёог өөр өөрөөр тодорхойлон хэрэглэхээс сэргийлэх, нэр томьёог нэг мөр ойлгон хэрэглэхэд чухал ач холбогдолтой.

Түүнчлэн, шүүхийн цахимжилттай холбогдуулан цахим нотлох баримт, цахим хавтаст хэрэг, цахимжуулсан хавтаст хэрэг зэрэг шинэ шинэ нэр томьёо, ойлголт, ухагдахуун гарч ирж байгаатай холбогдуулан анхнаасаа тухайн нэр томьёог оновчтой зөв тодорхойлж, нэг мөр ойлгон хэрэглэх шаардлага бий болж байгааг дурдах нь зүйтэй.

6. 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн УДШ-ийн Ерөнхий шүүгч, ХЗДХ-ийн Сайд, УЕП-ын хамтарсан Дугаар А/18, 34, А/31 “Заавар батлах тухай”

Тус тушаалаар “Эрүүгийн болон зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдох баримтыг архивд хадгалах заавар”-ыг нэгдүгээр, “Эрүүгийн хэргийн төв болон салбар архивд хадгалагдаж байгаа баримтыг хадгалах хугацааны заавар”-ыг хоёрдугаар хавсралтаар баталсан.

Эрүүгийн хэргийн төв болон салбар архивд хадгалагдаж байгаа баримтыг хадгалах хугацааны зааварт:

Хоёр. Шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн баримтын хадгалах хугацаа

2.1. Шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн баримтыг дор дурдсан хугацаагаар хадгална.

2.1.1. хорихоос өөр төрлийн үндсэн болон нэмэгдэл ялын тухай баримтыг ялыг эдэлж дууссан өдрөөс хойш 10 жил;

2.1.2. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг 1 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээг 1 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон эрүүгийн гэмт хэргийн баримтыг шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 12 жил;

2.1.3. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг 1 жилээс дээш, дээд хэмжээг 8 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг 1 жилээс дээш хугацаагаар тогтоосон эрүүгийн гэмт хэргийн баримтыг шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 16 жил;

2.1.4. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг 5 жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг 15 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон эрүүгийн хэргийн баримтыг шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 жил;

2.1.5. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг 12 жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг 20 жил хүртэл тогтоосон ба бүх насаар хорих ял оногдуулахаар заагаагүй эрүүгийн гэмт хэргийн баримтыг байнга;

2.1.6. Эрүүгийн хуульд бүх насаар нь хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг, хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг, хүний амь нас хохирсонтой холбоотой, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээдэд холбогдох, нууцад хамаарах баримт, Төв болон салбар архивын ББНШАЗК-ын хурлын шийдвэрээр байнга хадгалахаар шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн баримт, баримт бичгийг байнга;

2.2. 1961, 1986 оны Эрүүгийн хуулиар шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргийн баримтын хадгалах хугацааг тухайн хэргийг шийдвэрлэсэн хуулийн зохих зүйл, хэсэгт заасан ялын дээд хэмжээг 2002 оны Эрүүгийн хуулийн гэмт хэргийн ангилалд хамааруулан тооцож, хадгалах хугацааг нь тогтооно.

2.3. Шүүхээс хэрэгсэхгүй болгосон, цагаатгасан, өршөөж шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн баримтын хадгалах хугацааг энэ зүйлийн 1.1.1-1.1.5 дахь заалтад заасан хугацаагаар хадгална.

2.4. Шүүхээр шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн баримтыг дор дурдсан хугацаагаар хадгална.

2.4.1. хүнд холбогдох хэргийн баримтыг шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 3 жил;

2.4.2. хуулийн этгээдэд холбогдох хэргийн баримтыг байнга;

Гурав. Прокуророос шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн баримт материалыг хадгалах хугацаа

3.1. Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн материал – шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 3 жил;

3.2. Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан болон хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн хэргийн баримт;

3.2.1. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг 1 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээг 1 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэргийн баримтыг – шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 3 жил;

3.2.2. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг 1 жилээс дээш, дээд хэмжээг 8 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг 1 жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэргийн баримтыг – шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 5 жил;

3.2.3. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг 5 жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг 15 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэргийн баримтыг – шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 12 жил;

3.2.4. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг 12 жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг 20 жил хүртэл тогтоосон ба бүх насаар нь хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэргийн баримтыг – шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 20 жил;

3.2.5. Эрүүгийн хуульд бүх насаар нь хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг, хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг болон хүний амь нас хохирсон бүх хэргийн баримт, материал, баримт бичиг – байнга.

3.2.6. Улс төрд нөлөө бүхий хүн, төрийн өндөр албан тушаалтан, дипломат дархан эрх ямба эдэлж байгаа хүн, шүүгч, прокурор болон авлигатай тэмцэх, хил хамгаалах, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдах албан тушаалтанд холбогдох хэргийн баримт – байнга.

Практикт шүүхийн шийдвэрээр тухайн хэрэгт хураагдан ирсэн эд мөрийн баримтыг цаашид хадгалах эсэхийг хэрхэн шийдвэрлэснээс хамаарч нотлох баримтыг хадгалах эсхүл устгах арга хэмжээг авдаг. Цахим нотлох баримтын хувьд практикт ихэвчлэн CD дээр хуулбарлан хавтаст хэрэгт хавсаргадаг бөгөөд энэ нь тухайн хавтас хэргийг хадгалах хугацаатай ижил хугацаанд хадгалагдаж байна.

Энэ талаар буюу дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалтын талаар холбогдох мэргэжилтэн, судлаач дараах мэдээллийг өгсөн.

Шигтгээ 6.

Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хувьд 100% хийгдэж чаддаггүй. Одоогийн байдлаар тус дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуустал хадгалдаг бөгөөд зарим нь богино хугацаанд устгагдах тохиолдол байдаг. Нөхцөл байдлын тухайд дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийг хадгалах сервер, багтаамжийн хүрэлцээ муу байдаг нь асуудал үүсгэж байна. Түүнчлэн бичлэгийн чанар муу байгаа нь хэрэгжүүлж буй зорилготойгоо нийцэхгүй байна.

Шүүхийн цахимжилтын сайн жишгийг авч үзвэл шүүх хуралдаан нь боловсронгуй тоног, төхөөрөмжөөр тоноглогдсон, сайтар бичлэг хийх дуу, дүрсний төхөөрөмжтэй, түүнийг хадгалах багтаамжтай байх нь зүйтэй. Дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн найдвартай байдал нь шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн гишүүн Н.Баасанжавтай хийсэн ярилцлагын хэсгээс...

3.3.3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалалтын харьцуулсан судалгаа

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим нотлох баримтын талаар харьцуулсан судалгааг хийхдээ өмнө нь авч үзсэн шүүх, хууль, эрх зүйн үйл ажиллагааг цахимжуулах талаар дэвшил гаргасан, эрх зүйн тогтолцооны хувьд жишиг болгож судалдаг дараах улсуудыг судаллаа.

3.3.3.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын сайн туршлага

Ерөнхий зохицуулалт

ХБНГУ-ын ЭХХШтХ-ийн “Хэргээ хүлээсний дараа буюу эсэргүүцсэн тохиолдолд шүүгчийн тэмдэглэлээс уншиж танилцуулах” гэсэн 254-р зүйлийн (1) -т “Шүүгдэгчийн мэдүүлэг, шүүх хуралдааны тэмдэглэл, дуу дүрсний бичлэгт тусгагдсан мэдүүлгийг хэргээ хүлээсэн тухай нотлох баримт авах зорилгоор уншиж, сонсгож болно” мөн “Баримт бичгийг унших замаар баримтат нотлох баримт бүрдүүлэх; баримт бичгийн найруулгыг анхаарч үзэх” гэсэн 249-р зүйлийн (1) хэсэгт “Баримт бичгийг агуулгынх нь талаар нотлох баримт авах зорилгоор үндсэн шүүх хуралдаанд уншина. Цахим баримт бичгийг уншиж танилцах боломжтой баримт бичиг гэж үзнэ.” гэж тус тус зааснаас үзэхэд дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг нь ЭХХША-нд авах, үнэлэх буюу үнэнийг тогтоох зорилгоор ашиглах боломжтой цахим (дижитал) нотлох баримт буюу цахим баримт бичгийн нэг төрөл юм.

Нарийвчилсан зохицуулалт

ХБНГУ-ын ЭХХШтХ-ийн 1-р бүлгийн “Хавтаст хэргийн удирдлага (менежмент) ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь харилцаа холбоо” гэсэн 4-р дэд бүлэгт “Хавтаст хэргийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор баримт бичгийг хувиргах (хөрвүүлэх)” гэсэн 32е зүйлд цахим баримт бичгийг хэрхэн цахим хавтаст хэрэгт хавсаргах, цахим байдалд хөрвүүлэх болон хадгалалтын хугацаа зэргийг зохицуулсан байна. Уг дэлгэрэнгүй зохицуулалтыг доор танилцуулъя.

Хэсэг 32е

Хавтаст хэргийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор баримт бичгийг хувиргах (хөрвүүлэх)[83]

(1) Тухайн хавтаст хэргийг хадгалж буй хэлбэртэй (эх баримт бичигтэй) баримт бичиг нь тохирохгүй байвал тохирох хэлбэрт тус баримт бичгийг хөрвүүлж болно. Нотлох баримт болгон баталгаажуулсан эх баримт бичгийг зохих шаардлагатай хэлбэрт шилжүүлж болно.

(2) Баримт бичгийг хөрвүүлэхдээ хөрвүүлсэн баримт бичиг нь харагдах байдал болон агуулгын хувьд эх баримт бичгийн агуулгатай тохирох байдлыг хангахуйц хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглана. .

83 БНЭсУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Kriminaalmenetluse seadustik**,** 2003)

(3) Цахим бус эх баримт бичгийг цахим баримт бичиг болгон хөрвүүлэхдээ хөрвүүлэхэд ямар процедур ашигласан, энэ нь эх баримт бичигтэй харагдах байдал болон агуулгатай тохирч байгаа зэргийг нотлох баримтыг хавсаргана. Прокурорын байгууллага болон шүүхэд хэрэглэгдэж байсан, хариуцах үүрэг бүхий этгээдийн гарын үсэг зурсан баримт бичгийг хөрвүүлэх тохиолдолд хөрвүүлэлтийг нотлох баримт нь прокурорын газар, шүүхийн бүртгэлийн ажилтны мэргэшсэн цахим гарын үсэгтэй байх ёстой. Мэргэшсэн цахим гарын үсэг бүхий эсхүл дамжуулах аюулгүй аргаар ирүүлсэн цахим эх баримт бичгийг уг баримт бичигт хийсэн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг шалгасан шалгалтын дүнгийн хавтаст хэрэгт бичилт хийн оруулна

(4) Үргэлжилж буй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтаар хадгалагдаагүй эх баримт бичгийг хөрвүүлснээс хойш дор хаяж зургаан сар хадгална. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дууссан, эсхүл хугацаа хэтэрсэн тохиолдолд нотлох баримтаар хадгалагдаагүй эх баримт бичгийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дууссанаас хойшхи хуанлийн хоёр дахь жилийг дуустал хадгалах боломжтой.

(5) Нотлох баримтаар хадгалагдаагүй эх баримт бичгийг баталгаатай нотлох баримтад хамаарах нөхцөлөөр шалгаж болно. Хавтаст хэргийг шалгах эрх бүхий этгээд нь энэ төрлийн шалгалтыг хийх бүрэн эрхтэй.

Дээрхээс дүгнэвэл, ХБНГУ-ын тухайд дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийг цахим нотлох баримтад хамааруулан зохицуулж, хадгалалт, хамгаалалтын асуудлыг ерөнхий журмаар зохицуулдаг байна. Нарийвчилсан журмын тухайд нотлох баримтаар авагдаагүй эх баримт бичгийг хадгалах журмыг нарийвчлан зохицуулжээ.

3.3.3.2. Бүгд Найрамдах Эстони Улсын сайн туршлага

Ерөнхий зохицуулалт

Эстонийн ЭХХШтХ-ийн "Кино ба дуу, дүрсний бичлэг" гэсэн 150-р зүйлийн (1)-д "Мөрдөн шалгах ажиллагаа болон бусад процесс ажиллагаа, эсхүл түүний тодорхой хэсгийг камержуулж, дууны, дүрсний бичлэг хийж болно. Мөрдөн шалгах ажиллагаа болон бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлэхээс өмнө энэ тухай гэрч, ЭХХША-нд оролцогчид мэдэгдэнэ." гэсэн бол (4)-р зүйлд *"Дууны, дүрсний бичлэгийг эрүүгийн хавтаст хэрэгт хавсаргана. Дууны болон дүрсний бичлэгт өөрчлөлт оруулахыг хориглоно."* Гэж зохицуулсан байна.

Дээр дурдсанчлан Эстони улсын ЭХХША-нд хавтаст хэргийг цахим хавтаст хэргийн системээр цахимаар хөтлөх (ЭХХШтХ-ийн 160[1] (5), 210-р зүйл) бөгөөд 150-р зүйлийн (4)-т зааснаас үзэхэд ЭХХША-ны явцад бэхжүүлж авсан дуу, дүрсний бичлэг, киног цахим хавтаст хэрэгт цахим хэлбэрээр хавсаргах бололтой гэвч энэ талаар нарийвчлан зохицуулсан зохицуулалт одоогоор алга байх бөгөөд 160[1]-р зүйлийн (6),(7)-д шүүхийн хавтаст хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлэх хугацаа, цахим хэрэг хөтлөлт, түүнд хандах, цахим баримт бичгийн хадгалалт түүнд тавигдах техник шаардлага, цахим хавтаст хэргийг архивлах журам зэрэг нарийвчилсан зохицуулалтыг Хууль зүйн сайдын гаргасан журмаар тогтооно гэж заасан боловч одоогоор тус төрлийн журам батлагдаагүй байна.

Нарийвчилсан зохицуулалт, хугацаа

Эстонийн ЭХХШтХ-ийн 124-р зүйлд "Биет эд мөрийн баримт гэж эрүүгийн гэмт хэргийн объект болсон зүйл, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан эд зүйл, эрүүгийн гэмт хэргийн нотлох баримт бүхий зүйл, гэмт хэргийн нотлох

бариmтын ул мөр бүхий сэтгэгдэл, хэвлэмэл, эрүүгийн гэмт хэрэг, эсхүл нотлох баримттай холбоотой үйл бариmтыг тогтооход ашиглаж болох эрүүгийн үйлдэлтэй холбоотой бусад чухал объектыг хэлнэ." гэж тодорхойлсон бөгөөд уг биет эд мөрийн баримтыг хадгалах журмыг уг хуулийн 125-р зүйлд зохицуулсан байна. Гэвч ЭХХШтХ-ийн 63-р зүйлд "нотлох баримт"-ыг тодорхойлохдоо биет нотлох барим буюу биет эд мөрийн баримтад, дууны, дүрсний болон дуу-дүрсний бичлэгийг багтаалгүй тусад нь тоочин бичсэн байх тул ЭХХШтХ-ийн 125-р зүйлд зохицууласан "Эд мөрийн баримтыг хадгалах журам" нь дууны, дүрсний болон дуу-дүрсний бичлэгт хамаарах эсэх нь эргэлзээтэй байна.

Хэрэв 125-р зүйлд зохицуулсан "Эд мөрийн баримтыг хадгалах журам" нь дууны, дүрсний болон дуу-дүрсний бичлэгт ижил хамаарах бол 125-р зүйлийн (1)-т заасны дагуу эд мөрийн баримтыг *"ЭХХША явуулж буй байгууллагын эд мөрийн бариmтын хадгалах газар, эсхүл шүүх эмнэлгийн байгууллагын эзэмшил, хамгаалалтад байгаа бусад байранд*" хадгалах бөгөөд хадгалах хугацааны хувьд 6 сар байх бөгөөд прокурор, мөрдөн байцаах байгууллагын хүсэлтээр энэ хэсгийн (4) дэд хэсэгт заасан зургаан сарын хугацааг нэг жил хүртэл хугацаагаар сунгаж болно (ЭХХШтХ-ийн 124-р зүйлийн (4), (5)) гэж тус тус заасан байна.

*Нууц мөрдөн шалгах ажиллагааны үед олж авсан дууны, дүрсний, дуу-дүрсний бичл*эгийн хадгалалт, хамгаалалт

БНЭсУ-ын ЭХХШтХ-ийн "Нууц мөрдөн шалгах ажиллагааны хавтаст хэргийг хадгалах, хөтлөх" гэсэн 126[11] –р зүйлийн (1)-д заасны дагуу нууц мөрдөн шалгах ажиллагааны явцад олж авсан аливаа мэдээллийг нууц мөрдөн шалгах ажиллагааны хавтаст хэрэгт хадгалах бөгөөд уг зүйлийн (2)-т ийнхүү "...хадгалах, хөтлөх журмыг Дотоод хэргийн сайдын санал болгосноор Бүгд Найрамдах Улсын Засгийн газар тогтооно" гэж заасан байна. Уг хуулийн зохицуулалтын дагуу Эстони улсын Засгийн газраас 2013 оны 03 дугаар сарын 01-ний өдөр баталсан №3 "Мөрдөн шалгах ажиллагааны хавтаст хэргийг хөтлөх, хадгалах журам"-ын 7-р зүйлийн (5) дахь хэсэгт "Нууц мөрдөн шалгах ажиллагааны явцад авсан гэрэл зураг, кино, дуу авианы болон дүрс бичлэг, бусад мэдээллийг эсхүл түүний зарим хэсгийг болон хавтаст хэргийг нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагын нууц мэдээллийг боловсруулах цахим системд эсхүл нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагын энэ зорилгоор тусгайлан тохируулсан өрөөнд хадгална" гэж заасан байна.

Дээрхээс үзэхэд Эстони улсад ЭХХША-ны явцад бэхжүүлж авсан болон цахим хавтаст хэрэгт авагдсан аливаа дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг цахим хэлбэрээр цахим хавтаст хэргийн системд болон биет байдлаар эд мөрийн баримт хадгалах тусгай зориулалт бүхий эрх бүхий байгууллагын байранд нийтлэг журмын дагуу хадгалдаг байна.

3.3.3.3. Америкийн Нэгдсэн Улсын сайн туршлага

Нотлох баримтыг хадгалах гэдэг нь засгийн газар нотлох баримтын бүрэн бүтэн байдлыг дараа нь шалгах эсвэл дүн шинжилгээ хийх зорилгоор хадгалах ёстой байдаг. Ингэхийн тулд эд хөрөнгө, нотлох баримтыг хадгалагч нь хадгалалтын бүртгэлийг үнэн зөв, бүрэн гүйцэд хөтөлж, нотлох баримтыг зохих ёсоор хадгалж, нотлох баримтыг бохирдуулах, гэмтээх, устгахаас урьдчилан сэргийлэх ёстой

байдаг. Хадгалалтын протокол нь нотлох баримтын төрлөөс хамаардаг, биологийн дээж эсвэл дижитал нотлох баримтыг хадгалах дүрэм гэх мэт.

Нотлох баримтыг хадгалах үүрэг нь аливаа төрийн байгууллага, эрүүгийн мөрдөн байцаалтын ажиллагааны хүрээнд нотлох баримт цуглуулж, эзэмшиж авснаас хойш эхэлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүгдэгчийн ял хүртэл үргэлжилдэг.

Цагдаа нар ихэвчлэн эрүүгийн хэрэгт ашигласан нотлох баримтыг цуглуулдаг ч нотлох баримтыг хадгалах цорын ганц төрийн байгууллага биш юм. Хадгалах үүрэг нь мөн:

- орон нутаг, муж, муж улсын мөрдөн байцаах агентлагууд-эдгээрт зөвхөн мөрдөгч, мөрдөн байцаагчид төдийгүй захиргааны, бичиг хэргийн болон шүүх эмнэлгийн ажилтнууд ордог.

- Хэргийг хариуцаж байгаа прокурор мөн прокурорын эрх мэдлийн доор ажиллаж байгаа хүмүүс нотлох баримтыг хадгалах үүрэгтэй (жишээлбэл мөрдөн байцаагч, прокурорын томилсон шинжээч)

- Ерөнхий прокурор-ихэнх мужид болон ихэнх тохиолдолд нотлох баримтыг хадгалах үүрэг нь шүүгдэгчийг яллагдсаны дараа ч хэвээр үлдээдэг. Тиймээс, уг үүрэг нь муж улсын Ерөнхий прокурорын газарт (ихэвчлэн давж заалдах болон ял шийтгүүлсний дараах асуудлыг зохицуулдаг) хамаарна.

- Ерөнхий прокурор-ихэнх мужид болон ихэнх тохиолдолд нотлох баримтыг хадгалах үүрэг нь шүүгдэгчийг яллагдсаны дараа ч хэвээр үлддэг. Тиймээс, уг үүрэг нь муж улсын Ерөнхий прокурорын газарт (ихэвчлэн давж заалдах болон ял шийтгүүлсний дараах асуудлыг зохицуулдаг) хамаарна.

Нотлох баримтыг хадгалах үүрэг нь хууль сахиулах байгууллагатай албан ёсны харилцаагүй бол хувь хүмүүс эсвэл агентлагуудад хамаарахгүй. Иймд хэргийн газраас цуглуулсан цусны дээжийг шалгахын тулд ДНХ шинжилдэг хувийн лабораторийг прокурор хөлсөлсөн бол тухайн лаборатори нь нотлох баримт, нотлох баримт дээр хийсэн аливаа шинжилгээний үр дүнг хамгаалж , хадгалах ёстой.

3.3.3.4. Бүгд Найрамдах Солонгос Улсын сайн туршлага

БНСУ-ын тухайд дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг Эрүүгийн процессын хуулийн 311, 312 дугаар зүйлд заасны дагуу нотлох баримтаар тооцдог.[84]

1) Нэгдүгээрт, видео бичлэг нь эх хувь байх ба эсвэл эх хувиас хуулбарласан хуулбарын хувьд хуулбарлах явцад зориудаар засварлах гэх мэт ямар нэгэн зохиомол өөрчлөлтгүйгээр эхийн агуулгын хуулбарлаагүй байх ёстой;

2) Хоёрдугаарт, Эрүүгийн процессын хуулийн 313 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шүүх хуралдаанд бэлтгэх эсвэл шүүх хурлын товын үеэр гэрчийн мэдүүлэгт үндэслэн видеог хуулбарласан байх ёстой. Дуу бичлэгт бичигдсэн хүн бүрийн мэдүүлгийг яг өөрийнх нь хэлсэнчлэн тэмдэглэж авсан гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой

3) Видео бичлэг нь тухайн сэдэв болон зураг авалтын хүний нөхцөл байдалд тулгуурладаг. Энэ нь хүмүүсийн хөдөлгөөн, яриаг бичиж авдаг бөгөөд

84 전문법칙 관련 비디오테이프 등의 증거능력, https://blog.naver.com/duckhee2979/220751969840

бичлэг хийгдэж буй хүний хөдөлгөөнийг байгаагаар нь хуулбарлах боломжтой тул бичлэгийн агуулгад ямар нэгэн зохиомол нөлөө үзүүлээгүй гэж үзвэл анхны мэдүүлэг нь тухайн камерт бичигдэж буй хүний гадаад төрх, дуу хоолойг баталж, бичигддэг. Шүүх хуралдаанд бэлтгэгдэж байх үед видео бичлэгт бичигдсэн хүн бүрийн мэдүүлэг яг хэлсэнчлэн бичигдсэн болохыг гэрчлэгч нарын мэдүүлгээр хүлээн зөвшөөрсөн бол видео бичлэгийг нотлох баримт гэж үзнэ.[85]

БНСУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалалтын хувьд шүүх хуралдаан хүртэлх болон нийтлэг нотлох баримт хадгалах журмын дагуу хадгалдаг байна.

Шүүх хуралдаан хүртэл нотлох баримт хадгалах зохицуулалтыг Эрүүгийн процессын хуулийн 15 дугаар бүлгийн 184, 185 дугаар зүйлээр зохицуулдаг байна. Харин нийтлэг нотлох баримт хадгалах журмыг Прокурорын ерөнхий газраас баталсан Хэргийн бүртгэлийг хадгалах журмаар зохицуулдаг байна.

Шүүх хуралдаан хүртэл нотлох баримт хадгалах зохицуулалтыг Эрүүгийн процессын хуулийн 184, 185 дугаар зүйлд зааснаар дараах байдлаар зохицуулж байна.

Энэ нь шүүх хуралдааны үеэр нотлох баримтыг шалгахыг хүлээж байх хугацаанд нотлох баримтыг ашиглахад хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд прокурор, шүүгдэгч (сэжигтэн), өмгөөлөгчийн хүсэлтээр шүүх хуралдаан болохоос өмнө түүнийг шалгах боломжийг олгодог тогтолцоог хэлнэ. Суурь журам нь бол нотлох баримтын шалгалтыг шүүх хурлын өдөр бүх процедурыг дуусгасны дараа хийдэг. Гэхдээ шүүх хурал болтол хүлээвэл нотлох баримтыг ашиглахад хүндрэлтэй байж болно. Тухайлбал, тодорхой хадгалах хугацаатай камерын бичлэгийн хувьд шүүх хурлын товыг хүлээвэл бичлэг алга болох тул шүүх хурлын тов гарахаас өмнө ч нотлох баримтыг шалгаж болно[86]. Үүнийг нарийвчлан авч үзье.

184 дүгээр зүйл. Хүсэлт гаргах, нотлох баримтыг хадгалах журам

(1) Нотлох баримтыг урьдчилан хадгалахаас бусад тохиолдолд ашиглах боломжгүй нөхцөл байдал үүсвэл прокурор, эрүүгийн шүүгдэгч, эрүүгийн сэжигтэн, түүний өмгөөлөгч анхан шатны шүүх хурал болохоос өмнө мөрдөн шалгах, шалгах, гэрчээс байцаалт авах, шинжээчийн дүгнэлт зэргээр нотлох баримтыг хавсаргах арга хэмжээг авах хүсэлтийг гаргана.

(2) Өмнөх хэсэгт заасан хүсэлтийг хүлээн авсан шүүгч ийм хүсэлтийг шийдвэрлэх талаар шүүх эсвэл даргалагч шүүгчийн эрх мэдэлтэй адил эрх эдэлнэ.

(3) (1)-д дурдсан хүсэлтийг гаргахдаа тухайн хүн үндэслэлийн талаар таамагласан нотлох баримтыг бичгээр гаргаж өгнө.

(4) (1)-д заасан хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан шийдвэрийн эсрэг гомдлыг гурав хоногийн дотор гаргаж болно.

185 дугаар зүйл. Баримт бичгийг шалгах

Прокурор, эрүүгийн яллагдагч, эрүүгийн сэжигтэн, өмгөөлөгч нь шүүгчийн зөвшөөрлөөр өмнөх зүйлд дурдсан захирамжийн талаарх баримт, нотлох баримтыг

85 성폭행피해아동의 진술녹화 비디오테이프의 증거능력, https://www.lawtimes.co.kr/news/104776
86 증거보전, https://namu.wiki/w/%EC%A6%9D%EA%B1%B0%EB%B3%B4%EC%A0%84

шалгаж, хуулбарлаж болно[87].

Харин нийтлэг нотлох баримт хадгалах журмыг Прокурорын ерөнхий газраас баталсан 2010 онд батлагдсан Хэргийн бүртгэлийг хадгалах журмаар зохицуулдаг байна[88]. Тус журмын зорилго нь прокурорын байгууллагаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэрэг бүртгэлт, шүүх хуралдааны тэмдэглэл, бусад баримт бичгийн хадгалалт, зохицуулалттай холбоотой асуудлыг тогтоож, хадгалалтын үйл ажиллагааг хэвийн явуулахад хувь нэмэр оруулахад оршино. Тухайн журамд дараах нэр томьёог тайлбарласныг анхаарч үзэх нь зүйтэй байна.

“Хэргийн бүртгэл” гэдэгт мөрдөн байцаалтын ажиллагаа, шүүх хурал, түүнтэй холбоотой баримт бичиг (баримт бичиг, холбогдох бусад баримт бичиг, эд зүйл, зураг, гэрэл зураг, диск, соронзон хальс, кино, слайд, видео бичлэг, цахим бичлэг гэх мэт тусгай мэдээллийн хэрэгслээр бүртгэгдсэн бичлэгүүд) хамаарна) гэж тодорхойлдог.

“Видео бичлэг” гэж Эрүүгийн процессын хуулийн 221 дүгээр зүйл, 244 дүгээр зүйлийн 244.2-т заасны дагуу мөрдөн байцаалтын явцад сэжигтэн, сэжигтнээс бусад этгээдийн мөрдөн байцаалтын ажиллагааны явцыг дүрс бичлэгт буулгаж, хадгалсан бичлэгийг хэлнэ.

“Хадгалалт” гэж хэргийн материал (өргөдөл, дотоод мөрдөн байцаалтын хэргийн бүртгэлийг оролцуулан) болон шүүхийн баримт бичгийг эдгээр журамд заасан хадгалах хугацааны дагуу зохион байгуулахыг хэлнэ.

Дараах зохицуулалтыг журамд нарийвчлан тодорхойлсон байна.

Хүснэгт 2.8. *БНСУ-ын Хэргийн бүртгэлийг хадгалах журам*

Шүүхийн баталгаажуулалтын бүртгэлийг хадгалах	Хадгалах хугацаа: Шүүхийн шийдвэрээр ял оногдуулсан хэргийн материал нь ялын хөөн хэлэлцэх хугацаа дуустал хадгалагдана. Харин баривчлах, хөнгөн торгох ялтай бол 3 жил хэвээр хадгална. Процесс: Хадгалах ажилтан нь шүүхийн баталгаажуулалтын бүртгэлийн хавтасны баруун дээд хэсэгт бүртгэлийн ангиллын хүнийг хэвлэж, шийдвэрийн тэмдэглэлийн дагуу баталгаажуулсан огноо, дүгнэлтийн ангилал (шүүхийн баталгаажуулалтын үр дүн), бүртгэл хадгалах хугацаа, хадгалалтын эцсийн жилийг тэмдэглэнэ. Хадгалалтын асуудал эрхэлсэн ажилтан 1 дэх хэсэгт заасан баримт бичгүүдийг хадгалалтын төрөл, баталгаажсан жилээр нь ангилж, 1-р маягтын дагуу эрүүгийн хэргийн бүртгэлийн хавтас дээр тогтоосон мэдээллийг оруулж, хэд хэдэн бүртгэлийг нэг хадгалах хайрцагт цуглуулна. Тэдгээрийг ангилсны дараа чанарын дугаар олгож, тогтоосон мэдээллийг эрүүгийн хэргийн бүртгэл хадгалах дэвтэрт 2-р маягтаар оруулах ёстой.

87 CRIMINAL PROCEDURE ACT OF KOREAN [Enforcement Date 09. Dec, 2021.] [Act No.17572, 08. Dec, 2020., Partial Amendment],https://www.law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2&section=lawNm&query=criminal+procedure&x=0&y=0#liBgcolor1

88 Prosecutor’s Office Preservation Rules Partially revised 2021-01-01 Ministry of Justice Ordinance No. 993 amendment, http://www.yeslaw.com/lims/front/page/fulltext.html?pAct=view&pLawId=2408#:~:text=%E2%91%A0%20EC%A7%84%EC%A0%95%EC%82%AC%EA%B1%B4%EA%B8%B0%EB%A1%9D%EC%9D%80,%EC%9D%80%203%EB%85%84%EA%B0%84%20%EB%B3%B4%EC%A1%B4%ED%95%9C%EB%8B%A4.

Яллагдаагүй хэргийн бүртгэлийг хадгалах	Хадгалах хугацаа: Яллагдаагүй хэргийн бүртгэлийг хөөн хэлэлцэх хугацаа дуусах хүртэл хадгална. Харин 2 жил ба түүнээс доош хөөн хэлэлцэх хугацаатай хэрэгт холбогдсон яллах дүгнэлт үйлдээгүй хэргийн бүртгэлийг 3 жил, 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт холбогдсон яллах дүгнэлт үйлдээгүй, ахуйн болон олон улсын ач холбогдол, эсвэл прокурорын ажилд онцгой ач холбогдолтой байх нь хагас байнгын хадгалагдана. Процесс: Яллах дүгнэлт үйлдээгүй хэргийн бүртгэлээс яллах ажиллагааг түдгэлзүүлсэн хэргийн бүртгэлийг тусад нь хадгална. Хадгаламжийн ажилтан нь яллах дүгнэлт үйлдээгүй шийдвэрийн баруун дээд захад хадгалалтын эцсийн жил болон хадгалалтын хугацааг зааж өгөх ёстой. 9 дүгээр зүйлийн заалтыг яллагдаагүй хэргийн бүртгэлийг хадгалах журамд mutatis mutandis хэрэглэнэ.
Гомдол, дотоод хэргийн бүртгэлийг хадгалах	Хадгалах хугацаа: Гомдлын хэргийн бүртгэл гурван жилийн турш хадгалагдана. Дотоод хэргийн хэргийн бүртгэлийг хадгалах хугацаанд яллагдаагүй хэрэгтэй адил зохих ёсоор хамаарна. Процесс: Хэрэг эрхэлсэн ажилтан нь гомдол/дотоод хэргийн бүртгэлийн хавтасны баруун дээд хэсэгт тэмдэглэлийн хадгалалтын хугацаа болон хадгалалтын эцсийн жилийг бичнэ. 1 дэх хэсэгт заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх албаны ажилтан тэмдэглэлийг хадгалахдаа тэдгээрийг хадгалалтын төрөл, хадгалалт дууссан жилээр нь ангилж, эрүүгийн хэргийн бүртгэлийн хавсралтад заасан мэдээллийг хавсралтын маягт 1-д оруулж, олон хэргийг хадгална. Бүртгүүлсэн, хянан шийдвэрлэсэн дотоод хэргийн бүртгэлийг дотоод хэргийн хэлтсийн саналын баганад хэргийн ажилтан “Эрүүгийн хэргийн бүртгэлд хавсаргасан” гэж тэмдэглэнэ.
Видео бичлэгийг хадгалах	Хадгалах хугацаа: Хуулийн 244-2-т заасны дагуу прокурор видео бичлэгийг үүсгэсний дараа хадгалалтын ажилтанд нэн даруй хүлээлгэн өгнө. Прокурорын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 3, 4, 6 дахь хэсэгт заасны дагуу хэргийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд хэргийн ажилтан аливаа видео бичлэгийг хадгалалтын ажилтанд нэн даруй хүлээлгэн өгөх ёстой. Хадгаламжийн ажилтнууд видео бичлэгийг 1, 2-т заасны дагуу хүлээн авахдаа хавсаргасан баримт бичгийн 3-2 дугаар маягт дахь видео бичлэгийн түр хадгалалтад заасан мэдээллийг оруулж, дараа нь жил бүр бүртгэнэ. Тэдгээрийг тоон дарааллаар зохион байгуулж, түр хадгална. Прокурор яллах, яллахгүй байх, хэргийг өөр шүүхэд шилжүүлэх шийдвэр гаргахдаа хавсаргасан Хүснэгт 2-ын хавсралтад байгаа “Видео бичлэг байна” гэсэн тамга дарж, хэргийн бүртгэлийн хавтасны баруун доод талд байгаа видео бичлэгийн тоог бичнэ. Прокурор яллах дүгнэлт үйлдээгүй хэргийг дахин нээх үед хадгалалтын ажилтан, хэрэв ямар нэгэн дүрс бичлэг байгаа бол түүний шалтгааныг дүрс бичлэгийн хадгалалтын албаны тайлбар баганад бичиж, 3 дахь хэсэгт заасны дагуу түр хадгалах ёстой. Процесс: Яллахгүй байх, шүүх хуралдааныг явуулахгүй байх тухай шийдвэр батлагдсан тохиолдолд хамгаалалтын ажилтан нь бичлэгийг битүүмжлэн, холбогдох тэмдэглэлийг хадгална. Хамгаалалтын ажилтан нь видео бичлэгийг битүүмжилсэн дугтуйны баруун дээд захад хадгалалтын хугацаа болон эцсийн оныг бичих ёстой. Видео бичлэгийг хадгалахдаа хадгалалтын ажилчид хадгалалтын төрөл, хадгалалтын эцсийн жилээр нь ангилж, 3-3 дугаар маягтын видео бичлэгийн хадгалалтын шошго дээр заасан мэдээллийг бичиж, нэг хадгалах хайрцагт олон видео бичлэг хийнэ. Чанарыг ангилсны дараа чанарын дугаар өгч, тогтоосон мэдээллийг 2-р маягтын эрүүгийн хэргийн бүртгэл хадгалах тасгийн видео бичлэгийн хэсэгт оруулна. Жилд хадгалагдах видео бичлэгийн хэмжээ бага, 3-р зүйлд заасны дагуу чанарын ангилал, чанарын дугаар олгох нь тохиромжгүй бол тэдгээрийг орхиж, тусдаа хадгалах хайрцагт хадгалж болно.

Шүүхийн шийдвэрийг хадгалах	Хадгалах хугацаа: Шүүхийн баримт бичгүүдээс 1 дүгээр хавсралтад заасан шүүхийн баримт бичгийг үүрд, шүүхийн бусад баримтыг хэргийн хадгалах хугацааны дагуу хадгална. Процесс: Хадгалах ажилтан нь хавсралт 1-д бичсэн шүүхийн шийдвэрийг хэргийн бүртгэлээс гаргаж авах ёстой. Энэ тохиолдолд хэргийг тусад нь буюу нэгтгэж байгаа эсэхийг шалгаж, шийтгэх тогтоол нь батлагдсан шүүгдэгч нарын шүүх хуралдааны материалыг орхигдуулахгүй байхыг анхаарах шаардлагатай байна. Нэг хэрэгт олон яллагдагч байгаа тохиолдолд хорих ангийн ажилтан шүүгдэгч бүрийн ялыг баталгаажуулсан эсэхийг шалгадаг. Тусдаа шүүх хурал гэх мэт шалтгаанаар ял нь батлагдаагүй хүн байгаа тохиолдолд хадгалалтын асуудал эрхэлсэн ажилтан нь зөвхөн баталгаажуулсан шүүхийн эх хувийг гаргаж, үлдсэн тэмдэглэлийг бүртгэдэг. Хадгалах ажилтан нь эд хөрөнгийн шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэртэй холбогдуулан торгуулийн хэмжээг тохируулсан эсэхийг шалгана. Хамгаалах ажилтан нь шүүлтийн баримтын доод талд анхан шатны шүүхэд харьяалагдах прокурорын хэргийн дугаар, ялтны нэрсийн жагсаалтад байгаа хавтасны тоо, тоог бичнэ. Хадгалах ажилтан нь задлан авсан шүүхийн баримт бичгүүдийг төрлөөр нь ангилж, баталгаажуулсан огнооны дарааллаар эмхэлнэ. Олон шүүгдэгчтэй тохиолдолд шүүгдэгч тус бүрд ялын эцсийн хугацаа өөр өөр байвал эцсийн шийдвэр гарсан өдрөөр ялыг зохион байгуулна. Хадгалах асуудал эрхэлсэн ажилтан нь шийдвэр гарснаас хойш нэг жил өнгөрсөн шүүхийн шийдвэрийн баримт бичгийг жилд нэг удаа хавсаргаж, хавсралтын 4-р маягтын дагуу эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн баримт бичгийн жагсаалтад заасан мэдээллийг оруулна. Хадгалах асуудал эрхэлсэн ажилтан нь эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн баримт бичгийн жагсаалтад тухайн хэргийн холбогдох шүүхийн баримт бичгийн хоорондын хамаарлыг тэмдэглэнэ. Хадгалах ажилтан нь задалсан туршилтын файлын хавтсанд серийн дугаар, баталгаажуулсан огноог жилээр нь бичиж, серийн дугаарын дарааллаар жилээр нь эмхэлж, хадгалах ёстой.

Дээрхээс дүгнэвэл, БНСУ-ын тухайд дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, шалгалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн ерөнхий зохицуулдаг хэдий ч Ерөнхий прокурорын газраас гаргасан журмаар мөн нарийвчлан зохицуулж байна. Тодруулбал, Шүүхийн баталгаажуулалтын бүртгэлийг хадгалах, яллагдаагүй хэргийн бүртгэлийг хадгалах, гомдол, дотоод хэргийн бүртгэлийг хадгалах, видео бичлэгийг хадгалах, шүүхийн шийдвэрийг хадгалах гэж нарийвчилсан ангиллыг тогтоож өгсөн байна. Түүнчлэн хэргийн төрлөөс хамааруулан баримт бичгийг жилээр, цаашлаад хөөн хэлэлцэх хугацаагаар тогтоон хадгалдаг байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Тус судалгааны хүрээнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хавтаст хэрэг, нотлох баримт, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгтэй холбоотой эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийсэн ба эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шуурхай, тасралтгүй, найдвартай, ил тод байлгах зорилгын үүднээс цахимжуулах, түүний найдвартай байдлыг хангах хүрээнд нөхцөл байдал, хэрэгжилтийн үр дагаврыг үнэллээ. Ийнхүү үнэлэхдээ Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зохицуулалтын хэрэгжилтийн нөхцөл байдлыг тодорхойлж сөрөг үр дагавар болон сайжруулах хэрэгцээ, шаардлагыг мөн авч үзсэн юм. Түүнчлэн гадаадын сайн туршлага бүхий улс, орнууд болох Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Эстони Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Америкийн нэгдсэн улсын эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн талаар судалж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зохицуулалтыг сайжруулах арга замыг судаллаа. Тус судалгааны хүрээнд дараах дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэрэг

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.11 дүгээр зүйл буюу хавтаст хэргийн зохицуулалтад цахим хавтаст хэргийн талаар тусгаагүй байна. Гэвч Улсын Их Хурал, Засгийн газар, Шүүхийн Ерөнхий Зөвлөл, Улсын Ерөнхий Прокурор зэрэг байгууллагаас гаргасан бодлогын баримт бичиг, дүрэм, журамд цахимжуулах талаар олон зохицуулалт, үйл ажиллагааг тусгасан байна.
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хавтаст хэргийг цахим болгосноор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа шуурхай, тасралтгүй, найдвартай, ил тод байх ач холбогдолтой. Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас мөрдөгч нотлох баримт цуглуулж, хавтаст хэрэг бүрдүүлдгээрээ ялгаатай болохын хувьд шүүхийн цахимжилтад цагдаагийн байгууллага, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын цахимжилт чухал үр нөлөөтэй. Сүүлийн үеүдэд цахим хавтаст хэргийн талаар буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь баримт бичгийн цахимжилт, шүүхийн цахимжилтийн талаар хэлэлцүүлэг ихээхэн хийгдэж байгаа нь түүнийг бий болгох хэрэгцээ, шаардлага байгааг харуулж байна.

Монгол Улсын хувьд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим хавтаст хэргийн талаар тусгахдаа ХБНГУ-тай адилаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэргийн зохицуулалтыг захиргааны процесс, иргэний процессын дараа нь зохицуулж байгаа тул ХБНГУ-ын сайн жишгийг баримтлах нь зүйтэй байна. Тодруулбал, цахим хавтаст хэргийн удирдлага, түүнтэй холбоотой хуульд заасан арга хэмжээ, прокурорын байгууллагууд болон шүүхүүдийн цахим харилцаа холбоо, прокурорын байгууллага, шүүхийн ашиглаж буй цахим баримт бичгийг бүрдүүлэх, дамжуулах; хуульд заасан арга хэмжээ, цахим хавтаст хэргээс гаргаж авсан хувь хүний мэдээллийг ашиглах гэх мэт боловсронгуй зохицуулалтын агуулга, зарчмыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нийцүүлэн тусгах шаардлагатай.

Бүгд Найрамдах Эстони Улс нь цахим хавтаст хэргийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд чухалчилж авч үздэг болох нь тодорхойлогдсон. Тус улс нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульдаа энэ тухай хуульчилж гэрэл

зураг, шүүх хуралдааны бичлэг, тэмдэглэлийг шалгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийг шүүх хуралдаанд бэлэн болгох, цахим хавтаст хэргийн ерөнхий зохицуулалт, цахим баримт бичгийг дамжуулах, бичгээр зарлан дуудах хуудас хүргэх журам, цахим хавтаст хэргийг боловсруулах мэдээллийн системийн талаар нарийвчлан авч үзсэн нь сайн жишиг болохоор байна. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим хавтаст хэргийн зохицуулалтыг тусгахдаа тус улсын жишгийг харгалзан үзэх нь зүйтэй.

АНУ-ын хэмжээнд шүүхэд цахим мэдүүлэг гаргах, цахим хавтаст хэрэг бүрдүүлэх нь жишиг болж байна. Одоогоор 41 мужид зөвшөөрөгдсөн бөгөөд үлдсэн ихэнх мужид хэрэгжих төлөвтэй байна. Тус шинэчлэлт нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хөнгөвчилж, хэргийн оролцогч, өмгөөлөгчдөд бий болох саад бэрхшээлийг арилгах үр дүнтэй өөрчлөлт болсон байна. Мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим хавтаст хэргийн боловсруулалтыг техник технологи талаас нь боловсронгуй болгосон ба үүнийг ашиглахад ямар нэг төлбөр хураамж авдаггүй нь сайн жишиг болж байна.

БНСУ-ын тухайд 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн БНСУ-ын парламентын чуулганы нэгдсэн хуралдаанаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт ашиглах тухай хуулийг баталж нарийвчилсан хуулиар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хавтаст хэргийг зохицуулж байгаа нь сайн жишиг бүхий боловсронгуй зохицуулалт болж байна. Тус хуульд «цахим хавтаст хэрэг", "цахимжуулсан хавтаст хэрэг" гэх нэр томьёог нарийвчлан тодорхойлсноос гадна эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахим баримт бичгээр гүйцэтгэх, компьютержсон мэдээлэл боловсруулах системийг ажиллуулах, цахим баримт бичгийг хүлээн авах, цахим баримт бичгийг бэлтгэх, цахим баримт бичгийг үзэх, хуулбарлах, цахим баримт бичгийг устгах гэх мэт зохицуулалтыг тусгасан байна. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим хавтаст хэргийн зохицуулалтыг тусгахдаа дээрх зохицуулалтын агуулгыг тусгах талаар авч үзэх хэрэгтэй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахим нотлох баримт

Монгол Улсад иргэн, захиргааны хэрэгт цахим баримтыг нотолгооны хэрэгсэлд хамааруулан авч үзэхээр хуульд тодорхойлон заасан нь цахим нотлох баримтыг цаасан суурьтай нотлох баримттай ижил түвшинд үнэлэх боломжийг бүрдүүлсэн гэж дүгнэж болохоор байгаа. Хэдийгээр одоогоор практикт тус цахим нотлох баримтын үр нөлөө цаасан суурьтай нотлох баримттай харьцуулахад бага байгаа боловч хуульд тусгагдсан учир цаашид цахим нотлох баримт цаасан суурьтай нотлох баримттай адил үнэлэгдэх боломж бүрдэж эхэлсэн гэж үзэж болохоор юм. Мөн цахим орчинд үйлдэгдэж буй гэмт халдлагын талаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх цахим нотлох баримтын хэрэглээ нэмэгдэж байна. Практикт хэрэгт ач холбогдол бүхий цахим, аналоги, дижитал (тоон) баримтуудыг хамтад нь "цахим баримт" гэж нэрлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нийтлэг байдлаар хэрэглэж байна. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.1 дүгээр зүйлд "цахим нотлох баримт"-ыг хуульчлан зохицуулах хэрэгцээ, шаардлага бий болоод байна.

Олон улсын гэрээ, конвенцын тухайд Европын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараах хорих

ял эдлүүлэх ажиллагаан дахь цахим нотлох баримтыг бий болгох, хадгалах журам, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим нотлох баримт цуглуулах үүрэг бүхий байгууллагыг үүсгэн байгуулах, түүний хууль ёсны төлөөлөгчдийг томилох зохицуулалтыг ижилтгэх удирдамж, Кибер гэмт хэргийн тухай Будапештын конвенц, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц ба түүнд заасан протоколууд, Истанбулын протокол (Эрүүдэн шүүх болон бусад хэрцгий, хүнлэг бус буюу нэр төрийг гутаан харьцах, шийтгэхийг үр дүнтэй мөрдөн шалгах, баримтжуулах гарын авлага) зэрэг олон улсын гэрээ, конвенцод "цахим нотлох баримт"-ыг зохицуулж ач холбогдол, агуулгыг нь тодорхойлсон байна.

ХБНГУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим нотлох баримтыг тусгайлан тодорхойлж зохицуулаагүй ч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим нотлох баримтыг ашиглах, үнэлэхийг хориглосон аливаа хязгаарлалт байхгүй буюу хуульд заасан шаардлагыг хангасан тохиолдолд ЭХХША-нд ашиглах боломжтой байна. Нарийвчилсан зохицуулалтын тухайд "Европын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараах хорих ял эдлүүлэх ажиллагаан дахь цахим нотлох баримтыг бий болгох, хадгалах журам"-ыг дагаж мөрддөг байна.

Бүгд Найрамдах Эстони Улсын тухайд нотлох баримтын төрлийг ерөнхийд нь тодорхойлсон тул энэхүү заалтыг үндэслэн цахим хэлбэрийн нотлох баримтыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглах боломжтой байна. Үүний зэрэгцээ, Эстонийн хууль эрх зүйн орчинд цахим (дижитал) нотлох баримтын талаар тусгай журам, тодорхой заалтууд зайлшгүй шаардлагатай байгаа тухай хэлэлцүүлэг хэсэг хугацаанд явагдсан байна. Цахим мэдээлэл нь олон эрүүгийн хэрэгт нотлох баримт болж, ийм нотлох баримтын ач холбогдол улам бүр нэмэгдсээр байгааг олж тогтоосон бөгөөд Хуульчдын холбооноос цахим (дижитал) нотлох баримтыг олж авах, түүнийг ЭХХША-нд ашиглах асуудлыг уламжлалт нотлох баримтаас тусад нь зохицуулах нь зүйтэй гэж үзсэн байна.

АНУ-д цахим нотлох баримтыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглах нь түгээмэл болох нь харагдаж байна. Мөн "цахим нотлох баримт" гэдгийг тодорхойлж өгснөөс гадна үзлэг нэгжлэг хийх, баримтжуулах үйл ажиллагааг Wiretap Act (18 U.S.C. §2510 et seq.); the Pen Registers and Trap and Trace Device Statute (18 U.S.C. §3121 et seq.); Цахим харилцааны нууцлалын тухай хууль (ECPA) (18 U.S.C. §2701 гэх мэт); болон Нууцлалыг хамгаалах тухай хууль (PPA) (42 U.S.C. §2000aa ба бусад) гэх хуулиудаар нарийвчлан зохицуулсан нь боловсронгуй зохицуулалт болжээ. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим нотлох баримтыг тусгахдаа дээрх боловсронгуй зохицуулалтыг жишиг болгон авч үзэх нь зүйтэй.

БНСУ-ын тухайд цахим нотлох баримтыг ангилан тодорхойлдог нь сайн жишиг бүхий зохицуулалт байх ба Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн нотлох бариматтай холбоотой нийтлэг зохицуулалтуудад цахим нотлох баримтыг хамааруулж уялдуулан хуулийг хэрэглэдэг сайн туршлагатай байна. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цахим нотлох баримтын талаар тусгахдаа түүний ангилал болон хууль хэрэглээний талаар сайн жишгийг авч үзэх нь зүйтэй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалалт

Практикт шүүхийн шийдвэрээр тухайн хэрэгт хураагдан ирсэн эд мөрийн баримтыг цаашид хадгалах эсэхийг хэрхэн шийдвэрлэснээс хамаарч нотлох баримтыг хадгалах эсхүл устгах арга хэмжээг авдаг. Цахим нотлох баримтын хувьд практикт ихэвчлэн CD дээр хуулбарлан хавтаст хэрэгт хавсаргадаг бөгөөд энэ нь тухайн хавтас хэргийг хадгалах хугацаатай ижил хугацаанд хадгалагдаж байна. Хавтаст хэргийн хадгалалт буюу дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалал талаар Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2021 оны 5 сарын 20-ны өдрийн А/69 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүгийн хэрэгт хөрөнгө, орлого, эд мөрийн баримт, эд зүйлийг хураан авах, бэхжүүлэх, хадгалах, хамгаалах, шилжүүлэх, шийдвэрлэх журам”, 2019 оны 12 сарын 5-ны өдрийн Дугаар 246, А/80 Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий Прокурорын хамтарсан захирамж, тушаалын нэгдүгээр хавсралтаар “Эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, барьцааны мөнгө, эд мөрийн баримтыг шийдвэрлэх журам”, хоёрдугаар хавсралтаар “Хавтаст хэргийг хүлээн авах, хадгалах, шилжүүлэх журам”, Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2022 оны 4 сарын 15-ны өдөр дугаар А/42 тушаалын нэгдүгээр хавсралтаар “Эрүүгийн хэргийн тусгай, салбар архивд баримт хүлээн авах, тоо бүртгэл хөтлөх, хадгалах, ашиглуулах журам”, хоёрдугаар хавсралтаар “Архивд хөтлөгдөх тоо бүртгэлийн баримт бичиг, мэдээний жагсаалт, загвар”, 2022 оны 1 сарын 6-ны өдрийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоолоор батлагдан “Шүүхийн архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх журам” гэх журмууд хүчин төгөлдөр үйлчилж байна. Иймд эдгээр зохицуулалтыг нэг мөр болгон хуульчилж дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалалтын талаар тогтсон зохицуулалтыг бий болгох нь зүйтэй байна.

Хувийн мэдээллийг автоматаар боловсруулахтай холбоотой хувь хүнийг хамгаалах тухай Европын зөвлөлийн конвенцын 5 дугаар зүйлийн е хэсэгт агуулгыг таних боломжтой хэлбэрээр хадгалагдсан өгөгдлийг тухайн өгөгдлийг хадгалах зорилгод шаардагдах хугацаанаас илүүгээр хадгалж болохгүй талаар зохицуулсан байна.

ХБНГУ-ын тухайд дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийг цахим нотлох баримтад хамааруулан зохицуулж, хадгалалт, хамгаалалтын асуудлыг ерөнхий журмаар зохицуулдаг байна. Нарийвчилсан журмын тухайд нотлох баримтаар авагдаагүй эх баримт бичгийг хадгалах журмыг нарийвчлан зохицуулжээ.

Бүгд Найрамдах Эстони Улсад ЭХХША-ны явцад бэхжүүлж авсан болон цахим хавтаст хэрэгт авагдсан аливаа дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг цахим хэлбэрээр цахим хавтаст хэргийн системд болон биет байдлаар эд мөрийн баримт хадгалах тусгай зориулалт бүхий эрх бүхий байгууллагын байранд нийтлэг журмын дагуу хадгалдаг байна.

БНСУ-ын тухайд дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, шалгалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн ерөнхий зохицуулдаг хэдий ч Ерөнхий прокурорын газраас гаргасан журмаар мөн нарийвчлан зохицуулж байна. Тодруулбал, Шүүхийн баталгаажуулалтын бүртгэлийг хадгалах, яллагдаагүй хэргийн бүртгэлийг хадгалах, гомдол, дотоод хэргийн бүртгэлийг хадгалах, видео

бичлэгийг хадгалах, шүүхийн шийдвэрийг хадгалах гэж нарийвчилсан ангиллыг тогтоож өгсөн байна. Мөн түүнчлэн хэргийн төрлөөс хамааруулан баримт бичгийг жилээр, цаашлаад хөөн хэлэлцэх хугацаагаар тогтоон хадгалдаг байна.

Иймд дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалалтын талаар зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгахдаа хадгалах зорилгод шаардагдах хугацаанаас илүүгээр хадгалж болохгүй талаар зохицуулахаас гадна дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалтыг тусад нь авч үзэн хэргийн төрлөөс хамааруулан баримт бичгийг жилээр, цаашлаад хөөн хэлэлцэх хугацаагаар тогтоон хадгалдаг жишгийг анхаарах нь зүйтэй.

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж

Монгол хэлээр:

1. Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992, №1;
2. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2020, №29;
3. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016, №9;
4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002, №8;
5. Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2021, №5;
6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №23;
7. Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
8. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
9. Монгол Улсын Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 5 сарын 18-ны өдрийн А/24 тушаалаар батлсан “Цахим үндэстэн” баримтлах чиглэл (2022-2027);
10. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 332 дугаар тогтоол;
11. 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоол, Дугаар 31, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөв хэрэглэх албан ёсны тайлбар;
12. 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн УДШ-ийн Ерөнхий шүүгч, ХЗДХ-ийн Сайд, УЕП-ын хамтарсан Дугаар А/18, 34, А/31 “Заавар батлах тухай”;
13. 2019 оны 12 сарын 5-ны өдрийн Дугаар 246, А/80 Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий Прокурорын хамтарсан захирамж, тушаал;
14. 2022 оны 1 сарын 6-ны өдрийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоол Дугаар 1 “Журам батлах тухай”
15. Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2021 оны 5 сарын 20-ны өдрийн А/69 дугаар тушаал;
16. Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2022 оны 4 сарын 15-ны өдөр дугаар А/42 тушаал
17. 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоол, Дугаар 31, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөв хэрэглэх албан ёсны тайлбар

Гадаад хэлээр:

1. Шүүх байгууллагын цахим үйл ажиллагааг дэмжих тухай хууль (Gesetz zur Förderung des elektronischen Rechtsverkehrs mit den Gerichten, 2013)

2. Gesetzentwurf der Bundesregierung BT-Drucksache 17/12634 vom 6. März 2013, S. 3 ff, Verfügbar um https://dserver.bundestag.de/btd/17/126/1712634.pdf
3. ХБНГУ-ын Шүүхийн үйл ажиллагаанд цахим хавтаст хэргийг нэвтрүүлэх, цаашид цахим хууль зүйн үйл ажиллагааг дэмжих тухай хууль (Gesetz zur Einführung der elektronischen Akte in der Justiz und zur weiteren Förderung des elektronischen Rechtsverkehrs, 2017).
4. Beschlussempfehlung und Bericht des Ausschusses für Recht und Verbraucherschutz (6. Ausschuss) zu dem Gesetzentwurf der Bundesregierung, Deutscher Bundestag, Drucksache 18/12203, Wahlperiode 28.04.2017. Verfügbar um https://dserver.bundestag.de/btd/18/122/1812203.pdf
5. ХБНГУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Strafprozeßordnung – StPO, 1987)
6. БНЭсУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Kriminaalmenetluse seadustik, 2003) https://www.riigiteataja.ee/akt/104102013004
7. Framework act on electronic documents and transactions of Korea, https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=27334&type=part&key=28
8. Framework act on electronic documents and transactions of Korea, https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=27334&type=part&key=28
9. Act on the Use of Electronic Documents in Criminal Judicial Procedures [Enforced into force on October 20, 2024] [Law No. 18485, enacted on October 19, 2021], https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%ED%98%95%EC%82%AC%EC%82%AC%EB%B2%95%EC%A0%88%EC%B0%A8%EC%97%90%EC%84%9C%EC%9D%98%EC%A0%84%EC%9E%90%EB%AC%B8%EC%84%9C%EC%9D%B4%EC%9A%A9%EB%93%B1%EC%97%90%EA%B4%80%ED%95%9C%EB%B2%95%EB%A5%A0/(18485,20211019)
10. Regulation (EU) 2023/1543 of the European Parliament and of the Council of 12 July 2023 on European Production Orders and European Preservation Orders for electronic evidence in criminal proceedings and for the execution of custodial sentences following criminal proceedings, https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=uriserv%3AOJ.L_.2023.191.01.0118.01.ENG
11. Directive (EU) 2023/1544 of the European Parliament and of the Council of 12 July 2023 laying down harmonised rules on the designation of designated establishments and the appointment of legal representatives for the purpose of gathering electronic evidence in criminal proceedings, https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=uriserv%3AOJ.L_.2023.191.01.0181.01.ENG
12. Details of Treaty No.185, https://www.coe.int/en/web/conventions/full-list?module=treaty-detail&treatynum=185
13. Convention on Cybercrime Budapest, 23.XI.2001, https://rm.coe.int/1680081561
14. United Nations Convention against Transnational Organized Crime and the Protocols Thereto, https://www.unodc.org/unodc/en/organized-crime/intro/UNTOC.html
15. Manual on the Effective Investigation and Documentation of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment, https://www.ohchr.

org/sites/default/files/documents/pub lications/2022-06-29/Istanbul-Protocol_Rev2_EN.pdf

16. Convention for the Protection of Individuals with regard to Automatic Processing of Personal Data Strasbourg, 28.I.1981, https://rm.coe.int/1680078b37
17. Convention for the Protection of Individuals with regard to Automatic Processing of Personal Data Strasbourg, 28.I.1981, https://rm.coe.int/1680078b37
18. CRIMINAL PROCEDURE ACT OF KOREAN [Enforcement Date 09. Dec, 2021.] [Act No.17572, 08. Dec, 2020., Partial Amendment],https://www.law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2&section=lawNm&qu ery=criminal+procedure&x=0&y=0#liBgcolor1
19. Prosecutor's Office Preservation Rules Partially revised 2021-01-01 Ministry of Justice Ordinance No. 993 amendment, http://www.yeslaw.com/lims/front/page/fulltext.html?pAct=view&pLawId=2408#:~:text =%E2%91%A0%20%EC%A7%84%EC%A0%95%EC%82%AC%EA%B1%B4%EA%B8%B0%EB%A1%9D%EC%9D%80,%EC%9D%80%203%EB%85%84%EA%B0%84%20%EB%B3%B4%EC%A1%B4%ED%95%9C%EB%8B%A4

Ном, сурах бичиг, судалгааны тайлан, эмхэтгэл

Монгол хэлээр:

1. 2023 оны 3 сарын 23-24-ний өдөр зохион байгуулагдсан "Монгол Улсын Шүүхийн цахимжуулалт" ОУБХ-д ЦХХХ-ны дэд сайд Ж.Эрхэмбаатарын хэлэлцүүлсэн "Монгол Улсын шүүхийн болон хуулийн байгууллагуудыг цахимжуулах мэдээлэл технологийн үүрэг" сэдэвт илтгэл;
2. 2023 оны 3 сарын 23-24-ний өдөр зохион байгуулагдсан "Монгол Улсын Шүүхийн цахимжуулалт" ОУБХ-д Н.Отгончимэгийн хэлэлцүүлсэн "Шүүхийн санхүүжилтийн механизмыг шинэчлэх шаардлага" сэдэвт илтгэл;
3. ГХУСАЗЗ, Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2022, 2023 он;
4. Л.Галбаатар, Кибер гэмт хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх нь, 2015 он;
5. Монгол Улсад үйлдэгдэж байгаа кибер гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, түүнтэй тэмцэх арга зам, үндсэн чиглэл /Суурь судалгааны тайлан/, 2015 он;
6. Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын төсөлд хийсэн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ /Хөндлөнгийн судалгаа/, 2023 он;
7. Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын төсөлд хийсэн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ /Хөндлөнгийн судалгаа/, 2023 он;
8. ННФ, Кибер гэмт хэргийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа /Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, үйл ажиллагааны эрсдэлийн хүрээнд/, 2022 он;
9. ННФ, Нотолгооны өнөөгийн практик, арга зүй, техник хэрэгсэл, анхаарах асуудал /Судалгааны тайлан/, 2021 он;
10. Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг (Кибер) гэмт хэргийн гүнзгийрүүлсэн судалгаа, 2019 он;
11. Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг (Кибер) гэмт хэргийн гүнзгийрүүлсэн судалгаа, 2019 он;

Гадаад хэлээр:

1. Digital Evidence and the U.S. Criminal Justice System: Identifying Technology and Other Needs to More Effectively Acquire and Utilize Digital Evidence. Sean E. Goodison, Robert C. Davis, and Brian A. Jackson. https://www.ojp.gov/pdffiles1/nij/grants/248770.pdf
2. Eneli Lauritis, “Criminal procedure and digital evidence in Estonia”, Digital Evidence and Electronic Signature Law Review, 13 (2016)
3. European Judicial Network, Fiches Belges on electronic evidence Germany. Available at.https://www.ejn-crimjust.europa.eu/ejnupload/DynamicPages/FB-EEGermany.pdf
4. Manual on the Effective Investigation and Documentation of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment, https://www.ohchr.org/sites/default/files/documents/pub lications/2022-06-29/Istanbul-Protocol_Rev2_EN.pdf
5. Эрик Хилгендорф, “Цахим нотлох баримт танилцуулга” сургалтын орчуулга, 2023.09.15.

Цахим эх сурвалж

Монгол хэлээр:

1. “Эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, барьцааны мөнгө, эд мөрийн баримтыг шийдвэрлэх журам”, “Хавтаст хэргийг хүлээн авах, хадгалах, шилжүүлэх журам” http://old.supremecourt.mn/act/view/266
2. Г.Даваадорж: Шүүхийн цахимжилтад хууль эрх зүйн орчин ус агаар мэт хэрэгтэй байна, https://www.judcouncil.mn/site/news_full/13818
3. М.Бямбасүрэн, Цахим баримт бичгийг нотлох баримтын хэмжээнд үнэлдэг байх шаардлагатай нийтлэл, 2024.01.29, https://business.mn/2024/01/29/m-byambasuren-tsahim-barimt-bichgiig-notloh-barimtiin-hemjeend-uneldeg-baih-shaardlagatai/
4. Цахим орчин дахь гэмт хэргийн ул мөрийг баримтжуулж авах нь, https://www.mnb.mn/i/92447
5. Ш.Мөнхжаргал, Л.Уянга, Б.Нямцэрэн нар, Нотлох баримт, түүнийг үнэлэхтэй холбоотой эрх зүйн эх сурвалжуудыг судалж бичсэн, асуудал дэвшүүлсэн өгүүлэл, https://legaldata.mn/buteel/pdf?id=1761

Гадаад хэлээр:

1. Beschlussempfehlung und Bericht des Rechtsausschusses zu dem Gesetzentwurf der Bundesregierung Drucksache 17/12634 – vom 12. Juni 2013, Verfügbar um https://dserver.bundestag.de/btd/17/139/1713948.pdf
2. Verordnung über die elektronische Aktenführung in der Hamburger Justiz (HmbEAktFVO, 2019) Verfügbar um https://www.landesrecht-hamburg.de/bsha/document/jlr-JElektAktfVHAV9Anlage1/part/X
3. Elektronische Akte in der Justiz, 2024.02.28, https://justiz.hamburg.de/e-justice/elektronische-akte-in-der-justiz zuletzt besucht 2024.03.20.

4. Factsheet E-Justice. Available at https://e-estonia.com/wp-content/uploads/2020mar-facts-a4-v04-e-justice.pdf
5. БНЭсУ-ын Шүүхийн мэдээллийн системийн, https://www.rik.ee/en/international/court-information-system
6. БНЭсУ-ын Шүүхийн олон нийттэй харилцах порталын вебийн https://www.rik.ee/en/international/public-e-file
7. Electronic Filing in Criminal Actions and Proceedings: A REPORT TO THE GOVERNOR, LEGISLATURE AND CHIEF JUDGE, page 10 https://ww2.nycourts.gov/sites/default/files/document/files/2018-06/eFile_Criminal_Report%20April%2019.pdf
8. Electronic Filing (CM/ECF), https://www.uscourts.gov/court-records/electronic-filing-cmecf
9. Electronic Filing in Criminal Actions and Proceedings: A REPORT TO THE GOVERNOR, LEGISLATURE AND CHIEF JUDGE, page 8 https://ww2.nycourts.gov/sites/default/files/document/files/2018-06/eFile_Criminal_Report%20April%2019.pdf
10. 미리 보는 형사전자소송, https://help.scourt.go.kr/nm/min_9/min_9_9/index.html
11. E-evidence - cross-border access to electronic evidence Improving cross-border access to electronic evidence, https://commission.europa.eu/law/cross-border-cases/judicial-cooperation/types-judicial-cooperation/e-evidence-cross-border-access-electronic-evidence_en
12. European Judicial Network, Fiches Belges on electronic evidence Estonia. Available at https://www.ejn-crimjust.europa.eu/ejnupload/DynamicPages/EE%20electronic%20evidence%20fb.pdf
13. 형사절차상 digital evidence 에 관한 연구 - 압수, 수색을 중심으로 - Digital Evidence in Criminal Procedure, pp.21, https://www.kicj.re.kr/boardDownload.es?bid=0001&list_no=9714&seq=1
14. 전문법칙 관련 비디오테이프 등의 증거능력, https://blog.naver.com/duckhee2979/220751969840
15. 성폭행피해아동의 진술녹화 비디오테이프의 증거능력, https://www.lawtimes.co.kr/news/104776
16. 증거보전, https://namu.wiki/w/%EC%A6%9D%EA%B1%B0%EB%B3%B4%EC%A0%84

ХАВСРАЛТ. ХБНГУ-ын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”-ийн цахим хавтаст хэргийн зохицуулалт (албан бус орчуулга)

ХБНГУ-ЫН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ (STRAFPROZESSORDNUNG – STPO)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Гарчиг 4

Хавтаст хэргийн удирдлага ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь харилцаа холбоо

32-р хэсэг

Цахим хавтаст хэргийн удирдлага, түүнтэй холбоотой хуульд заасан арга хэмжээ авах бүрэн эрх

(1) Хавтаст хэргийг цахим хэлбэрээр (цахим хэлбэрт шилжүүлэн) хадгалж болно. Холбооны болон муж улсын (орон нутгийн) засгийн газар тус бүр өөрийн харьяалах нутаг дэвсгэртээ хавтаст хэргийн цахимаар хадгалагдах хугацааг хуульд заасан арга хэрэгслээр тогтооно. Засгийн газрууд нь цахим хавтаст хэргийн удирдлагыг зарим бие даасан шүүх, прокурорын байгууллага, ерөнхий тодорхойлсон процесс ажиллагаанд нэвтрүүлэхийг хязгаарлах, цаасан хэлбэрээр хадгалагдаж байсан хавтаст хэрэгт цахим хэлбэрийг нэвтрүүлсэн ч үргэлжлүүлэн цаасан хэлбэрээр хадгалах зэрэг хязгаарлалт хийнэ. Ийм хязгаарлалт хийж байгаа тохиолдолд олон нийтэд ямар мэдэгдэл илгээх, ямар процесс ажиллагаанд ямар материалыг цахим хэлбэрээр хадгалах зэргийг хуульд нийцүүлэн гаргасан захиргааны журам батлан зохицуулж болно. Уг журам боловсруулах, тогтоох, мөрдүүлэх бүрэн эрхийг хуульд заасан арга хэрэгслээр (хуульд нийцүүлэн) эрх бүхий холбооны эсхүл муж улсын (орон нутгийн) яамдад шилжүүлж болно.

(2) Холбооны засгийн газар болон муж улсын (орон нутгийн) засгийн газар тус бүр өөрийн харьяалах нутаг дэвсгэртээ холбогдох хууль тогтоомжийн мэдээллийн хамгаалалт, мэдээллийн аюулгүй байдал, мөрдлөг болгох хүртээмжтэй байдлын шаардлагууд зэргийг багтаасан орчин үеийн дэвшилтэт байдал, байгууллагын болон техникийн үзүүлэлтийг хангасан цахим хавтаст хэргийн удирдлагыг батлан дагж мөрдүүлнэ. Уг эрхээ холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий холбооны эсхүл муж улсын (орон нутгийн) яамдад шилжүүлж болно.

(3) Холбооны засгийн газар хуульд заасны дагуу Бундесратаас шаардлагатай зөвшөөрлийг авсны үндсэн дээр прокурорын байгууллага болон шүүхийн хооронд цахим хавтаст хэрэг дамжуулахад мөрдөх стандартыг батална. Энэ нь Бундесратын зөвшөөрөл авах шаардлагагүй хуульд заасан арга хэрэгсэл байвал энэ бүрэн эрхийг холбооны эрх бүхий яамдад шилжүүлнэ.

Хэсэг 32а

Прокурорын байгууллагууд болон шүүхүүдийн цахим харилцаа холбоо; хуульд заасан арга хэмжээ авах бүрэн эрх

(1) Прокурорын байгууллага, шүүхүүд нь цахим баримт бичгийг дараах дэд зүйлд заасны дагуу гаргаж болно.

(2) Цахим баримт бичиг нь прокурорын байгууллага эсвэл шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгдэхэд тохиромжтой байх ёстой. Холбооны засгийн газар Бундесратаас хуульд заасан шаардлагатай зөвшөөрлийг авсны үндсэн дээр цахим баримт бичгийг дамжуулах техникийн үзүүлэлтүүд, тэдгээрийг прокурорын байгууллага болон шүүхүүдийн хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгдэхэд тохиромжтой байдал зэргийг тогтооно.

(3) Баримт бичгийг цахим хэлбэрээр хадгалахад тэдгээрийг хариуцах этгээдийн мэргэжлийн цахим гарын үсэгтэй эсхүл хариуцах этгээдийн гарын үүсгээ зурж дамжуулах аюулгүй аргаар ирүүлсэн бичмэл хувь байх шаардлагатай.

(4) ‘Дамжуулах аюулгүй арга’ гэдэг нь

1. De-Mail бүртгэлтэй холбогдсон шуудангийн хайрцаг болон шуудангийн үйлчилгээ бол илгээгч нь шуудангийн тухай хуулийн (De-Mail-Gesetz) 4 (1) хэсгийн 2-т заасны дагуу шууданг илгээх үед аюулгүй нэвтрэлт хийсэн бол шуудангийн тухай хуулийн 5 (5) дахь хэсэгт заасны дагуу аюулгүй нэвтэрсэн эсэхээ баталгаажуулсан,
2. Холбооны хуульчдын тухай хуулийн (Bundesrechtsanwaltsordnung) 31a, 31b хэсэгт заасан хууль зүйн тусгай шуудан эсхүл хуулийн дагуу байгуулагдсан цахим шуудан болон эрх бүхий байгууллага, шүүх хоорондын цахим шуудангийн сүлжээгээр ,
3. Эрх бүхий байгууллага болон шүүхийн цахим шууданг зохицуулах сүлжээгээр баталгаажуулсан эрх бүхий байгууллага болон нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн хоорондын шуудан дамжуулах аргаар,
4. Эрх бүхий байгууллага, шүүхийн цахим шуудангийн сүлжээгээр баталгаажуулах ажиллагаа хийсний үндсэн дээр байгуулагдсан хувь хүн, хуулийн этгээд болон бусад этгээд хоорондын цахим шуудан амжуулах аргаар,
5. Онлайн хандалтын тухай хуулийн (Onlinezugangsgesetz) 2(5)-д заасны дагуу хэрэглэгчийн бүртгэл болон эрх бүхий байгууллага эсвэл шүүхийн цахим шуудангийн сүлжээнд холбогдсон, баталгаажуулах ажиллагаа хийж баталгаажуулсны үндсэн дээр байгуулагдсан шуудангийн хаяг болон шуудангийн үйлчилгээ хооронд дамжуулах аргаар,
6. Холбооны улсын хэмжээнд стандартчилагдсан, Бундесратаас зөвшөөрөл аван Холбооны Засгийн газраас гаргасан хууль тогтоомжоор тогтоосон мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдал, хүртээмжтэй байдлыг баталгаажуулсан дамжуулах бусад аргууд.

(5) Цахим баримт бичгийг эрх бүхий байгууллага, шүүх хүлээн авахаар заасан төхөөрөмжид хадгалмагц хүлээн авсанд тооцно. Илгээгч нь хүлээн авсан огноо, цагийг автоматаар баталгаажуулах болно.

(6) Хэрэв илгээгдсэн барим бичиг нь эрх бүхий байгууллага болон шүүх боловсруулах, ашиглагдах боломжгүй байвал энэ талаар илгээгчид нэн даруй мэдэгдэл илгээх ёстой бөгөөд баримт бичгийг хүлээн авах боломжгүй шалтгааныг мэдэгдэлд дурдана. Цахим баримт бичгийг илгээгч нь эрх бүхий байгууллага, шүүх боловсруулахад тохиромжтой хэлбэрээр нэн даруй дахин ирүүлсэн бөгөөд илгээгч нь анх ирүүлсэн баримт бичгийн агуулгатай дахин ирүүлсэн баримт бичгийн агуулга таарч байгааг хангалттай нотолсон тохиолдолд түүнийг өмнө нь ирүүлсэн өдөр, цагт хүлээн авсанд тооцно.

Хэсэг 32b

Прокурорын байгууллага, шүүхийн ашиглаж буй цахим баримт бичгийг бүрдүүлэх, дамжуулах; хуульд заасан арга хэмжээ авах эрх

(1) Прокурорын байгууллага, шүүхээс ашигласан баримт бичгийг цахим баримт бичиг болгон бүрдүүлсэн бол уг баримт бичгийг хариуцаж буй бүх хүмүүс уг баримт бичигт нэрээ нэмж оруулах ёстой. Гарын үсэг зурах шаардлагатай баримт бичиг нь тэдгээрийг хариуцах бүх хүмүүсийн мэргэшсэн цахим гарын үсэгтэй байх ёстой.

(2) Цахим баримт бичигийг түүнийг хариуцах эрх бүхий этгээд цахим хавтаст хэрэгт нэмсэн болон ийм этгээд хадгалуулсан даруйд уг хавтаст хэрэгт нэмэгдсэнд тооцно.

(3) Хэрэв хавтаст хэргийг цахим хэлбэрээр хөтөлж байгаа бол прокурорын байгууллага болон шүүх нь журмын дагуу баримт бичгийг өөр хоорондоо цахим хэлбэрээр дамжуулна. Яллах дүгнэлт, үндсэн хуралдаанаас гадуур шийтгэл оногдуулах тухай хүсэлт, баримт болон хууль хэрэглээний асуудлаар давж заалдах гомдол, тайлбар, хариу тайлбар, шүүхийн аливаа шийдвэрүүд цахим хэлбэрээр бүрдүүлэгдсэн бол цахим хэлбэрээр дамжуулна. Техникийн шалтгаанаар үүнийг түр хугацаанд хийх боломжгүй бол цаасан хэлбэрээр дамжуулахыг зөвшөөрнө; хүсэлтийн дагуу цахим баримт бичгийг дараа нь ирүүлнэ.

(4) Хуулбар болон баталгаат хуулбарыг цахим эсхүл цаасан хэлбэрээр гаргаж болно. Цахимаар баталгаажуулсан хуулбар нь хуулбарыг баталгаажуулсан хүний цахим гарын үсэгтэй байх ёстой. Мэргэшсэн цахим гарын үсэг бүхий цахим баримт бичгийг шилжүүлэх, эсвэл найдвартай дамжуулах замаар баталгаажуулсан хуулбарыг цаасан хэлбэрээр олгосон бол уг баримт бичгийг баталгаажуулсан тэмдэглэлд цахим баримт бичгийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг шалгасны үр дүнг тусгасан байх ёстой.

(5) Холбооны засгийн газар хуульд заасны дагуу Бундесратаас шаардлагатай зөвшөөрлийг авсаны үндсэн дээр цахим баримт бичгийг бүрдүүлэх, түүнийг прокурорын байгууллага болон шүүх хоорондамжуулахад хамаарах стандартыг тогтооно. Энэ нь Бундесратын зөвшөөрөл авах шаардлагагүй

хуульд заасан арга хэрэгсэл байвал энэ бүрэн эрхийг холбооны эрх бүхий яамдад шилжүүлнэ.

Хэсэг 32c

Цахим хэлбэр; хуульд заасан арга хэмжээ авах эрх

Холбооны засгийн газар хуульд заасны дагуу Бундесратаас шаардлагатай зөвшөөрлийг авсаны үндсэн дээр цахим хэлбэрийг нэвтэрүүлж болно. Хуульд заасан арга хэрэгслээр маягтанд агуулагдах мэдээллийг бүтнээр эсхүл хэсэгчлэн, бүтцээр нь болон машинд уншигдахуйц хэлбэрээр дамжуулах зэрэг асуудлыг зохицуулж болно. Маягт нь хууль тогтоомжид заасан интернет харилцааны платформ дээр ашиглах боломжтой хэлбэрт байна. Хуулийн 32a(3) дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд иргэний үнэмлэхний тухай хуулийн (Personalausweisgesetz) 18-р зүйл, цахим иргэний үнэмлэхний тухай хуулийн 12-р хэсэг (eID-Karte-Gesetz), Оршин суух тухай хуулийн (Aufenthaltsgesetz) 78 (5) дахь хэсэгт заасны дагуу маягтын хэрэглэч нь үнэмлэхээ цахим үнэмлэхээр гаргаж болно. Холбооны засгийн газар нь Бундесратын зөвшөөрөл авах шаардлагагүй хуульд заасан арга хэрэгсэл байвал энэ бүрэн эрхийг холбооны эрх бүхий яамдад шилжүүлнэ.

Хэсэг 32d

Цахим дамжуулалтын үүрэг

Хуульч, өмгөөлөгч нь бичгээр өгсөн тайлбар, түүний хавсралт, хүсэлт, мэдэгдэл зэрэг цахим баримт бичгийг холбогдох журамд заасны дагуу прокурорын байгууллага болон шүүхэд цахим хэлбэрээр гаргана. Хуульч, өмгөөлөгч нь баримт болон хууль хэрэглээтэй холбоотой давж заалдах гомдол, хууль зүйн үндэслэлтэй холбоотой давж заалдах гомдол, тэдгээрийн үндэслэл, хариу тайлбар, хувийн яллах ажиллагаа ба яллах ажиллагааны нэмэлт гомдолын мэдэгдэл зэргийг шүүхэд цахим хэлбэрт оруулан ирүүлнэ. Хэрэв техникийн шалтгаанаар үүнийг түр хугацаанд хийх боломжгүй бол цаасан хэлбэрээр ирүүлэхийг зөвшөөрнө. Ийнхүү шалтгаанаар баримт бичгийг цахим хэлбэрээр гаргах боломжгүй шалтгаанаа барим бичгийг цаасан хэлбэрээр гаргахдаа тайлбар,хүсэлт гарган нотлох шаардлагатай бөгөөд уг хүсэлтийг үндэслэн цахим баримт бичгийг дараа нь нөхөн ирүүлнэ.

Хэсэг 32e

Хавтаст хэргийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор барим бичгийг хувиргах (хөрвүүлэх)

(1) Тухайн хавтаст хэргийг хадгалж буй хэлбэртэй (эх барим бичигтэй) баримт бичиг нь тохирохгүй байвал тохирох хэлбэрт тус баримт бичгийг хөрвүүлж болно. Нотлох баримт болгон баталгаажуулсан эх баримт бичгийг зохих шаардлагатай хэлбэрт шилжүүлж болно.

(2) Баримт бичгийг хөрвүүлэхдээ хөрвүүлсэн баримт бичиг нь харагдах байдал болон агуулгын хувьд эх баримт бичгийн агуулгатай тохирох байдлыг хангахуйц хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглана.

(3) Цахим бус эх баримт бичгийг цахим баримт бичиг болгон хөрвүүлэхдээ хөрвүүлэхэд ямар процедур ашигласан, энэ нь эх баримт бичигтэй харагдах байдал болон агуулгатай тохирч байгаа зэргийг нотлох баримтыг хавсаргана. Прокурорын байгууллага болон шүүхэд хэрэглэгдэж байсан, хариуцах үүрэг бүхий этгээдийн гарын үсэг зурсан баримт бичгийг хөрвүүлэх тохиолдолд хөрвүүлэлтийг нотлох баримт нь прокурорын газар, шүүхийн бүртгэлийн ажилтны мэргэшсэн цахим гарын үсэгтэй байх ёстой. Мэргэшсэн цахим гарын үсэг бүхий эсхүл дамжуулах аюулгүй аргаар ирүүлсэн цахим эх баримт бичгийг уг баримт бичигт хийсэн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг шалгасан шалгалтын дүнгийн хаитаар хавтаст хэрэгт бичилт хийн оруулна.

(4) Үргэлжилж буй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтаар хадгалагдаагүй эх баримт бичгийг хөрвүүлснээс хойш дор хаяж зургаан сар хадгална. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дууссан, эсхүл хугацаа хэтэрсэн тохиолдолд нотлох баримтаар хадгалагдаагүй эх баримт бичгийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дууссанаас хойшхи хуанлийн хоёр дахь жилийг дуустал хадгалах боломжтой.

(5) Нотлох баримтаар хадгалагдаагүй эх баримт бичгийг баталгаатай нотлох баримтад хамаарах нөхцөлөөр шалгаж болно. Хавтаст хэргийг шалгах эрх бүхий этгээд нь энэ төрлийн шалгалтыг хийх бүрэн эрхтэй.

Хэсэг 32f

Хавтаст хэргийн шалгалт (Танилцах буюу хандах эрх); хуульд заасан арга хэмжээ авах эрх

(1) Цахим хавтаст хэрэгт хандах эрхийг хэргийн хяналт шалгалт гэдэг нь хавтаст хэргийн агуулгыг сэргээх эсхүл аюулгүй дамжуулах аргыг ашиглан хавтаст хэргийн агуулгыг дамжуулах замаар олгоно. Тусгай хүсэлтийн дагуу албан байранд хадгалагдаж буй цахим хавтаст хэрэгт хандах эрхийг олгож болно. Тодорхой шалтгаан буюу хүсэлт гаргагчийн ашиг сонирхол байгаа гэсэн үндэслэл бүхий хүсэлтийн дагуу хавтаст хэргийн хэвлэмэл хуулбарыг олгох эсхүл цахим хавтаст хэргийн агуулгыг агуулсан өгөгдөл зөөгчийг дамжуулна. Хэрэв 1 дүгээр өгүүлбэрт заасан журмаар хавтаст хэрэгт хандах (шалгахад) саад болж байгаа чухал шалтгаан бол 2, 3 дугаар өгүүлбэрт заасан журмаар хүсэлт гаргахгүйгээр шалгалтыг хийж болно.

(2) Цаасан хэлбэрээр байгаа хавтаст хэрэгт хандах (хандах) эрхийг албаны байранд хадгалагдаж буй хавтаст хэргийг шалгах замаар олгоно. Хориглох чухал шалтгаан байхгүй бол хавтаст хэргийн агуулгыг сэргээх, аюулгүй дамжуулах аргыг ашиглан хавтаст хэргийн агуулгыг дамжуулах, хавтаст хэргийн хуулбарыг авч явах боломжтой болгох замаар хавтаст хэрэгт хандах эрхийг олгож болно. Өмгөөлөгч болон хуульчид нь хориглох онцгой шалтгаан байхгүй бол хүсэлт гарган өөрийн аж ахуйн нэгж, хувийн байрандаа хавтаст хэрэгтэй танилцах зорилгоох (шалгахаар) авч болно.

(3) (1) ба (2)-т заасны дагуу хавтаст хэрэгт хандах эрх олгох хэлбэрийн талаархи шийдвэрийг давж заалдах боломжгүй.

(4) Хавтаст хэргийг шалгах (танилцах зорилгоор хандах буюу нэвтрэх) үед нээлттэй байхад гуравдагч этгээд хавтаст хэргийн агуулгын талаарх мэдээлэл олж авах боломжгүй байлгахын тулд техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээг авна. Хавтаст хэрэгт хандах эрх олгосон хүний нэрийг техникийн арга хэрэгслийг ашиглан нэвтэрсэн файлууд болон дамжуулсан цахим баримт бичигт орчин үеийн шаардлагад нийцүүлэн таних боломжтой болгоно.

(5) Хавтаст хэрэгтэй танилцах эрх авсан этгээд нь (1) эсвэл (2) дэд хэсгийн дагуу өөрт нь хүлээлгэн өгсөн хавтаст хэрэг, баримт бичиг, цаасан хуулбар, хуулбарыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн олон нийтэд түгээх болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас бусад зорилгоор гуравдагч этгээдэд дамжуулахыг хориглоно. Хавтаст хэрэгтэй танилцах эрх авсан этгээд нь (1) эсвэл (2) дахь дэд хэсэгт заасны дагуу олж авсан хувийн мэдээллээ зөвхөн хавтаст хэрэгт хандах зөвшөөрөл олгосон зорилгоор ашиглаж болно. Хавтаст хэрэгт хандах эрх олгосон хүмүүс уг зорилгын хязгаарлалтыг.

(6) Холбооны Засгийн газар Бундесратаас зөвшөөрөл авсны үндсэн дээр цахим хавтаст хэрэгт шалгахад (танилцах буюу хандах эрх олгоход) хамаарах стандартыг журмаар тогтооно. Бундесратаас зөвшөөрөл авалгүйгээр тус бүрэн эрхийг холбооны эрх бүхий яамдад хуулийн дагуу шилжүүлж болно.

НАЙМДУГААР БҮЛЭГ
МЭДЭЭЛЛИЙН ХАМГААЛАЛТ БА ХЭРЭГЛЭЭ

Гарчиг 4
Цахим хавтаст хэрэг дэх хувийн мэдээллийг хамгаалах; цахим хавтаст хэргээс гаргаж авсан хувийн мэдээллийг ашиглах

496-р хэсэг

Цахим хавтаст хэрэг дэх хувийн мэдээллийг ашиглах

(1) Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай бол цахим хавтаст хэрэг эсхүл хавтаст хэргийн цахим хуулбар дахь хувийн мэдээллийг боловсруулах, ашиглахыг зөвшөөрнө.

(2) Ийнхүү хувийн мэдээлийг ашиглахдаа,

1. Мэдээллийн хамгаалалт, мэдээлийн аюулгүй байдалын тусгай шаардлагыг хангахад шаардлагатай зохион байгуулалтын болон техникийн зохих арга хэмжээг авах, мөн

2. Мэдээллийг (өгөгдлийг) зөв боловсруулах зарчмуудыг дагаж мөрдөх, тэр дундаа өгөгдлийг байнга бэлэн байлгах, мэдээлэл алдагдхаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллана.

(3) Цахим хавтаст хэрэг болон хавтаст хэргийн цахим хуулбар гэдэгт энэ бүлгийн гарчиг 2 дахт хавтаст хэргийн систем хамаарахгүй.

497-р хэсэг

Мэдээллийг (өгөгдөлийг) түүний хянах этгээдийн нэрийн өмнөөс боловсруулах

(1) Төрийн байгууллага цахим хавтаст хэрэг хадгалагдаж буй мэдээлэл (өгөгдөл) боловсруулах төрөөрөмжид нэвтрэх болон нэвтрэх эрхийг хуульд заасны дагуу бодитоор болон дагнан хянаж байгаа бол хувийн хуулийн этгээдээр хуульд заасны дагуу цахим файлыг байнгын хадгалах үүрэг өгч болно.

(2) Хэрэв үйлчлүүлэгч өмнө нь хувь хүний хувьд зөвшөөрсөн бол хувийн хуулийн этгээдийг цахим хавтаст хэргийг хуульд заасны дагуу байнгын хадгалахтай холбоотой туслан гүйцэтгэх харилцаанд орохыг зөвшөөрнө. Мэдээлэл боловсруулах төхөөрөмжид нэвтрэх, нэвтрэх эрхийг энэ хэсгийн (1)-т заасны дагуу туслан гүйцэтгэх гэрээгээр зохицуулсан тохиолдолд л зөвшөөрлийг олгоно.

(3) Төрийн бус байгууллагын нэрийн өмнөөс мэдээлэл боловсруулдаг хувийн хуулийн этгээдийн мэдээлэл боловсруулдаг тахөөрөмжийг хураан авах, битүүмжлэхийг хориглоно. Ийм төхөөрөмжийг хураан авах ажиллагааг хийхийн тулд төлөөлүүлэн мэдээлэл боловсруулах ажилаа гүйцэтгүүлж буй төрийн байгууллагын зөвшөөрлийг заавал авсан байна.

498-р хэсэг

Цахим хавтаст хэргээс гаргаж авсан хувь хүний мэдээллийг ашиглах

(1) Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэхэд ашиглахыг зөвшөөрсөн эсхүл хуульд заасны дагуу гаргасан шийдвэрээр зөвшөөрсөн бол цахим хавтаст хэрэг эсхүл хавтаст хэргийн цахим хуулбараас гаргаж авсан хувийн мэдээллийг боловсруулах, ашиглахыг зөвшөөрнө.

(2) Дан хавтаст хэрэг эсхүл түүний хуулбараас болон анх хувьчилсан хавтаст хэргийг ашиглан хийгээгүй тохиолдолд уг хуулийн 98с хэсэгт заасны дагуу хувийн мэдээллийг цахим хавтаст хэрэг эсхүл хавтаст хэргийн цахим хуулбартай автоматаар тохируулахыг хориглоно.

499-р хэсэг

Хавтаст хэргийн цахим хуулбарыг устгах

(1) Хавтаст хэргийн цахим хуулбарыг шаардлагагүй болсон даруйд цаг алдалгүй устгана.

ГУРАВ. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭ

(Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 18 дугаар тогтоол)

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Хууль зүйн ухааны доктор (Dr.jur.)

Судалгааны багийн бусад гишүүд:

М.Түвшинжаргал	Эрдэмтэн нарийн бичгийн дарга Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
О.Энххүслэн	Эрдэм шинжилгээний ахлах ажилтан (LL.M)
Б.Ариунжаргал	Эрдэм шинжилгээний ажилтан (LL.M)

Судалгааг захиалагч: Хууль зүй, дотоод хэргийн яам

Судалгааг гүйцэтгэж хүргүүлсэн огноо: 2024.05.13.

АГУУЛГА

УДИРТГАЛ 171

НЭГ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ 176

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ 177

2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал 177

2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал 178

2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал 178

2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал. 179

2.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал 179

ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ 181

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал 182

3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал 195

3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал 202

3.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал . . 203

3.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал 224

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ 226

НОМ ЗҮЙ 231

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 18 дугаар тогтоолын 1-д хүний эрхийг хангахтай холбоотой 14 асуудлыг судалж, холбогдох хуулийн төслийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн боловсруулж 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасан.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлд “3(b).Хүн бүр өөрийг нь яллагдагчаар татсан аливаа эрүүгийн хэргийг хянан хэлэлцэхэд бүрэн тэгш эрхийн үндсэн дээр өмгөөлүүлэх ажлаа бэлтгэх хүрэлцээтэй хугацаа, бололцоотой байх, сонгож авсан өмгөөлөгчтэйгөө харилцах баталгаагаар хангагдах эрхтэй” гэж заасан.[1]

НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн дүгнэлт болон Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын 22 дахь илтгэлд тусгасан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх шаардлага тулгараад байна.

Тухайлбал, НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгээс өгсөн дүгнэлтэд “Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 10 дугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 (1) ба 14 (3) (b) зүйлд нийцүүлэн өмгөөлөгч шүүхийн өмнөх шатны ажиллагаа зэрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх бүх шатанд хэргийн материалтай танилцах адил тэгш эрхээр хангах, өмгөөлөгч хэргийн материалыг хуулбарлах боломжийг олгох;” гэж зөвлөсөн.[2]

Улсын Их Хурлын 2024 оны “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 05 дугаар тогтоолын 1 дэх заалтын 1 дүгээрт “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээлэл хариуцагч нь өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх, хүн, хуулийн этгээд, төрийн байгууллага хоорондоо цахим хэлбэрээр харилцах боломжийг олгосон зохицуулалтыг Иргэний хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид тусгах талаар хуулийн төсөл боловсруулж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын эээлжит чуулганы хугацаанд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;” гэж тусгасан.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах дараах практик хэрэгцээ, шаардлага тулгараад байна.

-Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 10 дугаар дүгнэлтэд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрхийг үндэслэлгүй хязгаарласан шинжгүй, хууль зүйн процессын суурь

1 Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 14 дүгээр зүйл 3 дахь хэсэг.

2 Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсэг: Монголд хийсэн айлчлалын урьдчилсан дүгнэлт,https://www.ohchr.org/sites/default/files/documents/issues/detention-wg/country-visit/2022-10-13/EOM_statement_Visit_Mongolia_14Oct2022_Mongolian.pdf

зарчмуудад нийцсэн байх ёстой. Энэ утгаараа хуульд гэмт хэрэгт сэрдэгдэж байгаа этгээдийн эрх зүйн байдлыг дээрх хуулиар нарийвчлан зохицуулж өгөөгүйн улмаас тухайн этгээдээс гэрчийн мэдүүлэг авч, түүний эрхийг хөндөх байдал гаргахаар байгааг хууль тогтоогч анхаарч, хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага байна...” гэж дүгнэсэн байдаг.

Хүнийг гэмт хэрэгт сэжиглэх илэрхий, хангалттай үндэслэл байсаар атал гэрчээр мэдүүлэг авсны дараа баривчлах, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэний дараа сэжигтэн болгох нь Үндсэн хуулиар баталгаажсан “өөрийгөө өмгөөлөх” эрх, “өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно” гэж заасантай нийцэхгүй тул гэрчээр мэдүүлэг авч байх үед гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл тогтоогдвол мэдүүлэг авах ажиллагааг зогсоож, сэжигтнээр мэдүүлэг авах ажиллагааг хуульд заасны дагуу явуулах зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.

-Практикт хойшлуулшгүй ажиллагааны хүрээнд мэдүүлэг авах ажиллагааг өмгөөлөгчгүйгээр явуулж, хууль бусаар хэрэг хүлээлгэх, өөрийнх нь эсрэг мэдүүлэг авах тохиолдлууд цөөнгүй гарч байгаатай холбоотойгоор сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчлах тохиолдолд өмгөөлөгч заавал оролцуулах асуудлыг хуулиар баталгаажуулах шаардлага тулгараад байна.

-Шүүх хуралдаан хойшилж буй шалтгаан нөхцөлийн дийлэнх нь өмгөөлөгчтэй холбоотой болох нь шүүхийн практикт хийсэн судалгаагаар харагддаг бөгөөд шүүх хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа хойшлуулж байгаа нөхцөл байдлыг хязгаарлах үүднээс өмгөөлөгчийн хариуцлагатай холбоотой асуудлыг хуульчлах шаардлагатай байна.

Түүнчлэн шүүгдэгчийн гэм буруутай эсэхийг хянан хэлэлцэх үндсэн шүүх хуралдааны бэлтгэлийг талуудын оролцоотой хангаж, шүүх хуралдаан хойшлогдох явдлыг багасгах зорилгоор 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах журмыг шинээр хуульчилсан бөгөөд мөн хуулийн 33.1 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт “Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт оролцох хүсэлт гаргасан тохиолдолд хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг оролцуулж болно. Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч ирээгүй нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болохгүй.” гэж заасан.

Ийнхүү шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг шүүх нэг удаа явуулах агуулгаар дээрх заалтыг хуульчилсан боловч хуулийн буруу хэрэглээ тогтож, оролцогч ирээгүй нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг удаа дараа хойшлуулах шалтгаан болсоор байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүх хуралдааныг хойшлуулахад талуудын санал, хүсэлтийг харгалзан дараагийн шүүх хуралдааны товыг тогтоож, хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээг авна.” гэж заасан ба шүүхийн практикт шүүх хуралдааныг 1 сар, түүнээс илүү хугацаагаар хойшлуулах явдал гарсаар байна.

Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх ашигт сөргөөр нөлөөлж байх тул шүүх хуралдааныг түргэн, шуурхай явуулах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

-Тухайн хэргийн ээдрээ төвөгтэй байдал, эсхүл ажиллагаа ихтэй, олон яллагдагчтай, эсхүл олон үйлдэлтэй зэрэг нөхцөл байдлыг харгалзан шаардлагатай тохиолдолд мөрдөн байцаалт явуулах хугацааг сунгаж болох зохицуулалтыг хуульчилсан боловч олон оролцогчтой хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг хэрхэн, ямар журмаар явуулах нь тодорхойгүй байх тул нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

-Хавтаст хэргийг цахимжуулах, цахим хэрэгсэл ашиглаж нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, хадгалах, үнэлэх хэрэгцээ, шаардлага нь өнөө цагт тулгамдсан асуудал болж байгаа бөгөөд хавтаст хэргийг цахимжуулах нь цаасан суурьтай бичиг баримт, нотлох баримтыг боловсруулахад шаардагдах зардал, цаг хугацааг бууруулах ач холбогдолтой юм.

Иймд тус ажиллагааг процессжуулах, хуульчлах хэрэгцээ, шаардлага тулгараад байна. Тухайлбал, олон оролцогчтой хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд прокурорын яллах дүгнэлтийг хуулбарлан гардуулж өгөхөд ихээхэн зардал, цаг хугацаа шаардагддаг.

-Шүүхийн шийдвэрийг оролцогчид гардуулах харилцааг журамласан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.5 дугаар зүйлийн 9 дэх хэсэг, 36.13 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 39.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 40.8 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн зохицуулалтаас үзэхэд Төрийн болон албаны нууц мэдээлэл агуулсан шийдвэрийг оролцогчид хэрхэн танилцуулах, эсхүл гардуулах асуудлыг хуульд нарийвчлан зохицуулаагүй байна.

-Мөрдөн шалгах ажиллагааны явцад дахин гэмт хэрэг үйлдэж цагдан хоригдсон тохиолдолд цагдан хорих хугацааг тусад нь тоолох эсэх нь тодорхой зохицуулагдаагүй байна.

-Мөрдөн шалгах ажиллагааны үр дүнг бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг хавтаст хэрэгт нотлох баримтаар хавсаргаж, хэргийн хамт хадгалагддаг. Ингэхдээ хэргийн оролцогчоос мэдүүлэг авах процессыг бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг ямар хугацаанд хэрхэн хадгалах талаар зохицуулаагүй байна. Мэдүүлгийн тэмдэглэлүүд дууны болон дуу-дүрсний бичлэгээс зөрөх тохиолдол практикт гардаг бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.7 дугаар зүйлийн 2-т “Мөрдөн шалгах ажиллагаа, прокурорын хянан шалгах ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэлд тусгагдсан нөхцөл байдал нь дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгээс зөрсөн тохиолдолд шүүх, прокурор дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг нотлох баримтаар тооцно.” гэж заасан тул дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг тодорхой хугацаагаар хадгалах зохицуулалтыг хуульчлах шаардлагатай байна.

-Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд хамаарах Өмгөөллийн тухай хуульд заасан өмгөөлөгчийн зарим эрх процессын хуульд тодорхой тусгагдаагүйгээс мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэгчийн зүгээс хуулийн зохицуулалтыг зөрүүтэй ойлгох, хууль зүйн туслалцаа үзүүлэх үүргээ хэрэгжүүлэхэд

хүндрэл үүсэх, хэргийн бодит байдлыг тогтооход чухал ач холбогдол бүхий баримтыг шүүхэд гарган өгөх боломжгүй болох тохиолдлууд гарч байх тул эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох өмгөөлөгчийн эрх, үүргийг Өмгөөллийн тухай хуулийн зохицуулалттай уялдуулан нарийвчлан тусгах шаардлагатай байна.

-Хүний эрхийн Үндэсний Комиссын хийсэн судалгаагаар шүүхийн хэлэлцүүлэг үр дүнтэй явагддаггүй, шүүх мэтгэлцээнд үндэслэсэн хөндлөнгийн шийдвэр гаргадаггүй, өмгөөлөгчийн оролцоо хангалтгүй байгаа нь тогтоогдсон. Тодруулбал, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох, хугацаа сунгах эсэхийг шийдвэрлэх шүүхийн хэлэлцүүлэгт “өмгөөлөгчийн оролцоо, мэтгэлцэх зарчим хангагдаж байгаа эсэх” талаар судалгаанд оролцсон шүүгч, прокурорууудын 46 хувь нь “дунджаас дээгүүр” гэж хариулсан бол “хангалттай сайн” гэж шүүгчдийн 3.8 хувь, прокурорууудын 10.3 хувь нь тус тус үзжээ. Харин өмгөөлөгчдийн 72.1 хувь нь “өмгөөлөгчийн оролцоо туйлын хангалтгүй” байдаг талаар дурджээ.[3]

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хэлэлцүүлэгт оролцох өмгөөлөгчийн оролцоо хангалтгүй, өмгөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлж чадахгүй байгаа шалтгааныг “цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахаар гаргаж буй саналын үндэслэл, түүнийг нотолсон нотлох баримттай өмгөөлөгчийг танилцуулдаггүй, талуудыг мэтгэлцэх боломж олгодоггүй” гэж тайлбарласан байна.

Түүнчлэн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг ихэвчлэн мөрдөн байцаалтын шатанд авдаг бөгөөд мөрдөн байцаалтын ажиллагаа дуусаагүй гэх шалтгаанаар цагдан хорих арга хэмжээ авах, сунгах, өөрчлөх үндэслэл болж буй нотлох баримтыг өмгөөлөгчид танилцуулдаггүй, мөрдөн шалгах ажиллагааны нууц алдагдах гэсэн шалтгаанаар хаалттай бөгөөд эргэлзээтэй байдлаар шүүхийн хэлэлцүүлэг явагдаж байгаа нь НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан ажлын хэсгийн урьдчилсан дүгнэлтэд мөн дурдагдсан.

Иймд мөрдөн шалгах ажиллагаанд хүний эрхийн зөрчил гарахаас урьдчилсан сэргийлэх зорилгоор сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг сэжигтнийг баривчлах, таслан сэргийлэх арга хэмжээ авах болсон үндэслэлд хамаарах нотлох баримттай танилцуулах замаар шүүхийн хэлэлцүүлгийг талуудын мэтгэлцээний үндсэн дээр явуулах эрх зүйн орчинг сайжруулах шаардлагатай байна.

-Анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тухайн шүүгдэгчийн хувьд прокуророос шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэргийн хүрээнд явагдахаар хуульчлагдсан бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа прокурорын удирдлага, хяналтад явдаг, өмгөөлөгчийн зүгээс гаргадаг нэмэлт нотлох баримт цуглуулахтай холбоотой хүсэлтийг хангалттай шийдвэрлэдэггүй тул өмгөөлөх тал шүүхэд нэмэлт нотлох баримт гаргаж өгөх боломжийг нээх нь зүйтэй байна.

-Хуульд ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх эрхийн хэрэгжилтийг бодитойгоор хангах хүрээнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татагдсан тогтоолын хувийг авах эрхийг яллагдагчид олгох шаардлагатай байна. Олон үйлдэлтэй, мөн Эрүүгийн хуульд заасан олон зүйл хэсэгт буруутгагдаж байгаа

3 Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, URL: https://nhrcm.gov.mn/assets/img/58c1302622c8c88d036544f656fdff5d.pdf

хүний тухайд яллагдагчаар татах тогтоол хэдэн зуун хуудастай, шууд танилцаж, юунд буруутгагдаж байгаагаа ойлгоход төвөгтэй байдгаас хуулиар баталгаажсан эрхийг нь хангах боломж хязгаарлагддаг.

-Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч, прокуророос гарч байгаа, тэр тусмаа мөрдөн шалгах ажиллагаа явуулах, нотлох баримттай холбоотой шийдвэрүүд хууль зүйн болон нотолгооны үндэслэлтэй байх зайлшгүй шаардлагатай. Дээрх асуудлаар хэргийн оролцогчоос гаргасан хүсэлтийг шийдвэрлэхдээ прокурор, мөрдөгч хангаагүй, татгалзсан үндэслэлээ тодорхой заахгүй, зөвхөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байгаа талаарх хариу өгч хэвших хандлагатай байна. Энэ нь Үндсэн хуульд заасан "... албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага албан тушаалтан нь иргэдийн өргөдөл гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй" гэсэн заалтыг бодитоор хэрэгжих боломжийг хааж, үндэслэлгүй, ёс төдий, ажил хэрэгч бус хандлагыг бүрдүүлж байна.

Иймд хүсэлтийг хангахаас татгалзаж байгаа үндэслэлийг тухайн шийдвэртээ тодорхой тусгах зохицуулалтыг хуульчлах шаардлагатай байна.

Дээр дурдсан хэрэгцээ, шаардлагыг үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

Энэхүү судалгааны зорилго нь Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал /цаашид "Аргачлал" гэх/"-ын дагуу тус "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль"-ийн төслийн үр нөлөөг үнэлэхэд оршино. Ийнхүү үнэлэхдээ "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль"-ийн төслийн зохицуулалт, агуулга нь өөрчлөлтийн үзэл баримтлал, зорилгод нийцэж буй эсэх, зохион байгуулалтыг өөрчилж буй зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх, шинээр тусгагдсан зохицуулалтууд нь хүлээн зөвшөөрөгдсөн эсэх, хуулийн төсөл нь хууль зүйн техникийн хувьд алдаатай эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгсөн болно.

"Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль"-ийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг аргачлалд заасны дагуу дараах үе шаттайгаар үнэллээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ сонгох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг тооцохдоо хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан дараах 6 шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал
4. Ойлгомжтой байдал
5. Харилцан уялдаа

Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараах үндэслэлийг харгалзан үзсэн. Тухайлбал,

1. Хуулийн төслийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах зохицуулалт, сэжигтэн, гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэх ойлголттой холбоотой зохицуулалт, шүүх хуралдааныг хойшлуулахтай холбоотой зохицуулалт нь өөрчлөлтийн үзэл баримтлал, зорилго, хууль батлагдах хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэх;
2. Хуулийн төсөлд өөрчлөгдсөн зохицуулалт болох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах зохицуулалт, сэжигтэн, гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэх ойлголттой холбоотой зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх;
3. Хуулийн төсөлд тусгагдсан нэр томьёонууд нь ойлгомжтой эсэх, мөн хууль зүйн техникийн алдаа бий эсэх;
4. Хуулийн төсөлд шинээр тусгагдсан бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн талаар зохицуулалт, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь төрийн болон албаны нууцтай холбоотой зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх эсэх;
5. Хуулийн төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой нийцсэн эсэх зэргийг шалгах.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

Энэхүү хэсэгт уг хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгийг тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Энэхүү зүйл заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авлаа. Өөрөөр хэлбэл, тухайн төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс хуулийн төсөлд шинээр орж буй, голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож үр нөлөө үнэлнэ.

Түүнчлэн хуулийн төсөл батлагдсанаар тодорхой зардал үүсгэж болохуйц, эсхүл тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой, мөн тодорхой субъектэд үүрэг хүлээлгэсэн, тодорхой байгууллагад шинээр үүрэг хүлээлгэж байгаа, мөн тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор шинэ хэлтэс, нэгж байгууллага бий болгох шаардлагатай эсэх зэргийг харгалзан үр нөлөө тооцох хэсгээ тогтоосон.

Ингээд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт бүрээр тус бүрд нь авч үзье.

2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтээр хууль тогтоомжийн төслийн зохицуулалтыг шалгаж, үр нөлөөг нь үнэлэх бол тухайн төслөөр тавьсан зорилгод хүрэхэд чиглэгдсэн эсхүл түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зүйл, заалтыг сонгоно. Үүний тулд тухайн төслийн үзэл баримтлалтай сайтар танилцаж, хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг хэрхэн тодорхойлсон, энэхүү үндэслэл, шаардлага нь зорилгыг хэрхэн илэрхийлж байгаа эсэхийг судалдаг.

Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөс дээрх асуудлын дагуу зорилгодоо хүрсэн эсэхийг “зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах байдлаар үр нөлөөг тооцно. Үүнд:

Хүснэгт 3.1. *Зорилгод хүрэх түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт*

№	Зорилгод хүрэх байдал	Сонгосон зүйл, заалт
1	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах зохицуулалт нь зорилгод хүрч байгаа эсэх	Төслийн 1.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг Төслийн 1.16 дугаар зүйл
2	Хуулийн төслийн сэжигтэн, гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэх ойлголттой холбоотой зохицуулалт ЭХХШтХ-ийн зорилгод хүрч байгаа эсэх	Төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.38 дахь заалт Төслийн 16.3 дугаар зүйлийн 4.7 дахь заалт Төслийн 16.3 дугаар зүйлийн 10 дахь хэсэг Төслийн 16.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг Төслийн 25.1 дүгээр зүйлийн 18 дахь хэсэг Төслийн 31.2 дугаар зүйлийн 9-12 дахь хэсэг Төслийн 31.3 дугаар зүйлийн 6 дахь хэсэг Төслийн 31.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг Төслийн 31.11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг

3	Шүүх хуралдааныг хойшлуулахтай холбоотой зохицуулалт нь нэмэлт, өөрчлөлтийн зорилгод нийцэж буй эсэх	Төслийн 34.9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг Төслийн 34.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Төслийн 34.16 дугаар зүйлийн 6 дахь хэсэг Төслийн 34.16 дугаар зүйлийн 9 дэх хэсэг Төслийн 34.19 дүгээр зүйлийн 1.9 дэх заалт Төслийн 35.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг

2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслөөр шинээр бий болгож байгаа чиг үүрэг, эрх хэмжээ, бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг сонгон авдаг. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах агуулгын хүрээнд зохицуулалтуудыг сонгон “Практикт хэрэгжих боломж” гэх шалгуурын үр нөлөөг тооцсон болно.

Хүснэгт 3.2. *Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт*

№	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл, заалт
1	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх	Төслийн 1.16 дугаар зүйл Төслийн 11.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг Төслийн 11.11 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг
2	Хуулийн төслийн сэжигтэн, гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэх ойлголттой холбоотой зохицуулалт ЭХХШтХ-ийн практикт хэрэгжих боломжтой эсэх	Төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.38 дахь заалт Төслийн 16.3 дугаар зүйлийн 4.7 дахь заалт Төслийн 16.3 дугаар зүйлийн 10 дахь хэсэг Төслийн 16.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг Төслийн 25.1 дүгээр зүйлийн 18 дахь хэсэг Төслийн 31.2 дугаар зүйлийн 9-12 дахь хэсэг Төслийн 31.3 дугаар зүйлийн 6 дахь хэсэг Төслийн 31.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг Төслийн 31.11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг

2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд хууль тогтоомжийн төслөөс тодорхой заалтыг, эсхүл бүхэлд нь сонгон авч шалгах боломжтой. Хууль тогтоомжийн төсөлд хэрэглэсэн нэр томьёо, хэл зүйн найруулга, үг сонголтын хувьд ойлгомжтой байгаа эсэх, иргэд байгууллагууд тухайн зохицуулалтыг шууд ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэхийг шалгаж үнэлнэ. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс нэр томьёоны тодорхойлолттой холбоотой хэсгийг болон хууль зүйн техникийн алдаатай зохицуулалтыг сонгон авч үнэллээ.

Хүснэгт 3.3. *Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт*

№	Ойлгомжтой байдал	Сонгосон зүйл, заалт
1	Хуулийн төслийн ойлгомжтой байдлыг үнэлэх	Хуулийн төсөл бүхэлдээ

2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэх байгууллага хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх боломжтой эсэхийг үнэлэх учраас тодорхой байгууллага, иргэний эрх ашиг хөндөгдөж буй зохицуулалтыг сонгон авах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, тухайн төслөөр зохицуулж буй эсхүл шинээр оруулсан зохицуулалтыг иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх эсэхийг үнэлэх учраас иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын эрх үүрэг, тэдгээрийн ашиг сонирхол хөндөгдөх зохицуулалтыг сонгон авлаа.

Хүснэгт 3.4. *Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт*

№	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Сонгосон зүйл, заалт
1	Бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн талаар зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх эсэх	Төслийн 16.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг
2	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь төрийн болон албаны нууцтай холбоотой зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх эсэх	Төслийн 32.10 дугаар зүйлийн 9 дэх хэсэг Төслийн 36.13 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг Төслийн 3.2 дугаар зүйл Төслийн 31.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

2.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоог шалгах учраас шалгах хэсгээ сонгохдоо хуулийн төслийн тодорхой заалт, зохицуулалтыг бус тухайн төслийг бүхэлд нь сонгох нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, харилцан уялдаа гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд бид тухайн зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоо, бусад хуультай нийцтэй байдлыг шалгадаг.

Хүснэгт 3.5. *Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт*

№	Харилцан уялдаа	Сонгосон зүйл, заалт
1	Хуулийн төслийн зүйл, заалт хуулийн төслийн болон бусад хууль тогтоомжтой зөрчилдөж байгаа эсэх	Төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.38 дахь заалт Төслийн 16.3 дугаар зүйлийн 4.7 дахь заалт Төслийн 16.3 дугаар зүйлийн 10 дахь хэсэг Төслийн 16.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг Төслийн 25.1 дүгээр зүйлийн 18 дахь хэсэг Төслийн 31.2 дугаар зүйлийн 9-12 дахь хэсэг

		Төслийн 31.3 дугаар зүйлийн 6 дахь хэсэг Төслийн 31.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг Төслийн 31.11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг
2	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах зохицуулалт нь харилцан уялдаатай эсэх	Төслийн 1.16 дугаар зүйл Төслийн 11.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг Төслийн 11.11 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг

ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Тохирох шалгах хэрэгсэл нь урьдчилан тогтоосон шалгуур үзүүлэлтээс шалтгаалан харилцан адилгүй байх бөгөөд шалгуур үзүүлэлт тус бүрд нийцсэн дараах шалгах хэрэгслийн дагуу үнэлгээ өгөхөөр тогтлоо.

Хүснэгт 3.6. *Тохирох шалгах хэрэгсэл*

Шалгуур үзүүлэлт	Тохирох шалгах хэрэгсэл
Зорилгод хүрэх байдал	Зорилгод дүн шинжилгээ хийх.
Практикт хэрэгжих боломж	Практикт турших.
Ойлгомжтой байдал	Ойлгомжтой байдлыг шалгах.
Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх.
Харилцан уялдаа	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах.

Өмнөх үе шатуудад журмын төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтсон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав.

Хүснэгт 3.7. *Тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг үнэлэх хэсэг*

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Төслийн 1.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг Төслийн 1.16 дугаар зүйл Төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.38 дахь заалт Төслийн 16.3 дугаар зүйлийн 4.7 дахь заалт Төслийн 16.3 дугаар зүйлийн 10 дахь хэсэг Төслийн 16.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг Төслийн 25.1 дүгээр зүйлийн 18 дахь хэсэг Төслийн 31.2 дугаар зүйлийн 9-12 дахь хэсэг Төслийн 31.3 дугаар зүйлийн 6 дахь хэсэг Төслийн 31.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг Төслийн 31.11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг Төслийн 34.9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг Төслийн 34.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Төслийн 34.16 дугаар зүйлийн 6 дахь хэсэг Төслийн 34.16 дугаар зүйлийн 9 дэх хэсэг Төслийн 34.19 дүгээр зүйлийн 1.9 дэх заалт Төслийн 35.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	Хуулийн төслийн зорилго, үзэл баримтлал, хууль боловсруулах хэрэгцээ, шаардлага болон тус хуулийн хуулийн төслийн зорилт, холбогдох зохицуулалтын зорилго, үзэл баримтлалд дүн шинжилгээ хийх.
2	Практикт хэрэгжих боломж	Төслийн 1.16 дугаар зүйл Төслийн 11.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг Төслийн 11.11 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг Төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.38 дахь заалт Төслийн 16.3 дугаар зүйлийн 4.7 дахь заалт Төслийн 16.3 дугаар зүйлийн 10 дахь хэсэг Төслийн 16.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг Төслийн 25.1 дүгээр зүйлийн 18 дахь хэсэг	Практикт хэрэгжих байдлыг баримт, бичигт дүн шинжилгээ хийх замаар хэрэгжих эсэхийг судлах.

		Төслийн 31.2 дугаар зүйлийн 9-12 дахь хэсэг Төслийн 31.3 дугаар зүйлийн 6 дахь хэсэг Төслийн 31.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг Төслийн 31.11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг	
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Тодорхойлоогүй нэр томьёонуудыг тайлбарлах байдлаар санал болгох, хуулийн төсөл боловсруулах нийтлэг шаардлагад нийцүүлэх саналыг гаргах.
4	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Төслийн 16.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг Төслийн 32.10 дугаар зүйлийн 9 дэх хэсэг Төслийн 36.13 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг Төслийн 3.2 дугаар зүйл Төслийн 31.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх асуудлын хүрээнд баримт бичгийн судалгаа хийж дүгнэх.
5	Харилцан уялдаа	Төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.38 дахь заалт Төслийн 16.3 дугаар зүйлийн 4.7 дахь заалт Төслийн 16.3 дугаар зүйлийн 10 дахь хэсэг Төслийн 16.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг Төслийн 25.1 дүгээр зүйлийн 18 дахь хэсэг Төслийн 31.2 дугаар зүйлийн 9-12 дахь хэсэг Төслийн 31.3 дугаар зүйлийн 6 дахь хэсэг Төслийн 31.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг Төслийн 31.11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг Төслийн 1.16 дугаар зүйл Төслийн 11.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг Төслийн 11.11 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг	Харилцан уялдааг судлах, ингэхдээ холбогдох хуулийн зохицуулалтуудад дүн шинжилгээ хийх.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэлэв.

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Зорилгод хүрэх байдал”-ыг үнэлэхдээ хуулийн төсөл нь хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэх, хуулийг батлан хэрэгжүүлснээр хүрэх үр дүн тодорхой байдлаар томьёологдож чадсан эсэхийг тухайн хуулийн төсөл, дээд эрэмбийн хуулийн үзэл баримтлал, түүний агуулгыг хуулийн төслийн үр нөлөөг үнэлж буй зохицуулалттай харьцуулан дүн шинжилгээ хийдэг. Энэ хүрээнд хуулийн төслийн холбогдох зохицуулалтад дүн шинжилгээ хийнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах зохицуулалт нь зорилгод хүрч байгаа эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Төслийн 1.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөтлөх баримт бичиг, хэргийн материал нь цаасан болон цахим хэлбэртэй байна.” гэх нэмэлтийг оруулсан байна. Мөн түүнчлэн төслөөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.16 дугаар зүйлийг нэмж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулахыг дараах байдлаар зохицуулжээ.

- Шүүх хэргийн оролцогчтой харилцах, хэргийн материалыг оролцогчид танилцуулах, шүүх хуралдаан, шүүхийн хэлэлцүүлэг явуулах, баримт бичиг хүлээн авах, хүргэх ажиллагааг цахим платформ ашиглан цахимаар явуулж болно.

- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг, хавтаст хэрэг нь шүүхийн цахим платформын техникийн шаардлагад нийцсэн байна.

- Хэргийн оролцогчтой цахимаар харилцахад төрийн байгууллага, албан тушаалтны албаны цахим шуудан, албан бичиг солилцооны дундын систем, мэдэгдэл хүргэх систем, төрийн үйлчилгээний нэгдсэн систем, мэдэгдэл хүргэх системд иргэний үүсгэсэн, бүртгүүлсэн цахим шуудан, тухайн этгээдийг таньж, баталгаажуулах боломжтой бусад цахим систем, өмгөөлөгчийн Монголын Өмгөөлөгчдийн Холбооны цахим системд бүртгүүлж холбогдсон цахим шууданг ашиглана.

- Өмгөөлөгч тайлбар, гомдол, хүсэлт зэрэг баримт бичгийг цахим баримт бичгээр хүргүүлнэ. Техникийн шалтгаанаар ийнхүү хүргүүлэх боломжгүй тохиолдолд цаасан баримт бичгээр ирүүлж болох бөгөөд энэ тохиолдолд техникийн боломжгүй байсан шалтгаанаа нотолж цахим баримт бичгээр нөхөн ирүүлж болно.

- Мөрдөгч, прокуророос шүүхэд хүргүүлэх эрүүгийн хэрэг, баримт бичгийг шүүхийн цахим платформын техникийн шаардлагад нийцүүлж цахим баримт бичгийн хэлбэрт хөрвүүлж, албан тушаалтны цахим гарын үсгээр баталгаажуулан хүргүүлнэ. Шүүхийн шатанд цахим баримт бичгээр хүргүүлэх боломжгүй цаасан баримт бичгийг шүүхийн захиргааны ажилтан цахим баримт бичигт хөрвүүлнэ.

Энэ тухай тус хуулийн дэлгэрэнгүй танилцуулгад дараах байдлаар авч үзсэн байна.

Хавтаст хэргийг цахимжуулах, цахим хэрэгсэл ашиглаж нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, хадгалах, үнэлэх хэрэгцээ, шаардлага нь өнөө цагт тулгамдсан асуудал болж байгаа бөгөөд тус ажиллагааг процессжуулах, хуульчлах хэрэгцээ, шаардлага тулгараад байна.

Тухайлбал, олон оролцогчтой хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд прокурорын яллах дүгнэлтийг хуулбарлан гардуулж өгөхөд ихээхэн зардал, цаг хугацаа шаардагддаг.

Иймд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөтлөх баримт бичиг, хэргийн материал нь цаасан болон цахим хэлбэртэй байхаар тусгаж, шүүх хэргийн оролцогчтой харилцах, хэргийн материалыг оролцогчид танилцуулах, шүүх хуралдаан, шүүхийн хэлэлцүүлэг явуулах, баримт бичиг хүлээн авах, хүргэх ажиллагааг цахим платформ ашиглан цахимаар явуулж болохоор тусгалаа.

Хавтаст хэргийг цахимжуулах нь цаасан суурьтай бичиг баримт, нотлох баримтыг боловсруулахад шаардагдах зардал, цаг хугацааг бууруулах ач холбогдолтой юм[4].

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах болон цахим нотлох баримтыг бий болгох талаар хэрэгцээ, шаардлага манай улсад бий болоод байна. Үүнийг нарийвчлан авч үзье.

4 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга, ХЗДХЯ, (2024).

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах талаар хэрэгцээ, шаардлага:

Аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал болон дэлхий нийтээрээ цахим шилжилтэд шилжиж буй өнөө үед харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшил нь хөгжлийн хурдасгуур, цахим үндэстнийг цогцлоон хөгжүүлэх гол хүчин зүйл болж байна.[5] Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 3-т "...Шүүх улсын төсвөөс санхүүжнэ. Шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана..." гэж, мөн "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжихээр заасан. Ингэхдээ 2021-2030 он төрийн албаны хувьд төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх үе гэж тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл, Монгол Улс ойрын жилүүдэд төрийн алба, мөн түүний нэг төрөл болох шүүхийн албаны үр дүн, үр нөлөөг дээшлүүлэхийг зорьж байна. Төрийн үйлчилгээг ийнхүү үр дүн, үр нөлөөгөөр (output/outcome) хэмжиж дээшлүүлэх нь New public management буюу нийтийн албаны шинэ менежментийн ухаанаас улбаатай гэж үзэх бөгөөд энэ нь бизнесийн салбарын удирдлагын "багаар ихийг хийх" (do more with less) -тэй холбоотой зарим арга зүйг төрийн буюу нийтийн албанд нэвтрүүлж үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэжээ.[6] Энэ хүрээнд шүүхийн цахимжилтын асуудал нэн тэргүүнд хөндөгдөж байна.

Түүнчлэн, шүүхийн цахимжилт нь дан ганц шүүхийн асуудал биш шүүх эрх мэдлийн бүхий л байгууллага, цагдаа, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, улсын бүртгэлийн газар гэх мэт олон талын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцох интеграци учир хууль, эрх зүйн орчинд ач холбогдол өгөх ёстой. Тодруулбал, иргэн, эрүү, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх процессын хуулиудад цахимаар мэдүүлэх, цахим нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, үнэлэх, цахим хавтаст хэрэг үүсгэх, цахимаар мэтгэлцэх эрх зүйн орчныг бүрдүүлж өгөх хэрэгцээ шаардлага тулгараад байна.[7]

Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн хэрэг, цагдан хорих гэх мэт асуудлыг цахимжуулах боломжтой. Гадаад орнуудын туршлагаас харахад процессын хуулиудад ерөнхий зохицуулалтыг тусгаж, нарийвчилсан зохицуулалтыг журам батлан хэрэгжүүлдэг туршлага нийтлэг байна. Манай улс хуулиндаа цахимаар мэдүүлэх, цахим хавтаст хэрэгтэй холбоотой ерөнхий зохицуулалтыг тусгах нь цаашдын шүүх болон бусад хуулийн байгууллагын цахимжилтад эергээр нөлөөлөх боломжтой.[8]

Улсын Их Хурлын Байнгын хороо 2015 онд "Шүүх хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн цахим нэгдсэн сүлжээ бүрдүүлэх тухай" 23 дугаар тогтоол гарсан. Энэ тогтоолыг үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн яам, шүүх,

5 Монгол Улсын Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 5 сарын 18-ны өдрийн А/24 тушаалаар баталсан "Цахим үндэстэн" баримтлах чиглэл (2022-2027)

6 2023 оны 3 сарын 23-24-ний өдөр зохион байгуулагдсан "Монгол Улсын Шүүхийн цахимжуулалт" ОУБХ-д Н.Отгончимэгийн хэлэлцүүлсэн "Шүүхийн санхүүжилтийн механизмыг шинэчлэх шаардлага" сэдэвт илтгэлээс. https://docs.google.com/document/d/10Dj6LDSgTdrjOyp8UkrRIZ0z3Bq-DyvcaqLBsJSrEAw/edit

7 Г.Даваадорж: Шүүхийн цахимжилтад хууль эрх зүйн орчин ус агаар мэт хэрэгтэй байна, https://www.judcouncil.mn/site/news_full/13818

8 Мөн тэнд.

прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон ХБНГУ-ын Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс хамтран хэрэгжүүлсэн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчныг баталгаажуулах” төслөөс шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудыг нэгдсэн сүлжээнд холбосон.[9]

2020-2021 онд “Ковид-19” цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд шүүхээс хэрэг, нэхэмжлэл, гомдлыг цахимаар хүлээн авах, хэргийн оролцогчдыг цахимаар шүүх хуралдаанд оруулах, зарим нотлох баримтыг төрийн эрх бүхий байгууллагуудаас авах, солилцох зэргээр үйл ажиллагааныхаа тодорхой хэсгийг цахимд шилжүүлэн, шүүн таслах ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулж байсан.[10]

Өөрөөр хэлбэл, Коронавирус цар тахлын дэгдэлттэй холбоотойгоор шүүх эрх мэдлийн байгууллагын хүрээнд үүссэн шүүхийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах, шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, шүүхийн үйлчилгээг иргэдэд үзүүлэх, шүүхийн байранд аюулгүй байдлыг хангах, хамгаалах, удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтын цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ шүүхийн зарим үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлсэн. Энэ нь шүүхийн ачаалал, цаг хугацаа, хөрөнгө санхүү, хүний нөөц, шүүх хурлын танхим зэрэг олон асуудлыг бууруулахад эерэг нөлөөлөл үзүүлж байсан тиймээс ч цаашид шүүхийн цахимжилтийн эрчимжүүлэх хэрэгцээ шаардлага байгааг практикт ажиллаж буй шүүх, прокурор, өмгөөлөгч, хууль сахиулах байгууллагын төлөөллүүд олон удаагийн хурал, сургалт, хэлэлцүүлгийн явцад хөндсөөр байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэлэх тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ /Цахим хавтаст хэрэг, цахим нотлох баримт, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт/ сэдэвт судалгааны тайлангийн 3.1.2, 3.2.2-оос эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим хавтаст хэрэг, цахим нотлох баримтын хэрэгцээ шаардлагыг дэлгэрүүлж үзнэ үү.

Дээрхээс дүгнэвэл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах, ялангуяа цахим хавтаст хэргийг бий болгох, цахим нотлох баримтын талаар зохицуулах нь одоогийн хэрэгцээ, шаардлагад нийцэхүйц байна. Өөрөөр хэлбэл орчин үед цахим хөгжил эрчимтэй явагдаж буй энэ үед эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох, хялбарчлах, хэмнэлттэй, үр дүнтэй байх ач холбогдлыг бий болгож байна. Хуулийн төслийн 1.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 1.16 дугаар зүйл, 11.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 11.11 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг болон бусад цахимжуулахтай холбоотой зохицуулалт нь тус хэрэгцээ, шаардлага, зорилгод ерөнхийдөө нийцэж буй боловч цахим нотлох баримтыг хуулийн төсөлд тусгаж нарийвчлан зохицуулаагүйгээрээ нэмэлт, өөрчлөлтийн хэрэгцээ, шаардлага, зорилгод нийцэхгүй байна. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд цахим нотлох баримтын талаар нарийвчлан зохицуулах шаардлагатай.

Хуулийн төсөлд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах талаар тусгасан нь зорилгод нийцэхээс гадна цахим хэлбэртэй байхаас гадна цаасан хэлбэртэй байхаар тусгасан нь зорилгод нийцэж байна. Учир нь 2020 онд

9 Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын төсөлд хийсэн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ /Хөндлөнгийн судалгаа/, (Уб, 2023), 86-87 дахь тал.

10 Мөн тэнд, 87 дахь тал.

батлагдсан Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд дараах зохицуулалтуудыг тусгасан.

- 14.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг. Архивын баримтын тоо бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл цаасан болон цахим хэлбэрээр байх бөгөөд уг санг ашиглан төрийн архивууд хооронд мэдээлэл солилцох нөхцөл бүрдүүлсэн байна.
- 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг. Байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд захирамжлалын, зохион байгуулалтын болон мэдээлэл, лавлагааны баримт бичгийг хуульд өөрөөр заагаагүй бол цахим хэлбэрээр, шаардлагатай тохиолдолд цаасан хэлбэрээр үйлдэнэ.
- 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэг. Хуульд өөрөөр заагаагүй бол цаасан болон цахим баримт бичиг нь хууль тогтоомж болон стандартаар тогтоосон баримт бичгийн бүрдлээр баталгаажна гэх мэт.

Дээрх байдлаар цаасан болон цахим суурьтай байх нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийн шаардлага юм. Түүнчлэн зохицуулалтын практик хэрэгжилт бий болох хүртэл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийн найдвартай байдлыг хангах хөшүүрэг болохоор байна.

Хуулийн төслийн сэжигтэн, гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэх ойлголттой холбоотой зохицуулалт ЭХХШтХ-ийн зорилгод хүрч байгаа эсэхэд хийсэн дүн шинжилгээ

2015 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль батлагдсантай холбогдуулан 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг шинэчлэн найруулах асуудал зүй ёсоор хөндөгдөж байсан. ЭБШХ-ийг шинэчлэн найруулахдаа нэрийн хувьд ч “байцаан шийтгэх” бус “хэрэг хянан шийдвэрлэх” гэж өөрчлөн, агуулга, зүйл, заалтыг өөрчлөн сайжруулж, гадаад орны сайн туршлагыг судлан нэлээд олон зохицуулалтыг шинээр тусгаж, зарим зохицуулалтыг халсан билээ.

Тус хуулиас халсан зохицуулалтын нэг нь “сэжигтэн” юм. 2015 онд шинэчлэн найруулсан ЭХХШтХ-ийн төсөл хэлэлцэгдэж байх үед тухайн үеийн Хууль зүйн сайд Д.Дорлигжав хэвлэлд өгсөн ярилцлагадаа “…Сэжигтэн гэсэн ойлголт үгүй болно. Хэн нэгнийг ямар нэг гэмт хэрэгт сэжиглэсэн тохиолдолд дуудаж байцаадаг, хорьж цагддаг явдал эцэс болно. Мөрдөн байцаагч гагцхүү нотлох баримт цуглуулах бөгөөд нотлох баримт бүрдүүлсний дараа прокурорт танилцуулан, түүнийг нь прокурор хангалттай гэж үзсэн тохиолдолд тухайн хүнийг яллагдагчаар тооцон байцаалт явуулах эрхтэй. Өөрөөр хэлбэл, хангалттай нотлох баримтгүй атлаа дуудаж байцаадаг, сэжигтнээр тооцуулан авчраад өрөөнийхөө үүдэнд байцаалт авах нэрээр хэдэн цагаар суулгадаг, хорьдог явдлыг эцэслэнэ…”[11] гэжээ.

Тиймээс ч ЭХХШтХ-аар сэжигтэн гэх ойлголтыг халж, хүний эрхийг хангах боломжийг бүрдүүлнэ хэмээн үзэж байсан ч ЭХХШтХ-ийн зарим зүйл, заалтад сэжигтэн гэх ойлголт тусгагдсан бөгөөд үүнээс үүдэн практикт сэжигтэнтэй холбоотой зохицуулалт дутуу, хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй эрх зүйн хийдэлтэй хуульчлагдсны улмаас хүний эрхийг ноцтой зөрчих үндэслэл болоод байна. Энэ талаар салбарын судлаач, эрдэмтэд хурал, хэлэлцүүлгээр олонтоо хөндөж, эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл, ярилцлага өгсөн байдаг.

11 Шинэ хуулиар сэжигтэн гэх ойлголт үгүй болно нийтлэл, 2015.05.06, https://gogo.mn/r/qo8v7

Тухайлбал, Хууль зүйн ухааны доктор Б.Өнөрмаа *“Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны “оролцогч биш” оролцогч буюу “сэжигтний” талаарх зохицуулалтын ХБНГУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн / stpo/ зохицуулалттай харьцуулах нь” сэдэвт өгүүлэлдээ “...Монгол Улсын ЭХХШтХ-д сэжигтнийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч гэж хуульчилсан атлаа сэжигтнээс мэдүүлэг авах ажиллагаа зохицуулагдаагүй бөгөөд хэрэгт сэрдэгдэж буй хүнээс гэрчийн мэдүүлэг авах нь түүний үндсэн эрхийг ноцтой зөрчиж “сэжигтэн”- ий статус, эрх үүргийг тодорхойлоогүй нь Монгол Улсын Үндсэн хуульд харшилж байна. Сэжигтэн нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гол оролцогчийн хувьд гэрчийн мэдүүлэг өгч байгаа нь гэм буруугүй болохоо өөрөө нотлох үүрэг хүлээж буй үйлдэл юм. Энэ нь Монгол Улсын ЭХХШтХийн 1.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Шүүх, прокурор, мөрдөгч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс гэм буруугүй болохыг өөрөөр нь нотлуулахаар шаардахыг хориглоно”* гэж заасантай зөрчилдөж байна…” гэжээ.

Нээлттэй нийгэм форумаас 2022 онд зохион байгуулсан “Чухал сэдэв” хэлэлцүүлгийн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр бүлэг” тэмдэглэлд *“...Өмнөх хуулийн хүрээнд байсан хүний эрхийг сэжиг таамгаар хязгаарлахыг таслан зогсоох зорилгоор сэжигтэн гэх нэршлийг эрүүгийн процессын оролцогчоор тооцохоо больсон. Учир нь сэжигтэнд хугацаагүйгээр хилийн хориг тавих, батлан даалт, барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ авах, хамгийн ноцтой нь хүнийг зүгээр л сэжиглээд 14 хоног хорьдог, 72 цагтайгаа нийлэх юм бол 17 хоног хорьж саатуулах нөхцөл бүрдсэн байсан. Тиймээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31-р бүлэгт бүхэлд нь ямар тохиолдолд хүнийг сэжигтнээр дуудах, баривчлахыг нарийвчлан заасан. Гэтэл энэ бүлгийг хэрэглэхийн оронд хүнийг гэрчээр дуудаад өөрийнх нь эсрэг мэдүүлэг авч, улмаар яллагдагчаар татаж байна. Нэг ёсондоо сэжигтнээр оролцох ёстой хүнийг гэрчээр оролцуулсны улмаас Монгол Улсын Үндсэн хуульд заасан гомдол гаргах эрх нь автоматаар хасагдаж байгаа буюу “гэрч” болсноор гомдол гаргах, мөрдөгч, прокуророос татгалзах, өөрөө өөрийгөө өмгөөлөх эрхгүй болж байна…”* гэжээ.

Мөн Нээлттэй нийгэм форум, Монголын Хуульчдын холбооны Эрүүгийн эрх зүйн хороотой хамтран “Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал” сэдэвт цуврал хэлэлцүүлгийн хүрээнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой хэлэлцүүлэг зохион байгуулахад оролцогчид “…Сэжигтний асуудал байхгүй явж байгаад сүүлд нь сэжигтний өмгөөлөгч, баривчлагдсан сэжигтэн гэж гарч ирээд байгаа нь хуулийг нэг мөр ойлгож хэрэглэхэд хүндрэл учруулж байна. Аливаа гэмт хэрэгт сэжигтнээр татаж байгаа этгээдийг шинэ хуулиар гэрчээр асуугаад, хууль сануулаад, худал мэдүүлэг өгч болохгүй гэчхээд, дараа нь буцаагаад яг тэр үндэслэлээр яллагдагчаар татаж байна. Энэ нь Үндсэн хуульд заасан өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх гэсэн зарчимтай зөрчилдөж байна. Иймд сэжигтэн гэсэн томьёолол орж ирвэл, дагаад эрх, үүрэг нь тодорхой болох боломжтой...”[12] гэжээ.

Дүгнэвэл, ЭХХШтХ-д заасан сэжигтэнтэй холбоотой зохицуулалтууд зорилгод хүрэх байдал, практикт хэрэгжих боломжийн хувьд хязгаарлагдмал байдалтай байна.

12 ННФ, Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудал: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Хуулийн шүүмж, Цуврал 22, (Уб, 2018), 9 дэх тал.

Сэжигтэн гэх нэр томьёо дэлхийн олон орны эрүүгийн процессын ажиллагаанд түгээмэл хэрэглэдэг бөгөөд 2002 оны ЭБШХ-ийг хэрэгжүүлэхэд үүсээд байсан асуудал нь "сэжигтэн" гэх нэр томьёонд биш харин сэжигтэнтэй холбоотой эрх зүйн зохицуулалт, харилцааг практикт өрөөсгөл байдлаар хэрэгжүүлж байсантай холбоотой гэж үзэх болох юм. Тиймээс ч сэжигтэн гэх нэр томьёог зөв зүйтэй тодорхойлон хуульчилж, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сэжигтнийг эрхийг хангах, зөрчигдөхөөс сэргийлэх, тухайн зохицуулалтыг практикт хэрэгжүүлэх асуудлыг нарийвчлан зөв хуульчлах нь тус нэр томьёог халахаас илүү оновчтой сонголт байсан болох нь ЭХХШтХ хэрэгжиж эхэлснээс хойш өнөөдрийг хүртэлх сэжигтэнтэй холбоотой хуулийн зохицуулалтын хэрэгжилтээс харагдаж байна.

ЭХХШтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд сэжигтэнтэй холбоотой зохицуулалтаас гадна шинээр "гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн" гэх ойлголтыг тодорхойлж, холбогдох зохицуулалтуудыг төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.38 дахь заалт, 16.3 дугаар зүйлийн 4.7 дахь заалт, мөн зүйлийн 10 дахь хэсэг, 16.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 25.1 дүгээр зүйлийн 18 дахь хэсэг, 31.2 дугаар зүйлийн 9-12 дахь хэсэг, 31.3 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 31.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 31.11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт тусгажээ.

"Гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн" гэдгийг энэ хуульд заасан үндэслэлээр гэмт хэрэг үйлдсэн гэж буруутгагдах нотлох баримт, хавтаст хэрэгт тусгагдсан, эсхүл мөрдөн шалгах ажиллагаагаар тогтоогдож байгаа хүн гэж хуулийн төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.38-д тодорхойлжээ. Тус тодорхойлолтоос үзвэл "гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн" гэдэгт:

1/ гэмт хэрэг үйлдсэн гэж буруутгагдах нотлох баримт, хавтаст хэрэгт тусгагдсан;

Гэмт хэрэг үйлдсэн гэж буруутгагдах нотлох баримт хавтаст хэрэгт тусгагдсан гэдэгт ЭХХША явуулж, хуульд заасан үндэслэл журмын дагуу нотлох баримт цуглуулж, тухайн нотлох баримтад үндэслэн тухайн хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх үндэслэл тогтоогдож байхыг ойлгож болох юм.

2/ мөрдөн шалгах ажиллагаагаар тогтоогдож байгаа хүн хамаарч байна.

Мөрдөн шалгах ажиллагаагаар тогтоогдож байгаа хүн гэдгийг хуульд заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулж, тухайн ажиллагааны үр дүнд гэмт хэрэг үйлдсэн болох нь тогтоогдож байгаа хүн гэж ойлгож болох юм.

Харин ЭХХШтХ-ийн 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт сэжигтэн гэдгийг энэ хуульд заасны дагуу баривчлагдсан, эсхүл яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар дуудагдсан хүн гэж заажээ. Үүнээс үзвэл, сэжигтэнд:

1/ баривчлагдсан;

/ЭХХШтХ-ийн 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас дүгнэвэл, сэжигтэнд зөвхөн баривчлагдсан хүн хамаарах бөгөөд баривчлагдаагүй хүн сэжигтэн биш/

2/ яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар дуудагдсан хүн хамаарч байна.

/Энэхүү тодорхойлолтоор яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар дуудагдсан хүн буюу сэжигтэн маш богино хугацааны ойлголт болоод байна. Учир

нь мөрдөгч яллагдагчаар татах тогтоол танилцуулах тухай мэдэгдэж, тухайн хүн тус тогтоолтой танилцахаар ирж буй хугацаандаа л “сэжигтэн” гэх статустай байх бөгөөд яллагдагчаар татах тогтоол танилцуулсны дараа яллагдагч болно/

Хүснэгт 3.8. *Сэжигтэн, гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн*

Сэжигтэн	Гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн
/ЭХХШтХ-ийн 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	/Төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.38 дахь заалт/
Энэ хуульд заасны дагуу баривчлагдсан	Энэ хуульд заасан үндэслэлээр гэмт хэрэг үйлдсэн гэж буруутгагдах нотлох баримт, хавтаст хэрэгт тусгагдсан
Яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар дуудагдсан хүн	Мөрдөн шалгах ажиллагаагаар тогтоогдож байгаа

Хуулийн төслийн 2 дугаар зүйлд 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “баривчлагдсан” гэсний дараа “эсхүл гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэж нэмэхээр тусгасан нь сэжигтэн гэх ойлголтод “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” хамааруулж байгаа мэт харагдаж байгаа ч хуулийн төслийн бусад зүйл, заалтад тусгасан “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэх ойлголт нь сэжигтнээс ялгаатай зохицуулалт мэт ойлгогдож байна. Тухайлбал, хуулийн төслийн 16.3 дугаар зүйлийн 4.7 дугаар зүйл.

Учир нь ЭХХШтХ-ийн 16.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “дараах хүнээс гэрчийн мэдүүлэг авч болохгүй” гэж тусгасан бөгөөд тус үндэслэлүүд дээр “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэж нэмж оруулахаар хуулийн төслийн 16.3 дугаар зүйлийн 4.7-д тусгажээ. Мөн хуулийн төсөлд “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн”-ийг гэрчээр дуудан ирүүлэхийг хориглох заалтыг тусгасан байна.

Хэрэв хуулийн төсөлд тусгаснаар “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” сэжигтэнд хамаарч байсан бол сэжигтнээс гэрчийн мэдүүлэг авахгүй нь хэн хүнд ойлгомжтой. Энэ мэтчилэн “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” нь сэжигтэн биш, түүнээс ялгаатай мэт ойлгогдох зохицуулалтууд хуулийн төсөлд тусгагдсан нь тухайн зохицуулалтын зорилгыг алдагдуулж байна.

Мөн ЭХХШтХ-ийн 31.11 дүгээр зүйлийн нэр нь “Сэжигтнээс мэдүүлэг авах” бөгөөд хуулийн төслийн 2 дугаар зүйлд зааснаар 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг заасан сэжигтэнд “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” үнэхээр хамаарч байгаа бол үүнийг сэжигтнээс ялгаатай байдлаар “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэж хуулийн төслийн 31.11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт тусгах шаардлагагүй байсан. Зүй нь хуулийн төсөлд “сэжигтэн” гэх нэр томьёонд хамааруулсан бол сэжигтэн гэх нэр томьёог хэрэглэх нь оновчтой байжээ.

Түүнчлэн, ЭХХШтХ болон хуулийн төсөлд “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн”-ий эрх, үүргийн талаар тусдаа тусгагдаагүй. Дээр дурдсанчлан хуулийн төслийн 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн сэжигтэнд хамаарч байгаа учир сэжигтний адил эрх эдлэхээр байна. Гэтэл хуулийн төслийн бусад зохицуулалтад сэжигтэн, гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэх ойлголтыг өөр хоорондоо ялгаатай мэтээр тусгаснаас үзвэл гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн сэжигтний хуульд заасан эрхийг түүнтэй адил эдлэх эсэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрхэн явуулах нь ойлгомжгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлд зааснаар 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “баривчлагдсан,” гэсний дараа “эсхүл гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэж нэмэхээр заасан бөгөөд тус нэмэлт орвол сэжигтэнд:

- Баривчлагдсан
- гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн
- яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар дуудагдсан хүн хамаарахаар байна.

Одоогийн ЭХХШтХ-ийн зохицуулалтаас үзвэл, сэжигтэн нь баривчлагдсан эсхүл яллагдагчаар татах тогтоол танилцуулахаар дуудагдсан буюу маш богино хугацааны ойлголт бөгөөд яллагдагчаар татах тогтоолтой танилцсанаар яллагдагч болж байна.

Харин “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэх тодорхойлолтоос харвал, мөрдөн шалгах ажиллагаагаар тогтоогдож байгаа хүн буюу харьцангуй нотлогдсон ЭХХШтХ-ийн 1.4 дүгээр зүйлийн 1.23-т заасан үндэслэл бүхий сэжигтнээс илүү гэмт хэрэг үйлдсэн нь баримтаар нотлогдож, тогтоогдож байгаа хүн байхаар тодорхойлжээ.

Дээрхээс тодорхойлолтоос үзвэл, гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэх ойлголт одоогийн ЭХХШтХ-д заасан сэжигтнээс илүү тухайн гэмт хэргийг үйлдсэн болох нь нотлогдож байгаа хүнийг тодорхойлсон байна. Нөгөөтээгүүр, “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэдгийг сэжигтнээс ялгамжтай байдлаар тусгасны ач холбогдол хуулийн төслөөс харагдахгүй байгааг дурдах нь зүйтэй.

Түүнчлэн, хуулийн төслийн 2 дугаар зүйлд заасанчлан 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг нэмэлт оруулахдаа “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэх ойлголтыг сэжигтэнд хамааруулсан атлаа хуулийн төслийн бусад зохицуулалтад ялгаатай ойлголт мэтээр тусгасан нь тухайн зохицуулалтын зорилгод хүрэх байдлыг алдагдуулж байна.

Дээрхээс дүгнэвэл, ЭХХШтХ-д сэжигтэн, гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэж ЭХХША-ны нэг субъектыг ялгамжтай байдлаар тусгаж хуульчлах нь хуулийн нэр томьёог нэг мөр ойлгон хэрэглэх, ойлгомжтой байдал, хууль хоорондын уялдаа холбоог хангахад сөргөөр нөлөөлөхөөр байна. Иймд одоо байгаа хуулийн зохицуулалт буюу сэжигтэнтэй холбоотой зохицуулалтаа засаж сайжруулах, эрх зүйн хийдлийг арилгахад чиглэсэн зохицуулалтуудыг хуулийн төсөлд тусгаж, сэжигтэнг тодорхойлон хуульчлах нь илүү оновчтой байж болох юм.

Шүүх хуралдааныг хойшлуулахтай холбоотой зохицуулалт нь нэмэлт, өөрчлөлтийн зорилгод нийцэж буй эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Тус хуулийн төслийн 34.9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 34.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 34.16 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 34.16 дугаар зүйлийн 9 дэх хэсэг, 34.19 дүгээр зүйлийн 1.9 дэх заалт, 35.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт дараах зохицуулалтыг нэмсэн байна

- Шүүгдэгч энэ хуулийн 35.9 дүгээр зүйлд заасны дагуу шүүх хуралдаанд оролцож, шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэг өгөх эсэх эрхээ эдэлсний дараа хүндэтгэн

үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдааныг орхин явж, шүүх хуралдаанд оролцохоос санаатай зайлсхийсэн бол шүүх түүний эзгүйд шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулж, шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг эцэслэн шийдвэрлэж болно. Шүүгдэгчийн эзгүйд шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулахад шүүгдэгчийн өмгөөлөгчийг оролцуулна.

- Улсын яллагч, шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч нь гэрч, шинжээч оролцуулах хүсэлтээсээ татгалзаагүй тохиолдолд шүүх талуудын хүсэлтийг харгалзан шүүх хуралдааныг хойшлуулах эсэхийг шийдвэрлэнэ.

- Прокурор энэ хуулийн 5 дахь хэсэгт заасан ажиллагааг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлэх боломжгүй бол шүүх хуралдааныг 30 хүртэл хоногоор хойшлуулж болно.

- Шүүгдэгчийн сонгож авсан өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй, эсхүл шүүгдэгч өмгөөлөгчөөс татгалзсан тохиолдолд энэ хуулийн 5.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу шүүх хуралдаанд өөр өмгөөлөгчийг томилж оролцуулна.

- Шүүх хэд хэдэн шүүгдэгчид холбогдох хэрэгт энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шүүхийн хэлэлцүүлэг явуулах дарааллыг тогтоохдоо өөрийнх нь хууль ёсны ашиг, сонирхол хөндөгдөхгүй шүүхийн хэлэлцүүлэг явагдах үед шүүх хуралдааны танхимд байлцахгүй байх талаар оролцогчийн гаргасан хүсэлтийг талуудын саналыг харгалзан шийдвэрлэж болно. Шүүх хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн бол энэ тухай шүүх хуралдааны тэмдэглэлд тусгаж, шүүх хуралдаанд үргэлжлүүлэн оролцох товыг оролцогчид мэдэгдэнэ.

- Хохирогчийг шүүх хуралдаанд оролцуулахаар шүүх шийдвэрлэсэн бол хохирогч ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болно.

Энэ тухай хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгад дараах байдлаар авч үзсэн.

Шүүх хуралдаан хойшилж буй шалтгаан нөхцөлийн дийлэнх нь өмгөөлөгчтэй холбоотой болох нь шүүхийн практикт хийсэн судалгаагаар харагддаг.

Өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах, өмгөөлүүлэх эрхээр хангагдах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчтэй оролцох нь яллагдагч, шүүгдэгч, хохирогч, гэрчийн хувьд Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар баталгаажуулсан үндсэн эрхийн нэг юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийн оролцоог хангах нь хүн хилсээр ял шийтгэгдэхгүй байх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуульд заасан журмын дагуу явагдах чухал баталгаа юм.

Шүүх хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа хойшлуулж байгаа нөхцөл байдлыг хязгаарлах үүднээс өмгөөлөгчид хариуцлага тооцох зохицуулалтыг тусгасан бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, хариуцлага хүлээлгэх талаарх мэдээллийг Монголын өмгөөлөгчдийн холбоонд даруй хүргүүлэхээр тусгалаа. Тус зохицуулалт нь улсын яллагчид мөн хамаарах бөгөөд энэ тохиолдолд харьяалах прокурорын байгууллагад мэдэгдэж, мэдээллийг даруй хүргүүлэхээр зохицуулсан болно.

Түүнчлэн шүүгдэгчийн гэм буруутай эсэхийг хянан хэлэлцэх үндсэн шүүх хуралдааны бэлтгэлийг талуудын оролцоотой хангаж, шүүх хуралдаан хойшлогдох явдлыг багасгах зорилгоор 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах журмыг шинээр хуульчилсан бөгөөд мөн хуулийн 33.1 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт “Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт оролцох хүсэлт гаргасан тохиолдолд хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг оролцуулж болно. Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч ирээгүй нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болохгүй.” гэж заасан.

Ийнхүү шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг шүүх нэг удаа явуулах агуулгаар дээрх заалтыг хуульчилсан боловч хуулийн буруу хэрэглээ тогтож, оролцогч ирээгүй нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг удаа дараа хойшлуулах шалтгаан болсоор байна. Иймд прокурор, оролцогч ирээгүй нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болохгүй байх зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлд тусгалаа.

Түүнчлэн шүүгдэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй тохиолдолд шүүх хуралдааныг хойшлуулахгүй бөгөөд шүүгдэгч шүүх хуралдаанд оролцож, шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэг өгөх эрхээ эдэлсний дараа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдааныг орхин явж, шүүх хуралдаанд оролцохоос санаатай зайлсхийсэн бол шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулж, гэм буруутай эсэхийг эцэслэн шийдвэрлэхээр тусгалаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүх хуралдааныг хойшлуулахад талуудын санал, хүсэлтийг харгалзан дараагийн шүүх хуралдааны товыг тогтоож, хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээг авна.” гэж заасан ба шүүхийн практикт шүүх хуралдааныг 1 сар, түүнээс илүү хугацаагаар хойшлуулах явдал гарсаар байна.

Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх ашигт сөргөөр нөлөөлж байх тул шүүх хуралдааныг 14 хүртэл хоногийн хугацаагаар хойшлуулдаг практик тогтоож хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэн, шуурхай явуулах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар “...Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.9 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт болон 40.8 дугаар зүйлийн 1.3 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсон” бөгөөд анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанаас хэргийг прокурорт буцаах, түүнчлэн давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хэргийг дахин хэлэлцүүлэхээр доод шатны шүүхэд буцаах эрх хэмжээгүй болсон.

Зөвхөн анхан шатны шүүх хуралдааны явцад нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг үндэслэн шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэх шаардлагатай болсон, эсхүл хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан болон нотлох баримт цуглуулж, бэхжүүлэхэд хуульд заасан журам зөрчигдсөн талаар талуудын гаргасан гомдлыг шийдвэрлэх шаардлагатай нөхцөлд шүүх хуралдааныг нэг удаа 60 хүртэл хоногийн хугацаагаар хойшлуулж, шаардлагатай ажиллагаа явуулахыг прокурорт даалгах замаар мөрдөн байцаалтын шатанд гарсан хууль хэрэглээний алдааг зөвтгөх зохицуулалт үйлчилж байна.

Хэргийн бүрдэл хангагдаагүй буюу мөрдөн шалгах ажиллагааны явцад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлд заасан нотолбол зохих байдлыг дутуу шалгасан, хэрэгт цугларсан нотлох баримтууд нь гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдлыг хөдөлбөргүй тогтооход хүрэлцэхүйц байх нотолгооны стандартыг хангаагүй, түүнчлэн мөрдөн байцаалтын шатанд оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан болон нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар хуульд заасан журам зөрчсөн алдааг шүүхийн шатанд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.16 дугаар зүйлийн 5, 6, 7 дахь хэсэгт заасан журмын дагуу 60 хоногт багтаан нөхөн гүйцэтгэх боломжгүй, хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэн өөрчилж, эсхүл зарчмын өөр агуулгатай ял сонсгох шаардлагатай нөхцөлд хуулийн зорилт, нийтлэг зарчмуудад нийцүүлэн холбогдох өөрчлөлтийг тусгах шаардлага үүсээд байна.

Иймд шүүх хуралдааны явцад нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг үндэслэн шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэхээр бол, эсхүл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6.13, 6.14-т заасан гомдлыг шийдвэрлэх зорилгоор шүүх хэргийг хянан хэлэлцэхийг зөвхөн нэг удаа 60 хүртэл хоногийн хугацаагаар хойшлуулдаг байсан зохицуулалтыг өөрчилж, шүүхээс даалгасан ажиллагааг прокурор шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлэх боломжгүй бол шүүх хуралдааныг 60 хүртэл хоногоор хойшлуулсныг дахин 30 хүртэл хоногоор нэмж хойшлуулах зохицуулалтыг тусгалаа.[13]

Мөн тус хуулийн төслийн үзэл баримтлалд дараах байдлаар авч үзжээ.

-Шүүх хуралдаан хойшилж буй шалтгаан нөхцөлийн дийлэнх нь өмгөөлөгчтэй холбоотой болох нь шүүхийн практикт хийсэн судалгаагаар харагддаг бөгөөд шүүх хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа хойшлуулж байгаа нөхцөл байдлыг хязгаарлах үүднээс өмгөөлөгчийн хариуцлагатай холбоотой асуудлыг хуульчлах шаардлагатай байна.

Түүнчлэн шүүгдэгчийн гэм буруутай эсэхийг хянан хэлэлцэх үндсэн шүүх хуралдааны бэлтгэлийг талуудын оролцоотой хангаж, шүүх хуралдаан хойшлогдох явдлыг багасгах зорилгоор 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах журмыг шинээр хуульчилсан бөгөөд мөн хуулийн 33.1 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт “Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт оролцох хүсэлт гаргасан тохиолдолд хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг оролцуулж болно. Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч ирээгүй нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болохгүй.” гэж заасан.

Ийнхүү шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг шүүх нэг удаа явуулах агуулгаар дээрх заалтыг хуульчилсан боловч хуулийн буруу хэрэглээ тогтож, оролцогч ирээгүй нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг удаа дараа хойшлуулах шалтгаан болсоор байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүх хуралдааныг хойшлуулахад талуудын санал, хүсэлтийг харгалзан дараагийн шүүх хуралдааны товыг тогтоож, хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээг авна.” гэж заасан ба шүүхийн практикт шүүх хуралдааныг 1 сар, түүнээс илүү хугацаагаар хойшлуулах явдал гарсаар байна.

Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх ашигт сөргөөр нөлөөлж байх тул шүүх хуралдааныг түргэн, шуурхай явуулах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

13 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга, ХЗДХЯ, (2024).

-Тухайн хэргийн ээдрээ төвөгтэй байдал, эсхүл ажиллагаа ихтэй, олон яллагдагчтай, эсхүл олон үйлдэлтэй зэрэг нөхцөл байдлыг харгалзан шаардлагатай тохиолдолд мөрдөн байцаалт явуулах хугацааг сунгаж болох зохицуулалтыг хуульчилсан боловч олон оролцогчтой хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг хэрхэн, ямар журмаар явуулах нь тодорхойгүй байх тул нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.[14]

Дээрхээс дүгнэвэл, хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь шүүх хуралдааныг үндэслэлгүйгээр хойшлуулж байгаатай холбоотойгоор өмгөөлөгчид хариуцлага тооцох, шүүгдэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй тохиолдолд шүүх хуралдааныг хойшлуулахгүй байх, прокурор шүүхээс тогтоосон хугацаанд даалгаврыг биелүүлэх боломжгүй бол дахин сунгах зэрэг зохицуулалтыг тусгасан нь хуулийн төслийн өөрчлөлтийн зорилго, үзэл баримтлалд нийцэж байна.

Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төвөөс хийсэн “Шүүх хурал хойшлох шалтгаан, нөхцөлийг тодруулах нь” судалгааны тайланд шүүх хуралдаан хойшлох нөхцөл байдлыг дараах байдлаар авч үзсэн.

Шүүх хуралдаан хойшлоход нөлөөлж буй шалтгаан нөхцөлийг тодорхойлох зорилтын хүрээнд:

• Шүүх хурал дор хаяж 2-3 удаа хойшлох магадлал өндөр бөгөөд шүүх хурал хойшилсноор хүндрэл үүссэн гэж 87.5 хувь нь үзсэн байна. Ихэвчлэн анхан шатны иргэний хэрэг дээр хүндрэл үүсдэг байна.

• Хэрэг хянан шийдвэрлэх хугацааны хувьд дийлэнх иргэд хэрэг маргаанаа 1-5 сарын хугацаанд асуудлаа шийдвэрлүүлж байна.

• Шүүх хуралдаан хойшилсноор онлайн судалгаанд оролцогчийн 34 хувь нь, цаасан судалгаанд оролцогчдын 53 хувь нь маш их болон нэлээн хүндрэл үүсгэсэн гэжээ.

• Эрүү, иргэн, захиргааны хэргийн төрлөөс үл хамааран өмгөөлөгч авах хүсэлт гаргасан, өмгөөлөгч өвчтэй, хэргийн материалтай танилцах хүсэлт гаргасан болон өмгөөлөгчийн хурал давхацсан гэсэн шалтгаанаар ихэнх хурлууд хойшилж байна.

• Мөн шүүх хурлын 48.1-56.7 хувь нь хэргийн оролцогч талуудаас хамаарч байгаа бол 41.1-42.7 хувь нь өмгөөлөгчтэй холбоотой асуудлаас харин 1.2-9.2 хувь нь шүүх болон хууль зүйн байгууллагууд хамааралтай асуудлаас болж хойшилж байна.

Шүүх хуралдаан хойшлоход үүсэх үр дагаврыг тодорхойлох зорилтын хүрээнд:

• Онлайн судалгааны хувьд олонх нь шүүх хуралдааныг үргэлжлүүлэх нь зөв гэсэн бол харин цаасан суурьт судалгааны хувьд хойшлуулах нь зөв байсан гэжээ.

• Тийм зөв гэж хариулсан хүмүүсийн олонх нь эрэгтэйчүүд харин үргэлжлэх нь буруу гэж хариулсан хүмүүсийн дийлэнх нь эмэгтэйчүүд байв.

• Шүүх хуралдаан хойшилсноор хохирлоо төлүүлэх цаг хугацаа алдсан, олон удаа нааш цааш явж зардал их гаргасан, дараа дараагийн төлөвлөсөн ажилд сөргөөр нөлөөлсөн гэх хувилбарууд нийт 15 сөрөг үр дагаврын дийлэнх хувь болох 67.9 хувийг эзэлж байгаа бөгөөд онлайн судалгааны үр дүнтэй ижил байна. Үүнээс шүүхтэй шууд холбоотой байж болох сөрөг үр дагаврын 2.2 хувь нь шүүгчийн бие даасан байдалд эргэлзсэн, 1.7 хувь нь шүүх, шүүгчийн ачаалал нэмэгдэх, 1.7 хувь

14 Мөн тэнд.

нь шүүгчийн мэргэжлийн ур чадварт эргэлзсэн байна.[15]

Тус нэмэлт, өөрчлөлтийн зохицуулалт нь тус практик судалгааны үр дүнд тогтоосон асуудлыг шийдэхэд мөн түлхэц үзүүлэх тул зорилгодоо нийцсэн гэж үзэхээр байна.

3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хууль тогтоомжийн төслийн зохицуулалт нь тодорхой тохиолдолд үйлчлэх, бодит байдал дээр хэрэгжих эсэхийг үнэлнэ. Энэхүү хүрээнд хуулийн төслийн холбогдох зохицуулалтад баримтын судалгааны аргад тулгуурлан дүн шинжилгээ хийлээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Тус төслөөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.16 дугаар зүйлийг нэмж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулахыг дараах байдлаар зохицуулжээ.

- Шүүх хэргийн оролцогчтой харилцах, хэргийн материалыг оролцогчид танилцуулах, шүүх хуралдаан, шүүхийн хэлэлцүүлэг явуулах, баримт бичиг хүлээн авах, хүргэх ажиллагааг цахим платформ ашиглан цахимаар явуулж болно.

- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг, хавтаст хэрэг нь шүүхийн цахим платформын техникийн шаардлагад нийцсэн байна.

- Хэргийн оролцогчтой цахимаар харилцахад төрийн байгууллага, албан тушаалтны албаны цахим шуудан, албан бичиг солилцооны дундын систем, мэдэгдэл хүргэх систем, төрийн үйлчилгээний нэгдсэн систем, мэдэгдэл хүргэх системд иргэний үүсгэсэн, бүртгүүлсэн цахим шуудан, тухайн этгээдийг таньж, баталгаажуулах боломжтой бусад цахим систем, өмгөөлөгчийн Монголын Өмгөөлөгчдийн Холбооны цахим системд бүртгүүлж холбогдсон цахим шууданг ашиглана.

- Өмгөөлөгч тайлбар, гомдол, хүсэлт зэрэг баримт бичгийг цахим баримт бичгээр хүргүүлнэ. Техникийн шалтгаанаар ийнхүү хүргүүлэх боломжгүй тохиолдолд цаасан баримт бичгээр ирүүлж болох бөгөөд энэ тохиолдолд техникийн боломжгүй байсан шалтгаанаа нотолж цахим баримт бичгээр нөхөн ирүүлж болно.

- Мөрдөгч, прокуророос шүүхэд хүргүүлэх эрүүгийн хэрэг, баримт бичгийг шүүхийн цахим платформын техникийн шаардлагад нийцүүлж цахим баримт бичгийн хэлбэрт хөрвүүлж, албан тушаалтны цахим гарын үсгээр баталгаажуулан хүргүүлнэ. Шүүхийн шатанд цахим баримт бичгээр хүргүүлэх боломжгүй цаасан баримт бичгийг шүүхийн захиргааны ажилтан цахим баримт бичигт хөрвүүлнэ.

Түүнчлэн 11.11 дүгээр зүйлийн 2, 7 дахь хэсэгт дараах зохицуулалтыг нэмсэн.

- Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хавтаст хэрэг нь мэдээллийн системийг ашиглан үүсгэх, боловсруулах, хадгалах, илгээх болон хүлээн авах боломжтой цахим хэлбэртэй байж болно

15 Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв, “Шүүх хурал хойшлох шалтгаан, нөхцөлийг тодруулах нь”, (Уб, 2023), 40 дэх тал.

- Хавтаст хэргийг цахимжуулах, шүүх, прокурор, мөрдөн шалгах эрх бүхий байгууллагуудын нэгдсэн системд холбох журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

Хуулийн төсөлд дээрх байдлаар зохицуулсан байна. Энэхүү зохицуулалтыг бусад улсын сайн туршлагатай харьцуулан үзэх нь зүйтэй. Тухайлбал, ХБНГУ, Бүгд Найрамдах Эстони Улс, АНУ, БНСУ болон олон улсын гэрээ конвенцод хэрхэн зохицуулсан талаар судлан үзэх нь зүйтэй.

Дээрх улс орнууд болон олон улсын гэрээ конвенцын зохицуулалтын талаар “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ (Цахим хавтаст хэрэг, цахим нотлох баримт, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт) сэдэвт судалгааны тайлангийн 3.1.3, 3.2.3, 3.3.3 дахь хэсгээс үзнэ үү.

Бусад улс орны сайн жишгийг харгалзан үзэж тухайлбал, БНСУ-д цахим нотлох баримтыг ангилан тодорхойлдог энэ мэт сайн жишгийг харгалзан үзэх, өөрийн улс орны онцлогт тохируулан авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

Хуулийн төслийн сэжигтэн, гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэх ойлголттой холбоотой зохицуулалт ЭХХШтХ-ийн практикт хэрэгжих боломжтой эсэх

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13-т “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно...” гэж мөн зүйлийн 14-т “ өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно....” гэж хүний халдашгүй байх, өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх үндсэн эрхийг баталгаажуулсан. Мөн ЭХХШтХ-ийн 1.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “…Шүүх прокурор, мөрдөгч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс гэм буруугүй болохыг өөрөөр нь нотлуулахаар, шаардахыг хориглоно…” гэзд тодорхой заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 11 сарын 4-ний өдрийн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлийн зарим хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 10 дугаартай дүгнэлтийн 3-т “…Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрхийг үндэслэлгүй хязгаарласан шинжгүй, хууль зүйн процессын суурь зарчмуудад нийцсэн байх ёстой. Энэ утгаараа хуульд гэмт хэрэгт сэрдэгдэж байгаа этгээдийн эрх зүйн байдлыг дээрх хуулиар нарийвчлан зохицуулж өгөөгүйн улмаас тухайн этгээдээс гэрчийн мэдүүлэг авч, түүний эрхийг хөндөх байдал гаргахаар байгааг хууль тогтоогч анхаарч, хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага байна..."

гэж дүгнэсэн.[16]

ЭХХШтХ 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлснээс хойш нийт 16 удаа нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд хамгийн сүүлд 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оржээ. 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар ЭХХШтХ-д сэжигтэнтэй холбоотой зарим зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт орсон. Тухайлбал, ЭХХШтХ-ийн 31.5 дугаар зүйлийг өөрчлөн найруулж, зүйлийн нэрийг “Сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах” байсныг “Сэжигтнийг хойшлуулахгүйгээр баривчлах” болгон өөрчилж, тухайн зүйлийн зохицуулалтыг өөрчлөн найруулжээ. Мөн ЭХХШтХ-ийн 2.2 дугаар зүйлийн 10-12 дахь хэсэг, 5.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, 16.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 31.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 31.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч тус өөрчлөлт нь 2024 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлэх юм.

Хуульд ийнхүү өөрчлөлт оруулах болсон үндэслэл, шаардлагаа “…Сэжигтнийг баривчлах ажиллагааны 98-99 хувийг шүүхийн зөвшөөрөлгүй явуулж буй өнөөгийн нөхцөл байдлаас харахад Монгол Улсад баривчлах ажиллагаа үндсэндээ шүүхийн хяналтаас гадуур хэрэгжиж байна.[17] Сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан үндэслэлүүдийг 2020, 2021, 2022 оны байдлаар авч үзвэл, нийт баривчлах ажиллагааны 60-аас дээш хувийг “хойшлуулшгүй тохиолдолд” гэсэн үндэслэлээр баривчилсан байна.[18] Шүүхийн зөвшөөрөлгүй баривчлаад үргэлжлүүлэн цагдан хорьсон тохиолдол 2020 онд 448 буюу 56.4 хувь, 2021 онд 496 буюу 61.3 хувь, 2022 онд 595 буюу 55.5 хувийг тус тус эзэлж байна. Шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан сэжигтний 42.1 орчим хувийг 24-48 цаг хорьсны дараа суллажээ.[19] Иймд сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаа явуулахад практикт хамгийн их хэрэглэгддэг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т заасан “хойшлуулшгүй тохиолдол” гэх үндэслэлийг “өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах, эсхүл оргон зайлах, эсхүл хэргийн ул мөр, эд мөрийн баримт, нотлох баримтыг устгах, өөрчлөх, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдүүлэх, хуурамчаар үйлдэх, гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргээ төгсгөх, эсхүл гэрч, хохирогч, хамтран гэмт хэрэг үйлдсэн хүнд хууль бусаар нөлөөлөх үндэслэл илэрсэн” гэж шинжийг өргөжүүлж, нарийвчлан[20] тусгаж ЭХХШтХ-ийн холбогдох зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулсан гэжээ.

Тус нэмэлт, өөрчлөлтөөс өмнө 2020 оны ЭХХШтХ-ийн нэмэлт, өөрчлөлтөөр тус хуулийн 31.8 дугаар зүйлд “Баривчлагдсан сэжигтний эрх”-ийг засаж сайжруулан “Сэжигтнийг эрх” болгон өөрчилсөн боловч тус нэмэлт, өөрчлөлтөөр сэжигтэнтэй холбоотой асуудлыг бүхэлд нь шийдвэрлэж чадаагүй юм.

Энэ мэтчилэн, ЭХХШтХ-ийн сэжигтэнтэй холбоотой зохицуулалтад хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч өнөөдрийг хүртэл тухайн асуудлыг бүрэн шийдвэрлэж чадаагүй байна. Нөгөөтээгүүр, 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар оруулсан сэжигтэнтэй холбоотой нэмэлт, өөрчлөлтийг дагаж

16 ЭХХШтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга, ХЗДХЯ, (2024).

17 Мөн тэнд.

18 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 02/311 дүгээр албан бичиг.

19 Мөн тэнд.

20 ЭХХШтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга, ХЗДХЯ, (2024).

мөрдөгдөж эхлээгүй байгаа учир энэхүү хуулийн төсөлд сэжигтэнтэй холбоотой зохицуулагдаагүй үлдсэн, засаж сайжруулбал зохих бүх асуудлыг цогц байдлаар судлан тусгаж хуульчлах нь нэн чухал юм.

Энэхүү хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгад "…Хүнийг гэмт хэрэгт сэжиглэх илэрхий, хангалттай үндэслэл байсаар атал гэрчээр мэдүүлэг авсаны дараа баривчлах, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэний дараа сэжигтэн болгох нь Үндсэн хуулиар баталгаажсан "өөрийгөө өмгөөлөх" эрх, "өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байх тул гэрчээр мэдүүлэг авч байх үед гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл тогтоогдвол мэдүүлэг авах ажиллагааг зогсоож, сэжигтнээр мэдүүлэг авах ажиллагааг хуульд заасны дагуу явуулах зохицуулалтыг тусгах шаардлагатай байна. Иймд хүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл байгаа бол түүнийг гэрчээр дуудах, эсхүл түүнээс гэрчийн мэдүүлэг авахгүй байх, гэрчийн мэдүүлэг авах үед түүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл илэрсэн бол гэрчийн мэдүүлэг авахыг даруй зогсоож, сэжигтнээр мэдүүлэг авах ажиллагааг хуульд заасны дагуу явуулах зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.3 дугаар зүйлд тусгалаа…" гэжээ.

Хуулийн төслийн 16.3 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт "…Гэрчээр мэдүүлэг авч байх үед энэ зүйлийн 4.7-д заасан үндэслэл илэрвэл энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан эрхийг сануулж мэдүүлэг авах ажиллагааг зогсоож, сэжигтнээр мэдүүлэг авах ажиллагааг энэ хуульд заасны дагуу явуулна..." гэж заажээ.

Практикт сэжигтнийг баривчилсан тохиолдолд л сэжигтнээр, бусад үед гэрчээр мэдүүлэг авч байна. Учир нь ЭХХШтХ-ийн 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 1/ баривчлагдсан, 2/ яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар дуудагдсан хүнийг сэжигтэн гэнэ гэж тодорхойлсон. Иймээс баривчлагдсан тохиолдолд сэжигтэн, баривчлагдаагүй бол сэжигтэн биш учраас гэрчээр мэдүүлэг авдаг.

Нөгөөтээгүүр, гэмт хэрэг үйлдэгдсэний дараа тухайн иргэнийг гэмт хэрэгт холбогдуулан сэжигтэн, эсхүл яллагдагчаар татаж шалгах үндэслэл бүхий нөхцөл байдал тогтоогдсон байхад мөрдөгч нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.6 дугаар зүйлийн 31.6.4-т заасны дагуу сэжигтнээр мэдүүлэг авах ёстой байтал өөрийнх нь эсрэг гэрчээр мэдүүлэг авч, уг мэдүүлгийг нотлох баримтаар тооцож прокурор яллах дүгнэлт үйлдсэн тохиолдол гарч байна.[21]

ХБНГУ-ын эрүүгийн эрх зүйд гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй сэрдэгдэж буй хүн /Verdächtiger/, сэжигтэн, /Beschuldigter/, яллагдагч /Angeschuldigte/ гэсэн нэр томьёо байдаг бөгөөд Verdächtiger буюу сэрдэгдэж буй хүн нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч биш тул хуульд тухайн субъектийн талаар зохицуулалт байдаггүй.[22]

Хуулийн төсөлд шинээр тусгагдаж буй "гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн" гэх нэр томьёо нь ХБНГУ-ын гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй сэрдэгдэж буй хүн гэх ойлголттой төстэй мэт боловч хуулийн төслийн "гэмт хэрэгт сэжиглэх

21 ННФ, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь өмгөөлөгчийн оролцооны эрх зүйн асуудал, (Уб, 2024), 44 дэх тал.

22 Мөн тэнд.

үндэслэлтэй хүн" гэх нэр томьёог гэмт хэрэг үйлдсэн гэж буруутгах нотлох баримт хавтаст хэрэгт тусгагдсан, мөрдөн шалгах ажиллагаагаар тогтоогдсон гэж тодорхойлсон учир ХБНГУ-ын гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй сэрдэгдэж буй хүнээс илүү гэмт хэрэг үйлдсэн нь баримтаар тогтоогдсон хүнийг тодорхойлсон байна. Энэ утгаараа "гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн" гэх ойлголт ЭХХШтХ-д заасан сэжигтэнтэй ойролцоо утга агуулгатай болж байна.

Монгол Улсын ЭХХШтХ-д "сэжигтэн"-г эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч байхаар тус хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.13 дахь заалтад тодорхойлсон бөгөөд гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй гэж хуульд заасан үндэслэлээр сэрдэгдсэн, хууль ёсны эрх ашиг, сонирхлоо хамгаалуулах, хууль зүйн туслалцаа авах эрхтэй субъект юм. Хууль заасан үндэслэлээр сэрдэгдэнэ гэдэг нь ЭХХШтХ-ийн 1.4 дүгээр зүйлийн 1.23 дахь заалтад заасан "үндэслэл бүхий сэжиг" гэж энэ хуульд заасан тодорхой ажиллагаа явуулах нөхцөл үүссэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй гэмт хэргийн талаарх мэдээлэл, хэргийн нөхцөл байдалд тулгуурласан мөрдөгч, прокурор, шүүгчийн дотоод итгэлийг хэлнэ гэжээ.[23]

Шүүгч, прокурор, мөрдөгчийн дотоод итгэл гэдэг нь хувь хүний асуудалд хандах сэтгэл зүйн хандлага ч биш хувийн итгэл үнэмшил ч биш бөгөөд аливаа хэрэг, маргааныг шийдвэрлэхэд ач холбогдолтой баримтын хүрээг зөв тодорхойлж эх сурвалжийг тогтоосон, тэдгээр нь хөдөлбөргүй нотлогдсон талаар мэргэжлийн ур чадварт тулгуурласан итгэл үнэмшил бөгөөд уг итгэл үнэмшилдээ хуульд нийцүүлж гаргасан шийдвэрээр баталгаажуулж байдаг. Эрх бүхий албан тушаалтан хуулиар бусдыг гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй гэж сэжиглэх үндэслэл буюу эрхийг баталгаажуулснаар хүний эрхэнд халдах боломж, нөхцөл бүрдэж байгаа бол нөгөө талдаа сэжиглэгдэж буй хүнд өөрийгөө хамгаалах эрх буюу боломж нь давхар үүсч байх ёстой.[24]

Харин сэжигтэн /Beschuldigter/ гэсэн нэр томьёо нь прокурор, мөрдөгчийн дотоод итгэлээр гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй гэсэн хангалттай үндэслэлээр хүнээс мэдүүлэг авсан тэр цаг мөчөөс тухайн хүн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч болж ирдэг. Сэжигтнээр тооцох эсхүл тогтоох гэсэн шийдвэр гардаггүй бөгөөд мэдүүлэг авахдаа эрх үүргийг нь шууд тайлбарлан өгдөг.

ХБНГУ-ын ЭХХШтХ-ийн /STPO/ 133 дугаар зүйлд сэжигтнийг мэдүүлэг авахаар бичгээр дуудан ирүүлэх ажиллагааг, 134 дүгээр зүйлд түүнийг баривчлах хангалттай үндэслэл байгаа тохиолдолд шууд албадан ирүүлэх ажиллагааг зохицуулсан байдаг. Сэжигтнийг ямар хэрэгт буруутгаж байгааг эхэлж тайлбарлахдаа мөрдөгч, прокурор түүнийг холбогдуулан шалгаж байгаа хэргийн талаар тодорхой тайлбарлах үүрэгтэй бөгөөд ингэхдээ тодорхой бус, битүүлэг эсхүл үл ойлгогдох байдлаар илэрхийлж болохгүй.

Монгол Улсын ЭХХШтХ-д сэжигтнийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч гэж хуульчилсан атлаа сэжигтнээс мэдүүлэг авах ажиллагаа зохицуулагдаагүй бөгөөд хэрэгт сэрдэгдэж буй хүнээс гэрчийн мэдүүлэг авах нь түүний үндсэн эрхийг ноцтой зөрчиж "сэжигтэн"-ий статус, эрх үүргийг

23 Б.Өнөрмаа, "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны "оролцогч биш" оролцогч буюу "сэжигтний" талаарх зохицуулалтын ХБНГУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн /stpo/ зохицуулалттай харьцуулах нь", Хууль дээдлэх ёс сэтгүүл, №1 (71), (Уб, 2019), 18 дахь тал.

24 Мөн тэнд.

тодорхойлоогүй нь Үндсэн хуульд харшилж байна.[25]

Иргэдийн хувьд “гэрч” нэртэй ямар хэрэгт сэжиглэгдэж байгаагаа мэдэхгүй “сэжигтэн” яваад байдаг. Гэрчийн эрх, үүрэг өөр, өөрийгөө өмгөөлөх эрхийн асуудал яригдахгүй. Статус тодорхой бол ямар хэрэгт сэжиглэгдэж шалгагдаж байгаагаа эрт мэдэж, өөрийгөө өмгөөлөх эрхээ шаардах боломжтой.[26] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гол оролцогч атлаа эрх үүрэг нь тодорхой бус оролцогч “сэжигтэн”-ий эрх зүйн байдлыг тодорхойлох, тухайлбал сэжигтэн нь дээрх ажиллагааны гол оролцогчийн хувьд гэрчийн мэдүүлэг өгч байгаа нь гэм буруугүйгээ өөрөө нотлох үүрэг хүлээж буй хуулийн хийдлийг арилгах зохицуулалт хийх буюу сэжигтнээс мэдүүлэг авах, эрх, үүргийг нь танилцуулах тодорхой заалтыг хуульд тусгаж өгөх шаардлагатай байна.[27]

Түүнчлэн, НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан ажлын хэсгийн ахлагч Элина Штайнертегийн мэдээлснээр олон тохиолдолд цагдаа гэрчээр мэдүүлэг өгүүлэхээр дууддаг ч сэжигтэн болж хувирдаг байдал газар авсан. Цагдаагийн байгууллагад байцаалт өгөхөөр дуудагдсан иргэд олон цагаар хүлээж, хүнд сурталд өртдөг, дээр нь, цагдаа иргэнийг сэжигтэн эсхүл гэрчээр дуудаж мэдүүлэг авч байгаа эсэх нь ихэнх тохиолдолд тодорхой бус байдаг гэжээ. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэн өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх үндсэн эрхтэй гэсэн баталгаа нь бодит байдал дээр хэрэгжилт тааруу байгааг харуулж буй нэг жишээ юм. Мөрдөн шалгах ажиллагааны явцад гэмт хэрэгт сэжиглэгдэж буй этгээдээс гэрчийн мэдүүлэг авдаг, түүнийг өөрийнх нь эсрэг нотлох баримт болгож ашигладаг, худал гэрчийн мэдүүлэг өгсөн гэх зэргээр яллах буруу практик бодитой бий.[28]

Процессын шударга байдал нь шударгаар шүүгдэх эрхийн суурь юм. Гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа хүнийг хууль, эрх зүйн мэдлэг, ойлголт бага байгааг ашиглан гэрчээр мэдүүлэг авч өөрийгөө өмгөөлөх боломжийг хаадаг, дараа нь тухайн иргэнийг сэжигтэн, яллагдагчаар татсаны дараа мэдүүлэг зөрвөл гэрчийн мэдүүлэг худал өгсөн гэж яллаж буруутгадаг явдал оршсоор байна. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд өмгөөлөгчийн эрх, оролцоо хязгаарлагдмал байдгаас өмгөөлөгч шүүхийн өмнөх шатанд нотлох ажиллагаа явуулах боломж бага, яллах тал болох прокурорын яллах нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажил давамгайлсан байдаг.[29]

Тиймээс ч дээрх асуудлуудыг шийдвэрлэх үүднээс энэ хуулийн төсөлд сэжигтэнтэй холбоотой хэд хэдэн зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгажээ. Гэхдээ хуулийн төсөлд дан ганц сэжигтэн бус “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэх нэр томьёог тусгасан нь практикт хуулийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэхэд хүндрэлтэй зохицуулалт болохоор байна.

25 Мөн тэнд.

26 ННФ, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь өмгөөлөгчийн оролцооны эрх зүйн асуудал, (Уб, 2024), 43-44 дэх тал.

27 Б.Өнөрмаа, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны “оролцогч биш” оролцогч буюу “сэжигтний” талаарх зохицуулалтын ХБНГУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн /stpo/ зохицуулалттай харьцуулах нь”, Хууль дээдлэх ёс сэтгүүл, №1, (71), (Уб, 2019) 18 дахь тал.

28 ННФ, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь өмгөөлөгчийн оролцооны эрх зүйн асуудал, (Уб, 2024), 18 дахь тал.

29 Мөн тэнд.

Учир нь хуулийн төслийн 2 дугаар зүйлд зааснаар 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “баривчлагдсан,” гэсний дараа “эсхүл гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэж нэмэхээр заасан бөгөөд энэхүү заалтаас харвал сэжигтэн гэх ойлголтод гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн хамаарч байна. Дээрх зохицуулалтаас бусад гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэх нэр томьёо орсон хуулийн төслийн зохицуулалтуудыг харвал сэжигтэн, гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн нь өөр хоорондоо ялгаатай зохицуулалт болоод байна. Энэ нь хуулийн төслийн тухайн асуудалтай холбоотой зохицуулалтын зорилгод хүрэх байдал, практикт хэрэгжих боломж, хүлээн зөвшөөрөгдөх байдал, ойлгомжтой байдал, харилцан уялдааг алдагдуулж байна. Өөрөөр хэлбэл, хуулийн төслийн сэжигтэн, гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэх ойлголттой холбоотой зохицуулалтууд нь бүхэлдээ төслийн үр нөлөөг алдагдуулж байна.

Тухайлбал, хуулийн төсөлд 31.2 дугаар зүйлийн 9-12 дахь хэсгийг нэмэхээр тусгасан бөгөөд тухайн зүйлийн 9 дэх хэсэгт “Гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүнийг дуудан ирүүлэхэд энэ зүйлд заасан журмыг баримтлахгүй” гэж, 10 дахь хэсэгт “Гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүнийг мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлж болох ба энэ хуульд заасан албадлага хэрэглэх, шөнийн цагт дуудан ирүүлэхийг хориглоно” гэж, 11 дэх хэсэгт “Гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн өөрөө сайн дурааараа хүрэлцэн ирж мэдүүлэг өгөхөө зөвшөөрсөн тохиолдолд энэ бүлэгт заасан ажиллагааг явуулж болно” гэж, 12 дахь хэсэгт “Гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүнийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах, баривчлах энэ хуульд заасан үндэслэл тогтоогдвол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн журмыг баримтлан явуулна” гэж тус тус заажээ.

Тухайн заалтууд нь ЭХХШтХ-ийн 31.2 дугаар зүйл буюу “Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэний дараа хийгдэх ажиллагаа” хэсэгт тусгагдсан байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлд зааснаар 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан сэжигтэнд “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн”-ийг хамааруулахаар тусгасан хэрнээ хуулийн төсөлд тухайн зүйлд 9-12 дахь хэсэг нэмэхээр тусгахдаа сэжигтэн биш “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэж тусгасан нь сэжигтнээс ялгаатай ойлголт мэт харагдаж байна.

Мөн ЭХХШтХ-ийн 16.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэрчээр мэдүүлэг авч болохгүй хүнд хуулийн төслийн 16.3 дугаар зүйлийн 4.7 дахь хэсэг зааснаар “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэж нэмэхээр тусгажээ. Өөрөөр хэлбэл, төслийн 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” сэжигтэнд хамаарахаар тусгасан хэрнээ тухайн ойлголтыг сэжигтнээс ялгаатай мэтээр хуульд ялгамжтай байдлаар тусгаж байгаа нь ойлгомжгүй байдлыг бий болгож байна.

Түүнчлэн, хуулийн төслийн 31.3 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “...Сэжигтэн эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцах, гардан авахаас татгалзсан нь мөрдөн шалгах ажиллагаа явуулахад саад болохгүй” гэсний сэжигтэн гэдэгт “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” хамаарч байна. Гэвч ЭХХШтХ-д заасан сэжигтэнтэй холбоотой бүх зохицуулалт “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн”-д хамаарах эсэх нь эргэлзээтэй байна.

Иймд хуулийн төсөл тусгагдсан “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэх ойлголттой холбоотой зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэл учруулахаар байна.

Нэгэнт сэжигтний шинжийг агуулж буй субъект болохын хувьд “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэх ойлголтыг сэжигтнээс ялгаатай мэтээр хуулийн төсөлд тусгасан хэдий ч тухайн зохицуулалтыг тухайлан тусгасны ач холбогдол, хэрэгцээ шаардлага, ялгагдах онцлог, давуу тал гэх мэт зүйл байхгүй байгааг дурдах нь зүйтэй.

Иймд гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэх ойлголтыг хасаж, сэжигтэнг хуулийн нэр томьёо хэсэгт тодорхойлон хуульчилж, сэжигтэнтэй холбоотой зохицуулалтыг засаж сайжруулах нь илүү оновчтой.

3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Тус шалгуур үзүүлэлтээр хуулийн төслийн зүйл, заалт нь найруулга, хэл зүйн болон агуулгын хувьд ойлгомжтой байдлаар томьёологдсон болон логик дараалалтай боловсруулагдсан эсэхийг шалгана. Ингэхдээ Хууль тогтоомжийн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан болон “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримталсан эсэхийг нарийвчлан давхар шалгана. Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд бүхэлд нь дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн зохицуулалт нь ойлгомжтой, хууль зүйн техникийн шаардлагад нийцсэн эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Тухайн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дараах байдлаар дүн шинжилгээ хийж холбогдох дүгнэлт, саналыг боловсруулаа.

Хүснэгт 3.9. *Ойлгомжгүй байгаа хуулийн төслийн зохицуулалт*

№	Ойлгомжгүй байгаа хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Санал
1	Төслийн 25.1 дүгээр зүйлийн 18 дахь хэсэг	ЭХХШтХ-ийн 25.1 дүгээр зүйлд “Мэдүүлэг авах” зохицуулалтыг хуульчилсан бөгөөд төслийн 25.1 дүгээр зүйлийн 18 дахь хэсэгт “Гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүнийг гэрчээр дуудан ирүүлэхийг хориглоно” гэж заасан нь хуулийн 25.1 дүгээр зүйлд хамаарахгүй байна.	Төслийн 25.1 дүгээр зүйлийн 18 дахь заалтыг хамаарал бүхий ЭХХШтХ-ийн холбогдох зүйл, заалтад нэмж тусгах нь зүйтэй.
2	Төслийн 32.5 дугаар зүйлийн 1.7 дахь хэсэг	ЭХХШтХ-ийн 32.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...Мөрдөн шалгах ажиллагааг явуулсан боловч яллагдагчийн гэмт хэрэг үйлдсэн болох нь нотлогдохгүй бол эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгож, хавтаст хэргийн материалыг хэрэг бүртгэлтэд буцаана…” гэж заасан бөгөөд төслийн 32.5 дугаар зүйлийн 1.7 дахь заалтад тус зохицуулалттай агуулгын хувьд төстэй буюу “…нэмэлт нотлох баримтыг цуглуулах бүхий л ажиллагааг хийсэн боловч яллагдагч гэмт хэрэг үйлдсэн болох нь нотлогдоогүй…” гэх үндэслэлээр прокурорын хэргийг хэрэгсэхгүй болгох зохицуулалтыг нэмэхээр тусгажээ.	ЭХХШтХ-д агуулгын хувьд төстэй зохицуулалт байгааг харгалзан үзэж, тухайн зохицуулалтыг нэмж хуульд тусгах шаардлагатай эсэхийг нягтлан үзэх нь зүйтэй.

3	Төслийн 2 дугаар зүйлд заасан 7.3 дугаар зүйл	Төслийн 2 дугаар зүйлд 7.3 дугаар зүйлийн “танилцах,” гэсний дараа “хувийг авах” гэж нэмэхээр тусгажээ. Гэвч ЭХХШтХ-ийн 7.3 дугаар зүйлийн аль хэсэгт заасан “танилцах” гэсний дараа “хувийг авах” гэж нэмэхийг орхигдуулан бичжээ.	Төслийн 2 дугаар зүйлд заасан 7.3 дугаар зүйлийн “танилцах” гэсний дараа “хувийг авах” гэснийг 7.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “танилцах” гэсний дараа “хувийг авах “ гэж өөрчлөх.
4	Төслийн 2 дугаар зүйлд заасан 14.13 дугаар зүйл	Төслийн 2 дугаар зүйлд 14.13 дугаар зүйлийн “прокурор” гэсний дараа “яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч” гэж нэмэхээр тусгажээ. Гэвч ЭХХШтХ-ийн 14.13 дугаар зүйл нь 12 хэсгээс бүрдэж байна. Харин тус 12 хэсгийн аль хэсэг дэх “прокурор” гэсний дараа ““яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч” гэж нэмэх нь ойлгомжгүй байна.	Төслийн 14.13 дугаар зүйлийн аль хэсэг дэх “прокурор” гэсний дараа ““яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч” гэж нэмэх нь ойлгомжгүй байна. Иймд хэсгийн дугаарыг ойлгомжтой байдлаар тусгах.
5	Төслийн 2 дугаар зүйлд заасан 34.1 дүгээр зүйл	Төслийн 2 дугаар зүйлд 34.1 дүгээр зүйлийн “болохгүй.” гэсний дараа “Шүүгдэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй нь шүүх хуралдаан хойшлуулах үндэслэл болохгүй” гэж нэмэхээр тусгажээ. Гэвч төсөлд 34.1 дүгээр зүйлийн хэд дэх хэсэгт заасан “болохгүй.” гэсний дараа нэмж оруулахаар заагаагүй байна. ЭХХШтХ-ийн 34.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “болохгүй.” гэх үг тусгагдсан байна.	ЭХХШтХ-ийн 34.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “болохгүй.” гэх үг тусгагдсан байна. Иймд төслийн 34.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “болохгүй.” гэсний дараа “Шүүгдэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй нь шүүх хуралдаан хойшлуулах үндэслэл болохгүй” гэж өөрчлөх.
6	Төслийн 4 дүгээр зүйлд заасан 5.1 дүгээр зүйлийн 2.10-2.15 дахь заалтыг 2.12-2.16	Төслийн 4 дүгээр зүйлд заасан 5.1 дүгээр зүйлийн 2.10-2.15 дахь заалтын дугаарыг 2.12-2.16 гэж өөрчлөх талаар тусгажээ. Гэвч 2.10-2.15-д нийт 6 заалт хамааруй байх бөгөөд 2.12-2.16 гэж өөрчилснөөр нийт 5 зохицуулалтын дугаарыг өөрчлөхөөр тусгаж, нэг зохицуулалтын дугаарыг орхигдуулсан байна.	Төслийн 4 дүгээр зүйлд заасан 5.1 дүгээр зүйлийн “2.10-2.15 заалтын дугаарыг 2.12-2.16 гэж” гэсний орхигдуулсан дугаарыг оруулж “2.10-2.15 дахь заалтын дугаарыг “2.12-2.17” гэж өөрчлөх.
7	Төслийн 4 дүгээр зүйлд заасан 32.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	Төслийн 4 дүгээр зүйлд заасан 32.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “тэдний өмгөөлөгчид” гэснийг “тэдний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид” гэж өөрчлөх талаар тусгажээ. Гэвч ЭХХШтХ-ийн 32.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Мөрдөгч мөрдөн шалгах бүх ажиллагааг хийж дууссан, хэргийн бодит байдлыг бүрэн нотолж тогтоосон гэж үзвэл яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид хавтаст хэргийн материалтай танилцахыг мэдэгдэнэ.” гэж заасан. Өөрөөр хэлбэл, ЭХХШтХ-д оруулахаар тусгасан өөрчлөлт нь энэ хуулийн зохицуулалттай ижил байна.	ЭХХШтХ-ийн 32.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “тэдний өмгөөлөгчид” гэж бус өөрчлөлт оруулахаар тусгасан ““тэдний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид” гэх ойлголт ЭХХШтХ-д хуульчлагдсан байх тул зохицуулалтыг өөрчлөхөөр тусгасан нь ойлгомжгүй байдлыг бий болгож байна. Иймд төслийн тус зохицуулалтыг хасах.

3.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Тухайн хууль тогтоомжийн төсөлд тодорхой этгээдэд үүрэг хүлээлгэсэн, аж ахуй, байгууллагын салбарт хүндрэл үүсгэх зохицуулалт байх тохиолдолд хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон үнэлгээ хийнэ. Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд шинээр тусгасан зохицуулалт болох хуулийн төслийн 16.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 32.10 дугаар зүйлийн 9 дэх хэсэг, 36.13 дугаар зүйлийн

5, 6 дахь хэсэг, 3.2 дугаар зүйл, 31.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дүн шинжилгээ хийлээ.

Бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн талаар зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Тус хуулийн төслөөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт дараах нэмэлтийг оруулсан.

- Мөрдөн шалгах ажиллагааны явцад гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авахад бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хувийг шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох хүртэл, эсхүл хэрэг бүртгэлтийн хэргийг хаах, хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрийг давж заалдах хугацаа дуустал хадгална.

Хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгад энэ зохицуулалтыг дараах байдлаар тодорхойлсон.

Мөрдөн шалгах ажиллагааны үр дүнг бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг хавтаст хэрэгт нотлох баримтаар хавсаргаж, хэргийн хамт хадгалагддаг. Ингэхдээ хэргийн оролцогчоос мэдүүлэг авах процессыг бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг ямар хугацаанд хэрхэн хадгалах талаар зохицуулаагүй байна.

Иймд мэдүүлгийн тэмдэглэлүүд дууны болон дуу-дүрсний бичлэгээс зөрөх тохиолдол практикт гардаг бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.7 дугаар зүйлийн 2-т “Мөрдөн шалгах ажиллагаа, прокурорын хянан шалгах ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэлд тусгагдсан нөхцөл байдал нь дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгээс зөрсөн тохиолдолд шүүх, прокурор дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг нотлох баримтаар тооцно.” гэж заасан тул бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хувийг шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох хүртэл, эсхүл хэрэг бүртгэлтийн хэргийг хаах, хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрийг давж заалдах хугацаа дуустал хадгалах зохицуулалтыг тусгалаа.[30]

Одоогийн эрх зүйн зохицуулалтын дагуу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цахим нотлох баримт, түүнийг цуглуулах, бэхжүүлэх, шинжлэх судлах, үнэлэхтэй холбоотой холбогдох байгууллагуудаас гаргасан эрх зүйн акт, журмыг судлан үзвэл:

- 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны 31 дүгээр тогтоол, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөв хэрэглэх албан ёсны тайлбар;
- Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2021 оны 5 сарын 20-ны өдрийн А/69 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүгийн хэрэгт хөрөнгө, орлого, эд мөрийн баримт, эд зүйлийг хураан авах, бэхжүүлэх, хадгалах, хамгаалах, шилжүүлэх, шийдвэрлэх журам”;

30 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, (2024).

- 2019 оны 12 сарын 5-ны өдрийн Дугаар 246, А/80 Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий Прокурорын хамтарсан захирамж, тушаалын[31] нэгдүгээр хавсралтаар “Эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, барьцааны мөнгө, эд мөрийн баримтыг шийдвэрлэх журам”, хоёрдугаар хавсралтаар “Хавтаст хэргийг хүлээн авах, хадгалах, шилжүүлэх журам”-ыг тус тус шинэчлэн батлсан.
- Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2022 оны 4 сарын 15-ны өдөр дугаар А/42 тушаалын нэгдүгээр хавсралтаар “Эрүүгийн хэргийн тусгай, салбар архивт баримт хүлээн авах, тоо бүртгэл хөтлөх, хадгалах, ашиглуулах журам”, хоёрдугаар хавсралтаар “Архивт хөтлөгдөх тоо бүртгэлийн баримт бичиг, мэдээний жагсаалт, загвар”-ыг тус тус баталжээ.
- 2022 оны 1 сарын 6-ны өдрийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоол Дугаар 1 “Журам батлах тухай” буюу “Шүүхийн архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх журам”-ын 6 дугаар зүйлд цахим баримтыг хадгалах талаар тусгасан.
- 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн УДШ-ийн Ерөнхий шүүгч, ХЗДХ-ийн Сайд, УЕП-ын хамтарсан Дугаар А/18, 34, А/31 “Заавар батлах тухай”. Тус тушаалаар “Эрүүгийн болон зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдох баримтыг архивт хадгалах заавар”-ыг нэгдүгээр, “Эрүүгийн хэргийн төв болон салбар архивт хадгалагдаж байгаа баримтыг хадгалах хугацааны заавар”-ыг хоёрдугаар хавсралтаар баталсан.

Дээрх тайлбар, журмуудаар дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалалтын талаар зохицуулсан хэдий ч эрх зүйн хийдэлтэй, дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийг хадгалах сервер, багтаамжийн хүрэлцээ бага, практикт хэрэгжилт хангалтгүй байна. Иймд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалалтын талаарх бусад улс орны эрх зүйн зохицуулалтыг судлан, сайн туршлагыг харгалзан үзэх нь зүйтэй.

Зарим улсын дээрх эрх зүйн зохицуулалтын талаарх туршлагыг “Эрүүгийн хэрэг хянан шийдвэлэх тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ /Цахим хавтаст хэрэг, цахим нотлох баримт, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт/” сэдэвт судалгааны тайлангийн 3.3.3-аас үзнэ үү.

Түүнчлэн, бусад улсад хэргийн төрлөөс хамааруулан баримт бичгийг жилээр, эсхүл хөөн хэлэлцэх хугацааг дуусах хүртэл хугацаагаар хадгалдаг жишгийг харгалзан үзэх хэрэгтэй. Мөн нотлох баримт, эд мөрийн баримтын хадгалалт, хамгаалалтын талаар нэгдсэн журам боловсруулан гаргах шаардлагатай болохыг анхаарах нь зүйтэй.

31 “Эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, барьцааны мөнгө, эд мөрийн баримтыг шийдвэрлэх журам”, “Хавтаст хэргийг хүлээн авах, хадгалах, шилжүүлэх журам” http://old.supremecourt.mn/act/view/266

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь төрийн болон албаны нууцтай холбоотой зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд төрийн болон албаны нууцтай холбоотой шүүх хуралдаан, шүүхийн шийдвэр, яллах дүгнэлтийн зохицуулалтыг тусгасан байна.

Энэ тухай тус хуулийн төслийн танилцуулгад дараах байдлаар тодорхойлжээ.

“Шүүх хуралдааныг нээлттэй, хаалттай явуулсан, шүүхийн шийдвэрт төрийн болон албаны нууц мэдээлэл агуулагдсан эсэхээс үл хамаарч прокурор, оролцогчийг шүүхийн шийдвэр, түүний үндэслэлтэй бүрэн танилцах, уг шийдвэрийг эс зөвшөөрвөл эсэргүүцэл, гомдол гаргах эрхийг баталгаатай хангах нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан “... шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх...” хүний үндсэн эрхтэй салшгүй холбоотой билээ.

Шүүхийн шийдвэрийг оролцогчид гардуулах харилцааг журамласан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.5 дугаар зүйлийн 9 дэх хэсэг, 36.13 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 39.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 40.8 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн зохицуулалтаас үзэхэд Төрийн болон албаны нууц мэдээлэл агуулсан шийдвэрийг оролцогчид хэрхэн танилцуулах, эсхүл гардуулах асуудлыг хуульд нарийвчлан заахгүй орхигдуулжээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг баримтална.” хэмээн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зөвхөн эрүүгийн процессын хуулийг баримтлах зарчмыг хуульчлан заасан тул төрийн болон албаны нууц мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэрийг прокурор, оролцогчид гардуулах, танилцуулах талаар эрүүгийн процессын хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, тухайн харилцааг нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

Иймд төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан шүүх, прокурорын шийдвэрийг оролцогчид танилцуулах, гардуулан өгөх журмыг нарийвчлан тодорхойлсон.”[32]

Дээрх байдлаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нарийвчлан зохицуулахдаа 3 төрлийн процессын зохицуулалтыг хамааруулан нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгажээ.

1. Яллах дүгнэлтийг гардуулах талаар

32.10 дугаар зүйлд 9 дэх хэсгийг дараах байдлаар нэмсэн.

“9.Төрийн нууцтай холбоотой хэргийн яллах дүгнэлтийг бүрэн бодитой танилцуулж, төрийн нууц мэдээлэл агуулсан хэсгийг хассан хувийг гардуулан өгнө.”

32 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга, ХЗДХЯ, (2024).

2. Шүүхийн шийдвэрийн талаар

36.13 дугаар зүйлд 5, 6 дахь хэсгийг дараах байдлаар нэмсэн.

“5.Төрийн нууц мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэрийн нууц агуулаагүй “Удиртгал” болон “Тогтоох” хэсгийг нууцын тэмдэглэлээ, дардас дарахгүйгээр прокурор, оролцогчид гардуулж, нууц мэдээлэл агуулсан “Тодорхойлох” хэсгийг гардуулахгүйгээр, шүүхийн шийдвэрийг бүрэн бодитой танилцуулах арга хэмжээ авна.

6.Шүүхийн шийдвэрийн “Удиртгал” болон “Тогтоох” хэсэгт төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулагдсан бол тэр хэсгийг хасч хэвлэн, прокурор, оролцогчид гардуулна.”

3. Шүүх хуралдааны талаар

3.2 дугаар зүйлд дараах байдлаар өөрчлөлтийг оруулсан.

Хүснэгт 3.10. *Шүүх хуралдааны талаар орсон өөрчлөлт*

ОДОО	ӨӨРЧЛӨЛТ
3.2 дугаар зүйл.Шүүх хуралдааныг нээлттэй явуулах 1.Төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийг хамгаалах шаардлагатай, өсвөр насны яллагдагч, арван найман насанд хүрээгүй хохирогчтой холбогдох эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхээс бусад шүүхийн хэлэлцүүлэг, бүх шатны шүүх хуралдааныг нээлттэй явуулна. 2.Өсвөр насны яллагдагч, арван найман насанд хүрээгүй хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор улсын яллагч, хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан шүүх хуралдааныг нээлттэй явуулж болно. 3.Шүүх хуралдааныг хаалттай явуулсан бол шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг нийтэд уншиж сонсгоно.	“3.2 дугаар зүйл.Шүүх хуралдааныг нээлттэй, хаалттай явуулах 1.Төрийн болон албаны нууц, хүний эмзэг мэдээллийг хамгаалах шаардлагатай, өсвөр насны яллагдагч, арван найман насанд хүрээгүй хохирогчтой холбогдох болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хаалттай явуулахаар хуульд заасан эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхээс бусад шүүхийн хэлэлцүүлэг, бүх шатны шүүх хуралдааныг нээлттэй явуулна. 2.Өсвөр насны яллагдагч, арван найман насанд хүрээгүй хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор улсын яллагч, хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан шүүх хуралдааныг нээлттэй явуулж болно. 3.Хэргийн нотлох баримт, үйл явдал нь хүний эмзэг мэдээллээс бусад хувийн мэдээлэл болон байгууллагын нууц мэдээлэлд хамаарч байвал мэдээллийн эзэн буюу хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр шүүх хуралдааныг бүрэн, эсхүл түүний зарим ажиллагааг хаалттай явуулж болно. 4.Мэдээллийн эзэн зөвшөөрсөн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн ажиллагаан дахь хүний эмзэг мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод байлгаж болно. 5.Хаалттай шүүх хуралдааны явцад илэрхий болсон төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний хувийн мэдээллийг шүүгч, шүүх хуралдаанд оролцогч задруулж болохгүй. 6.Шүүх хуралдааныг хаалттай явуулсан бол шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг нийтэд уншиж сонсгоно.”

Ерөнхийд нь авч үзвэл нэмэлт, өөрчлөлтийн зохицуулалтад “Төрийн нууц”, “Албаны нууц”, “хүний эмзэг мэдээлэл”, “хувийн мэдээлэл”-тэй холбоотой эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар авч үзжээ.

Төрийн нууцын тухайд:

2016 онд батлагдсан Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх хэсэгт зааснаар төрийн нууцыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, задруулах, үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд аюул, занал, хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг хэлэхээр зохицуулжээ.

Мөн тус хуулийн 13 дугаар зүйлд хамаарах мэдээллийг нарийвчлан тусгасан байна.

13 дугаар зүйл. Төрийн нууцад хамааруулах мэдээлэл

13.1.Төрийн нууцад дараахь мэдээллийг хамааруулна:

13.1.1.төрийн бодлогын хүрээнд:

13.1.1.а.Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын үзэл баримтлал, номлолын нууцалбал зохих хэсэг;

13.1.1.б.Улсын Их Хурлын чуулган, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээлэл;

13.1.1.в.аливаа улстай харилцах Монгол Улсын чиг бодлого, байр суурийг нарийвчлан илэрхийлсэн мэдээлэл, гадаад орнуудаас итгэмжлэгдсэн байдлаар авсан мэдээлэл;

13.1.1.г.Засгийн газар, Төв банкнаас гадаад улс, олон улсын байгууллагатай санхүүгийн салбарт хамтран ажиллах болон өр, зээл, тусламжтай холбоотой гэрээ хэлэлцээрийн төсөл, тэдгээрийн боловсруулалтын шатанд хамаарах мэдээлэл;

13.1.1.д.төрийн дээд, өндөр хэмжээний харилцан айлчлал, хоёр болон олон талын яриа, хэлэлцээрийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл;

13.1.1.е.энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан асуудлаар гадаад улсын Засгийн газар, байгууллагатай байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээр, протокол, тэдгээрийн төсөл, хэрэгжилтийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

13.1.1.ё.хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газрын онцгой нөхцөл байдал үүссэн үед ажиллах төлөвлөгөө, ажлын удирдамж;

13.1.1.ж.энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан асуудлаар олон улсын хурал зөвлөгөөн, чуулганд оролцох төлөөлөгчдийн ажлын чиглэл, удирдамж.

13.1.1.з.улсын батлан хамгаалах, эдийн засагт чухал ач холбогдол бүхий үйлдвэр, онц чухал объектод гарсан гэмт халдлага, осол, сүйрэл, онцгой нөхцөл байдлын үед эрх бүхий байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээ, түүнтэй холбоотой мэдээллийн нууцалбал зохих хэсэг.

13.1.2.эдийн засаг, шинжлэх ухаан, техник технологийн хүрээнд:

13.1.2.а.эдийн засгийн аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн нууцалбал зохих хэсэг;

13.1.2.б.мөнгөн тэмдэгтийн нөөц, нөөцийн сангийн байршил, хамгаалалтын тухай мэдээлэл;

13.1.2.в.үндэсний аюулгүй байдлыг хангахад ач холбогдолтой шинжлэх ухаан, технологийн ололт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, судалгааны туршилт, угсралт, төслийн ажил, технологийн тухай мэдээлэл;

13.1.2.г.мөнгөн тэмдэгтийн эх загвар бүтээх, үйлдвэрлэх, устгах, мөнгөн тэмдэгтийн нийлүүлэлт, солилцоо, гүйлгээнээс гаргах тухай мэдээлэл.

13.1.3.батлан хамгаалах хүрээнд:

13.1.3.а.батлан хамгаалах бодлого, төрийн цэргийн номлолын нууцалбал зохих мэдээлэл;

13.1.3.б.зэвсэгт хүчний тайван цагийн болон дайны байдлын үеийн зохион байгуулалтын бүдүүвч, төрийн цэргийн байгууллагын нэгтгэл, ангийн байлдааны цагийн орон тоо, жинхэнэ нэр, зохион байгуулалт, бүтэц, тэдгээрийн байлдах чадвар, байлдааны бэлэн байдлыг тодорхойлсон нэгдсэн үзүүлэлт, мэдээлэл;

13.1.3.в.төрийн цэргийн байгууллагын стратегийн удирдамж, бэлэн байдлын төлөвлөгөө, тэдгээрийн биелэлт, тооцоо, зэвсэгт хүчнийг бэхжүүлэх, хэрэглэх болон стратегийн төлөвлөлтийн баримт бичиг, бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, байлдаанд бэлтгэх, шилжүүлэн байрлуулах төлөвлөгөө, зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалах арга ажиллагааны тактикийн тухай мэдээлэл;

13.1.3.г.байлдааны болон хил хамгаалалтын бэлэн байдлын мэдээ, байлдааны тушаал, захирамж, байлдааны ажиллагааны газар, орныг төхөөрөмжлөхтэй холбогдсон мэдээлэл;

13.1.3.д.батлан хамгаалах болон улсын хил хамгаалах зориулалттай болон энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээлэл агуулсан байр зүйн зураг;

13.1.3.е.улсын болон цэргийн дайчилгааны даалгавар, төлөвлөгөө, нөөц, нөхөн хангах тооцоо, төрийн цэргийн байгууллагын байлдааны техник зэвсэглэл, материал, галт хэрэглэлийн хангалт, захиалга, нөөцийн талаархи мэдээлэл;

13.1.3.ё.төрийн цэргийн байгууллагын бие бүрэлдэхүүний тоо бүртгэл, бэлтгэл үүрэгтэн, цэрэгт татах болон цэргээс халагдах хүмүүсийн нэгдсэн мэдээлэл, цэргийн мэргэжлийн ангилал, оногдуулан данслагдсан хүн, техникийн нэгдсэн дүн, тооцоо /улсын болон нийслэл, аймгийн хэмжээнд/;

13.1.3.ж.төрийн цэргийн байгууллагын автоматжуулсан болон далдуур /удирдлага холбооны/ удирдлагын системийн бүтэц, зохион байгуулалт, хангалтын тухай мэдээлэл;

13.1.3.з.төрийн цэргийн байгууллагын удирдлагын байрны байршил, мэдээлэл, холбооны сүлжээ, радио долгионы давтамжийн хуваарилалтын тухай мэдээлэл;

13.1.3.и.улсын болон цэргийн дайчилгааны зорилго, цар хүрээ, хэрэгжүүлэх арга хэмжээний төрөл, багтаамж, арга хэлбэр, улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөө, төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны даалгавар, төлөвлөгөөний тухай мэдээлэл;

13.1.3.й.улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх албаны арга ажиллагаа, хангалтыг зохион байгуулахтай холбоотой мэдээлэл;

13.1.3.к.улсын болон батлан хамгаалах нөөцийн бодит хэмжээ, байршил, тайлан, санхүүжилтийн тухай мэдээлэл;

13.1.3.л.улсын болон батлан хамгаалах нөөцийн жилийн болон дунд, урт хугацааны үндсэн чиглэлийн төслийн тооцоо, үндэслэл, түүнийг хэрэгжүүлэх талаар төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан баримт бичиг;

13.1.3.м.улс орныг дайны байдалд шилжүүлэх төлөвлөгөө, дайны болон дайн бүхий байдлын үед төрийн байгууллагын ажиллах төлөвлөгөө, түүнд холбогдох мэдээлэл;

13.1.3.н.онцгой байдлын үеийн арга хэмжээний төлөвлөгөө, холбоо, зарлан мэдээллийн үйл ажиллагааны зохион байгуулалт, энэ зорилгоор дэд бүтцийг ашиглах тухай мэдээлэл, удирдлагын хоргодох байр, төсөв, байршил, хүчин чадлын тухай мэдээлэл.

13.1.3.о.Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн орлого, зарлагатай холбоотой нууцалбал зохих мэдээлэл.

13.1.4.тагнуул, сөрөх тагнуул, хууль сахиулах ажлын хүрээнд:

13.1.4.а.тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажлын мэдээллийн эх сурвалж, тэдгээрийг халхавчлахтай холбоотой мэдээлэл;

13.1.4.б.гүйцэтгэх ажлын нэгдсэн тоо бүртгэлийн болон тусгай сангийн мэдээлэл;

13.1.4.в.гүйцэтгэх ажлын мэдээллийн болон тусгай техник хэрэгслийн тоо бүртгэлийн сан, түүнд ашиглагдаж байгаа тусгай зориулалтын техник технологи, программ хангамж, нууцлах код, түлхүүр, өгөгдөл, нууц тээгчид байгаа мэдээлэл;

13.1.4.г.бие бүрэлдэхүүнийг нь нууцалбал зохих тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын салбар нэгж, тэдгээрийн барилга байгууламж, байршил, тээврийн хэрэгслийн улсын дугаар, гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслийн тухай мэдээлэл;

13.1.4.д.гүйцэтгэх ажлын шугамаар шалгасан болон шалгаж байгаа хэргийн материал, баримт сэлт, мэдээлэл;

13.1.4.е.эрх бүхий байгууллагын удирдлагаас гүйцэтгэх ажлыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар гаргасан шийдвэр, заавар, журам, бусад баримт бичиг;

13.1.4.ё.гүйцэтгэх ажилтны үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөө, тайлан, ажлын байрны тодорхойлолтын мэдээлэл;

13.1.4.ж.тагнуул, сөрөх тагнуул, эрх бүхий бусад байгууллагын гүйцэтгэх ажил эрхлэх нэгжийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны тухай мэдээлэл;

13.1.4.з.тагнуулын байгууллагын төсөв, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий бусад байгууллагын гүйцэтгэх ажлын зардал, тэдгээрийн гүйцэтгэлийн тайлангийн мэдээлэл;

13.1.4.и.гүйцэтгэх ажилтан, нууц гүйцэтгэх ажилтны хувийн хэргийн болон тэдний албан ажилтай холбоотой мэдээлэл;

13.1.4.й.тагнуулын байгууллагаас үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд илгээсэн мэдээлэл;

13.1.4.к.гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын тусгай архивын данс, бүртгэл, эд зүйл;

13.1.4.л.гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагыг өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлэх төлөвлөгөө, террор, хорлон сүйтгэх ажиллагаа, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны төлөвлөгөө, удирдамж, хэрэглэх дохио;

13.1.4.м.Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор тагнуулын байгууллагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа;

13.1.4.н.тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын өөрийн аюулгүй байдлыг хангах ажлын зохион байгуулалт, арга, тактик, хүч, хэрэгсэл, төлөвлөгөөний мэдээлэл;

13.1.4.о.тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын гүйцэтгэх ажлын зориулалттай зэвсэг, тусгай хэрэгсэл, материал техникийн хангалт, нөөцийн мэдээлэл;

13.1.4.ө.тагнуулын байгууллагаас гадаад улсын тусгай албатай тогтоосон хамтын ажиллагааны тухай мэдээлэл;

13.1.4.п.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан нүүлгэн шилжүүлэх, баримт бичгийг солих, гадаад төрхийг өөрчлөх арга хэмжээний явц, уг арга хэмжээгээр хамгаалагдсан этгээдийн нууцалбал зохих мэдээлэл.

13.1.5.мэдээллийн аюулгүй байдлын болон бусад хүрээнд:

13.1.5.а.төрийн тусгай хэрэглээний мэдээлэл, холбооны сүлжээний бүтэц, зохион байгуулалт, программ хангамж, мэдээлэл нууцлагч техник хэрэгсэл, тэдгээрийн ажиллагааны зарчим, радио долгионы давтамжийн хуваарилалтын мэдээлэл;

13.1.5.б.төрийн мэдээллийн сүлжээний удирдлагын төвийн тусгай зориулалтын техник, программ хангамж;

13.1.5.в.төрийн шифр харилцааны бодлого, төрийн тусгай хэрэглээний мэдээлэл, холбооны болон шифрийн криптографын боловсруулалт, сан, нөөц, шифрийн арга ажиллагаа, аргачлал, тэдгээрийг ашиглах заавар, код, түлхүүр, түүнтэй холбоотой мэдээлэл;

13.1.5.г.төрийн шифр мэдээ, шифрийн харилцааны дүрэм, заавар, шифрийн материалын бүртгэл;

13.1.5.д.төрийн нууц тээгчийг хүлээлцсэн, шилжүүлсэн, шалгасан тухай мэдээлэл;

13.1.5.е.төрийн нууцад хамаарах мэдээлэл, нууц тээгчийг ашиглан бэлтгэсэн ном, сурах бичиг, бүтээл, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, тайлан, илтгэл, мэдээлэл, дүгнэлт, хурал, зөвлөгөөн, лекц, гүйцэтгэх ажлын сургалтын хөтөлбөр, хичээлийн тэмдэглэл;

13.1.5.ё.энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан асуудлыг шалгасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны нууцалбал зохих баримт бичиг, мэдээлэл;

13.1.5.ж.хуулиар төрийн тусгай хамгаалалтын нэгдүгээр зэрэглэлээр хамгаалуулж байгаа албан тушаалтны эрүүл мэндийн байдлын тухай мэдээлэл;

13.1.5.з.улсын онц чухал болон тусгай объектын байршил, олгосон газрын нэр, зураг, хамгаалалтын зохион байгуулалт, хүч хэрэгслийн тухай мэдээлэл;

13.1.5.и.цэвэр ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн байршлын зураг;

13.1.5.й.энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээ, баримт бичиг, эд зүйлийг битүүмжлэн хүргэх төрийн тусгай болон дипломат шуудан, битүүмжлэхээс хэрэглэгчид хүртэл үйл ажиллагаа;

13.1.5.к.энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан асуудал хэлэлцсэн хаалттай хуралдааны тэмдэглэл, баримт бичиг;

13.1.5.л.хуулиар төрийн тусгай хамгаалалтад байх албан тушаалтан, иргэн болон хурал, чуулган, арга хэмжээ, тээврийн хэрэгсэл, бусад зүйлийн байнгын болон цаг үеийн хамгаалалтын зохион байгуулалт, хүч, хэрэгслийн болон төрийн тусгай хамгаалалтын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, төсвийн тухай мэдээлэл;

13.1.5.м.улсын онц чухал болон тусгай объект, үйл ажиллагааг халхлах журам.

13.2.Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд нь энэ зүйлийн 13.1-д заасан жагсаалтын хүрээнд салбар, байгууллагын хэмжээнд нууцлах төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг боловсруулж, тагнуулын байгууллагын саналыг авч Засгийн газраар батлуулна.

13.3.Салбарын болон байгууллагын хэмжээнд нууцлах мэдээллийн жагсаалтад тухайн мэдээллийг нууцлах хугацаа, нууцын зэрэглэлийг тусгасан байна.

Засгийн газрын 2017 оны 257 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-д 2019-2021 онд нийтдээ 10 мэдээллийг нэмж, 1 мэдээллийг өөрчилсөн байна.

Хүснэгт 3.11. *Жагсаалтаар батлагдсан төрийн нууц мэдээллийн тоо:*

№	Байгууллага, салбар	Төрийн нууцад хамаарах мэдээллийн тоо
1	Улсын Их хурлын тамгын газар	31
2	Ерөнхийлөгчийн тамгын газар	16
3	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	32
4	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, Стратегийн судалгааны хүрээлэн	33
5	Гадаад харилцааны салбар	19
6	Батлан хамгаалах салбар	78
7	Хууль зүй, дотоод хэрэг, хууль сахиулах салбар	56
8	Банк, санхүүгийн салбар	21
9	Байгаль орчин, аялал жуулчлалын салбар	10
10	Барилга, хот байгуулалтын салбар	16

11	Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын салбар	9
12	Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар	11
13	Зам, тээврийн салбар	10
14	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар	10
15	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар	12
16	Эрүүл мэндийн салбар	10
17	Эрчим хүчний салбар	12
18	Авлигатай тэмцэх газар	20
19	Төрийн аудитын байгууллага	6
20	Сонгуулийн ерөнхий хороо	5
21	Санхүүгийн зохицуулах хороо	4
22	Үндэсний статистикийн хороо	5
23	Цөмийн энергийн комисс	6
24	Төрийн албаны зөвлөл	7
25	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбар	9
26	Мэргэжлийн хяналтын байгууллага	5
27	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	7
28	Үндэсний хөгжлийн газар	5
29	Тагнуулын байгууллага, Төрийн тусгай хамгаалалтын газар	60
30	Онцгой байдлын салбар	13
31	Стандарт, хэмжил зүйн газар	4
32	Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, шүүх, прокурорын байгууллага	13
33	Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар	17

Засгийн газрын тогтоолоор нийт 575, давхцалгүй тоогоор 404 мэдээллийг төрийн нууцад хамааруулжээ.[33]

Албаны нууцын тухайд:

2016 онд батлагдсан Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь хэсэгт зааснаар албаны нууцыг задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг хэлэхээр тодорхойлсон.

Мөн тус хуулийн 14 дүгээр зүйлд албаны нууцад хамаарах мэдээллийн талаар дараах байдлаар зохицуулжээ.

> 14 дүгээр зүйл. Албаны нууцад хамаарах мэдээлэл
>
> 14.1. Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг тухайн хариуцсан байгууллага боловсруулж, асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр батална.
>
> 14.2.Энэ зүйлийн 14.1-д заасан жагсаалтыг батлахад тагнуулын байгууллагын саналыг авна.

Дээрхээс үзвэл албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг хариуцсан байгууллага боловсруулж баталж байгаа нь хууль хэрэглээний асуудал бий болгох боломжийг үүсгэдэг. Тодруулбал, Төрийн болон албаны нууцын тухай хуульд албаны нууцын тодорхойлолт нь хэт өргөн, тодорхойгүй бөгөөд ялгаа зааг, шалгуур үзүүлэлтийг тогтоогоогүйгээс үүдэн албаны нууцыг ангилахад хүндрэл учирч байна.

33 Зарим мэдээлэл хэд хэдэн удаа давхацсан байгааг анхаарах нь зүйтэй.

Өнөөгийн түвшинд “албаны нууц” гэх ойлголтын хүрээнд төрийн байгууллага бүр өөрсдийн дур зоргоор аливаа мэдээллийг нууцлах байдал үүссэн. Улс, орнуудад “албаны нууц” хэмээх ойлголт тодийлөн байдаггүй. Харин улс орнуудын нийтийн мэдээллийн тухай хууль, мэдээллийн ил тод байдлын тухай хууль тогтоомжид “албан мэдээлэл” гэх ойлголт цөөнгүй тусгагджээ. Төрийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагааны үр дүн, хэрэгжилтийг бууруулахгүй байх, иргэн, хуулийн этгээдийн нууц мэдээллийг задруулж тэдгээрт хохирол учруулахаас сэргийлэх зорилгоор албан мэдээлэлтэй танилцах иргэний эрхийг хязгаарлах боломжтой ч хязгаарласан мэдээллийг нууц гэж үздэггүй байна.

Иймд Төрийн нууцын хууль тогтоомж дахь “албаны нууц” гэх ойлголтыг халж, Нийтийн мэдээллийн тухай хуулиар үүнд холбогдох харилцааг зохицуулах, хязгаарлаж болох албан мэдээллийн жагсаалтыг байгууллагын дотоод журмаар нэг удаа батлаад орхих бус жил бүр, эсхүл тодорхой давтамжтайгаар шинэчилж байх зохицуулалтыг тусгаж, төрийн байгууллагын мэдээлэл хариуцсан ажилтнуудын ойлголтыг нэгдмэл болгох шаардлагатай. Байгууллагын дотоод журам, жагсаалт нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцсэн байх, хэрэв зөрчилдвөл уг хуулийн давуу байдлыг хангах зохицуулалтыг хуульчилбал өнөөгийн практикт тулгарч буй хууль хэрэглээний хүндрэлийг даван туулахад чухал ач холбогдолтой.

Түүнчлэн төрийн байгууллага, албан хаагч нь иргэний мэдээлэл авах хүсэлтэд татгалзсан хариу өгөх тохиолдолд тухайн мэдээллийг нууцалсан үндэслэлээ тайлбарлах, улмаар татгалзсан шийдвэрт гомдол гаргах боломж бүрдүүлэх нь иргэдийн төрийн байгууллагад итгэх итгэлийг нэмэгдүүлэх, цаашилбал иргэний мэдэх эрхийн баталгааг хангахад чухал нөлөө үзүүлнэ. Түүнчлэн иргэний хүсэлтийг бүртгэх, улмаар хяналтын чиг үүрэг бүхий байгууллагад тоон мэдээллийг тогтмол хугацаанд өгөх чиг үүргийг хуульд тусгах нь зүйтэй юм.[34]

Хүний эмзэг мэдээллийн тухайд:

2021 онд батлагдсан Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь хэсэгт зааснаар хүний эмзэг мэдээлэл гэдэгт хүний үндэс, угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх мэдээллийг хэлэхээр зохицуулсан.

Хувийн мэдээллийн тухайд:

2021 онд батлагдсан Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх хэсэгт зааснаар хүний хувийн мэдээлэл гэдэгт хүний эмзэг мэдээлэл болон хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, оршин суугаа газрын хаяг, байршил, иргэний бүртгэлийн дугаар, хөрөнгө, боловсрол, гишүүнчлэл, цахим тодорхойлогч, хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой бусад мэдээллийг хамааруулахаар хуульчилсан.

Хуульд дээрх байдлаар нэмэлт, өөрчлөлт оруулсан зохицуулалтын хүрээг 2 хуваан авч үзье.

34 ХЗҮХ, “Төрийн болон албаны нууцын хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх тайлан”, (Уб, 2023), 36 дахь тал.

1. Шүүхийн шийдвэр, яллах дүгнэлттэй холбоотой өөрчлөлтийн талаар

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд буюу яллах дүгнэлт, шүүхийн шийдвэр, шүүх хуралдаанд төрийн болон албаны нууц, хүний эмзэг мэдээлэл, хувийн мэдээллийг нууцлах, хаалттай явуулах нь тухайн субъектуудын эрх ашгийг хамгаалдаг хэдий ч нөгөө талаас ил тод байдлын асуудлыг хөнддөг.

Шүүхийн шийдвэр ил тод байх талаар үзэл баримтлалын дараах асуудлууд байдаг.

Нэгдүгээрт, Шүүхийн шийдвэр бүрэн эхээрээ (бүхэлдээ) ил тод байна. Шүүхийн шийдвэрт дурдагдсан аливаа мэдээлэлд ямар нэгэн өөрчлөлт, нууцлал хийлгүйгээр бүрэн эхээр нь нийтэлж ил тод болгоно.Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэр бүхэлдээ ил тод байдаг бөгөөд төрийн мэдээлэл эмхэтгэлд хэвлэн нийтлэгдэхийн зэрэгцээ, эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем wwww.legalinfo.mn болон Үндсэн хуулийн цэцийн www.conscourt.gov.mn цахим хуудаст бүрэн эхээрээ ямар нэгэн засвар, өөрчлөлтгүйгээр нийтэлдэг.

Хоёрдугаарт, Нууц, аюулгүй байдалд хамаарахаас бусад шүүхийн шийдвэр ил тод байна. Шүүхээр хянан шийдвэрлэгдэж байгаа хэргийн нотлох баримт ба үйл явдал нь төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хувь хүний эмзэг мэдээллийг агуулсан, түүнчлэн аюулгүй байдалд хамаарах бол тухайн шүүхийн шийдвэрийг ил тод болгохгүй болно.

Гуравдугаарт, Шүүхийн шийдвэрт дурдагдсан хүн, хуулийн этгээд болон тэдгээрийн өмч, хөрөнгийг тодорхойлох мэдээллээс бусад мэдээлэл ил тод байна. Шүүхийн шийдвэр нь ямагт хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолтой холбоотой мэдээллийг агуулж байдаг тул тус шийдвэрт дурдагдсан мэдээллийн эзнийг тодорхойлох нэр, регистрийн дугаар, хаяг болон өмч тэдгээрийн талаар мэдэх боломжтой мэдээллийг нууцлах ба бусад мэдээлэлд ямар нэгэн өөрчлөлт оруулахгүй болно.

Дөрөвдүгээрт, Шүүхийн шийдвэр хэргийн оролцогчдоос бусад этгээдэд хаалттай байна. Шүүхийн шийдвэр нь нууцад хамаарах мэдээллийг агуулахын зэрэгцээ хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, байр суурийн талаарх мэдээллийг агуулж байдаг тул хэргийн оролцогч болон бусад оролцогчдын хувьд нээлттэй байж болно, харин нийтэд ил тод болгох нь зохистой биш байдаг.

Улс орнууд засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх нийтлэг зарчмыг хүлээн зөвшөөрч, төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн гурван эрх мэдэлд хуваадаг. Хууль тогтоох эрх мэдлийн үйл ажиллагаа хуулийн төслийг санаачлах, боловсруулах, хэлэлцэх, батлах, хэвлэн нийтлэх, дагаж мөрдүүлэх бүх үе шатандаа нээлттэй ил тод байдаг бол гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн гүйцэтгэл, хэрэгжилтийг хангах хүрээнд мөн ил тод, нээлттэй байдаг. Үүний жишгээр шүүх эрх мэдлийн үйл ажиллагаа (процесс)-г ил тод, нээлттэй болгох хүрээнд шүүх хэргийг ил таслан шийдвэрлэх зарчим хэдийнээ төлөвшсөн болно[35].

Түүнчлэн Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа ба Хөгжлийн Байгууллага (OECD)-аас 2019 онд хийсэн “Хавтаст хэрэгтэй танилцах, нууц мэдээллийг хамгаалах” талаар гишүүн улсуудын дунд судалгаа хийж холбогдох зөвлөмжийг өгсөн байна.

35 ННФ, “Шүүхийн шийдвэрийн ил тод байдал Мониторингийн тайлан”, (Уб, 2024), 12-13 дахь тал.

Тус судалгаанд хавтаст хэрэгтэй танилцах, нууц мэдээллийг хамгаалах нь хууль сахиулах ажиллагааны хоёр тал юм гэж авч үзсэн. Хэргийн материалтай танилцах нь талууд, тэр дундаа зарим эрх мэдлийн хүрээнд гуравдагч этгээдүүдтэй холбоотой байгууллагын мэдэлд байгаа нотлох баримтыг шалгах эрх юм. Тайлбарласны дагуу хэргийн материалтай танилцах нь талуудын өмгөөллийн эрхийг хамгаалахад чухал ач холбогдолтой бөгөөд энэ нь мэтгэлцээнийг хэрэгжүүлэх тогтолцооноос хамааран агентлаг, шүүх ямар үндэслэлээр шийдвэрлүүлэхийг шалгах боломжийг олгодог. Нууц мэдээллийг хамгаалах нь хэргийн материалтай танилцах эрхийг хязгаарласан байдаг. Хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, өмгөөлөх эрхийг хамгаалахын тулд шаардлагагүй бол нууц мэдээллийг задруулахгүй байж болно. Ил болгох шаардлагатай бол нууц мэдээллийг нөхцөлтэйгөөр хуваалцаж болно[36].

Энэхүү судалгааны хүрээнд хавтаст хэрэгтэй танилцах, нууц мэдээллийг хамгаалах хүрээнд Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа ба Хөгжлийн Байгууллага (OECD)-аас дараах зөвлөмжийг өгсөн байна.

- Шүүхийн харьяалал нь талууд тус байгууллагын хавтаст хэрэгт байгаа нотлох баримттай танилцах боломжийг янз бүрээр баталгаажуулдаг. Зарим нь бараг бүхэл бүтэн хавтаст хэргийг хамарсан маш өргөн хандалтыг олгодог бол зарим нь зөвхөн тодорхой баримт бичигт хандах боломжийг олгодог. Оролцогчийг хамгаалах эрхийг хамгаалахын тулд талууд холбогдох бүх буруутгах, цагаатгах нотлох баримтыг олж авах боломжтой байх нь чухал юм. Аль мэдээллийг цагаатгах боломжтой болохыг тодорхойлох, талуудад зохих журмаар хандах эрх олгох бэрхшээлтэй байж болно. Талууд холбогдох бүх нотлох баримтыг цаг тухайд нь олж авах боломжтой байх нь зайлшгүй шаардлагатай бөгөөд ингэснээр тэд өөрсдийгөө зохих ёсоор хамгаалж чадна.

- Хавтаст хэргийн тодорхой баримт бичигтэй танилцах эрхийг бусад сонирхогч этгээд болон олон нийтэд олгож болно. Харьяаллын бүсүүд, ялангуяа олон нийтэд нэлээд хязгаарлагдмал хүртээмжтэй байдаг.

- Нууц мэдээллийг хамгаалах нь хавтаст хэрэгт хандах эрхийг хязгаарладаг. Харьяаллын дийлэнх нь нууц мэдээллийг хамгаалдаг ч «нууц мэдээлэл» гэсэн тодорхой тодорхойлолт нь харьяалал бүрт харилцан адилгүй байдаг. Арилжааны нууц мэдээлэл болон хувийн нууц мэдээллийг ихэвчлэн нууц гэж үздэг.

- Мэдээлэл нууц байна гэдэг нь зарчмын хувьд задруулахгүй гэсэн үг. Гэсэн хэдий ч илчлэх нь хэд хэдэн нөхцөл байдалд байж болно. Нэгдүгээрт, тэдний эрх, ашгийг хамгаалах эрхийг хамгаалахын тулд нууц мэдээллийг талуудтай хуваалцаж болно. Нууц мэдээлэл агуулсан баримт бичгийг агентлагуудад хуваалцах боломжийг олгодог хэд хэдэн механизм байдаг.

- Хоёрдугаарт, дотоод, гадаадын бусад байгууллагад нууц мэдээллийг задруулж болно. Зарим эрх мэдлийн хүрээнд дотоодын байгууллагуудад мэдээлэл өгөх талаар нэлээд нээлттэй хандлагыг баримталдаг. Зарим нь илүү хатуу байдаг. Гадаадын агентлагт мэдээлэл өгөх нь ерөнхийдөө мэдээллийг илгээсэн тал гарын үсэг зурсны дагуу хийгддэг.

- Эцэст нь, хувийн эрх зүйн шийдвэр гүйцэтгэх зорилгоор мэдээллийг задруулж болно. Нэхэмжлэгч нарт хавтаст хэрэгт байгаа мэдээлэлтэй танилцах боломжийг

36 OECD, “Working Party No. 3 on Co-operation and Enforcement Access to the case file and protection of confidential information – Background Note by the Secretariat”, 2019, https://one.oecd.org/document/DAF/COMP/WP3(2019)6/en/pdf, pp.4.

олгох нь хохирлыг барагдуулах үйл ажиллагааг дэмжихэд тустай. Гэсэн хэдий ч өршөөлийн болон төлбөр тооцооны материалыг задруулах нь талууд эдгээр механизмыг ашиглахад саад болж болзошгүй юм.[37]

Дээрхээс дүгнэвэл, Нууц, аюулгүй байдалд хамаарах мэдээлэл, төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хувь хүний эмзэг мэдээлэл, хүн, хуулийн этгээд болон тэдгээрийн өмч, хөрөнгийг тодорхойлох мэдээллээс бусад мэдээлэл нь ил тод байх талаар нийтлэг жишиг тогтсон байна. Хавтаст хэрэгтэй танилцах, нууц мэдээллийг хамгаалах нь харилцан уялдаатай ойлголт ба нэг талаас нууцлах мэдээллийг оновчтой тодорхойлж, хязгаарлах нөгөө талаас талуудын нотлох баримт, баримт бичигтэй танилцах эрх, ашгийг хамгаалах ойлголт байхаар байна. Мөн түүнчлэн энэхүү зохицуулалтыг улс, орон болгон өөрийн шүүхийн харьяалал, хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд тохиромжтой байдлаар зохицуулдаг байна.

Хуулийн төсөлд төрийн болон албаны нууц мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэр, прокурорын яллах дүгнэлтийг прокурор, оролцогчид гардуулах, танилцуулах талаар, хүний хувийн мэдээлэл, эмзэг мэдээлэл агуулсан шүүх хуралдааны талаар нарийвчлан зохицуулсан хэдий ч талуудын нотлох баримт, баримт бичигтэй танилцах эрх, ашгийг хамгаалах талаар өргөнөөр хязгаарласан байна.

Тодруулбал, Төслийн 32.10 дугаар зүйлд 9 дэх хэсэгт төрийн нууцтай холбоотой хэргийн яллах дүгнэлтийг бүрэн бодитой танилцуулж, төрийн нууц мэдээлэл агуулсан хэсгийг хассан хувийг гардуулан өгөхөөр тусгасан нь яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн нотлох баримт, баримт бичигтэй танилцах эрх, ашгийг зөрчих боломжид хүргэж болох юм. Учир нь бүрэн бодитой танилцах нь тухайн талын нөхцөл байдлаас хамаарч өөр байж болох ба яллах дүгнэлтийг бүхэлд нь гардан аваагүйн улмаас түүний эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх магадлалтай. Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар яллагдагч ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх эрхтэй. Иймд тус эрхүүдийг өргөнөөр ийнхүү хязгаарлахын оронд яллах дүгнэлттэй танилцах, гардан авах яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид нууц задруулахгүй байх үүргийг хүлээлгэх нь зүйтэй.

Мөн тус төслийн 36.13 дугаар зүйлийн 5,6 дахь хэсэгт төрийн нууц мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэрийн “Тодорхойлох”, “Удиртгал”, “Тогтоох” хэсэгт төрийн нууц агуулсан мэдээлэл агуулагдсан бол гардуулахгүйгээр, шүүхийн шийдвэрийг бүрэн бодитой танилцуулах арга хэмжээ авахаар зохицуулжээ. Энэ нь өмнө дурдсан талуудын нотлох баримт, баримт бичигтэй танилцах эрх, ашгийг зөрчих боломжид хүргэхээс гадна шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхийг өргөнөөр хязгаарлах нөхцөл байдал үүсгэх юм. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт зааснаар “…шүүхийн шийдвэрийг давж заалдах…” иргэний үндсэн эрхийг тусгасан ба үүнийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар баталгаажуулж 38.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, тэдгээрийн өмгөөлөгч шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах, улсын яллагч, дээд шатны прокурор эсэргүүцэл бичих эрхтэй.” гэж тусгасан байдаг. Иймд тус эрхүүдийг өргөнөөр

37 OECD, “Working Party No. 3 on Co-operation and Enforcement Access to the case file and protection of confidential information – Background Note by the Secretariat”, 2019, https://one.oecd.org/document/DAF/COMP/WP3(2019)6/en/pdf, pp.30-31.

хязгаарлахын оронд шүүхийн шийдвэртэй танилцах, гардан авах талуудад нууц задруулахгүй байх үүргийг хүлээлгэн давж заалдах эрхийг хангах талаар авч үзэх хэрэгтэй.

2. Шүүх хуралдааныг хаалттай явуулах зохицуулалтын өөрчлөлтийн талаар

Өмнө дурдагдсанаар тус нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд хэргийн нотлох баримт, үйл явдал нь хүний эмзэг мэдээллээс бусад хувийн мэдээлэл болон байгууллагын нууц мэдээлэлд хамаарч байвал мэдээллийн эзэн буюу хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр шүүх хуралдааныг бүрэн, эсхүл түүний зарим ажиллагааг хаалттай явуулж болохоор зохицуулалтыг нэмжээ. Мэдээллийн эзэн зөвшөөрсөн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн ажиллагаан дахь хүний эмзэг мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод байлгаж болно. Мөн хаалттай шүүх хуралдааны явцад илэрхий болсон төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний хувийн мэдээллийг шүүгч, шүүх хуралдаанд оролцогч задруулж болохгүй талаар тусгажээ.

Одоогийн зохицуулалтыг авч үзвэл, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2019 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 56 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Шүүхийн төрийн болон албаны нууцыг хамгаалах журам”-ын 9 дүгээр хэсэгт шүүх хуралдааныг хаалттай явуулах талаар тусгажээ.

9.1. Нууцад хамаарах мэдээлэл агуулсан шүүхийн хэлэлцүүлэг, урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг холбогдох хуульд заасны дагуу бүхэлд нь эсхүл зарим хэсгийг хаалттай явуулна.

9.2. Төрийн нууцад хамаарах асуудал хэлэлцсэн хаалттай шүүхийн хэлэлцүүлэг, урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдааны явцыг төрийн нууцтай танилцах эрх олгогдсон шүүх хуралдааны нарийн бичгийн дарга тэмдэглэл хөтөлж, шүүхийн серверт холбогдоогүй төхөөрөмжөөр дууны, эсхүл дуу-дүрсний бичлэг хийж баталгаажуулна.

9.3. Төрийн нууцад хамаарах асуудал хэлэлцэх шүүхийн хэлэлцүүлэг, урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдаанд хууль журмын дагуу төрийн нууцтай танилцах эрх олгогдсон буюу төрийн нууц задруулахгүй байх баталгаа гаргасан албан тушаалтан, хэргийн оролцогч, иргэнийг оролцуулах асуудлыг хуульд заасны дагуу шүүх шийдвэрлэнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.4 дүгээр зүйлд шүүх хуралдаан хаалттай явуулах процессын талаар нарийвчлан дараах байдлаар зохицуулсан байна.

34.4 дүгээр зүйл.Шүүх хуралдааныг нээлттэй явуулах

1.Шүүх хуралдааныг нээлттэй явуулна.

2.Шүүх хуралдааныг дараахь тохиолдолд бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хаалттай явуулна:

2.1.төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлтэй холбоотой хэргийг хянан шийдвэрлэх;

2.2.өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэхэд түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч хүсэлт гаргасан бол;

2.3.арван найман насанд хүрээгүй хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах шаардлагатай гэж үзвэл түүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэх;

2.4.хамгаалалтад байгаа гэрчийн мэдүүлгийг уншиж сонсох, эрэн сурвалжлах нууц ажиллагаа, мөрдөн шалгах нууц ажиллагааны явцад олж авсан нотлох баримтыг шинжлэн судлах.

3.Хаалттай явуулах шүүх хуралдаанд оролцуулах, байлцуулах хүнийг шүүх шийдвэрлэнэ.

4.Шүүх хуралдаанд мөрдөн шалгах ажиллагааг нууцаар явуулахтай холбоотой ил болгохыг хориглосон мэдээллийг танилцуулахдаа холбогдох хуулийг баримтална.

5.Шүүх эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг хаалттай явуулсан бол шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг нийтэд уншиж сонсгоно.

6.Өсвөр насны шүүгдэгч, арван найман насанд хүрээгүй хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор улсын яллагч, хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан шүүх хуралдааныг нээлттэй явуулж болно.

Дээрхээс дүгнэвэл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.4 дүгээр зүйлд шүүх хуралдаан хаалттай явуулах зохицуулалтыг хуульчилсан байсныг тус нэмэлт, өөрчлөлтөөр 3.2 дугаар зүйлд давхардуулан хуульчилсан байна. Тухайлбал, шүүх хуралдаан хаалттай явуулах нөхцөл байдлыг хуульчилсан байсныг дахин тодорхойлж хүний эмзэг мэдээллээс бусад хувийн мэдээлэл болон байгууллагын нууц мэдээлэлд хамаарч байвал мэдээллийн эзэн буюу хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр хаалттай явуулахыг тодорхойлсон байна. Харин мэдээллийн эзэн зөвшөөрсөн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн ажиллагаан дахь хүний эмзэг мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод байлгаж болох зохицуулалт болон хаалттай шүүх хуралдааны явцад илэрхий болсон төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний хувийн мэдээллийг шүүгч, шүүх хуралдаанд оролцогч задруулж болохгүй талаар зохицуулалт нь давхцаагүй хэдий ч 3.2 дугаар зүйлд бус 34.4 дүгээр зүйлд тусгагдах нь зохимжтой байна.

Үүнээс гадна шүүх хуралдааныг хаалттай явуулах дээрх үндэслэлүүдийг эргэн харах хэрэгтэй. Гадаадын улс, орнууд өөрийн эрх зүйн тогтолцоо, шүүхийн харьяаллаас хамааруулан онцлог зохицуулалттай байдаг. Зарим улс орныг авч үзье.

Австрали Улс

Австралид шүүх “нээлттэй шударга ёсыг” хэрэгжүүлэх ёстой гэсэн хуулийн үндсэн зарчмыг эртнээс баримталж ирсэн. Энэ нь шүүх ажиллагаа ерөнхийдөө олон нийтийн нүдэн дээр явагдах ёстой гэсэн үг юм. Энэхүү зарчим нь хууль дээдлэх ёсыг хамгаалж, шударга ёсыг тогтооход олон нийтийн итгэлийг төрүүлдэг гэдгээрээ ач холбогдолтой.

Гэхдээ шүүх хуралдааныг хаалттай явуулах тохиолдлууд байдаг. Энэ нь шүүх хуралдааны танхимд зөвхөн тухайн хэрэгт шууд хамааралтай хүмүүс буюу шүүгчийн урилгаар оролцох хүмүүс байна гэсэн үг. Одоогоор шүүх хуралдааны танхимд хэвлэл мэдээллийнхэн болон олон нийтийн төлөөлөл оролцох боломжгүй. Хаалттай шүүх хуралдаанууд нь бэлгийн хүчирхийлэл, үндэсний аюулгүй байдалд эрсдэлтэй хэрэг гэх мэт нууц мэдээлэл эсвэл хэрэгт холбогдсон хүмүүсийн хувийн мэдээлэлтэй холбоотойгоор хаалттай явагддаг.

1986 оны Эрүүгийн процессын тухай хуульд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн гомдол гаргагчдад шүүхэд мэдүүлэг өгөх тусгай журмын зохицуулалтыг тусгасан

байдаг. Ийм хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гомдол гаргагч нь мэдүүлэг өгөх, тэр дундаа тэдний нотлох баримтын бичлэг шүүх дээр хаалттай байх ёстой.

Шинэ Өмнөд Уэльст хаалттай шүүх хуралдааныг 2010 оны Шүүхийн хязгаарлалт болон хэвлэн нийтлэхгүй байх тухай хуулиар зохицуулдаг. Тус хуульд шүүх хуралдааныг хаалттай явуулах тохиолдлыг ихэвчлэн хүүхдийн шүүхэд хамааруулдаг. Энэ эь прокурорууд хүүхдэд ял оногдуулах асуудлыг шийдвэрлэх тусгай шүүх юм. 1987 оны Хүүхдийн (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай) хуулийн 15А бүлэгт мөн хүүхдийн нэрийг нийтлэх, дамжуулахыг хориглосон байдаг. Хууль ёсны төлөөлөгчид шүүх хуралдаан эхлэхээс өмнө шүүхийг хаалттай явуулах үндэслэл, хүсэлтийг шүүхэд гаргаж өгөх шаардлагатай.[38]

Монгол Улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулбал, нууц мэдээлэл, хувийн мэдээлэлтэй холбоотойгоор болон хүүхэд оролцсон шүүх хуралдааныг хаалттай явуулдгаараа ижил боловч гэр бүлийн хүчирхийллийн хэргийн шүүх хуралдааныг хаалттай явуулдгаараа өөр байна.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Хуульд заасны дагуу Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад шүүх хурал нээлттэй байдаг. Энэ нь үйл явц, шүүхийн шийдвэрт иргэд хяналт тавих боломжийг хангах зорилготой юм. “Шүүхийн нууц тогтолцоо”-оос аль болох зайлсхийх хэрэгтэй. Тийм ч учраас зарчмын хувьд сонирхсон хүн бүр, сэтгүүлчид хэлэлцүүлэгтэй танилцах боломжтой байх ёстой.

Үүний зэрэгцээ олон нийтэд шүүх хуралдааныг танилцуулах нь хувийн шинжтэй зүйлсийг гаргаж ирдэг тул холбогдох хүмүүст дарамт учруулах тохиолдол байдаг. Тийм ч учраас жишээлбэл, гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ихэнх нь нийтэд нээлттэй байдаггүй. Мөн өсвөр насны шүүгдэгчийн эсрэг (жишээ нь гэмт хэрэг үйлдэх үед 18 нас хүрээгүй хүмүүсийн эсрэг) эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ч хаалттайгаар явагддаг. Хуульд зааснаар дараах тохиолдлуудад шүүх хуралдаан хаалттай явагддаг байна.

§ 171a GVG – Байрлуулах

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд яллагдагчийг дангаар буюу ялаас гадна сэтгэцийн эмнэлэг, сэргээн засах төвд хэвтүүлэх тохиолдолд шүүх хуралдааныг хаалттайгаар явуулж болно. Эрүүгийн хуульд торгууль, хорих ялаас гадна сэтгэцийн эмгэг, донтолтын эмнэлэгт (албадан) байрлуулах зэрэг арга хэмжээнүүд байдаг. Эдгээр арга хэмжээг сэтгэцийн эмгэг, түүнчлэн мансууруулах бодис, эм, архины донтолтын үед харгалзан үздэг. Шүүгдэгчийн тухай хувийн зүйлийг байнга ярилцаж байх шаардлагатай байдаг тул ихэнхдээ хаалттайгаар шүүх хуралдааныг явуулдаг.

§ 171b GVG-ийн 1-р зүйл - Хувийн амьдралын хэсэг

Процедурт оролцсон хүн, гэрч, хууль бус үйлдлээс болж гэмтсэн хүний хувийн амьдралаас (Эрүүгийн хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь хэсэг) хэлэлцсэн тохиолдолд шүүх хуралдааныг хаалттай явуулж болно. Нийгмийн амьдралд хүн болгонд тийм ч амархан түгээгдээд байдаггүй баримтуудыг багтаасан

38 What is a Closed Court? Ashley Chung, https://obriensolicitors.com.au/what-is-a-closed-court/

байх ёстой. Үүнд, юуны түрүүнд эрүүл мэндийн асуудал, хувийн шинж чанар, хандлага, бэлгийн дур хүсэл, гэр бүлийн харилцаа холбоо, улс төрийн үзэл бодол, шашин шүтлэг, үзэл суртлын хандлага зэрэг орно.

§ 171b GVG-ийн 2-р зүйл - Хүнд гэмт хэргийн насанд хүрээгүй гэрчүүд

Бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг, хамгаалалтад байгаа хүмүүстэй зүй бус харьцсан, хувийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг үйлдсэн хэрэгт 18 нас хүрээгүй гэрчийг сонссон тохиолдолд хаалттайгаар шүүх хуралдааныг явуулна. Онц хүнд гэмт хэрэг, тэр дундаа бэлгийн гэмт хэрэг гарсан тохиолдолд хүүхэд, залуучуудыг нээлттэй шүүх хуралдаанд хамруулж болохгүй.

§ 171b GVG-ийн 3-р зүйл - Эрх бүхий этгээдийн өргөдөл

1, 2-р зүйлд заасан шаардлагыг хангаж, хүсэлт гаргасан тохиолдолд шүүх хуралдааныг хаалттай зохион байгуулах ёстой. Хэрэв холбогдох хүн хүсэлт гаргавал шүүх дагаж мөрдөх ёстой.

§ 171b GVG-ийн 4-р зүйл – Эрх бүхий этгээдийн эсэргүүцэл

1 ба 2-т зааснаас ялгаатай нь хүсэлт гаргах эрхтэй хүмүүс хаалттай явуулахыг эсэргүүцсэн тохиолдолд шүүх хуралдаан нээлттэй явагдах ёстой.

§ 171b GVG-ийн 5-р зүйл – Маргаангүй байдал

1-4 дэх хэсэгт заасны дагуу гаргасан шийдвэр нь эцсийнх байна. Хуралдааныг хурдан явуулахын тулд шийдвэр эцсийнх бөгөөд давж заалдах эрхгүй байна. Гэхдээ энд шүүхийн шийдвэр харьцангуй явцуу хүрээнд байна.

Нэгдүгээрт, холбогдох ашиг сонирхлыг дэнсэлж үзсэний үндсэн дээр хаалттай явуулах үндэслэл байгаа эсэхийг тодорхойлох ёстой (1 ба 2-р зүйл).

Дараа нь тухайн хаалттай явуулах хүсэлт гаргасан уу, эсхүл хасахыг эсэргүүцсэн үү гэсэн асуултыг тавьж, үүнийг дагаж мөрдөх ёстой (3 ба 4-р зүйл).

Гагцхүү хаалттай явуулах үндэслэл байгаа боловч тухайн хүн аль нэг талаар тайлбар зайлшгүй шаардлагатай.

§ 172 GVG – Хаалттай явуулах нэмэлт шалтгаанууд

172-р зүйлд хасах нэмэлт үндэслэлийг оруулсан болно. Гэсэн хэдий ч, хасах шалтгаан нь асуудал байгаа тохиолдолд л ерөнхийдөө үндэслэлтэй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Жишээлбэл, төрийн ашиг сонирхолд заналхийлсэн тул хаалттай явуулсан бол ийм аюул занал учруулахаа больсон асуудлыг хэлэлцэж эхэлмэгц нээлттэй хийх ёстой.

§ 172 No 1 GVG – Төрийн ашиг сонирхол

Төрийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам, ёс суртахуунд аюул заналхийлж байгаа тохиолдолд шүүх хуралдааныг хаалттай хийж болно. Цэргийн асуудал гэх мэт нууц мэдээлэлтэй холбоотой үед улсын ашиг сонирхол эрсдэлд ордог.

§ 172 No 1a GVG – Хувь хүний хувьд ноцтой аюул

Гэрч болон өөр хүний амь нас, бие махбодь, эрх чөлөөнд аюул учирсан бол шүүх хуралдааныг хаалттай явуулж болно. Энэ нь ялангуяа мэдүүлэг өгөх хүсэлтэй гэрчүүдийн эсрэг тусгайлан заналхийлсэн тохиолдолд бий болдог. Тухайлбал, хамсаатнуудын хэлмэгдүүлэлтээс айж мэдүүлэг өгөхийг хүсэхгүй байгаа тохиолдолд уг журам нь хамаарна.

§ 172 No 2 GVG – Эдийн засгийн нууц

Шүүх хуралдаанаар хэлэлцэх асуудал хамгаалагдахуйц давамгайлсан ашиг сонирхлыг зөрчих чухал бизнес, үйл ажиллагааны, шинэ бүтээл, татварын нууцыг хэлэлцэх тохиолдолд хаалттай явуулж болно. Хэрэв бизнес эрхлэгч борлуулалтын тоог зарлах, патент зарлах эсвэл ижил төстэй нууцыг задруулах шаардлагатай бол хаалттай хуралдаанд хийж болно.

§ 172 No3 GVG – Нууцлалд хамаарах хувийн нууц

Гэрч, шинжээчийн зөвшөөрөлгүй задруулсан нь шийтгэл ногдуулдаг хувийн нууцыг хэлэлцэж байгаа бол хаалттай хуралдаан хийнэ. Зөвхөн хуульч, эмч гэх мэт нууцлалыг хариуцсан хүмүүст хамаарах хувийн нууцыг л хамгаална.

§ 172 No 4 GVG - Цөөнхийн гэрч

Өсвөр насны гэрчийг оруулсан шүүх хуралдааныг ихэвчлэн хаалттай явуулна.

§ 173 GVG - Шүүхийн шийдвэрийг олон нийтэд зарлах

(1) Гэр бүлийн маргаантай холбоотой шүүхийн шийдвэр, эцсийн шийдвэрийг зарлах нь үргэлж нээлттэй байдаг.

(2) Шүүхийн тусгай захирамжаар 171b, 172 дугаар зүйлийн дагуу шийдвэрийн шалтгаан, тэдгээрийн зарим хэсгийг нээлттэй зарлахгүй байж болно. Бусад тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүнд гарсан шийдвэрийг үргэлж нээлттэй зарлах ёстой. Шүүхийн шийдвэрийн үндэслэлийг олон нийтэд ил тод зарласан бол нийтэд нээлттэй бус хэсгийг аль болох ашиг сонирхлыг хамгаалах үүднээс хуулбарлах ёстой[39].

Монгол Улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулбал, сэтгэцийн эмнэлэг, сэргээн засах төвд хэвтүүлэх тохиолдолд, төрийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам, ёс суртахуунд аюул заналхийлж байгаа тохиолдолд, бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн тохиолдолд, эдийн засгийн нууцтай холбоотой тохиолдолд, өсвөр насны гэрчийг оруулсан тохиолдолд гэх зэргээр шүүх хуралдааныг хаалттай явуулах нөхцөлийг өргөжүүлэн зохицуулснаас гадна процессын зохицуулалтыг нарийвчлан авч үзжээ.

Бүгд Найрамдах Солонгос Улс

Ерөнхий зарчмын хувьд шүүх хурлыг олон нийт, шүүгдэгчид нээлттэй явуулах шаардлагатай байдаг. Гэхдээ шүүх хуралдааныг хаалттай явуулах тохиолдолд үүсч болдог. Энэ нь Үндсэн хуулийн холбогдох зүйл заалтуудаас үндэстэй.

39 Der Ausschluss der Öffentlichkeit aus Gerichtsverhandlungen, https://www.anwalt.de/rec htstipps/der-ausschluss-der-oeffentlichkeit-aus-gerichtsverhandlungen_137107.html

Үндсэн хуулийн 109 дүгээр зүйл.

Шүүх хуралдаан, шүүхийн шийдвэр нээлттэй байна. Харин үндэсний аюулгүй байдал, дэг журамд халдах, ёс суртахуунд халдах эрсдэлтэй тохиолдолд шүүх хуралдааныг хаалттай явуулж болно.

Үндсэн хуулийн 27 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.

Яллагдагч хүндэтгэн үзэх шалтгаан байхгүй тохиолдолд нэн даруй шүүх хурлыг нээлттэй явуулах эрхтэй.

Шүүхийг нээлттэй явуулах талаар дээрх Үндсэн хуулийн зохицуулалт нь дараах агуулгыг илэрхийлж байна.

- Шүүхийн шийдвэрийг олон нийтэд зарлах ёстой;
- Харин тодорхой шалтгаантай бол шүүхийн шийдвэрээр хаалттай явуулна;
- Шүүхийг нээлттэй явуулах нь яллагдагчийн үндсэн эрх юм.

Мөн үүнээс гадна бие даасан хуулиудад шүүх хуралдааныг нээлттэй, хаалттай явуулах талаар дараах байдлаар тусгасан.

Шүүхийн зохион байгууллагын тухай хуулийн 57 дугаар зүйл (Шүүх хуралдааныг нийтэд мэдээлэх)

1. Шүүх хуралдаан, шүүхийн шийдвэр нь нээлттэй байна. Харин үндэсний аюулгүй байдал, амгалан тайван байдал, ёс суртахууныг алдагдуулах эрсдэлтэй тохиолдолд шүүх хурлыг шийдвэрээр хаалттай явуулна.

2. 1 дэх хэсэгт заасан шийдвэрт шалтгааныг дурдсан байна.

3. 1 дэх хэсэгт заасан шийдвэр гарсан ч шүүх бүрэлдэхүүний даргалагч үлдэхийг зөвшөөрч болно.

Цэргийн шүүхийн тухай хуулийн 67 дугаар зүйл (Нийтийн шүүх хурал)

1. Шүүх хуралдаан, шүүхийн шийдвэр нээлттэй байна. Харин нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах эрсдэлтэй, цэргийн нууцыг хамгаалах шаардлагатай үед зөвхөн цэргийн шүүхийн шийдвэрээр шүүх хуралдааныг хаалттай явуулж болно.

2. 1 дэх хэсэгт заасан шийдвэрт шалтгааныг дурдсан байна.

3. 1 дэх хэсэгт заасан шийдвэр гарсан ч шүүх бүрэлдэхүүний даргалагч үлдэхийг зөвшөөрч болно.

Үүний зэрэгцээ бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн шүүх хуралдаанд зориулсан тусгай журам байдаг.

Бэлгийн гэмт хэрэгт шийтгэлийн тухай тусгай хуулийн 31 дүгээр зүйл (Сонсголыг задруулахгүй байх)

1. Бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн сонсголыг хохирогчийн хувийн нууцыг хамгаалах үүднээс шийдвэрээр олон нийтэд зарлахгүй байж болно.

2. Гэрчээр дуудагдсан бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчид болон тэдний ар гэрийнхэн нь хувийн нууцыг хамгаалах зэрэг шалтгаанаар гэрчийн байцаалтыг нууцлах хүсэлт гаргаж болно.

3. 2-т заасны дагуу хүсэлтийг хүлээн авсны дараа даргалагч гэрчийг байцаах арга, байршлыг шийдэж болно.

4. 1 ба 3 дахь хэсгийн хувьд Шүүхийн зохион байгуулалтын хууль болон Цэргийн шүүхийн тухай хуулийн холбогдох зохицуулалтыг хэрэглэнэ

Тус зохицуулалттай холбогдуулан БНСУ-ын Улсын дээд шүүх шийдвэр гаргасан.

Улсын дээд шүүхийн 2013 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 2511 дүгээр шийдвэр

1. Ил болгохыг хориглох үндэслэлгүй атлаа шүүх хуралдааны явцыг задруулахыг хориглосон шийдвэр гаргасан нь шүүх хуралдааныг нээлттэй явуулах эрхийг зөрчиж байна.

2. Иймд шүүгдэгчийн шүүх хуралдааныг нээлттэй явуулах эрхийг зөрчсөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гэрчийн мэдүүлгийг нотлох баримтаар хүлээн зөвшөөрөхгүй.

3. Шүүгдэгчийн шүүх хуралдааныг нээлттэй явуулах эрхийг зөрчсөн мэдүүлэг нь өмгөөллийн хөндлөнгийн эрхийг баталгаажуулсан хэдий ч хүлээн зөвшөөрөх боломжгүй.

4. Ил болгохыг хориглосон шийдвэр гараагүй гэх мэт шалтгаан тодорхойгүй байхад ч хуулийн заалт үйлчилнэ.

Дээрх зохицуулалтыг нэгтгэн үзвэл дараах байдалтай байна.

- Шүүхийг нээлттэй явуулах эрх нь яллагдагчийн Үндсэн хуулиар олгогдсон эрх юм.
- Шийдвэрийг болзолгүйгээр олон нийтэд зарлах ёстой бөгөөд шалтгаантай бол шүүхийн шийдвэрээр хурлыг хаалттай явуулж болно.
- Шүүх хуралдааны нууцыг хадгалах шийдвэр гаргахын тулд шалтгааныг тодруулах ёстой.
- Шүүх хуралдааныг нууцлах үндэслэлгүй ч шүүх хурлыг хаалттай явуулж байгаа нь шүүгдэгчийн шүүх хурлыг нээлттэй явуулах эрхийг зөрчинө.

Бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хувьд гэрчээр дуудагдсан хохирогч болон түүний ар гэрийнхэн гэрчийг нууцаар байцаах хүсэлт гаргаж байгаа эсэхийг шалгаж, хохирогчийн хувийн нууцыг хамгаалах үүднээс шүүх хуралдааныг хаалттай явуулах эсэхийг тогтоодог.

Шүүх хуралдааныг хаалттай явуулсан ч даргалагч зохих хүмүүсийг шүүх хуралдааны танхимд оруулахыг зөвшөөрч болно.[40]

Монгол Улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулбал, зөвхөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгахаас гадна бусад хуулиар зохицуулсан байна. Үндэслэлийн тухайд аюулгүй байдал, амгалан тайван байдал, ёс суртахууныг алдагдуулах, цэргийн гэмт хэрэг, бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн зарим тохиолдолд шүүх хуралдааныг хаалттай явуулахаар тусгажээ.

Иймд, хуулийн төсөл болон одоогийн эрх зүйн зохицуулалтад шүүх хуралдааныг хаалттай явуулах талаар тусгасныг өргөжүүлж төрийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам, ёс суртахууны эсрэг тохиолдлыг болон бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн хохирогч, гэрч, 18 нас хүрээгүй хохирогч, гэрч, өсвөр насны шүүгдэгчийг тусгах талаар анхаарч үзэх нь зүйтэй. Мөн байгууллагын нууц болон албаны нууцын талаар шүүх хуралдааныг хаалттай явуулах нь нийтлэг жишиг биш байна. Харин эдийн засаг, бизнесийн нууцын талаар анхаарч авч үздэг байна. Албаны нууц нь өмнө дурдсанаар байгууллага бүр өөрсдийн дур зоргоор аливаа мэдээллийг нууцлах байдал бий болгодог, тодорхойгүй байдлыг үүсгэдэг учраас хуулийн төсөл болон одоогийн эрх зүйн зохицуулалтаас хасах нь зүйтэй.

40 재판을-비공개로-진행할-수-있는가?, https://leepro127.tistory.com/entry/%EC%9E%AC%ED%8C%90%EC%9D%84-%EB%B9%84%EA%B3%B5%EA%B0%9C%EB%A1%9C-%EC%A7%84%ED%96%89%ED%95%A0-%EC%88%98-%EC%9E%88%EB%8A%94%EA%B0%80

3.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Энэхүү шалгах хэрэгслийг хэрэглэж хуулийн төслийн үр нөлөөг үнэлснээр хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг тогтоож, тэдгээрийг арилгаж, тухайн хуулийн төслийн дотоод болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулна. Энэ хүрээнд хуулийн холбогдох зохицуулалтад дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн зүйл, заалт хуулийн төслийн болон бусад хууль тогтоомжтой зөрчилдөж байгаа эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төслийн нэр нь Эрүүгийн хэрэг хянан тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай бөгөөд энэ нь тухайн зохицуулж буй харилцаандаа хамааралтай байна.

Судалгааны зорилгод хүрэх байдал, практикт хэрэгжих байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгон авсан сэжигтэн, гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэх ойлголтод хамаарах зохицуулалтууд нь өөр хоорондоо зөрчилдөж байна.

Учир нь хуулийн төслийн 2 дугаар зүйлд заасан 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “баривчлагдсан” гэсний дараа “эсхүл гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэж нэмэхээр тусгасан нь гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүнийг сэжигтэнд хамааруулж буй зохицуулалт юм. Гэтэл хуулийн төслийн бусад гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүнтэй холбоотой зохицуулалтууд нь тухайн ойлголтыг сэжигтнээс ялгаатай мэт ойлгогдох байдлаар тусгагджээ. Үүнийг судалгааны зорилгод хүрэх байдал, практикт хэрэгжих байдал хэсгээс дэлгэрэнгүй үзнэ үү.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах зохицуулалт нь харилцан уялдаатай эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төслийн 1.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөтлөх баримт бичиг, хэргийн материал нь цаасан болон цахим хэлбэртэй байна.” гэж нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгасан. Мөн хуулийн төслийн 1.16 дугаар зүйлд “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах” зохицуулалтыг тухайлан оруулжээ. ЭХХШтХ-ийн 1-р бүлгийн нэр нь “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго, зарчим” гэсэн байх бөгөөд энэ бүлэгт дээрх байдлаар шинэ зүйл нэмж оруулсан нь тохиромжгүй байна. Учир нь 1.6-1.15 дугаар зүйл нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмуудыг агуулж байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах гэдэг нь процессын зарчим биш бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэл, бичигт мөн хамаарахгүй юм. Иймд 11.11 дүгээр зүйл буюу хавтаст хэргийн зохицуулалтад хамааруулан хуульчлах шаардлагатай.

Гадаадын эрх зүйн өндөр хөгжилтэй зарим улс, орнуудын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийг цахимаар явуулах, цахим хавтаст хэргийн зохицуулалтыг авч үзвэл ихэвчлэн процессын хуулийн хавтаст хэрэгтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын хүрээнд тусгасан болохыг анхаарах нь зүйтэй. Тухайлбал, ХБНГУ-ын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”[41], ХБНГУ-ын Хамбург мужийн “Хамбург мужийн шүүхүүд дэх цахим хавтаст хэргийн удирдлагын

41 ХБНГУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Strafprozeßordnung – StPO, 1987)

тухай журам”[42], Бүгд Найрамдах Эстони Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”[43]-д цахим хавтаст хэрэг болон түүний зохион байгуулалттай холбоотой зохицуулалтад үүнийг хамааруулан тусгажээ.

42 Elektronische Akte in der Justiz, 2024.02.28, https://justiz.hamburg.de/e-justice/elektronische-akte-in-der-justiz zuletzt besucht 2024.03.20.

43 БНЭсУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Kriminaalmenetluse seadustik, 2003) https://www.riigiteataja.ee/akt/104102013004

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Тус судалгааны хүрээнд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ төслийн зохицуулалт, агуулга нь өөрчлөлтийн үзэл баримтлал, зорилгод нийцэж буй эсэх, зохион байгуулалтыг өөрчилж буй зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх, шинээр тусгагдсан зохицуулалтууд нь хүлээн зөвшөөрөгдсөн эсэх, хуулийн төсөл нь хууль зүйн техникийн хувьд алдаатай эсэхэд дүн шинжилгээ хийсэн бөгөөд дараах дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

1.Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах, ялангуяа цахим хавтаст хэргийг бий болгох, цахим нотлох баримтын талаар зохицуулах нь одоогийн хэрэгцээ, шаардлагад нийцэхүйц байна. Өөрөөр хэлбэл орчин үед цахим хөгжил эрчимтэй явагдаж буй энэ үед эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох, хялбарчлах, хэмнэлттэй, үр дүнтэй байх ач холбогдлыг бий болгож байна. Хуулийн төслийн 1.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 1.16 дугаар зүйл, 11.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 11.11 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг болон бусад цахимжуулахтай холбоотой зохицуулалт нь тус хэрэгцээ, шаардлага, зорилгод нийцэж буй боловч цахим нотлох баримтыг хуулийн төсөлд тусгаж нарийвчлан зохицуулаагүйгээрээ нэмэлт, өөрчлөлтийн хэрэгцээ, шаардлага, зорилгод нийцэхгүй байна. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд цахим нотлох баримтын талаар нарийвчлан зохицуулах шаардлагатай.

Хуулийн төсөлд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах талаар тусгасан нь зорилгод нийцэхээс гадна цахим хэлбэртэй байхаас гадна цаасан хэлбэртэй байхаар тусгасан нь зорилгод нийцэж байна. Учир нь 2020 онд батлагдсан Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу цаасан болон цахим суурьтай байх нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийн шаардлага юм. Түүнчлэн зохицуулалтын практик хэрэгжилт бий болох хүртэл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийн найдвартай байдлыг хангах хөшүүрэг болохоор байна.

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд сэжигтэн, гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэж ЭХХША-ны нэг субъектыг ялгамжтай байдлаар тусгаж хуульчлах нь хуулийн нэр томьёог нэг мөр ойлгон хэрэглэх, ойлгомжтой байдал, хууль хоорондын уялдаа холбоог хангахад сөргөөр нөлөөлөхөөр байна. Иймд одоо байгаа хуулийн зохицуулалт буюу сэжигтэнтэй холбоотой зохицуулалтаа засаж сайжруулах, эрх зүйн хийдлийг арилгахад чиглэсэн зохицуулалтуудыг хуулийн төсөлд тусгаж, сэжигтэнг тодорхойлон хуульчлах нь илүү оновчтой байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон хуулийн төсөлд “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн”-ий эрх, үүргийн талаар тусад нь зохицуулаагүй. Дээр дурдсанчлан хуулийн төслийн 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн сэжигтэнд хамаарч байгаа учир сэжигтний адил эрх эдлэхээр байна. Гэтэл хуулийн төслийн бусад зохицуулалтад сэжигтэн, гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэх ойлголтыг өөр хоорондоо ялгаатай мэтээр

тусгаснаас үзвэл гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн сэжигтний хуульд заасан эрхийг түүнтэй адил эдлэх эсэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрхэн явуулах нь ойлгомжгүй байна.

Гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн гэх ойлголт одоогийн ЭХХШтХ-д заасан сэжигтнээс илүү тухайн гэмт хэргийг үйлдсэн болох нь нотлогдож байгаа хүнийг тодорхойлсон байна. Нөгөөтээгүүр, “гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэдгийг сэжигтнээс ялгамжтай байдлаар тусгасны ач холбогдол хуулийн төслөөс харагдахгүй байгааг дурдах нь зүйтэй.

- Хуулийн төсөлд шүүх хуралдааныг үндэслэлгүйгээр хойшлуулж байгаатай холбоотойгоор өмгөөлөгчид хариуцлага тооцох, шүүгдэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй тохиолдолд шүүх хуралдааныг хойшлуулахгүй байх, прокурор шүүхээс тогтоосон хугацаанд даалгаврыг биелүүлэх боломжгүй бол дахин сунгах зэрэг зохицуулалтыг тусгасан нь хуулийн төслийн өөрчлөлтийн зорилго, үзэл баримтлалд нийцэж байна. Мөн түүнчлэн практик судалгааны үр дүнд тогтоосон асуудлыг шийдэхэд ач холбогдолтой тул зорилгодоо нийцсэн гэж үзэхээр байна.

2.Практикт хэрэгжих байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Хуулийн төсөлд тусгагдсан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах талаар зохицуулалтыг дэлгэрүүлж нарийвчлан зохицуулах шаардлагатай. Гадаадын эрх зүйн өндөр хөгжилтэй зарим улс, орнуудын зохицуулалтыг авч үзвэл цахим баримт бичиг, хавтаст хэргийг цугт нь нарийвчлан зохицуулах жишиг тогтсон байна. Тухайлбал, БНСУ-ын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт ашиглах тухай хууль”-д "цахим хавтаст хэрэг”, “цахимжуулсан хавтаст хэрэг” гэх нэр томьёог нарийвчлан тодорхойлсноос гадна эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахим баримт бичгээр гүйцэтгэх, компьютержсэн мэдээлэл боловсруулах системийг ажиллуулах, цахим баримт бичгийг хүлээн авах, цахим баримт бичгийг бэлтгэх, цахим баримт бичгийг үзэх, хуулбарлах, цахим баримт бичгийг устгах зэрэг зохицуулалтыг тухайлан зохицуулсан байна.

Үүнээс гадна тус хуулийн төсөлд цахим нотлох баримтыг тодорхойлж, холбогдох зохицуулалтыг нарийвчлан тусгаагүй байна. Олон улсын гэрээ, конвенц, гадаадын эрх зүйн өндөр хөгжилтэй зарим улс, орнуудын зохицуулалтыг авч үзвэл цахим нотлох баримтыг тухайлан хуульчилж, нарийвчлан зохицуулсан жишиг бий болоод байна. Иймд тус хуулийн төсөлд цахим нотлох баримтыг тодорхойлон хуульчилж нарийвчлан зохицуулах хэрэгтэй.

3.Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- ЭХХШтХ-ийн 25.1 дүгээр зүйлд “Мэдүүлэг авах” зохицуулалтыг хуульчилсан бөгөөд төслийн 25.1 дүгээр зүйлийн 18 дахь хэсэгт “Гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүнийг гэрчээр дуудан ирүүлэхийг хориглоно” гэж заасан нь хуулийн 25.1 дүгээр зүйлд хамаарахгүй байна. Иймд төслийн 25.1 дүгээр зүйлийн 18 дахь заалтыг хамаарал бүхий ЭХХШтХ-ийн холбогдох зүйл, заалтад нэмж тусгах нь зүйтэй.

- Төслийн 2 дугаар зүйлд 7.3 дугаар зүйлийн “танилцах,” гэсний дараа “хувийг авах” гэж нэмэхээр тусгажээ. Гэвч ЭХХШтХ-ийн 7.3 дугаар зүйлийн аль хэсэгт

заасан “танилцах” гэсний дараа “хувийг авах” гэж нэмэхийг орхигдуулан бичжээ. Иймд төслийн 2 дугаар зүйлд заасан 7.3 дугаар зүйлийн “танилцах” гэсний дараа “хувийг авах” гэснийг 7.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “танилцах” гэсний дараа “хувийг авах “ гэж өөрчлөх.

- Төслийн 2 дугаар зүйлд 14.13 дугаар зүйлийн “прокурор” гэсний дараа “яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч” гэж нэмэхээр тусгажээ. Гэвч ЭХХШтХ-ийн 14.13 дугаар зүйл нь 12 хэсгээс бүрдэж байх бөгөөд энэхүү 12 хэсгийн аль хэсэг дэх “прокурор” гэсний дараа ““яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч” гэж нэмэх нь ойлгомжгүй байна. Иймд хэсгийн дугаарыг ойлгомжтой байдлаар тусгах.

- Төслийн 2 дугаар зүйлд 34.1 дүгээр зүйлийн “болохгүй.” гэсний дараа “Шүүгдэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй нь шүүх хуралдаан хойшлуулах үндэслэл болохгүй” гэж нэмэхээр тусгажээ. Гэвч төсөлд 34.1 дүгээр зүйлийн хэд дэх хэсэгт заасан “болохгүй.” гэсний дараа нэмж оруулахаар заагаагүй байна. Харин ЭХХШтХ-ийн 34.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “болохгүй.” гэх үг тусгагдсан байна. Иймд төслийн 34.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “болохгүй.” гэсний дараа “Шүүгдэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй нь шүүх хуралдаан хойшлуулах үндэслэл болохгүй” гэж өөрчлөх.

- Төслийн 4 дүгээр зүйлд 5.1 дүгээр зүйлийн 2.10-2.15 дахь заалтын дугаарыг 2.12-2.16 гэж өөрчлөх талаар тусгажээ. Гэвч 2.10-2.15-д нийт 6 заалт хамаарч байх бөгөөд 2.12-2.16 гэж өөрчилснөөр нийт 5 зохицуулалтын дугаарыг өөрчлөхөөр тусгаж, нэг зохицуулалтын дугаарыг орхигдуулсан байна. Иймд төслийн 4 дүгээр зүйлд заасан 5.1 дүгээр зүйлийн “2.10-2.15 заалтын дугаарыг 2.12-2.16 гэж” гэсний орхигдуулсан дугаарыг оруулж “2.10-2.15 дахь заалтын дугаарыг “2.12-2.17” гэж өөрчлөх.

- Төслийн 4 дүгээр зүйлд заасан 32.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “тэдний өмгөөлөгчид” гэснийг “тэдний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид” гэж өөрчлөх талаар тусгажээ. Гэвч ЭХХШтХ-ийн 32.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Мөрдөгч мөрдөн шалгах бүх ажиллагааг хийж дууссан, хэргийн бодит байдлыг бүрэн нотолж тогтоосон гэж үзвэл яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид хавтаст хэргийн материалтай танилцахыг мэдэгдэнэ.” гэж заасан. Өөрөөр хэлбэл, ЭХХШтХ-д оруулахаар тусгасан өөрчлөлт нь энэ хуулийн зохицуулалттай ижил байна. Иймд тус зохицуулалтыг хасах.

4.Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Практикт шүүхийн шийдвэрээр тухайн хэрэгт хураагдан ирсэн эд мөрийн баримтыг цаашид хадгалах эсэхийг хэрхэн шийдвэрлэснээс хамаарч нотлох баримтыг хадгалах эсхүл устгах арга хэмжээг авдаг. Цахим нотлох баримтын хувьд практикт ихэвчлэн CD дээр хуулбарлан хавтаст хэрэгт хавсаргадаг бөгөөд энэ нь тухайн хавтас хэргийг хадгалах хугацаатай ижил хугацаанд хадгалагдаж байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалалтын талаар зохицуулалтыг нэг мөр болгон хуульчилж дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн хадгалалт, хамгаалалтын талаар тогтсон зохицуулалтыг бий болгох нь зүйтэй.

Бусад улсад хэргийн төрлөөс хамааруулан баримт бичгийг жилээр, цаашлаад хөөн хэлэлцэх хугацааг дуусах хүртэл хадгалдаг болохыг харгалзан үзэх хэрэгтэй. Мөн нотлох баримт, эд мөрийн баримтын хадгалалт, хамгаалалтын талаар нэгдсэн журам боловсруулан гаргах шаардлагатай.

- Хуулийн төсөлд төрийн болон албаны нууц мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэр, прокурорын яллах дүгнэлтийг прокурор, оролцогчид гардуулах, танилцуулах талаар, хүний хувийн мэдээлэл, эмзэг мэдээлэл агуулсан шүүх хуралдааны талаар нарийвчлан зохицуулсан хэдий ч талуудын нотлох баримт, баримт бичигтэй танилцах эрх, ашгийг хамгаалах талаар өргөнөөр хязгаарласан байна. Тодруулбал, Төслийн 32.10 дугаар зүйлд 9 дэх хэсэгт төрийн нууцтай холбоотой хэргийн яллах дүгнэлтийг бүрэн бодитой танилцуулж, төрийн нууц мэдээлэл агуулсан хэсгийг хассан хувийг гардуулан өгөхөөр тусгасан нь яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн нотлох баримт, баримт бичигтэй танилцах эрх, ашгийг зөрчих боломжид хүргэж болох юм. Учир нь бүрэн бодитой танилцах нь тухайн талын нөхцөл байдлаас хамаарч өөр байж болох ба яллах дүгнэлтийг бүхэлд нь гардан аваагүйн улмаас түүний эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх магадлалтай. Түүнчлэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар яллагдагч ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх эрхтэй. Иймд тус эрхүүдийг өргөнөөр ийнхүү хязгаарлахын оронд яллах дүгнэлттэй танилцах, гардан авах яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид нууц задруулахгүй байх үүргийг хүлээлгэх нь зүйтэй.

Мөн тус төслийн 36.13 дугаар зүйлийн 5,6 дахь хэсэгт төрийн нууц мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэрийн “Тодорхойлох”, “Удиртгал”, “Тогтоох” хэсэгт төрийн нууц агуулсан мэдээлэл агуулагдсан бол гардуулахгүйгээр, шүүхийн шийдвэрийг бүрэн бодитой танилцуулах арга хэмжээ авахаар зохицуулжээ. Энэ нь өмнө дурдсан талуудын нотлох баримт, баримт бичигтэй танилцах эрх, ашгийг зөрчих боломжид хүргэхээс гадна шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхийг өргөнөөр хязгаарлах нөхцөл байдал үүсгэх юм. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт зааснаар “…шүүхийн шийдвэрийг давж заалдах…” иргэний үндсэн эрхийг тусгасан ба үүнийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар баталгаажуулж 38.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, тэдгээрийн өмгөөлөгч шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах, улсын яллагч, дээд шатны прокурор эсэргүүцэл бичих эрхтэй.” гэж тусгасан байдаг. Иймд тус эрхүүдийг өргөнөөр хязгаарлахын оронд шүүхийн шийдвэртэй танилцах, гардан авах талуудад нууц задруулахгүй байх үүргийг хүлээлгэн давж заалдах эрхийг хангах талаар авч үзэх хэрэгтэй.

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.4 дүгээр зүйлд шүүх хуралдаан хаалттай явуулах зохицуулалтыг хуульчилсан байсныг тус нэмэлт, өөрчлөлтөөр 3.2 дугаар зүйлд давхардуулан хуульчилсан байна. Тухайлбал, шүүх хуралдаан хаалттай явуулах нөхцөл байдлыг хуульчилсан байсныг дахин тодорхойлж хүний эмзэг мэдээллээс бусад хувийн мэдээлэл болон байгууллагын нууц мэдээлэлд хамаарч байвал мэдээллийн эзэн буюу хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр хаалттай явуулахыг тодорхойлсон байна. Харин мэдээллийн эзэн зөвшөөрсөн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн ажиллагаан дахь хүний эмзэг мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод

байлгаж болох зохицуулалт болон хаалттай шүүх хуралдааны явцад илэрхий болсон төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний хувийн мэдээллийг шүүгч, шүүх хуралдаанд оролцогч задруулж болохгүй талаар зохицуулалт нь давхцаагүй хэдий ч 3.2 дугаар зүйлд биш 34.4 дүгээр зүйлд тусгагдах нь зохимжтой байна.

Гадаадын эрх зүйн өндөр хөгжилтэй зарим улс, орнуудын жишгийг авч үзвэл, сэтгэцийн эмнэлэг, сэргээн засах төвд хэвтүүлэх тохиолдолд, төрийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам, ёс суртахуунд аюул заналхийлж байгаа тохиолдолд, бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн тохиолдолд, эдийн засгийн нууцтай холбоотой тохиолдолд, өсвөр насны гэрчийг оруулсан тохиолдолд гэх зэргээр шүүх хуралдааныг хаалттай явуулах нөхцөлийг өргөжүүлэн зохицуулснаас гадна процессын зохицуулалтыг нарийвчлан авч үзсэн нь сайн жишиг болж байна. Иймд хуулийн төсөлд тус үндэслэлүүдээс тусгах эсэхийг шийдвэрлэх шаардлагатай.

Мөн байгууллагын нууц болон албаны нууцын талаар шүүх хуралдааныг хаалттай явуулах нь нийтлэг жишиг биш байна. Харин эдийн засаг, бизнесийн нууцын талаар анхаарч авч үздэг байна. Албаны нууц нь өмнө дурдсанаар байгууллага бүр өөрсдийн дур зоргоор аливаа мэдээллийг нууцлах байдал бий болгодог, тодорхойгүй байдлыг үүсгэдэг учраас хуулийн төсөл болон одоогийн эрх зүйн зохицуулалтаас хасах нь зүйтэй.

5.Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Хуулийн төслийн 2 дугаар зүйлд заасан 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “баривчлагдсан” гэсний дараа “эсхүл гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүн” гэж нэмэхээр тусгасан нь гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүнийг сэжигтэнд хамааруулж буй зохицуулалт юм. Гэтэл хуулийн төслийн бусад гэмт хэрэгт сэжиглэх үндэслэлтэй хүнтэй холбоотой зохицуулалтууд нь тухайн ойлголтыг сэжигтнээс ялгаатай мэт ойлгогдох байдлаар тусгагджээ. Иймд тус зохицуулалтыг засварлах шаардлагатай.

- Хуулийн төслийн 1.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөтлөх баримт бичиг, хэргийн материал нь цаасан болон цахим хэлбэртэй байна.” гэж нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгасан. Мөн хуулийн төслийн 1.16 дугаар зүйлд “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах” зохицуулалтыг тухайлан оруулжээ. ЭХХШтХ-ийн 1-р бүлгийн нэр нь “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго, зарчим” гэсэн байх бөгөөд энэ бүлэгт дээрх байдлаар шинэ зүйл нэмж оруулсан нь тохиромжгүй байна. Учир нь 1.6-1.15 дугаар зүйл нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмуудыг агуулж байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах гэдэг нь процессын зарчим биш бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэл, бичигт мөн хамаарахгүй юм. Иймд 11.11 дүгээр зүйл буюу хавтаст хэргийн зохицуулалтад хамааруулан хуульчлах шаардлагатай. Гадаадын эрх зүйн өндөр хөгжилтэй зарим улс, орнуудын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийг цахимаар явуулах, цахим хавтаст хэргийн зохицуулалтыг авч үзвэл ихэвчлэн процессын хуулийн хавтаст хэрэгтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын хүрээнд тусгасан болохыг анхаарах нь зүйтэй.

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж

Монгол хэлээр:

1. Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992, №1;
2. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2020, №29;
3. Төрийн болон албаны нууцын тухай хууль, 2016;
4. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, 2021;
5. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, 2021;
6. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016, №9;
7. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002, №8;
8. Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2021, №5;
9. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №23;
10. Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
11. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
12. Монгол Улсын Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 5 сарын 18-ны өдрийн А/24 тушаалаар батлсан “Цахим үндэстэн” баримтлах чиглэл (2022-2027);
13. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 332 дугаар тогтоол;
14. 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоол, Дугаар 31, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөв хэрэглэх албан ёсны тайлбар;
15. 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн УДШ-ийн Ерөнхий шүүгч, ХЗДХ-ийн Сайд, УЕП-ын хамтарсан Дугаар А/18, 34, А/31 “Заавар батлах тухай”;
16. 2019 оны 12 сарын 5-ны өдрийн Дугаар 246, А/80 Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий Прокурорын хамтарсан захирамж, тушаал;
17. 2022 оны 1 сарын 6-ны өдрийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоол Дугаар 1 “Журам батлах тухай”
18. Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2021 оны 5 сарын 20-ны өдрийн А/69 дугаар тушаал;
19. Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2022 оны 4 сарын 15-ны өдөр дугаар А/42 тушаал;
20. 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоол, Дугаар 31, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөв хэрэглэх албан ёсны тайлбар.

Ном, сурах бичиг, судалгааны тайлан, эмхэтгэл

Монгол хэлээр:

1. 2023 оны 3 сарын 23-24-ний өдөр зохион байгуулагдсан “Монгол Улсын Шүүхийн цахимжуулалт” ОУБХ-д ЦХХХ-ны дэд сайд Ж.Эрхэмбаатарын хэлэлцүүлсэн “Монгол Улсын шүүхийн болон хуулийн байгууллагуудыг цахимжуулах мэдээлэл технологийн үүрэг” сэдэвт илтгэл;
2. ГХУСАЗЗ, Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2022, (Уб, 2023);
3. 2023 оны 3 сарын 23-24-ний өдөр зохион байгуулагдсан “Монгол Улсын Шүүхийн цахимжуулалт” ОУБХ-д Н.Отгончимэгийн хэлэлцүүлсэн “Шүүхийн санхүүжилтийн механизмыг шинэчлэх шаардлага” сэдэвт илтгэл;
4. Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын төсөлд хийсэн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ /Хөндлөнгийн судалгаа/, (Уб, 2023);
5. Л.Галбаатар, Кибер гэмт хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх нь, (Уб, 2015);
6. ННФ, Кибер гэмт хэргийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа /Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, үйл ажиллагааны эрсдэлийн хүрээнд/, (Уб, 2022);
7. Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг (Кибер) гэмт хэргийн гүнзгийрүүлсэн судалгаа, (Уб, 2019);
8. Монгол Улсад үйлдэгдэж байгаа кибер гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, түүнтэй тэмцэх арга зам, үндсэн чиглэл /Суурь судалгааны тайлан/, (Уб, 2015);
9. Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг (Кибер) гэмт хэргийн гүнзгийрүүлсэн судалгаа, (Уб, 2019);
10. Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын төсөлд хийсэн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ /Хөндлөнгийн судалгаа/, (Уб, 2023);
11. ННФ, Нотолгооны өнөөгийн практик, арга зүй, техник хэрэгсэл, анхаарах асуудал /Судалгааны тайлан/, (Уб, 2021);
12. ННФ, Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудал: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Хуулийн шүүмж, Цуврал 22, (Уб, 2018);
13. ННФ, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь өмгөөлөгчийн оролцооны эрх зүйн асуудал, (Уб, 2024);
14. Б.Өнөрмаа, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны “оролцогч биш” оролцогч буюу “сэжигтний” талаарх зохицуулалтын ХБНГУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн /stpo/ зохицуулалттай харьцуулах нь”, Хууль дээдлэх ёс сэтгүүл, №1, (71), (Уб, 2019);

Цахим эх сурвалж

Монгол хэлээр:

1. Г.Даваадорж: Шүүхийн цахимжилтад хууль эрх зүйн орчин ус агаар мэт хэрэгтэй байна, https://www.judcouncil.mn/site/news_full/13818

2. Цахим орчин дахь гэмт хэргийн ул мөрийг баримтжуулж авах нь, https://www.mnb.mn/i/92447
3. М.Бямбасүрэн, Цахим баримт бичгийг нотлох баримтын хэмжээнд үнэлдэг байх шаардлагатай нийтлэл, 2024.01.29, https://business.mn/2024/01/29/m-byambasuren-tsahim-barimt-bichgiig-notloh-barimtiin-hemjeend-uneldeg-baih-shaardlagatai/
4. Ш.Мөнхжаргал, Л.Уянга, Б.Нямцэрэн нар, Нотлох баримт, түүнийг үнэлэхтэй холбоотой эрх зүйн эх сурвалжуудыг судалж бичсэн, асуудал дэвшүүлсэн өгүүлэл, https://legaldata.mn/buteel/pdf?id=1761
5. “Эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, барьцааны мөнгө, эд мөрийн баримтыг шийдвэрлэх журам”, “Хавтаст хэргийг хүлээн авах, хадгалах, шилжүүлэх журам” http://old.supremecourt.mn/act/view/266
6. Шинэ хуулиар сэжигтэн гэх ойлголт үгүй болно нийтлэл, 2015.05.06, https://gogo.mn/r/qo8v7

Гадаад хэлээр:

1. Der Ausschluss der Öffentlichkeit aus Gerichtsverhandlungen, https://www.anwalt.de/rec htstipps/der-ausschluss-der-oeffentlichkeit-aus-gerichtsverhandlungen_137107.html
2. Elektronische Akte in der Justiz, 2024.02.28, https://justiz.hamburg.de/e-justice/elektronische-akte-in-der-justiz zuletzt besucht
3. OECD, “Working Party No. 3 on Co-operation and Enforcement Access to the case file and protection of confidential information – Background Note by the Secretariat”, 2019, https://one.oecd.org/document/DAF/COMP/WP3(2019)6/en/pdf
4. БНЭсУ-ынЭрүүгийнхэрэгхянаншийдвэрлэхтухайхууль(Kriminaalmenetluse seadustik, 2003) https://www.riigiteataja.ee/akt/104102013004
5. ХБНГУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Strafprozeßordnung – StPO, 1987)
6. 재판을-비공개로-진행할-수-있는가?, https://leepro127.tistory.com/entry/%EC%9E%AC%ED%8C%90%EC%9D%84-%E B %B 9 %8 4 %E A %B 3 %B 5 %E A %B 0 %9 C %E B %A 1 %9 C -% E C % A 7 % 8 4 % E D % 9 6 % 8 9 % E D % 9 5 % A 0 -% E C % 8 8 % 9 8 - % E C % 9 E % 8 8 % E B % 8 A % 9 4 % E A % B 0 % 8 0

ДӨРӨВ. ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Хууль зүйн ухааны доктор (Dr.jur.)

Судалгааны багийн бусад гишүүд:

М.Түвшинжаргал	Эрдэмтэн нарийн бичгийн дарга Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
Р.Хатансайхан	Эрдэм шинжилгээний ахлах ажилтан (LL.M)
С.Нарантунгалаг	Эрдэм шинжилгээний ахлах ажилтан
Г.Болор-Эрдэнэ	Эрдэм шинжилгээний ажилтан
М.Ганди	Эрдэм шинжилгээний ажилтан
Э.Тамир	Эрдэм шинжилгээний ажилтан

Судалгааг захиалагч: Хууль зүй, дотоод хэргийн яам
Судалгааг гүйцэтгэж хүргүүлсэн огноо: 2024.10.08.

АГУУЛГА

УДИРТГАЛ 237
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ 238
1.1. Үнэлгээ хийх шалтгаан 238
1.2. Үнэлгээ хийх хүрээ 238
1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт 239
1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр 239
1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох 240
1.6 Мэдээлэл цуглуулах аргыг сонгох 240
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ 242
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ 244
3.1. Зорилгод хүрсэн түвшин 246
3.2. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал 250
3.3.Практикт хэрэгжих байдал 257
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ 263
НОМ ЗҮЙ 265

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 7.3.9-д “Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоог бэхжүүлж, мансууруулах бодис хэрэглэгч, донтогчид эрүүл мэндийн болон сэтгэл зүйн засал, нийгмийн тусламж үйлчилгээг үзүүлэх, урьдчилан сэргийлэх төвийг бий болгон олон нийтэд чиглэсэн нөлөөллийн ажлыг цогц байдлаар хэрэгжүүлнэ.” гэж, Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.1.14-т “Гэрч, хохирогчийг хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах алба шинээр байгуулж, хохирогчийн эрхийг хангах, хохирол барагдуулах үйл ажиллагааг шинэ шатанд гаргана.” гэж, Монгол Улсын Засгийн Газрын 2015 оны 346 дугаар тогтоолоор батлагдсан “Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 7.1-д “Гэрч, хохирогчийг хамгаалах хөтөлбөрийн гуравдугаар үе шатыг 2022-2024 он хүртэл хэрэгжүүлнэ” гэж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно”[1] гэж тус тус заасныг үндэслэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэллээ.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3-т заасны дагуу Хууль зүйн үндэсний хүрээлэн эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн харилцааг зохицуулж буй нийтлэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх чиг үүргийн хүрээнд Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, тулгарч буй хүндрэл бэрхшээлүүд, тэдгээрийн үр дагавар, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлсний үндсэн дээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, зөвлөмж боловсруулахыг зорьсон болно.

Энэхүү судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэлээ.

1 Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг 2018 онд хийсэн байна.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Төлөвлөх үе шатны зорилго нь үнэлгээ хийх хүрээг тогтоож, түүнд тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход чиглэгдэнэ. Энэ үе шатанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1. *Үнэлгээ хийх шалтгаан*

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалд заасны дагуу хууль тогтоомж нь тухайн харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх болон тухайн хууль тогтоомжийн нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэхийн тулд үнэлгээний ажлыг эхлэхээс өмнө үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх эрх зүйн үндсийг 2013 онд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиар тогтоосон бөгөөд 2018 онд тус хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн байна. Энэ удаагийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг удиртгалд дурдсан эрх зүйн үндэслэл, шаардлагаас гадна дараах шалтгааны улмаас гүйцэтгэсэн болно. Үүнд:

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад түүний зохицуулалт бодит байдалтай нийцээгүй, тухайн харилцааг зохицуулах боломжгүй, эсхүл нийгмийн харилцааны өөрчлөлт, хөгжлөөс хоцорсон, зайлшгүй зохицуулах ёстой харилцааг хамарч зохицуулаагүй, эсхүл тэдгээрээс улбаалсан сөрөг үр дагавар бий болсон;

Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хангах талаарх үүргээ хангалтгүй биелүүлж байгаа;

1.2. *Үнэлгээ хийх хүрээ*

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.4-т “Хууль тогтоомжийн зохицуулах харилцааны онцлог, асуудлаас хамааран хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийхдээ хууль тогтоомжид бүхэлд нь, эсхүл түүний зарим зүйл, хэсэг, заалтыг сонгож болно” гэж заасны дагуу Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дараах заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлсэн болно. Үүнд:

Хүснэгт 4.1. *Үнэлэх зүйл, заалт*

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт	4.1.1.”гэрч, хохирогч” гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогчийг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан гэрчийг;
2	13 дугаар зүйл. Аюулгүй газарт түр байрлуулах	13.1.Шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан насанд хүрсэн гэрч, хохирогчийг өөрийнх нь зөвшөөрснөөр, насанд хүрээгүй гэрч, хохирогчийг түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын зөвшөөрснөөр аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулна.
3	21 дүгээр зүйл. Хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам	21.5.Энэ хуулийн 7.1.3-7.1.9-д заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Энэ хуулийн 10.2-т заасан бүсэд биечилсэн хамгаалалтыг хэрэгжүүлэх журмыг батлахдаа холбогдох байгууллагын саналыг харгалзана.
4	23 дугаар зүйл. Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага, түүний үүрэг	23.1.Хамгаалалтын арга хэмжээг дараах байгууллагууд өөрийн эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ: 23.1.1.цагдаагийн алба; ~~23.1.2.мөрдөх алба;~~ ~~23.1.3.Тахарын алба;~~ 23.1.4.Авлигатай тэмцэх газар; 23.1.5.Тагнуулын ерөнхий газар.

1.3. *Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт*

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.4-т Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлоход сонгох шалгуур үзүүлэлтүүдийн жагсаалтыг тусгасан. Үнэлгээ хийх асуудал тодорхой болсон үед тодорхой 1 шалгуур үзүүлэлтийг сонгон авах бөгөөд зөвхөн 1 шалгуур үзүүлэлтээр тухайн асуудалд бүрэн үнэлэлт өгөх боломжгүй тохиолдолд 2 болон түүнээс дээш шалгуур үзүүлэлтийг сонгох боломжтой.

Аргачлалд дурдсан шалгуур үзүүлэлтээс уг аргачлалын 3.4.1-д заасан “Зорилгод хүрсэн түвшин”, 3.4.4-т заасан “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” болон 3.4.5-д заасан “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгов. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтээр тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг, “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтээр иргэд, хуулийн этгээдээс хууль тогтоомжийг хэрэгжүүлснээр гарсан үр дагаврыг хэрхэн хүлээн авч байгааг буюу хууль тогтоомжийг нийгэм хүлээн зөвшөөрч, сайн дураар сахин биелүүлж байгаа эсэхийг, “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтээр тухайн хууль тогтоомжийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тус тус тодорхойлно.

1.4. *Үнэлгээний харьцуулах хэлбэр*

Хууль тогтоомж хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтүүдийг олж тодорхойлоход харьцуулах хэлбэрүүдийг ашигладаг. Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний

хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрүүдээс сонгоно. Үүнд:

1. Байх ёстой болон одоо байгаа;
2. Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших;
3. Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших;
4. Тохиолдол судлах.

Эдгээр дөрвөн төрлийн харьцуулах хэлбэрээс “байх ёстой болон одоо байгаа”, “тохиолдол судлах” хэлбэрүүдийг сонголоо. Ийнхүү харьцуулан судлах нь Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгох ажлын хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай гэж үзэв.

Хүснэгт 4.2. *Тогтоосон шалгуур үзүүлэлтэд тохирох харьцуулах хэлбэр*

№	Шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэр
1	Зорилгод хүрсэн түвшин	Байх ёстой болон одоо байгаа: Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагавар (одоо байгаа нөхцөл байдал)-ыг бодитой хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийг тухайн хууль тогтоомжоор тогтоосон шаардлага, норм, хугацаа, давтамж, хэмжиж болохуйц тодорхой тоогоор илэрхийлэгдсэн тоон үзүүлэлттэй харьцуулах хэлбэрээр хууль тогтоомжийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтооно.
2	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш: Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дараалаар судалж тогтооход чиглэгдэнэ.
3	Практикт нийцэж байгаа байдал	Тохиолдол судлах: Хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт) хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийхийг хэлнэ.

1.5. *Шалгуур үзүүлэлтийг томьёолох*

Энэхүү үнэлгээг хийхдээ Аргачлалын “практикт нийцэж байгаа байдал”, “зорилгод хүрсэн түвшин”, “хүлээн зөвшөөрөгдсөн байдал”гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгож авсан. Уг шалгуур үзүүлэлтийг томьёолж, дараах асуултыг боловсруулав.

- ***Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1.*** Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн зохицуулалтууд нь зорилгодоо нийцэж байгаа эсэх?
- ***Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2***. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл, байдал хэрхэн өөрчлөгдсөн байна вэ?
- ***Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3.*** Гэрч, хохирогчийн хамгаалах тухай хууль практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хүндрэл, бэрхшээл үүсгэж байгаа эсэх?

1.6 Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд тоон болон чанарын мэдээлэл ашиглах ба дараах аргуудаас сонгож ашиглана.

1. Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах;
2. Холбогдох субъектээс судалгаа авах;
3. Шинжээчдийн зөвлөгөөн зохион байгуулах;
4. Биечлэн судалгаа хийх.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдсөн байдал, практик хэрэгжилтийг үнэлэх зорилгоор бодлогын баримт бичиг, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан уншиж судлах, өмнөх хэрэгжилтийн үнэлгээний тайлантай танилцах, бусад хууль тогтоомжтой харьцуулалт хийх зэрэг аргаар хэрэгцээтэй мэдээлэл олж авсан ба аргачлалын дараах аргыг ашигласан болно. Үүнд:

- Аргачлалын 3.7.3.1-д заасны дагуу “Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах” хүрээнд: Гэрч хохирогчийн хамгаалах тухай хууль, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль болон ном, гарын авлага, эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайлан, статистикийн тоо баримт цуглуулж, дүн шинжилгээ хийсэн болно.
- Аргачлалын 3.7.3.2-т заасны дагуу “Холбогдох субъектээс судалгаа авах” хүрээнд: Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2018 онд УИХ-д өргөн мэдүүлсэн Хууль зүйн байнгын хорооны хуулийн төсөлтэй холбогдуулсан гүйцэтгэсэн Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд яамд, байгууллагаас ирүүлсэн санал, Гэрч, хохирогчийг хамгаалалтын талаар ЦЕГ-ын нийтэлсэн үйл ажиллагааны тайлан, мэдээтэй тус тус танилцсан болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн холбогдох зохицуулалтад хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ эх сурвалж судлах, холбогдох субъектээс судалгаа авах аргаар дараах материалыг цуглуулж үнэлгээ хийхэд ашигласан.

Бэлэн мэдээллийг цуглуулах хүрээнд:

Нэг. Хууль тогтоомж

1. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 2013 он;
2. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, 2012 он;
3. Эрүүгийн хууль, 2015 он;
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он;
5. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2016 он;
6. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, 2017 он;
7. Шүүхийн тухай хууль, 2021 он;
8. Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам, 2021 он;
9. Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндэд аюул занал учрах нөхцөл үүссэн үед хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх журам, 2021 он;
10. Тахарын албаны тухай хууль, 2013 он (Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон.)

Хоёр. Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, “Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь” судалгааны тайлан, Уб, 2022 он;
2. Нээлттэй нийгэм форум, “Гэрч, хохирогчийн хамгаалалт” бодлогын судалгааны тайлан, Уб, 2019 он;
3. Тогтвортой хөгжлийн санаачлага ТББ, “Монгол улсын хүүхэд хамгааллын тогтолцооны зураглал”, Судалгааны тайлан, Уб., 2021 он;
4. Улсын дээд шүүхийн 2023 оны ажлын тайлан, Уб, 2024 он;
5. Улсын дээд шүүхийн 2022 оны ажлын тайлан, Уб, 2023 он;
6. Улсын дээд шүүхийн 2021 оны ажлын тайлан, Уб, 2022 он;
7. Улсын дээд шүүхийн 2020 оны ажлын тайлан, Уб, 2021 он;
8. Ц.Цогт, Шүүгчийн аюулгүй байдал, Шүүх эрх мэдэл-мэдээлэл арга зүйн улирал тутмын эмхэтгэл (2022 оны №1 тусгай дугаар), Уб, 2022 он;
9. Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын шүүхийн тайлан-2022, Уб, 2023 он;
10. Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын шүүхийн тайлан-2021, Уб, 2022 он;
11. Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын шүүхийн тайлан-2020, Уб, 2021 он.

Гурав. Цахим эх сурвалж

1. Ш.Шинэбаяр Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн ахлах мэргэжилтэн, Цагдаагийн ахмад, Гэрч хохирогчийг хамгаалах хэлтсийн үйл ажиллагааны тухай, Уб, 2019 он, Цагдаагийн ерөнхий газрын албан ёсны цахим хуудас, Холбоос: https://police.gov.mn/p/3791

Холбогдох субъектээс судалгаа авах хүрээнд:

Нэг. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар судалгаа, бусад мэдээлэл

1. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2018 онд УИХ-д өргөн мэдүүлсэн Хууль зүйн байнгын хорооны хуулийн төсөлтэй холбогдуулсан гүйцэтгэсэн Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд яамд, байгууллагаас ирүүлсэн санал;
2. Гэрч, хохирогчийг хамгаалалтын талаар ЦЕГ-ын нийтэлсэн үйл ажиллагааны тайлан, мэдээ.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд, Аргачлалын “Практикт хэрэгжиж буй байдал”, “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” болон “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн томьёоллын дагуу Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 13 дугаар зүйлийн 13.1, 21 дүгээр зүйлийн 21.5, 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтуудын хэрэгжилтийн үр дагаврыг үнэллээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан. Энэ хүрээнд Улсын Их Хурлаас 2013 оны 7 дугаар сарын 5-ны өдөр Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг баталсан ба тус хуулийн 25.1.1-д заасны дагуу “Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр” хэрэгжиж байна. Түүнчлэн, бодлогын баримт бичгүүдэд гэрч, хохирогчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох тухай тусгасан байдаг. Үүнд:

- Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.3.6-д “Гэрч, хохирогчийн аюулгүй байдал, нууцлалыг хамгаалах чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгож гэрч, хохирогчийн хамгаалалтын цогц механизмыг бүрдүүлнэ” гэж;
- Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.5-д “Гэмт хэргийн хохирогч болсон хүүхэд, хүүхдийн тэтгэмж тогтоох болон газар өмчлөх эрх нь хөндөгдсөн төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэж;
- Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.1.14-т “Гэрч, хохирогчийг хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах алба шинээр байгуулж, хохирогчийн эрхийг хангах, хохирол барагдуулах үйл ажиллагааг шинэ шатанд гаргана.” гэж тус тус заасан.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль нь 2013 онд батлагдсанаас хойш нийт 5 удаа нэмэлт, өөрчлөлт орсон ба тус хуультай холбогдох дараах эрх зүйн актууд байна.

Хүчин төгөлдөр үйлчилж буй журам:

1. Хууль зүйн сайдын 2014 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/110 дугаар тушаалын хавсралт "Гадаад төрхийг өөрчлөх аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам";
2. Хууль зүйн сайдын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/111 дүгээр тушаалын хавсралт "Гэрч, хохирогчийн баримт бичгийг солих журам";
3. Хууль зүйн сайдын 2014 оны А/112 дугаар тушаалын хавсралт "Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам";
4. Хууль зүйн сайдын 2014 оны А/113 дугаар тушаалын хавсралт "Гэрч, хохирогчийг тусгай техник хэрэгслийн жагсаалт, хэрэгслээр хангах, хэрэглэх журам";

5. Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайдын хамтарсан 2014 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/356, А/182 дугаар тушаалын хавсралт "Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам";
6. Хууль зүйн сайдын 2016 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн МН/101 дүгээр тушаалын хавсралт "Нүүлгэн шилжүүлэх журам";
7. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн А/107 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт "Цагдан хоригдож байгаа болон хорих ял эдэлж байгаа гэрч, хохирогчийг хамгаалах журам";
8. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/73 дугаар тушаалын хавсралт "Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам";

Гэрээ:

1. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 04 дугаар сарын 08 -ны өдрийн А/77 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт "Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангахад хамтран ажиллах гэрээ";
2. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 04 дугаар сарын 08 -ны өдрийн А/77 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт "Гэрч, хохирогчийг нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник, хэрэгслээр хангах хамгаалалтын арга хэмжээний гэрээ";
3. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 04 дугаар сарын 08 -ны өдрийн А/77 тушаалын гуравдугаар хавсралт Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 04 дугаар сарын 08 -ны өдрийн А/77 дугаар тушаалын тавдугаар хавсралт "Биечилсэн хамгаалалтын арга хэмжээний гэрээ";
4. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 04 дугаар сарын 08 -ны өдрийн А/77 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт "Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах хамгаалалтад авах гэрээ";
5. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 04 дугаар сарын 08 -ны өдрийн А/77 дугаар тушаалын тавдугаар хавсралт "Биечилсэн хамгаалалтын арга хэмжээний гэрээ";
6. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/107 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт "Хамгаалалтын арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх байгууллагатай ажиллах гэрээ";
7. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/107 дугаар тушаалын гуравдугаар хавсралт "Гэрч, хохирогч хамгаалалтын арга хэмжээнд хамтран ажиллах гэрээ";
8. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/107 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт "Насанд хүрээгүй гэрч, хохирогч хамгаалалтын арга хэмжээнд хамтран ажиллах гэрээ";

Манай улсад гэрч хохирогчийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр боловсруулж, баталсан нэлээдгүй эрх зүйн баримт бичгүүд хүчин төгөлдөр үйлчилж байх боловч эдгээр журмуудын хүрээнд гэрч, хохирогч хамгаалллын үйлчилгээ үр дүнтэй хэрэгжиж буй эсэх дээр хэрэгжилтийн үр дүнг дүгнэсэн судалгааны тайлан, мэдээлэл байхгүй байна.

Өөрөөр хэлбэл, тус журмуудын харилцан уялдааг шалгаж, журмаар зохицуулсан харилцаа нь Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нийцэж буй эсэх, мөн хуулиар хориглоогүй зүйлийг хориглосон эсэх гээд журмуудад хяналт-шинжилгээ хийсэн, хэрэгжилтийг үнэлсэн судалгаа байхгүй байгаа нь гэрч, хохирогчийг хамгаалах харилцааг зохицуулсан эрх зүйн баримт бичгүүдийн тоог олшруулах хандлагатай байна. Иймд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуультай холбогдон гарсан 8 журмын хэрэгжилтэд үнэлгээ хийж, хуулиар зохицуулах болон журмаар зохицуулах харилцаанд шалгуур тавих шаардлагатай байна.

3.1. Зорилгод хүрсэн түвшин

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн зохицуулалтууд нь зорилгодоо нийцэж байгаа эсэх?

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт
4.1.1.”гэрч, хохирогч” гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогчийг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан гэрчийг;

Практикт гэрч, хохирогчийг сүрдүүлэх, дарамтлах, хуурч мэхлэх, мөнгө өгөх, гуйх, ятгах, заналхийлэх зэрэг хэлбэрээр тэдэнд нөлөөлөх явдал гарсаар байгаа бөгөөд үүний улмаас гэрч, хохирогч мэдүүлэг өгөхгүй байх, эсхүл худал мэдүүлэг өгөх, сэтгэл зүйн хувьд хэвийн байдлаа алдах, амиа хорлох, амиа хорлох оролдлого хийх зэрэг үйлдэл гарч байгааг судлаачид тэмдэглэсэн байдаг.[2] Мөн олон улсын хэмжээнд дөрвөн гэрч тутмын нэг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өөрийн мэдүүлгээс буцдаг тул хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бэрхшээл учирч, бодит үр дүнд сөргөөр нөлөөлдөг гэж үздэг.[3]

Иймд гэмт хэргийг илрүүлэх, нотлох, хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангахад гол үүрэг гүйцэтгэдэг гэрч, хохирогчийг хамгаалах, тэдний аюулгүй байдлыг хангах нь Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн гол зорилго юм. Тус хуулийн хамгааллын үйлчлэх хүрээ нь гэрч болон хохирогчийг хуулийн нэр томьёонд хэрхэн тодорхойлсноор хязгаарлагдах үндэслэлтэй байх тул хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх суурь нөхцөл болж байна. Хүснэгт 4.3-т хохирогчийг тодорхойлсон хуулийн зохицуулалтуудыг харьцуулах замаар дүн шинжилгээ хийв.

Хүснэгт 4.3. *Хохирогчийг тодорхойлсон тодорхойлолтууд*

Д/д	Хууль	Хуулийн тодорхойлолт
1	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль (2013)	4.1.1. “гэрч, хохирогч” гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогчийг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан гэрчийг;
2	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017)	8.1.1. Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ.

2 Засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр.

3 Нээлттэй нийгэм Форум, Гэрч, хохирогчийн хамгаалалт, Бодлогын судалгааны тайлан, (Уб, 2019), 6 дахь тал.

3	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012)	3.1.2. “хохирогч” гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн хүнийг;
4	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2017)	5.1.2. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч гэж гэр бүлийн хүчирхийллийн улмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон хүнийг хэлнэ.
5	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль (2017)	3.2. “Хохирогч” гэж зөрчлийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн хүн, хуулийн этгээдийг хэлнэ.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд хохирогчийг “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан...хохирогчийг” гэж тодорхойлжээ. Процессын хувьд гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, туслалцаа үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд эрх бүхий албан тушаалтны шийдвэрийн дагуу “эрүүгийн хэрэг” үүссэн байхыг шаарддаг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд мөрдөгчийн санал, гэрч, хохирогч, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэн прокурор, шүүхийн шатанд прокурорын санал, гэрч, хохирогч, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэн шүүгч Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэглэх шийдвэр гаргана.[4]

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд хохирогчийг өргөн хүрээнд тодорхойлсон байх бөгөөд хохирогч нь заавал хохирогчоор тогтоогдсон эсэхээс үл шалтгаалан үйлчилгээ үзүүлэгч байгууллагад шууд хандан хохирогчоор бүртгэгдэж болохоор заасан нь хохирогчдод ээлтэй зохицуулалт болжээ. Гэтэл Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн үйлчлэлд зөвхөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хохирогчоор тогтоогдсон (шүүх, прокурор, мөрдөн байцаагчийн шийдвэрт үндэслэн) хүн хамаарагдахаар заасан байна. Энэ нь хохирогч хууль хяналтын байгууллагад хандаагүй тохиолдолд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгааллын үйлчилгээг авах боломжгүйг харуулж байна.[5]

Энэ нь хохирогчийг тодорхойлсон хуулийн заалт хооронд агуулгын зөрүү буюу хийдэл байгааг харуулах ба түүний нөлөөгөөр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон олон хүн хуулийн дагуу шаардлагатай хамгааллын туслалцаа авч чадахгүйд хүрдэг тухай үйлчилгээ үзүүлэгч Төрийн бус байгууллагуудын төлөөллүүд ярилцлагадаа дурдаж байлаа. Тухайлбал, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хүрээнд хамгаалалтын арга хэмжээг авахын тулд зайлшгүй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогчоор тогтоогдсон байхаар заасан нь хохирогч хуулийн байгууллагад хандаж тусламж, дэмжлэг авч чадахгүйд хүргэдэг байна.[6]

Дүгнэвэл, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиар хохирогч нь заавал хохирогчоор тогтоогдсон эсэхээс үл шалтгаалан үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хандан хохирогчоор бүртгэгдэж, хамгаалалтын арга хэмжээ авах эрх нь шууд нээгдэх

4 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017), 13.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

5 Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгаа, (Уб, 2022), IRIM судалгааны хүрээлэн, Холбоос: https://mongolia.iom.int/sites/g/files/tmzbdl1611/files/documents/mongol-uls-dakh-khun-khudaldaalakh-gemt-khergiyn-suur-sudalgaa.pdf.

6 Мөн тэнд.

боломжгүй байна. Тус хуулийн үйлчлэлд зөвхөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хохирогчоор тогтоогдсон (шүүх, прокурор, мөрдөн байцаагчийн шийдвэрт үндэслэн) хүн хамаарахаар заасан байна. Иймд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиар "хохирогч"-ийг тодорхойлсон тодорхойлолтод "эрүүгийн хэрэг" үүсгэж хохирогчоор тогтоосон байх шаардлага тавьсан нь хохирогчийн эрхийг бүрэн хамгаалах нөхцөлд хүрч чадахгүй байдал үүсгэж байна.

13 дугаар зүйл.Аюулгүй газарт түр байрлуулах

13.1.Шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан насанд хүрсэн гэрч, хохирогчийг өөрийнх нь зөвшөөрснөөр, насанд хүрээгүй гэрч, хохирогчийг түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын зөвшөөрснөөр аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулна. 13.2.Насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах асуудлыг нарийвчлан зохицуулсан стандартыг холбогдох байгууллагаар батлуулан мөрдөж ажиллана.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Насанд хүрсэн гэрч, хохирогчийг өөрийнх нь зөвшөөрснөөр, насанд хүрээгүй гэрч, хохирогчийг түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын зөвшөөрснөөр аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулна." гэж, мөн зүйлийн 13.2-т "Насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах асуудлыг нарийвчлан зохицуулсан стандартыг холбогдох байгууллагаар батлуулан мөрдөж ажиллана" гэж тус тус заажээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/73 дугаар тушаалын хавсралтаар "Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам"-ыг баталсан. Тус журмын 2.2 дугаар хэсэгт "Хамгаалах болон тусгай хамгаалах байр нь MNS 6040:2009 Монгол Улсын стандартын шаардлагыг хангасан байх бөгөөд үйл ажиллагааны дотоод журамтай байна." гэж заасан байна. Тодруулбал, дээрх журмаар насанд хүрсэн иргэний тусгай хамгаалах байр нь MNS 6040:2009 Монгол Улсын стандартын шаардлагыг хангасан байх шаардлагатай байна.

Үүнээс харвал насанд хүрсэн гэрч, хохирогчийн "стандартын шаардлага хангасан тусгай хамгаалах байранд байх" эрхийг журмаар хамгаалсан бол насанд хүрээгүй гэрч, хохирогчийн "стандартын шаардлага хангасан тусгай хамгаалах байранд байх" эрхийг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиар хамгаалсан ялгавартай зохицуулалт болсон байна.

Иймд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлд насанд хүрсэн гэрч, хохирогчийн "стандартын шаардлагыг хангасан тусгай хамгаалах байранд байх" эрхийг хамгаалсан зохицуулалт оруулах шаардлагатай байна.

21 дүгээр зүйл.Хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам

21.5.Энэ хуулийн 7.1.3-7.1.9-д заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Энэ хуулийн 10.2-т заасан бүсэд биечилсэн хамгаалалтыг хэрэгжүүлэх журмыг батлахдаа холбогдох байгууллагын саналыг харгалзана.

Улсын хэмжээнд одоогоор ХЗДХЯ-нд бүртгэлтэй нийт 880 хууль, 2765 захиргааны хэм хэмжээний акт үйлчилж байна. Энэ нь хууль болон журмаар зохицуулах харилцааны заагийг тодорхойлж өгөөгүйтэй холбоотой гэж үзэж байна. Хуулиар зохицуулбал зохих харилцааг журмаар зохицуулснаар хүний эрхэд халдах, хүний эрхийг хязгаарлах, эрх мэдлийн төвлөрөл бий болгох ноцтой үр дагаварт хүргэдэг.

Монгол Улсын Их Хурлын 2024-2028 онд баримтлах стратеги төлөвлөгөөний төслийг танилцуулах Парламент 2.0 “Гурван төгөлдөршил” хэлэлцүүлэгт дурдагдсан эрх зүйн орчныг сайжруулах нэг гол тодорхойлолт нь “Иж бүрэн зохицуулалттай, ойлгомжтой хууль” батлах явдал юм. Хуулийг иж бүрэн зохицуулалттай, тодорхой, ойлгомжтой болгож, хууль болон журмаар зохицуулах харилцааны заагийг тодорхойлсноор дараах эерэг үр дагавар гарна[7] гэж үзжээ. Үүнд:

- Харилцааны нэг тал болох байгууллага журам баталж байгааг багасгаснаар хүний эрхийг зөрчих эрсдэлийг бууруулна;
- Хууль болон журмын зохист харилцааг хангаж, иж бүрэн, ойлгомжтой байх эрх зүйн үндсийг бий болгоно;
- Үндэслэл, судалгаа, нотолгоо, хууль хэрэглээний практикт суурилсан хууль тогтоох ажиллагааг хөгжүүлнэ.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 21.5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Хууль зүйн сайд 2014 оны 07 дугаар сарын 04-ний өдөр А/112 дугаартай тушаалаар “Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам”-ыг баталсан. Тус журам нь 3 зүйл, 12 хэсгээс бүрдсэн байх бөгөөд агуулгын хувьд өргөн цар хүрээтэй биш байна. Түүнчлэн тус журам нь Монгол Улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт заасан “...хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэсэн иргэний үндсэн эрх, эрх чөлөөтэй холбоотой зохицуулалттай байна. Иймд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7.1.3-7.1.9-д заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх харилцааг журмаар бус хуулиар зохицуулах нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17 дахь хэсэг болон Монгол Улсын Их Хурлын 2024-2028 онд баримтлах стратеги төлөвлөгөөнд нийцнэ гэж үзлээ.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль (2015)-ийн 21.5 дугаар зүйлд “Гэрч, хохирогч, шинжээч, орчуулагч, хэлмэрчид хууль бусаар нөлөөлөх” гэмт хэргийг зүйлчилсэн байдаг. Тус гэмт хэрэг нь гэрч, хохирогчийг зориуд худал мэдүүлэг өгүүлэх ... зорилгоор өөрт нь, ойр дотнын хүнд нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл ашиг сонирхолд нь ноцтой хохирол, хор уршиг учруулахаар сүрдүүлсэн, эсхүл ятгасан, шан харамж амласан, өгсөн байхыг[8] ойлгоно. Гэрч, хохирогчийн хамгаалалт үр дүнтэй хэрэгжиж буй эсэхийг хэмжих нэг шалгуур үзүүлэлт нь тус гэмт хэргийн гаралтын тоо байж болох тул График 4.1-д Эрүүгийн хуулийн 21.5 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн статистик мэдээг авч үзэв.

7 Д.Амарбаясгалан, Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Их Хурлын 2024-2028 онд баримтлах стратеги төлөвлөгөөний төслийг танилцуулах Парламент 2.0 “Гурван төгөлдөршил” хэлэлцүүлэг, (2024.09.30).

8 Эрүүгийн хуулийн 21.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

График 4.1. *2017-2023 онд Эрүүгийн хуулийн 21.5 дугаар зүйлд заасан гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдал*



Тус графикаас дүгнэвэл, 2017-2023 оны хооронд “Гэрч, хохирогч, шинжээч, орчуулагч, хэлмэрчид хууль бусаар нөлөөлөх” гэмт хэрэгтэй холбоотой нийт 47 шүүхийн шийдвэр байгаагаас 29 хэрэг буюу 62 хувь нь хөдөө орон нутагт үйлдэгдсэн гэмт хэрэг байна. Иймд гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа буюу гэрч, хохирогчийг хууль бус нөлөөллөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх механизм хөдөө орон нутагт сул байна гэж дүгнэхээр байна.

3.2. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл, байдал хэрхэн өөрчлөгдсөн байна вэ?

23 дугаар зүйл.Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага, түүний үүрэг
23.1.Хамгаалалтын арга хэмжээг дараах байгууллагууд өөрийн эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ: 23.1.1.цагдаагийн алба; ~~23.1.2.мөрдөх алба;~~ /Энэ заалтыг 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./ ~~23.1.3.Тахарын алба;~~ /Энэ заалтыг 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./ 23.1.4.Авлигатай тэмцэх газар; 23.1.5.Тагнуулын ерөнхий газар. 23.2.Энэ хуулийн 23.1-д заасан байгууллагууд нь тухайн байгууллагын даргын дэргэд гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүрэг бүхий хамгаалалтын тусгай албатай байна.

Хуулийн 23.1-д заасны дагуу гэрч, хохирогчийн хамгаалалтын арга хэмжээг Цагдаагийн алба, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар хэрэгжүүлж байна. 2014-2016 оны хооронд Тахарын алба нь шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, гэрч, хохирогчийг хамгаалах, яллагдагч, ялтныг хуяглан хүргэх, шүүгдэгч, оролцогчийг албадан ирүүлэх чиг үүрэг бүхий Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагаар ажиллаж байсан. Тахарын албаны тухай хууль 2016

оны 07 сарын 21-ний өдөр хүчингүй болсонтой холбоотойгоор, Цагдаагийн албаны тухай хуулийн дагуу гэрч, хохирогчийг хамгаалах тусгайлсан чиг үүрэг цагдаагийн байгууллагад оногдож, Цагдаагийн ерөнхий газрын бүтэц, зохион байгуулалтад Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс 2016 оны 08 сарын 11-ны өдөр орсон.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл, байдал хэрхэн өөрчлөгдсөнийг судлахын тулд гэрч, хохирогчийн хамгааллын арга хэмжээг голчлон хэрэгжүүлэгч байгууллага болох ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийв.

Цагдаагийн ерөнхий газраас гаргасан 2024 оны эхний 08 сарын байдлаар бүртгэгдсэн гэмт хэргийн статистик мэдээллээс авч үзвэл:[9]

График 4.2. *2024 оны эхний 08 сарын байдлаар бүртгэгдсэн гэмт хэргийн тоо*



	2023	2024
Нийт гэмт хэргийн тоо	25392	28219
Хөнгөн гэмт хэрэг	22555	24463
Хүнд гэмт хэрэг	2837	3756

2023 оны байдлаар нийт гэмт хэргийн тоо 25392 бол 2024 оны эхний 8 сарын байдлаар 28219 болж өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс хөнгөн гэмт хэргийн тоо 2023 онд 22555 бол 2024 онд 24463 болж өссөн байна. Харин хүнд гэмт хэргийн тоо 2023 оны байдлаар 2837 бол 2024 онд 3756 болсон буюу 11.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

9 Цагдаагийн ерөнхий газрын статистик мэдээлэл, https://police.gov.mn/a/7266

График 4.3. *2024 оны эхний 08 сарын байдлаар гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоо*



Гэмт хэргийн улмаас хохирсон нийт иргэний тоо 2023 оны байдлаар 24808 бол 2024 оны 8 дугаар сарын байдлаар 26973 болж өссөн буюу гэмт хэргийн улмаас хохирсон иргэний тоо 2165-аар (8.7 хувиар) өссөн үзүүлэлттэй байна.

График 4.4. *Гэрч хохирогчийг хамгаалахад хэрэгжүүлсэн арга хэмжээ*



Цагдаагийн ерөнхий газрын гэрч, хохирогчийн хамгаалах хэлтэс нь 2023 оны I улиралд улсын хэмжээнд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу нийт 77 хамгаалалтын арга хэмжээгээр 77 хүний аюулгүй байдлыг хангаж ажилласан байна.[10]

10 Цагдаагийн ерөнхий газар, гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс, Холбоос: https://police.gov.mn/a/6482, Сүүлд үзсэн: 2024.10.01.

Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд урьдчилан сануулах, тодорхой үйлдлийг хязгаарлах, биечилсэн хамгаалалт, мэдээллийн нууцлалыг хангах, нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах, аюулгүй газарт түр байрлуулах, нүүлгэн шилжүүлэх, баримт бичгийг солих, гадаад төрхийг өөрчлөх зэрэг есөн хамгаалалтын аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ авахаар тусгасан. Үүнээс Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс нь 2023 оны I улиралд улсын хэмжээнд урьдчилан сануулах арга хэмжээг түлхүү хэрэгжүүлсэн нь харагдаж байна.

График 4.5. *Гэрч хохирогчийг хамгаалалтад авсан хүний тоо*

Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн холбогдох мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагад дурдсанаар дийлэнх тохиолдолд гэрч, хохирогчид урьдчилан сануулах арга, биечилсэн хамгаалалтад авах болон аюулгүй газарт түр байрлуулах арга хэмжээг авдаг ба тухайн хэргийн нөхцөл байдал, гэрч хохирогчийн хүсэлтээс хамааран аюулгүй байдлын арга хэмжээг дангаар болон хамтатган хэрэгжүүлдэг гэв. Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс нь 2016 оноос хойш нийт 997 хамгаалалтын арга хэрэгжүүлж 1014 иргэнийг хамгаалалтад авсан байна.[11]

Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх байгууллагууд нь гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, хүлээн зөвшөөрөгдсөн эсэхэд дүн шинжилгээ хийх зорилгоор 2014-2016 онд тус ажиллагааг бие даан хэрэгжүүлэгч байгууллага болох Тахарын алба болон одоо хэрэгжүүлэгч байгууллага болох ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн үйл ажиллагааг дараах шалгууруар харьцуулав.

11 Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн Эрүүгийн мөрдөгч, Цагдаагийн ахмад Ж.Бат-Эрдэнэтэй 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдөр хийсэн ярилцлагын хэсгээс.

Хүснэгт 4.4. *ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс болон Тахарын албаны бие даасан байдал*[12]

№	Бие даасан байдлын нөхцөл	Тахарын алба	ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс
1	Чиг үүрэг	Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах; Гэрч, хохирогчийг хамгаалах; Яллагдагч, ялтныг хуяглан хүргэх; Яллагдагч, гэрчийг албадан ирүүлэх; Ялтан шилжүүлэх; Оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах; Хуульд заасан бусад чиг үүрэг.	Гэрч, хохирогчийг хамгаалах;
2	Гэрч, хохирогчийг хамгаалах	Тахарын алба нь гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрч, хохирогчийг хамгаалах, тэдэнд туслалцаа үзүүлэх ажлыг Тахарын албаны тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан журмын дагуу хэрэгжүүлнэ. Тахарын алба хорих ял эдэлж байгаа гэрч, хохирогчийг хамгаалалтад авах ажиллагааг зохион байгуулна. Тахарын албаны хамгаалалтад гэмт хэрэгтэй тэмцэх бусад байгууллага өөрийн мөрдөн шалгаж байгаа гэмт хэргийн гэрч, хохирогчийг шилжүүлэн өгч болно.	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль, журмын дагуу хэрэгжүүлнэ.
3	Бүтэц, зохион байгуулалт	Тойргийн тахарын албаны зохион байгуулалтын бүтцийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хариуцсан нэгжтэй байна.	Цагдаагийн төв байгууллагын орон тооны дээд хязгаар, зохион байгуулалтын бүтцийг Засгийн газар тогтооно. Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хариуцсан нэгжтэй байна.
4	Үйл ажиллагааны төсөв	Тахарын алба улсын төсвөөс санхүүжих бөгөөд төсөв нь түүний хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг хангасан байна.	Цагдаагийн байгууллагын төсвийг улсын төсөвт тусгаж санхүүжүүлэх бөгөөд энэхүү төсөв нь цагдаагийн байгууллага үйл ажиллагаагаа шуурхай, тасралтгүй, үр дүнтэй явуулах шаардлагыг хангасан байна.
5	Алба хаагчийн баталгаа	Тахарын албаны алба хаагчийн эрх, үүрэг, баталгаа болон хориглох зүйлийг Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулна.	Иргэн, албан тушаалтан хэн боловч цагдаагийн алба хаагчийн хууль ёсны үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, хуулиар хүлээсэн үүрэгт нь үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгэхийг шаардахыг хориглоно. Цагдаагийн алба хаагч болон түүний хамаарал бүхий этгээдийн амь нас, аюулгүй байдлыг цагдаагийн байгууллага хамгаална.

12 Нээлттэй нийгэм форум, “Гэрч,хохирогчийн хамгаалалт”, Бодлогын судалгааны тайлан, (Уб 2019), 39 дэх тал.

6	Үйл ажиллагааны хяналт	Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу хяналт тавина. Шүүх, прокурорын байгууллага нь холбогдох хуульд заасан үндэслэл журмын дагуу хяналт тавина.	Дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, гүйцэтгэх ажлаас бусад асуудлаар Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу хяналт тавина.

Дээрхээс дүгнэвэл, Цагдаагийн ерөнхий газрын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс нь Тахарын албатай харьцуулахад үйл ажиллагааны чиг үүргийн хүрээнд хязгаарлагдмал шинжтэй болсон буюу зөвхөн гэрч, хохирогчийг хамгаалах үүрэгтэй болсон байна. Өөрөөр хэлбэл, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, яллагдагч, ялтныг хуяглан хүргэх, яллагдагч, гэрчийг албадан ирүүлэх, ялтан шилжүүлэх, оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах зэрэг чиг үүрэггүй байна. Түүнчлэн бүтэц, зохион байгуулалтын хувьд Тахарын алба нь гэрч, хохирогчийг хамгаалах үндсэн чиг үүрэгт суурилан үүсгэн байгуулагдсан байгууллага бол одоогийн Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс нь Цагдаагийн ерөнхий газрын бүтцэд хамаарах нэгж байна.

Тахарын алба (2014-2016 онд) болон Цагдаагийн ерөнхий газрын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсээс (2016-2018 онд) нийт 262 гэрч, хохирогч, иргэнийг (хамаарал бүхий этгээд, гэмт хэрэг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл, баримт сэлт өгөх болон бусад байдлаар туслалцаа үзүүлсэн хүн, шүүгч, прокурор) хамгаалалтад авч, нийт 179 аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлжээ.[13]

Одоогийн Цагдаагийн ерөнхий газрын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсээс гэрч, хохирогчийг хамгаалахад дараах хүндрэл гарч буйг холбогдох албаны хүмүүс онцолсон байна. Үүнд:

- Үүрэг гүйцэтгэх техник хэрэгсэл, автомашин, ажлын байр, хүний нөөцийн асуудлууд шаардлага хангах хэмжээнд хүрсэн хэдий ч, хэрэгцээ шаардлага өсөн нэмэгдэхээр байна;
- Гадаад улсаас хохирогч иргэнийг авчрах болон гадаадын иргэн, хүлээн авч, аюулгүй байдлын арга хэмжээг эрсдэлгүй зохион байгуулахад алба хаагчид мэргэших шаардлагатай байна;
- Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах эрх бүхий байгууллагуудын ажлын уялдаа холбоо сайнгүй, төрийн болон төрийн бус байгууллагуудын үүрэг, оролцоо бага;
- Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах ажиллагааны нэгдсэн мэдээллийн сан байхгүй[14] гэв.

13 Мөн тэнд, 40 дэх тал.
14 Мөн тэнд, 11 дэх тал.

Тахарын албыг буцааж сэргээх хэрэгцээ, шаардлагын талаар хууль зүйн салбарын зарим судлаачдын дэвшүүлсэн үндэслэлийг оруулав.

Тахарын алба гэрч, хохирогчийг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, яллагдагч, ялтныг хуяглан хүргэх, хуяглан харгалзах, оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах үндсэн чиг үүрэгтэй, үүгээрээ шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэхийг зорьдог. Эдгээр чиг үүрэг урд нь хангалттай хэрэгждэггүй байсан учраас Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Тахарын албаны тухай хууль зэргийг батлах, илүү үр нөлөөтэй шинэ бүтэц бий болгох шаардлагатай байсан. Тахарын алба байгуулагдахаас өмнө гэрч, хохирогч, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг бүрэн хамгаалах цогц тогтолцоо хангалттай бүрэлдээгүй байсан. Гэрч, хохирогчийг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах зэрэг тусгай чиг үүргийг цагдаагийн эсхүл өөр бусад байгууллагад хавсруулснаас бие даасан, алба, бүрэлдэхүүнд хариуцуулах нь илүү дээр гэж үздэг. Үүнийг таван үндэслэлээр хэлье.

- *Нэгд, гэрч, хохирогч, шүүгчийн аюулгүй байдлыг хангах тусгайлсан алба байснаар зөвхөн энэ зорилгын төлөө ажилладаг, мэргэшсэн албан хаагчидтай болж байна. Эдгээр чиг үүргийг дагнасан байгууллага хариуцах, мэргэшсэн албан хаагчдаар гүйцэтгүүлэх нь өөр байгууллагын харьяа болгож хавсарга ажил болгохоос хавьгүй үр дүнтэй. Тахарын алба, тахар ажилласнаар шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, гэрч, хохирогчийг хамгаалах соёл, боловсрол, хандлага, тогтолцоо хөгжиж байна.*
- *Хоёрт, эрх мэдэл хуваарилах зарчим бие даасан Тахарын алба байхыг дэмждэг. Ганцхан хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг биш ерөнхийдөө төрийн ялгаатай чиг үүргүүдийг өөр өөр субъектүүд дээр хэрэгжүүлэх юм бол тэр нь илүү үр дүнтэй гэсэн зарчим олон ардчилсан улсад хэрэгждэг. Хэрэв бүх эрх мэдлийг нэг газар төвлөрүүлчихвэл тэр эрх мэдлийг урвуулан ашиглах, нийтийн ашиг сонирхол зөрчигдөхөд хүрдэг. Цагдаагийн байгууллага бол нийгмийн аюулгүй байдал хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх зэрэг үндсэн чиг үүргэтэй. Гэтэл энэ нь дээр нэмээд Тахарын албаны чиг үүргийг нэмээд өгөхөөр тэнд эрх мэдлийн төвлөрөл бий болдог. Үүнээс сэргийлж тухайлсан Тахарын алба байгуулсан болов уу гэж бодож байна.*
- *Гуравт, цагдаагийн байгууллагад шилжүүлэх юм бол үр нөлөө буурна гэж ойлгож болно. Яагаад гэвэл цагдаагийн албан хаагчдын тоо Монголын хүн амын тоотой харьцуулахад тийм хүрэлцээтэй биш гэдэг. Хууль зүйн сайд асан Х.Тэмүүжин үүний талаар хэлэхдээ: «Цагдаагийн байгууллага байх ёстой орон тоогоосоо 1250 албан хаагчаар дутуу байгаа. Төсөв байхгүй учраас орон тоогоо гүйцээж чадахгүй байгаа шүү дээ. Ийм байхад яаж цагдаагийн байгууллага гэрч хохирогчийг хамгаалах юм бэ. Ийм байхад өөр ажил нэмж өгвөл цалгардах магадлалтай.*
- *Дөрөвт, тахарын чиг үүрэг Цагдаагийн байгууллагад шилжсэнээр эргээд Цагдаагийн албан хаагчид ч юм уу, эрх мэдэлтэй хүмүүсийн хэрэг шүүхээр шийдвэрлэгдлээ гэхэд заримдаа ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэл бий. Ганц жишээ авахад дээр дурдсан цагдаагийн хурандаа нарын хэргийг 2012 оны 3-р сард шүүх шийдвэрлэж байсан юм. Тухайн хэргийг шүүсэн шүүгчийг гарч явж байхад нь шүүхийн үүдэн дээр хүмүүс хэл амаар доромжилж, хоёр залуу биед нь халдсан. Цагдаагийн дарга нарын асуудлыг шийдэж байсан учраас тэнд байсан цагдаа нар тухайн шүүгчийг хамгаалахаас татгалзсан гэсэн мэдээ тухайн үед хэвлэлээр цацагдаж байсан.*
- *Тавд, Тахарын алба байгуулагдаад 3 жил ч хүрээгүй байна. Шинэ хууль, шинэ тогтолцоо, шинэ бүтцийг бий болгочхоод ийм богино хугацааны дараа тогтолцоогоор нь өөрчлөх нь хууль дээдлэх ёсонд харш юм. Хуулийн институт тогтвортой үйлчилж байж үр дүн нь гардаг. Тахарын алба тогтвортой ажиллаж байж гэрч, хохирогч хамгаалагдаж, шүүхийн аюулгүй байдал хангагдана.*[15]

Хууль зүйн ухааны доктор, дэд профессор О.Мөнхсайханы ярилцлагын хэсгээс...

15 “Тахарыг үлдээх таван үндэслэл”, Холбоос: https://news.mn/r/742689/, Сүүлд үзсэн огноо: 2024.10.03.

3.3.*Практикт хэрэгжих байдал*

Тахарын алба нь шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, гэрч, хохирогчийг хамгаалах, шүүгдэгч, ялтныг хуяглан хүргэх, сураггүй алга болсон шүүгдэгч, гэрчийг албадан ирүүлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэхээр 2014 онд байгуулсан боловч 2016 онд татан буулгасан юм. Тухайн үед шинээр бүрэлдсэн Засгийн газрын мэдээлснээр төсөв, санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдлыг улмаас энэхүү шийдвэрийг гаргах болсон гэж тайлбарлаж байв. Өнөөдрийн байдлаар өмнөх Тахарын албатай харьцуулахад шүүхийн барилгад цөөн тооны цагдаагийн албан хаагчид ажиллаж байгаа бөгөөд эдгээр албан хаагчийн гарт шүүхийн аюулгүй байдлыг хангах ажил ногдож байна. Цагдаагийн албан хаагчдын хувьд Тахарын албатай харьцуулахад хамгаалалтын арга хэрэгсэл, арга механизм харьцангуй цөөн байгааг дурдах нь зүйтэй.[16]

Манай улсын хувьд шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг 2013 оны “Тахарын албаны тухай” хуулийн гуравдугаар бүлгийн 9 зүйл, 34 заалт[17], болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын А/96, 90 дүгээр хамтарсан тушаалын хавсралтаар батлагдсан “Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журам”-аар зохицуулж байв.[18] Гэвч “Тахарын албаны тухай” хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар, болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын А/96, 90 дүгээр хамтарсан тушаалын хавсралтаар батлагдсан “Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журам”-ыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын хамтарсан 2021 оны А/116/65 дугаар тушаалаар тус тус хүчингүй болгожээ.

Тахарын албаны хувьд шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр илүү зохион байгуулагдсан, түүнд тусгайлсан чиг үүргийг хариуцуулснаараа цагдаагийн албанаас онцлогтой. Зарим албаныхан болон хүмүүсийн хэлдгээр цагдаагийн байгууллагаас шүүх, шүүхийн аюулгүй байдлыг хангаж, хамгаалах чиглэлээр чадавх хангалттай биш байна гэж үздэг. Энэ шүүмжлэл 2008 оны 07 сарын 01-ний өдрийн үймээн самууны дараах шүүх хуралдааны харуул, хамгаалалттай шууд холбоотой.[19]

2017 оны 1 дүгээр сард болон эрүүгийн шүүх хуралдааны явцад шүүгдэгч өөрийнхөө хоолойг хэрчсэн (хумсаараа хоолойгоо хэрчсэн байх магадлалтай) тохиолдол гарсан. Энэ шүүгдэгч эмнэлэгт хэвтэж, эмнэлгийн тусламж авч чадсан. Гэвч шүүхийн захиргааны байгууллагын зүгээс аюулгүй байдал алдагдсан энэ нөхцөл байдал нь Тахарын албыг татан буулгасантай холбоотой. Учир нь цагдаагийн байгууллагад шилжсэн шүүх, шүүхийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг хүний нөөцийн хязгаарлагдмал байдлаас болж ийм нөхцөл байдалд хүрсэн гэж үздэг. 1 шүүхийн байранд 4-5 цагдаагийн албан хаагч байх шаардлагатай бол зарим шүүхэд хамгаалалт огт байхгүй байна. 2014-2015 онд шүүн таслах ажиллагааны эсрэг үйлдэгдсэн 5 эрүүгийн гэмт хэрэг шүүхээр хянан шийдвэрлэсэн. Ердөө 9 сарын хугацаанд Тахарын алба хаагчид нийт 64 шүүгч, прокурор, гэрч хохирогчид аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.[20]

16 Ц.Цогт, Шүүхийн аюулгүй байдал, Шүүх эрх мэдэл-мэдээлэл арга зүйн улирал тутмын эмхэтгэл (2022 оны №1 тусгай дугаар), (Уб, 2022), 2 дахь тал, https://legaldata.mn/buteel/pdf?id=1243

17 Тахарын албаны тухай хууль, (2013), https://legalinfo.mn/mn/detail/9286

18 Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журам, https://legalinfo.mn/mn/detail?lawId=207418

19 General Council of Courts, 2017 Annual Report at 63.

20 Ц.Цогт, Шүүхийн аюулгүй байдал, Шүүх эрх мэдэл-мэдээлэл арга зүйн улирал тутмын эмхэтгэл (2022 оны №1 тусгай дугаар), (Уб, 2022), 3 дахь тал, https://legaldata.mn/buteel/pdf?id=1243

АНУ-ын Маршалын алба

АНУ-д шүүх, шүүгчийг хамгаалах, шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангах үүргийг Маршалын алба /U.S Marshal Service/-ны Шүүхийн аюулгүй байдлын хэлтэс /Judicial Security Division/ гүйцэтгэдэг. Тус нэгж нь шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангах, холбооны шүүгч, тангарагтны шүүгчдийг хамгаалах, шүүгч, шүүх эрх мэдэлд учирч болзошгүй аюул заналхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. АНУ-ын 94 дүүрэг, 12 тойрог дахь холбооны шүүх, 2700 гаруй шүүгч, албан тушаалтнуудыг хамгаалах ажлыг өдөр тутамд гүйцэтгэдэг байна.

Маршалын албаны шүүхийн аюулгүй байдлыг хариуцсан нэгж нь шүүх танхимд аюулгүй байдлыг хангахаас гадна шүүхээс гаднах орчинд шүүгчийн болон түүний гэр бүлийн аюулгүй байдлыг урьдчилан сэргийлэх болзошгүй эрсдэлээс хамгаалах, яаралтай тохиолдолд таслан зогсоох арга хэмжээ авах эрхтэй байна. Тухайлбал 2022 онд гэхэд аюул заналхийлэл учирч болзошгүй 1362 хэрэгт мөрдөх, судлах ажлыг гүйцэтгэсэн байна. (Жилийн дундаж 1300)[21] Шүүхийн тойргуудад урьдчилан сэргийлэх талаар мэдлэг, заавар өгөх, дэмжлэг үзүүлэх, эрсдэл үүссэн, анхаарал татахуйц процессуудыг хянах, эрсдэлийн үнэлгээ хийж, зохих арга хэмжээг хэрэгжүүлэх зэрэг үүргийг хүлээсэн Маршалын албаны Хамгаалах ажиллагааны газар/ The Office of Protective Operations/[22] гэсэн нэгж нь мөн уг асуудлыг хамтран хариуцдаг байна. Монгол Улсад 2008 онд болсон үймээн самуунтай холбоотойгоор олны эсэргүүцэл дор өндөр албан тушаалтнуудын шүүх хурлыг зохион байгуулсан туршлага, цагдаагийн албанд шүүх, шүүгч, гэрч, хохирогчийг хамгаалах үүрэг оногдож байгаа асуудалд шинэчлэл хийх зорилгоор Тахарын албыг 2014-2016 онд байгуулан ажиллуулж байв.

Энэ байдал 2014 онд АНУ-ын Маршалын албатай төстэй чиг үүрэг бүхий Тахарын алба байгуулагдсанаар өөрчлөгдсөн"[23] гэж үзсэн байна. Монгол Улсад 2014-2016 онд үйл ажиллагаа явуулж байсан Тахарын алба нь хамаарах чиг үүрэг, гэрч хохирогчийг хамгаалах болон шүүгчийн аюулгүй байдлыг хангах зэрэг ерөнхий ойлголтоороо АНУ-ын Маршалын албатай төстэй гэж үзэх дотоодын судлаачдын байр суурь байна.

Маршалын алба нь АНУ-ын Хууль зүйн яамны харьяаны агентлагийн статустайгаар үйл ажиллагаагаа явуулдаг нэг төрлийн хууль сахиулах байгууллага юм. Тус албаны хариуцах чиглэлд шүүгч, шүүхийн аюулгүй байдал, мөрдөн шалгах ажиллагаа, тактикийн ажиллагаа, хөрөнгө хураах, сэжигтэн ялтныг хуяглан хамгаалах, гэрчийг хамгаалах ажиллагаа зэрэг асуудлуудыг хамаардаг байна. Хэдийгээр Монгол Улсад шүүгчийн эсрэг үйлдэгдэж байгаа ихэнх халдлага нь шүүхийн барилга дотор, түүний ойр орчимд, шүүхийн барилга руу нэвтрэх, гарах үед үйлдэгдэх шинжтэй[24] байдаг. Энэ нь шүүгч болон шүүх хурлын бусад оролцогчид нэг хаалгаар орж гарч буйтай холбоотой ба хэдийгээр олон улсын туршлага, шаардлагад нийцүүлэн өөр хаалгаар орох, гарах бололцоог нэмэгдүүлж байгаа боловч практик хэрэгжилтэд бүрэн хэрэгжихгүй байгааг шүүгч нар хэлж байна.

21 Judicial Security-U.S.Marshals Service website, холбоос: www.usmarshals.gov

22 Department of Justice, Audit of the U.S. Marshals Service Judicial Security Activities, 2021, 3 дахь тал. https://oig.justice.gov/sites/default/files/reports/21-083.pdf

23 Ц.Цогт, Шүүгчийн аюулгүй байдал, Шүүх эрх мэдэл-мэдээлэл арга зүйн улирал тутмын эмхэтгэл (2022 оны №1 тусгай дугаар), (Уб, 2022), 12 дахь тал.

24 Мөн тэнд, 8 дахь тал.

АНУ-д Маршалын албаны Шүүхийн аюулгүй байдлын хэлтэс нь шүүгчдийн хувийн орон сууцанд 1600 гаруй хамгаалалтын системийн хяналтыг ажиллуулж, 800 гаруй байгууламжийн биет хамгаалалтыг хангах, хамгаалалтын системийг боловсруулж, удирдан хэрэгжүүлдэг байна.[25]

Шүүгч Ц.Цогт Шүүхийн аюулгүй байдал өгүүлэлдээ “Тахарын албыг татан буулгасан нь шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр ухралт болсон”[26] гэж дүгнэлт хийсэн байна.

Иймд шүүгчийн аюулгүй байдалтай холбоотойгоор Тахарын алба нь дараах чиг үүргийг гүйцэтгэхэд хүний нөөцийн дутмаг байдлаас шалтгаалан хүндрэл бэрхшээл тулгарч болзошгүй.

1. Шүүгчийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь зөвхөн шүүх танхим, шүүхийн ойр орчимд цагдаагийн оролцоотойгоор хангагдах арга хэмжээг авч ажилладаг байна. Шүүгчийн аюулгүй байдлыг түүний орон байр, гадуурх орчинд хангах асуудал шийдэгдээгүй байна. Энэ нь шүүхээс бусад орчинд шүүгч халдлагад өртөх эрсдэлтэйг харуулж байна.
2. Шүүгчийн аюулгүй байдалд заналхийлж болзошгүй анхаарал татахуйц үйл ажиллагаа, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр мөрдөн шалгах ажиллагаа хэрхэн явуулж буй тухай мэдээлэл олдоогүй буюу энэ талын мэдээлэл нь албаны болон хувь хүний нууцтай холбоотойгоос шалтгаалж байна. Гэвч урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээг авч хэрэгжүүлэх байгууллагын хүний нөөц, мэргэшсэн байдал зэргийг үнэлэн тогтоох шаардлагатай.
3. Шүүгчийн гэр бүлийн гишүүдийг хамгаалах, эрсдэлээс сэргийлэх талаарх шүүхийн тухай хууль, “Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндэд аюул занал учрах нөхцөл үүссэн үед хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх журам”-аар зохицуулагдаж байгаа боловч энэ чиглэлийн арга хэмжээнд үнэлгээ хийх, хэрэгжилтийн үр дүнгийн дүгнэлт гаргах нь зүйтэй.

Шүүгч, шүүхийн аюулгүй байдлыг хангах өнөөгийн хууль, эрх зүйн орчин.

2024 онд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 2021 оны Шүүхийн тухай хуульд шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах тодорхой зохицуулалт орсон.[27] Гэвч энэ цөөн хэдэн заалтаар хязгаарлагдаж байна. Тодруулбал, Шүүхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8-д (1) шүүхийн үйл ажиллагааг хэвийн, (2) шүүхийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах, (3) шүүхийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, (4) аюулгүй байдлыг хангах, (5) судалгаа, мэдээллээр хангах гэсэн 5 үндсэн чиг үүрэг бүхий захиргааны байгууллага байх ба түүний эрх зүйн байдалтай холбогдсон харилцааг Шүүхийн тухай хуулиар зохицуулна гэжээ. Эдгээр чиг үүргээс зөвхөн шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн практик хэрэгжилтийг үнэлсэн болно. Шүүх, шүүгчийн аюулгүй байх чиг үүргийн Цагдаагийн ерөнхий газарт шүүхийн аюулгүй байдлыг хангах нэгж зохион байгуулдаг[28] бөгөөд мөн хуулийн 71 дүгээр зүйлийн

25 Judicial Security-U.S.Marshals Service website, холбоос: www.usmarshals.gov

26 Ц.Цогт, Шүүгчийн аюулгүй байдал, Шүүх эрх мэдэл-мэдээлэл арга зүйн улирал тутмын эмхэтгэл (2022 оны №1 тусгай дугаар), (Уб, 2022), 12 дахь тал.

27 Монгол Улсын Шүүхийн тухай хууль, (2021).

28 Ц.Цогт, Шүүхийн аюулгүй байдал, Шүүх эрх мэдэл-мэдээлэл арга зүйн улирал тутмын эмхэтгэл (2022 оны №1 тусгай дугаар), (Уб, 2022),2 дахь тал, https://legaldata.mn/buteel/pdf?id=1243

71.2-т "...шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан оролцогчийн аюулгүй байдлыг хангах үүргийг цагдаагийн байгууллага гүйцэтгэх журмыг Ерөнхий зөвлөлийн дарга, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална..." гэж эрх шилжүүлсэн.[29]

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А116/65 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралтаар "Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам"-ыг баталжээ.[30]

Энэхүү журмын нэгдүгээр бүлэгт "Нийтлэг үндэслэл", хоёрдугаар бүлэгт "Шүүх, шүүхийн барилга байгууламжийн аюулгүй байдлыг хамгаалах", гуравдугаар бүлэгт "Шүүх хуралдааны дэг сахиулах", дөрөвдүгээр бүлэгт "Шүүгч, шүүх бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангах"–ыг тус тус тусгажээ.[31] Гэвч Шүүхийн ерөнхий зөвлөл дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 12 дугаар 28-ны А/301/186 дугаар тушаалаар дөрөвдүгээр бүлэг болох "Шүүгч, шүүх бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангах" журмын 13 заалтыг хүчингүй болгосон. Мөн, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2023 оны 281, 151 дүгээр тушаалаар 4 дүгээр бүлгийг нэмсэн.[32]

Өөрөөр хэлбэл, 2021 оны 5 сард анх батлагдсан "Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам" болон одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа "Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам"-ын шүүгч, шүүх бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангах эрх зүйн заалтууд хоорондоо эрс ялгаатай.

Хүснэгт 4.5. *Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам"-ын харьцуулалт*

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А116/65 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралтаар "Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам"[33]	Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ""Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам"[34]
Дөрөв.Шүүгч, шүүх бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангах	Дөрөв.Бусад
4.1.Шүүгч, шүүх бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг цагдаагийн байгууллага хариуцна. 4.2.Хамгаалалтын арга хэмжээнд дараах шаардлага, нөхцөлийг харгалзана: 4.2.1.хамгаалалтын арга хэмжээ нь хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, эрүүл мэнд, аюулгүй байдалд харшлахгүй байх; 4.2.2.хамгаалалтын арга хэмжээний нэр, төрөл, нууцлалын нөхцөл, шуурхай байдал;	4.1.Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтан, алба хаагчид холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ. 4.2.Энэ журамд хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөлт оруулж болно.

29 Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.2 дахь хэсгийг үзнэ үү.

30 Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2021 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн А116/65 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралтаар "Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам, https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230447688911

31 Мөн тэнд.

32 Мөн тэнд.

33 http://103.11.195.37/san/hr/table5_full/33

34 https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230447688911

4.2.3.хамгаалалтын арга хэмжээ нь хууль сахиулах байгууллага, төрийн болон иргэний нийгмийн байгууллага, иргэдтэй харилцахдаа саад учруулахгүй, аюулгүй байдлыг хангасан байх; 4.2.4.хамгаалалтын арга хэмжээний гэрээ, төлөвлөгөөтэй байх; 4.3.Шүүн таслах ажиллагаатай холбогдуулан шүүгч, шүүх бүрэлдэхүүн, тэдгээрийн гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учирсан, эсхүл учирч болзошгүй бодит нөхцөл байдал үүсвэл шүүгч өөрийгөө болон гэр бүлийн гишүүн, эд хөрөнгөө хамгаалалтад авхуулах тухай хүсэлтээ шүүхийн тамгын газар болон цагдаагийн байгууллагад амаар, эсхүл бичгээр гаргана. 4.4.Улаанбаатар хотод цагдаагийн төв байгууллагын дарга, орон нутагт нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын дарга хүсэлтийг хүлээн авч нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгч, шаардлагатай гэж үзвэл хамгаалалтын арга хэмжээг нэн даруй зохион байгуулахаас гадна мэдээллийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлнэ. 4.5.Цагдаагийн байгууллага хамгаалалтад авах шийдвэр гарсны дараа энэ тухай шүүгчид мэдэгдэж, хамгаалалтад авах тухай гэрээ байгуулж, үйл ажиллагааны талаар төлөвлөгөөг боловсруулан нэгжийн даргаар батлуулна. Гэрээнд дараах зүйлийг тусгана: 4.5.1.гэрээний үндсэн нөхцөл, талуудын эрх, үүрэг; 4.5.2.хамгаалалтын хамрах хүрээ, чиглэл, хугацаа; 4.5.3.хамгаалагчийн тоо, хамгаалагчийн гүйцэтгэх ажил, үүрэг, ашиглах техник, тусгай хэрэгсэл; 4.5.4.хамгаалалтын арга хэмжээний хугацааг сунгах, зогсоох нөхцөлийг дэлгэрэнгүй тусгах. 4.6.Шүүгч, шүүх бүрэлдэхүүний аюулгүй байдлын хамгаалалтыг биечлэн дагах хэлбэрээр зохион байгуулна. 4.7.Цагдаагийн алба хаагч нь шүүгч, шүүх бүрэлдэхүүн, тэдгээрийн гэр бүлийн гишүүний аюулгүй байдлыг хангах зорилгоор биеийн хүч, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, галт зэвсгийг хууль тогтоомжид заасан журмын дагуу хэрэглэнэ. 4.8.Хамгаалалтад авах шүүгч, шүүх бүрэлдэхүүнд ажлын байранд учирч болох аюул, эрсдэлийг тооцож мэдэгдэх, урьдчилан сэргийлэх, хамгаалалтын арга хэмжээний дэг горимыг мөрдөх сургалт явуулна. 4.9.Шүүхийн тамгын газар цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн хамгаалалтад байгаа шүүгч, шүүх бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангах зорилгоор шүүхэд нэвтрэх ажилтнуудын картын нууцлалыг тухай бүр солих, шүүгч, шүүхийн ажилтны өрөө, шүүхийн барилга байгууламжид нэвтрэх, гарах хэсэг, эвлэрүүлэн зуучлах хэсэг, авто машины ил, далд зогсоол, лифт, коридор, уулзалтын өрөө зэргийг хамгаалалтын дохиолол, камерын хяналтад авах ажлыг зохион байгуулна. 4.10.Цагдаагийн байгууллага хамгаалалтыг зогсоохдоо тухайн шүүгч, шүүхийн тамгын газартай зөвшилцөнө. 4.11.Шүүгч хамгаалалтын талаар мэдээлэл авах эрхтэй бөгөөд хамгаалалтыг хэрэгжүүлж буй цагдаагийн албаа хаагч хууль бус шийдвэр, үйлдэл гаргасан тохиолдолд эрх бүхий албан тушаалтанд гомдол, хүсэлт гаргах эрхтэй. 4.12.Заналхийлэл болон бодит аюул занал таслан зогсоогдсон эсхүл арилсан нь бүрэн тогтоогдохоос өмнө хамгаалуулахаас татгалзвал үүнээс учирч болох эрсдэлийг шүүгч өөрөө бүрэн хариуцна. 4.13.Хамгаалалтад байгаа шүүгчийн хамгаалалттай холбогдон тавьсан хууль ёсны хүсэлт, шаардлагыг цагдаагийн албаа хаагч биелүүлэх үүрэгтэй.	

Дээрх хүснэгтээс үзвэл Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А116/65 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам”-ын дөрөвдүгээр бүлгийг Шүүхийн ерөнхий зөвлөл дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 12 дугаар 28-ны А/301/186 дугаар тушаалаар хүчингүй болгосноос үүдэж, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг зохицуулсан журмын зохицуулалт тодорхойгүй болжээ.

Аюулгүй байдлыг хангахтай холбоотой хэрэгжүүлж буй үйл ажиллагаа.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой сургалтыг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулдаг бөгөөд 2023 онд тус сургалтад 52 хүн хамрагдсан[35] байна. 2021 оноос шүүгчид сүлжээний эцсийн хэрэглэгчийн аюулгүй байдлыг хангах үүднээс албан ёсны эрхтэй “Касперски” программ хангамжийг ашиглаж эхэлсэн бөгөөд интернэтийн урсгалыг Төрийн мэдээлэл холбооны хамгаалалттай сүлжээгээр дамжуулан ашиглаж эхэлжээ. Энэ нь хувийн мэдээллийн нууцлалыг хадгалах, болзошгүй цахим халдлагаас урьдчилан сэргийлэхэд тодорхой үр нөлөө үзүүлж байна гэж Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс үзжээ. “Шүүхийн тайлан-2022”-д Шүүгчийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай дурдахдаа шүүгчийг албан үүргээ гүйцэтгэсэнтэй нь холбогдуулан хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр шүүгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй буюу заналхийлсэн, хүчирхийлэлд уриалсан мэдээ, мэдээллийг түгээсэн гэх 7 асуудлыг Шүүхийн ерөнхий зөвлөлд танилцуулан холбогдох эрх бүхий байгууллагад хандаж[36], хуульд заасан журмын дагуу 1 үйлдэлд Зөрчлийн тухай хуульд зааснаар торгох шийтгэл оногдуулж, 1 үйлдлийг хэрэгсэхгүй болгосон байна.

Монгол Улсын Шүүхийн тухай хуульд нийцүүлэн баталсан журмуудын хэрэгжилтийг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл, Хууль зүй дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газрын төлөөлөл бүхий хамтарсан ажлын хэсгийг байгуулан ажиллуулах Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын саналын дагуу Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар “Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэлтэс”-ийг ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Эргүүл хамгаалалтын газраас гаргаж, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны шууд харьяанд шилжүүлж бүтцийг өөрчилсөн байна.

Шүүгчийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой арга хэмжээг Шүүхийн ерөнхий зөвлөл, Цагдаагийн ерөнхий газраас хэрэгжүүлж, холбогдох хэрэг зөрчлийг шалгах, хамгаалалтад авах шаардлагатай нөхцөл байдал үүссэн тохиолдолд зохих арга хэмжээг авч ажиллаж буй тухай аль аль байгууллагын тайлангууд болон холбогдох мэдээллүүдэд дурдагдсан байна. Гэвч мэдээллийн нууцлал, аюулгүй байдалтай холбоотойгоор судалгаанд ашиглах мэдээллийн олдоц хязгаарлагдмал хүрээтэй байна.

35 Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв, Монгол Улсын шүүхийн тайлан-2022, (Уб, 2023), 30 дахь тал.

36 Мөн тэнд.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Гэрч, хохирогчийг хамгаалах хүрээнд:

Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, захиргааны хяналт тавих үндсэн чиг үүрэгтэй байгууллага юм. Харин гэрч, хохирогчийн амь нас эрүүл мэндийг хамгаалах, тэдний зөрчигдсөн эрхийг сэргээх, нийгмийн амьдралд эргэж оролцоход дэмжлэг, туслалцаа үзүүлэх, нөхөн сэргээх чиг үүрэг нь цагдаагийн байгууллагын чиг үүрэгтэй уялдаатай байх боловч тус чиг үүргийг хэрэгжүүлэх бие даасан байгууллага байх нь гэрч, хохирогчийн хамгааллын үе шатуудыг үр дүнтэй хэрэгжүүлэх, мэргэшсэн хүний нөөцөөр хангах, үйл ажиллагааны үндсэн чиглэлдээ анхаарч ажиллах зэрэг эерэг үр дагавар үүсгэхээр байна. Мөн гэмт хэргийг илрүүлэх болон гэрч хохирогчийн хамгааллын үйл ажиллагааг нэг байгууллагын эрх мэдэлд төвлөрүүлэх нь эрх мэдлийг урвуулан ашиглах, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөлд хүргэдэг. Жишээлбэл, 2024 онд Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газрын эргүүлийн цагдаа, цагдаагийн жолооч байсан хүмүүс 13 нас, 2 сар, 26 хоногтой бага насны хохирогчийг эрэн сурвалжлах ажиллагаа явуулах үедээ хохирогчийг өөрийн гэртээ болон тээврийн хэрэгсэл дотор үргэлжилсэн үйлдлээр хүүхэдтэй бэлгийн харьцаанд орж хүчиндсэн гэмт хэрэг гарсан явдал юм. Иймд эрх мэдлийн төвлөрлийг сааруулах, чиг үүргийн оновчтой зохион байгуулалт хийх нь гэрч, хохирогчийн хамгааллын асуудалд тулгамдаж буй асуудал болно. Түүнчлэн, хуулийн зохицуулалтын хүрээнд дараах асуудлууд байна гэж дүгнэв.

- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд хохирогчийг “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан…хохирогчийг” гэж тодорхойлсон нь Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд заасан хохирогчийн тодорхойлолттой нийцдэггүйгээс энэ төрлийн гэмт хэргийн хохирогч Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн хамгаалалтын гадна үлдэх эрсдэлтэй;
- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан 9 төрлийн хамгаалалтын арга хэмжээг журмаар зохицуулсныг хуулиар зохицуулах;
- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд зөвхөн насанд хүрээгүй гэрч, хохирогчийг түр байрлуулан хамгаалах асуудлыг стандарттай байхаар ялгаварлан тусгасныг засах.

Шүүгч, шүүхийн аюулгүй байдлын хүрээнд:

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8, 71 дүгээр зүйлийн 71.2 дахь хэсэгт заасан зохицуулалтын практик хэрэгжилтийг үнэлж, дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- “Тахарын албыг татан буулгасан нь шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр ухралт болсон” талаар судлаачид санал нийлж байна.
- Манай улс 2014 оныг хүртэл анхан шатны шүүхийн хэмжээнд цагдаагийн нэг алба хаагч ажиллаж, аюулгүй байдлыг сахиулдаг байсан. Энэ байдал 2014 оны АНУ-ын Маршалын албатай төстэй чиг үүрэг бүхий Тахарын албыг 2013 онд байгуулснаар өөрчлөгдсөн.

- Монгол Улсад 2014-2016 онд үйл ажиллагаа явуулж байсан Тахарын алба нь хамаарах чиг үүрэг, гэрч хохирогчийг хамгаалах болон шүүгчийн аюулгүй байдлыг хангах зэрэг ерөнхий ойлголтоороо АНУ-ын Маршалын албатай төстэй гэж үзэх дотоодын судлаачдын байр суурь байна.
- АНУ-д шүүх, шүүгчийг хамгаалах, шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангах үүргийг Маршалын алба (U.S Marshal Servic)-ны Шүүхийн аюулгүй байдлын хэлтэс (Judicial Security Division) гүйцэтгэдэг. Тус нэгж нь шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангах, холбооны шүүгч, тангарагтны шүүгчдийг хамгаалах, шүүгч, шүүх эрх мэдэлд учирч болзошгүй аюул заналхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. АНУ-ын 94 дүүрэг, 12 тойрог дахь холбооны шүүх, 2700 гаруй шүүгч, албан тушаалтнуудыг хамгаалах ажлыг өдөр тутамд гүйцэтгэдэг.
- Тахарыг албыг татан буулгасан нь шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр ухралт болсон гэж үздэг. Учир нь 2013 оны Тахарын албаны тухай хуулийн гуравдугаар бүлгийг “шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах” гэж нэрлээд 9 зүйл, 34 заалт, болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын А/96, 90 дүгээр хамтарсан тушаалын хавсралтаар батлагдсан “Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журам”-аар “шүүх, шүүгчийн аюулгүй байдал”-ыг хангаж байв.
- Харин одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Шүүхийн тухай хуульд “шүүх, шүүгчийн аюулгүй байдал”-ыг хангахтай холбоотой эрх зүйн зохицуулалт дутмаг бөгөөд хуулиар гэхээс илүүтэйгээр журмаар тодорхойлогдож байв. Энэхүү журмыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2021 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн А116/65 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралтаар баталж, үүний дөрөвдүгээр бүлэгт шүүх, шүүхийн аюулгүй байдлыг хангах 13 заалтыг тусгасан. Энэхүү журмыг баталснаас хойш 7 сарын дараа уг журамд өөрчлөлт оруулсан бөгөөд ингэхдээ шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой 13 заалтыг хүчингүй болжээ. Ингэснээр шүүх, шүүгчийн аюулгүй байдлын эрх зүйн орчин Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн ерөнхий хэдхэн зохицуулалтаар тодорхойлогдож байна.

Иймд шүүх, шүүгчийн аюулгүй байдлын асуудлыг Шүүхийн тухай хуулийн ерөнхий хэдэн зохицуулалтаар бус цогцоор нь нарийвчлан хуульчлах шаардлагатай байна.

НОМ ЗҮЙ

Нэг. Хууль тогтоомж

1. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, (2013);
2. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, (2012);
3. Эрүүгийн хууль, (2015);
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, (2017);
5. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, (2016);
6. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, (2017);
7. Монгол Улсын Шүүхийн тухай хууль, (2021);
8. Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам, (2021);
9. Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндэд аюул занал учрах нөхцөл үүссэн үед хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх журам, (2021);
10. Тахарын албаны тухай хууль, (2013), (Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон.)

Хоёр. Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, “Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь” судалгааны тайлан, (2022);
2. Нээлттэй нийгэм форум, “Гэрч, хохирогчийн хамгаалалт” бодлогын судалгааны тайлан, (2019);
3. Тогтвортой хөгжлийн санаачилга ТББ, “Монгол улсын хүүхэд хамгааллын тогтолцооны зураглал” сэдэвт судалгааны тайлан, (2021);
4. Улсын дээд шүүхийн 2023 оны ажлын тайлан, (Уб, 2024);
5. Улсын дээд шүүхийн 2022 оны ажлын тайлан, (Уб, 2023);
6. Улсын дээд шүүхийн 2021 оны ажлын тайлан, (Уб, 2022);
7. Улсын дээд шүүхийн 2020 оны ажлын тайлан, (Уб, 2021);
8. Ц.Цогт, Шүүгчийн аюулгүй байдал, Шүүх эрх мэдэл-мэдээлэл арга зүйн улирал тутмын эмхэтгэл (2022 оны №1 тусгай дугаар), (Уб, 2022);
9. Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын шүүхийн тайлан-2022, (Уб, 2023);
10. Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын шүүхийн тайлан-2021, (Уб, 2022);
11. Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын шүүхийн тайлан-2020, (Уб, 2021).

Гурав. Цахим эх сурвалж

1. Ш.Шинэбаяр Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн ахлах мэргэжилтэн, Цагдаагийн ахмад, Гэрч хохирогчийг хамгаалах хэлтсийн үйл ажиллагааны тухай, (Уб, 2019), Цагдаагийн ерөнхий газрын албан ёсны цахим хуудас, Холбоос: https://police.gov.mn/p/3791

ТАВ.МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН ӨВИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТ

Судалгааг хянасан:

Х.Эрдэм-Ундрах — Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur.)

Судалгааг гүйцэтгэсэн:

Ч.Доржсүрэн — Судлаач, МУИС-ийн ХЗС-ийн докторант

Судалгааны тайлан хүлээн авсан:

Х.Буянбат — Эрдэм шинжилгээний ахлах ажилтан (LL.M)

АГУУЛГА

УДИРТГАЛ 269

НЭГ. СОЁЛЫН ӨВИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ 272

1.1.Соёлын өвийн эсрэг гэмт хэргийг хуульчилсан байдал, харьцуулалт. . . . 272

1.2.Соёлын өвийн эсрэг гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж, анхаарах асуудал 280

1.3. Гадаадын зарим орны соёлын өвийн эсрэг гэмт хэргийн зохицуулалт . . 287

1.4. Бүлгийн дүгнэлт 296

ХОЁР. СОЁЛЫН ӨВИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ 298

2.1. Бүртгэж шалгасан соёлын өвийн эсрэг гэмт хэргийн судалгаа. 298

2.2. Шүүхээр шийдвэрлэсэн соёлын өвийн эсрэг гэмт хэргийн тоон мэдээлэл.....305

2.3. Соёлын өвийн эсрэг гэмт хэргийн шийдвэрлэлт, тулгамдаж буй асуудал.....308

2.4. Бүлгийн дүгнэлт 320

ДҮГНЭЛТ 322

ЗӨВЛӨМЖ 323

НОМ ЗҮЙ 324

УДИРТГАЛ

Дэлхийн улс, үндэстэн бүр өв соёлоо хадгалан хамгаалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх эрхэм үүргийг ард түмэн, хүн төрөлхтний өмнө хүлээн соёлын өвийг хамгаалах улс төр, нийгэм, эдийн засгийн янз бүрийн механизмыг хэрэгжүүлдэг. Тэдгээр арга хэрэгслүүд дотор олон улсын болон үндэсний эрх зүйн зохицуулалт гол байр суурийг эзлэх бөгөөд тухайн орны эрх зүйн бүл (тогтолцоо)-ээс хамаарч дотоодын хууль тогтоомжид өөр өөрөөр тусгасан боловч бүгд соёлын өвийн эсрэг хууль бус аливаа үйлдлийг гэмт хэрэг, зөрчилд тооцож, ял, шийтгэл оногдуулж байна.

Монгол Улс түүх, соёлын дурсгалт зүйлийг Эрүүгийн хуулиар хамгаалж ирсэн уламжлалтай. Тодруулбал 1926, 1929, 1934 оны Шүүх цаазын бичгүүд, 1942, 1961, 1986, 2002 оны Эрүүгийн хуулиудад соёлын өвд халдсан тодорхой (устгах, эвдэх, гэмтээх, хууль бусаар хил нэвтрүүлэх, тонон дээрэмдэх г.м) гэмт хэргүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр зааж, түүх, соёлын дурсгалт зүйлийг хулгайлах, дээрэмдэх, завших, эртний булш, хиргисүүрийг ухах үйлдлүүдийг “Өмчийн эсрэг гэмт хэрэг”, “Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны гэмт хэрэг” бүлгийн холбогдох зүйл, хэсгээр зүйлчлэн шийдвэрлэж байв.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд боловсруулсан Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга)-ийг УИХ-аас 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталж, 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн билээ. Эрүүгийн хуульд хүний орон байранд хууль бусаар халдах, хууль бусаар нэгжих, эд хөрөнгө хураан авах, битүүмжлэх, ялгаварлан гадуурхах, заналхийлэх, хууль бусаар мөрдөн мөшгөх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зэрэг 30 гаруй төрлийн гэмт хэргийг шинээр нэмсэн[1] ба түүх, соёлын дурсгалт зүйл, археологи, геологи, палеонтологийн үнэт олдвор, хосгүй үнэт зүйлийг хамгаалах талаар төрөөс баримталж буй бодлогод нийцүүлж[2] Соёлын өвийн эсрэг 6 гэмт хэрэг (зүйл) бүхий шинэ бүлэг оруулсан юм.

“Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг” бүлэгт “Түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах” (25.1 дүгээр зүйл) болон “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг эвдэх, гэмтээх, устгах” (25.2 дугаар зүйл) гэмт хэргүүдийг тусад нь салгаж, “Соёлын өвийг завших, үрэгдүүлэх” (25.3 дугаар зүйл) гэмт хэргийг бие даасан гэмт хэрэг болгож, “Хууль бусаар археологи, палеонтологийн хайгуул, малтлага хийх” (25.4 дүгээр зүйл), “Соёлын биет өвийн хууль бус худалдааг зохион байгуулах, зуучлах” (25.5 дугаар зүйл), “Түүх, соёлын дурсгалт зүйлийг тогтоосон хугацаанд хилээр оруулж ирэхгүй байх” (25.6 дугаар зүйл) гэмт хэргүүдийг шинээр хуульчилж, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар тус бүлэгт “Эрдэнэсийн сангийн үндсэн санг хууль бусаар зарцуулах” (25.7 дугаар зүйл) гэмт хэргийг нэмж хуульчилжээ.[3]

Түүнчлэн, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйл (Хулгайлах)-ийн 2.2 дахь заалтад: энэ гэмт хэргийг түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлж үйлдсэн; мөн хуулийн 18.5 дугаар зүйл (Улсын хилээр барааг хууль бусаар

1 ННФ, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв. Шинэ төрлийн гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдал (Судалгааны тайлан), (Уб, 2021).

2 Шинэ Эрүүгийн хуулийн үзэл баримтлал (анхных).

3 Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга), Төрийн мэдээлэл эмхэтгэл, (2016), №07.

нэвтрүүлэх)-ийн 3 дахь хэсэгт: энэ гэмт хэргийг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний амьтны, ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн, палеонтологийн олдвор, эд өлгийн зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж үйлдсэн[4] бол гэж тус тус халдлагын зүйлийн шинжээр хүндрүүлж үзэхээр заасан байна.

Соёлын өвийн эсрэг гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинэлэг зохицуулалт агуулсан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр үйлчлээд даруй 7 жил өнгөрсөн ч соёлын өвтэй холбоотой гэмт хэргийн талаарх хуулийн зүйл, хэсэг, заалтыг нэг мөр ойлгон хэрэглэж буй байдал, энэ төрлийн гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлт, тулгамдсан асуудлын талаар 2020 онд эрдэм шинжилгээний 1 өгүүлэл[5] нийтлэгдсэнийг эс тооцвол дагнасан судалгаа одоог хүртэл хийгдээгүй байна. Иймд соёлын өвийн эсрэг гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн байдлыг судалж дүгнэх, хууль хэрэглэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох бодит хэрэгцээ шаардлага нэгэнт үүсжээ.

Судалгааны ажлын зорилго, зорилт

Тус судалгаа нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан соёлын өвийн эсрэг гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн байдлыг судлах зорилготой бөгөөд энэ хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүллээ. Үүнд:

1. Өмнөх үеийн эрүүгийн хууль тогтоомж дахь түүх, соёлын дурсгалт зүйлтэй холбоотой гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтыг одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга)-ийн зүйл, хэсэг, заалттай харьцуулан дүгнэх;
2. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан соёлын өвийн эсрэг гэмт хэргүүдийн бүрэлдэхүүнийг задлан шинжлэх;
3. Эрүүгийн хуулийн дээрх зүйл, хэсэг, заалтыг практикт (шүүгч, прокурор, мөрдөгч, өмгөөлөгч нар) хэрхэн ойлгож хэрэглэж байгааг тогтоон үнэлэх;
4. Бүртгэгдсэн болон шийдвэрлэсэн соёлын өвийн эсрэг гэмт хэргийн тоон мэдээлэл, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх;
5. Соёлын өвийн эсрэг гэмт хэргийн талаарх гадаадын зарим орны эрүүгийн эрх зохицуулалтын байдлыг жишин харьцуулах;
6. Эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, хэрэгжилтийг хангах талаар санал, зөвлөмж боловсруулах зэрэг болно.

Судалгааны хамрах хүрээ, арга зүй

Судалгааны хүрээг Монгол Улсын ЭХТА-ийн 25 дугаар (Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг) бүлгийн 25.1 - 25.7 дугаар зүйл, 17.1 дүгээр зүйл, (2 дахь хэсгийн 2.2 дахь заалт) болон 18.5 дугаар зүйл (3 дахь хэсэг)-д заасан гэмт хэргүүд, тэдгээртэй холбоотой ном, сурах бичиг, гарын авлага, цагдаагийн байгууллага, прокурор, шүүхийн мэдээлэл, судалгааны материал, шүүхийн шийдвэр зэргээр тогтоолоо.

4 Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2020 оны 01 сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан.

5 Ч.Доржсүрэн, “Эрүүгийн хуулийн шинэчлэл: Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг”, Хууль дээдлэх ёс сэтгүүл, №2, (Уб, 2020).

Судалгааны зорилго, зорилттой уялдан түүхчлэх, харьцуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, баримт бичиг судлах, лавлагаа, мэдээлэл авах, тохиолдол шинжлэх, учир шалтгааны тайлбарлах, ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага хийх, статистикийн үр дүнг ашиглах аргуудыг хэрэглэв.

НЭГ. СОЁЛЫН ӨВИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

1.1.Соёлын өвийн эсрэг гэмт хэргийг хуульчилсан байдал, харьцуулалт

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 25 дугаар бүлэг (Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг)-т соёлын биет өв (түүх, соёлын хөдлөх дурсгал, түүх соёлын үл хөдлөх дурсгал)-д халдсан 7 гэмт хэргийг багтаасан бөгөөд түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлсан тохиолдолд “Хулгайлах” гэмт хэргийн хүндрүүлэх шинж, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний амьтны, ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн, палеонтологийн олдвор, эд өлгийн зүйлийг хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бол “Улсын хилээр бараг хууль бусаар нэвтрүүлэх” гэмт хэргийн хүндрүүлэх шинж байхаар хуульчилжээ.

Хүснэгт 5.1. *Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд Соёлын өвийн эсрэг гэмт хэргийг хуульчилсан байдал*

Арван долдугаар бүлэг **Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг**	17.1 дүгээр зүйл. Хулгайлах	2.Энэ гэмт хэргийг: 2.2.<u>түүх, соёл,</u> шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд <u>чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлж үйлдсэн</u> бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
Арван наймдугаар бүлэг **Эдийн засгийн гэмт хэрэг**	18.5 дугаар зүйл. Улсын хилээр бараг хууль бусаар нэвтрүүлэх	3.Энэ гэмт хэргийг <u>түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний амьтны, ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн, палеонтологийн олдвор, эд өлгийн зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж үйлдсэн</u> бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
Хорин тавдугаар бүлэг **Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг**	25.1 дүгээр зүйл.<u>Түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах</u> 25.2 дугаар зүйл.<u>Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг эвдэх, гэмтээх, устгах</u> 25.3 дугаар зүйл.<u>Соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх</u> 25.4 дүгээр зүйл.<u>Хууль бусаар археологи, палеонтологийн хайгуул, малтлага хийх</u> 25.5 дугаар зүйл.<u>Соёлын биет өвийн хууль бус худалдааг зохион байгуулах, зуучлах</u> 25.6 дугаар зүйл.<u>Түүх, соёлын дурсгалт зүйлийг тогтоосон хугацаанд хилээр оруулж ирэхгүй байх</u> 25.7 дугаар зүйл. <u>Эрдэнэсийн сангийн үндсэн санг хууль бусаар зарцуулах</u>	

Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн хөгжлийн явцад анх удаа “Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг” бие даасан бүлэгтэй болсон байх ба дээрх хуулийн зохицуулалтыг өмнөх буюу 2002 оны Эрүүгийн хуулийн холбогдох зүйл, хэсэгтэй харьцуулж, тайлбарлая.

Хүснэгт 5.2. *Соёлын өвийн эсрэг гэмт хэргийг хуульчилсан байдлыг харьцуулсан нь*

Эрүүгийн хууль **2002 он**	Эрүүгийн хууль **2015 он**	Тайлбар
145 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг хулгайлах	**17.1 дүгээр зүйл. Хулгайлах**	
145.1. Бусдын эд хөрөнгийг хулгайлсны улмаас бага бус хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. 145.2. Энэ гэмт хэргийг давтан, бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, машин механизм, тусгайлан бэлтгэсэн багаж хэрэгсэл хэрэглэж буюу орон байр, агуулах савand нэвтэрч үйлдсэн, энэ хэргийн улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан, олон тооны мал хулгайлсан бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 145.3. Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн, эсхүл энэ хэргийн улмаас хохирогчийг амьдралын эх үүсвэрээс нь салгасан буюу их хэмжээний хохирол учирсан, түүнчлэн нийтэд учирсан гамшигт байдлыг далимдуулж үйлдсэн бол эд хөрөнгийг хурааж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 145.4. Энэ хэргийг булаах, дээрэмдэх, уулгалан довтлох гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтэн, гэмт бүлэглэл үйлдсэн, энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хурааж, арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	1.Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан бол хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, ***эсхүл*** **зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.** 2.Энэ гэмт хэргийг: 2.1.хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч үйлдсэн; 2.2.түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлсан; 2.3.ноцтой хохирол учруулсан, эсхүл их хэмжээний эд хөрөнгийг хулгайлсан; 2.4.учрах саадыг арилгах зорилгоор зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэсэн, машин механизм ашигласан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3.Энэ гэмт хэргийг: 3.1.байнга үйлдэж, амьжиргааны эх үүсвэр болгосон; 3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	- Шинэ зохицуулалтаар түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлсан үйлдлийг хүндрүүлэхээр заасан. Энэ нь сүүлийн жилүүдэд түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлах явдал цагдаагийн байгууллагад цөөнгүй бүртгэгдэж байгаатай холбоотой.[6] - Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.2 дахь хэсгийн ял нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51-250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, 3-6 сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл 2-5 жил хүртэл хугацаагаар хорих байсан бол шинэчилсэн найруулгын 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт 2-8 жил хорих ял оногдуулахаар заажээ. Өөрөөр хэлбэл уг гэмт хэргийг хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэн тохиолдолд зөвхөн хорих ял шийтгэхээр зааж, хорих ялын дээд хэмжээг 3 жилээр нэмэгдүүлсэн байна.

6 ХЗДХЯ, Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/. Сургагч багш нарт зориулсан гарын авлага /Тусгай анги/. (Уб, 2017), 66 дахь тал.

175 дугаар зүйл. Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх	18.5 дугаар зүйл. Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх	Тайлбар
175.1.Хориглосон буюу хязгаарласан эд зүйлийг бага бус хэмжээгээр, ховор амьтан, түүнчлэн их хэмжээний валют, валютын үнэт зүйл, эрдэнэс, эрдэс, түүнчлэн байгалийн төрийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. 175.2.Энэ хэргийг давтан буюу бүлэглэж, эсхүл албан тушаалынхаа байдлыг ашиглаж үйлдсэн, түүнчлэн түүх соёлын дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний амьтны болон ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн ба палеонтологийн олдвор, эд өлгийн зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бол эд хөрөнгийг хурааж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 175.3.Энэ хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл, түүнчлэн онц их хэмжээтэйгээр үйлдсэн бол эд хөрөнгийг хурааж, таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	1.Хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу хориглосон бараа, эрдэнэс, эрдсийг Монгол Улсын хилээр, гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ. 2.Энэ гэмт хэргийг: 2.1.албан тушаалынхаа байдлыг ашиглаж; 2.2.байлдааны галт зэвсэг, галт хэрэгсэл, цөмийн бодис, цацраг идэвхт хаягдал, тэсэрч дэлбэрэх бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3.Энэ гэмт хэргийг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний амьтны, ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн, палеонтологийн олдвор, эд өлгийн зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 4.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	- Эрүүгийн хуулийн 175 дугаар зүйлийн 175.2 дахь хэсэгт: - давтан - бүлэглэж - албан тушаалын байдлыг ашиглаж - түүх соёлын дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний амьтны болон ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн ба палеонтологийн олдвор, эд өлгийн зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлж үйлдсэн байх зэрэг 4 (объектив талын үйлдлийн арга, халдлагын зүйл) хүндрүүлэх шинжийг нэг дор тусгасан байв. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт: түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний амьтны, ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн, палеонтологийн олдвор, эд өлгийн зүйлийг дангаар нь оруулжээ. - Энэ гэмт хэрэгт оногдуулах торгох ял хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (192.000)-г 151-250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх байсан нь одоогийнхоос 8 сая орчим төгрөгөөр илүү байв. Харин хорих ялын дээд хэмжээ 8 жил болж өмнөхөөс 3 жилээр нэмэгджээ.

	5.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хоёр зуун мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	
210 дугаар зүйл. Байгалийн объектыг санаатай эвдэх, гэмтээх, устгах	**25.1 дүгээр зүйл. Түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах**	**Тайлбар**
210.1.Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад орсон байгалийн объектыг санаатай эвдсэн, гэмтээсэн, устгасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	1.Түүх, соёлын дурсгалт зүйлийг санаатай эвдсэн, гэмтээсэн, устгасан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ. 2.Үнэт зэрэглэлд хамаарах түүх, соёлын дурсгалт зүйлийг санаатай эвдсэн, гэмтээсэн, устгасан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3.Хосгүй үнэт зэрэглэлд хамаарах түүх, соёлын дурсгалт зүйлийг санаатай эвдсэн, гэмтээсэн, устгасан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	- “Байгалийн объектыг санаатайгаар эвдэх, гэмтээх, устгах” гэмт хэргийн шинжийг буруу тодорхойлсон учир хэм хэмжээний диспозиц үгүйсгэгдсэн. Өөрөөр хэлбэл түүх соёлын хосгүй үнэт зүйлийн жагсаалтад байгалийн объект ороогүй бөгөөд амьдралд гарсан хэрэг, үйлдэлд энэ зүйл заалтаар эрүүгийн хэрэг үүсгэн шалгах боломжгүй юм.[7] Тиймээс 2002 оноос хойш 2017 оны 07 дугаар сарын 01-нийг хүртэл ЭХТА-ийн 210 дугаар зүйлээр хэрэг нээн шалгаагүй. - Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар дээрх алдааг засаж, түүх, соёлын дурсгалт зүйл болон түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг эвдэх, гэмтээх, устгах гэмт хэргийг тусдаа 2 зүйл болгон хуульчилсан юм.
129 дүгээр зүйл. Булш сүйтгэх	**25.2 дугаар зүйл. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг эвдэх, гэмтээх, устгах**	**Тайлбар**

7 Ч.Доржсүрэн, Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг /Тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам/, (Уб, 2014), 33 дахь тал.

129.1. Булш сүйтгэсэн буюу түүнд байсан эд зүйлийг авсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс гурван зуун тавин цаг хүртэлх хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэлх хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. 129.2. Энэ хэргийг давтан, бүлэглэж, тохуурхан даажигнаж, эсхүл онц жигшүүртэй авирлаж үйлдсэн бол гурван зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэлх хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл хоёроос таван жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ.	1.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг санаатай эвдсэн, гэмтээсэн, устгасан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ. 2.Улс, орон нутгийн хамгаалалтад авсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг санаатай эвдсэн, гэмтээсэн, устгасан, эсхүл энэ гэмт хэргийг олон хүний амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулж болох аргаар үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	Булш сүйтгэх гэмт хэрэг нь объектив талын хувьд булшны хөшөө, оршуулгын барилга байгууламжийг устгаж, зарим тохиолдолд булшин доторх эд зүйлийг авч байгаагаараа эртний хүний булш, бунхан зэрэг түүх соёлын дурсгалт зүйлсийг эвдэж гэмтээх, ухаж тонох гэмт үйлдэлтэй адил төсөөтэй боловч гэмт хэргийн бүрэлдэхүүний объект болон субьектив талын хувьд ялгаатай.[8] Энэ гэмт хэргийн объект нь нийгмийн ёс суртахуун /нас барагсдад үзүүлэх хүндэтгэл/, субьектив тал нь гэм буруугийн шууд санаатай, өш хонзон, шунахай, эсхүл танхайн сэдэлттэй байж болно. Гэхдээ Эрүүгийн хуулийн шинэчлэлээр булш сүйтгэх гэмт хэргийг түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг эвдэх, гэмтээх, устгах гэмт хэрэг болгон өөрчлөөгүй бөгөөд 2002 оны Эрүүгийн хуулийн 210 дугаар зүйлийг хэрэглэх боломжгүйгээс эртний булш, хиргисүүрт халдсан үйлдлийг 129 дүгээр зүйлээр зүйлчлэн шалгаж шийдвэрлэсэн хэд хэдэн тохиолдол байдагтай холбоотойгоор энд орууллаа.
150 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх	**25.3 дугаар зүйл. Соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх**	**Тайлбар**
150.1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өмчийг итгэмжлэгдэн хариуцсан этгээд завшсан буюу үрэгдүүлсний улмаас бага бус хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.	1.Соёлын биет өвийг завшсан, үрэгдүүлсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	- 2002 оны Эрүүгийн хуульд бусдын эд хөрөнгийг завших үрэгдүүлэх гэж ерөнхий байдлаар томьёолж байсан бол 2015 оны Эрүүгийн хуульд тусад нь бие даасан гэмт хэрэг болгожээ.

8 Ч.Доржсүрэн, *Соёлын өвийн эсрэг* гэмт хэрэг /Тулгамд*сан асуудал, шийдвэрлэх арга зам/,* (Уб, 2014), 39 дэх тал.

150.2.Энэ хэргийг давтан буюу бүлэглэж үйлдсэн, энэ хэргийн улмаас бусдад үлэмж хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 150.3.Энэ хэргийн улмаас бусдад их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хураах, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.		- Нийтлэг субъекттэй байхаар тусгаж, эрх хасах нэмэгдэл ялыг авсан бөгөөд үндсэн бүрэлдэхүүний торгох ялын дээд хэмжээг 4 сая орчим төгрөгөөр нэмж, баривчлах ялыг хорих ялаар сольжээ. ЭХ-ийн 17.4 дүгээр зүйл (Хөрөнгө завших)-д гэмт хэрэгт хамтран оролцох хэлбэр, хохирлын хэмжээг харгалзан хүндрүүлж үзэхээр тусгасан бол 25.3 дугаар зүйл хүндрүүлэх шинж байхгүй байна.
-	**25.4 дүгээр зүйл. Хууль бусаар археологи, палеонтологийн хайгуул, малтлага хийх**	**Тайлбар**
	1.Хууль бусаар археологи, палеонтологийн хайгуул, малтлага, судалгаа хийсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2.Хууль бус археологи, палеонтологийн хайгуул, малтлага, судалгааг санхүүжүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	- Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвшөөрөлгүй археологи, палеонтологийн хайгуул, малтлага, судалгаа хийж, түүх, соёлын дурсгалт зүйлийг хууль бусаар олж авдаг нь үр дагаврын хувьд аюултай юм. Иймээс уг үйлдлийг тусгайлан гэмт хэрэгт тооцсон.[9] - Уг зүйлийн 2 дахь хэсэгт хууль бус малтлага, судалгааг санхүүжүүлсэн үйлдэлд, 3 дахь хэсэгт хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байна.

9 ХЗДХЯ, *Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/, Сургагч багш нарт зориулсан гарын авлага /Тусгай анги/,* (Уб, 2017), 194 дэх тал.

-	**25.5 дугаар зүйл.Соёлын биет өвийн хууль бус худалдааг зохион байгуулах, зуучлах**	**Тайлбар**
	1.Соёлын биет өвийн худалдааг хууль бусаар явуулсан, зуучилсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	- Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуульд зааснаар түүх, соёлын хосгүй үнэт зүйлийг худалдах анхны саналыг төрд тавихгүйгээр худалдах, археологи, палеонтологийн олдворыг худалдахыг хориглодог. - УДШ-ээс энэ зүйлийн хууль бус худалдааг зохион байгуулах, зуучлах, худалдааг хууль бусаар явуулсан, зуучилсан гэдгийг ялгаж сайн тайлбарлах, эсхүл хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр илүү оновчтой болгох нь зохистой юм. - Хуулийн анхны төсөлд энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, түүний ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр оруулсан боловч 2017.05.11-ний өдрийн ЭХНӨОтХ-аар хасжээ.
-	**25.6 дугаар зүйл.Түүх, соёлын дурсгалт зүйлийг тогтоосон хугацаанд хилээр оруулж ирэхгүй байх**	**Тайлбар**
	1.Түүх, соёлын дурсгалт зүйлийг хуулиар тогтоосон журмын дагуу тогтоосон хугацаанд улсын хилээр оруулж ирээгүй бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	- Түүх, соёлын дурсгалт зүйлийг судлан шинжлүүлэх, сэргээн засварлах, үзэсгэлэнд оролцуулах, өмчлөгч язгуур зориулалтаар нь ашиглах зорилгоор зохих зөвшөөрлийн дагуу 2 жил хүртэлх хугацаагаар гадаад улсад түр гаргадаг. Харин зөвшөөрөлтэй хил нэвтрүүлсэн боловч эргэж авчраагүй тохиолдлыг гэмт хэрэгт тооцох болсон. Энэ зохицуулалт ОХУ, Гүрж, Беларус, Киргизстан улсын Эрүүгийн хуульд аль эрт (1996-1998 он) тусгалаа олсон байдаг.

	2.Түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлийг хуулиар тогтоосон журмын дагуу тогтоосон хугацаанд улсын хилээр оруулж ирээгүй, эсхүл түүх, соёлын дурсгалт зүйлийг завшсан бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	
-	**25.7 дугаар зүйл. Эрдэнэсийн сангийн үндсэн санг хууль бусаар зарцуулах**	**Тайлбар**
	1.Эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр эрдэнэсийн сангийн байнгын бус хэсгээс эрдэнэсийг худалдсан, шилжүүлсэн, захиран зарцуулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2.Эрдэнэсийн сангийн байнгын хэсгээс эрдэнэсийг худалдсан, шилжүүлсэн, захиран зарцуулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ.	- 2022.04.22-ны өдрийн ЭХНӨОтХ-аар тус зүйлийг шинээр нэмсэн бөгөөд Монгол Улсын эрдэнэсийн сангийн тухай хуульд заасны дагуу үндсэн сангийн байнгын бус хэсэгт түүх, соёлын үнэт дурсгалт зүйл, байнгын хэсэгт түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг байршуулан хадгалдагтай холбоотой. Гэхдээ “эрдэнэс” гэдэгт түүх, соёлын үнэт, хосгүй үнэт дурсгалт зүйлээс гадна түүхий эд, хайлш, химийн нэгдэл, бүтээгдэхүүн зэрэг ямар ч байдалд байгаа үнэт металл, эрдэнийн чулуу, байгалийн төрц мөн багтана.
299 дүгээр зүйл. Хориглосон арга хэрэгслээр дайн хийх	**29.4 дүгээр зүйл. Дайны үед хориглосон арга, хэрэгсэл хэрэглэх**	**Тайлбар**
299.1. Олзлогдогсод, энгийн хүн амтай харгис хэрцгийн харьцсан, хүн амыг оршин суугаа нутгаас нь албадан зайлуулсан, <u>эзлэгдсэн нутагт түүх, соёлын дурсгалт зүйлийг тонон дээрэмдсэн,</u> зэвсэгт мөргөлдөөний үеэр Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон арга хэрэгсэл хэрэглэсэн бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 299.2. Монгол улсын олон улсын гэрээгээр хориглосон хүн амыг үй олноор хөнөөх, устгах зэвсэг хэрэгсэл хэрэглэсэн бол арван таваас дээш хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.		НҮБ-ээс 1954 онд “Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлсийг хамгаалах тухай конвенц”-ийг баталж, манай улс 1964 оны 8 дугаар сарын 7-ны өдөр нэгдэн орсон. Энэхүү гэмт хэргийн үйлдлийн аргыг дотоодын хууль тогтоомж, нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцүүлэн “соёлын үнэт зүйл”, “соёлын биет өв” гэх байтал өмнө нь хэрэглэж байсан “түүх, соёлын дурсгалт зүйл”-ийг сольж, “үндэсний эд хөрөнгө” гэж ерөнхий нэрлэжээ.

1.2.Соёлын өвийн эсрэг гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж, анхаарах асуудал

Эрүүгийн эрх зүйн онол ёсоор тодорхой гэмт хэргийн хууль цаазын шинжийг тодорхойлохдоо гэмт хэргийн бүрэлдэхүүн гэсэн ухагдахууныг хэрэглэнэ. Гэмт хэргийн бүрэлдэхүүн гэдэг нь тодорхой нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг болохыг тодорхойлж байгаа эрүүгийн хуульд заасан объектив ба субьектив шинжүүдийн цогц бүрдлийг хэлдэг.[10] Гэмт хэргийн бүрэлдэхүүний аль нэг элемент байхгүй, эсхүл буруу томьёолсноос тухайн гэмт хэрэг үгүйсгэгдэх ба гэмт хэргийн зүйлчлэлд шууд нөлөөлдөг.

Соёлын өвд халдсан амьдралд гарсан хэрэг, үйлдэл нь гэмт хэрэг мөн эсэх, Эрүүгийн хуулийн тусгай ангийн аль зүйл, хэсгээр зүйлчлэн шалгаж, шийдвэрлэхийг тогтоохдоо тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг заавал ойлгож мэдсэн байх ёстой бөгөөд эрх зүйн хэм хэмжээнд ямар нэг алдаа байвал даруй засаж залруулах шаардлагатай. Иймд ЭХТА-д заасан соёлын өвийн эсрэг гэмт хэргүүдийг бүрэлдэхүүний шинжээр нь задалж, объект, объектив тал, субъект, субьектив тал буюу хуулийн зохицуулалт, ойлголт, нэр томьёотой холбоотой анхаарах асуудлыг дүгнэн тодорхойлъё.

Хүснэгт 5.3. *Түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж*

Түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 25.1 дүгээр зүйл)	
Объект	Соёлын өв, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах журам байна. Халдлагын зүйл нь түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, хүндрүүлэх шинжид түүх, соёлын үнэт дурсгалт зүйл, түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл байна.
Объектив тал	Түүх, соёлын дурсгалт (хөдлөх) зүйлийг эвдсэн, гэмтээсэн, устгасан идэвхтэй үйлдэл байна.
Субъект	Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, хувь хүн байна. Тухайн хүн Монгол улсын иргэн, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн, хоёрдмол харьяалалтай хүн аль нь ч байж болно.
Субьектив тал	Гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн хүн өөрийн үйлдлийн хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж, түүнийг хүсэж үйлдсэн байна.
Анхаарах асуудал	
1. Энэ зүйлийн гарчиг ба 1 дэх хэсгийн халдлагын зүйлийг “Түүх, соёлын дурсгалт зүйл” гэсэн хуулиар тодорхойлсон нэр томьёоноос өөр байна. Соёлын өвийг хамгаалах тухай хуульд зааснаар соёлын биет өвийг түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон хөдлөх дурсгалт зүйл гэж ангилсан[11] байдаг. Хуулийн хэллэг, агуулгын хувьд түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл гэвэл таарна.	
2. Гэмт хэргийн бүрэлдэхүүний обьектив талд эвдэх, гэмтээх, устгах 3 үйлдлийг тусгасан бөгөөд ЭХТА-д үйлдлийн аргаар нь бие даасан гэмт хэрэг болгон заасан бусад хэргүүд (17.8 дугаар зүйл.Эд хөрөнгө устгах, гэмтээх; 17.11 дүгээр зүйл. Болгоомжгүйгээр эд хөрөнгө устгах, гэмтээх, үрэгдүүлэх; 19.17 дугаар зүйл.Улсын хилийн тэмдэг, хилийн шугам дээрх байгууламжийг устгах, гэмтээх, шилжүүлэх; 23.3 дугаар зүйл.Баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт хулгайлах, устгах, гэмтээх, нуух; 27.5 дугаар зүйл.Осол, зөрчилд өртсөн агаарын хөлгийн бодит хяналтын хэрэгслийг устгах, гэмтээх; 27.6 дугаар зүйл. Агаарын навигацийн тоног төхөөрөмжийг устгаж гэмтээх, нислэгийн хөдөлгөөнд саад учруулах; 28.8 дугаар зүйл. Цэргийн эд хөрөнгийг санаатай устгах, гэмтээх)-ээс “эвдэх” үйлдлийг заан оруулснаараа онцлогтой байна.	

10 Г.Гантөмөр, Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол, (Уб, 2011), 14 дэх тал.

11 Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг.

Эдгээр гэмт хэргүүдийн халдлагын зүйл[12] хоорондоо ялгаатай боловч бүгд эвдэрч, гэмтэж болох нийтлэг шинж чанартай материаллаг эд зүйл юм. Судлан үзвэл эвдэх, гэмтээх 2 нь ижил утга илэрхийлэх ба энэ байдал гэмт хэргийн үндсэн шинж болох үйлдэл хоорондын өрсөлдөөнийг бий болгож байна. Сонгох санкц бүхий энэ гэмт хэргийн хувьд объектив талын өрсөлдөх хэм хэмжээ[13] нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй боловч учруулж буй хохиролт үр дагавар шүүхээс ял оногдуулахад харгалзах нөхцөл болох нь зайлшгүй.

Хүснэгт 5.4. *Түүх, соёлын дурсгалт үл хөдлөх дурсгалыг эвдэх, гэмтээх, устгах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж*

Түүх, соёлын дурсгалт үл хөдлөх дурсгалыг эвдэх, гэмтээх, устгах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 25.2 дугаар зүйл)	
Объект	Соёлын өв, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах журам байна. Халдлагын зүйл нь түүх, соёлын үл хөдлөх дурсгал, хүндрүүлэх шинжид улс, орон нутгийн хамгаалалтад авсан түүх, соёлын үл хөдлөх дурсгал байна.
Объектив тал	Түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдсэн, гэмтээсэн, устгасан идэвхтэй үйлдэл байна.
Субъект	Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, хувь хүн байна. Тухайн хүн Монгол улсын иргэн, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн, хоёрдмол харьяалалтай хүн аль нь ч байж болно.
Субьектив тал	Гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн хүн өөрийн үйлдлийн хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж, түүнийг хүсэж үйлдсэн байна.
Анхаарах асуудал	
1. Обьектив талын “эвдэх, гэмтээх” үйлдлийн хувьд дээр дурдсантай ижил бөгөөд аль нэгийг сонгон хэрэглэх нь оновчтой. 2. Зөрчлийн тухай хуулийн 9.7 дугаар зүйл /Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих/-ийн 5 дахь хэсэгт: Соёлын биет өвийг хадгалах, хамгаалах, ашиглах талаар хуулиар тогтоосон хориглолт, журам, стандарт зөрчсөн, эсхүл анхны төрх, нэгдмэл цогц байдлыг алдагдуулсан, эсхүл зөвшөөрөлгүй хөдөлгөж, зөөж тээвэрлэсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй, тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно; 11 дэх хэсэгт: Түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдол бүхий олдворыг хадгалах, хамгаалах, судлахдаа түүний анхны төрх, байдал, хэлбэр шинж чанарыг алдагдуулж гэмтээсэн, олдворыг стандартын шаардлага хангаагүй өрөө тасалгаа орчинд хадгалсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй, тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно; 12 дахь хэсэгт: Соёлын биет өвийг сурталчлах, судалгаа, шинжилгээ хийх, сургалт явуулах зориулалтаар ашиглахдаа гэмтээсэн, эсхүл үрэгдүүлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй, тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно[14] гэж заасан. Соёлын биет өвийн анхны төрх, нэгдмэл цогц байдлыг алдагдуулсан үйлдлийг эвдсэн, гэмтээсэн гэж үзэх үндэслэлтэй учир Зөрчлийн тухай хуулийн 9.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан энэ зөрчил уг зүйлд заасан гэмт хэргийн эвдэх, гэмтээх үйлдлийн шинжтэй давхацна. Соёлын биет өвийг хадгалах, хамгаалах, ашиглах талаар хуулиар тогтоосон хориглолт, журам, стандарт зөрчсөний “улмаас” бус “эсхүл” гэсэн тул тусдаа бие даасан үйлдэл гэж ойлгох ба зөрчлийг санаатай болон болгоомжгүйгээр үйлдэж болно. Тиймээс практикт энэ төрлийн гэмт хэргийг зөрчил гэж үзэх, улмаар гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай этгээдэд ял “завших” боломж олгоно.	

12 “Халдлагын зүйл бол Эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх ашгийн илрэн гарах материаллаг хэлбэр мөн.” С.Нарангэрэл, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /ерөнхий анги/, (Уб, 1999), 124 дэх тал.

13 “Эрүүгийн эрх зүйн өрсөлдөх хэм хэмжээ гэдэг нь агуулга хэмжээгээрээ нэг эрх зүйн харилцааг хэд хэдэн хэм хэмжээгээр зохицуулахыг хэлдэг бөгөөд тэдгээрийн нэг хэм хэмжээ нь нөгөөгөөсөө давамгайлах үүрэг гүйцэтгэнэ.” С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол /боть I/, (Уб, 2009), 290 дэх тал.

14 Зөрчлийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, (2017), №24.

Зөрчлийн 11, 12 дахь хэсэгт олдворыг хадгалах, хамгаалах, судлахдаа... , биет өвийг сурталчлах, судалгаа, шинжилгээ хийх, сургалт явуулах зориулалтаар ашиглахдаа гэж нөхцөл заасан нь нэгдүгээрт, эдгээр үйл ажиллагааг эрхлэн явуулах чиг үүрэг бүхий этгээд /тусгай субъект/-д хамаарах, хоёрдугаарт, гэм буруугийн болгоомжгүй /хөнгөмсгөөр найдсан, эсхүл хайхрамжгүй хандсан/ хэлбэрээр үйлдэгдэх магадлалыг илэрхийлнэ. Заавал эрх бүхий этгээдээс уг зөрчлийг үйлдэнэ гэж явцуурах нь хуулийн хийдэл үүсгэж болзошгүй тул субъектийг биш субьектив талын шинжийг тодорхой зааж /Зөрчлийн тухай хуулийн 9.7 дугаар зүйлийн 5, 11, 12 дахь хэсгүүдэд “болгоомжгүйгээр” гэж нэмж/ өгснөөр асуудлыг шийдвэрлэж болно. Өөрөөр хэлбэл, соёлын биет өвийг санаатайгаар гэмтээсэн тохиолдолд гэмт хэрэгт тооцон эрүүгийн хуулиар ял шийтгэж, соёлын биет өвийг болгоомжгүйгээр гэмтээсэн бол зөрчил гэж үзэн захиргааны хариуцлага хүлээлгэх нь зүйд нийцнэ. Энэ асуудал 25.1 дүгээр зүйлд мөн хамаатай.

Хүснэгт 5.5. *Соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж*

Соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 25.3 дугаар зүйл)	
Объект	Соёлын биет өвийг хамгаалах хууль, журам байна. Халдлагын зүйл нь биет өв байна.
Объектив тал	Соёлын биет өвийг завшсан, үрэгдүүлсэн идэвхтэй үйлдэл байна. Соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийн үндсэн шинж нь хохирол учирсан байхыг шаардахгүй, соёлын биет өвийг завшсан, үрэгдүүлснээр төгсдөг хэлбэрийн шинжтэй гэмт хэрэг юм.
Субъект	Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, хувь хүн байна. Тухайн хүн Монгол улсын иргэн, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн, хоёрдмол харьяалалтай хүн аль нь ч байж болно.
Субьектив тал	Гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн хүн өөрийн үйлдлийн хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж, түүнийг хүсэж үйлдсэн байна.
Анхаарах асуудал	
1. Бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэхийг гэмт хэргийг Хөрөнгө завших /17.4 дүгээр зүйл/, Болгоомжгүйгээр эд хөрөнгө устгах, гэмтээх, үрэгдүүлэх /17.11 дүгээр зүйл/, соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх /25.3 дугаар зүйл/ гэмт хэрэг болгон гэмт хэргийн бүрэлдэхүүний объект, халдлагын зүйл, субьектив шинжээр нь салган хуульчилсан. Соёлын өв нь ердийн эд хөрөнгөтэй харьцуулшгүй үнэ цэнтэй бөгөөд тэдгээрийг мөнгөн дүнгээр үнэлэхэд төвөгтэй тул ийнхүү онцлон үзсэн боловч ялын ялгамжтай байдал огт байхгүй байна. Соёлын биет өвийг завшсан, үрэгдүүлсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх ба бусдын итгэмжлэн хариуцуулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг завшсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Нийтэд тустай ажил хийлгэх ялыг эс тооцвол оногдуулах бусад ялын төрөл, хэмжээ яг адил байна. Энэ гэмт хэргийг итгэмжлэн хариуцсан хүн албан тушаалын байдлаа ашиглаж, мөн гэмт этгээдүүд зохион байгуулалттайгаар бүлэглэж үйлддэг гэдгийг харгалзан эдгээрийг хүндрүүлэх бүрэлдэхүүнд багтаах шаардлагатай. 2. Зөрчлийн тухай хуулийн 9.7 дугаар зүйлийн 12 дахь хэсэгт: Соёлын биет өвийг сурталчлах, судалгаа, шинжилгээ хийх, сургалт явуулах зориулалтаар ашиглахдаа ...үрэгдүүлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй, тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэжээ. Соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх гэмт хэрэг нь гэм буруугийн санаатай хэлбэрээр, уг зөрчил ч мөн гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэж болно. Энд зүйлчлэлийн асуудал үүсэж болзошгүй.	

Хүснэгт 5.6. *Хууль бусаар археологи, палеонтологийн хайгуул, малтлага хийх гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж*

Хууль бусаар археологи, палеонтологийн хайгуул, малтлага хийх гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 25.4 дүгээр зүйл)	
Объект	Соёлын өв, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах болон археологи, палеонтологийн малтлага, хайгуул, судалгаа хийх журам байна. Халдлагын зүйл нь археологи, палеонтологийн олдвор, эд өлгийн зүйл байна.
Объектив тал	Хууль бусаар археологи, палеонтологийн хайгуул, малтлага, судалгаа хийсэн идэвхтэй үйлдэл байна. Хууль бусаар археологи, палеонтологийн хайгуул, малтлага хийх гэмт хэргийн үндсэн шинж нь хохирол учирсан байхыг шаардахгүй, хууль бусаар археологи, палеонтологийн хайгуул, малтлага, судалгаа хийснээр төгсдөг хэлбэрийн шинжтэй гэмт хэрэг юм. Хүндрүүлэх шинжид хууль бус археологи, палеонтологийн хайгуул, малтлага, судалгааг санхүүжүүлсэн идэвхтэй үйлдэл байна.
Субъект	Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, хувь хүн байна. Тухайн хүн Монгол Улсын иргэн, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн, хоёрдмол харьяалалтай хүн аль нь ч байж болно. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.
Субьектив тал	Гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн хүн өөрийн үйлдлийн хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж, түүнийг хүсэж үйлдсэн байна.
Анхаарах асуудал	
1. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт хууль бус археологи, палеонтологийн хайгуул, малтлага, судалгааг санхүүжүүлсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан. Археологи, палеонтологийн хайгуул, малтлагын үйл ажиллагаа хүн хүч, багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, цаг хугацаа, хөрөнгө мөнгө багагүй шаардах болохоор судалгааны багаар гүйцэтгэдэг. Энэ утгаараа хууль бус малтлагыг ихэнхдээ бүлэглэж буюу зохион байгуулалттайгаар үйлдэнэ. Уг гэмт хэрэгт хэд хэдэн гүйцэтгэгч, зохион байгуулагч, хатгагч, хамжигч байж болох талтай. Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын олгосон зөвшөөрөлгүй гэдгийг мэдсээр байж газрын хөрс, хэвлийг ухаж соёлын биет өвийг хайх, олох, судлан шинжлэх үйл ажиллагаа эрхлэхэд мөнгө, техник хэрэгслийн тусламж үзүүлснийг санхүүжүүлсэн гэвэл хууль бус хайгуул, малтлага, судалгааг санхүүжүүлсэн буюу уг үйл ажиллагаанд тусламж, дэмжлэг үзүүлсэн этгээд 25.4 дүгээр зүйлийн 1-д заасан гэмт хэргийн хамжигч[15] болно. Хамжигч гэдэгт бусдыг гэмт хэрэг үйлдэхэд зааж зөвлөх, зэвсэг хэрэгсэл өгөх, учрах саадыг арилгах, унаа орон байраар хангах, мэдээлэл өгөх зэргээр гэмт хэрэг үйлдэхэд дэмжлэг үзүүлж[16] тусалсан этгээдийг хэлэх бөгөөд бусад оролцогчидтой, ялангуяа гүйцэтгэгч, зохион байгуулагчтай үйлдэх хэргийнхээ талаараа урьдчилан үгсэн тохиролцсон нэг санаа зорилготой, тэднийг хууль зөрчсөн нийгэм, иргэдэд аюултай хэрэг хийж байгааг мэддэг учраас гэмт хэргийн хамтран оролцогч болдог.[17] Хуулийн 25.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр зааж, санкцыг 25.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийнхээс нэмэгдүүлж тогтоосон нь ерөнхий ангийн 3.5 дугаар зүйлийн 2-т: Гэмт хэргийн хамжигчид гэмт хэрэг үйлдэхэд гүйцэтгэсэн үүрэг, үйлдлийн шинж чанарыг харгалзан шүүх энэ хуульд тухайн гэмт хэрэгт оногдуулахаар заасан ялын төрөл, хэмжээний дотор гүйцэтгэгчид оногдуулах ялаас ихгүй ял оногдуулна гэсэнтэй зөрчилдөнө. Эрүүгийн эрх зүй дэх ноёрхлын онолоор үүнийг зөвшөөрч болох ч тусад нь бие даасан зүйл (29.10 дугаар зүйл.Терроризмыг санхүүжүүлэх, 29.11 дүгээр зүйл.Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх зэрэгтэй адилаар) байхаар хуульчилбал таарна. Тэгэхээр энэ гэмт хэргийн хүндрүүлэх /25.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг/ шинжийг бүлэглэж (мөн гэмт этгээдүүд металл хайгч багаж, ухагч техник, тээврийн хэрэгсэл ашигладаг гэдгийг тооцон “тусгайлан бэлтгэсэн багаж, хэрэгсэл, машин механизм ашиглаж” гэж нэмэх) үйлдсэн байхаар өөрчилж дээрх хийдлийг арилгах боломжтой. Байнга тогтвортой болон зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдвэл онц хүндрүүлэх бүрэлдэхүүн байж болно.	

15 Эрүүгийн хуулийн 3.5 дугаар зүйл. Гэмт хэргийн хамжигч. 1.Урьдчилан амлаж бусдыг санаатай гэмт хэрэг үйлдэхэд дэмжлэг үзүүлсэн хүнийг гэмт хэргийн хамжигч гэнэ.

16 Д.Насанбат, А.Цэнгэл нар, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги /Сурах бичиг/, (Уб, 2018), 193 дахь тал.

17 Х.Доржпалам, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /Ерөнхий анги/, (Уб, 2019), 242 дахь тал.

Хүснэгт 5.7. *Соёлын биет өвийн хууль бус худалдааг зохион байгуулах, зуучлах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж*

Соёлын биет өвийн хууль бус худалдааг зохион байгуулах, зуучлах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 25.5 дугаар зүйл)	
Объект	Соёлын өв, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах болон соёлын биет өвийн дуудлага худалдаа зохион байгуулах журам байна. Халдлагын зүйл нь соёлын биет өв байна.
Объектив тал	Соёлын биет өвийн худалдааг хууль бусаар явуулсан, зуучилсан идэвхтэй үйлдэл байна.
Субъект	Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, хувь хүн байна. Тухайн хүн Монгол Улсын иргэн, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн, хоёрдмол харьяалалтай хүн аль нь ч байж болно.
Субьектив тал	Гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн хүн өөрийн үйлдлийн хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж, түүнийг хүсэж үйлдсэн байна.
Анхаарах асуудал	
1. Тус гэмт хэргийн объектив тал соёлын биет өвийн хууль бус худалдааг явуулсан, зуучилсан идэвхтэй үйлдэл бөгөөд Эрүүгийн эрх зүйн сурах бичигт соёлын биет өвийн хууль бус худалдааг явуулсан, зуучилсан гэж эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр соёлын биет өвийг олон нийт, тодорхой хүмүүсийн хүрээнд үнэ хаялцуулан худалдах үйл ажиллагааг зохион байгуулсан, энэхүү үйл ажиллагаанд зуучилсан үйлдлийг ойлгоно[18] гэвэл хууль бус худалдаа /худалдах, худалдан авах/-г зохион байгуулах /эрхлэх, явуулах/, зуучлахыг гэмт хэрэгт тооцжээ. Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг худалдах анхны саналыг төрд тавихгүйгээр худалдсан, эсхүл гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлсэн, эсхүл зуучилсан бол Зөрчлийн тухай хуулийн 9.7 дугаар зүйлийн 3-т заасны дагуу уг дурсгалт зүйлийг хураан авч улсын орлого болгон хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох арга хэмжээ авна. Хэн нэг этгээд түүх, соёлын үнэт дурсгалт зүйл болох палеонтологийн олдворыг гадаадын иргэнд зарвал тэрээр дуудлага худалдаа зохион байгуулаагүй бас зуучлаагүй тул гэмт хэрэг болохгүй, тухайн олдвор нь түүх, соёлын хосгүй үнэт бус үнэт зэрэглэлд хамаарах учир төрд санал тавихгүй худалдаж гадаадын иргэний өмчлөлд шилжүүлсэн нь зөрчил биш. Гэтэл соёлын өвийг хамгаалах тухай хуулиар ямар ч тохиолдолд палеонтологи, археологийн олдворыг худалдахыг хориглосон байдаг. Тиймээс эрүүгийн болон зөрчлийн хуулийн дээрх зохицуулалтуудыг дахин нягталж, тодорхой болгох шаардлагатай. Товчоор хэлбэл түүх, соёлын хосгүй үнэт, үнэт зүйл, археологи, палеонтологийн олдворыг хууль бусаар худалдсан, худалдан авсан, зуучилсан, хадгалсан үйлдлийг гэмт хэрэг, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлтэй холбоотой дээрх хууль бус үйлдлийг зөрчил байхаар хуульчлах юм. 2. Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол хүндрүүлэн үзэхээр заасан хэдий ч шинэчилсэн найруулгын анхны төсөлд байсан хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх /3 дахь/ хэсгийг 2017 оны 05 сарын 11-ны өдрийн хуулиар хүчингүй болгожээ. Хуулийн этгээд уг гэмт хэргийн субъект болох магадлал өндөр юм.	

Хүснэгт 5.8. *Түүх, соёлын дурсгалт зүйлийг тогтоосон хугацаанд хилээр оруулж ирэхгүй байх гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж*

Түүх, соёлын дурсгалт зүйлийг тогтоосон хугацаанд хилээр оруулж ирэхгүй байх гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 25.6 дугаар зүйл)	
Объект	Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах журам байна. Халдлагын зүйл нь түүх, соёлын дурсгалт зүйл байна.
Объектив тал	Түүх, соёлын дурсгалт зүйлийг хуулиар тогтоосон журмын дагуу тогтоосон хугацаанд улсын хилээр оруулж ирээгүй эс үйлдэхүй байна. Хүндрүүлэх шинжид түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлийг хуулиар тогтоосон журмын дагуу тогтоосон хугацаанд улсын хилээр оруулж ирээгүй, эсхүл түүх, соёлын дурсгалт зүйлийг завшсан идэвхтэй үйлдэл байна.

18 С.Гантулга, Б.Энхболд нар, Эрүүгийн эрх зүйн тусгай анги (Сурах бичиг), (Уб, 2018), 473 дахь тал.

Субъект	Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, хувь хүн байна. Тухайн хүн Монгол улсын иргэн, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн, хоёрдмол харьяалалтай хүн аль нь ч байж болно.
Субьектив тал	Гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн хүн өөрийн үйлдлийн хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж, түүнийг хүсэж үйлдсэн байна.
Анхаарах асуудал	
1. Энэ зүйлийн гарчиг ба 1 дэх хэсгийн халдлагын зүйлийг “Түүх, соёлын дурсгалт зүйл” гэсэн хуулиар тодорхойлсон нэр томьёоноос өөр байна. Соёлын өвийг хамгаалах тухай хуульд зааснаар соёлын биет өвийг түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон хөдлөх дурсгалт зүйл гэж ангилсан байдаг. Хуулийн хэллэг, агуулгын хувьд түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл гэвэл таарна. 2. Судлан шинжлүүлэх, сэргээн засварлах, үзэсгэлэнд оролцуулах, өмчлөгч язгуур зориулалтаар нь ашиглах зорилгоор зохих зөвшөөрлийн дагуу түр хугацаагаар түүх, соёлын дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлж болох ч тогтоосон хугацаанд буцаан авчрахгүй байхыг гэмт хэрэгт тооцох нь зөв. Энэ гэмт хэргийн 2 дахь хэсэг буюу хүндрүүлэх шинжид ...эсхүл түүх соёлын дурсгалт зүйлийг завшсан бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж заасан. Хүлээлгэх хариуцлагын хувьд “Хөрөнгө завших” гэмт хэргийг албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн, бусдад ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулж үйлдсэн тохиолдолд оногдуулах ялын төрөл, хэмжээтэй ижил байна. Дээрхээс үйлдлийн аргын төрлийг харгалзан түүх, соёлын дурсгалт зүйлийг гадаад улсад зөвшөөрөлтэйгөөр гаргаад завших үйлдлийг 25.3 дугаар зүйл буюу соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх “үндсэн” гэмт хэргийнх нь хүндрүүлэх шинж болгон хуульчилж, ялын хэмжээг нэмэгдүүлбэл зохино.	

Хүснэгт 5.9. *Эрдэнэсийн сангийн үндсэн санг хууль бусаар зарцуулах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж*

Эрдэнэсийн сангийн үндсэн санг хууль бусаар зарцуулах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 25.7 дугаар зүйл)	
Объект	Эрдэнэсийн сангийн тухай хууль тогтоомж байна. Халдлагын зүйл нь эрдэнэс байна.
Объектив тал	Эрдэнэсийн сангийн байнгын бус хэсгээс эрдэнэсийг худалдсан, шилжүүлсэн, захиран зарцуулсан идэвхтэй үйлдэл байна. Хүндрүүлэх шинжид эрдэнэсийн сангийн байнгын хэсгээс эрдэнэсийг худалдсан, шилжүүлсэн, захиран зарцуулсан үйлдэл байна.
Субъект	Монгол банк, эрдэнэсийн санг эрхлэх нэгжийн албан тушаалтан байна.
Субьектив тал	Гэм буруугийн санаатай хэлбэрээр буюу гэмт хэрэг үйлдсэн хүн өөрийн үйлдлийн хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж, түүнийг хүсэж үйлдсэн байна.
Анхаарах асуудал	
1. Эрдэнэсийн сангийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д “эрдэнэс” гэж түүхий эд, хайлш, химийн нэгдэл, бүтээгдэхүүн зэрэг ямар ч байдалд байгаа үнэт металл, эрдэнийн чулуу, түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйл, байгалийн төрцийг ойлгоно[19] гэзд үндсэн сангийн байнгын хэсэгт түүх, соёлын хосгүй үнэт зүйл, байнгын бус хэсэгт түүх, соёлын үнэт зүйл байхаар заасан. Соёлын өвийг хамгаалах тухай хуулиар ховор эрдэс, эрдэнийн чулууны ховор олдвор, солир нь түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлд хамаарах боловч үнэт металл, байгалийн төрц нь геологи, экологийн судлагдахуун юм. Үүнээс эрдэнэсийн сангийн үндсэн санг хууль бусаар зарцуулах гэмт хэрэг гэсэн томьёоллоор “Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг” бүлэгт багтах нь хэр зохимжтой вэ гэсэн асуулт гарна.	

19 Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт.

Хүснэгт 5.10. *Түүх, соёлын чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг Хулгайлах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж*

Түүх, соёлын чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.2 дахь заалт)	
Объект	Бусдын өмлөх эрх байна. Халдлагын зүйл нь түүх, соёлын чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйл байна.
Объектив тал	Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэж, эрх бүхий байгууллагын шийдвэрээр тусгайлан хамгаалсан соёлын өвийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан идэвхтэй үйлдэл байна. Байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон, зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол хүндрүүлж үзнэ.
Субъект	Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 14 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, тухайн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхгүй Монгол Улсын иргэн, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн, хоёрдмол харьяалалтай хүн байна.
Субьектив тал	Гэм буруугийн санаатай хэлбэрээр буюу гэмт хэрэг үйлдсэн хүн өөрийн үйлдлийн хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж, түүнийг хүсэж үйлдсэн байна.
Анхаарах асуудал	
1. Түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлийг хулгайлах гэж Соёлын өвийг хамгаалах тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэж, эрх бүхий байгууллагын шийдвэрээр тусгайлан хамгаалсан соёлын өвийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар хууль бусаар авсныг ойлгоно.[20] Үүнд “Түүх соёлын хосгүй үнэт зүйлсийн жагсаалт”-д оруулсан 778[21] зүйлээс гадна байгууллага, сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсын соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн соёлын биет өв хамаарна гэсэн үг. Нөгөөтээгүүр энэ заалтын нэр томьёог ойлгож хэрэглэхэд хүндрэл үүсэж болзошгүй. Яагаад гэвэл хууль тогтоогчоос Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.1-д заасан “тусгайлан хамгаалсан байр” гэдэгтэй утга давхцах[22] магадлалтай. Гэвч уг чанартаа тусгайлан хамгаалсан соёлын үнэт зүйлийг агуулж буй байр, агуулах нь нэвтрэхийг зөвшөөрөгдөөгүй, эсвэл тухайн цаг хугацаанд нэвтрэхийг хориглосон орон зай байх ба хориг саад хамгаалалтыг бусдад мэдэгдэхээр байршуулсан, эсвэл хориг саадтай болохыг анхааруулсан тэмдэг, тэмдэглэгээтэй[23], эсвэл гэр, орон сууц, музей, үзэсгэлэн, эрдэм шинжилгээний байгууллага, үйлчилгээний газар байхыг заавал шаардахгүй. Гагцхүү тухайн түүх, соёлын дурсгалт зүйл холбогдох шатны соёлын өвийн бүртгэл мэдээллийн санд бүртгэгдсэн нь гол шалгуур байх учиртай.	

Хүснэгт 5.11. *Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж*

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг)	
Объект	Улсын хил, гаалийн хилээр барааг нэвтрүүлэх, тээвэрлэх талаар тогтоосон журам байна. Халдлагын зүйл нь түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, музейн үзмэр байна.
Объектив тал	түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний амьтны, ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн, палеонтологийн олдвор, эд өлгийн зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн үйлдэл байна.
Субъект	Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, Монгол Улсын иргэн, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн хэн ч байж болно.

20 С.Гантулга, Б.Энхболд, Эрүүгийн эрх зүйн тусгай анги /Сурах бичиг/, (Уб, 2018), 181 дэх тал.

21 “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт батлах тухай” Засгийн газрын 1995 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 241 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтад Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 360 дугаар тогтоолоор 778 дахь заалтыг нэмсэн.

22 С.Нарангэрэл, Ж.Эрдэнэбулган, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: Үзэл баримтлал, уламжлал, сургамж, (Уб, 2019), 193 дахь тал.

23 Монголын криминологичдын холбоо, “УДШ-ийн 2019.10.30-ны №570 тогтоол”, Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэглээ, (Уб, 2020), 71 дэх тал.

Субьектив тал	Ашиг олох зорилготой, гэм бурyугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ.
Анхаарах асуудал	
1. Энэ гэмт хэргийн халдлагын зүйлийг давхардуулан тоочсон байна. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар эртний амьтны, ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн, палеонтологийн олдвор, эд өлгийн зүйл бүгд түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлд хамаарна. Эртний амьтан, ургамлын чулуужсан үлдэгдэл, ор мөрийг палеонтологийн олдвор[24] гэнэ. Зарим музейн үзмэрүүд ч түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлс байдаг ч бүгд тийм биш. Тэгэхээр халдлагын зүйлийг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, музейн үзмэрийг... гэвэл тохиромжтой. 2. Зөрчлийн тухай хуулийн 9.7 дугаар зүйлийн 1.Хуульд заасны дагуу: 1.4. түүх, соёлын дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эд зүйлийг хураах хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэсэн ойлгомжгүй зохицуулалт бий. Хууль заасны дагуу нэвтрүүлсэн бол зөрчил болохгүй, хууль бусаар нэвтрүүлсэн бол ямар ч тохиолдолд гэмт хэрэг гэж үзнэ.	

1.3. Гадаадын зарим орны соёлын өвийн эсрэг гэмт хэргийн зохицуулалт

Соёлын өвийн эсрэг гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг гадаад орнуудын эрүүгийн хууль тогтоомжтой харьцуулан судлах нь үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох, олон улсын жишигт нийцүүлэхэд чухал ач холбогдолтой. Дэлхийн улсуудын эрх зүйн тогтолцоо ялгаатай тул аливаа тусгаар тогтносон улс бусад улсын эрх зүй, хууль тогтоомжийг шууд хуулбарлан авах учиргүй, харин өөрийн газар зүйн байршил, соёл, уламжлал, улс төр, нийгмийн онцлогийг харгалзан үзсэний үндсэн дээр бүтээлчээр нутагшуулан авах нь зүйтэй.[25]

Эрүүгийн төрөлжсөн хуультай улсуудыг соёлын өвийн эсрэг гэмт хэргийг 1) бие даасан бүлэг болгон хуульчилсан, 2) халдлагын зүйлээр нь зүйл, хэсэг, заалт болгож оруулсан, 3) тусгайлан заагаагүй гэж 3 ангилж болно. Эдгээр ангиллын эхний 2-т хамаарах дараах 4 улсын эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг харьцуулан үзье.

Хүснэгт 5.12. *Гадаад орнуудын соёлын өвийн эсрэг гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг харьцуулсан нь*

БНХАУ-ын Эрүүгийн хууль	
3 дугаар бүлэг. Нийгэм, эдийн засгийн эсрэг гэмт хэрэг 2 дугаар хэсэг. Хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэг 151-р зүйл	2. Гадаадад гаргахыг хориглосон түүхийн дурсгалт зүйл, шар алт, мөнгө болон бусад үнэт металл, ховор амьтан, түүний эд эрхтнийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бол таван жилээс дээш арваас доошгүй жил хорих ял шийтгэж, мөнгөн торгууль оногдуулна. Хүндрүүлэх нөхцөл байдалтай бол арван жилээс дээш, эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэж, эд хөрөнгийг хураан авна. Хөнгөрүүлэх нөхцөл байдалтай бол таван жилээс доошгүй хугацаагаар хорих ял шийтгэж, мөнгөн торгууль оногдуулна. - Аж ахуйн нэгж энэ гэмт хэргийг үйлдсэн бол мөнгөн торгууль оногдуулж, удирдах албан тушаалтан болон холбогдох ажилтанд хариуцлага хүлээлгэнэ.

24 ШУА, Хууль зүйн үндэсний төв хамтран, Шинжлэх ухаан технологийн холбогдолтой эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл, (Уб, 2008), 495 дахь тал.

25 Ц.Цэлмэг, Д.Майцэцэг нар, *Харьцуулсан эрүүгийн эрх зүй /Магистрант, оюутнуудад зориулсан гарын авлага/,* (Уб, 2021), 22 дахь тал.

6 дугаар бүлэг Нийгмийн дэг журамд халдсан гэмт хэрэг 4 дүгээр хэсэг. Түүхэн дурсгалт зүйлд халдсан гэмт хэрэг 324-р зүйл	1. Улсын, мужийн, түүхийн дурсгалыг хамгаалах нэгжийн ховор нандин үнэт зүйл болон түүхийн дурсгалт зүйлийг санаатайгаар эвдэж сүйтгэсэн бол гурван жилээс доош хугацаатай хорих, эсхүл албадан хөдөлмөрлүүлэх ял шийтгэж, мөнгөн торгууль оногдуулна. Хүндрүүлэх нөхцөл байдал байвал гурваас дээш арваас доошгүй жилээр хорих ял шийтгэж, мөнгөн торгууль оногдуулна. 2. Улсын хамгаалалтын соёлын дурсгалт газрыг санаатайгаар эвдэж сүйтгэсэн нь хүнд ноцтой бол таван жилээс доошгүй хугацаагаар хорих, эсхүл албадан хөдөлмөрлүүлэх, эсхүл торгох ял шийтгэнэ. 3. Улсын, мужийн, түүхийн дурсгалыг хамгаалах нэгжийн ховор нандин үнэт зүйл болон түүхийн дурсгалт зүйлийг болгоомжгүйгээр эвдэж сүйтгэсэн нь хүнд ноцтой бол гурван жилээс доошгүй хугацаатай хорих, эсхүл албадан хөдөлмөрлүүлэх ял шийтгэнэ.
325-р зүйл	1. Соёлын өвийг хамгаалах хууль тогтоомжийг зөрчиж, гадаад улсад гаргахыг нь хориглосон ховор нандин түүхийн дурсгалт зүйлийг өөрийн дураараа худалдсан, гадаадын иргэнд бэлэглэсэн бол таван жилээс доош хугацаатай хорих, эсхүл албадан хөдөлмөрлүүлэх ял шийтгэж, мөнгөн торгууль оногдуулна. - Аж ахуйн нэгж энэ гэмт хэргийг үйлдсэн бол мөнгөн торгууль оногдуулж, удирдах албан тушаалтан болон холбогдох ажилтанд хариуцлага хүлээлгэнэ.
326-р зүйл	1. Ашиг олох зорилгоор улсын хамгаалалт бүхий түүхийн дурсгалт зүйлийг дамлан худалдаасан нь хүнд ноцтой бол таван жилээс доош хугацаатай хорих, эсхүл албадан хөдөлмөрлүүлэх ял шийтгэж, мөнгөн торгууль оногдуулна. Илүү онц ноцтой бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэж, мөнгөн торгууль оногдуулна. - Аж ахуйн нэгж энэ гэмт хэргийг үйлдсэн бол мөнгөн торгууль оногдуулж, удирдах албан тушаалтан болон холбогдох ажилтанд хариуцлага хүлээлгэнэ.
327-р зүйл	1. Үндэсний музей, номын сан зэрэг аж ахуйн нэгжүүд соёлын өвийг хамгаалах хууль тогтоомжийг зөрчиж, түүхийн дурсгалт зүйлийг худалдан борлуулсан, өөрийн дураар хувийн хэвшил, хувь хүнд шилжүүлэн өгсөн бол аж ахуйн нэгжид мөнгөн торгууль оногдуулж, удирдах албан тушаалтан болон холбогдох ажилтныг гурваас доошгүй жилээр хорих, эсхүл албадан хөдөлмөрлүүлэх ял шийтгэнэ.
328-р зүйл	1. Түүх, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнтэй эртний соёлын дурсгал, эртний булш бунхныг ухсан бол гурван жилээс дээш арван жилээс доош хугацаатай хорих ял шийтгэж, мөнгөн торгууль оногдуулна. Хөнгөрүүлэх нөхцөл байдалтай бол гурван жилээс доош хугацаатай хорих, эсхүл албадан хөдөлмөрлүүлэх, эсхүл тэнсэн харгалзаж, торгох ял шийтгэнэ. 2. Доорх үйлдлүүдийн аль нэгийг үйлдсэн бол арван жилээс дээш хугацаатай хорих, эсхүл бүх насаар нь хорьж мөнгөн торгууль оногдуулах, эсхүл эд хөрөнгийг хураан авах ял шийтгэнэ. /Нэг/ Улсын, мужийн, түүхийн дурсгалыг хамгаалах нэгжийн соёлын дурсгалт газар, эртний булш, бунхныг ухсан, /Хоёр/ Соёлын дурсгалт газар, эртний булш, бунхныг ухах хэргийг үйлдсэн гэмт бүлэглэлийн удирдсан, /Гурав/ Соёлын дурсгалт газар, эртний булш, бунхныг олон удаа ухсан, /Дөрөв/ Соёлын дурсгалт газар, эртний булш, бунхныг ухаж хүнд ноцтойгоор эвдэж сүйтгэсэн, эсхүл соёлын ховор нандин түүхийн дурсгалт зүйлийг авсан. 3. Улсын хамгаалалт дахь шинжлэх ухааны үнэ цэнэ бүхий эртний хүний болон сээр нуруутны чулуужсан олдворыг ухсан бол тус зүйлд заасны дагуу шийтгэнэ.

329-р зүйл	1. Улсын өмчлөл бүхий архивын бичиг баримтыг хулгайлсан, завшсан бол таван жилээс доош хугацаатай хорих, эсхүл албадан хөдөлмөрлүүлэх ял шийтгэнэ. 2. Хууль тогтоомж зөрчиж, улсын өмчлөл бүхий архивын бичиг баримтыг өөрийн дураар худалдсан, шилжүүлсэн нь хүнд ноцтой байвал гурван жилээс доош хугацаатай хорих, эсхүл албадан хөдөлмөрлүүлэх ял шийтгэнэ. 3. Дээрх 2 үйлдлийг хамт тус хуульд заасан бусад гэмт хэргийг үйлдсэн бол хүндрүүлэх нөхцөл байдалд тооцно.[26]
ОХУ-ын Эрүүгийн хууль	
21 дүгээр бүлэг. Өмчийн эсрэг гэмт хэрэг 164 дүгээр зүйл. Онцгой үнэ цэнтэй зүйлийг хууль бусаар олж авах	1. Түүх, шинжлэх ухаан, урлаг, соёлын онцгой үнэ цэнтэй эд зүйл, бичиг баримтыг хууль бусаар олж авсан бол түүний аргаас үл хамааран 500 мянга хүртэл рублиэр эсхүл ялтны 3 жил хүртэлх хугацааны цалин хөлс түүнтэй тэнцэх хэмжээний орлогоор торгох, эсхүл 1 жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах буюу хязгаарлахгүй, эсхүл 5 жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөрлүүлэх, эсхүл 10 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2. Энэ хэргийг: а) урьдчилсан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг, в) гэмт хэргийн улмаас энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эд зүйл, баримт бичиг устгагдсан, гэмтсэн бол 500 мянга хүртэл рублиэр эсхүл ялтны 3 жил хүртэлх хугацааны цалин хөлс түүнтэй тэнцэх хэмжээний орлогоор торгох, эсхүл 2 жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах буюу хязгаарлахгүй, 15 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
22 дугаар бүлэг. Эдийн засгийн үйл ажиллагааны салбар дахь гэмт хэрэг 190 дүгээр зүйл. Соёлын үнэт зүйлийг ОХУ-ын нутаг дэвсгэрт буцаан авчрахгүй байх	Оросын Холбооны улсын хууль тогтоомжийн дагуу тус улсын нутаг дэвсгэрээс экспортолсон соёлын үнэт зүйлийг ОХУ-ын хууль тогтоомжийн дагуу тогтоосон хугацаанд буцаан авчраагүй бол 1 сая рублиэр эсхүл ялтны 5 жил хүртэлх хугацааны цалин хөлс, түүнтэй тэнцэх хэмжээний орлогоор торгох буюу торгохгүйгээр 5 жил хүртэл хугацаагаар албанд хөдөлмөрлүүлэх, эсхүл 8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
24 дүгээр бүлэг. Олон нийтийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 226.1 дүгээр зүйл. ...соёлын үнэт зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх (контрабанд)	1. Евроазийн эдийн засгийн холбооны гаалийн хил, эсхүл Евроазийн эдийн засгийн холбооны гишүүн орнууд ОХУ-ын муж улсуудын хилээр улаан номд орсон төрөл зүйл, стратегийн ач холбогдол бүхий бараа, баялаг, соёлын үнэт зүйл, ховор зэрлэг амьтад, ОХУ-ын олон улсын гэрээгээр хамгаалагдсан усны болон биологийн нөөц, ургамал, мөөг ба тэдгээрийн эд хэсгийг хууль бусаар нэвтрүүлсэн 300 мянгаас хүртэл рублиэр эсхүл ялтны 1-3 жил хүртэлх хугацааны цалин хөлс, түүнтэй тэнцэх хэмжээний орлогоор торгох, эсхүл 5 жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөрлүүлэх, эсхүл мөн хугацаагаар хорих ял шийтгэнэ. Энэ зүйлийн 1, 1.1-д заасан хэргийг: а) албан тушаалын байдлаа ашиглаж, б) хил, гаалийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээдэд хүч хэрэглэж, в) урьдчилан тохиролцсон бүлэг этгээд, г) үйл олноор хөнөөх зэвсэг, хэрэгсэл, түүнийг бүтээхэд ашиглаж болох түүхий эд материал, шинжлэх ухаан, техник технологи, оюуны үйл ажиллагаа, техникийн мэдээлэлтэй холбоотой зүйлийг нэвтрүүлж үйлдсэн бол 1 сая рублиэр эсхүл ялтны 5 жил хүртэлх хугацааны цалин хөлс, түүнтэй тэнцэх хэмжээний орлогоор торгох буюу торгохгүйгээр 1 жил 6 сар хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах, эсхүл 5-10 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3. Энэ зүйлийн 1, 1.1, 2 дахь хэсэгт заасан хэргийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол 2 сая рублиэр эсхүл ялтны 5 жил хүртэлх хугацааны цалин хөлс, түүнтэй тэнцэх хэмжээний орлогоор торгох, эсхүл 2 хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах, эсхүл 7-12 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

26 中华人民共和国刑法（中华人民共和国惩罚犯罪的法律_百度百科，Холбоос:https://baike.baidu.com

25 дугаар бүлэг. Хүн амын эрүүл мэнд, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг 243 дугаар зүйл. ОХУ-ын ард түмний соёлын өв (түүх, соёлын дурсгал)-ийн бүртгэлд орсон соёлын үнэт зүйл, байгалийн цогцолбор, объектыг устгах, гэмтээх	1 ОХУ-ын ард түмний соёлын өв (түүх, соёлын дурсгал)-ийн улсын хамгаалалтад авсан түүх соёлын хөшөө дурсгал, байгалийн цогцолбор объект, соёлын үнэт зүйлийг устгасан, гэмтээсэн бол 3 сая хүртэл рублиэр эсхүл ялтны 3 жил хүртэлх хугацааны цалин хөлс, түүнтэй тэнцэх хэмжээний орлогоор торгох, эсхүл 400 цаг хүртэл хугацаагаар нийгэмд тустай ажил хийлгэх, эсхүл 3 жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөрлүүлэх, эсхүл мөн хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2. ОХУ-ын ард түмний соёлын өвийн онцгой үнэ цэнтэй объект, (түүх, соёлын дурсгал), Дэлхийн өвийн жагсаалт, музей, түүх, соёлын нөөц газар, ОХУ-ын соёлын өвийн нэгдсэн бүртгэлд орсон объект, хөшөө дурсгал, археологийн өвд бүхий объект, хөшөө дурсгалтай холбогдуулан дээрх үйлдлийг хийсэн бол 5 сая хүртэл рублиэр эсхүл ялтны 5 жил хүртэлх хугацааны цалин хөлс, түүнтэй тэнцэх хэмжээний орлогоор торгох, эсхүл 480 цаг хүртэл хугацаагаар нийгэмд тустай ажил хийлгэх, эсхүл 5 жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөрлүүлэх эсхүл 6 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
243.1 дүгээр зүйл. ОХУ-ын ард түмний соёлын өв (түүх, соёлын дурсгал)-ийн бүртгэлд орсон түүх, соёлын дурсгалт газар, соёлын өвийн объектыг хадгалах, ашиглах журам зөрчих	ОХУ-ын ард түмний соёлын өв (түүх, соёлын дурсгал)-ийн нэгдсэн бүртгэлд орсон ОХУ-ын түүх, соёлын дурсгалт газар, соёлын өвийн объектыг хадгалах, ашиглах журмыг зөрчсөн, эсхүл болгоомжгүйгээр тогтоосон соёлын өвийн объектыг их хэмжээгээр устгасан, гэмтээсэн бол 1 сая хүртэл рублиэр эсхүл ялтны 2 жил хүртэлх хугацааны цалин хөлс, түүнтэй тэнцэх хэмжээний орлогоор торгох, эсхүл 360 цаг хүртэл хугацаагаар нийгэмд тустай ажил хийлгэх, эсхүл 2 жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөрлүүлэх эсхүл мөн хугацаагаар хорих ял шийтгэнэ.
243.2 дугаар зүйл. Археологийн талбайд хууль бус малтлага хийх болон олдворыг авах	1.Археологийн олдворыг газрын гадарга, хэвлий, усан доор зөвшөөрөлгүй хайсан, эсхүл авсан, үүний улмаас соёлын давхаргыг гэмтэх, устахад хүргэсэн бол 500 мянга хүртэл рублиэр эсхүл ялтны 18 сар хүртэлх хугацааны цалин хөлс, түүнтэй тэнцэх хэмжээний орлогоор торгох, эсхүл 2 жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2. ОХУ-ын ард түмний соёлын өв (түүх, соёлын дурсгал)-ийн нэгдсэн бүртгэлд орсон газарт, эсхүл тодорхойлсон соёлын объектод үйлдсэн бол 700 мянга хүртэл рублиэр эсхүл ялтны 2 жил хүртэлх хугацааны цалин хөлс, түүнтэй тэнцэх хэмжээний орлогоор торгох, эсхүл 4 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3. Энэ хэргийг: а) хайгуулын тусгай техник хэрэгсэл, газар шорооны машин механизм ашиглаж, б) албан тушаалын байдлаа ашиглаж, в) урьдчилан тохиролцсон болон зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол 1 сая хүртэл рублиэр эсхүл ялтны 5 жил хүртэлх хугацааны цалин хөлс, түүнтэй тэнцэх хэмжээний орлогоор торгох, эсхүл тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэх эрхийг 5 жил хүртэл хугацаагаар хасах, эсхүл 5 жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөрлүүлэх эсхүл 6 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Тайлбар: 1. Энэ зүйлийн зорилгын дагуу хүн төрөлхтний оршин тогтнох ул мөр, түүний дотор зуу гаруй жилийн настай археологийн олдвор бүхий газар болон усан доорх давхаргыг соёлын давхарга гэж ойлгоно. 2.Энэ зүйл дэх хайгуулын тусгай техник хэрэгсэл гэж металл илрүүлэгч, радарууд, тухайн байршилд археологийн объект байгаа эсэхийг тодорхойлох соронзон төхөөрөмж болон бусад техник хэрэгслүүдийг хэлнэ.

243.3 дугаар зүйл. Газар шорооны ажил, барилга, нөхөн сэргээлт, аж ахуйн болон бусад ажил, эсхүл археологийн хээрийн судалгааны ажил гүйцэтгэгч нь үйл ажиллагааны явцад илрүүлсэн төрийн мэдэлд заавал шилжүүлэх соёлын үнэ цэнтэй объект, их хэмжээний соёлын эд зүйлийг шилжүүлэн өгөхөөс зайлсхийх	1. Газар шорооны ажил, барилга, нөхөн сэргээлт, аж ахуйн болон бусад ажил, эсхүл археологийн хээрийн судалгааны ажил гүйцэтгэгч нь үйл ажиллагааны явцад илрүүлсэн ОХУ-ын хууль тогтоомжийн дагуу төрийн мэдэлд заавал шилжүүлэх соёлын үнэ цэнтэй объект, их хэмжээний соёлын эд зүйлийг шилжүүлэн өгөхөөс зайлсхийсэн бол 500 мянга хүртэл рублиэр эсхүл ялтны 2 жил хүртэлх хугацааны цалин хөлс, түүнтэй тэнцэх хэмжээний орлогоор торгох, эсхүл тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэх эрхийг 5 жил хүртэл хугацаагаар хасах, эсхүл 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2. Энэ хэргийг: а) албан тушаалын байдлаа ашиглаж, б) урьдчилан тохиролцсон болон зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол 800 мянга хүртэл рублиэр эсхүл ялтны 3 жил хүртэлх хугацааны цалин хөлс, түүнтэй тэнцэх хэмжээний орлогоор торгох, эсхүл тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэх эрхийг 5 жил хүртэл хугацаагаар хасах, 200 мянга хүртэл рублиэр эсхүл ялтны 6 сар хүртэлх хугацааны цалин хөлс, түүнтэй тэнцэх хэмжээний орлогоор торгож, эсхүл торгохгүйгээр 1 жил 6 сар хүртэл хугацаагаар эрх чөлөөг нь хязгаарлах буюу хязгаарлахгүйгээр 6 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Тайлбар: Энэ зүйл дэх их хэмжээний соёлын эд зүйлийг зуун мянган рублиэс дээш үнийн дүнгээр тодорхойлсон болно.
243.4 дүгээр зүйл. Цэргийн булш, эх орны төлөө амь үрэгдэгсдийн дурсгалыг мөнхжүүлсэн, Оросын цэргийн алдар гавьяаны өдрүүдэд зориулсан хөшөө, дурсгал, бусад дурсгалын байгууламж, объектыг устгах, гэмтээх	1. ОХУ-ын нутаг дэвсгэрт болон хилийн гадна байрлах цэргийн булш, түүнчлэн эх орноо хамгаалж амь үрэгдэгсдийн дурсгалыг мөнхжүүлсэн дурсгалт газар, хөшөө, бусад дурсгалын байгууламж, объект, эсхүл ОХУ-ын цэргийн алдар гавьяаны өдрүүд, (цэргийн ажиллагаа явуулж буй газрын музей болон дурсгалын тэмдэг) түүнчлэн эх орноо хамгаалсан хүмүүст зориулсан хөшөө, бусад дурсгалын байгууламж, объектын түүх, соёлын ач холбогдол, ашиг сонирхолд хохирол учруулах зорилгоор устгасан, гэмтээсэн бол 3 сая хүртэл рублиэр эсхүл ялтны 3 жил хүртэлх хугацааны цалин хөлс, түүнтэй тэнцэх хэмжээний орлогоор торгох, эсхүл 3 жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөрлүүлэх эсхүл үүнтэй ижил хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2. Энэ гэмт хэргийг: а) урьдчилан тохиролцсон болон зохион байгуулалттай бүлэг, б) Аугаа эх орны дайнд эх орноо хамгаалж амь үрэгдэгсдийн дурсгалыг мөнхжүүлсэн цэргийн булш, түүнчлэн хөшөө, бусад дурсгалын байгууламж, объект, эсхүл Аугаа эх орны дайнтай холбоотой ОХУ-ын цэргийн алдар гавьяаны өдөр, (цэргийн ажиллагаа явуулж буй газрын музей болон дурсгалын тэмдэг) түүнчлэн эх орноо хамгаалсан хүмүүст зориулсан хөшөө, бусад дурсгалын байгууламж, объектын хохирол учруулж, в) хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж үйлдсэн бол 2-5 сая хүртэл рублиэр эсхүл ялтны 1-5 жил хүртэлх хугацааны цалин хөлс, түүнтэй тэнцэх хэмжээний орлогоор торгох, эсхүл 480 цаг хүртэл хугацаагаар нийгэмд тустай ажил хийлгэх, эсхүл 5 жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөрлүүлэх эсхүл үүнтэй ижил хугацаагаар хорих ял шийтгэнэ. [27]
ХБНГУ-ын Эрүүгийн хууль	
19 дүгээр бүлэг. Хулгайлах болон хууль бусаар эзэмших гэмт хэрэг 243 дугаар зүйл. Онц ноцтой хулгай	(1) Хулгайлах гэмт хэргийг онц ноцтойгоор үйлдсэн бол гурван сараас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 4. сүм эсвэл бусад төрлийн шашны зан үйл хийдэг барилга буюу өрөөнөөс мөргөл үйлдэх буюу шашны хүндэтгэл үзүүлэх зориулалт бүхий эд юмс хулгайлсан, 5. олон нийтэд нээлттэй түүвэр маягаар тавьсан буюу олон нийтийн хүртээл болгосон шинжлэх ухаан, урлаг, түүх эсвэл техникийн хөгжилд ач холбогдол бүхий эд зүйлийг хулгайлсан,[28]

27 Уголовный кодекс Российской Федерации, Холбоос: www.consultant.ru/document/cons_doc_LAW

28 Т.Золбоо, Монгол Улс болон Герман Улсын Эрүүгийн хууль, (Уб, 2023), 441 дэх тал.

27 дугаар бүлэг. Эд зүйлийг сүйтгэх 304 дүгээр зүйл. Нийтийн эзэмшлийн эд юмсыг сүйтгэх	(1) Улсын хэмжээний шашны нийгэмлэгийн хүндэтгэл үзүүлдэг объект, эсвэл бурханд мөргөл үйлдэхэд зориулагдсан эд юмс, эсвэл булш, олон нийтийн дурсгал, байгалийн дурсгал, олон нийтэд зориулсан цуглуулгад хадгалагдаж буй нийтэд үзэсгэлэн болгож дэлгэсэн урлагийн, шинжлэх ухааны, эсвэл гар урлалын объект, эсвэл нийтийн ашиглалт болон тохижилтод зориулагдсан зам, талбай, байгууламжийн объект зэргийг хууль бусаар гэмтээсэн эсвэл устгасан бол гурван жил хүртэл хугацаагаар хорих эсвэл торгох ял шийтгэнэ. (2) Зөвшөөрөлгүйгээр энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эд юмсыг үзэгдэх байдлыг үлэмж хэмжээгээр бүрмөсөн өөрчилсөн бол мөн адил ял шийтгэнэ. (3) Уг гэмт хэргийн завдалтад ял оногдуулна.[29]
Бүгд Найрамдах Казахстан Улсын Эрүүгийн хууль	
4 дүгээр бүлэг. Хүн төрөлхтөн, энх тайвны эсрэг гэмт хэрэг 167 дугаар зүйл. Олон улсын гэрээгээр хамгаалагдсан тэмдгийг хууль бусаар ашиглах.	1. Цэргийн ажиллагааны явцад олон улсын гэрээг зөрчиж, Улаан загалмай, Улаан хавирган сар, Улаан болор, эсвэл соёлын үнэт зүйлийн хамгаалалтын тэмдэг, эсхүл олон улсын эрх зүйгээр хамгаалагдсан тэмдэг, эсвэл дайсан, төвийг сахигч улсын үндэсний болон төрийн далбаа, олон улсын байгууллагын туг, тэмдгийг хууль бусаар ашигласан бол 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
6 дугаар бүлэг. Өмчийн эсрэг гэмт хэрэг 193 дугаар зүйл. Онцгой үнэ бүхий зүйлийг хууль бусаар олж авах	1. Түүх, шинжлэх ухаан, урлаг, соёлын онцгой үнэт зүйл болох эд зүйлс эсхүл бичиг баримтыг хууль бусаар олж авсан бол түүний аргаас үл хамааран эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр 3-6 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2. Энэ гэмт хэргийг: 1/ урьдчилан үгсэн тохиролцсон бүлэг хүмүүс, 2/ давтан үйлдсэн бол эд хөрөнгийг хурааж 7-10 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3.Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг: 1/ гэмт бүлэглэл 2/ эхний хэсэгт заасан эд зүйл, баримт бичгийг устгаж, гэмтээсэн бол эд хөрөнгийг хурааж 10-12 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
196 дугаар зүйл. Хууль бус эд хөрөнгийг худалдаж авах, эзэмших	1. Хууль бус болох нь илэрхий эд хөрөнгийг урьдчилан амлахгүйгээр худалдаж авсан, эсхүл эзэмшсэн бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр 160 хүртэл тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний мөнгөөр торгох, эсхүл 160 цаг хүртэл хугацаагаар нийтийн ажил хийлгэх, эсхүл 40 хоног хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. 2. Энэ гэмт хэргийг давтан үйлдсэн бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр 200 хүртэл тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний мөнгөөр торгох, эсхүл 200 цаг хүртэл хугацаагаар нийт, эсхүл 50 хоног хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. 3. Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан үйлдэл нь: 1/ Их хэмжээний тээврийн хэрэгсэл, газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, бусад эд хөрөнгөтэй холбоотой, 2/ урьдчилан үгсэн тохиролцсон бүлэг хүмүүс, 3/ түүх, шинжлэх ухаан, урлаг, соёлын онцгой үнэ цэнэ бүхий эд зүйл, бичиг баримт, түүх, соёлын хөшөө дурсгалтай холбоотой бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр 4000 нэгжтэй тэнцэх хэмжээний мөнгөөр торгох, 1000 цаг хүртэл хугацаагаар нийтийн ажил хийлгэх, эсхүл үүнтэй ижил хэмжээгээр албадан хөдөлмөрлүүлэх, эсхүл 4 жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг нь хязгаарлах, эсхүл ижил хугацаагаар эрх чөлөөг хасах ял шийтгэнэ.

29 Мөн тэнд. 461 дэх тал.

	4. Энэ зүйлийн 1, 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг гэмт бүлэг, эсхүл албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр тодорхой албан тушаал эрхлэх, эсхүл тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг 3 жил хүртэл хугацаагаар хасаж, эрх чөлөөг 5 жил хүртэл хугацаагаар хязгаарлах, эсхүл үүнтэй ижил хугацаагаар эрх чөлөөг хасах ял шийтгэнэ.
203 дугаар зүйл. Онцгой үнэ цэнтэй зүйлийг санаатай устгах, гэмтээх, экспортлох	1. Улсын хамгаалалтад авагдсан түүх, соёлын дурсгал, байгалийн цогцолбор газар, объект, түүнчлэн түүх, шинжлэх ухаан, урлаг, соёлын онцгой үнэ цэнэ бүхий эд зүйл, бичиг баримтыг устгасан, гэмтээсэн бол 3-7 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 1-1. Үндэсний соёлын үнэт зүйл, эд юмсыг Бүгд Найрамдах Казахстан Улсаас хууль бусаар экспортолсон, эсхүл Бүгд Найрамдах Казахстан Улсад буцаан авчраагүй бол 3-7 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийг: галдан шатаах, дэлбэлэх болон бусад аюултай аргаар үйлдсэн, хайхрамжгүй хандсанаас хүний эрүүл мэндэд хүнд болон дунд зэргийн хохирол учруулсан, нийгэм, үндэстэн, арьс өнгө, шашны дайсагналын үндсэн дээр үйлдсэн бол 5-10 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3. Энэ зүйлийн 1, 2 дугаар хэсэгт заасан үйлдлийн улмаас хүний амь нас хохирсон бол 7-12 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
10 дугаар бүлэг. Олон нийтийн дэг журам, аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 294 дүгээр зүйл. Вандализм	Вандализм, өөрөөр хэлбэл улсын хамгаалалтад байгаа түүх, соёлын дурсгалт зүйлс, түүх, соёлын хөшөө, дурсгал, байгалийн объектод бичээс, зураг зурах, эсхүл олон нийтийн ёс суртахууныг доромжилсон бусад үйлдэл хийсэн бол 5-160 хүртэл хэмжээний нэгжтэй тэнцэх мөнгөөр торгох, эсхүл 160 цаг хүртэл хугацаагаар нийтийн ажил хийлгэх, эсхүл ижил хугацаагаар албадан хөдөлмөрлүүлэх, эсхүл 40 хоног хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.
295 дугаар зүйл. Хууль бусаар археологийн ажил хийх	1.Археологийн ажил хууль бусаар хийсэн бол 2000 хүртэл хэмжээний нэгжтэй тэнцэх мөнгөөр торгох, эсхүл 600 цаг хүртэл хугацаагаар нийтийн ажил хийлгэх, эсхүл ижил хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэх эрхийг 3 жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр 2 жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах, эсхүл мөн хугацаагаар эрх чөлөөг нь хасна. 2. Энэ хэргийг: 1) урьдчилан үгсэн тохиролцсон бүлэг, 2) давтан, 3) албан тушаалын байдлаа ашиглаж, 4) хайгуулын тусгай техник хэрэгсэл (металл илрүүлэгч, радар, соронзон төхөөрөмж, тухайн газарт археологийн эд зүйл байгаа эсэхийг тодорхойлох бусад техник хэрэгсэл), эсхүл ухагч машин ашиглаж үйлдсэн бол 5000 хүртэл хэмжээний нэгжтэй тэнцэх мөнгөөр торгох, эсхүл 1200 цаг хүртэл хугацаагаар нийтийн үйлчилгээ хийлгэх, эсхүл ижил хугацаагаар албадан хөдөлмөрлүүлэх, эсхүл тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэх эрхийг 3 жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр 5 жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах, эсхүл мөн хугацаагаар эрх чөлөөг нь хасах ял шийтгэнэ.[30]

Хөрш орнууд болох БНХАУ,ОХУ-ын эрүүгийн хуулиуд, Монгол Улсын эрүүгийн эрх зүйн хууль тогтоомжийг боловсронгуй болгоход гол суурь болсон ХБНГУ-ын эрүүгийн хууль, нүүдлийн соёл иргэншил, эртний түүхээрээ харилцан хамааралтай, өдгөө түүх судлал, археологийн судалгааны салбарт тэргүүлэх эгнээнд хамтран ажиллаж буй Бүгд Найрамдах Казакстан улсын эрүүгийн хуулийн соёлын өвийн эсрэг гэмт хэргийн зохицуулалтыг судлан үзэхэд:

30 Penal Code of the Republic of Kazakhstan, 3 July 2014, No. 226-V, Холбоос: www.gov.kz/legalacts/details/

БНХАУ-ын Эрүүгийн хуульд түүх, соёлын дурсгалт зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлсэн, санаатай болон болгоомжгүйгээр эвдэж сүйтгэсэн, зөвшөөрөлгүй худалдсан, гадаадын иргэнд бэлэглэсэн, бусдад шилжүүлсэн, эртний булш, бунхныг ухсан, архивын бичиг баримтыг хулгайлсан, завшсан, худалдсан, шилжүүлсэн зэрэг үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцож, зарим гэмт хэргийг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн бол бүх насаар нь хорих ял хүртэл оногдуулахаар заажээ.

Түүх, соёлын дурсгалт зүйлд халдсан гэмт хэргүүдийг (7 зүйл бүхий) бие даасан хэсэг болгож, гадаад улсад гаргахыг хориглосон түүхийн дурсгалт зүйлийг хил нэвтрүүлэх гэмт хэргийг “Нийгэм, эдийн засгийн эсрэг гэмт хэрэг” бүлэгт хуульчилсан нь Монгол Улсын эрүүгийн хуулийн зохицуулалттай тогтолцооны хувьд адил байна.

Эдгээр гэмт хэргүүдэд оногдуулах ялын хэмжээ харьцангуй өндөр байгаагаас гадна зарим тохиолдолд торгох болон хорих ялыг хамт оногдуулдаг онцлогтой ажээ. Түүнчлэн улс, мужийн хамгаалалтад авагдсан түүх, соёлын ховор нандин болон дурсгалт зүйлийг болгоомжгүйгээр эвдэн сүйтгэж хүнд ноцтой хохирол учруулбал эрүүгийн хариуцлага хүлээлгэх ба хувь хүн, аж ахуйн нэгж, албан тушаалтан хууль зөрчиж түүх, соёлын дурсгалт зүйлийг зөвшөөрөлгүй худалдсан, гадаадын иргэнд бэлэглэсэн, дамлан худалдсан, шилжүүлсэн бол гэмт хэрэг болно. Мөн тус хуулийн 328 дугаар зүйлийн 2 дахь заалт манай улсын ЭХТА-ийн 25.4 дүгээр зүйлд зааснаас илүү нарийн зохицуулалтыг агуулжээ. Тодруулбал, 1) улс, муж, байгууллагын хамгаалалтад байх дурсгалт газар, эртний булш, бунхныг ухсан, 2) дурсгалт газар, эртний булш, бунхныг ухахдаа хүнд ноцтойгоор эвдэж сүйтгэсэн, эсхүл хосгүй үнэт олдворыг авсан, 3) энэ гэмт хэргийг давтан үйлдсэн, 4) энэ хэргийг үйлдсэн гэмт бүлэглэлийг удирдсан бол хүндрүүлж үзсэн байна.

Мөн тус хэсгийн 329 дүгээр зүйлд улсын өмчлөлийн архивын бичиг баримтыг хулгайлсан, завшсан, хууль зөрчиж худалдсан, шилжүүлсэн бол 3 ба 5 жилээс доош хугацаагаар хорих, эсхүл албадан хөдөлмөрлүүлэх ял шийтгэхээр хуульчилжээ. Үүнийг Монгол Улсын хууль тогтоомжтой жишин үзвэл Үндэсний архивын сан хөмрөг нь өмчийн хэлбэрээс үл хамааран төрийн хамгаалалтад байх бөгөөд архивын баримт нь түүх, соёл, шинжлэх ухаан, техник технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлд хамаарах учир архивын бичиг баримтыг хулгайлсан бол ЭХТА-ийн 17.1 дүгээр зүйлийн 2.2 дахь заалтаар эрүүгийн хариуцлага хүлээлгэж, бусад тохиолдолд (завших, худалдах, шилжүүлэх) Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулийн холбогдох зүйлээр ял, шийтгэл оногдуулахаар байна.

ОХУ-д соёлын үнэт зүйлийг хууль бусаар олж авсан, гадаадад гаргасан соёлын үнэт зүйлийг буцаан авчраагүй, улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн, улсын хамгаалалтад авсан түүх соёлын хөшөө дурсгал, байгалийн цогцолбор объект, соёлын үнэт зүйлийг устгасан, гэмтээсэн, хадгалах, хамгаалах журам зөрчсөн, археологийн хууль бус хайгуул хийсэн, олдворыг авсан, үүний улмаас соёлын давхаргыг гэмтэх, устахад хүргэсэн, зөвшөөрөл бүхий газар, шороо барилгын ажлын явцад олсон олдвор, дурсгалт зүйлийг улсад шилжүүлэн өгөхөөс зайлсхийсэн, цэргийн булш, эх орныхоо төлөө амь үрэгдэгсдийн дурсгалыг мөнхжүүлсэн, гавьяаны өдөрт зохиулсан хөшөө, дурсгал, байгууламж, объектыг устгасан, гэмтээсэн үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцож, Эрүүгийн хуулийнхаа тусгай ангийн 4 бүлэгт 8 зүйл болгон хуульчилсан байна.

Түүх, шинжлэх ухаан, урлаг, соёлын онцгой үнэ цэнтэй эд зүйл, бичиг баримтыг зөвхөн хулгайлах бус үйлдлийн арга харгалзахгүйгээр хууль бусаар олж авсан, ОХУ-ын соёлын өвийн нэгдсэн бүртгэлд орсон түүх, соёлын дурсгалт газар, соёлын өвийн объектыг хадгалах, ашиглах журмыг зөрчсөн, эсхүл соёлын өвийн объектыг болгоомжгүйгээр гэмтээж, эсхүл устгаж их хэмжээний хохирол учруулсан үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцсон нь манай ЭХ-ийн зохицуулалтаас илүү байна. ОХУ-ын нутаг дэвсгэрт болон хилийн гадна орших цэргийн булш, эх орноо хамгаалж амь үрэгдэгсдийн дурсгалын хөшөө, байгууламж, объектыг устгах, гэмтээхийг соёлын өв, үнэт зүйлийг устгах, гэмтээх гэмт хэргээс тусад (243.4 дүгээр зүйл) нь хуульчилжээ. Түүнчлэн хууль бус археологийн хайгуул, малтлагын хийсэн болон хууль бус хайгуул, малтлага хийх явцдаа археологийн олдвор бүхий газар болон усан доорх соёлын давхаргыг устгаж, гэмтээсэн үйлдлүүдийг нэг зүйл (243.2)-д багтаасан нь Монгол Улсын ЭХТА-ийн 25.2, 25.4 дүгээр зүйлийн объектив талын шинжийг хамтад нь оруулсан гэсэн үг юм. Мөн түүх, соёлын үнэт эд зүйл, бичиг баримтыг хууль бусаар олж авах явахдаа устгасан, гэмтээснийг уг гэмт хэргийн хүндрүүлэх шинжид оруулсан байна. Эдгээр зохицуулалт нь тухайн хэргийг давхар зүйлчлэхгүйгээр нийгмийн хор аюулын шинжээр нь зохих ялыг оногдуулж шийдвэрлэх боломжийг бүрдүүлжээ.

ХБНГУ-ын Эрүүгийн хуульд сүм хийдээс шашны эд зүйл, олон нийтийн хүртээл болгосон түүх, урлагийн ач холбогдол бүхий эд зүйлийг хулгайлсан бол ноцтой хэрэг гэж үзээд арван жил хүртэл хугацаагаар хорих ял, шашны хүндэтгэлийн объект, эд зүйлс, булш, олон нийтийн болон байгалийн дурсгал, нийтэд үзэсгэлэн болгож дэлгэсэн урлагийн, гар урлалын объектыг устгасан, гэмтээсэн, үзэгдэх байдлыг үлэмж хэмжээгээр өөрчилсөн, завдсан тохиолдолд торгох, гурван жил хүртэл хорих ял оногдуулахаар хуульчилсан байна. Түүх, соёлын эд зүйлийг хулгайлах гэмт хэрэгт оногдуулах ялын дээд хэмжээ харьцангуй өндөр байгаагийн зэрэгцээ хүндэтгэл, дурсгал, урлагийн объектын харагдах байдлыг үлэмж хэмжээгээр өөрчилсөн үйлдлийг гэмт хэрэгт тооцсон байна.

Бүгд Найрамдах Казакстан Улсын Эрүүгийн хуульд соёлын үнэт зүйлийн хамгаалалтын тэмдгийг хууль бусаар ашигласан, түүх, шинжлэх ухаан, урлаг, соёлын онцгой үнэт зүйл болох эд зүйлс эсхүл бичиг баримтыг хууль бусаар олж авсан, хууль бус болох илэрхий түүх, шинжлэх ухаан, соёл, урлагийн үнэ цэнэ бүхий зүйлийг худалдаж авсан, соёлын үнэт зүйлийг устгасан, гэмтээсэн, хууль бусаар экспортолсон, тогтоосон хугацаанд буцаан авчраагүй, түүх, соёлын дурсгалт зүйл, хөшөө, байгалийн объектод бичиг, зураг зурах, бусад доромжилсон үйлдэл хийсэн, археологийн ажил хууль бусаар хийсэн бол гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тусгажээ.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн зохицуулалттай адил түүх, соёлын үнэт зүйл, баримт бичгийг хууль бусаар олж авах гэмт хэрэг түүний үйлдлийн аргаас үл хамаарах бөгөөд ингэхдээ утгасан, гэмтээсэн бол хүндрүүлэн үзжээ. Манай улсын ЭХ-д байхгүй өөрмөц зүйл нь соёлын үнэт зүйлийн хамгаалалтын тэмдгийг хууль бусаар ашиглах гэмт хэрэг юм. Мөн хууль бус болох нь илт тодорхой соёл, урлагийн үнэ цэнэ бүхий зүйлийг урьдчилан амлахгүйгээр худалдаж авсан болон вандализм буюу түүх, соёлын дурсгалт зүйл, хөшөө, байгалийн объектод бичиг, зураг зурсан, доромжилсон үйлдлүүд тусдаа бие даасан гэмт хэрэг болдог ажээ.

Хууль бусаар археологийн ажил хийх гэмт хэргийг урьдчилан үгсэн тохиролцсон бүлэг, давтан, албан тушаалын байдлаа ашиглаж, металл илрүүлэгч, радар, соронзон төхөөрөмж гэх мэт хайгуулын тусгай техник хэрэгсэл, шороо ухагч машин ашиглаж үйлдсэн нь хүндрүүлэх бүрэлдэхүүн болох бөгөөд ОХУ-ын ЭХТА-ийн 243.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгтэй ижил байна.

1.4. Бүлгийн дүгнэлт

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд “Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг”-ийг тусад нь бие даасан (7 зүйл бүхий) бүлэг болгож, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлтэй холбоотой хулгайлах болон улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх үйлдлийг эдгээр гэмт хэргийг хүндрүүлэх шинж байхаар тус тус хуульчилсан нь Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэнд анх удаа соёлын өвийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг шинэ тогтолцоог бий болгожээ. Өөрөөр хэлбэл өмнөх үеийн Шүүх цаазын бичиг, Эрүүгийн хуулиудад байгаагүй бүлэг, зүйл, заалтуудыг тусгасан байна. Тэр дундаа 2002 оны Эрүүгийн хуультай харьцуулахад зарим гэмт хэрэгт оногдуулах торгох ялын хэмжээ буурсан, дайны үед хориглосон арга, хэрэгсэл хэрэглэх (29.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг) гэмт хэргийн халдлагын зүйлийн нэршлийг өөрчилсөн зэргийг эс тооцвол ерөнхийдөө эрх зүйн хийдэл багатай сайн зохицуулалт болжээ.

Гэхдээ ЭХТА-ийн соёлын өвийн эсрэг болон өмчийн эсрэг, эдийн засгийн гэмт хэрэг бүлэгт орсон соёлын өвд халдсан нийт 9 гэмт хэргийг бүрэлдэхүүнийг задлан шинжилбэл засаж өөрчлөх, анхаарах хэд хэдэн асуудал байна. Тухайлбал, ЭХТА-ийн 25.1, 25.2 дугаар зүйлд заасан /түүх, соёлын дурсгалт зүйл болон түүх соёлын үл хөдлөх дурсгалыг эвдэх, гэмтээх, устгах/ гэмт хэргийн үйлдлийн арга, зөрчлөөс ялгагдах шинж, 25.3 дугаар зүйлд заасан /соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх/ гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн, 25.4 дүгээр зүйлд заасан / хууль бусаар археологи, палеонтологийн хайгуул, малтлага хийх/ гэмт хэргийн хамтран оролцогч, хүндрүүлэх шинж, зүйлчлэл, 25.5 дугаар зүйлд заасан /соёлын биет өвийн хууль бус худалдааг зохион байгуулах, зуучлах/ гэмт хэргийн субъект, объектив тал, 25.6 дугаар зүйлд заасан /түүх, соёлын дурсгалт зүйлийг тогтоосон хугацаанд хилээр оруулж ирэхгүй байх/ гэмт хэргийн халдлагын зүйл, хүндрүүлэх шинж, мөн хулгайлах /17.1 дүгээр зүйлийн 2.2 дахь хэсэг/, улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх /18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг/ гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүний халдагын зүйлийг засварлах шаардлагатай. Мөн зарим хэргийн ялын төрөл, хэмжээг эргэн харах нь зүйтэй.

Эрүүгийн эрх зүйн тогтолцоо ижил болон хөрш орнуудын соёлын өвийн эсрэг гэмт хэргийн зохицуулалтыг судлан үзэхэд манай улсынхаа адил төстэй, эсхүл өөр, илүү нарийн зүйл, заалтуудыг агуулжээ. БНХАУ, ОХУ-ын Эрүүгийн хуулиар түүх, соёлын дурсгалт зүйлийг болгоомжгүйгээр устгасан, гэмтээсний улмаас хүнд хохирол учруулсан бол гэмт хэрэг болдог, ОХУ, Бүгд Найрамдах Казакстан Улсын Эрүүгийн хуульд зааснаар түүх, шинжлэх ухаан, урлаг, соёлын онцгой үнэ цэнтэй эд зүйл, бичиг баримтыг хууль бусаар олж авсныг үйлдлийн арга харгалзахгүйгээр (дээрэмдэх, залилах г.м) эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, археологийн хууль бус хайгуул, малтлага хийх гэмт хэргийг урьдчилан үгсэн тохиролцсон бүлэг, давтан, албан тушаалын байдлаа ашиглаж, металл илрүүлэгч, радар, соронзон төхөөрөмж, ухагч машин ашиглаж үйлдсэн, эсхүл энэ гэмт хэргийн улмаас соёлын

биет өв устаж гэмтвэл хүндрүүлэх шинж болгон үзсэн нь Монгол Улсын ЭХТА-ийн зохицуулалтаас илүү нарийн юм. Түүнчлэн манай эрүүгийн хуульд байдаггүй соёлын үнэт зүйлийн хамгаалалтын тэмдгийг хууль бусаар ашиглах, хууль бус болох нь илт тодорхой соёлын дурсгалт зүйлийг худалдаж авах үйлдлийг гэмт хэрэгт тооцдог зохицуулалт Бүгд Найрамдах Казакстан Улсын Эрүүгийн хуульд байна. Мөн БНХАУ, ХБНГУ-д энэ төрлийн гэмт хэрэгт оногдуулах хорих ялын дээд хэмжээ харьцангуй өндөр ажээ.

ХОЁР. СОЁЛЫН ӨВИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2.1. Бүртгэж шалгасан соёлын өвийн эсрэг гэмт хэргийн судалгаа

2002 оны Эрүүгийн хууль хүчин төгөлдөр байх хугацаанд музей, сүм хийд зэрэг газруудаас түүх, соёлын дурсгалт зүйл хулгайлсан 40 гэмт хэрэг, иргэдийн үе дамжсан бурхан, шашны эд хэрэглэл, эртний хийцтэй хөөрөг, мөнгөн аяга, унжлага, эмээл, хаш соруул гэх мэт зүйлийг хулгайлсан 325 гэмт хэрэг (1999-2013 он), булаасан гэмт хэрэг 5 (2008-2011 он), дээрэмдсэн гэмт хэрэг 18 (2000-2012 он), залилан мэхэлж авсан гэмт хэрэг 7 (2008-2012 он), завшиж, үрэгдүүлсэн гэмт хэрэг 12 (1997-2012 он), хууль бусаар улсын хил нэвтрүүлсэн гэмт хэрэг 13 (2010-2013 он) тус тус цагдаагийн байгууллагад бүртгэгдэн шалгагдсан[31] тоо мэдээлэл байна.

Тухайн үед ЭХТА-д соёлын өвтэй холбоотой гэмт хэргийн бие даасан бүлэг, зүйл байгаагүй, түүх, соёлын дурсгалт зүйл мөн эсэхийг тогтооход хүндрэлтэй зэргээс бүртгэгдэн шалгагдсан гэмт хэргийн статистик мэдээ зөв гарахгүй байх, тоо зөрөх тохиолдол гарахын зэрэгцээ энэ төрлийн гэмт хэргийн нэгдсэн болон хэсэгчилсэн мэдээлэл, судалгаа хийгддэггүй байв.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөж эхэлснээс хойших буюу 2017 оны 07 сараас 2024 оны 04 сар хүртэлх хугацаанд Цагдаагийн байгууллагад:

- Хулгайлах /ЭХТА-ийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг/ гэмт хэрэг (иргэн, аж ахуй нэгжээс алдагдсан түүх, соёл, эртний эдлэл, зоос, судар, бурхан, хиргисүүр, булш) – 406,
- Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх /ЭХТА-ийн 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг/ гэмт хэрэг (түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний амьтны, ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн, палеонтологийн олдвор, эд өлгийн зүйлийг улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн) – 25,
- Түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах /ЭХТА-ийн 25.1 дүгээр зүйл/ гэмт хэрэг – 5,
- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг эвдэх, гэмтээх, устгах /ЭХТА-ийн 25.2 дугаар зүйл/ гэмт хэрэг – 7,
- Соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх /ЭХТА-ийн 25.3 дугаар зүйл/ гэмт хэрэг – 5,
- Хууль бусаар археологи, палеонтологийн малтлага хайгуул, малтлага хийх /ЭХТА-ийн 25.4 дүгээр зүйл/ гэмт хэрэг – 18,
- Соёлын биет өвийн хууль бус худалдааг зохион байгуулах, зуучлах /ЭХТА-ийн 25.5 дугаар зүйл/ гэмт хэрэг – 12 тус тус бүртгэгджээ. Харин түүх, соёлын дурсгалт зүйлийг тогтоосон хугацаанд оруулж ирэхгүй байх /ЭХТА-ийн 25.6 дугаар зүйл/ болон эрдэнэсийн сангийн үндсэн санг хууль бусаар зарцуулах /ЭХТА-ийн 25.7 дугаар зүйл/ гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.[32]

31 Ч.Доржсүрэн, Түүх, соёлын дурсгалт зүйлтэй холбоотой гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн асуудал, Магистрын судалгааны ажил, (Уб, 2013), 52-53 дахь тал.

32 ЦЕГ-ын Мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба, Соёлын өвийн эсрэг гэмт хэргийн судалгаа, 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр.

Хүснэгт 5.13. *Бүртгэгдсэн гэмт хэргийн тоон мэдээлэл (2017-2024 он)*

ЭХТА-ийн холбогдох зүйл, хэсэг, заалт	2017.07-12 сар	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024.04 сар
17.1 дүгээр зүйл 2.2 заалт	60	130	44	53	35	42	40	2
18.5 дугаар зүйл 3 хэсэг	2	5	12	-	-	-	3	3
25.1 дүгээр зүйл	-	1	1	1	-	-	2	-
25.2 дугаар зүйл	-	-	1	-	5	1	-	-
25.3 дугаар зүйл	-	-	1	3	1	-	-	-
25.4 дүгээр зүйл	-	2	1	1	-	4	5	5
25.5 дугаар зүйл	-	-	1	-	2	4	5	-
25.6 дугаар зүйл	-	-	-	-	-	-	-	-
25.7 дугаар зүйл	-	-	-	-	-	-	-	-

Прокурорын байгууллагын бүртгэл, мэдээлэлд дурдсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн дээрх зүйл, хэсэг, заалтаар 2018-2023 онд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэргийн тоо судалгаатай танилцъя.[33]

Хүснэгт 5.14. *Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэргийн тоо (2018-2023 он)*

ЭХТА-ийн холбогдох зүйл, хэсэг, заалт	2018 он		2019 он		2020 он		2021 он		2022 он		2023 он	
	ХБ	МБ	ХБ	МБ	ХБ	МБ	ХБ	МБ	ХБ	МБ	ХБ	МБ
17.1 дүгээр зүйл 2.2 заалт	129	47	114	44	100	29	70	24	169	61	142	42
18.5 дугаар зүйл 3 хэсэг	19	24	43	41	10	14	2	4	3	3	11	7
25.1 дүгээр зүйл	2	-	3	1	4	2	2	-	6	3	6	-
25.2 дугаар зүйл	6	1	6	2	4	3	7	4	3	-	1	2
25.3 дугаар зүйл	-	-	2	-	5	2	4	-	1	-	-	-
25.4 дүгээр зүйл	1	-	3	1	4	-	3	-	7	5	9	4
25.5 дугаар зүйл	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
25.6 дугаар зүйл	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
25.7 дугаар зүйл	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Соёлын өвийн эсрэг гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн тоо, энэ төрлийн хэрэг бүртгэлтийн хэргийн тоо хоорондоо зөрүүтэй байгаад (1) ЭХТА-ийн 17.1 дүгээр зүйлийн 2.2 дахь заалтад түүх, соёлын дурсгалт зүйлээс гадна шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлах үйлдлийг хамт хуульчилсан, (2) ЭХТА-ийн 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний амьтны, ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн, палеонтологийн олдвор, эд өлгийн зүйлийн хамт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хамт оруулсан байсан (2020.01.10-ны өдрийн ЭХНӨОтХ-аар

33 УЕПГ, Соёлын өвийн эсрэг гэмт хэргийн судалгаа, 2024 оны 6 дугаар сарын 5.

мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар улсын хил нэвтрүүлэх үйлдлийг ЭХТА-ийн 20.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг болгож салгасан) нь нөлөөсөн байх үндэслэлтэй. Үүнээс гадна гүйцэтгэх ажлын шугамаар илрүүлсэн, харьяаллын дагуу шилжүүлсэн гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг нээсэн, хэргийг нэгтгэсэн зэрэг процессын шинжтэй нөхцөл байдлаас статистик тоо мэдээлэлд өөрчлөлт орж байна.

Цагдаагийн болон прокурорын байгууллагын албан ёсны тоо баримтаар соёлын өвийн эсрэг гэмт хэрэг 2018, 2019 онд тогтвортой, 2020, 2021 онд бууралттай, 2022, 2023 онд өсөх хандлагатай болжээ. Энэ төрлийн гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад тавьсан прокурорын хяналтыг нутаг дэвсгэрээр нь ангилбал хэрэг бүрд харилцан адилгүй бөгөөд 2018-2023 онд ЭХТА-ийн 17.1 дүгээр зүйлийн 2.2-т заасан 720 хэрэгт хэрэг бүртгэлт явуулсны 74.1 хувь нь БЗД, ХУД, хөдөө орон нутагт, нийт 239 эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалт явуулсны 62.3 хувь нь БЗД, СХД, хөдөө орон нутагт байна.

График 5.1. *Хэрэг бүртгэлт явуулсан хэргийн тоо*
(Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.2 дахь хэсэг)



График 5.2. *Мөрдөн байцаалт явуулсан хэргийн тоо*
(Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.2 дахь хэсэг)



Мөн онуудад ЭХТА-ын 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан 82 хэрэгт хэрэг бүртгэлт, 93 хэрэгт мөрдөн байцаалт явуулсны дийлэнхэд Нийслэлийн прокурорын газар, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын 51 хэрэгт Тээврийн болон Дорноговь аймгийн прокурорын газар хяналт тавьжээ. Энэ гэмт хэрэг нь улсын хил дээр (нисэх болон төмөр зам, авто замын хилийн шалган нэвтрүүлэх цэг) үйлдэгддэг болохоор харьяаллын дагуу дээрх газруудад төвлөрч байна. (График 5.3, 5.4)

Улсын хэмжээнд ЭХТА-ийн 25 дугаар бүлгийн 7 зүйлээс 2018-2023 онд 4 төрлийн 75 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, 23 гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулсан байна. Эдгээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргүүдийг Нийслэл, СБД, Чингэлтэй дүүрэг болон орон нутаг (Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Сүмбэр, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгууд)-т мөрдөн шалгажээ.

График 5.3. *Хэрэг бүртгэлт явуулсан хэргийн тоо (Эрүүгийн хуулийн 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг)*



График 5.4. *Мөрдөн байцаалт явуулсан хэргийн тоо (Эрүүгийн хуулийн 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг)*



График 5.5. *Хэрэг бүртгэлт явуулсан хэргийн тоо (Эрүүгийн хуулийн 25 дугаар бүлэг)*



График 5.6. *Мөрдөн байцаалт явуулсан хэргийн тоо (Эрүүгийн хуулийн 25 дугаар бүлэг)*



Эрх бүхий байгууллагаас мөрдөн шалгах ажиллагаа явуулаад 2018 онд 21, 2019 онд 21, 2020 онд 47, 2021 онд 13, 2022 онд 35, 2023 онд 46 хэрэг бүртгэлтийн хэргийг хааж, 2018 онд 1, 2019 онд 1, 2020 онд 1 хэргийн эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан тогтоолыг хүчингүй тогтоолыг хүчингүй болгон, хэрэг бүртгэлтэд буцааж, 2018 – 2023 онд тус бүр 1 (нийт 5) эрүүгийн хэргийг түдгэлзүүлж, 2019 онд 4, 2020 онд 2, 2021 онд 1, 2022 онд 1, 2023 онд 2 хэргийг хэрэгсэхгүй болгож, 2018 онд 26, 2019 онд 51, 2020 онд 27, 2021 онд 20, 2022 онд 31, онд 21 хэргийг шүүхэд шилжүүлсэн байна.

Соёлын өвийн эсрэг гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүмүүсийн тоо, нас, ажил эрхлэлтийн байдлын талаарх судалгаанаас үзвэл хулгайлах гэмт хэргийг 14-

44 насны ажилгүй иргэд (96.8%), улсын хилээр хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэргийг 18-44 ба 45-аас дээш насны хөдөлмөр эрхэлдэг (42.9%) эрхэлсэн тодорхой ажилгүй (57.1%) иргэд, түүх,соёлын дурсгалт зүйл болон үл хөдлөх дурсгалыг эвдэх, гэмтээх, устгах, хууль бусаар археологи, палеонтологийн хайгуул, малтлага хийх гэмт хэргийг 18-44 ба 45-аас дээш насны ажилгүй иргэд (91.6%) үйлджээ. (График *5.7*)

График 5.7. *Яллагдагчаар татагдсан хүмүүсийн насны байдал*



Сүүлийн 6 жилийн дотор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хулгайлах (ЭХТА-ийн 17.1-2.2) хэрэгт 3074 хүн, улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх (ЭХТА-ийн 18.5-3) хэрэгт 78 хүн, соёлын өвийн эсрэг гэмт (ЭХТА-ийн 25.1-1, 25.1-2, 25.2-1, 25.2-2, 25.3-1, 25.4-1) хэрэгт нийт 92 хүнийг хохирогчоор тогтоосон ба эдгээр хэргүүдийн улмаас учирсан хохирлын хэмжээг 52,900,597,852 төгрөг гэжээ. Үүнээс хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд зөвхөн ЭХТА-ийн 17.1 дүгээр зүйлийн 2.2-т заасан гэмт хэргийн хохирол болох 44,151,669,888 төгрөгөөс 3.49 хувийг л нөхөн төлүүлсэн мэдээтэй байна.

Хүснэгт 5.15. *2018-2023 онд ЭХТА-ийн 17.1 дүгээр зүйлийн 2.2-т заасан гэмт хэргийн улмаас учирсан хохирол, түүний нөхөн төлөлт (хувиар)*

Он	Хохирлын хэмжээ	Нөхөн төлөлтийн хэмжээ	Нөхөн төлөгдсөн хохирол /хувиар/
2018	1,238,123,327	88,414,817	7,14%
2019	1,814,950,236	191,302,807	10,54%
2020	10,233,629,152	305,272,990	2,98%
2021	1,078,301,891	385,285,790	35,73%
2022	10,183,240,180	367,672,990	3,61%
2023	9,898,025,102	206,643,500	2,08%
Нийт	44,151,669,888	1,544,592,894	3.49%

2.2. Шүүхээр шийдвэрлэсэн соёлын өвийн эсрэг гэмт хэргийн тоон мэдээлэл

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн мэдээллээр 2017 оны 7 дугаар сарын 01-ээс 2023 оныг дүүсталх хугацаанд:

1. ЭХТА-ийн 17.1 дүгээр зүйлийн 2.2-т заасан 13 шүүгдэгчид холбогдох 11 хавтаст хэрэг,
2. ЭХТА-ийн 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан 64 шүүгдэгчид холбогдох 39 хавтаст хэрэг,
3. ЭХТА-ийн 25.1 дүгээр зүйлийн 1, 25.2 дугаар зүйлийн 1, 2, 25.4 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан 16 шүүгдэгчид холбогдох 11 хавтаст хэргийг тус тус шийдвэрлэсэн байна.[34]

Хүснэгт 5.16. *Шүүгдэгч нарын нас болон нийгмийн байдал*

Зүйл, хэсэг, заалт	Тоо	Нас	Тоо	Боловсролын түвшин	
ЭХТА-ийн 17.1 дугаар зүйлийн 2.2 дахь заалт	13	22-29 нас	5	Бүрэн дунд	6
		30-34 нас	6	Суурь	2
		35-аас дээш	2	Бага	5
ЭХТА-ийн 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	64	22-29 нас	27	Бакалавр	22
		30-34 нас	18	Тусгай мэргэжлийн дунд	6
		35-аас дээш	19	Бүрэн дунд	29
				Суурь	3
				Бага	3
				Боловсролгүй	1
ЭХТА-ийн 25 дугаар бүлгийн 25.1, 25.2, 25.4 дүгээр зүйлүүд	16	22-29 нас	-	Бакалавр	3
		30-34 нас	6	Тусгай мэргэжлийн дунд	2
		35-аас дээш	10	Бүрэн дунд	8
				Суурь	1
				Бага	2

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд соёлын өвийн эсрэг 2018 онд шилжүүлсэн 26 хэргээс 14, 2019 онд шилжүүлсэн 51 хэргээс 16, 2020 онд шилжүүлсэн 27 хэргээс 4, 2021 онд шилжүүлсэн 20 хэргээс 3, 2022 онд шилжүүлсэн 31 хэргээс 7, 2023 онд шилжүүлсэн 21 хэргээс 10 хэргийг шийдвэрлэсэн бөгөөд гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл, хэрэг бүртгэлтийн хэрэг, мөрдөн байцаалтын хэргийн тооноос шүүхээс шийдвэрлэсэн хэргийн тоо бага байна. Өөрөөр хэлбэл шүүхэд шилжүүлсэн нийт хэргийн 30 хувьд шүүхээс таслан шийдвэрлэжээ.

34 Шүүхийн ерөнхий зөвлөл. ЭХТА-ийн 17.1 дүгээр зүйлийн 2.2-т заасан Хулгайлах гэмт хэргийг түүх, соёл, шинжлэх ухаан, техник технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлж үйлдсэн гэмт хэрэг, ЭХТА-ийн 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэргийг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний амьтны, ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн, палеонтологийн олдвор, эд өлгийн зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж үйлдсэн гэмт хэрэг, ЭХТА-ийн 25 дугаар бүлэгт заасан Соёлын өвийн эсрэг гэмт хэргийн мэдээлэл. 2024.05.22.

График 5.8. *Хянан шийдвэрлэгдсэн байдал*
(Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.2 дахь хэсэг)



График 5.9. *Хянан шийдвэрлэгдсэн байдал*
(Эрүүгийн хуулийн 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг)



График 5.10. *Хянан шийдвэрлэгдсэн байдал (Эрүүгийн хуулийн 25 дугаар бүлэг)*



2.3. Соёлын өвийн эсрэг гэмт хэргийн шийдвэрлэлт, тулгамдаж буй асуудал

Соёлын өвийн эсрэг гэмт хэргийг шалгаж, шийдвэрлэхэд гарч буй асуудал, зүйлчлэл, эрүүгийн хариуцлага хүлээлгэхтэй холбоотой хүндрэл бэрхшээлийг дараах тохиолдлууд дээр жишээлэн дүгнэе.

Тохиолдол 1.

Дорноговь аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх аймгийн прокуророос Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2.2-т заасан гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн шүүгдэгч Д.А, Э.Э нар бүлэглэн 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс 24-ний өдөрт шилжих шөнө Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутагт байрлах музейн хаалганы цоожийг эвдэн музейн үзмэр болох түүх соёлын хөдлөх дурсгалт зүйл Намжил-бумба, сангийн бойпор, сунадаг гуулин дуран зэрэг эд зүйлсийг хулгайлсан хэргийг хэлэлцээд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсэг болгон үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байранд нэвтэрч хулгайлах гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцож, шүүгдэгч нарыг тус тус 2 жилийн хорих ялаар шийтгэжээ.

- Хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтыг шинжлэн судлаад Соёлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "...Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж харгалзахгүйгээр бүх нийтэд соёл, урлагаар үйлчлэх зорилго бүхий төрийн өмчийн байгууллага нь мэргэжлийн соёл, урлагийн төв байгууллагад тооцогдоно", мөн хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "... Аймаг, нийслэл, сум, дүүргийн болон бүс нутгийн хүн амд соёл, урлагаар үйлчлэх зорилго бүхий байгууллага нь орон нутгийн соёлын байгууллагад хамаарна" гэж заасан.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д "...соёлын өв гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий өвийг, 3.1.2-т "...соёлын биет өв гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх биетээр оршин байгаа дурсгалыг, 3.1.4-т "...түүх соёлын хөдлөх дурсгалт зүйл гэж тодорхой орон зайд шилжүүлэн байрлуулах боломжтой дурсгалыг тус тус ойлгохоор зохицуулсан. Мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11-д "уламжлалт шашин, шүтлэгийн холбогдолтой эд өлгийн зүйлийг түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлд хамааруулна" гэсэн. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар бүлэгт зааснаар тусгайлан хамгаалсан эд зүйлс гэх талаар хавтаст хэрэгт нотлох баримт авагдаагүй. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т: "... түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлээс хуулийн 8.3-т заасан шалгуурын дагуу хосгүй үнэт, үнэт гэж зэрэглэл тогтооно..." гэж заасан ба хуулийн энэхүү шаардлагын аль хэсгээр, ямар шалгууруар түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцсон талаар нотлох баримт авагдаагүй зэрэг байдлыг үндэслэн шүүгдэгч нарыг Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутагт байрлах орон нутгийн музейд хадгалагдаж байгаа түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийг үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байранд нэвтэрч хулгайлсан гэмт хэрэг үйлдсэн байна гэжээ.

- Хохирогч байгууллагын төлөөлөгч О-ийн зүгээс алдагдсан эд өлгийн зүйлийг 2007 онд улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлэн түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлээр бүртгэсэн, сумын соёлын төв нь номын сан гэж байгаад 2012 онд музей болгож үзмэрүүдийг бүртгэл мэдээллийн санд үнэлж бүртгэсэн талаар мэдүүлсэн боловч шүүхээс дээрх зүйлсийг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн ямар зүйл, заалт, шалгууруар түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож хамгаалсан нь тодорхой бус, тус музей нь соёл, урлагаар үйлчлэх зорилготой төрийн өмчийн орон нутгийн соёлын байгууллага байна гэж шүүх үзжээ.[35]

Прокуророос ЭХТА-ийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.2 заалтаар яллах дүгнэлт үйлдэж шилжүүлсэн боловч шүүх алдагдсан музейн үзмэрүүдийг түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан гэх нотлох баримт байхгүй, музей бол үйл ажиллагаа явуулах зориулалттай байр гэж үзээд зүйлчлэлийг өөрчилж шийдвэрлэсэн байна. Гэвч СӨХтХ-д тусгайлан хамгаалсан түүх, соёлын дурсгалт зүйл гэсэн нэр томьёо байхгүй бөгөөд сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн санг соёлын төвд; аймгийн бүртгэл, мэдээллийн санг орон нутгийн музейд; нийслэлийн бүртгэл, мэдээллийн санг нийслэлийн Засаг даргын дэргэдэх соёлын асуудал хариуцсан нэгжид; улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг Соёлын өвийн үндэсний төвд тус тус бүрдүүлж, хадгална. Улс, орон нутгийн музей нь тухайн нутаг дэвсгэрт орших соёлын өвийг бүртгэх, цуглуулах, хадгалж хамгаалах, судлах, сурталчлах чиг үүрэг бүхий соёл, эрдэм шинжилгээний байгууллага байна[36] гэж заасан. Түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлах гэж Соёлын өвийг хамгаалах тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэж, эрх бүхий байгууллагын шийдвэрээр тусгайлан хамгаалсан соёлын өвийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсныг ойлгоно[37] гэсэн албан ёсны бус (онол, арга зүй, практик) тайлбар бий. Эдгээрээс түүх, соёлын ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан гэдэг нь тус тайлангийн 1.2 дугаар зүйлд дурдсан

35 Дорноговь аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 02 сарын 12-ны өдрийн 35 дугаар шийтгэх тогтоол.

36 Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 20.4 дэх хэсэг.

37 С.Гантулга, Б.Энхболд, Эрүүгийн эрх зүйн тусгай анги /Сурах бичиг/ нэмж засварласан хоёр дахь хэвлэл, (Уб, 2020), 156 дахь тал.

холбогдох шатны соёлын өвийн бүртгэл мэдээллийн санд бүртгэгдсэн байх болон музейд хадгалагдаж байгаа шалгууруар тодорхойлогдоно. Иймээс зүйлчлэлийг өөрчлөх нь оновчгүй байв.

Тохиолдол 2.

Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх Нийслэлийн прокуророос Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг журамлан, мөн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1., 2.2., 2.3 дахь заалт, мөн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг журамлан, мөн хуулийн тусгай ангийн 25.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар тус тус зүйлчлэн, яллах дүгнэлт үйлдэж, ирүүлсэн С.О нь БЗД-ийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Шинжлэх ухааны академийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн байрны 101 тоот Археологийн судалгааны танхим (лаборатори)-ийн өрөөнд буюу хүн үйл ажиллагаа явуулах орон байр, тусгайлан хамгаалсан байранд 2 удаагийн үйлдлээр нэвтэрч, түүх, соёл, шинжлэх ухааны хөгжилд ач холбогдолтойд тооцож, тусгайлан хамгаалсан Монголын түүхийн XVI-XVII зууны үеийг төлөөлөх түүх, соёлын биет өв, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ, цэнэ, ач холбогдол бүхий түүхэн олдвор “Хоромсого” саадгийн мөнгөн тоног, зориулалт нь тодорхойгүй мөнгөн эдлэл” зэрэг 2 ширхэг эд зүйлсийг 2021 оны 9 дүгээр сард, шүншгийн цэвэр мөнгөн аягыг 2022 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр тус тус хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар хулгайлж Монгол Улсад ноцтой хохирол учруулсан, мөн Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсэгт “...Археологийн олдворыг худалдахыг хориглоно” гэж заасныг мэдсээр байж, археологийн малтлага, судалгаагаар илэрсэн Монголын түүхийн XVI-XVII зууны үеийг төлөөлөх түүх, соёлын биет өв, нийгэм, түүх соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ, цэнэ, ач холбогдол бүхий түүхэн олдвор “Соёлын биет өв” болох “Хоромсого саадгийн мөнгөн тоног, зориулалт нь тодорхойгүй мөнгөн эдлэл” зэрэг 2 ширхэг эд зүйлсийг 2021 оны 9 дүгээр сард, шүншгийн цэвэр мөнгөн аягыг 2022 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороо, Урт цагаан гудамж, Чин толгой гэх үйлчилгээний төвд тус тус бусдад худалдсан эрүүгийн хэргийг хэлэлцээд шүүгдэгч С.О-д ЭХЕА-ийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг журамлан, мөн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1., 2.2 дахь заалтад зааснаар 3 жил 6 сарын хугацаагаар хорих ял оногдуулжээ.

- Шүүх энэ гэмт хэргийг ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн 101 тоотод археологийн олдворын лаборатори буюу үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байранд нэвтэрч үйлдсэн тул ЭХТА-ийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтаар, алдагдсан эд зүйл нь археологийн судалгаа, малтлагаар илрүүлсэн, соёлын биет өв болох нь археологийн судалгааны тайлан, байгууллагын археологийн тэнхимийн сан хөмрөгийн бүртгэл зэргийг үндэслэсэн шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсон тул ЭХТА-ийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.2 дахь заалтаар тус тус зүйлчилсэн нь оновчтой гэж үзээд, Соёлын яамны дэргэдэх Түүх соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээ тогтоох мэргэжлийн зөвлөлийн шинжээч нарын дүгнэлтээр алдагдсан эд зүйлийн үнэлгээ 47.025.000 төгрөг байх (их хэмжээний хохирол гэж үзэхгүй) тул ЭХТА-ийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.3 дахь заалтыг хэрэгсэхгүй болгожээ. Мөн хулгайлах гэмт хэрэг нь гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэхээс гадна өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн болохын хувьд өөрт эдийн ашигтай байдал бий болгох зорилгыг агуулж, шунахайрах сэдэлтээр үйлдэгдэнэ.

Хулгайлах гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлсийг зарж борлуулах, бусдад худалдах, барьцаалан зээлдүүлэх газарт барьцаанд тавьж бэлэн мөнгө болгох зэрэг үйлдэл нь энэхүү гэмт хэргийн субьектив санаа зорилготой гарцаагүй уялдах тул субьектив талын энэхүү санаа зорилгоо хэрэгжүүлж буй үйлдэлд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 25.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар зүйлчлэн хариуцлага хүлээлгэх нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна гэх зарчимтай зөрчилдөж байна гээд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.14 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 34.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтад зааснаар шүүгдэгч С.О-д холбогдуулан ЭХТА-ийн 25.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар зүйлчлэн ирүүлсэн хэргийг гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгожээ.[38]

Хууль тогтоогчийн нэмсэн “түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлж” гэсэн хүндрүүлэх шинжийг практикт хэрэглэхэд төвөгтэй байдлыг үүсгэнэ[39] гэж эрүүгийн эрх зүйн эрдэмтэд үзсэн нь дээрх шүүхийн шийдвэрээр батлагдана. Өөрөөр хэлбэл ЭХТА-ийн 17.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалт дахь “тусгайлан хамгаалсан байр” болон 2.2 дахь заалтын “тусгайлан хамгаалсан эд зүйл” хоёрыг хамтад нь зүйлчилжээ. Түүх, соёлын ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлийг соёлын өвийн мэдээллийн санд бүртгэгдсэн байх гол шалгууруар тогтооно гэдгийг өмнө өгүүлсэн бөгөөд СӨХтХ-ийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэгт: Монгол банк; дурсгалт газрын хамгаалалтын захиргаа, музей, галерей, номын сан, сүм хийд, эрдэм шинжилгээний байгууллага, судалгааны лаборатори, үндэсний төв архив зэрэг аж ахуйн нэгж, байгууллага бүртгэл, мэдээллийн санг заавал бүрдүүлэхээр хуульчилсан юм. Тэгэхээр 17.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтаар давхар зүйлчлэх шаардлагагүй.

Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан С.О-гийн Дорноговь аймгийн их хэт сумын нутаг дэвсгэр “хэсэг байшингийн туурийн” малтлагаар 2018 онд олж илрүүлсэн 17 дугаар зууны үед холбогдох шүншгийн цэвэр мөнгөн аяга (археологийн олдвор) буюу соёлын биет өвийг хулгайлж, дараа нь хууль бусаар худалдсан болохыг мөрдөн шалгах ажиллагаагаар тогтоон, прокурор ЭХТА-ийн 25.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар зүйлчлэн яллах дүгнэлт үйлдэж, шилжүүлснийг шүүх гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон бөгөөд үүнийгээ хулгайлах гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлээ бусдад худалдах нь хулгайлах гэмт хэргийн субьектив талын санаа зорилгоо хэрэгжүүлж буй үйлдэл гэж тайлбарласан байна. Хэдийгээр хулгайлах хэргийн хувьд үргэлжилсэн үйлдэлтэй байж болох ч соёлын биет өвийг худалсан үйлдэл нь тусдаа бие даасан гэмт хэрэг юм.

38 Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 11 сарын 01-ний өдрийн 2022/ШЦТ/845 дугаар шийтгэх тогтоол.

39 С.Нарангэрэл, Ж.Эрдэнэбулган, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: Үзэл баримтлал, уламжлал, сургамж, (Уб, 2019), 193 дахь тал.

Тохиолдол 3.

Төв аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх аймгийн прокуророос Эрүүгийн хуулийн тусгай ангийн 25.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн Д.Э-т холбогдох 2019 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Төв аймгийн Эрдэнэсант сумын "Баян-Уул" 1 дүгээр багийн нутагт байрлах "Хангинах" гэх газраас металл хайгч ашиглаж, эртний булшийг хүрзээр ухаж, соёлын биет өв болох тогоог гарган авч, түүх, соёлын дурсгалт бүхий зүйлийг санаатай эвдэж гэмтээсэн эрүүгийн хэргийг шүүн хэлэлцээд түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон ч 2021 оны 7 дугаар сарын 6-ны өдрөөс дагаж мөрдсөн Өршөөл үзүүлэх тухай хуулиар ялаас өршөөн хэлтрүүлжээ.

- Яллагдагч Д.Э, хохирогч Ц.Х, гэрч Х.Б, Б.Ө, М.И, А.Г нарын мэдүүлгээр металл хайгч багаж ашиглан хууль бус хайгуул хийсэн болох нь тогтоогдох ба ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн дүгнэлтэд уг ухагдсан газар нь хүрэл зэвсгийн үед холбогдох шоргоолжин булш болон хиргисүүр бүхий түүхийн дурсгалт газар бөгөөд тогоо нь он цагийн хувьд XIII-XVIII зууны үед холбогдоно гэсэн байна. Хэрэгт эд мөрийн баримтаар хураагдан ирсэн металл хайгч 1 ширхэг, хүрз 1 ширхэг, зэв идэгдсэн тогоо 1 ширхгийг тус тус улсын орлого болгожээ.[40]

Энэ хэргийн нотлох баримтуудаас шүүгдэгч Д.Э тус газар орон нь эртний булш, хиргисүүр бүхий газар болохыг мэдэж, зориуд металл хайгч багаж, хүрз ашиглан хууль бус хайгуул, малтлага хийж, хүрэл зэвсгийн үед холбогдох шоргоолжин булш буюу түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг (хүрзээр ухаад эргэж булсан) эвдэж гэмтээсэн бөгөөд олдвор буюу төмөр тогоо (түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл)-г гэмтээж, сүйтгээгүй өөртөө авсан болох нь тодорхой харагдана. Гэтэл хэргийг 25.1 дүгээр зүйл (Түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах)-ээр зүйлчлэн шалгаж, шийдвэрлэсэн нь ойлгомжгүй юм. Харин ЭХТА-ийн 25.4 дүгээр зүйл (Хууль бусаар археологи, палеонтологийн хайгуул, малтлага хийх), 25.2 дугаар зүйл (Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг эвдэх, гэмтээх, устгах)-үүдээр давхар зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэх ёстой.

Тохиолдол 4.

Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх тус дүүргийн прокуророос Эрүүгийн хуулийн тусгай ангийн 25.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, мөн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 25.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн Н.О-д холбогдох Төв аймгийн нутаг дэвсгэр Хан Хэнтий уулын тусгай хамгаалалттай газарт байрлах "Н" гэх газраас эрх бүхий байгууллагын зохих зөвшөөрөлгүйгээр хууль бусаар археологи, палеонтологийн хайгуул, малтлага хийж, олж авсан Соёлын өвийг хамгаалах тухай хуульд заасан "Соёлын биет өв"-ийн хууль бус худалдааг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдөр Чингэлтэй дүүргийн 0 тоотод байх өөрийн гэртээ зохион байгуулж, улмаар иргэн Ч.А 70,000,000 төгрөгөөр худалдан борлуулсан эрүүгийн хэргийг хянан хэлэлцээд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 25.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 2700 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 2,700,000 төгрөгөөр торгох ял, мөн хуулийн тусгай ангийн 25.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 5400 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 5,400,000 төгрөгөөр торгох ял тус тус оногдуулжээ.[41]

40 Төв аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 07 сарын 06-ны өдрийн /ШЦТ/231 дугаар шийтгэх тогтоол.

41 Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 09 сарын 26-ны өдрийн 2023/ШЦТ/619 дугаар шийтгэх тогтоол.

Тохиолдол 2 дээр археологийн олдворыг хулгайлж аваад бусдад худалдсан үйлдлийг ялгаж салгахгүйгээр хулгайлах нэг гэмт хэрэг болгон шийдвэрлэсэн бол энэ тохиолдолд археологийн хууль бус малтлага хийсэн, олдворыг худалдсан үйлдлийг тусдаа гэмт хэрэг гэж үзэж ЭХТА-ийн холбогдох зүйл, хэсгээр зүйлчлэн эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн байна. Харин эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг тал бүрээс нь харгалзан[42] үзсэнгүй. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг үйлдсэн буюу археологийн хууль бус малтлага хийсэн газар нь тусгай хамгаалалттай газар нутаг, учирсан хохирлын хувьд зөвхөн олдворыг зарсан үнэ 70 сая төгрөг (тухайн олдвор болон гэмт хэрэг үйлдэхэд ашигласан багаж, хэрэгслийг эд мөрийн баримтаар хураан авч улсын орлого болгоогүй), гэмт хэрэг үйлдсэн хүн нь эртний эдлэлийн лангуу ажиллуулдаг, шүүгдэгч 2014.02.17-ны өдөр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 211 дүгээр зүйл (Ойн тухай хууль тогтоомж зөрчих)-ийн 211.1 дэх хэсэгт зааснаар 1 жил 3 сарын хугацаагаар хорих ял шийтгэгдэж байсан, энэ хуулийн тусгай ангийн нэг бүлэг (Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг)-т заасан санаатай гэмт хэргийг хоёр удаа үйлдсэн хүндрүүлэх нөхцөл байдал байгаа зэргийг үл харгалзан тус гэмт хэргүүдэд оногдуулж болох хамгийн бага ял (торгох ялын доод хэмжээ)-аар шийтгэжээ.

Тохиолдол 5.

Баянхонгор аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх Нийслэлийн Чингэлтэй дүүргийн прокурорын газрын хяналтын прокуророос яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн шүүгдэгч ****** нь өөрийн металл хайгч багажийг ашиглан ашигт малтмал буюу алт хайх зорилгоор эрэл хайгуул хийх явцдаа: 2022 оны 03 сарын эхээр Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Ханангийн хоолой гэх газарт газар ухаж, хүрлээр хийсэн хонины дүрс, 2022 оны 03 сарын дундуур Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Ханангийн хоолой гэх газарт газар ухаж, хүрлээр хийсэн хонины дүрс, 2022 оны 08 сарын сүүлээр Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын 2 дугаар багийн Доо цагаан хадны дэнж гэх газарт газар ухаж, хүрлээр хийсэн морины дүрс, 2022 оны 12 сарын сүүлээр Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын 2 дугаар багийн Хөх цав гэх газарт газар ухаж, хүрлээр хийсэн ямааны дүрс, 2023 оны 03 сарын эхээр Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Хоолтын Дөрж гэх газарт газар ухаж, хүрлээр хийсэн хутга зэргийг олж, улмаар хүрлийн үед хийгдсэн, соёлын биет өв гэдгийг мэдэж, үнэд хүргэн бусдад зарж борлуулан ашиг олох зорилгоор фейсбүүкийн “эртний эдлэл” гэсэн группэд зар тавьж, зарын дагуу холбогдсон ***** гэгчид нийт 1,400,000 төгрөгөөр худалдан борлуулж, Соёлын биет өвийн худалдааг хууль бусаар явуулсан гэмт хэргийг үйлдсэн гэх хэргийг хянан хэлэлцээд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 25.5 дугаар зүйлийн 1 дэх заалтад заасан соёлын биет өвийн худалдааг хууль бусаар явуулсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 25.5 дугаар зүйлийн 1-д зааснаар шүүгдэгч ****** -т хорих ял оногдуулахгүйгээр 1 /нэг/ жилийн хугацаагаар тэнсжээ.[43]

Археологи, палеонтологийн хууль бус хайгуул, малтлагыг өөр өөр цаг хугацаанд өөр өөр газарт хийсэн үйлдэл бүр тусдаа гэмт хэрэг юм. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар хууль бусаар археологи, палеонтологийн хайгуул, малтлага хийх гэмт хэргийн субьектив талын тогтоож чадаагүй байна. Үнэхээр шүүгдэгч өөрийн металл хайгчаар энд тэнд алт хайсан гэвэл ЭХТА-ийн 24.2 дугаар зүйл “Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох”-д заасан гэмт хэрэг болно.

42 Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.

43 Баянхонгор аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 10 сарын 24-ний өдрийн 2023/ШЦТ/221 дугаар шийтгэх тогтоол.

Тохиолдол 6 (1-4)

6-1. Баянхонгор аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх Баянхонгор аймгийн Прокурорын газраас Э.Х, Б.З, Д.А, Х.Х нарт холбогдох Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын 3 дугаар багийн нутагт байрлах "Хотын булан" гэх газраас хуучны эд өлгийн зүйлийг тусгай зөвшөөрөлгүйгээр, хууль бусаар археологи, палеонтологийн хайгуул, малтлага хийсэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 25.4 дүгээр зүйлийн 1-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн 2114002260020 дугаартай эрүүгийн хэргийг 2022 оны 03 сарын 09-ний өдөр хүлээн авч хянан хэлэлцээд шүүгдэгч нарыг 2.700 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 2.700.000 төгрөгөөр торгох ялаар тус тус шийтгэжээ.[44]

6-2. Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүх Нийслэлийн Прокурорын газрын хяналтын прокуророос Б.Л, Т.Г.Б, О.О, Б.Б нар Архангай аймгийн Хайрхан сумын нутаг дэвсгэр "Гол мод-1" гэх газарт байрлах Хүннү үеийн эртний язгууртны булш, хиргисүүрт хууль бусаар археологийн хайгуул, малтлага хийсэн Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.1 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус журамлан тусгай ангийн 25.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн 200200543 0089 дугаартай хэргийг 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдөр хүлээн авч хянан хэлэлцээд 2021 оны Өршөөл Үзүүлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8 дахь заалтад заасныг баримтлан шүүгдэгч нарт холбогдох Эрүүгийн хуулийн тусгай ангийн 25.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг өршөөн хэрэгсэхгүй болгожээ.[45]

6-3. Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх Нийслэлийн прокурорын газраас Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.1 дүгээр зүйлийн 1, 3, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 25.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар ЭХЕА-ийн 2.2 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг журамлан мөн хуулийн тусгай ангийн 25.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн шүүгдэгч Ч.Г, Н.Л, Б.А, Ц.Б нар Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутаг дэвсгэрт байрлах "Дарьтын хийд", "Орхироогийн хурал" гэх газарт, мөн Баянгол сумын нутаг дэвсгэрт байрлах "Баянголын дуган" гэх газарт тус тус орших хуучны сүм, хийдийн туурьд металл хайгч хүрз, зээтүү ашиглан хууль бусаар малтлага хийж, Монгол Улсын XIX-XX зууны үед хамаарах бурхны шашны эдлэл хэрэглэл, өв соёлыг илэрхийлэх түүхэн дурсгал бүхий 103 ширхэг эд зүйлсийг, Архангай аймгийн Хотонт сумын нутаг дэвсгэрт байрлах халуун рашаанаас зүүн тийш 20-30 километрийн зайд байрлах хуучны сүм, хийдийн туурьд шүүгдэгч Ч.Г, Б.А, Н.Л нар металл хайгч ашиглан хууль бусаар малтлага хийж, Монгол Улсын XIX-XX зууны үед хамаарах бурхны шашны эдлэл хэрэглэл, өв соёлыг илэрхийлэх түүхэн дурсгал бүхий 10 ширхэг эд зүйлсийг тус тус олж авсан, үүнийг шүүгдэгч Б.Э санхүүжүүлэн 300.000 төгрөгийг шилжүүлсэн эрүүгийн 2202002480442 дугаартай хэргийг хянан хэлэлцээд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 25.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Ч.Г, Н.Л, Б.А, Ц.Б нарт тус тус 2700 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 2.700.000 төгрөгөөр торгох ял оногдуулж, шүүгдэгч Б.Э-г ЭХТА-ийн 25.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 3000 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 3.000.000 төгрөгөөр торгох ял шийтгэжээ.[46]

44 Баянхонгор аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 03 сарын 24-ний өдрийн 2022/ШЦТ/070 дугаар шийтгэх тогтоол.

45 Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 05 сарын 30-ны өдрийн 2022/ШЦТ/772 дугаар шийтгэх тогтоол.

46 Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 05 сарын 25-ны өдрийн 2023/ШЦТ/368 дугаар шийтгэх тогтоол.

6-4. Төв аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх аймгийн Прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 25.4 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэхээр ирүүлсэн шүүгдэгч Б.Н, Л.Б, В.Т нарт холбогдох 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 02-ны өдөр хүртэл Төв аймгийн Борнуур сумын Нарт 4 дүгээр багийн нутаг дэвсгэр “Дуган хадны Хав чулуутын ам” гэх газарт эртний алт, мөнгөн эдлэл олох зорилгоор хууль бусаар археологийн хайгуул, малтлага хийсэн эрүүгийн 2434000000124 дугаартай хэргийг хэлэлцээд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 25.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Б.Н, В.Т, Л.Б нарыг 4000 /дөрвөн мянга/ нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 4.000.000 /дөрвөн сая/ төгрөгөөр торгох ялаар тус тус шийтгэжээ.[47]

Дээрх бүгд ЭХТА-ийн 25.4 дүгээр зүйлд заасан хууль бусаар археологи, палеонтологийн хайгуул, малтлага хийх гэмт хэргийг бүлэглэж үйлдсэн тохиолдлууд бөгөөд энэ нь ЭХЕА-ийн 6.6 дугаар зүйлийн 1.2-т заасан эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдал болно. Гэвч 6-4 дэх тохиолдол (хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн)-оос бусдад тухайн зүйл, хэсэгт заасан (торгох) ялын хамгийн бага хэмжээгээр шийтгэжээ. Өөрөөр хэлбэл хүндрүүлж үзээгүй. Мөн ЭХЕА-ийн 3.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: Бүлэглэн гүйцэтгэсэн гэмт хэргийг гүйцэтгэгчдийн үйлдлийг нэгтгэн зүйлчилж гүйцэтгэгч тус бүрийн гэмт хэргийг үйлдэхэд гүйцэтгэсэн үүрэг, оролцоог харгалзан ялыг ялгамжтай оногдуулна гэснийг хангаагүй байна. Түүнчлэн 6-3 дахь тохиолдолд ЭХТА-ийн 25.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хууль бус археологи, палеонтологийн хайгуул, малтлага, судалгааг санхүүжүүлсэн гэмт хэрэгт хуулиар тогтоосон ялын хэмжээ (5400 нэгжээс 27000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох) –нээс доогуур ял (3000 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 3.000.000 төгрөгөөр торгох) оногдуулсан байх юм.

Шүүгч хэргийн нотлох баримтыг дотоод итгэлээр үнэлэх боловч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай хүн, хуулийн этгээдэд хууль заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэх ёстой. Нөгөө талаас археологи, палеонтологийн хууль бус хайгуул, малтлага хийх гэмт хэргийг бүлэглэж, металл хайгч ашиглан үйлдсэн бол хүндрүүлэх шинж байхаар ЭХТА-ийн 25.4 дүгээр зүйлд тусгаж өгөөгүй нь ийнхүү ял хөнгөдөх, эрүүгийн хариуцлагын үр нөлөө буурах нэг хүчин зүйл болжээ.

Тохиолдол 7 (1-15)

7-1. Монгол улсын хилээр 195 ширхэг соёлын дурсгалт эд зүйлийг хууль бусаар нэвтрүүлсэн шүүгдэгч Ж.Б-г 2015 оны Эрүүгийн хуулийн 1.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг журамлан мөн хуулийн Тусгай ангийн 18.5 дугаар зүйлийн 3 дахь зааснаар 10.000 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 10.000.000 төгрөгөөр торгох ялаар шийтгэж, ялыг 3 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр тогтоожээ.[48]

47 Төв аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 05 сарын 02-ны өдрийн 2024/ШЦТ/157 дугаар шийтгэх тогтоол.

48 Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 09 сарын 26-ны өдрийн 137 дугаар шийтгэх тогтоол.

7-2. 2017 оны 08 сарын 11-ний өдөр Монгол улсын хил буюу Замын-Үүд сумын Авто замын шалган нэвтрүүлэх боомтоор хязгаарласан бараа болох түүх соёлын дурсгалт зүйл буюу (нийт 1.280.000 төгрөгийн үнэлгээтэй) 3 ширхэг гуулин хувинг хууль бусаар нэвтрүүлсэн шүүгдэгч Ш.А-г ЭХТА-ийн 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар 10.000 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 10.000.000 /арван сая/ төгрөгөөр торгох ялаар шийтгэж, ялыг 3 жилийн хугацаанд сард 277.777 /хоёр зуун далан долоон мянга долоон зуун далан долоо/ төгрөгөөр хэсэгчлэн төлөхөөр тогтоожээ.[49]

7-3. 2018 оны 06 дугаар сарын 12-ны өдөр Дорноговь аймгийн Замын-Үүд дэх Авто замын шалган нэвтрүүлэх боомтоор Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хязгаарласан 11 нэр төрлийн (нийт 4.400.000 төгрөгийн үнэлгээтэй) түүх соёлын дурсгалт эд зүйлийг улсын хилээр хууль бусаар, зохих зөвшөөрөлгүйгээр нэвтрүүлсэн шүүгдэгч Т.Б, Ц.А нарыг ЭХЕА-ийн 3.2 дугаар зүйлийн 1-д заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 18.5 дугаар зүйлийн 3-т зааснаар тус бүр 10.000 /арван мянга/ нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 10.000.000 /арван сая/ төгрөгөөр торгох ялаар тус тус шийтгэж, ялыг 1 /нэг/ жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр тогтоожээ.[50]

7-4. 2019 оны 02 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хязгаарласан бараа болох 39 нэр төрлийн түүх соёлын дурсгалт зүйлийг ... улсын дугаартай автомашин нууж, Монгол Улсын хил нэвтрүүлэхийг завдсан, мөн 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдөр Замын-Үүд сум дахь Авто замын шалган нэвтрүүлэх цэгээр ... улсын дугаартай тээврийн хэрэгсэлд Соёлын өвийг хамгаалах тухай хуулиар хязгаарласан бараа болох түүх, соёлын дурсгалт зүйлд (нийт 66,850,000 төгрөгийн үнэлгээтэй) хамаарах 1 ширхэг хонх, 1 ширхэг очрыг нууж, хууль бусаар улсын хил нэвтрүүлсэн шүүгдэгч Т овогт Э.Б-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар арван мянга тавин нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 10,050,000 /арван сая тавин мянган/ төгрөгийн торгох ялаар шийтгэж, ялыг 3 /гурван/ жилийн хугацаанд сард 279,167 төгрөгөөр хэсэгчлэн төлөхөөр тогтоожээ.[51]

7-5. 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Авто замын шалган нэвтрүүлэх боомтоор 47-60 ДГО улсын дугаартай тээврийн хэрэгслийн баруун талын урд, хойд хаалга, ар талд хязгаарлалт тогтоосон бараа болох Сундуй, Дэвтэрлэсэн, Үлгэрийн далай судар, хийморийн дарцгийн хэлний бар, хүрэл толь 2 ширхэг, Дэншиг, Цэнд судар, Хийморийн дарцгийн хэлний бар, суваргын модон бар, гуулин сангийн бойпор, модон гуутай бурхан багш голлосон дүншигийн 35 бурхан, модон гуутай жүжигшил Жанрайсэг, гууль цутгамал намсрай бурхан, хүрэл цутгамал очир, толгойгүй хятад шаазан хөөрөг, гууль цутгамал суварга, тал хэвийн шавар бурхан багш, Доржзодов судар, Бумбатай дарь эх загал зураг, цагаан дарь эхийн загал зураг, Цагаан шүхэрт загал зураг, хүрэл морь, хүрэл толь, тал хэвийн Гонгор бурхан судартай цэхэр манан хөөрөг, гууль цутгамал манал бурхан, зэс гуу, гууль цутгамал цөгц, сангийн бойпор, пүрэв, ган сийлбэртэй хэт хутга, хийморийн дарцгийн бар, зэс завьяа Алтангэрэл, Тарбочимба хэсэг бусаг судар, Жадамба судар, Алтангэрэл судар, Найман мянгат их хөлгөн судар зэрэг 39 нэр төрлийн (нийт 37,190,000 төгрөгийн үнэлгээтэй) соёлын дурсгалт зүйлүүдийг нууж, хилээр хууль бусаар нэвтрүүлсэн шүүгдэгч С овогт Х.Б-г ЭХЕА-ийн 3.7 дугаар зүйлийн 1, 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 10,000,000 /арван сая/ төгрөгийн, шүүгдэгч

49 Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 07 сарын 09-ний өдрийн 84 дугаар шийтгэх тогтоол (Тус шүүхээс хэргийг 2018.02.12-ны өдөр анх хэлэлцэж 23 дугаар шийтгэх тогтоолоор 10.000.000 төгрөгийн торгох ялыг 1 жил 6 сарын хугацаанд сард 555.555,56 /таван зуун тавин таван мянга таван зуун тавин таван төгрөг тавин зургаан мөнгө/ төгрөгөөр хэсэгчлэн төлөхөөр тогтоосон шүүгдэж гомдол гаргаж Давж заалдах шатны шүүхээс хэргийг дахин хэлэлцэж шийдвэрлэсэн байна).

50 Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 02 сарын 25-ны өдрийн 24 дугаар шийтгэх тогтоол.

51 Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 07 сарын 19-ний өдрийн 77 дугаар шийтгэх тогтоол.

Х овогт Д.Б-г ЭХЕА-ийн 3.7 дугаар зүйлийн 1, 3.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 10,000,000 /арван сая/ төгрөгийн торгох ялаар тус тус шийтгэж, ялыг 3 /гурван/ жилийн хугацаанд сард 277,778 төгрөгөөр хэсэгчлэн төлөхөөр тогтоожээ.[52]

7-6. 2019 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 1 дүгээр баг Авто замын шалган нэвтрүүлэх цогцолборын БНХАУ руу гарах чиглэлээр түүхийн дурсгалт зүйл болох (1.800.000 төгрөгийн үнэлгээтэй) Санжид молом гэх 1 ширхэг судрыг ... улсын дугаартай тээврийн хэрэгсэлд нууж, хууль бусаар, зохих зөвшөөрөлгүйгээр улсын хил нэвтрүүлсэн шүүгдэгч Б овогт Н.Э-г ЭХТА-ийн 18.5 дугаар зүйлийн 3-т зааснаар 10.000 /арван мянган/ нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 10.000.000 /арван сая/ төгрөгөөр торгох ялаар шийтгэж, ялыг 3 /гурав/ жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр тогтоожээ.[53]

7-7. 2019 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Авто замын шалган нэвтрүүлэх боомтоор ... улсын дугаартай ... маркийн тээврийн хэрэгслийн таазанд (нийт 3.060.000 төгрөгийн үнэлгээтэй) 30 ширхэг танкаа зураг /бурхны хөрөг/ буюу түүх соёлын дурсгалт эд зүйлийг хууль бусаар, зохих зөвшөөрөлгүйгээр нэвтрүүлсэн шүүгдэгч Г овогт Д.Ч-г ЭХТА-ийн 18.5 дугаар зүйлийн 3-т зааснаар 10.000 /арван мянган/ нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 10.000.000 /арван сая/ төгрөгөөр торгох ялаар шийтгэж, ялыг 3 /гурав/ жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр тогтоожээ.[54]

7-8. 2019 оны 08 дугаар сарын 12-ны өдөр Улаанбаатар-Эрээн чиглэлийн суудлын ... дугаар галт тэрэгний ... дугаар вагонд зорчин явахдаа Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Өргөн төмөр замын гаалийн хяналтын бүсийн шалган нэвтрүүлэх боомтоор 215 ширхэг (нийт 47,990,000 төгрөгийн үнэлгээтэй) соёлын дурсгалт зүйл болох бурхан шашны эд зүйл, судрыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн шүүгдэгч Т.М-г ЭХТА-ийн 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 10,000,000 /арван сая/ төгрөгийн торгох ялаар шийтгэж, ялыг 3 /гурван/ жилийн хугацаанд сард 277,777 төргөөр хэсэгчлэн төлөхөөр тогтоожээ.[55]

7-9. 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Авто замын шалган нэвтрүүлэх боомтоор БНХАУ руу гарах чиглэлээр өөрийн гар цүнхэндээ түүхийн дурсгалт зүйл болох нэг багц 5 ширхэг бүхий модон дээр зурсан (930000 төгрөгийн үнэлгээтэй) Рин-аа гэх бурхныг хил нэвтрүүлсэн шүүгдэгч Б овогт Д.Г-г ЭХТА-ийн 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар 10,000 /арван мянган/ нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 10,000,000 /арван сая/ төгрөгөөр торгох ялаар шийтгэж, ялыг 3 /гурав/ жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр тогтоожээ.[56]

52 Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 07 сарын 26-ны өдрийн 79 дугаар шийтгэх тогтоол.

53 Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 08 сарын 28-ны өдрийн 92 дугаар шийтгэх тогтоол.

54 Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 08 сарын 28-ны өдрийн 93 дугаар шийтгэх тогтоол.

55 Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 12 сарын 18-ны өдрийн 155 дугаар шийтгэх тогтоол.

56 Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 01 сарын 31-ний өдрийн 20 дугаар шийтгэх тогтоол ((Анхан шатны шүүхийн шийдвэрт шүүгдэгчийн өмгөөлөгчөөс гомдол гаргасан бөгөөд Дорноговь аймгийн Эрүү, иргэний давж заалдах шатны шүүхийн 2020 оны 03 сарын 23-ны өдрийн 12 дугаар магадлалаар шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, гомдлыг хэрэгсэхгүй болгосон байна).

7-10. 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Замын-Үүд-Эрээн чиглэлийн 7804 дугаартай галт тэрэгний зүтгүүрт түүх, соёлын дурсгалт эд зүйл болох 2 боодол судар, мандлын суурь 1 ширхэг, суурьтай хүрд 1 ширхгийг нэвтрүүлсэн шүүгдэгч Ц овогт Г.Д, Б овогт Д.Д нарыг ЭХЕА-ийн 3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар тус бүр арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 10,000,000 /арван сая/ төгрөгийн торгох ялаар тус тус шийтгэж, ялыг 3 /гурван/ жилийн хугацаанд хэсэгчлэн төлөхөөр тогтоожээ.[57]

7-11. 2023 оны 08 сарын 09-ний өдөр Дорноговь аймгийн Замын-Үүд дэх Автозамын шалган нэвтрүүлэх боомтоор 5 нэр төрлийн судар, 10 нэр төрлийн зурмал бурхан, хэт хутга, бэл, цахиур, хутганы хуй зэрэг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг Монгол улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн шүүгдэгч С-ийн Х-г ЭХЕА-ийн 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар 11,000 /арван нэгэн мянга/ нэгжтэй тэнцэх хэмжээ буюу 11,000,000 /арван нэгэн сая/ төгрөгөөр торгох ялаар шийтгэж, ялыг 2 жилийн хугацаанд сар бүр 458,333 төгрөгөөр төлж барагдуулахаар тогтоожээ.[58]

7-12. 2023 оны 03 дугаар сарын 04-ний өдөр Дорноговь аймгийн Замын-Үүдийн авто замын шалган нэвтрүүлэх боомтоор 3 ширхэг сангийн бойпор, 3 ширхэг бурхны гар, 2 ширхэг цайвар зоос, 1 ширхэг очир зэрэг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлсийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн шүүгдэгч *****, 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Дорноговь аймгийн Замын-Үүдийн авто замын шалган нэвтрүүлэх боомтоор 1 ширхэг шавар бурхан, металл бурхад 7 ширхэг, илтгэл шастир 18 ширхэг, судар 5 ширхэг, ном 2 ширхэг, зоос 2 ширхэг зэрэг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлсийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн шүүгдэгч *****, ***** нарт ЭХЕА-ийн 3.3 дугаар зүйлийн 1, 3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч *****, ***** нарыг тус тус арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 10,000,000 /арван сая/ төгрөгийн торгох ялаар шийтгэж, ялыг гурван жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр тогтоожээ.[59]

7-13. 2023 оны 09 сарын 05-ны өдөр Дорноговь аймгийн Замын-Үүд дэх Автозамын шалган нэвтрүүлэх боомтоор төвд үсгээр бичигдсэн 12 төрлийн судар буюу түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг Монгол улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн шүүгдэгч Ж-ийн Б-ыг ЭХТА-ийн 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар 10,000 /арван мянга/ нэгжтэй тэнцэх хэмжээ буюу 10,000,000 /арван сая/ төгрөгөөр торгох ялаар шийтгэж, ялыг 2 жилийн хугацаанд сар бүр 416,666 төгрөгөөр төлж барагдуулахаар тогтоожээ.[60]

57 Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 05 сарын 28-ны өдрийн 44 дугаар шийтгэх тогтоол (Анхан шатны шүүхийн шийдвэрт шүүгдэгчийн өмгөөлөгчөөс гомдол гаргасан бөгөөд Дорноговь аймгийн Эрүү, иргэний давж заалдах шатны шүүхийн 2021 оны 07 сарын 27-ны өдрийн 2021/ДШМ/27 дугаар магадлалаар шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, гомдлыг хэрэгсэхгүй болгосон байна).

58 Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 11 сарын 22-ны өдрийн 2023/ШЦТ/107 дугаар шийтгэх тогтоол.

59 Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 11 сарын 23-ны өдрийн 2023/ШЦТ/108 дугаар шийтгэх тогтоол.

60 Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 12 сарын 04-ний өдрийн 2023/ШЦТ/114 дугаар шийтгэх тогтоол.

7-14. 2023 оны 09 сарын 15-ны өдөр Дорноговь аймгийн Замын-Үүд дэх Автозамын шалган нэвтрүүлэх боомтоор Сундуй хэмээх нэртэй, муутуу цаасан суурьтай, төвд бичигтэй 7 төрлийн 747 ширхэг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг Монгол улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн шүүгдэгч Б-ийн С-г ЭХТА-ийн 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар 10,000 /арван мянга/ нэгжтэй тэнцэх хэмжээ буюу 10,000,000 /арван сая/ төгрөгөөр торгох ялаар шийтгэж, ялыг 2 жилийн хугацаанд сар бүр 416,666 төгрөгөөр төлж барагдуулахаар тогтоожээ.[61]

7-15. 2023 оны 07 дугаар сарын 28-ны өдөр Улсын хилээр гаргахыг хориглосон түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл болох 656 хуудастай Жадамба судар, 167 хуудастай Банзрагч судар нийт 823 хуудастай судрыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн шүүгдэгч М-ийн У, Г-ийн С нарыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар тус бүр 10,000 /арван мянга/ нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 10,000,000 /арван сая/ төгрөгөөр торгох ялаар шийтгэж, ялыг 2 /хоёр/ жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр тогтоожээ.[62]

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг шүүхээс прокурорын саналыг үндэслэн (7-4-д торгох ялын хэмжээг 10.050.000, 7-11-д торгох ялын хэмжээг 11.000.000 төгрөг гэснийг эс тооцвол)-д хуульд заасан хамгийн бага буюу 10,000 /арван мянга/ нэгжтэй тэнцэх хэмжээ буюу 10,000,000 /арван сая/ төгрөгөөр торгох ял оногдуулж, торгох ялыг 1-3 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэжээ. Эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ:

1. Гэмт хэрэгт хамтран оролцсон хэлбэр (зохион байгуулсан, хамжсан, бүлэглэж гүйцэтгэсэн, ганцаараа үйлдсэн /7.1 – 7.15/
2. Хохирол, хор уршиг (түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, ач холбогдол, тоо, хэмжээ, эд зүйлийн үнэлгээ /7-2 – 7-9/
3. Гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал болон ажил, албан тушаал (урьд нь ял шийтгэгдсэн /7-6, 7-12/, галт тэрэгний машинист /7-10/)
4. Гэмт хэрэг үйлдсэн үйлдлийн арга (галт тэрэг, автомашинд нуусан, тусгайлан бэлтгэсэн нуувч ашигласан, гар тээшинд авч орсон /7.5 – 7.10/) зэрэг нөхцөл байдлыг харгалзан үзэж, ялыг ялгамжтай оногдуулаагүй байх бөгөөд хэд хэдэн шийдвэр /7-2, 7-3, 7-4, 7-5, 7-8, 7-9, 7-10/-т тохиолдлын шинжтэй нөхцөл байдлын улмаас анх удаа гэмт хэрэг үйлдсэнийг хөнгөрүүлэх нөхцөл байдалд тооцов гэжээ.

Түүнчлэн прокурорын яллах дүгнэлтэд авагдсанаар “...хязгаарлалт тогтоосон бараа болох... /7-2, 7-3, 7-4, 7-5, 7-7/”, хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт, Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу хориглосон бараа болох... /7-9, 7-11, 7-13, 7-14/” түүх, соёлын дурсгалт зүйлийг... гэж нэрлэн тусгасан байна.

Судалгааны ажлын хүрээнд Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Төв аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор, Эрүүгийн цагдаагийн албаны Соёлын өвийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх тасаг, Чингэлтэй дүүргийн Цагдаагийн 1 дүгээр хэлтэс, Дорноговь аймгийн Замын-

61 Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 12 сарын 05-ны өдрийн 2023/ШЦТ/116 дугаар шийтгэх тогтоол.

62 Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 12 сарын 19-ний өдрийн 2023/ШЦТ/127 дугаар шийтгэх тогтоол.

Үүд сум дахь Цагдаагийн хэлтсийн мөрдөгч, эрүүгийн хэргийн өмгөөлөгч нартай бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага хийхэд энэ төрлийн гэмт хэргийг шалгаж шийдвэрлэхэд тулгамдаж буй дараах хууль хэрэглээний болон бусад асуудал, бэрхшээлүүд байгаа талаар өгүүлсэн болно. Үүнд:

- ЭХТА-ийн 25 дугаар бүлэгт түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хууль бусаар олж авсан, хадгалсан, бусдад шилжүүлсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тусгаагүй нь гэмт этгээдүүд ял завших, цаашлаад энэ төрлийн гэмт хэрэг өсөн нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- ЭХТА-ийн 25.5 дугаар зүйлд соёлын биет өвийн хууль бус худалдааг зохион байгуулах болон соёлын биет өвийн хууль бус худалдааг явуулсан гэдэгт соёлын биет өвийн дуудлага болон үзэсгэлэн худалдаа зохион байгуулсныг, эсхүл интернэт, дэлгүүр, лангуу, гар дээрээс худалдсаныг алиныг ойлгох нь тодорхой бус байгаагаас хэрэг, үйлдлийг зүйлчлэн тогтооход асуудалтай байна. Мөн эртний эдлэл наймаа эрхэлдэг иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулсан журмыг яаралтай батлан гаргаж, хяналт тавих шаардлага бий.
- Манай улсад соёлын өвийн мэргэшсэн шинжээч байхгүй, түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээг тогтоох мэргэжлийн зөвлөл ажиллахаа больсны улмаас гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд хүндрэл учруулж, түүх, соёлын хосгүй үнэт, үнэт, дурсгалт зүйлс устаж гэмтэх, үрэгдэж алга болох эрсдэлийг үүсгэдэг.
- Шүүгч, прокурор, мөрдөгч, гаалийн байцаагч нарт соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шинж, ялгаа, энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах онцлог, соёлын биет өвийн ангилал, төрөл, тэдгээрийг таних мэдэх, хураан авах, хадгалах арга ажиллагааны чиглэлээр сургалт зохион байгуулах хэрэгцээ байна.

2.4. Бүлгийн дүгнэлт

Цагдаа, прокурор, шүүхийн мэдээлэл судалгаагаар Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсноос хойш 2023 оныг дуусталх хугацаанд иргэн, аж ахуй нэгжээс түүх, соёл, эртний эдлэл, зоос, судар, бурхан, хиргисүүр, булш хулгайд алдагдсан 404 гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл бүртгэн, ЭХТА-ийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.2-т заасан 724 хэрэг бүртгэлтийн хэрэг, 247 мөрдөн байцаалтын хэргийг шалгаж, 13 шүүгдэгчид холбогдох 11 эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэжээ. Мөн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний амьтны, ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн, палеонтологийн олдвор, эд өлгийн зүйлийг улсын хилээр нэвтрүүлсэн талаарх гомдол мэдээлэл 22, ЭХТА-ийн 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан хэрэг бүртгэлтийн хэрэг 88, мөрдөн байцаалтын хэрэг 93, шүүхээр шалгаж шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 39 байна. Соёлын биет өвийг устгаж гэмтээсэн, хууль бусаар худалдсан, завшсан, археологийн хууль бус хайгуул, малтлага хийсэн 42 гомдол мэдээлэл, 89 хэрэг бүртгэлтийн хэрэг, 30 мөрдөн байцаалтын хэргийг шалгаж, ЭХТА-ийн 25.1 дүгээр зүйлийн 1, 25.2 дугаар зүйлийн 1, 2, 25.4 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан 16 шүүгдэгчид холбогдох 11 эрүүгийн хэргийг шүүхээр шийдвэрлэжээ. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан болон хянан

шийдвэрлэсэн хэрэг 2020, 2021 онд (“Ковид-19” цар тахлын нөхцөл байдал, хорио цээрийн дэглэмтэй холбоотой байх магадлалтай) буурсан боловч 2022 оноос өссөн байна. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатнаас хэрэгсэхгүй болгосон хэргийн тоо (193) шүүхэд шилжүүлсэн хэргийн тоо (176)-ноос илүү ажээ.

Шүүхийн шийтгэх тогтоолуудад хийсэн дүн шинжилгээгээр ЭХТА-ийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.2-т “түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйл” гэснийг зөв ойлгож хэрэглээгүйгээс буруу зүйлчилсэн, түүх, соёлын дурсгалт зүйлийг бусдад худалдсан үйлдлийг үргэлжилсэн үйлдэлтэй хулгайлах гэмт хэрэг гэж тайлбарлан хэргийг хэрэгсэхгүй болгосон, түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг санаатайгаар гэмтээн металл хайгч багаж, хүрз ашиглан малтлага хийж, олдворыг авсан үйлдлийг 25.1 дүгээр зүйл (Түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах)-ээр зүйлчлэн шийдвэрлэсэн, хууль бусаар археологийн хайгуул малтлага хийсэн тусдаа хэд хэдэн гэмт хэргийн субьектив шинжийг тодорхойлж чадаагүй, тогтоогдсон хүндрүүлэх нөхцөл байдлыг үл харгалзсан, 25.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хууль бус археологи, палеонтологийн хайгуул, малтлага, судалгааг санхүүжүүлсэн хэрэгт хуульд заасан хэмжээнээс доогуур торгох ял оногдуулсан, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн ихэнх хэргийн гэмт хэрэгт хамтран оролцсон байдал, хохирол, хор уршиг, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт үйлдлийн арга буюу хүндрүүлэх нөхцөл байдлыг харгалзан үзэж, ялыг ялгамжтай хэрэглэлгүй торгох ялыг хамгийн бага хэмжээгээр тооцож оногдуулсан зэрэг байдлууд тогтоогдлоо.

Шүүгч, прокурор, мөрдөгч, өмгөөлөгч нарын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаар энэ төрлийн гэмт хэргийг шалгаж, шийдвэрлэхэд тулгарч буй зарим бэрхшээл, авах арга хэмжээг ЭХТА-ийн 25 дугаар бүлэгт түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хууль бусаар олж авах, хадгалах, бусдад шилжүүлэх гэмт хэргийг хуульчлах (ингэснээр соёлын биет өвийг залилах, дээрэмдэх, өөр бусад аргаар хууль бусаар олж авсан, хууль бусаар хадгалсан, шилжүүлсэн үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой болно), ЭХТА-ийн 25.5 дугаар зүйлд соёлын биет өвийн хууль бус худалдааг зохион байгуулах, зуучлах гэмт хэргийн объектив талын шинж (соёлын биет өвийн хууль бус худалдааг явуулсан)-ийг “худалдсан”, “худалдан авсан” гэх мэтээр тодорхой зааж, холбогдох байгууллагаас соёлын биет өвийг худалдах, худалдан авахтай холбоотой журмыг баталж мөрдүүлэх, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээг тогтоох зөвлөлийг байгуулах, соёлын өвийн мэргэшсэн шинжээчийг бэлтгэж, ажиллуулах, гэмт хэрэг, зөрчил шалгаж шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудад соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх эрх зүйн зохицуулалт, үйл ажиллагаа, арга тактикийн чиглэлээр сургалт явуулж, зохих мэдлэг, чадвар олгох гэж тодорхойлж байна.

ДҮГНЭЛТ

1. Монгол Улсын Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/-д “Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг”-ийг бие даасан (7 зүйлтэй) бүлэг болгож, хулгайлах гэмт хэргийн хүндрүүлэх шинжид түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлийг хулгайлах үйлдлийг хуульчилснаар соёлын өвийн эсрэг гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт шинэ түвшинд хүрчээ. Гэвч соёлын өвд халдсан зарим үйлдлийг шинээр гэмт хэрэгт тооцох, нэр томьёог нэгдэн орсон олон улсын гэрээ, СӨХтХ-ийн тодорхойлолт, хэм хэмжээнд нийцүүлэх, хуулийн тайлбар хийх, хэд хэдэн гэмт хэргийн бүрэлдэхүүний субъект, объектив тал, хүндрүүлэх шинжид өөрчлөлт оруулах, энэ төрлийн гэмт хэргийн нийгмийн хор аюулыг харгалзан торгох ялын доод хэмжээг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байна гэж үзлээ.

2. БНХАУ, ОХУ, Бүгд Найрамдах Казакстан Улсын эрүүгийн хуулиудад Монгол Улсын эрүүгийн хуульд тусгагдаагүй соёлын үнэт зүйлийн хамгаалалтын тэмдгийг хууль бусаар ашигласан, хууль бус болох нь илт тодорхой соёлын дурсгалт зүйлийг худалдаж авсан, түүх, соёлын онцгой үнэ цэнтэй эд зүйл, бичиг баримтыг хууль бусаар олж авсан, соёлын биет өвийг болгоомжгүйгээр болон хууль бусаар олж авах, археологийн хууль бус хайгуул малтлагын явцдаа устгаж гэмтээсэн бол гэмт хэрэгт тооцдог, археологийн хууль бус хайгуул, малтлага хийх гэмт хэргийг урьдчилан үгсэн тохиролцсон бүлэг, давтан, албан тушаалын байдал,металл илрүүлэгч, радар, соронзон төхөөрөмж, ухагч машин ашиглаж үйлдсэнийг уг гэмт хэргийн хүндрүүлэх шинж болгон заасан зэрэг өвөрмөц, илүү нарийн зүйл, заалтууд цөөнгүй байна.

3. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсноос хойших хугацаанд бүртгэн шалгасан түүх, соёл, эртний эдлэл, зоос, судар, бурхан, олдвор, эд өлгийн зүйлийг хулгайлсан гомдол мэдээлэл, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг, шүүхээр шийдвэрлэсэн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний амьтны, ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн, палеонтологийн олдвор, эд өлгийн зүйлийг улсын хилээр нэвтрүүлсэн эрүүгийн хэрэг дийлэнх хувийг эзэлж байна. Мэдээлэл судалгаагаар энэ төрлийн гэмт хэрэг цаашид өсөх хандлагатай байгаа бөгөөд ЭХТА-ийн соёлын өвийн эсрэг гэмт хэрэг бүлгээс 25.4 дүгээр зүйлд заасан хууль бус археологи, палеонтологийн хайгуул, малтлага хийх гэмт хэргийн тоо сүүлийн жилүүдэд нэмэгджээ.

4. Шүүхээс энэ төрлийн гэмт хэргийг хянан шийдвэрлэхдээ хуулийн нэр томьёо, объектив талыг буруу тайлбарласан, зүйлчлэлийн алдаа гаргасан, субьектив шинжийг тогтоогоогүй, хуулиар тогтоосон хэмжээнээс бага ял оногдуулсан, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг харгалзан үзээгүй зэрэг асуудлууд байна. Төв, орон нутгийн зарим шүүгч, прокурор, мөрдөгч, өмгөөлөгч нарын дунд хийсэн бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагаас соёлын дурсгалт зүйлийг хулгайлахаас гадна залилах, дээрэмдэх, өөр бусад аргаар олж авсан бүх үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, соёлын биет өвийн худалдааг зохион байгуулах үйлдлийг оновчтой тодорхойлох, эртний эдлэл худалдах, худалдан авах үйл ажиллагааг журамлах, түүх, соёлын хөдлөх болон үл хөдлөх дурсгалын зэрэглэл үнэлгээг зөв бодитой тогтоодог болох, энэ төрлийн гэмт хэргийг шалгаж шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудад зохих мэдлэг, чадвар эзэмшүүлэх шаардлагууд байгаа нь харагдлаа.

зөвлөмж

Соёлын өвийн эсрэг гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, хэрэгжилтийг хангах чиглэлээр судалгааны ажлын бүлгийн болон нэгдсэн дүгнэлтэд үндэслэн дараах санал, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/ дахь соёлын өвтэй холбоотой зарим гэмт хэргүүд (ЭХТА-ийн 25 дугаар бүлэг, 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.2, 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг)-ийн халдлагын зүйл, объектив тал, хүндрүүлэх шинжид зохих нэмэлт, өөрчлөлтийг хийх;

- ЭХТА-ийн 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн торгох ял, 25.3 дугаар зүйл, 25.4 дүгээр зүйлийн торгох, зорчих эрхийг хязгаарлах, хорих ялын хэмжээг нэмэгдүүлэх;

- “Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлсийг хамгаалах тухай конвенц”-ын тодорхойлолтод дурдсан нэр томьёог ЭХТА-ийн 29.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тусгах;

- Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хууль бусаар олж авах, хадгалах, бусдад шилжүүлэх үйлдлийг гэмт хэрэгт тооцож, хулгайлахтай хамт ЭХТА-ийн 25 дугаар бүлэгт шинэ зүйл болгон хуульчлах;

- Хөрш зэргэлдээ болон бусад улсуудын эрүүгийн хууль тогтоомжийг гүнзгийрүүлэн судалж, манай улсын эрүүгийн хуульд байдаггүй үр ашигтай зохицуулалтыг дотоодын эрх зүйн орчин, нийгмийн нөхцөл байдалд тохируулан суулгах арга хэмжээ авах;

- Энэ төрлийн бүртгэгдсэн гомдол мэдээлэл, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан, хэрэгсэхгүй болгосон, шүүхээр шийдвэрлэсэн хэргийн тоо мэдээллийг бүрэн бодитой гаргаж, жил бүр статистик шинжилгээ хийж байх;

- Практикт гарч буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор шүүгч, прокурор, мөрдөгч, өмгөөлөгч, судлаач, соёлын өвийн мэргэжилтэн нарын дунд сэдэвчилсэн уулзалт, хэлэлцүүлэг, шаталсан сургалтуудыг тогтмол зохион байгуулж хэвших;

- Соёлын өвийн зэрэглэл, үнэлгээг тогтоох мэргэжлийн зөвлөлийг байгуулж, соёлын өвийн чиглэлээр мэргэшсэн шинжээчийг бэлтгэн ажиллуулах;

- Соёлын биет өвийг худалдах, худалдан авах журмыг батлан мөрдүүлж, соёлын дурсгалт зүйлийн эргэлт, эртний эдлэлийн бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавих.

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж

1. Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, (2014), №23;
2. Зөрчлийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2017), №24;
3. Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: (2016), №07;
4. Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: (2002), №05;
5. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 2020.01.10;
6. Эрдэнэсийн сангийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, (2022), №20;

Ном, сурах бичиг, гарын авлага, эмхэтгэл, судалгаа

1. С.Нарангэрэл, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /ерөнхий анги/, (Уб, 1999);
2. С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол /боть I/, (Уб, 2009);
3. Г.Гантөмөр, Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол, (Уб, 2011);
4. Ч.Доржсүрэн, Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг /Тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам/, (Уб, 2014);
5. ХЗДХЯ, Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/ Сургагч багш нарт зориулсан гарын авлага /Тусгай анги/, (Уб, 2017);
6. С.Гантулга, Б.Энхболд, Эрүүгийн эрх зүйн тусгай анги /сурах бичиг/, (Уб, 2018);
7. Д.Насанбат, А.Цэнгэл. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги / Сурах бичиг/, (Уб, 2018);
8. С.Нарангэрэл. Ж.Эрдэнэбулган, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: Үзэл баримтлал, уламжлал, сургамж, (Уб, 2019);
9. Х.Доржпалам, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /Ерөнхий анги/, (Уб, 2019);
10. С.Гантулга, Б.Энхболд, Эрүүгийн эрх зүйн тусгай анги /сурах бичиг/ нэмж засварласан хоёр дахь хэвлэл (Уб, 2020);
11. Монголын криминологичдын холбоо, Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэглээ, (Уб, 2020);
12. Ц.Цэлмэг. Д.Майцэцэг, Харьцуулсан эрүүгийн эрх зүй /Магистрант, оюутнуудад зориулсан гарын авлага/, (Уб, 2021);
13. Т.Золбоо. Монгол Улс болон Герман Улсын Эрүүгийн хууль, (Уб, 2023).
14. Ч.Доржсүрэн, Түүх, соёлын дурсгалт зүйлтэй холбоотой гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн асуудал /Магистрын судалгааны ажил/, (Уб, 2013);
15. Нээлттэй нийгэм форум, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв. Шинэ төрлийн гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдал /Судалгааны тайлан/, (Уб, 2021);
16. Ч.Доржсүрэн. Эрүүгийн хуулийн шинэчлэл: Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг. Эрдэм шинжилгээний өгүүлэл. Хууль дээдлэх ёс сэтгүүл, (Уб, 2020), №2 (Цуврал 77);
17. ШУА, Хууль зүйн үндэсний төв, Шинжлэх ухаан технологийн холбогдолтой эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл, (Уб, 2008);

18. ЦЕГ-ын Мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба, Соёлын өвийн эсрэг гэмт хэргийн судалгаа, (Уб, 2024);
19. Улсын Ерөнхий Прокурорын Газар, Соёлын өвийн эсрэг гэмт хэргийн судалгаа, (Уб, 2024);
20. Соёлын өвийн эсрэг гэмт хэргийн мэдээлэл, Шүүхийн ерөнхий зөвлөл, (Уб, 2024);

Цахим эх сурвалж

1. https://baike.baidu.com
2. https://criminalman.blospot.com
3. www.consultant.ru/document/cons_doc_LAW
4. www.gov.kz/legalacts/details/
5. https://www.legalinfo.mn/law/
6. https://shuukh.mn/cases/

ЗУРГАА. ГЭМТ ХЭРГИЙН ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН ЛАВЛАГАА

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Хууль зүйн ухааны доктор (Dr.jur.)

Судалгааны багийн бусад гишүүд:

М.Түвшинжаргал	Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
О.Энхүслэн	Эрдэм шинжилгээний ахлах ажилтан (LL.M)
М.Ганди	Эрдэм шинжилгээний ажилтан
Э.Сэлэнгэ	Эрдэм шинжилгээний ажилтан

Судалгааг захиалагч: Хууль зүй, дотоод хэргийн яам
Судалгааг гүйцэтгэж хүргүүлсэн огноо: 2024.05.29.

№	Улсын нэр	Хөөн хэлэлцэх хугацааны ерөнхий зохицуулалт	Хугацааг тоолж эхлэх	Хугацаа тасрах, шинээр тоолох	Хугацааг зогсоох, сэргээн тоолох	Хугацааг тоолохгүй байх	Хугацааг тодорхой хязгаартай тоолох
1.	Монгол Улс	Эрүүгийн хууль 1.10 дугаар зүйл. Хөөн хэлэлцэх хугацаа Гэмт хэрэг үйлдсэнээс хойш дараах хугацаа өнгөрсөн нь тогтоогдвол яллагдагчаар татаж болохгүй: 1.1.энэ тусгай ангид хорих нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг хойш нэг жил өнгөрсөн; 1.2.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн;	Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэгийг үйлдсэн өдрөөс эхлэн тоолно” гэж хуульчилсан байна.	Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Гэмт хэрэг үйлдсэн этгээд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаа өнгөрөөгүй байхад гэмт хэрэг санаатай дахин үйлдвэл хөөн хэлэлцэх хугацааг сүүлчийн гэмт хэргийг үйлдсэн үеэс гэмт хэрэг тус бүрд шинээр тоолно.” гэж зохицуулсан.	Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт “Хуулиар халдашгүй байдлыг баталгаажуулсан албан тушаалтны бүрэн эрхийг эрх бухий байгууллага, албан тушаалтан түдгэлзүүлэгүй бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг зогсоож, бүрэн эрх дуусгавар болсны дараа тоолж эхэлнэ.” гэж, мөн зүйлийн 8 дахь хэсэгт “Сэжигтэн мөрдөн шалгах ажиллагаанаас орогн зайлсан бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг орогн зайлсан өдрөөс эхлэн зогсоож уг этгээд баригдсан, эсхүл хэргээ өөрөө илчилж ирсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хугацаа сэргээн тоолно.” гэж, мөн зүйлийн 10 дахь хэсэгт “Сэжигтэн мөрдөн шалгах ажиллагаанаас орогн зайлсан бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг орогн зайлсан өдрөөс эхлэн зогсоож уг этгээд баригдсан, эсхүл хэргээ өөрөө илчилж ирсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл хөөн хэлэлцэх хугацааг сэргээн тоолно.” гэж тус тус зохицуулсан.	Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Энэ хуульд бүх насаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайн, зэвсэгт мөргөлдөөн, геноцид, апартеидын гэмт хэрэг, хүний эсрэг гэмт хэрэг, террорист халдлага, авлига, албан тушаалын гэмт хэрэг, эрүүдэн шүүх, албадан алга болгох гэмт хэрэг, цэргийн гэмт хэрэг, дайны гэмт хэрэг, олон улсын гэмт хэрэг, хүний эрхийн ноцтой зөрчлийн гэмт хэрэг, мөн Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 20 дугаар бүлэгт заасан гэмт хэрэг, Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолно.” гэж зохицуулсан.

	1.3.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг арван таван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван хоёр жил өнгөрсөн; 1.4.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг арван хоёр жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг хорин жил хүртэл тогтоосон ба бүх насаар хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэнээс хойш хорин жил өнгөрсөн. 1.5.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш гурван жил өнгөрсөн.					

№	Улсын нэр	Хөөн хэлэлцэх хугацааны ерөнхий зохицуулалт	Хугацааг тоолж эхлэх	Хугацаа тасрах, шинээр тоолох	Хугацааг зогсоох, сэргээн тоолох	Хугацааг тоолохгүй байх	Хугацааг тодорхой хязгаартай тоолох
2	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	Эрүүгийн хууль (Strafgesetzbuch, StGB) 5 дугаар бүлэг 78-р зүйл. Мөрдөн байцаах хөөн хэлэлцэх хугацаа (МБХХХ) (1)Хөөн хэлэлцэх хугацаа дууссанаар гэмт хэрэгт ял оногдуулахгүй бөгөөд арга хэмжээ авахгүй. Энэ хуулийн 76а дугаар зүйлийн 2 дахь хэсэгт[1] хамаарахгүй. (3) МБХХХ-г дараах байдлаар тоолно: - Бүх насаар хорих ял оноох гэмт хэргийн хувьд 30 жил - 10-аас дээш хорих ял оноор гэмт хэргийн хувьд 25 жил	78а-р зүйл. Тоолж эхлэх Гэмт хэрэг төгссөнөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг тоолно. Хэрэв гэмт хэргийн бүрэлдэхүүн болж буй үр дүн хожим бий болсон бол тэр үеэс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг тоолно. Тодруулбал: ХБНГУ-ын Эрүүгийн хуульд гэмт хэрэг хэзээ үйлдэгдэхээс үл хамааран хор уршиг илэрсэн үеэс хөөн хэлэлцэх хугацааг тоолж эхлэхээр хуульчилсан нь ихээхэн онцлогтой.[2]	78с-р зүйл. Тасрах (МБХХХ) (1) Дараах үндэслэлээр ХХХ тасарна: - Сэжигтнээс анхны мэдүүлэг авах, түүний эсрэг мөрдөн шалгах ажиллагаа эхэлснийг мэдэгдэх, эсвэл ийм байцаалт болон мэдэгдэл гаргах тухай шийдвэрлэснээр, - Мэдүүлэг авах шүүхийн бүх ажиллагаа, эсвэл түүнийг явуулах тухай шийдвэрлэснээр, - Сэжигтэн өмнө нь байцаагдаж байсан эсвэл түүнд мөрдөн шалгах ажиллагаа эхэлсэн тухай мэдэгдсэн бол шүүгч эсвэл прокурор шинжээч томилох бүрд,	78b-р зүйл. Зогсох (МБХХХ) (1) Дараах тохиолдолд ХХХ зогсоно: - Энэ хуулийн 174-174с, 176-178 / бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргүүд/, 180 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт, 188 / хүүхдийн бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргүүд/, 225 /хэрцгийгээр тамлах/, 226а / хүний эд эрхтнийг зэрэмдэглэх/ болон 237 дугаар зүйлд / эмэгтэй хүний хүсэл зоригийн эсрэг хүчээр гэр бүл болох/ заасан гэмт хэргүүдийн хувьд хохирогч 30 нас хүрэх хүртэл,	78-р зүйл. Хугацаа тоолохгүй байх (2) Энэ хуулийн 211 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн (аллага) хувьд хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй. Тодруулбал: Аллага үйлдсэн этгээдийг бүх насаар нь хорих ял шийтгэх ба уг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тоолохгүй. Өөрөөр хэлбэл энэ гэмт хэрэг хэдийд ч илэрсэн байсан мөрдөн шалгах ажиллагаа явуулж гэмт хэрэг үйлдсэн хүнд хуулийн хариуцлага хүлээлгэх боломжтой байдаг.[3]	78с-р зүйл. (3)ХХХ тасрах бүрд ХХХ-г шинээр тоолж эхэлнэ. Энэ хуулийн 78а дугаар зүйлд заасан хугацаанаас хойш тухайн хугацааг 2 дахин нэмэгдүүлсэн хугацаа өнгөрсөн бөгөөд түсгайлсан хуулийн дагуу ХХХ 3 хүртэлх жил байгаа тохиолдолд хамгийн багадаа 3 жил өнгөрсөн бол мөрдөн шалгах ажиллагааны ХХХ дуусна. Энэ хуулийн 78b дугаар зүйл үүнд хамаарахгүй. (Энэ нь ХХХ тоолохыг хязгаарласан заалтууд ба МУ-ын ЭХХШтХ-ийн 31.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгтэй төстэй зохицуулалт юм.)

1 76а (2). Гэмт хэрэг мөрдөх хөөн хэлэлцэх хугацаа дууссан бол энэ хуулийн 73, 73b дугаар зүйл болон 73с дугаар зүйлд заасан урьдчилсан нөхцөлүүдийн хүрээнд гэмт хэргийн улмаас олсон орлого болон орлоготой тэнцэх мөнгөн дүнг хураан авахыг шүүх бие даан шийдвэрлэж болно. Энэ хуулийн 74b болон 74d дугаар зүйлд заасан урьдчилсан нөхцөлүүдийн хүрээнд аюултай эд зүйл хураан авах, баримт бичиг хураан авах болон ашиглах боломжгүй болгоход дээрх заалт мөн адил үйлчилнэ.

2 С.Өмирбек, “Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа, түүнийг тоолох журам, харьцуулсан судалгаа”, 2023.11.10, https://omir.blogmn.net/116964/gemt-hergiig-huun-helelceh-hugacaa,-tuuniig-tooloh-juram,--harcuulsan-sudalgaa.html

3 ХБНГУ-ын Бавари муж улсын Дээд шүүхийн дэд ерөнхийлөгч Андреас Цвергер: Хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт манай орныхоос зарчмын ялгаатай байна, https://ikon.mn/n/1oj3

	- 5-аас доошгүй 10 хүртэлх жилийн хорих ял оноох гэмт хэргийн хувьд 10 жил - 1-ээс доошгүй 5 хүртэлт жилийн хорих ял оноох гэмт хэргийн хувьд 5 жил - Бусад гэмт хэргийн хувьд 3 жил (4) Энэ хуулийн ерөнхий ангид зохицуулсан эсвэл онц хүнд, хүндэвтэр гэмт хэргийн хувьд заасан хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдлыг үл харгалзан энэ хуульд заасан гэмт хэрэг үйлдэж, ял шийтгэл хүлээхээс хамааруулах хөнөө хэлэлцэх хугацааг тогтооно.		- Шүүх хураан авах болон нэгжлэг хийх тухай шийдвэрлэх болон шүүхийн эдгээр шийдвэрийг хэвээр үлдээх бүрд, - ХХХ үндсэн ажиллагаа явуулах бүрд - Ял оногдуулах шийдвэр болон түүнд хамаарах бусад шийдвэрүүд. - Шүүгдэгч ирээгүйн улмаас шүүх хуралдааныг түр хугацаанд хойшлуулснаар, түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгдэгчийн байгаа газрыг тогтоох, эсвэл нотлох баримтыг багалгаажуулах зорилгоор шүүгч эсвэл прокурор шүүх хуралдааныг түр хугацаагаар хойшлуулах тухай шийдвэр гаргах бүрд, эсвэл	-Хуульд заасны дагуу мөрдөн шалгалт эхлэх, эсвэл үргэлжлэх боломжгүй бол; өргөдөл, зөвшөөрөл, гадаад улсад яллах хүсэлт гаргаагүйн улмаас мөрдөн шалгах боломжгүй байгаа тохиолдолд үүнд хамаарахгүй. (2)Гэмт хэрэгтэн Бүндестагийн гишүүн эсвэл мужийн хууль тогтоох байгууллагын гишүүн учир мөрдөн шалгах боломжгүй байгаа тохиолдолд дараах байдлаар ХХХ-г тоолж эхлэх ба энэ хугацаа ХХХ зогсоно: - Баривчлах, цагдан хорих зорилгоор баривчлах, урьдчилан баривчлах тухай шийдвэрлэх болон шүүхийн эдгээр шийдвэрийг хэвээр үлдээх бүрд, - Олон нийтийн нэхэмжлэл гарснаар, - Хэрэг хянан шийдвэрлэх үндсэн ажиллагаа эхэлснээр		Тодруулбал: Үүнээс үзвэл гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн (1) тухайн гэмт хэргийг хөнө хэлэлцэх хугацаатай хамт (2) мөрдөн шалгах ажиллагаа явуулах нийт хугацаа зэрэгцэн тоологдох бөгөөд гэмт хэргийг мөрдөн шалгах нийт хугацаа нь гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тухайн хэргийг хөнө хэлэлцэх хугацааг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хугацаагаар хязгаарлагдана. Тухайн хэргийн хөнө хэлэлцэх хугацааг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу уг хэргийн мөрдөн байцаалтын нийт хугацаа дуусан тохиолдолд хэргийг мөрдөж шалгах хугацааг сунгахгүй

		- Шүүгдэгч шүүх хуралдаанд оролцох боломжгүйн улмаас шүүх хуралдааныг тур хугацаанд хойшлуулснаар, түүнчлэн шүүгдэгч шүүх хуралдаанд оролцох боломжгүй эсэхийг хянан шалгах зорилгоор шүүгч эсвэл прокурор шүүх хуралдааныг тур хугацаанд хойшлуулах тухай шийдвэр гаргах бүрд. - Гадаад улсад мөрдөн шалгалт явуулах тухай шүүх хүсэлт гаргаснаар. Урьдчилан сэргийлэх зорилгоор цагдан хорих ажиллагаа болон бусад бие даасан ажиллагааны үеэр энэ зүйлийн 1 дэх өгүүлбэрт заасан үндэслэлээр дээрх ажиллагааныудыг явуулсан тохиолдолд ХХХ тасарна. (2) Бичгээр гаргасан шийдвэрийн хувьд шийдвэр дээр гарын үсэг зурснаар ХХХ тасарна.	- Прокурор, эрх бүхий байгууллага эсвэл цагдаагийн ажилтан тухайн гэмт хэрэг болон гэмт хэрэгтний тухай мэдсэн эсвэл, - Гэмт хэрэгтний эсрэг өргөдөл эсвэл гэмт хэрэг үйлдсэн тухай мэдэгдэл гарсан (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 158 дугаар зүйл) (3) ХХХ дуусахаас өмнө анхан шатны шүүхийн шийдвэр гарсан бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хүчин төгөлдөр болохоос өмнө ХХХ дуусгавар болохгүй. (4) Онц хүнд гэмт хэрэгт таваас дээш жилийн ял оногдуулахаар хуульд заасан бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх үндсэн ажиллагаа мужийн шүүхэд нээгдсэн бол энэ хуулийг 78 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 4-т		Энэ нь дурдсан хугацаанд цуглуулсан нотлох баримтын хэмжээнд хэргийг шүүхэд шилжүүлэх гэсэн давхар агуулгыг илэрхийлсэн бөгөөд уг хугацаа дууссаны дараа бэжүүлсэн, цуглуулсан нотлох баримт алдах чадвараа онцлоттой хууль хэрэглээний хувьд чухал ач холбогдолтой зохицуулалт болжээ.[4]

4 С.Өмирбек, "Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа, түүнийг тоолох журам, харьцуулсан судалгаа", 2023.11.10, https://omir.blogmn.net/116964/gemt-hergiig-huun-helelceh-hugacaa,-tuuniig-tooloh-juram,--harcuulsan-sudalgaa.html

		Хэрэв баримт бичиг гарын үсэг зурсны дараа шууд хэрэгжихгүй бол хэрэгжиж эхэлснээр ХХХ тасарна. Шинээр тоолох тухай зохицуулалт: (3)ХХХ тасрах бүрд ХХХ-г шинээр тоолж эхлэнэ. Энэ хуулийн 78а дугаар зүйлд заасан хугацаанаас хойш тухайн хугацааг 2 дахин нэмэгдүүлсэн хугацаа өнгөрсөн бөгөөд түсгайлсан хуулийн дагуу ХХХ 3 хүртэлх жил байгаа тохиолдолд хамгийн багадаа 3 жил өнгөрсөн бол мөрдөн шалгах ажиллагааны ХХХ дуусна. Энэ хуулийн 78b дугаар зүйл үүнд хамаарахгүй. (Энэ нь ХХХ тоолохыг хязгаарласан заалтууд ба МУ-ын ЭХХШтХ-ийн 31.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгтэй төстэй зохицуулалт юм.) Тодруулбал: ХБНГУ-д ХХХ-г хэрэг үйлдсэн мөчөөс тоолж эхэлдэг. Мөрдөн шалтах ажиллагааг эхлэх,	заасан тохиолдлын хувьд (1-зэс доошгүй 5 хүртэлт жилийн хорих ял оноох гэмт хэрлийн хувьд 5 жил ХХХ тоолно) дээрх ажиллагаа эхэлснээс хойш 5 хүртэлх жилийн хугацаанд ХХХ зогсоно; энэ зүйлийн 3 дахь хэсэг үүнд хамаарахгүй. (5) Гэмт хэрэгтэн гадаад улсад оршин суудаг бөгөөд эрх бүхий байгууллага тухайн улсад шилжүүлэн өгөх тухай хүсэлт гаргавал хүсэлтийг тухайн гадаад улс хүлээн авснаас хойш дор дурдсан хугацаа хүртэл ХХХ зогсоно: - Герман улсын эрх бүхий байгууллагад гэмт хэрэгтнийг шилжүүлэх хүртэл, - Гэмт хэрэгтэн тухай улсын нутаг дэвсгэрийг өөр байдлаар орхих хүртэл, - Гадаад улс энэ хүсэлтэд татгалзсан тухай шийдвэрийг Герман улсын эрх бүхий байгууллага хүлээн авах хүртэл, эсвэл			

			сэжигтэнд энэ талаар мэдэгдэх, сэжигтнийг байцаах, гэрчээс мэдүүлэг авах, хэргийг шүүхэд шилжүүлэх, шүүхээс нэмэлт мөрдөн шалгалт явуулах гэх мэт хэргийг илрүүлэхэд чиглэсэн алхам тус бүрд уг хугацаа дахин дахин шинээр тоологдож эхэлдэг. Хөөн хэлэлцэх хугацааны зорилго нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хурдан дуусгахад оршдоггүй. Гэмт хэргийн хортой үр дагавар нь цаг хугацааны явцад шарх мэт аажмаар илаарьшдаг гэж үздэг. Иймд тухайн хэрэгт мөрдөн шалгах алхам хэрэгжүүлэх болгонд тэрхүү шарх сэдэрч, хэрэг шалгах, шийдвэрлэх хугацаа нь шинээр эхлэх ёстой гэсэн зарчим цаана нь агуулагдаж байдаг.	- Энэ хүсэлтийг бүцаан татах хүртэл. Үйлчлэхгүй байх тохиолдол: Тухайн хүсэлтийг гадаад улс хүлээн авсан огноо тодорхойгүй бегөөд хүсэлт гаргасан эрх бүхий байгууллага тухайн хүсэлтийг огт хүлээн авааагүй буюу хожуу хүлээн авсныг мэдсэнээс бусад тохиолдолд тухайн хүсэлтийг илгээснээс эсвэл гардуулснаас хойш нэг сарын дотор гадаад улс түүнийг хүлээж авсан гэж үзнэ. 2002 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн Зөвлөлийн шийдвэрээр батлагдсан Европын холбооны гишүүн орнууд хоорондбаривч илгаа явуулах болон хэрэгтэн шилжүүлэх тухай журам дээр (ABl. EG Nr. L 190 S. 1) эсвэл Эрүүгийн эрх зүйн асуудлаар улс орон хоорондын харилцан туслалцаа үзүүлэх тухай олон улсын гэрээн дээр ХХХ-ны тухай тєсөөтэй зохицуулсан бол энэ зүйлийн 1 дэх өгүүлбэр үйлчлэхгүй.	

2.				(6)Энэ хуулийн 78 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 1-3-т заасан тохиолдлуудын хувьд гэмт хэрэгтнийг Олон улсын эрүүгийн шүүх эсвэл шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх бүхий гадаад улс руу шилжүүлэхээс эхлэзд Герман улсын эрх бүхий байгууллагад буцаан шилжүүлэх хүртэл бүюу Олон улсын эрүүгийн шүүх эсвэл шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх бүхий гадаад улс тухайн этгээдийг ялаас чөлөөлөх хүртэл ХХХ зогсоно.		

№	Улсын нэр	Хөөн хэлэлцэх хугацааны ерөнхий зохицуулалт	Хугацааг тоолж эхлэх	Хугацаа тасрах, шинээр тоолох	Хугацааг зогсоох, сэргээн тоолох	Хугацааг тоолохгүй байх	Хугацааг тодорхой хязгаартай тоолох
3	Америкийн Нэгдсэн Улс	Эрүүгийн хууль нь тухайн улс орныхоо соёл иргэншил, түүхэн уламжлал, нийгэм, эдийн засаг, улс төрийн байгууламж зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан өөр өөр байдаг. Англи-Америкийн эрүүгийн хууль тогтоомжид Эрүүгийн хууль үйлчлэх цаг хугацааг заадаггүй, тэрчлэн хөөн хэлэлцэх хугацаа гэсэн институт байдаггүй.[5] Гэхдээ Англи-Америкийн эрх зүйн бүлд хамаарах улс орнуудад хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт хязгаарлагдмал хүрээнд /зарим гэмт хэргүүдэд/ хэрэглэдэг.[6] Иймд судалгааны энэ хэсэгт АНУ-ын хууль тогтоомжид заасан гэмт хэргийн хязгаарлалт (манай улсын хөөн хэлэлцэх хугацаатай төстэй зохицуулалт)-ыг авч үзнэ. АНУ-ын 18 мужийн Гэмт хэргийн ерөнхий хууль /18 U.S. Code/ 213 дугаар хэсэг Хязгаарлалт (3281-3301 дүгээр зүйл) 18 U.S. Code § 3281 – Цаазын ялтай гэмт хэргийн хувьд Цаазаар авах ялтай аливаа гэмт хэргийн яллах дүгнэлтийг ямар ч үед ямар ч хязгаарлалтгүйгээр хийж болно. 18 U.S. Code § 3282 – Цаазаас бусад ялтай гэмт хэргийн хувьд (a)Хуульд өөрөөр заагаагүй бол тухайн гэмт хэрэг үйлдсэнээс хойш 5 жилийн дотор яллах дүгнэлт үйлдэгдэхгүй, эсхүл мэдээлэл тогтоогдоогүй бол хэнд ч эрүүгийн хариуцлага ногдуулах ёсгүй. (b)ДНХ-ийн профайлын яллах дүгнэлт. (1) Ерөнхий зохицуулалт: 109A бүлэгт заасан яллагдагчийг хэн болох нь тодорхойгүй гэмт хэрэгт буруутгах, аливаа яллах дүгнэлтэд яллагдагчийг нэр нь тодорхойгүй боловч тодорхой ДНХ-ийн дүр төрхтэй хувь хүн гэж тодорхойлоход хангалттай. (2) Үл хамаарах зохицуулалт: 109A бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэгдсэнээс хойш 5 жилийн дотор илэрсэн (1)-д заасан аливаа яллах дүгнэлтэд дараах зүйлс хамаарахгүй: (A) (a) дэд хэсэгт тодорхойлсон хөөн хэлэлцэх хугацаа; болон (B) яллах дүгнэлтэд тусгагдсан хэргүүдтэй холбогдуулан тухайн хүнийг баривчлах буюу зарлан дуудах хуудас өгөх хүртэл 208 дугаар бүлгийн заалтууд. (3) Нэр томьёоны тодорхойлолт:					

5 Д.Баярсайхан, Харьцуулсан эрүүгийн эрх зүй, (Уб, 2011), 42 дахь тал.

6 Улсын дээд шүүх, Авлигын болон эдийн засгийн зарим гэмт хэргийн эрх зүйн шинж, шүүхийн практик /гарын авлага/, (Уб, 2011), 254 дэх тал.

		Энэ дэд хэсгийн зорилгын үүднээс «ДНХ-ийн профайл" гэсэн нэр томьёо нь ДНХ-ийн таних шинж чанаруудын багцыг хэлнэ. 18 U.S. Code § 3283 – Хүүхдийн эсрэг гэмт хэрэг 18-аас доош насны хүүхдэд бэлгийн болон бие махбодын хүчирхийлэл үйлдэх, хулгайлах гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тоолохгүй. 18 U.S. Code § 3284 - Дампуурлын хөрөнгийг нуун дарагдуулах гэмт хэрэг 11 дүгээр зүйлд заасан хэрэгт хариуцагчийн эд хөрөнгийг нуун дарагдуулсан хариуцагчийг эцэслэн чөлөөлөх, эсхүл төлбөрөөс чөлөөлөхөөс таталзах хүртэл үйлдэл нь үргэлжилсэн гэмт хэрэгт тооцогдох бөгөөд уг хэргийг эцэслэн хэрэгсэхгүй болгох хүртэл хөөн хэлэлцэх хугацаа эхлэхгүй. 18 U.S. Code § 3285 – Яп шийтгэл биелүүлэхгүй байх, шүүхийн шийдвэрийг үл хүндэтгэх Аливаа хүн, корпорац, нийгэмлэг нь энэ хуулийн 402 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийсэн бол бүрүүтай үйлдлээс хойш нэг жилийн дотор хуулийн хариуцлага хүлээлгэнэ. Гэсэн хэдий ч үл хүндэтгэсэн тохиолдолд хуулийн хариуцлага хүлээлгэдэг байсан ч энэ нь ижил гэмт хэрэгт тусдаа эрүүгийн хэрэг үүсгэхийг зогсоож чадахгүй. 18 U.S. Code § 3286 - Терроризмын гэмт хэрэг (а) Найман жилийн хязгаарлалт 3282-р хэсгийг үл харгалзан, терроризмын гэмт хэрэг үйлдсэнээс хойш 8 жилийн дотор яллах дүгнэлт илрээгүй буюу мэдээлэл тогтоогдоогүй бол хэнд ч эрүүгийн хариуцлага ногдуулах ёсгүй. (б) Хязгаарлалтгүй 2332b(g)(5)(B)-д заасан гэмт хэрэг нь бусдын амь насыг хохироох, бие махбодод хүнд гэмтэл учруулах эрсдэлтэй буюу урьдчилан таамаглахүйц эрсдэлийг бий болгож байгаа бол гэмт этгээдийг яллах хугацаа байхгүй. Тодруулбал: АНУ-д хүн амины гэмт хэрэг нь цаазаар авах ялтай байдаг тул тус гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй. Мен терроризмын гэмт хэрэг нь хүний амь насанд хүрэх эрсдэл өндөр байдаг тул хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй, харин амь насанд хүрээгүй, амь насанд хүрэх хүнд гэмтэл учруулаагүй бол хөөн хэлэлцэх хугацаа 8 жил байна. Үүнээс гадна АНУ-д цагаан захтнуудын гэмт хэрэг (white collar crime)-ийн хөөн хэлэлцэх хугацаа мөн өөр байдаг.

№	Улсын нэр	Хөөн хэлэлцэх хугацааны ерөнхий зохицуулалт	Хугацааг тоолж эхлэх	Хугацаа тасрах, шинэзэр тоолох	Хугацааг зогсоох, сэргээн тоолох	Хугацааг тоолохгүй байх	Хугацааг тодорхой хязгаартай тоолох
4	Бүгд Найрамдах Эстони Улс	Эрүүгийн хууль (Penal code) 6 дугаар бүлэг 81 дугээр зүйл Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа (1)Эрүүгийн гэмт хэрэг үйлдэж дуусанаас шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл дараах хугацаа дуусан бол хэнийг ч эрүүгийн гэмт хэрэгт буруутгаж, шийтгэж болохгүй. - нэгдүгээр зэргийн эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд 10 жил; - хоёрдугаар зэргийн эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд 5 жил. Тодруулбал: Эстони улсын Эрүүгийн хуульд гэмт хэргийг нэгдүгээр зэрэг, хоёрдугаар зэрэг хэмээн ангилдаг. Нэгдүгээр зэргийн гэмт хэрэг нь тус хуульд заасан гэмт хэрэгтэнд таван жилээс дээш хугацаагаар хорих, эсхүл бүх насаар нь хорих ял	81 дугээр зүйл (4) Хэд хэдэн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг сүүлчийн үйлдэл дуусанаар тооцно. Үргэлжилсэн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг үргэлжилсэн үйлдлийг дуусгавар болгосноор тооцно. Тодруулбал: Ямарваа нэгэн гэмт хэргийн үйлдлийг дуусгавар болгосноор хөөн хэлэлцэх хугацааг тоолж эхэлнэ.	81 дугээр зүйл (5) Эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд дараах байцаан шийтгэх үйлдлийг хийснээр хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасалдана: 1/сэжиттэн, яллагдагчид урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, түүний эд хөрөнгө, мөнгө угаах гэмт хэргийн объект болох эд хөрөнгийг битүүмжлэх; 2) яллагдагчийг яллах; 3/ яллагдагч ирэгүй тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хойшлуулах; 4/шүүх хуралдааныд яллагдагчаас байцаалт авах; 5/шүүх хуралдааныд шинжээчийн дүгнэлт гаргах буюу нэмэлт нотлох баримт гаргах. (7) Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дараах тохиолдолд тасалдана:	81 дугээр зүйл (6[1]) Рийгикогугийн гишүүдийн халдашгүй эрхтэй холбоотой эрүүгийн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэх тухай заалтыг Рийгикогугийн гишүүдийн байдлын тухай хуулийн § 18[1]-д заасан болно. Рийгикогугийн гишүүдийн байдлын тухай хууль § 18[1] дүгээр зүйл (1) Хэрэв Рийгикогу гишүүн эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэгдэж байгаа бол уг хэргийн хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлнэ. (2) Рийгикогу гишүүний талаар нэхэмжлэл гаргахыг зөвшөөрснөөр, эсвэл Рийгикогу гишүүний бүрэн эрх дуусгавар болсон үед хөөн хэлэлцэх хугацаа дахин үргэлжилнэ.	81 дугээр зүйл (2) Түрэмгийллийн гэмт хэрэг, геноцидын гэмт хэрэг, хүн терөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг, бүх насаар нь хорих ял оногдуулсан эрүүгийн гэмт хэргийн хувьд хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй.	81 дугээр зүйл (8) Энэ зүйлийн (7) 1), 2)-д заасан тохиолдолд эрүүгийн гэмт хэрэг үйлдсэнээс хойш 15 жилээс илүү хугацаа өнгөрсөн бол хөөн хэлэлцэх хугацааг сэргээж болохгүй. Зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаа дууссанаас хойш 3 жилээс илүү хугацаа өнгөрсөн бол дахин сэргээж болохгүй. Зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаа 3 жил бол гэмт хэрэг дуусгавар болсноос хойш 10 өнгөрсөн бол түүнийг сэргээхгүй.

	оногдуулсан гэмт хэргийг; хоёрдугаар зэргийн гэмт хэрэг гэж тус хуульд заасан таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл эд хөрөнгийн ялаар шийтгэгдсэн гэмт хэргийг ойлгоно. Эстони улсын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа багадаа 5 жил, ихдээ 10 жил байхаар байна.		1/ сэжигтэн, яллагдагч, байцаан шийтгэх ажиллагаа явуулж буй этгээд урьдчилан байцаан шийтгэх ажиллагаа, шүүхээс гадуурх байцаан шийтгэх ажиллагаа, шүүхээс оргон зайлсан тохиолдолд тухайн хүнийг саатуулах, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй байгууллагад ирэх хүртэл; 2) гэмт хэргийн шинжтэй үйлдлийн талаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлснээс хойш эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болох хүртэл; 3) 18 нас хүрээгүй хүний эсрэг бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хохирогчийг 18 нас хүртлээ эрүүгийн хэрэг үүсгэсэн шаптгаан нь хохирогч ийм насанд хүрэхээс өмнө тодорхой болоогүй бол.		

			Шинээр тоолох (6) Эрүүгийн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасалдсан бол энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан байцаан шийтгэх ажиллагааг гүйцэтгэснээр хөөн хэлэлцэх хугацаа дахин эхэлнэ. Гэсэн хэдий ч эрүүгийн гэмт хэрэг үйлдэж дуусанаас шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаа энэ хуулийн (1) дэх хэсэгт заасан хугацаанаас таван жилээр илүү байвал тухайн этгээдийг эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, шийтгэж болохгүй.		

№	Улсын нэр	Хөөн хэлэлцэх хугацааны ерөнхий зохицуулалт	Хугацааг тоолж эхлэх	Хугацаа тасрах, шинээр тоолох	Хугацааг зогсоох, сэргээн тоолох	Хугацааг тоолохгүй байх	Хугацааг тодорхой хязгаартай тоолох
5	Япон Улс[7]	Эрүүгийн процессын хуулийн 250 дугаар зүйл. (1) Хүний амь насыг хохироосон гэмт хэрэг, хөдөлмөр эрхлүүлээгүй, эсхүл илүү хүндээр хорих ял оногдуулах гэмт хэрэг (цаазын ял оногдуулахаас бусад)-т дараах хугацаа өнгөрсний дараа хөөн хэлэлцэх хугацаа дуусна: (i) бүх насаар нь хорих, эсхүл хөдөлмөр эрхлүүлэхгүйгээр бүх насаар нь хорих ялаар шийтгүүлсэн гэмт хэрэгт 30 жил; (ii) дээд тал нь 20 жилийн хугацаатай хорих, эсхүл хөдөлмөр эрхлэхгүй хорих ялаар шийтгэгдэх гэмт хэрэгт 20 жил,; (iii) өмнөх хоёр зүйлд зааснаас бусад гэмт хэрэгт 10 жил. (2) Хүний амь нас хохироосон, хөдөлмөр эрхлүүлээгүй, эсхүл илүү хүнд хэлбэрийн ял оногдуулахаас бусад гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дараах хугацаа өнгөрсний дараа дуусна. (i) цаазаар авах ялаар шийтгэгдэх гэмт хэрэгт 25 жил;	Эрүүгийн процессын хуулийн 253 дугаар зүйл. (1) Хөөн хэлэлцэх хугацаань гэмт хэрэг үйлдэгдсэн үеэс эхлэн тоологдоно. (2) Хамтран оролцогчтой холбоотой хэргийн хувьд, бүх хамсаатны хувьд хөөн хэлэлцэх хугацаань эцсийн үйлдэл зогссон үеэс эхлэн тоологдоно.	Эрүүгийн процессын хуулийн 251 дүгээр зүйл. Хоёр буюу түүнээс дээш үндсэн ялыг хавсарч оногдуулах, эсхүл хоёр буюу түүнээс дээш үндсэн ялын аль нэгийг оногдуулах гэмт хэргийн хувьд хамгийн хүнд ялын тухайд хөөн хэлэлцэх хугацааны заалтыг хэрэглэнэ.		Эрүүгийн процессын хуульд энэ тухай заагаагүй.	Эрүүгийн процессын хуулийн 252 дугаар зүйл. Эрүүгийн хуульд заасны дагуу ялыг нэмэгдүүлэх, хөнгөлөхөд 250 дугаар зүйлийн заалтыг нэмэгдүүлээгүй, хөнгөрүүлээгүй ялыг үндэслэн тоолно.

7 Japan’s Code of Criminal Procedure Act No. 131 of 1948, https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3739/en

	(ii) бүх насаар нь хорих, эсхүл хөдөлмөр эрхлүүлэхгүй бүх насаар нь хорих ял оногдуулсан гэмт хэрэгт 15 жил; (iii) 15 жил ба түүнээс дээш хугацаагаар хорих, эсхүл хөдөлмөр эрхлүүлэхгүй хорих ялаар шийтгэдэх гэмт хэрэгт 10 жил; (iv) 15 жилээс бага хугацаагаар хорих, эсхүл ажил хөдөлмөр эрхлүүлэгүй хорих ялаар шийтгүүлсэн гэмт хэрэгт 7 жил; (v) 10 жилээс бага хугацаагаар хорих, эсхүл хөдөлмөр эрхлүүлэхгүй хорих ялаар шийтгүүлсэн гэмт хэрэгт 5 жил; (vi) 5 жилээс бага хугацаагаар хорих, эсхүл торгууль ногдуулах гэмт хэрэг үйлдсэн бол 3 жил; (vii) баривчлах эсвэл бага хэмжээний торгууль ногдуулах шийтгэл ногдуулах гэмт хэрэг үйлдсэн бол 1 жил.			Эрүүгийн процессын хуулийн 254 дүгээр зүйл. (1) Хөөн хэлэлцэх хугацаа нь холбогдох хэргийн эсрэг яллах үйл ажиллагаа явуулахаа больсон, шүүх эрх мэдлийн эрх хэмжээ хүрэхгүй гэж мэдэгдсэн эсвэл яллах ажиллагааг хэрэгсэхгүй болгосон шийдвэр эцэслэн хүчин төгөлдөр болсон үед тоологдож эхэлнэ. (2) Хамтран оролцогчийн аль нэгийг нь яллагдагчаар татсаны улмаас хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлсэн нь бусад хамтран оролцогчийн хувьд хүчин төгөлдөр болно. Энэ тохиолдолд түдгэлзүүлсэн хугацаа нь тухайн хэргийн шийдвэр эцэслэн хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн тоологдоно. 255 дугаар зүйл (1) Хэрэв гэмт хэрэгтэн Японоос гадуур байгаа эсвэл тухайн гэмт хэрэгтэн нуугдаж байгаа үед ялын хуудас өгөх, хураангуй тушаалыг мэдэгдэх боломжгүй бол тухайн гэмт хэрэгтэн Японоос гадуур байх хугацаанд хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлнэ.		

					(2) Шүүхийн журамд гэмт хэрэгтэн Японоос ирээгүй буюу нуугдаж байгаа эсэхийг нотлоход шаардлагатай заалтуудыг тусгасан бөгөөд үүнд яллагдагчаар татах тогтоол, хураангуй тушаалын талаар мэдэгдэх боломжгүй болсон байх ёстой.		

№	Улсын нэр	Хөөн хэлэлцэх хугацааны ерөнхий зохицуулалт	Хугацааг тоолж эхлэх	Хугацаа тасрах, шинээр тоолох	Хугацааг зогсоох, сэргээн тоолох	Хугацааг тоолохгүй байх	Хугацааг тодорхой хязгаартай тоолох
6	Бүгд Найрамдах Солонгос Улс[8]	Эрүүгийн процессын хуулийн 249 дүгээр зүйл. Улсын яллах хөөн хэлэлцэх хугацаа. (1) Улсын яллах тогтоол нь дараах хугацаа дууссаны дараа дуусгавар болно. 1. Цаазаар авах ялаар шийтгэх гэмт хэрэгт хорин таван жил; 2. Бүх насаар нь хорих ялаар шийтгэх, эсхүл бүх насаар хөдөлмөрлүүлж хорих ял оногдуулах гэмт хэрэгт арван таван жил; 3.Хорих, эсхүл арав ба түүнээс дээш жил хорих ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэн бол арван жил;	Эрүүгийн процессын хуулийн 252 дугаар зүйл. Хөөн хэлэлцэх хугацааг тоолж эхлэх (1) Эрүүгийн хэрэг үйлдэж дууссаны дараа хөөн хэлэлцэх хугацаа эхэлнэ. (2) Хамтран үйлдэгчийн хувьд эрүүгийн хэрэг эцэслэн зогссон үеэс хөөн хэлэлцэх хугацаа эхэлнэ.	Эрүүгийн процессын хуулийн 250 дугаар зүйл. Хоёр ба түүнээс дээш ялын хөөн хэлэлцэх хугацаа Хоёр буюу түүнээс дээш үндсэн ялыг хамтад нь ногдуулах, эсхүл хоёр ба түүнээс дээш үндсэн ялаас нэгийг нь оногдуулах гэмт хэргийн хувьд хамгийн хүнд ялыг харгалзан өмнөх зүйлийн заалтыг хэрэглэнэ.	Эрүүгийн процессын хуулийн 253 дугаар зүйл. Хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэх, түүний үр нөлөө (1) Улсын яллах ажиллагааг хэрэгсэхгүй болгосон, шүүхийн харьяаллыг зөрчсөнийг нотолсон шийдвэр эцсийн байдлаар хүчин төгөлдөр болмогц хөөн хэлэлцэх хугацаа нь улсын яллах ажиллагааг зогсоож, тоологдож эхэлнэ	-Олон улсын эрүүгийн шүүхийн харьяалах гэмт хэргийг шийтгэх тухай хуулийн 6 дугаар зүйл. Хөөн хэлэлцэх хугацаа үйлчлэхгүй байх. Геноцидын төрлийн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа үйлчлэхгүй. (Геноцидын төрлийн гэмт хэрэг гэдэгт геноцид, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэргүүд хамаарна.)[9]	Эрүүгийн процессын хуулийн 249 дүгээр зүйл. Улсын яллах ажиллагаа явуулж, эцсийн шийдвэр гаргаагүй гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь тухайн улсын ялласан өдрөөс хойш хорин таван жил байна.[10] Эрүүгийн процессын хуулийн 251 дүгээр зүйл. Эрүүгийн хуульд заасны дагуу ялыг нэмэгдүүлэх, хөнгөлөх тохиолдолд 249 дүгээр зүйлийн заалтыг нэмэгдүүлэх, хөнгөлөхөөс өмнөх ялыг харгалзан үзнэ. Хүчингийн болон танхайрлын гэмт хэргийн хувьд гэмт хэргийг нотлох шинжлэх ухааны үндэслэлтэй нотлох баримт, тухайлбал ДНХ-ийн нотлох баримт байгаа тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг 10 жилээр сунгадаг.

8 CRIMINAL PROCEDURE ACT OF KOREAN, Expand Act No. 9765, jun. 9, 2009, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?lang=ENG&hseq=22535

9 Act on the Punishment, etc. of Crimes under the Jurisdiction of the International Criminal Court [Enforced into force on April 12, 2011] [Law No. 10577, April 12, 2011, partially revised], https://www.law.go.kr/LSW//lsLawLinkInfo.do?lsJoLnkSeq=900147921&chrClsCd=010202&ancYnChk=

10 Мөн тэнд.

	4. Хорих, эсхүл арваас доошгүй жил хорих ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэн бол долоон жил; 5.Хорих, эсхүл таван жилээс доошгүй хугацаагаар хорих ял оногдуулах, эсхүл арваас доошгүй жилээр мэргэшүүлэхийг тудгэлзүүлэх, эсхүл торгох шийтгэл оногдуулсан гэмт хэрэгт таван жил; 6.Мэргэжлийн эрхийг дээд тал нь таваас доошгүй жилээр хасах шийтгэл оногдуулах гэмт хэрэгт гурван жил; болон 7.Мэргэжлийн эрхийг таваас доошгүй жилээр хасах, эсхүл сахилгын шийтгэл ногдуулах, хөнгөн торгох, эд хөрөнгө хураах шийтгэл оногдуулсан гэмт хэрэгт нэг жил. (2) Улсын яллах ажиллагаа явуулж, эцсийн шийдвэр гаргаагүй гэмт хэрэгийн хөөн хэлэлцэх хугацаа нь тухайн улсын ялласан өдрөөс хойш хорин таван жил байна.			(2) Өмнөх хэсэгт дурдсан хэд хэдэн хамтран оролцогчийн аль нэгнийх нь эсрэг эрүүгийн хэрэг үүсгэсэн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг бусад хамтран оролцогчдын хувьд түдгэлзүүлж, холбогдох хэргийн шийдвэр эцэслэн тарсны дараа дахин яллаж эхэлнэ. (3) Гэмт этгээд эрүүгийн ялаас мултрах зорилгоор гадаадад байх хугацаанд хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлнэ.	- Хүчингийн гэмт хэрэг, хүн амины хэрэг үйлдэгдсэн бол хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй. (Бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг шийтгэх тухай хуулийн 295-2-р зүйл)-д хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй[11].	(Бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг шийтгэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хүүхэд, өсвөр үеийнхний бэлгийн харилцааг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэг) Ард нийтийн санал асуулгын тухай хуулийг зөрчсөн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа санал хураалт явуулснаас хойш гурван сарын дараа дуусна. Харин гэмт хэрэгтэн оргон зайлсан тохиолдолд хугацаа нь нэг жил байна. (Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 122 дугаар зүйл) Төрийн албан хаагчийн тухай хууль, орон нутгийн төрийн албан хаагчийн тухай хуулийг зөрчсөн гэмт хэргүүдийн дотроос улс төрийн үйл ажиллагаа явуулах хөөн хэлэлцэх хугацаа 10 жил байна. (Үндэсний төрийн албан хаагчийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Орон нутгийн төрийн албан хаагчийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 2 дахь хэсэг) Энэхүү тустай заалтыг 2014 оны 1 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн мөрдөж байна. Цэргийн гэмт хэргийн тухай хууль, Үндэсний тагнуулын

11 공소시효, https://namu.wiki/w/%EA%B3%B5%EC%86%8C%EC%8B%9C%ED%9A%A8

					албаны тухай хуулийг зөрчсөн гэмт хэргүүдийн дотор улс төрийн оролцооны хөөн хэлэлцэх хугацаа мөн 10 жил байна. (Цэргийн гэмт хэргийн тухай хуулийн 94 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг. Үндэсний тагнуулын албаны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 3 дахь хэсэг) Төрийн албаны сонгуулийн тухай хуулийг зөрчсөн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа сонгуулийн өдрөөс хойш 6 сарын дараа (сонгуулийн өдрөөс хойш үйлдсэн гэмт хэргийн хувьд, үйлдэл гарсан өдрөөс хойш 6 сарын дараа) дуусна. (Төрийн албаны сонгуулийн тухай хуулийн 268 дугаар зүйлийн 1 дэх хэсэг) Гэсэн хэдий ч зарим үл хамаарах зүйлүүд байдаг. Цэргийн албыг хаасан тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа 10 жил байдаг ч тухайн алба бүрийн штабын дарга хөөн хэлэлцэх хугацаа дуусахаас өмнө буцах тушаал гаргадаг тул 10 жилийн дараа ч гэсэн тушаал зөрчсөн тохиолдолд шийтгэдэг. . Даалгавар зөрчсөн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа 5 жил байдаг ч хөөн хэлэлцэх хугацаа дуусахаас өмнө ажилд эгүүлэн тогтоолгох тушаал удаа дараа гарсан

							тохиолдолд энэ нь мөн зогсдог. Цэргийн албан тушаалаас цэргээ тэтгэвэрт гарах насанд хүрмэгц буцаж ирэх сүүлчийн тушаалыг арми тус бүрийн штабын дарга гаргадаг тул цэргээс цэргээ орхих шийтгэл хүлээхээс зайлсхийхийн тулд та цэргийн цолны тэтгэвэрт гарах нас 5 жил өнгөрөх хүртэл хүлээх хэрэгтэй.[12]

№	Улсын нэр	Хөөн хэлэлцэх хугацааны ерөнхий зохицуулалт	Хугацааг тоолж эхлэх	Хугацаа тасрах, шинээр тоолох	Хугацааг зогсоох, сэргээн тоолох	Хугацааг тоолохгүй байх	Хугацааг тодорхой хязгаартай тоолох
7.	Оросын Холбооны Улс[13]	Эрүүгийн хэргийн хөөн хэлэлцэх хугацааны талаар анх 1775 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн Екатерина II хатан хааны зарлигийн 44 дүгээр зүйлд тусгагдсан. ЗХУ-ын хууль тогтоомжуудад хөөн хэлэлцэх хугацааны талаар 1922 оны Эрүүгийн хуулийн 21-22 дугаар зүйлүүдэд орчин үед хэрэглэгдэж байсан уг агуулгаар нь анх зохицуулсан.[14] Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 1996 оны Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлд хөөн хэлэлцэх хугацааг зохицуулсан.	Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг эрүүгийн гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс эхлэн шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болох хүртэл тоолно" гэж заасан.	Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хөөн хэлэлцэх хугацаанд шинэ гэмт хэрэг үйлдсэн бол хөөн хэлэлцэх хугацааг тоолохдоо гэмт хэрэг тус бүрээр тусад нь тоолно гэж зохицуулсан байна.	Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 3 дахь зүйлд зааснаар мөрдөн шалгах ажиллагаа эсхүл шүүх хуралдаанаас оргон зайлсан бол хөөн хэлэлцэх хугацааг зогсоож уг этгээд баригдсан, эсхүл хэргээ өөрөө илчилж ирсэн өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг сэргээн тоолно.	Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар бусад улс орнуудын жишгээр хүн төрөлхтний эсрэг, түрэмгий дайн төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дайны үед хориглосон арга, хэрэгсэл хэрэглэх, төрөөр устгах, экосистемийг сүйтгэх зэрэг гэмт хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацааг тоолохгүй гэжээ. Мөн хуулийн 78.4 дэх хэсэгт зааснаар бүх насаар хорих эсхүл цаазаар авах ял оноох гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолох эсэхийг шүүх шийдвэрлэнэ.	Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг эрүүгийн гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс эхлэн шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болох хүртэл тоолно” гэж заасан нь хөөн хэлэлцэх хугацааг тодорхой хугацаатайгаар тоолох онцлогтой зохицуулалт юм.

12 공소시효, https://namu.wiki/w/%EA%B3%B5%EC%86%8C%EC%8B%9C%ED%9A%A8

13 ОХУ-ын Эрүүгийн хууль, https://www.legal-tools.org/doc/8eed35/pdf/

14 С.Өмирбек, Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа, түүнийг тоолох журам, харьцуулсан судалгаа, 2023.11.10, https://omir.blogmn.net/116964/gemt-hergiig-huun-helelceh-hugacaa,-tuuniig-tooloh-juram,--harcuulsan-sudalgaa.html.

		ОХУ-ын Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хөнгөн гэмт хэрэг үйлдсэнээс хойш хоёр жил, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэнээс хойш зургаан жил, хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван жил, онц хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван таван жил хөөн хэлэлцэх хугацаатай байхаар хуульчилсан.				Хэрэв хөөн хэлэлцэх хугацаа дууссантай холбоотойгоор уг этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх боломжгүй гэж үзвэл шүүх бүх насаар хорих эсхүл цаазаар авах ялыг хэрэглэхгүй гэжээ.	

№	Улсын нэр	Хөөн хэлэлцэх хугацааны ерөнхий зохицуулалт	Хугацааг тоолж эхлэх	Хугацаа тасрах, шинээр тоолох	Хугацааг зогсоох, сэргээн тоолох	Хугацааг тоолохгүй байх	Хугацааг тодорхой хязгаартай тоолох
8.	Шведийн Хаант Улс[15]	Тус улсын Эрүүгийн эрх зүйн гол эх сурвалж нь 1962 оны Эрүүгийн хууль бөгөөд тус хуулийн 35 дугаар бүлэгт хөөн хэлэлцэх хугацааг зохицуулсан.	ЭХ-ийн 35 бүлгийн 4 дэх хэсэгт зааснаар хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн үеэс тооцно. Гэвч гэмт хэргийн бүрэлдэхүүний хувьд хор уршиг байхыг шаардсан бол хор уршиг илэрсэн үеэс хөөн хэлэлцэх хугацааг тооцно. Эрүүгийн хуулийн 35 дугаар бүлгийн 4 дэх хэсэгт зааснаар дараах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хохирогч 18 нас хүрсэн эсхүл хүрэх өдрөөс эхлэн тоолно гэжээ. Үүнд:	Хөөн хэлэлцэх хугацааны явцад дахин шинэ гэмт хэрэг үйлдэх тохиолдлыг нарийвчлан зохицуулаагүй. Гэвч ЭХ-ийн 35 дугаар бүлгийн 1 дэх хэсэгт зааснаар үйлдэлнь хэд хэдэн гэмт хэргийн шинжийг хангаж байх тохиолдолд тэдгээрийн аль нэгт эрүүгийн	Хөөн хэлэлцэх хугацааг зогсоох, сэргээн тоолох зохицуулалт нарийвчлан тусгагдаагүй.[16]	Эрүүгийн хуулийн 35 дугаар бүлгийн 2 дахь хэсэгт зааснаар дараах тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг тоолохгүй. Үүнд:[17] ЭХ-ийн 3-р бүлгийн 1, 2 дахь хэсэгт заасан хүнийг санаатай болон болгоомжгүй алах гэмт хэрэг үйлдсэн; ЭХ-ийн 6-р бүлгийн 1 дэх хэсгийн 1 болон 3 дахь заалт дахь хүчиндэх гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон эсхүл эрхшээлдээ байсан хүнийг хүчиндсэн гэмт хэрэг (Гэвч хохирогч нь 18 нас хүрээгүй байх) үйлдсэн бол;	Эрүүгийн хууль бөгөөд тус хуулийн 35 дугаар бүлгийн 1 дэх хэсэгт яллагдагчаар татсан тухай мэдэгдлийг хүргүүлээгүй эсхүл баривчлагдаагүй бол хөөн хэлэлцэх хугацааг тоолохоор тогтоосон байна. Өөрөөр хэлбэл яллагдагчаар татсан тухай

15 Шведийн Эрүүгийн хууль, https://www.government.se/contentassets/7a2dcae0787e465e9a2431554b5eab03/the-swedish-criminal-code.pdf

16 Research note on Limitation rules in criminal matters, Directorate-General for Library, Research and Documentation https://curia.europa.eu/jcms/upload/docs/application/pdf/2019-12/ndr-2017-005_synthese_en_neutralisee_finale.pdf, p.60.

17 Шведийн Эрүүгийн хууль, https://www.government.se/contentassets/7a2dcae0787e465e9a2431554b5eab03/the-swedish-criminal-code.pdf

	Яллагдагчаар татсан тухай мэдэгдлийг хүргүүлээгүй эсхүл баривчлагдаагүй бол хөөн хэлэлцэх хугацааг дараах 5 төрлөөр тогтоосон байна. Үүнд, гэмт хэрэгт оногдуулах хорих ялын хэмжээ 1 жилээс ихгүй бол 2 жил, 2 жилээс ихгүй бол 5 жил, 8 жилээс ихгүй бол 10 жил, 8 жилээс их бол 15 жил, бүх насаар хорих ял ногдуулах бол 25 жил байхаар тус тус заажээ.	6-р бүлгийн 4-6, 8, 9 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдэх, түүнд завдах 6-р бүлгийн 1-3, 10, 12 дахь хэсэгт заасан гэмт хэргийг үйлдэх, эсхүл 6-р бүлгийн 1, 2, 12 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт завдах (18 нас хүрээгүй хүний эсрэг үйлдсэн байх) 16 бүлгийн 10а хэсгийн 1 болон 6 дахь заалтад заасан гэмт хэргийг үйлдсэн эсхүл түүнд завдсан (хүүхэд оролцуулж порнограф бүтээсэн бөгөөд 1 дэх заалтыг хэрэглэх тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг дараа нь тоолохгүй) Эмэгтэй хүний бэлэг эрхтнийг гэмтээх гаж зан үйлийн эсрэг хуулийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг 18 насанд хүрээгүй хүний эсрэг үйлдсэн бол; Нягтлан бодох бүртгэлийг санаатайгаар өөрчилсөн, нуусан хөнгөн бус гэмт хэргийн хувьд тус гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг дампуурал зарласан өдрөөс эсхүл компанийн бүтцийг өөрчлөх хурлаар зөвлөгчээс өрийг тодорхой хэмжээгээр тооцож дуусгавар болгох санал ирсэн эсхүл ийм санал хүлээж авсан өдрөөс тооцно. (Гэвч дээрх нөхцөл байдлууд нь гэмт хэрэг үйлдсэнээс 5 жилийн дотор бий болсон байх).	хариуцлага хүлээлгэж болохоор бол 35.1 дэх хэсгийг үл харгалзан тэдгээрийн тус бүрд нь эрүүгийн хариуцлага ногдуулж болно гэжээ.		ЭХ-ийн 6-р бүлгийн 4 дэх хэсэгт заасан 15 нас хүрээгүй хүүхдийн эсрэг үйлдсэн хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн бол; Эмэгтэй хүний бэлэг эрхтнийг гэмтээх гаж зан үйлийн эсрэг хуулийн 2 дахь заалтад заасан гэмт хэргийг 18 насанд хүрээгүй хүний эсрэг үйлдсэн бол; Зарим төрлийн олон улсын гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай хуульд заасан төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг, дайн өдөөх гэмт хэрэг үйлдсэн бол Терроризмын гэмт хэргийн тухай хуулийн 4 дэх хэсэгт заасан террорист үйлдэл үйлдсэн бол Энэ хэсгийн 1, 5, 6 дахь гэмт хэрэгт завдсан бол. Гэвч дээрх гэмт хэргийг 18 насанд хүрээгүй хүн үйлдсэн бол хөөн хэлэлцэх хугацаа үйлчилнэ.	мэдэгдлийг хүргүүлэх эсхүл баривчлах хүртэл хөөн хэлэлцэх хугацааг тоолох зохицуулалт нь хөөн хэлэлцэх хугацааг тодорхой хугацаатайгаар тоолох онцлогтой зохицуулалт юм.

№	Улсын нэр	Хөөн хэлэлцэх хугацааны ерөнхий зохицуулалт	Хугацааг тоолж эхлэх	Хугацаа тасрах, шинээр тоолох	Хугацааг зогсоох, сэргээн тоолох	Хугацаагүй байх	Хугацааг тодорхой хязгаартай тоолох
9.	Норвегийн Хант Улс[18]	Тус улсын 2005 оны Эрүүгийн хуулийн 86 дугаар зүйлд хөөн хэлэлцэх хугацааг дараах байдлаар тогтоожээ. Үүнд: а. Хорих ялын дээд хэмжээ 1 жилээс ихгүй бол 2 жил б. Хорих ялын дээд хэмжээ 3 жилээс ихгүй бол 5 жил в. Хорих ялын дээд хэмжээ 10 жилээс ихгүй бол 10 жил г. Хорих ялын дээд хэмжээ 15 жилээс ихгүй бол 15 жил д. Хорих ялын дээд хэмжээ 21 жилээс ихгүй бол 25 жил Торгох ялтай гэмт хэргийн хувьд торгох ялыг хорих ялд шилжүүлж хөөн хэлэлцэх хугацааг тодорхойлно. 89 дүгээр зүйлд хуулийн этгээдтэй холбоотой хөөн хэлэлцэх хугацааг тогтоосон байх бөгөөд түүнд холбогдох гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тооцохдоо эрх бүхий албан тушаалтанд оногдуулах хорих ялын дээд хэмжээг үндэслэнэ гэжээ.	ЭХ-ийн 87 дугаар зүйлд зааснаар гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хөөн хэлэлцэх хугацааг тооцно. ЭХ 87 дугаар зүйлд зааснаар ЭХ-ийн 253, 257, 282, 284, 299 болон 302 дахь хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь хохирогч 18 нас хүрснээс тоологдоно. Цаашлаад гэмт хэргийн бүрэлдэхүүний хувьд хор уршиг байхыг шаардсан бол хор уршиг илэрсэн үеэс хөөн хэлэлцэх хугацааг тооцно. ЭХ-ийн 90 дүгээр зүйлд зааснаар ЭХ 392, 394 дэх хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг дампуурлын ажиллагаа эсхүл өр тооцох ажиллагааны явцад тоолохгүй гэжээ.	Хөөн хэлэлцэх хугацааны явцад дахин шинэ гэмт хэрэг үйлдэх тохиолдлыг нарийвчлан зохицуулаагүй. Гэвч ЭХ-ийн 86 дугаар зүйлд зааснаар нэг үйлдлээр хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн бол аль урт хөөн хэлэлцэх хугацааг бүх гэмт хэрэгт хэрэглэнэ гэжээ.	ЭХ-ийн 88 дугаар зүйлд хөөн хэлэлцэх хугацаа дууссан эсэхийг тооцохдоо мөрдөн шалгах ажиллагааны хугацааг оруулж тооцно. Гэвч мөрдөн шалгах ажиллагаанаас оргон зайлснаас үүдэн мөрдөн шалгах ажиллагаа түдгэлзсэн хугацааг үүнд оруулж тооцохгүй гэжээ.	ЭХ-ийн 91 дүгээр зүйлд зааснаар дараах гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тооцохгүй. Үүнд, төрлөөр устгах, дайны гэмт хэрэг болон 15 болон түүнээс дээш хорих ял ногдуулах террорист гэмт үйлдэл хамаарна. ЭХ-ийн 275, 291, 299 болон 302 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тооцохгүй. Мөн 355 дугаар хэсэгт заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон бол хөөн хэлэлцэх хугацаа тооцохгүй.	ЭХ-ийн 88 дугаар зүйлд зааснаар сэжигтэн яллагдагчаар татагдсанаар 86 дугаар зүйлд заасан хөөн хэлэлцэх хугацаа зогсоно. ЭХ-ийн 88 дугаар зүйлд зааснаар мөрдөн шалган ажиллагааг үргэлжлүүлэх тухай дээд шатны прокурорын шийдвэр гараагүй тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг зогсоох зохицуулалтын үйлчлэл зогсоно. Мөн мөрдөн шалгах ажиллагааг хугацаагүйгээр түдгэлзүүлсэн тохиолдолд дээрх зохицуулалт хэрэглэгдэнэ.

18 Norwegian Penal Code, https://lovdata.no/dokument/NLE/lov/2005-05-20-28/KAPITTEL_1#KAPITTEL_1

9	Олон улсын гэрээ, конвенцын зохицуулалт	“Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм”-ийн 29 дүгээр зүйл. Хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байх Шүүхийн харьяалалд хамаарах гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй[19]. НҮБ-ын 1970 онд батлагдсан “Дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байх тухай конвенц” I дүгээр зүйл. Дараах гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс үл хамааран хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа үйлчлэхгүй. (а) 1945 оны 8-р сарын 8-ны өдрийн Нюрнберг дэх Олон улсын цэргийн шүүхийн дүрэмд тодорхойлсон дайны гэмт хэрэг, 1946 оны 2-р сарын 13-ны өдрийн 3 (I), 1946 оны 12-р сарын 11-ний өдрийн 95 (I) тогтоолоор батлагдсан Олон улсын цэргийн гэмт хэрэг. Нэгдсэн Үндэстний Байгууллага, ялангуяа 1949 оны 8-р сарын 12-ны Женевийн конвенцид дайнд нэрвэгдэгсдийг хамгаалах талаар дурдсан «ноцтой зөрчлүүд»; (б) 1945 оны 8-р сарын 8-ны өдрийн Нюрнберг дэх Олон улсын цэргийн шүүхийн дүрэмд тодорхойлогдож, 1946 оны 2-р сарын 13-ны өдрийн 3 (I) ба 95-р тогтоолоор батлагдсан дайны үед эсвэл энх тайвны үед үйлдэгдсэн хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг. (I) Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1946 оны 12-р сарын 11-ний өдрийн 1948 оны Конвенцод заасан апартеидын бодлогын үр дүнд бий болсон зэвсэгт халдлага, эзлэн түрэмгийлэл, хүнлэг бус үйлдлээр нүүлгэн шилжүүлэх, геноцидын гэмт хэрэг. Геноцид гэмт хэрэг (ийм үйлдэл нь үйлдэгдсэн улсын дотоодын хууль тогтоомжийг зөрчөөгүй ч гэсэн хамаарна) II дугаар зүйл Хэрэв I зүйлд дурдсан гэмт хэргүүдийн аль нэг нь үйлдэгдсэн бол эдгээр гэмт хэргийн аль нэгийг үйлдэхэд гол үүрэг гүйцэтгэгч, хамсаатнаар оролцсон, эсхүл бусдыг шууд турхирсан төрийн эрх бүхий байгууллагын төлөөлөгчид болон хувь хүмүүст энэхүү конвенцын заалт хамаарна. Эсхүл гүйцэтгэсэн зэргэлэзэс үл хамааран тэдгээрийг үйлдэхээр тохиролцсон хүмүүс, мөн тэдний хийсэн ажлыг хүлээн зөвшөөрсөн төрийн байгууллагын төлөөлөгчдөд хамаарна. III дугаар зүйл Энэхүү конвенцод оролцогч улсууд энэхүү конвенцын II зүйлд дурдсан хүмүүсийг олон улсын эрх зүйн дагуу шилжүүлэн өгөх боломжийг бүрдүүлэхийн тулд хууль тогтоомжийн болон бусад шаардлагатай дотоодын бүх арга хэмжээг авах үүрэгтэй. IV дүгээр зүйл Энэхүү конвенцод оролцогч улсууд өөрсдийн үндсэн хуульд заасан журмын дагуу I, II зүйлд дурдсан гэмт хэргийг мөрдөн мөшгөх, шийтгэхэд хуулийн болон бусад хязгаарлалт үйлчлэхгүй байхын тулд шаардлагатай аливаа хууль тогтоомжийн болон бусад арга хэмжээг авах үүрэгтэй. Энэхүү конвенцод хамаарах бөгөөд хэрэв байгаа бол эдгээр хязгаарлалтыг цуцална[20]. Европын зөвлөлөөс 1974 онд батлагдсан “Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэгт хуулийн дагуу хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байх тухай Европын конвенц” 1 дүгээр зүйл Хэлэлцэн тохирогч улс бүр дараах гэмт хэргийн мөрдөн байцаалтад хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байх, эсхүл тухайн гэмт хэрэгт оногдуулсан ялыг хэрэгжүүлэхэд дотоодын хууль тогтоомжийн дагуу шийтгэгдэх боломжтой байхаар шаардлагатай арга хэмжээг авах үүрэг хүлээнэ. 1. 1948 оны 12 дугаар сарын 9-ний өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан Геноцид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шийтгэх тухай конвенцод заасан хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг;

19 Rome Statute of the International Criminal Court, https://www.icc-cpi.int/sites/default/files/Publications/Rome-Statute.pdf

20 Convention on the Non-Applicability of Statutory Limitations to War Crimes and Crimes Against Humanity Adopted and opened for signature, ratification and accession by General Assembly resolution 2391 (XXIII) of 26 November 1968, https://treaties.un.org/pages/ViewDetails.aspx?src=TREATY&mtdsg_no=IV-6&chapter=4&clang=_en

		2 Дайны талбай дахь зэвсэгт хүчинд шархадсан болон өвчтэй хүмүүсийн байдлыг сайжруулах тухай 1949 оны Женевийн конвенцын 50 дугаар зүйл, 1949 оны Шархадсан, өвчтэй, хөлөг онгоцны сүйрсэн гишүүдийн нөхцөл байдлыг сайжруулах тухай Женевийн конвенцийн 51 дүгээр зүйлд заасан зөрчлүүд. Тэнгис дэх Зэвсэгт хүчний тухай, Дайны олзлогдогсодтой харьцах тухай 1949 оны Женевийн конвенцын 130 дугаар зүйл, Дайны үед энгийн иргэдийг хамгаалах тухай 1949 оны Женевийн конвенцын 147 дугаар зүйл, энэ конвенц хүчин төгөлдөр болох үед хүчин төгөлдөр болсон дайны хууль тогтоомж болон Женевийн конвенцын дээр дурдсан зүйл заалтад тусгагдаагүй тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан дайны ёс заншилтай харьцуулж болох аливаа зөрчил, (бодит болон санаатай шинж чанар, эсвэл урьдчилан таамаглаж болох үр дагаврын цар хүрээний хувьд онцгой ноцтой шинж чанартай) 3. 6 дугаар зүйлд заасан мэдэгдлийн дагуу холбогдох Хэлэлцэн тохирогч улс энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт дурдсантай харьцуулж болохуйц шинж чанартай гэж үзсэн, цаашид тогтоогдож болох олон улсын эрх зүйн дүрэм, заншлыг зөрчсөн бусад аливаа зөрчил.[21]

21 European Convention on the Non-Applicability of Statutory Limitation to Crimes against Humanity and War Crimes Strasbourg, 25.I.1974, https://rm.coe.int/168007617f

ХАРЬЦУУЛСАН ЛАВЛАГААНЫ ДҮГНЭЛТ

Харьцуулсан лавлагааны хүрээнд Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Эстони Улс, Япон Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Оросын Холбооны Улс, Шведийн Хаант Улс, Норвегийн Хант Улс гэх 8 улсын гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтыг Монгол Улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулан судалснаас гадна олон улсын гэрээ, конвенцын зохицуулалтыг судалж, дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Монгол Улсын хувьд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг 2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлээр зохицуулж байна. Судалсан гадаадын улс, орнуудын тухайд ихэвчлэн Эрүүгийн хуулиар зохицуулж байх хэдий ч Япон Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын тухайд Эрүүгийн процессын хуулиар зохицуулж байгаа нь ажиглагдсан. Мөн хөөн хэлэлцэх хугацааны ерөнхий зохицуулалтыг авч үзэхдээ өөр өөрийн онцлогтой буюу Эрүүгийн хууль дахь гэмт хэргийн ангилал, ялын төрөл, интервалыг харгалзан хөөн хэлэлцэх хугацааг тогтоож байна. Мөн тусгайлсан зохицуулалтуудыг ч хуульчилсан байна. Жишээлбэл, Бүгд Найрамдах Солонгос Улсад яллах ажиллагаа явуулж, эцсийн шийдвэр гаргаагүй гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг 25 жил байхаар тусад нь тогтоосон; Америкийн Нэгдсэн Улсад гэмт хэргийг тусгайлсан гэмт хэргүүдэд хязгаарлагдмал байдлаар тогтоосон байна.

- Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг Монгол Улс, бусад судалсан гадаадын улс, орнуудын тухайд ихэвчлэн гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс тоолж эхэлж байна. Гэсэн хэдий ч зарим улс, оронд онцлог зохицуулалтыг тусгажээ. Тодруулбал, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Шведийн Хаант Улсад гэмт хэргийн бүрэлдэхүүн болж буй үр дүн хожим бий болсон буюу хор уршиг илэрсэн цаг үеэс хөөн хэлэлцэх хугацааг тооцохоор зохицуулжээ. Мөн Шведийн Хаант Улс, Норвегийн Хант Улсын тухайд хохирогчийг 18 нас хүрснээр хөөн хэлэлцэх хугацааг тоолох, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой хэрэг бол дампуурлын үеэс тоолох зэрэг зохицуулалтыг тусгасан байна. Түүнчлэн судалсан улс, орнуудын хүрээнд хэд хэдэн гэмт хэрэг, үргэлжилсэн үйлдэлтэй гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолж эхлэх, хамтран оролцогчтой гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолж эхлэх тухай зохицуулсныг анхаарах нь зүйтэй.

- Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тасрах, шинээр тоолох тухайд Монгол улстай адил давтан гэмт хэрэг үйлдсэн, ял оногдуулсан тохиолдолд үйлчлэх зохицуулалтуудтай улс орнууд байна. Тухайлбал, Япон Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Оросын Холбооны Улс, Шведийн Хаант Улс, Норвегийн Хант Улсын тухайд ижилхэн зохицуулалттай хэдий ч гэмт хэрэг тус бүрд хөөн хэлэлцэх хугацаа тооцох, хүнд ялтай, илүү урт хөөн хэлэлцэх хугацаатай гэмт хэргийг сонгох зэргээр өөр өөрөөр зохицуулсан байна. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын тухайд хөөн хэлэлцэх хугацаа тасрах 13 үндэслэлийг, Бүгд Найрамдах Эстони Улсын тухайд 7 үндэслэлийг тусгасан ба шинээр тоолох зохицуулалтыг ч нарийвчилж авч үзжээ.

- Монгол Улсын Эрүүгийн хуулийн хөөн хэлэлцэх хугацааг зогсоохтой холбоотой зохицуулалттай адил үндэслэлээр хөөн хэлэлцэх хугацааг зогсоох үндэслэл бусад судалсан гадаадын улс, орнуудад ажиглагдаж байна. Гэхдээ өөр өөрийн онцлог байдлаар авч үзжээ. Тодруулбал, Оросын Холбооны Улс, Норвегийн

Хант Улсын тухайд мөрдөн шалгах ажиллагааны үед оргон зайлбал хөөн хэлэлцэх хугацааг зогсоохоор тусгасан. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Япон Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын тухайд гадаад улсад байгаа тохиолдолд болон хамтран оролцогчтой хэргийн хувьд хөөн хэлэлцэх хугацааг зогсоохыг болон хугацааг сэргээн тоолох талаар нарийвчлан авч үзсэнийг анхаарах шаардлагатай. Мөн Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын тухайд тодорхой төрлийн гэмт хэргүүдийн тухайд хохирогчийг 30 нас хүртэл хөөн хэлэлцэх хугацааг тооцдог байна. Түүнчлэн Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Эстони Улсад парламентын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд түүний хөөн хэлэлцэх хугацааг тооцох зохицуулалтыг нарийвчлан авч үзжээ.

- Монгол Улс болон бусад судалсан гадаадын улс, орнуудын тухайд түрэмгийллийн гэмт хэрэг, геноцидын гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тооцохгүй байгаа нь нийтлэг жишиг болж байна. Энэ нь НҮБ-ын 1970 оны “Дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байх тухай конвенц” болон бусад олон улсын гэрээ, конвенцын агуулгатай нийцэж байна. Гэхдээ улс, орнуудын онцлогоос хамаарч хүнийг алах, бага насны хүүхдэд бэлгийн хүчирхийлэл үйлдэх, терроризм үйлдэх гэх мэт хүнд, ноцтой гэмт хэргүүд болон бүх насаар хорих ял оногдуулах гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тоолохгүй байна.

- Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хязгаартайгаар тоолох тухайд судалсан гадаад улс, орнуудад хөөн хэлэлцэх хугацааг сэргээх боломжгүй тохиолдол, хөөн хэлэлцэх хугацааг сунгах, ялыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх тохиолдолд тооцох, зарим төрлийн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг өөрөөр тоолох зэргийг тусгасан байгаа нь Монгол Улсын зохицуулалтаас онцлогтой байна.

НОМ ЗҮЙ

1. Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, (2016), №7;
2. С.Өмирбек, “Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа, түүнийг тоолох журам, харьцуулсан судалгаа”, 2023.11.10.
3. ХБНГУ-ын Бавари муж улсын Дээд шүүхийн дэд ерөнхийлөгч Андреас Цвергер: Хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт манай орныхоос зарчмын ялгаатай байна, 2019.09.25.
4. Д.Баярсайхан, Харьцуулсан эрүүгийн эрх зүй, (Уб, 2011);
5. Улсын дээд шүүх, Авлигын болон эдийн засгийн зарим гэмт хэргийн эрх зүйн шинж, шүүхийн практик /гарын авлага/, (Уб, 2011);

Цахим эх сурвалж

1. Japan’s Code of Criminal Procedure (Act No. 131 of 1948), https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3739/en
2. Act on the Punishment, etc. of Crimes under the Jurisdiction of the International Criminal Court
3. 공소시효, https://namu.wiki/w/%EA%B3%B5%EC%86%8C%EC%8B%9C%ED%9A%A8
4. ОХУ-ын Эрүүгийн хууль, https://www.legal-tools.org/doc/8eed35/pdf/
5. Шведийн Эрүүгийн хууль, https://www.government.se/contentassets/7a2dcae0787e465e9a2431554b5eab03/the-swedish-criminal-code.pdf
6. Research note on Limitation rules in criminal matters, Directorate-General for Library, Research and Documentation https://curia.europa.eu/jcms/upload/docs/application/pdf/2019-12/ndr-2017-005_synthese_en_neutralisee_finale.pdf, p.60.
7. Rome Statute of the International Criminal Court, https://www.icc-cpi.int/sites/default/files/Publications/Rome-Statute.pdf
8. Convention on the Non-Applicability of Statutory Limitations to War Crimes and Crimes Against Humanity Adopted and opened for signature, ratification, and accession by General Assembly resolution 2391 (XXIII) of 26 November 1968, https://treaties.un.org/pages/ViewDetails.aspx?src=TREATY&mtdsg_no=IV-6&chapter=4&clang=_en
9. European Convention on the Non-Applicability of Statutory Limitation to Crimes against Humanity and War Crimes Strasbourg, 25.I.1974, https://rm.coe.int/168007617f
10. Norwegian Penal Code, https://lovdata.no/dokument/NLE/lov/2005-05-20-28/KAPITTEL_1#KAPITTEL_1
11. [Enforced into force on April 12, 2011] [Law No. 10577, April 12, 2011, partially revised], https://www.law.go.kr/LSW//lsLawLinkInfo.do?lsJoLnkSeq=900147921&chrClsCd=010202&ancYnChk=
12. CRIMINAL PROCEDURE ACT OF KOREAN, Expand Act No. 9765, jun. 9, 2009, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?lang=ENG&hseq=22535